БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН
ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭН

ЧОЙ. ЛУВСАНЖАВ

ОРОС МОНГОЛ ӨВӨРМӨЦ ХЭЛЛЭГИЙН ТОЛЬ

Эрхэлсэн Ш. Маамхүү, Х. Нямбуу

УЛААНБААТАР ХОТ
1970 он

ISTITUTO UNIVERSITARIO ORIENTALE
SEMINARIO DI STUDI ASIATICI

ИНСТИТУТ ЯЗЫКА И ЛИТЕРАТУРЫ
АКАДЕМИИ НАУК
МОНГОЛЬСКОЙ НАРОДНОЙ РЕСПУБЛИКИ

ЧОЙ. ЛУВСАНЖАВ

РУССКО—МОНГОЛЬСКИЙ ФРАЗЕОЛОГИЧЕСКИЙ СЛОВАРЬ

Редакторы *Ш. Маамхүү, Х. Нямбуу*

ISTITUTO ORIENTALE - NAPOLI

УЛАН БАТОР
1970

УДИРТГАЛ

Орос Зөвлөлтийн ард түмний утга соёлын зүйлээс **ихийг сурч авах** зорилгоор орос хэл эзэмших чин эрмэлзлэл бүхий нөхөддөө, ялангуяа залуу дүүнэртээ, басхүү орос хэл оротдож эрхбиш дэвсгэр хөрс сууcан хүмүүс хийгээд дунд сургуулийн орос хэлний **багш** нар, орчуулагч нараас орос хэлний мэдлэгээ зузаатгахад нь **өчүүхэн** ч болов тус болохсон хэмээх нэгэн үзүүрт санаагаар, мөн **монгол өвөрмөц** хэллэг нь ч монгол хэлний үгсийн санд хуримт болох юуны магад гэж горилон орос монгол **өвөрмөц** хэллэгийн эл товь бичгийг туурвисан минь энэ ээ

Орос хэл нь **өвөрмөц** хэллэгээр нэн баялаг юм Орос **хэлний өвөрмөц** хэллэг бол орос хэл найруулгын онь шим болсон хэсгийн нэг нь болой

Ер нь **өвөрмөц** хэллэг гэдэг бол тагцхүү тухайн үндэстний **хэлэнд** буюу тухайн соёлын хүрээнд багтах утсын хэлэнд байдаг бүрэлдүүлсэн үгсийн нь уг утга алдраад нэгэн нэгдмэл утга гаргах **болсон** тогтворжмол нийтэмж үгийн нэр юм Энийн арав хорин үгээр гаргах санаг ганц хоёрхон үгэнд хураагаад хүний он удхаг**дов** тод орууллж өгөх ид чадал чухамхүү, хэл хэлний **өвөрмөц** хэллэгт л байдаг юм **Туранхай** тэмээ—г **хана** удмаар тэмээ гэдэг нь тэмээнийхээ удаарээр хийл үдэг мэтчин монголын хэлэнд л байдаг юм шиг бшиг

Өвөрмөц хэллэгийн тоо нь тухайн хэлнийхээ дан үгийн тоонос олон байдаг Монгол хэл мэдэгч гэх ооддог олиндэр ч **монгол өвөрмөц** хэллэгээ тэр бүрнг мэдэгдүй ялаа

Монгол бичгийн хэлнээ орвол зохих ардын ярианы хэлний **хэллэгээс**, өөрнин олж цуглуулж авсан **өвөрмөц** хэллэгээс **болох** байх гэсэн газарт орууллж өгөв

Эл товьд орсон монгол ардын хэлний **өвөрмөц** хэллэгийн нэг хэсэг нь миний бичсэн **„Монгол хэлний өвөрмөц хэллэг“** гэсэн нэг сэдэвт зохиолын хавсралтад орсон **өвөрмөц** хэллэгээс орсон юм.

Хэдэн жил монгол, орос, англи, франц, нангиад ... зэрэг хэлний өвөрмөц хэллэгийг цуглуулан тэр тухай холбогдолтой ном зохиол гарсныг үзэж судалсан бага сага туршлагадаа дулдуйдан тэр дундаа түүвэрлэсэн орос өвөрмөц хэллэгээ бусад хэлнээ яаж яаж орчуулсныг нь мэдэхийн хирээр хөөн үзэж манай монгол хэлний ямар ямар хэллэгтэй дүйхий нь чадлын хирээр онолдуулав. Өвөрмөц хэллэгийг орчуулахад хэдэн зүйл бий, үүнд нэг овгийн хэлний хооронд бол үгчилсхийн орчуулж болох хэллэг элбэг байдаг боловч бас л утгачлахыг голлодог юм. Алтай овог хэл, энэгхэг европ овгийн хэл, нангиад төвд овог хэл гэхчлэн өвөр өвөр овог хэлний өвөрмөц хэллэгийг нэгээс нөгөөд нь орчуулахдаа хаа нэг хэрэгцээтэй газар үгчилсхийхээс бус гол зонхи нь утгачлан орчуулбаас зохилтой байдаг, өөрөөр хэлбэл үгчлэн махчилчихвал утга нь гарахгүй нь нлад захын хэрэг, аягүйдвэл шал өөр юм болчих ч газар дайралдана. **Опять двадцать пять** үгчилбэл *дахиад хорин тав* гэвэл монгол хүнд утга нь гарахгүй тул үгчлэхийн аргагүй, чухам утга нь *бахи байдаг, улигт л, өнөөх л даг болсон, нэг юм арав дахих* гэх мэт. **Белое мясо** гэдгийг үгчилбэл *цагаан мах* болчихно. *Цагаан мах* гэдэг маань монгол хэлэндээ та бидний мэдэж байгаагаар гургалдай гэж ёгт нэртэй нэг махны цээр нэр шүү дээ. Орос хэлэндээ тугал, тахиа зэргийн зөөлөн булбар махыг нэрлэдэг үг. **Двурогая луна** (Ушк.1 663) үгчилбээс монголоор (*хоёр*) *эвэртэй сар* гэсэн хачин юм болно. Орос хэлэндээ бол энэ хэллэг нь өнгөрөө сайхан хэллэг юм. Монгол хэлэнд *хавирган сар, шинэд сар, хөмсгөн сар* гэхээс өөр яах вэ. **Дать слово** гэдэг өвөрмөц хэллэг хоёр утгатай нэгдэх нь *үг хэлүүл—,үгий нь дуул*; хоердох нь за *хүлээ—,ам алда—амла—*,**держать нос по ветру** үгчилчихвэл *хамрга салхинд бари*-гэсэн үг болно. Утгачилбаас зохих үүнд. *Салхи хаашаа бол тийшээ, зүү хаашаа бол утас тийшээ*, салхины эерүүгээр *далбааг хийсгэ—, эрэг хаашаа бол ус тийшээ* гэх мэт олон хэллэг бий. **Сидеть у моря и ждать погоды** үгчилбээс *тэнгисийн хөвөөнд сууж тэнгэрийн янз хара* — гэсэн үг. Ингэж үгчлээд орхихоор монгол хүний санаанд яаж байгаа нь тэр юм бол гэсэн шиг бодогдож учир утга нь ухаанд буухгүй тул утгаар нь *бухын доотохыг харж үнэг турж үхэх гэгч* гэвэл хэлсэн даруй санаа нь ухаанд ив хийтэл орж ирнэ. Уг орос үгий маань утга нь ч яг ийм юм.

Өвөрмөц хэллэгийн англи, франц, герман зэрэг төрөл хэлний толинд ч утгачлан орчуулсан байдгийг хоёр хэлний орчуулгын толь сөхмөгц илт үзэгдэнэ. Ийм ийм учир байдлаас болж утгачлах

орчуулгыг голлов. Тун үгчлэх дуртай хүн байвал **хараад л үгчилэхэд** юухан байх вэ. Чингэтэл бас учир бий, орос хэлний нэг орос өвөрмөц хэллэг олон утгатай байдгийн дотроос гол гол утгыг нь гаргав. Орос өвөрмөц хэллэг бүрт жишээ авалтгүй хэмээн үзэв. Орос үгийн олон утгыг монгол хэлнээ зөв буулгахыг өвөрмөц хэллэгээс ажиглахад бас сонин. *Жить* гэдэг үгийн гол утга нь *суу* — гэсэн үг тэгээд, *бай-, ява-, нутагла-, орши-* гэх мэт утга буй. **жить в законе** *ёсолж төрлөөч эр эм бол*. **жить в людях** *бусдын цагаа уу-, айлын тогоо өчгийж ява-*, **жить в свое удовольствие** *зоргоороо ява-*, **жить душа в душу** *эвтэй найртай бай-, сайаа нийлж ява-*, **жить затворником** *аглагч бол-*, **жить на большую ногу** *баян хүн шиг балхалза-*, **жить** гэсэн толгойг үзээрэй. **По уши влюбиться** *ухаангүй хайрлай, унаж үхсэн* Он **по уши увяз в долгах** *өр нь үстэй толгойноосоо их болжээ, өрөнөөс баригдаж гүйцжээ, өрнийхөө доороос босолт (гаралт) гүй болчихжээ*. **По горло** 1. *Хүзүүгээр, хоолойгоор*; 2. ... *тэргэл ингэтэл* Дело **по горло** *ажил үстэй толгойноос ихээ*, **по горло в воде** *ус хүзүүгээр татах*, **сыт по горло** *амаараа гартал идэх, хойш гэдийтэл, гэдэс гартал, ивэртэл, гэдсээ цодойтол гэзгээ модойтол, битүүртлээ идэх*, **занята по горло** *борив бохисхийх завгүй, ажилдаа дарагдах, гарч шээх завгүй* гэх мэгчилэн.

Өвөрмөц хэллэгийг орчуулаад прэхээр орос нэг өвөрмөц хэллэгт нэг байтугай нэг хэсэг монгол өвөрмөц хэллэг онолдож болох юм. **С какой стати** гэдэг өвөрмөц хэллэгийг *хэрхэн яах гэж, ямар учраас* ... гэхчлэн тун олон янзлар орчуулж болох талтай.

Орос хэлний нэг өвөрмөц хэллэг монгол хэлний утга ойролцоо хэд хэдэн өвөрмөц хэллэгтэй утга таарах ёсон буйн жишээ нь орос хэлний **большому кораблю большое плавание** *хүн хирээрээ тэмээ тэнгээрээ (тэнхээгээрээ)· гар томтын төө их, хамар томтын нус их, хөл томтын гутал том*; *их мод их сүүдэртэй*; *их тогооны хусам гурван жил хусуулдаг, их айл их зараатай*; *их ойн сүүдэр их, их өвсний шүүдэр их, их өтөг гурван жил шатдаг*. **От горшка два вершка** *паацайсан, хүний хагас хугас, үдийн нарны сүүдэр үүргийн түнзний бөглөө шиг, хүний тайрдас, өвгөний хугархай, газрын бэтэг, аатан, тагалцаг шиг, нугалуур шиг, модны тайрдас шиг* г. м. **Работать (трудиться) как вол** (*лошадь*) *морь нохойн хүчээр зүтгэ-, бие хайргүй зүтгэ-, бөхгүй тэмээ бол,- чөдөр даадаг морь шиг*, **үүнд работать** гэдэг үг *зүтгэ*-гэдэг монгол үгтэй дүйж банна.

Одна кожа да кости гэдгийг утгачлан монголчилоход *яс арьс хөёр, ясан хэдрэг, ясан дээр толоотой арьс, сувээгээр нь тэнгэр харагдмаар; хэлхээтэй яс,* малын хувьд бол *ташаанд нь ташуур өлгөмөөр, чөмөггүй.* **Каменная баба** гэдгийг утгачлан орчуулмааргүй юм, үүнд тохирох олон монгол нэр байдаг миний дуулснаас л *хүн чулуу, лам чулуу, гэлэн чулуу, далх чулуу, хөшөө чулуу* г. м. **Сломить рога** (*кому*) утгачлахэд *эврий нь хуга цохи*-гээн ч болох боловч энэ санааг гаргах утга чанцуу олон хэллэг монгол хэлэнд байдаг үүнд:*цорвонд оруул-, хагаарлаж ав-, номхотгож ав-, омгий нь шантла-, бэлд нь буулга-, чедөрлеж ав-, шары нь дара-, дөрөлж ав-, шөргөлж ав-, гартаа оруул-, аагий нь дара-, омгий нь дара-*; **к моему большому прискорбию он отказался** *дургүйцээд байгаа нь даан ч тоогүй (үгүй ер, дургүйцээд байх гэж)* үүнд анхааран авалтай нь орос зэрэг энэтхэг европ хэлнээс ааш нь монголчлохдоо **я, ты, вы, он, она, оно** зэрэг төлөөний нэрийг орхиж хэрвүүлэх газар тун их байдаг нь монгол хэлний найруулгын ёсоо. Эл хэллэгээс **моему, он** хоёрыг үгчлэлгүй орхичихоод утга нь монгол найруулгандаа шингэж орсон байх юм. Утгачилан орчуулсан хэдэн үлгэр нэмэж гаргавал. **Как две капли воды похож** *(на кого) ихэр юм шиг, ив ижил, нэг эхээс гарсан юм шиг, ялгахын аргагүй, яг адил өрөвсөн нь, тал бэл шиг;* **полными пригоршнями (хватать)** *суусан газраасаа шороо атгадаг, атга авдаг , . . .* **полно налиеать-богато жить** *дүүрэн бэлэг түвшин жаргал,* **иголку негде воткнуть** монголоор *хөл хийх (гишгэх) газаргүй (зайгүй);* **раб божий** үгчлбээс *элэнгэрийн боол* уг утга нь *христосын шашны биширэл сайн шавийг* хэлдэг бөгөө. Одоо *дээдсийн гарын үзүүр, дамбийжаагийн тоодгор, зулгаа барсан зуйрган,* **каши просят** (сапеги) гэдгийг үгчлбэл *гутал чинь будаа гуйж байна,* монголоор *гутал чинь инээгээд байна* гэдэг. **Поставить на колени** кого-нибудь *буулгаж ав-, сөгдүүл-,* **прийти к выеоду** уг зүй нь *тэгэж ингэж тогто-,дүгнэн үзэ-,тэгэж ингэж мэдэ*-зэрэг утгатай шиг юм. **Получить** (от кого) **благословение** (на что) *шутл. мастуул-,нүүр ол-,сайн гэгдэ*-**Камня на камне не оставить** *үнсэн товрог болго-, үнсий нь хийсгэ-голомты нь эргүүл-,яйртал эвдэ-,ээзгий болго-,***каши** (пиво) **не сваришь с таким человеком, как он, кашн не сваришь.** *Тийм хүнтэй хүн яаж таарах вэ?* **Со всех ног** *(бүх хөлөөрөө* гэж үгчлэхгүй) *хөл мэдэн, хар хурдаараа. шандас сорин, дөрвөн (хөёр) тавхайгаа эргэтэл, нисэх шахан,*

далавчилсан мэт, шурт шурт хийн хурд саалгүй, хөлийнхөө хурдаар, жирэлзүүлэн, жирийлгэн, таварган, харайлган бөмбөлзүүлэн; **собачий холод** *муухай хүйтэн, чөмөс царцам хүйтэн, үхрийн сүүл (эвэр) хугарам хүйтэн, дээлтэйгээ дэрийж гуталтайгаа гурийм хүйтэн, голд ором хүйтэн.*

Зарим өвөрмөц хэллэгийг оноосон үгээр нь орчуулахаас гадна **өгүүлбэр** дунд нь монгол хүн ийм тийм санааг яаж найруулдаг билээ гэдгийг бодон байж орчуулмаар газар бас олон байдгаас жишээлэхэд **до невероятия** ч гэдэг **до невероятности** ч гэдэг хэллэгийг *хүн итгэх аргагүй, санаанд багтахаргүй* гэж орчуулахаас гадна *даан ч, жигтэйхэн, хачин* гэж орчуулж бас болдог. **Цена на эти продукты упала до невероятности** үүнийг *энэ номны үнэ шал буув* гэж орчуулан найруулж болох юм.

Монголд огт байдаггүй зарим бодот юмтай холбогдол бүхий хэллэгийг үгчлэн орчуулмаар газар бас байна үүнд, **греческий нос** *герег хамар* (хөмсөгний уулзараас аваад хөёр нүдний хоорондох хамрын хянга нь хотогүй шүв шулуун хамрыг герег хамар гэдэг).

Хэрэгтэй болов уу гэж үзсэн зарим газар үгчилсэн утгачилсан хөёр орчуулгыг зэрэг оруулсан газар нилээд буй үүнийг **только сөхтөл** нл буй.

Үг **хэллэгийг** уг утга, бас үгчилсэн утгыг гаргах гэж зориогүй учир зөвхөн шилжмэл буюу өвөрмөц болсон утгы нь л гаргав. Жишээ нь: **Центр тяжести** гэдэг хэллэгийн бодосзүйн үг утгыг энд гаргасангүй, *гол юм, амин чухал юм, онцс нь* гэснийг л гаргав. Харас үгчлэн орчуулмаар өвөрмөц хэллэг бас байна. **Как молодой месяц** *шинийн сар мэт, шинэ сар мэт;* **Что псу (собаке) под хвост** орос хэлнээ *сүүл дор нь* гэдэг бол монгол хэлэнд үүнийг *нохойн хүзүүнээс уяган мах, чононд хадгалуулсан хонь* гэж орчуулахад болох юм. **Шум в голове** *толгой шуугих,* **и смех и грех** *инээх ч хэцүү байх ч хэцүү, наашаа харж инээгээд цаашаа харж уйлах, инээх уйлах хөёрын хооронд, доголон нулимстай инээх;* **слово не воробей вылетит не поймаешь** *ам алдвал барьж болдоггүй аят алдвал барьж болдог, хэлснээ буцааж болдоггүй хэрчсэнээ идэж болдог.*

Үгчилье гэхүл үгчлж болохын аргагүй **да и то сказать** мэтийн өвөрмөц хэллэг олон байна. Энэ өвөрмөц хэллэгийн утга нь *үнэний нь хэлэхэд, үнэндээ, чухамдаа, нарийндаа очиход* гм юм. Энэ талаар түрүүн утгачлах тухайд гаргасан. Үгчлэн орчуулмагүй **авч** утга нь монгол орос хоёр хэлнээ ихэд ойрхон хэллэг байх юм. **Родиться в рубашке (сорочке)** үгчлбэл *цамцтайгаа төрсөн* гэдэг уг утга нь *цагаан хальстайгаа төрсөн* гэсэн үг. Орос монгол хоёр ардын ёсонд нйм төрсөн хүүхдийг заяа буянтай хүүхэд гэлцдэг ёс нжил байгаа нь их сонин юм.

Орос хэлний өвөрмөц хэллэгээс монгол хэлний өвөрмөц хэллэгийн хагастай утга тохирох сонин хэллэг бас байдаг. **Руки коротки** гэдэг нь монгол хэлний *гар богино гачзага татуу* гэдэгтэй яг дүйнэ. Бас *ахар дээс уяа хурэхгүй* гэдэгтэй ч тохирно. Үүнээ ялгаатай нь орос хэл ганц олны тоотой хэл тул гар гэхээр л хоёроос цааш бол олон гэж сэтгэдэг ёсоор **руки** гэж байна. Монгол хэл ганц олны тоогүй төрөл тоо (common numeral) хэсэг тоотой (partative numeral) тул гар л гэхээр ганц ч гар байж болох, хичнээн ч гар

байж болох тул гарууд богинуудтай гэж сэтгэхгүй болохоор чингэж өгүүлэх ч үгүй. Бас нэг жишээ гатваас **ходит на острие ножа** буюу **ходить по лезвию ножа** гэж хэлдэг нь монголоор *хутганы ир дээр, дэн дун дээсэн дөрвөн дээр* г.м үгстэй таарах юм.

Дэлхийн олон улс үндэсний алины нь ч хэлнээ бараг байдаг **Дундын өвөрмөц хэллэг мэр сэр байх юм. Орос хэлний Как на ветру сьеча** *салхин доторхи зул мэт* гэж монгол ардын амаар яриа, монгол судрын хэл аль алинд нь их дайралддаг. Энэ хэллэгийг төвөд хэлээр ч rlung nang-gi mar-me гэдэг нь ч яг л утга нэг. Энэ хэллэгийн шилжүүлмэл утга нь *дэн дун дээсэн дөрвөн дээр, үлгэн салган, хутганы ир дээр, үхэх сэхэхийн дааан дээр...* гэх мэт юм.

Монгол хэлнээ бурхны судраас гаралтай өвөрмөц хэллэг их байдаг шиг орос хэлэнд христосын библээс гаралтай өвөрмөц хэллэг гун элбэг байдгийг тус толиноо гарсан газар болгонд нь библээс библээс гэж дурдсангүй.

Бичгийн хэлний өвөрмөц хэллэг ярианы хэлний өвөрмөц хэллэг гэж бас бий, чингэвч орос хэлний бичгийн хэлний өвөрмөц хэллэгт монгол хэлний бичгийн хэлний өвөрмөц хэллэг таарна, ярианых нь таарахгүй гэх учиргүй юм. Орос өвөрмөц хэллэгийг монгол хэлний өвөрмөц хэллэгээр орчуулах газар ч бий, зүгээр хэллэгээр буюу тайлбар шинжийн үгээр орчуулмаар газар ч байдаг.

Өвөрмөц хэллэгт зарим зарим бүдүүлэг хэллэг, этгээд хэллэг хир хэмжээгээр байдаг тул орос, (англи, франц ...) аль ч хэлний өвөрмөц хэллэгийн тольд бүдүүлэг хэллэг бол груб. вульг. гэх мэт хураангуйлсан үг тавиад оруулдаг, тэр тэрний нь орчуулыг ч монголын тохирох бүдүүн хэллэгээр орчуулахаас өөр аргагүй тул зарим бүдүүвтэр хэллэг орсон учир тухайг болгоон уучлах ажаамуу.

Монголын судлал хөгжсөн цагаас өдүй болтол монголч эрдэмтэд энэтхэг европ хэлний үйл үгийн инфинитив гэдэг эс тухайлах хэтбэрг монгол үйл үгийн үндсийг оноон тогруулсаар ирсэн уламжлалтай тул тэр сайхан уламжлалыг барьж эл тольд ч орсон үйл үгийн инфинитив байгаа газар нь монгол хэлний үндсээр оноов. Үлгэрлэвээс **писать** *бичи-*, **выходить** *гар-*

Эл толь бичгийн дотор гарсан орчуулахуйяа хэцүү зарим хатуу хэллэгийг монголчлоход туслаж хайрласан багш Ринчен доктор, тус толь бичгийн зарим толгой үсгийн гар бичмэлийг үзэж зөвлөгөө өгсөн хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан Вандуй, Содном нар болон аспирант Маналжав, ялангуяа тус толь бичгийн бүх нооргийг үзэж саналаа өгсөн эрдэм шинжилгээний ажилтан Мижиддорж, МУИС-ийн англи хэлний багш Дамдин нарт талархлаа дэвшүүлье

Үзэх мэргэд энэ тольд цаашид засан залах санал шүүмжээ хайрлах буйзаа хэмээн горилном

Хэл шинжлэлийн дэд эрдэмтэн ЧОЙ, ЛУВСАНЖАВ
1968—11—21

ХЭРХЭН ХЭРЭГЛЭХ НЬ

1. Монгол үншигчдын үзэхүй, үгээ эрж олохуйд дөхөм болов уу хэмээх зорилгоор өвөрмөц хэллэгийг цагаан толгойн дэсээр дэслэв.

2. Нэг өвөрмөц хэллэг эрс өөр хоёр утгатай газар утгы нь 1. 2. гэсэн тоогоор дэслэж гаргасан буй.

3. Нэг өвөрмөц хэллэгийг орчуулгын зарим хувилгаа, ялангуяа жишээ өгүүлбэрийн хувилмал орчуулгыг хаалтнаа заасан буй.

4. Нэг орос өвөрмөц хэллэгийн доторхи зарим үгийг өвөр үгээр солих газар солиоод нь орох үгийг ард нь хаалтнаа бичив. Хаалтанд байгаа зарим үг хэллэг бол байж ч болох, үгүй ч байж болох хэллэг юм. Чухам алин болох нь үзүүлэл.

5. Орос өвөрмөц хэллэгийн хэд хэдэн монгол орчуулгын дундаас хамгийн түрүүнд байгаа нь орос эх өвөрмөц хэллэгийнхээ утгад хамгийн их ойр орчуулга нь гэж санагтун. **С животом** гэсэн өвөрмөц хэллэгийн утга нь *жирэмсэн* гэсэн санаа. Монгол хэлэнд *гэдэстэй* гэсэн үг бий, түүний нь тавиад араас нь *их гэдэстэй, бие давхар, бие шалтгаантай, хөл хүнд, бие муутай, давхар биетэй, юмтай, олз олсон* зэргий нь жагсаав.

6. ЗХУ-д 1955 онд хэвлэж гаргасан А. В. Кунины „Англо—русский фразеологический словарь", 1963 онд Москва хотноо хэвлэж гаргасан „Французско—русский фразеологический словарь" зэргийн түршлагыг авч цагаан толгойн үсэг тус бүрийг дотор нь нэгээс аваад тед өд гэж дугаарлав Чингэсэн нь нэгэнтээгүүр нэг дугаараас хөвж дам нөгөө дугаарт өвөрмөц хэллэгийг олоход хялбар, орчуулгатай орчуулгагүй орос өвөрмөц хэллэгийн ард байгаа ж—30 ..г м тоо нь тэр өвөрмөц хэллэгийн ойролцоо утгыг хөвж олоход зориулсан юм. Иймээс ж—30, н—33, а—9 зэрэгт ж, н, а ... нь цагаан толгойн ямар үсэг болохы нь зааж 30, 33, 9, нь тэр тэр толгой үсгийн хэддэх хэллэг болох дугаар нь юм.

7. Тус толийн цэг цэглэл нь тользүйн хувьд аль ч улсын өвөрмөц хэллэгийн нийтлэг журмын дагуу хийсэн тул олны өгүүлэлтгүй юм.

АШИГЛАСАН ГОЛ НОМЫН НЭР

1 **А. И. Молотков**, фразеологический словарь русского языка, Москва 1967

2 Словарь русского языка, тт I—IV М ,1957—1961

3 **Д. Н. Ушаков**, тт I—IV, М , 1935—1940

4 **В. П. Жуков**, Словарь русских пословиц и поговорок

5 **А. Н. Кунин**, Английско—русский фразеологический словарь, Москва 1951

6 **Я. И. Рецкер**, Французско—русский фразеологический словарь

7 **Н. С. Ашукин, М. Г. Ашукина** крылатые слова, Москва, 1955

8 Русско—китайский фразеологический словарь, Харбин, 1959

9 **Ц. Дамдинсүрэн, Ш. Лувсанвандан**, Русско—монгольский словарь Москва, 1942

11 **Ц. Дамдинсүрэн, А. Лусандэндэв**,, Орос монгол толь, Улаанбаатар 1969 I—II боть

12 **Ж. Дашдорж, Г. Ринченсамбуу**, Монгол сэцэн үгийн далаи

ХУРААНГУЙЛСАН ҮГ

Бран.	Бранное слово, выражение	Харааһын үг хэллэ́г
Вводн.	вводное слово	Оруулмал үг хэллэг
Воен.	военный термин	Цэргийн нэр томьео
Вульг.	вульгаризм	бүдүүлэг үг хэллэг
Высок.	высокое, высокого стиля	эрхэмсэг найруулга
Газет.	газетное выражение	сонины хэллэг
Грам.	грамматика	хэлзүй
Груб.	грубое выражение	бүдүүлэг хэллэг
Дип.	дипломатический термин	дипломат нэр томьео
Дореволюц.	дореволюционное слово, выражение	хувьсгалын өмнөх үеийн үг хэллэг
Иронич.	В ироническом смысле	еж хэлэгдэй
Ист.	исторический термин	түүхийн нэр томьео
Канцл.	канцелярское выражение	албан бичгийн хэллэг
Книж.	книжное книжного стиля	ном судрын хэл
Мат.	математика	тоозүй
Мор	морской термин	далайн нэр томьео
Неодобр.	неодобрительно	үл ойшоох
Охот.	охотничий термин	анчины нэр томьео
Офиц	официальный термин, официальное выражение	албан ёсны нэр томьёо, үг хэллэг
Перен.	В переносном значении	шилжүүлэгт утга
Погов.	поговорка	сэцэн үг
Посл	пословица	зүйр үг
Презр.	презрительно	жигшин (өгүүлэх)
Пренебр	пренебрежительно	тоомсоргүй (өгүүлэх)
Прост.	Просторечье	хар ярна
Разг	Разговорное	ярианы хэл
Сл	слово	үг
Спец	специальное слого	мэрэжлийн үг
Спорт.	Физкультура и спорт	биеийн тамир спорт

Стих.	стихотворение	шүлгийн
С. х.	сельское хозяйство	хөдөө аж ахуй
Устар.	устаревшее слово, выражение	хуучирсан үг хэллэг
Фам.	фамильярное	гэр зуурын
Филос.	философия	гүн ухаан
Фольк.	фольклор	ардын бичиг
Шутл.	шутливое слово, выражение	шог үг хэллэг
Эвф.	эвфемизм	эерүүлэл

А

1. А ВАСЬКА СЛУШАЕТ ДА ЕСТ. Чихгүй толгой; нүдэн балай чихэн дүлий; доль цохисон амьтан үл мэдэгчээн оргисон (парайлсан); дүлий дүмбэ дүлэн пад; дүлий годил оргисон; мэдсэн ч мэдээгүй юм шиг, дуулсан ч дулаагүй юм шиг;

2. А ЕЩЕ . . . (зэмлэх, шоолох, буруутгах, санаагаар) бас л, аанай л, бахь байдаг л, мөн л, мөн ч, мөн л нэг, бас тэгээд

Чего толкаетесь? А еще интеллигент. Яагаад хүнийг түлхлээд байна вэ? Аанай л сэхээтэн л биз дээ. (Яагаад түлхээд байнаа? Бас тэгээд сэхээтэн гэж байгаа шүү.)

3. А ЛАРЧИК ПРОСТО ОТКРЫВАЛСЯ юу амархан бэ тэр амархан; хүйтэн цай зайдан морь; нохойн наадам, хүүхдийн тоглоом; гарын үзүүрийн ажил; хонь алах хуруунд илхэн; морь эмээллэхийн хоорондхийхээр цай чанахын хоорондхийхээр нүдээ аньсан ч чадна. Ухаан зарах юмгүй; алга урвуулах адил·

4. А НЕ ТО [*разг*] 1. Эс тэгвэл, тэгэхгүй бол, эс . . . бол, нэг бол, эс бөгөөс, эс болж гэм, үгүй бол, тэгдэггүй юм бол 2. Магадгүй, тэгэж мэдэх юм.

5. А, НЕТ . . . эсвэл, үгүй юм гэхэд, үгүй бол, эсхүл

6. А НУ КАК . . . [*разг.*] 1. Гай болж . . . тэгвэл (ингэвэл) яана? Яах юм бэ? тэгвэл ч тээглэлээ шүү. Бажгадах нь тэр; ... бал[4] юугаа хэлэх билээ...-бал[4] хаашаа харж (яаж) ухдэг билээ. Н-1249

А ну как подымется буря? Шуурга тавивал яах юм бэ?

7. А, НУ ТЕБЯ (его, вас, их)! [*разг*]. за та (танар, тэднэр) боль л доо; Зүгээр шиг байгаарай! Сайхан мэдээрэй! Нэрээ мэдээрэй чи! Гайгүй чамайг дээ! Тэгэж л бай гайгүй! Арлаа даана биз! Амаа бариузай! Уйлах хүүхдийн юу урьд өдөр нь яах билээ! Хаана чинь загатнаад байна! мар мар гэх гайгүй, маргаашхонины ээлж гэж үг бий шүү!

8. А, ПОПАЛСЯ Уухай чи энд байж байдаг бий! За чамайг ингэж барьж авдаг юмаа бас! За, дээрээс чинь буулаа даа! За амбаа жаажаагийнхаа гарт ч нэг ороо бий хөө! Ингэж нэг олддог байжээ! Өрт хүн өл хөтөл дээр гэж! Чи олдохгүй байхгүй яагаа вэ!

9. **А ТО** [*разг*] 1. тэгвэл, ингэвэл, эс тэгвэл; . . . үгүй бол . . . шүү 2. Үнэндээ, чухамдаа 3 (эхлээд цааранлаж байснаа сүүлдээ за хүлээх буюу тэгье гэх зэрэг санааг илтгэхэд) за яах вэ тэгвэл тэгэе

Спеши, а то опоздаешь. Бушуулж үзээрэй хожимдоно шүү. (аджуудвал алдана даа.)

Добро бы был неуч, то ведь знающий человек. Юу ч мэдэхгүй хүн байсан бол ч бас яахав мэдэхийн цаагуур мэддэг хүн шүү дээ

А то бы скушали ещё! Яах вэ идвэл жаахан идье.

А то поеду. За яах вэ би явбал явъя.

10. **А ТО ВЕДЬ** ..., ... үгүй бол ч

11. **А ТО НЕТ?** [*прост*] Үгүй гэж үү дээ? Биш гэж үү? Иймгүй гэж үү? Яалаа гэнэ ээ? Арай үгүй байлгүй. Ээ мэдэхгүй, юу бол

12. **А ЧТО** [*разг*] Яах гэж? Яа гэж? Яах юм? Яагаад?

Ты хочешь ехать—А что? Гарах уу — Яах юм?

Не ходи сегодня купаться-А что? —Холодно. Өнөөдөр явж усанд ороод юу хийх юм бэ? —Яагаад? —Хүйтэн байна шүү дээ

Домой еду—А что? —Соскучился. Гэртээ харья — Яагаад вэ? —Уйдаад байна.

13. **АБСОЛЮТНЫЙ НОЛЬ.** Тэг хүн; идэхээс өөр идгүй, могой алахад модны нэмэргүй хүн, усан поолуу амьтан

14. **АВГИЕВЫ КОНЮШНИ** [*книжн*] Бузартсан (бузарлуулсан) газар, нохойн хороо шиг; бөгс эргэх зайгүй, толгой түрүүгүй, эх адаггүй, эмх замбараагүй явдал, эсэн бусын, ундуй, сундуй, тэмээ туйлсан юм шиг, холхон явмаар, өөд уруугүй, бөгс толгой нь ялгагдахгүй, зуун задгай жаран хагархай, ой гутмаар, бөөлжис хутгамаар, гахай төрчихсөн юм шиг.

15. **АВОСЬ ДА НЕБОСЬ** буюу **АВОСЬ, НЕБОСЬ ДА КАК-НИБУДЬ** [*прост*] Дурандаа болсон хэрэг, сохор азаар; аргалсан болох. тэгс тэгс хийх, нүглийн нүдийг нүхээр (гуриллаар, сүнсээр) хуурах, ор нэр болгох, оромдох, хийсэн болох, аз мэдэг, өөрөө мэдэг, дүүрсэн хэрэг дүмбийсэн толгой; аз байвал ёоз хүүгээр гэгчээр, голионы үлгэрээр.

16. **АД КРОМЕШНЫЙ** [*разг*] Чих дөжрөм (шуугиан зэрэг), тархи толгой эргэмээр газар, тамын орон, амар заяа үзэхгүй, халширмаар, холхон явмаар, байж ядмаар, санаа зовмоор, хэлэх юм биш, ярих юм биш, хавьтмаар юм биш, байж цохмөөр, Чихний үдээр таслах, чихний чийр болсон.

У них дома ад кромешный. Тэднийх дандаа хэрүүл хараал болж байдаг айл (тэднийх ч чухам л нэг тамын орон).

17. **АД КРОМЕШНЫЙ НА ДУШЕ (на сердце) у *кого*** Сэтгэл түвшингүй, ухаан нь ууланд гарсан, яая даа гэж.

На душе у меня ад кромешный Сэтгэл үймээд сүйдээ.

18. **АДАМОВА ГОЛОВА** Хохьмой толгой (хар ухаанийн тэмдэг). зүүдэнд ормоор.

19. **АДАМОВО ЯБЛОКО** (Гүрдгэр) төвөнхи

Когда он говорит, у него всегда играет адамово яблоко. Юм ярихаараа төвөнхи нь гүрдэс гүрдэс гээд л байдаг юм.

20. **АДМИНИСТРАТИВНЫЙ ВОСТОРГ** [*ирон*] Захиргааны арга голлох, муйхраар цагдан барих.

21. **АДМИРАЛЬСКИЙ ЧАС** [*ирон*] Манзны цаг, өглөөний зоогийн цаг, өглөөний арван нэгэн цаг.

22. **АДСКАЯ МАШИНА** Хэмжээндээ дэлбэрэх бөмбөг, цагтаа тэсрэх бөмбөг

23. **АДСКАЯ ПЛЯСКА** Нүүрэнд хүйтэн хөдөлгөөн, зэвүүн хөдөлгөөн, адын авнр, жаравганах, цамаа хараймаар; зэвүү хүргэм, эгдүү хүрмээр; харахаас эгдүү хүрэм, хавьтахаас зэвүү хүрэм.

24. **АДСКИЙ ШУМ** Чихэнд чийртэй дуу, царгиа дуу, муухай дуу чимээ, дожрөм шуугиан, пижигнээн пажигнаан, чөтгөр гуугалах, чихээ бөглөмөөр.

25. **АЖУРНАЯ РАБОТА** А—26

26. **АЖУРНАЯ СТРОЧКА** Уртай юм, нарийн хийцийн, нарийн урын ажил, нарийн ширийн ажил, гараа гаргаж хийсэн; бурхан ухаантай дархан хүн хийсэн юм.

27. **АЗ ГРЕШНЫЙ** буюу **МНОГОГРЕШНЫЙ** Над шиг юм, над шиг нь, мөхөс бие, доордос би, болхи миний бие, нөгөө муу чинь, өчүүхэн хүн бээр, муу нохөр чинь, хүдэхи би, мунхаг бядуу би

28 **АЗ ЕСМЬ** А-27

29 **АЗА В ГЛАЗА** [*разг*] А ч үгүй, а үсгийн толгой ч мэдэхгүй, ална ч гэсэн мэдэхгүй, таг хүн, паг хүн, тэг хүн, умаа хум хүн, гурван үгний утга мэдэхгүй гурвалжин зүйдлийн эв мэдэхгүй, дүлэн пад; а-гийн ацаггүй, арвын тэггүй; төгрөгийн тоо ч мэдэхгүй.

30 **АЗБУКА-К МУДРОСТИ СТУПЕНЬКА** Аав гэж хэлд ордог А гэж эрдэмд сурдаг; А үсэг эрдмийн дээж, аяга цай идээний дээж

31 **АЗБУЧНАЯ ИСТИНА** Хэний ч мэдээж юу шалих вэ. Таван хуруу шигээ алган дээр байгаа юм шиг, наад захын, нохойн наадам.

32 **АЙ-АЙ-АЙ** буюу **АЙ-АЙ** Пээ, үгүй ер мөн. эш

Ай-ай-ай какой шалун Пээ яасан дүрсгүй жаал вэ? (Ээ моцд)

Ай-ай, как стыдно. Неужели так серьёзно? Ай-ай (Чехов) Эш, юутай ичгүүр. Ийм сүрхий юм бий, үгүй ер

33 **АЙ ДА** . . . Я Мөн хөө болж байна хөө, ёстой ч нэг, бүр нэг төгмөөр байсан юм, ганц боллоо, ухай, уухайсдаа, ай ганц боллоо.

Ай да молодец Мөн хө сайн эр. (Мөн хө аавын хүү, уухай эр хүн.)

Ай да артист в любой роли хорош Юу ч болж гарсан чаддаг ёстой л нэг сайн жүжигчин дээ (Элдэвтэй амьтан; таван саваагүй (амьтан хүн)

34. АККУРАТНОСТЬ—ВЕЖЛИВОСТЬ КОРОЛЕЙ бороотой ч болсон болзоондоо хуртай болсон хугацаандаа, хэлэндээ хүрэх

35. АКРОБАТЫ БЛАГОТВОРИТЕЛЬНОСТИ [*ирон*] Нүглийн нүдийг цаасаар хуурагч, мигүй багш шиг; буянгүй буянтан, өнгө засах нигүүлсэл, засдаг нигүүлсэл, алж алж махы нь борцолчихоод, Хуурмаг дүртэй хувхай.

36. АКЦИИ ПОДНЯЛИСЬ буюу **УПАЛИ** 1. Ханш нь дээшлэв, ханш нь өсөв (унав), шалдаа буув, бэлдээ буув 2. [*перен разг*] Нөлөө буурь ихсэв (багасав). Гаргуундаа гарав. Сохор зоосны үнэгүй болов. Суурь суудал ахив. Морь явав (явахгүй), үнэд оржээ, дээгүүр давхилаа, гараад өгчээ.

37. АЛЛАХ ЕГО ВЕДАЕТ (знает) [*шутл*] Хэн мэдэх вэ, бүү мэд, Аллах тэнгэр л мэднэ дээ.

О чём здесь спор, аллах его ведает. Энд юундаа (юугаа) маргаад байгаа юм бүү мэд дээ.

38. АЛЧУЩИЕ И ЖАЖДУЩИЕ [*ирон*] Хорхой нь ассан, өттэй тэмээ шиг, өрөмний өт шиг; загатнасан амьтад, байж яаж байгаа, арангалсан, авч алдсан. хамуутай тэмээ хад харсан юм шиг

39. АЛЬФА И ОМЕГА (чего) [*книжн*]. Эх адаг, толгой бөхөс, эхнээсээ аваад адгаа хүртэл, зулайнаасаа тавхай хүртэл, хамаг байдаг, бүхлээрээ, бүхэл, хуу, шувт, булт, хүй, буйгаар, аль байдаг.

Я прочитал его труды от альфы до омеги Би зохиолы нь хуу уншсан.

40. АМЕРИКАНСКИЙ ДЯДЮШКА [*шутл*]. Гэрий нь гэрлэж дэрий дэрлэсэн; Гэрий нь гэрлэж гэдсий нь орлосон; өв идсэн төрөл, өврөөр баяжсан хамаатан, олсон зөөснөөр нь хөлжсөн хүн, юмы нь авсан хүн, их гэрий нь авсан төрөл, голомты нь сахисан ураг баяны нь өвлөж буяны нь хүртэх, уургалсны нь уутлагч, баянд нь бялхаж буянд нь булхах, хойноос ирээд хотонд, хотонд ороод минийх; оры нь орлож дэрий нь дэрлэх. Д-492

41. АМУРЫ (любовь) КРУТИТЬ (завести и. т. п) Янаг бололцо- (сэтгэлтэй бол-), учиртай бол-

Ты, того-этого, не амуры ли крутить с Зинайдой Павловной? Не серчай, по отцовски спрашиваю (Кочетов) Битгий уурлаарай, би эцгийн чинь хувьд нэг юм асууя. Чи Зинайда Павловна-д орж гардаг (сэтгэлтэй) болоо юу?

42. АНГЕЛ ВО ПЛОТИ [*устар*] Түвшин хүн, хүний хайлан, харвал хүн халдвал бурхан, хүн гэж хүний дээд, дөрвөлжин бурам шиг, баастай бурхан, санаа амар хүн, өө нь дэндүү сайн.

Ведь вам говорить нечего—вы знаете, что у меня за жена: ангел в плоти, доброта неизъяснимая. . . (Тургенев). Надаар хэлүүлэлтгүй та юу эс андах вэ? Миний хань гэдэг чинь чухам л хүний дээд хүн, санаа амар амьтан.

43. АНДРОНЫ ЕДУТ [*устар.*] Шал дэмий; учир утгагүй.

44. АНИКА*—ВОИН (Аники—воина) (*прост*). Уг нь үнэг гүйцнэ, үйлс нь мэлхий гүйцэхгүй; омон бардам, оронд шалдан; ам бардам гуя шалдан, Ам нь арслан зодно, ачир нь мэлхий . . .; санаа нь дэлхий, сачий нь мэлхий; өөрийгөө магтагч өөдгүй; онгирч байж олгойгоо хагалах, үнсэн дээр хөрьөх, цор цор хийж байж цөсөө хагалуулах.

45. АННА НА ШЕЕ [*устар*]. 1. Үгчилбээс Аннын тэргүүн зэрэгийн одонг (хүзүүндээ) зүүсэн.

46. АННИБАЛОВА буюу **АННИБАЛОВСКАЯ КЛЯТВА** Г-7

47. АНТИК С ГВОЗДИКОЙ (с мармеладом) [*прост*], [*ирон*]. Доги; чухам л; загатнасан газар нь маажих шиг, ганц болж; тахилы нь зөв өрж.

48. АППЕТИТ ПРИХОДИТ ВО ВРЕМЯ ЕДЫ [*разг., ирон*] Улам хорхой асах, атга авах, амтших, амташсан хэрээ арваагурав дахидаг (эргэдэг), гар бариад бугуй барих, даварсаар даварсаар Дагвын сууринд, даварсаар даварсаар дайчин гуайн толгой дээр, бууж мордож яваарай гэхээр өдрийн арван гурав дахих; амты нь авбал шимтий нь; атгы нь авбал чимхий нь; гэт сээр гэтсээр гэдсэндээ; өврий нь сөхсөөр өехий нийлэх, энгэрий нь сөхсөөр элэг нийлэх.

49. АРЕДОВЫ (Аридовы) ВЕК ЖИТЬ [*разг*] Урт насла-, удаан жарга- (амьд бай-), мөнхө-, эрлэг марта-, насан хутаг эдлэ-, насан шидийг ол-, галав юүлэхэд ганцаараа үлдэ-, эрлигийн дансны үдээсэнд оро-

50. АРЕСТАНТСКИЕ РОТЫ Шоронгийн зовлон, гяндангийн зовлон, хүнд хүчир алба хөдөлмөр, шоронгийн мухар, их айлынх (аавынх), нарсных, наарных, шаврынх, шоронгийн хадаас (болох), хар гэрт (орох), амьдын там

51. АРИАДНИНА НИТЬ [*книжн.*] гарах зам, мултрах арга, шүргамаар нүх, уяа алдуура-, давс хужры нь таруул-, зайгий нь ол-, амь зулба-, хүний нүд хариул-,

52. АРИСТОКРАТИЯ УМА (таланта) Сод ухаантан, их билэгтэн, тасархай дээдэс (ухаантан), билэг танхай, суу билэгтэн, цоорхой (хүн).

53. АРКАДСКАЯ ИДИЛЛИЯ [*книжн.*] Амар жимэр, ажин түжин, нам тайван, эрх тавваараа, дэл сул байх, гар гадаа хөл хөдөө амар жимэр суух

54. АРКАДСКАЯ ПАСТУШКА буюу **АРКАДСКИЙ ПАСТУШОК** Юм үзэж нүд тайлсан гудиггүй хүн (эр, эм), доль цохисон толгой, уужим дотортой, хий нь гарсан, мөрөө хөөсөн.

---

* *Аника* гэж орос домгийн нэг баатрын нэр. Онгирч сайрхаж байгаад өөрөө дайнд дийлдсэн гэдэг. Одоо үүгээр омой хөөрцөг хүнийг хэлэх үг болгожээ.

55. **АРТЕЛЬ ДРУЖБОЙ КРЕПКА**. Эвлэвэл бүтнэ, ховловол гутна. Эвт шаазгай буга барина. Эв мянган лан, эвийн үзүүр тос, ховын ёзоор цус. Цувж явсан барснаас цуглаж суусан шаазгай дээр.
56. **АРТИСТ СВОЕГО ДЕЛА** Гаршсан хүн, сурамгай; сайн лам чаджаа хийх мэт, уургач морь шиг; болсон хүн, барууп солгойгүй болсон, чадахаа нэг чаддаг. Тэр юм нь гарт нь орчихсон, боловсорсон хүн, нэвтэрсэн хүн.
57. **АРХИМЕДОВ РЫЧАГ*** Гол гогцоо, оньсон түлхүүр, амин судас.
58. **АСТРОНОМИЧЕСКОЕ ЧИСЛО** Од шиг олон, тоолж барамгүй, тоо томшгүй, тэнгэрийн одноос олон, тэнгэрийн од газрын үндэс шиг, далан (монгол хүний олныг илтгэх санаа); сэтгэшгүй (монгол тооны нэг нэр)
59. **АТМОСФЕРА НАКАЛЕНА** [*книжн*] Юмыг яаж мэдэх вэ, юу ч болж мэдмээр байх, хэрэг мандмаар байх, манзаа чанаж мэдмээр, гай удах, уршиг тарих, дэнсэлгэх. эмээлээ гэдсэндээ авч магадгүй Н-477
60. **АТТЕСТАТ ЗРЕЛОСТИ** Дунд сургуулийн гэрчилгээ, боловсролын гэрчилгээ.
61. **АТТЕСТОВАТЬ СЕБЯ** Өөрийгөө (биеэ) үнэмлэ-
62. **АТТИЧЕСКАЯ СОЛЬ** [*книжн*]. Наргина үг, есөн шидний юм, далан долоон юм, алиа ярна, хөхүүн зугаа, Ил Дандин шиг.
63. **АТУ ЕГО (её, их)** [*охот*] (Анд анч нохой турхирдаг үг) туу туу, чид туу,
64. **АФИНСКИЕ ВЕЧЕРА (ночи)** Нижгэр найр, хөлтэй баяр цэнгэл, наадам шиг, гэр хагарам найр.
65. **АХ ДА** [*разг*]. Өө, тийм, Пээ, тэр; үгүй ер, за ер, ер тэгэх гэж, мартсан, ээ харла, санаснаас. . .

    Ах да, чуть не забыл сказать. Өө тийм хэлэхээ мартах дөхөж, (Золтой арайтай, заяатай) л хэлэхээ мартчихсангүй).
66. **АХАЛБЫ ДЯДЯ, НА СЕБЯ ГЛЯДЯ** Хүнийг хэлбэл өөрт, хүнцэл идвэл араанд; хүнийг хэлэхээр өөрийгөө хар. Хүнийг хэлэхдээ хүрэн эрээн бүргэд, өөрийгөө болохоор өндгөө дарсан шувуу.
67. **АХИ ДА ОХИ НЕ ДАДУТ ПОДМОГИ** Алахаасаа өлгөх нь, барилдахаасаа таахалзах нь, хийхээсээ хээхэлзэх нь; уул үзээгүй байж хормой шуух, ус үзээгүй байж гутал тайлах.
68. **АХИЛЛЕСОВА ПЯТА** Амин газар, эмзэг газар, хар хулхиар нь (хийх), оночий нь (олох), газар, нимгэн газар, согогий нь олох.
69. **АХНУТЬ НЕ УСПЕЛ, КАК. . .** Юуны ч тухандгүй, хүүе хайя гэхийн завдалгүй яах нийхийн завгүй, гэв гэнэт, яах нийхийн хооронд, удаж төдөлгүй, тэгэж нигэхийн зуур, нүд ирмэхийн зуур, нэг харахнаа, харахын хооронд, нэг мэдэхнээ.

* Эртний Грегийн их тоозүйч, оньсэүйч, Сиракуз хотын Архимед (МЭӨ 287—212) хэмээх эрдэмтэн анх хөшүүргийн хуулийг нээгээд «Дайте мне точку опоры, и я сдвину землю—Надад тулах цэг өгөгтүн, би дэлхийг өргөсүгэй» хэмээсэн үгнээс үүсэлтэй аливаа хөдөлгөгч хүчийг илтгэсэн «Архимедийн хөшүүргэ» гэсэн хэлц ажээ. Энэ хэлц нь монгол хэлний «Малгай дотор толгой багтана, толгой дотор оюун багтана, оюун дотор орчлон багтана» гэдэгтэй санаа төсөрхүү болно.

Крестьянин ахнуть не успел, как на него медведь насел (Крылов) Баавгай тариачин эр рүү яах нийхийн завгүй ухасхийн ноцов (үнгэв, нухав).

70. **АХТИ МНЕ бүюу АХТИ НАМ** Ээ чааваас баларчээ. Дүүрлээ дүүрлээ, өнгөрчээ өнгөрч, тоогүй тоогүй: ээ зайлуул хайдаа бас. Ээ заяа нь хая. Ээ үйлс нь хазай. Эз нь татмар. Ээ голомт нь хийс. Яасан сүнсгүй юм бэ. Ээ халаг. Ээ дээ бас золиг байна даа. Үгүй ер тэгчих гэж. Одоо яая гэх вэ, хийморь нь хийс.

Б

1. **БАБУШКА ВОРОЖИТ** *кому* [*разг.*] Тал харах; талаа татах, талаа татаж (тушаал дэвшүүлэх), өөр мөртэй, өрөөсөн засаатай, тацилтай хүн талын чинээ

   Хорошо тому жить, кому бабушка ворожит (пословица). Танилтай хүн талын чинээн, баян хүн таван хаанд нүүртэй.
2. **БАБУШКА НАДВОЕ СКАЗАЛА** (гадала). Нэг бол үхнэ, нэг бол сэхнэ; хэлэхэд хэцүү, ацан шалаанд суув; хоёрын хооронд гурвын дунд болов; хаашаа ч үгүй, алцагчин палцагчин, хаашаа болохы нь мэдэхгүй, бааж чадахгүй нохойн хөл хөлдөөв, гүйх нохойн өмнө гүйхгүй нохой саад, учир нь олдохгүй, ацдав, онилгүй, хоёрдмол үг, заан тугалах гэж байгаа юм шиг. Е-71, 72
3. **БАБУШКИНЫ СКАЗКИ (бабьи сказки)** Дэмий яриа, болчимгүй ярна, хамар доор хагархай ам, хий санаа, далан долоон үг, амныхаа зоргоор бүрдаг, зөнөсөн хүний үг шиг.
4. **БАБЬЕ ЛЕТО** Намрын шар наран, налгар намар, тос даасан намар, шар навчны дулаан, чавганцын шар нар.

   Бабье лето у нас лучшее время года Манайхны намрын шар наран мөн ч сайхан даа.
5. **БАЗАР ЖИТЕЙСКОЙ СУЕТЫ** у г ч и л б э л Хорвоогийн үймээний зах. у т г а н ь эрхтэн дархтан, отготон жинстэн, баян тарган улс.
6. **БАЗАРНАЯ БАБА** [*груб. ,прост.*] Хэрүүлч чавганц, ховын тулам, хэрүүлийн хүүдий, ам хуурайгүй чалчдаг, ховын хэрээ жорын бошго болсон эхнэр, улаан хазаар, ховч эхнэр, ам хамар болсон авгай.
7. **БАЛАЛАЙКИН** Авилгач хүн, хахуульч түшмэл, хүний гар харж сурсан хүн.
8. **БАЛЬЗАКОВСКИЙ ВОЗРАСТ** (Эм хүний) идэр дунд нас, хамаг нас
9. **БАЛЯСЫ ТОЧИТЬ** [*прост.*] Дэмий чалчна, хоосон ярна, хамар доор хагархай ам, ам мэдэн донгос-, хэл амаа билүүдэ-, ярианы дон. амаа ура-.

10. **БАМБУКОВОЕ ПОЛОЖЕНИЕ** [*прост. ,ирон.*] Шар наран бор хоног, ядуу гуцуу, хоног төөрүүлэх, шороо хөдөлгөх, хорвоогийн тоос хөдөлгөх.
11. **БАРАБАННАЯ ДРОБЬ** Хэнгэргэ пижигнэх, хэнгэргийн дуу нижигнэх,
12. **БАРАШЕК В БУМАЖКЕ** [*ирон.*] Хээл хахууль, хүн өнгөрүүлэх юм, хүний гар дээр тавих юм, гар цайлгах юм, савны харцуу, алган дээр нь тавих юм.
13. **БАРСКИЕ ЗАМАШКИ** Баярхуу зан, дээгүүр зан, ихэрхүү зан, новрхуу зан, танхил зан, тансаг ааль. бөлэрхэг,
14. **БАРСКОЙ РАБОТЫ НЕ ПЕРЕРАБОТАЕШЬ** Боол хүн (муу хүн) борив нугалах завгүй, өлссөн гэдэс заяагаа хараах, муу хүнд үхэх чөлөө олдохгүй, хоосон хүний зовлон хорь гуч.
15. **БАТАРЕЯ БУТЫЛОК** [*разг. шутл.*] Дан архины лонх, бөөн архины лонх.
    На столе стояла целая батарея бутылок Ширээн дээр (архины) лонх пиг дүүрэн өрөөстэй байв.
16. **БАТЮШКИ МОЙ** [*разг.*] Ээ тэнгэр минь, ээж ээ, ижий минь, хөх тэнгэр минь, ээ халаг, пээ (гэх зэрэг айх, цочих, гайхах мэтэст хэлнэ.)
    Батюшки мой, Народу-то, народу сколько собралось Тэнгэр минь ээ юун олон амьтан цуглачихаа вэ?
17. **БАШ НА БАШ** [*прост.*] Солио наймаа, юмыг юмаар арилжих битүүлэх, дүйх, гар гараасаа арилжих, хазаарын солио.
18. **БАШКА ТРЕЩИТ** Г-136
19. **БАШМАКОВ ОНА ЕЩЁ НЕ ИЗНОСИЛА.** Өнгөрсний өрхийг бүтээнгээ ерөөлийн өврийг хүсэв. Нүд анимагц нь негөөгөө даллав. Бие нь хөрөөгүй байхад бишдийг бодов.
20 **БАШНЯ ИЗ СЛОНОВОЙ КОСТИ** у г ч и л б э э с Зааны ясан цамхаг. У т г а н ь үнэнээс тасархай, ардын саналаас гадуур худал хуумгай, дээрээс унаж дэргэдээс ургасан юм шиг, цэцэгнээс дэлбэрсэн юм шиг.
21 **БЕГ НА МЕСТЕ** 1. Дороо алхах 2. Дэвс нь шинэ, дэр нь хуучин; хоосон яарах; 3. шээс алдах, доороо шээчих пахах, хий тэвдэж орхих, яараад яах ч учраа олохгүй, хий уймрах, учраа олохгүй хий дэвхцэх, арга нь барагдах (мухардах) дэмий тэлчлэх, бүтээсэн юмгүй таван махбодь нь шархирах,
22. **БЕГАТЬ БЕГОМ** Жолоо хумхилгүй, хар эрчээрээ, нэг амьсгаагаар, гүйхийн сайнаар гүй-, амы нь сул тавьсаар, хурд саалгүй, хар хурдаараа, хар эрчээрээ, эрчээрээ, тоос гозойсоор, шуурганд хөөгдсөн юм шиг.
23. **БЕГАТЬ ГЛАЗАМИ** Ийш тийшээ хара-, нүд нь орой дээрээ гара-, нааш цаашаа хара-, нүд гүйлгэ-, хараа гүйлгэ нүд билчээ-,хараа билчээ-, нүд сэлүүрдэ-, нүд шилбүүрдэ-.
24. **БЕГАТЬ НА КОНЬКАХ (на лыжах)** Тэшүүрээр тэши-, (цанаар гулга-)
25. **БЕГЛЫЙ ОГОНЬ** [*воен.*] Тушаал өгөөгүй байхад буудах, өрсөж хөдлөх.

    Бойцы открыли беглый огонь по противнику. Байлдагчид тушаал өгөөгүй байхад дайснаа буудав.
26. **БЕДА, БЕДУ, РОДИТ** Муугаас муу, модноос хөө, нэг дордоход долоо дордох, нэг бүдэрвэл долоо бүдрэх, гай нүүрлэх, уруудахад буруудах,оройтоход доройдох, үхэл дээр тахал, мууд муу нэмэр, муухайд улцан нэмэр.
27. **БЕДА В ТОМ, ЧТО**. . . . . нь зовлонтой, төвөгтэй. Золгүй тусгүй; яах ч аргагүй нь... хамаг зовлон нь..., хамаг гай нь...,
28. **БЕДА ВИСИТ НАД ГОЛОВОЙ** [*перен.*] Хэнсгоо хүлээх, балардгийн даваан дээр очих, хутганы ир дээр байх, амь дүйн, дэн дун дээсэн дөрөөн дээр, харцганд хөөгдсөн бялзуухай шиг болох.
29. **БЕДА, КАК** [*разг.*] их, тун, сүрхий,... -ийн ихээр...
    Беда, как надоело Залхахын ихээр залхлаа.
    Беда, как испугались (Тэднүүсийн) сүнс нь зайлчихлаа, мөн ч сайн цочлоо доо.
30. **БЕДА (страх, ужас) КАКОЙ** [*прост.*] Юу ч гэж хэлэх вэ дээ, их шиг, лут, сүрхий, энгүй, адвиш (бяртай, эртэй, зоригтой гэх мэтэст).
    Дед у нас ужас какой смелый. Манай өвөг эцэг мөн их шиг зүрхтэй хүн дээ. Зүрх гэж чулуу.
31. **БЕДА НЕ ПРИХОДИТ ОДНА** Уруудахад буруудах, нэг дордоход долоо дордох, муу хүний үхэл бямба гаригт, оройтоход доройтох, нэг бүдэрвэл долоо бүдрэх. Б-26
32. **БЕДА ОДНА НЕ ХОДИТ** Б—31
33. **БЕДА (страх, ужас)** СКОЛЬКО [*прост.*] Өдүй төдүй, муухай олон, булай олон, тоо томшгүй, түг таг тооны мухар.
34. **БЕДА УМ РОДИТ** [*прост.*] Нохой хамартаа хүрэхээрээ үсч, жаргахдаа мартсанаа, зовохдоо сэрэх, аминд тулахад арга олддог, амьд хүн арга олох (аргатай) бэрх цаг цөлх ухаан сийлүүлнэ.
35. **БЕДЕН КАК ЦЕРКОВНАЯ КРЫСА (мышь)** Хувхай доён бол, чөмгөө бар, чөмөггүй бол, модоо барих, таягаа тулах, тартагтаа тулгал ядуурах, уутаа гүвэх.
36. **БЕДНОСТЬ НЕ ПОРОК** [*посл.*] Ядуу гэдэг ял биш, хоосон гэдэг нүгэл биш; ядуугийн зовлон яая гэх вэ; ямар сайндаа
37. **БЕДОВАЯ ГОЛОВА (головушка)** [*прост.*] Сөс ихтэй хүн, зүрхтэй хүн, бөх зүрхтэй бүдүүн хүзүүтэй хүн, чулуу шиг зүрхтэй амьтан
38. **БЕДУ СКОРО НАЖИВЁШЬ, ДА НЕ СКОРО ВЫЖИВЕШЬ** Зовлон ирэхдээ амархан, арилахдаа удаан. Муу юм модон улаатай, сайн юм сарын явдалтай; эвдрэхэд амархан, эвлэрэхэд хэцүү; оройтвоос олоход хэцүү, доройтвоос сэхэхэд хэцүү; нүүрлэж ирсэн гай нүүгээд явна гэж үү; муу нэр хусавч арилахгүй, сайн нэр хүсэвч олдохгүй.
39. **БЕЖАТЬ ВО ВСЕ ЛОПАТКИ** Хөл мэдэн гүй-, хар гүйхээгээрээ дутаа-, ухаан жолоогүй арила-

Нам пришлось бежать во все лопатки чтобы не опоздать с поезда За бид нар ч хар гүйхээгээрээ л явааг үй бол галт тэрэгнээсээ хожигдсон шүү.

40. **БЕЖАТЬ, КАК ОТ ОГНЯ** зайл-, зугата-, ухаан жолоогүй, үстэй толгойгоо барин зугада- юманд хөөгдсөн юм шиг зугата-, түймрийн гал шиг, зовхи нь буу-, сүнс нь халн-, чононд хөөгдсөн хонь шиг.

Он боится правды и бежит от неё, как от огня. Цаатах чинь үнэн юмнаас л ухаан жолоогүй айдаг хүн дээ.

41. **БЕЖАТЬ, КАК ЧЁРТ ОТ ЛАДАНА** Ухаангүй ай-, ум хумгүй, **ухаан жолоогүй**; учир зүггүй ай-, сүнсгүй ай-, үнхэлцэг нь хагарах шаха-, Таван ухаан нь талд гартлаа ай-,

... **(мелкая буржуазия) боится дисциплины, организации, учёта и контроля, как чёрт ладана (Ленин, Очередные задачи советской власти)** . . . (жижиг хөрөнгөтөн) сахилга журам, зохион байгуулалт, тоо бүртгэл, хяналтаас ухаангүй айдаг (Ленин, Зөвлөлт засгийн ээлжит зорилт).

42. **БЕЖАТЬ СЛОМЯ ГОЛОВУ** Ухаан зүггүй зугата-, уурга зүүсэн морь шиг, ухаан жолоогүй зайлан одо-, мөрөө бууруул-, эмээлээ хөглүүлсэн морь шиг, аргамжаатаа тасдуулсан морь шиг, хаавхаа авсан чоно шиг тархиар нь татсан юм шиг; хулжсан морь шиг; ороо морь шиг.

43. **БЕЖИТ, КАК УГОРЕЛЫЙ** Ухаан сэхээгүй давхих, амь тэмцэн зугатах, хөл мэдэн зугатах, түймэрт хөөгдсөн юм шиг, юманд хөөгдсөн юм шиг; амь наана там цаана; муур үзсэн хулгана шиг; чоно харсан зээр шиг;

44. **БЕЗ ВЕДОМА** *чьего буюу кого* (надгүйгээр, чамгүйгээр гэх мэт) мэдэгдэлгүй, хэлэлгүй, асуулгүй.

Это сделано без моего ведома (Энийг) над мэдэгдэлгүй хийчихсэн байна билээ. (Надгүйгээр болчихсон байна билээ).

45. **БЕЗ ВЕСТИ ПРОПАСТЬ** Сураггүй бол-, чимээ тасра-, мөр алдаор сураггүй бол-, тэр чигтээ бол-, авах нь алга бол-, бараа туруугүй, сураг жажиггүй, таг чиг бол-, үхсэн юм шиг бол-, гэрээ мартсан гэсэр шиг; хайх мөргүй, харах бараагүй; газар доогуур орчихсон юм шиг. Н-631.

46. **БЕЗ ВИНЫ ВИНОВАТЫ** Буруугүй атлаа буруутах, нүдээ олсонгүй, идсэн чоно нь худраггаж, идээгүй чоно нь нударгдах, хилсдэх, тээрмийн хөлд буудай, зүгээр суугаад гэмгэн болох, тэмээний хөлд ямаа, хааны гэмийг гуянд, хаа нь бүдрэхэд гуяны нь данцуурдав гэгч.

47. **БЕЗ ВОЛЬНОСТЕЙ** Бага шиг задар, хирээ мэд, бяраа тань; битгий дураараа дурги; битгий золиг орги; битгий нарги, таарууxан шиг бай, хирээ мэдэж яв бяраа мэдэж өргө.

48. **БЕЗ ВСЕГО** [*разг.*] 1. Юу юу ч үгүй болох, хувхайрах (хуухайрах), хоосрох, таван болох, орох оронгүй болих үсгүй, модоон барих, уутаа гүвэх, хов хоосон, гар мухардаж хөл явга-

рах, орон алдах, үнсэнд хаясан шалз шиг, өнчин хоцорсон яһ зага шиг. 2. Дээлгүй нүцгэн дэлэвчгүй шалдан, чармай нүцгэн мохой нүцгэн гахай явган, шалдан, чарай нүцгэн,

После пожара много семейств осталось без всего. Түймрээс болж олон айл юу юу ч үгүй хоцорсон байв. **Он выскочил из горящего дома без всего.** (Тэр нэг эрэгтэй хүн) шатаж байгаа гэрээс нүцгэн гүйж гарав.

49. **БЕЗ** (безо) **ВСЯКОГО ПРЕКОСЛОВИЯ** [*устар.*] Үг дуугүй дагах, хүлцэн дагах, дөрлүүлсэн юм шиг, гүзээнд наалдсан дэлүү шиг, сүүдэр шиг.

50. **БЕЗ ГЛУПОСТЕЙ** Бүү дэмийр; битгий донгос галзуурав уу? Битгий тэнэгтэр; солиноров уу?

51. **БЕЗ ГОДУ НЕДЕЛЯ** (неделю) [*прост., ирон.*] Ахар хугацаанд, удаж шалигүй, хэд хоног, хоёр нэг хоног, гялс гэзэл, сав саяхан

У нас он работает без году неделя (Цаатах чинь) манай энд ажиллаад удаагүй байгаа юм (удаж базаагаагүй).

52. **БЕЗ ГОЛОВЫ** Цул толгойтой; юм боддоггүй; ухаан муутай, мунгуу; эргүү; мэнгуу, усан толгой; битүү мах; махан толгойтой

53. **БЕЗ ГРОША** (**в кармане**) [*разг.*] (өвөртөө) сохор зоосгүй, **гроша** газрын санхүү (данс нь улайх) улаан мөнгөгүй, гуя ганзагалах, данс дугуйлах.

Приехал он (уездный врач) в город без гроша денег Тэр эмч (шинэ оточ) хүний урманд өвөртөө сохор зоос ч үгүй хотод иржээ.

54. **БЕЗ ДАЛЬНИХ СЛОВ (разговоров)** [*разг.*] Илүү ярианы хэрэггүй, ярианд байх юм алга, олон үгэнд олзгүй, үгийн олноос үхрийн слоп дээр, үг олдож үхэр холдлоо.

55. **БЕЗ ДУШИ** 1. *от кого-чего* [*разг.*] Сүнсгүй хайртай, ухаангүй хайртай, амь хайрлах, их дуртай, голт зүрх, боддог нь..., мөрөөддөг нь ..., зүүдлэхээ шахдаг... 2. Ухаан сэхээгүй, **ухаан жолоогүй**, ум хумгүй.

56. **БЕЗ ЗАБОТ** Хөл жийх, саная амар, айван тайван, амар жимэр, нам жим, айх ичих юмгүй, саная зовох юмгүй, жаргалаа эдлэх.

Жить без забот Амар жимэр аж төрө-(суу-.)

57. **БЕЗ ЗАБРАЛА** С—100

58. **БЕЗ ЗАДНИХ НОГ** (без ног) [*разг.*] Сүг болох, сүгтээ тулах, сүгтээ унах, их ядрах, мах болтол ядрах, шалдаа буух, тартагтаа тулах, (морь бол) үстэй чулуу болох, эцэж туйлдах, улдах, сөхрөх. Б-72.

Я не привык ходить пешком и на третьем километре чувствовал себя уже без ног. Явган явж сураагүй болоод би ч гурэвхан километр явав уу үгүй юу л хоёр хөл тасраад ойчих гэж байгаа юм шиг л ядарчихлаа.

59. **БЕЗ ЗАЗРЕНИЯ СОВЕСТИ** [*разг.*] Хүний үнэргүй, чоно үсэн үг, хүний мөсгүй, хүн шиг юм биш; ёсон бус, ичих нүүрээ барсан, юман чинээ бодохгүй, ичгүүр сонжуургүй, улаан цайм

ичих нүүрэндээ илэг наасан, нэр нүүрээ барсан, цагаандаа орсон (гарсан, буусан), улайхдаа тулсан.

Без зазрения совести убил человека Хүн алж байгаагаа юман чинээнд ч бодохгүй байна шүү (хүн алахдаа сийхгүй.)

Без зазрения совести воровать общественные деньги. Олны мөнгөн сангаас ичих нүүрээ барсан юм шиг хулгана шамшин-

60. **БЕЗ ЗАПИНКИ** Түгдрэхгүй, цуурай шиг, шүлэг шиг, бэлэн зэлэн, торохгүй; хүн зааж өгсөн юм шиг, бэлхэн, цээжтэй.

Ответить без запинки Түгдрэхгүй (бэлхэн, торохгүй) харилца-

61. **БЕЗ КОНЦА** [*разг.*] Хэзээ нэг цагт, хэзээ ямагт; дуусгавргүй, шувтрагагүй, тасралтгүй, зугаагүй, зогсоо зайгүй, үргэлж, адаггүй, чөлөөгүй, хязгааргүй.

Крику, шуму, веселья было без конца (Гончаров) Зогсоо зайгүй орилоон чарлаан инээд ханиад болж сонсдов.

62. **БЕЗ КОРНЯ И ПОЛЫНЬ НЕ РАСТЕТ** Овоо босгоогүй бол шаазгай хаанаас суух вэ? Дэгдэж сураагүй нисч сурахгүй, явж сураагүй гүйж сурахгүй.

63. **БЕЗ КРЕСТА** Хөөн дотортой, хар санаатай, ёс төргүй, үмхий санаатай, сэтгэлдээ мөстэй, санаа гэж жинжүү сахал гэж туужуу, хивцгий догшин, дотуур тамиртай, зан гэж зараа.

64. **БЕЗ ЛИЧНОСТЕЙ** Хувиа хичээ; хүний явдал хүнд хамаагүй, урт хошуу хүзүү ороono, урт хормой хөл ороono; зам замаараа; чам хүртэл яриагүй, хаяа хүртэл жийгээгүй; чамд хамаагүй, хаданд чимээгүй, хөндлөнгөөс хөгнөө, хөхүүрнээс айргаа; хөндлөнгөөс хөлөө, хөгшөнд хүзүүгээ, чамд хамаагүй, хаданд ямаагүй;

65. **БЕЗ МАЛА** Б—66.

66. **БЕЗ МАЛАГО** (мала) Бараг, дөхүү, шахуу, шахам, хиртэй, алдын, хирийн, орчим,... гаад..., багцаааны, дайны, дайтай, анзааны, хавилдуу.

Без малого сто рублей Нэг зуу хиртэй төгрөг.

67. **БЕЗ МЕНЯ МЕНЯ ЖЕНИЛИ** [*прост., шутл.*] Намайг эзгүй хойгуур тэгэж (ингэж). Эзгүйчлэх, бөгс ухах, үхлээ гэж бодоо юу.

68. **БЕЗ МЕРЫ** Үй түмэн, эх захгүй. тоо томшгүй, хэмжээ хирээгүй, хэмжээ дамжаагүй, нүд алдам, барьцгүй.

69. **БЕЗ МИЛОСЕРДИЯ** Энэрэлгүй, өршөөлгүй, харгис, хэрцгий, нинжгүй, алж шудахын одонд төрсөн

70. **БЕЗ МЫЛА (в душу) ВЛЕЗЕТ** (лезть) [*разг.*]

71. **БЕЗ НИКАКИХ** [*прост.*] Яриагүй, эргэлзээгүй, эргэлтгүй,...ээс зайлахгүй, эгнэгт, ямар ч гэсэн; Шууд, эрээлж бараалалгүй, эрээ цээргүй, айж ичилгүй, ичиж зоволгүй.

72. **БЕЗ НОГ** Б—58.

73. **БЕЗ НОЖА ЗАРЕЗАТЬ** (резать) [*разг.*] дуусч үхэ-, сүйд болго- (хий-), зөөлөн гараар бодий нь хөтлө-, балла-, махла-, амьдаар нь ала-, цусгүй ала-, голд нь хүрэ-, голы нь самна-, голы нь гогодо-.

Если вы не приедете во время, вы меня без ножа зарежете. Та яг цагтаа ирэхгүй бол намайгаа амьдаар нь алчихна шүү.

74. **БЕЗ ОБИНЯКОВ** (говорить, сказать, заявить и т. п.) Хэлбэл хийгүй, эм зангүй; хэлсэн үгэндээ эзэн, идсэн хоолондоо сав; түс тас, шулуухан, илэн далангүй, эршүүд, палайтал, гүндүүгүй, гоёчилдоггүй, хуурмагладаггүй; за гэвэл ёогүй; гүдэсхэн; засваргүй

75. **БЕЗ ОГЛЯДКИ** 1. Ухаан жолоогүй, ум хумгүй, хар хурдаараа эргэж ч харахгүй (давхих, хурдлах). 2. Долдой, гоомой, омтгой, хааш яйш, учры нь ололгүй. 3. Байдгаараа, чадах ядахаараа. 4. Эрс, эргэлзээгүй, иймээ тиймээгүй, эргэж буцалгүй, эргэж хургалгүй, дүлэгнэлгүй, бөөрөнхийлөлгүй,

Бежать без оглядки Ум хумгүй давхи-

Я не такая мать, я без оглядки. Ничего не сделаю (А. Островский) Би тийм хайнга алмай эх хүн биш шүү.

76. **БЕЗ ОКОЛИЧНОСТЕЙ** Шулуун шууд, ил, ний нуугүй, элдэв туухай юм бололгүй.

77. **БЕЗ ОТДАЧИ** Эргүүлж өгөх барих гэлтгүй, бүр ав, өгч байгаа юм, чиний юм гэж бод, өөрийн юм гэж бод, чиний хувь.

78. **БЕЗ ОТКАЗА** 1. Дураараа (санаснаараа), хичнээн л бол хичнээн, 2. Давгүй, дажгүй, сайхан, дураараа болох, дургих, тэвөөгүй.

Живя на молочной ферме, я пил молоко без отказа. Би сүүний аж ахуйханд байхдаа сүү гээчийг гэдэсний хээ хирээр (гэдсээ цодойтол, гээгээ модойтол) ууж байв аа.

Машина действует без отказа Машин давгүй (санасанчлан) хөдөлж байна,

79. **БЕЗ ОТМЕТИНЫ** Өвч, цулгуй, цул, нүдгүй, нэг өнгийн

Конь вороной без отметины Хилэн хар морь

80. **БЕЗ ОТЧЁТА** буюу **НЕ ДАВАЯ СЕБЕ ОТЧЁТА** Бодлогогүй, ийм тийм юм болно гэж саналгүй, тоогүйдэх, санаандгүй, өөрийн эрхгүй, зүгээр л, тэгэс ингэс гэлгүй, гэнэ сэнэгүй, мэдэхгүйн эрхээр, томоогүйтэх, барьцгүйтэх, хойтохы нь бодсонгүй, гэндэх, хэрсүү дутах, хаширлаагүйгээс.

Не давая себе отчёта, я размахнулся и ударил его Тэгчихээ ингэчихээ ч гэсэн юмгүй (олон таван юм ч бод сонгүй) далайгаад цохичихсон хэрэг.

81. **БЕЗ ПАМЯТИ** [*разг.*] 1. Ухаангүй, үнэн голоосоо, голт зүрхнээсээ, хөл малгайгүй, ухаан жолоогүй. 2. Амь наана там цаана; санд мэнд,

Я вас без памяти люблю (Грибоедов) Би чамд үнэн голоосоо хайртай шуу.

Я вижу, ты от неё без памяти Чи тэр эмэгтэйд унаж гүйцээ шивдээ. (Харваас чи тэр бүсгүйн мөрөөсөл бол жээ).

Они бежали без памяти Тэд амь наана, там цаана харайлгав.

Раненый лежал без памяти Шархтан ухаангүй хэвтэж байв (шархтан хүн муурчээ) муужирчээ.

82. БЕЗ ПАСТУХА ОВЦЫ НЕ СТАДО Азаргагүй адуу шиг; Эх муутын бөгс бүдүүн, эцэг муутын хүзүү бүдүүн; хүн ахтай, дээл захтай,ах нь дүүгээ сургадаг, мянган толгойтой нэг сүүлтэй (могой); ах нь сургаж дүү нь сонсдог, ам нь идэж сүүл нь таргалдаг.

86. БЕЗ ПЕРЕСАДКИ нэгэн үзүүрт сэтгэлээр, шув шулуун, олон таван санаагүй, чиглэсэндээ л, гар татганахгүй

84. БЕЗ ПРИЗОРА [*разг.*] Эзэнгүй, өнчин ишиг язгага шиг, харж хандах хүнгүй, үнсэнд хаясан шалз шиг, (**дети**) золбин

Не оставляйте детей без призора Хүүхдийг эзэнгүйтүүлж (ганцааранги нь маллах, (асрах) хүнгүй, харж хандах хүнгүй) бүү орхигтун.

85. БЕЗ ПРОСЫПА Дагт,дагнан, дандаа, ямагт, байнга, өдөр шө нөгүй, хоёр нарны хооронд, Ярихын аргагүй, мэдэх янзгүй ай хавтар, ухаангүй, мэдээ сэхээгүй, найгүй, мал болтлоо.

86. БЕЗ ПУТИ Оргүй, хоосон

87. БЕЗ ПЯТИ МИНУТ *кто* Бараг л, даваан дээр, юу юугүй, харнугүй нохойн дуу ойртох, ганц хуруу дутуу, ... гээд л байгаа.

88. БЕЗ РАССУДКА (рассудку) [*разг.*] хаангүй, дураараа дургиж, дунд чөмгөөрөө жиргэх, хэлэх хайх хүнгүй, намайг хэн хэлэх вэ, нохойг хэн саах вэ; хэлэх нь миний дур, хийсгэх нь тэнгэрийн дур; бодлогогүй, юу ч тоохгүй, зоргоороо, нүдэн балай чихэн дүлий; тэрээ энээ гэлтгүй.

Коль любить, так без рассудку Садагналаа л бол, сайн мууг хэлэлцэхгүй болох нь тэр.

89. БЕЗ РОДУ, БЕЗ ПЛЕМЕНИ *буюу* **БЕЗ РОДУ И ПЛЕМЕНИ** Гон бие гозон толгой,нааш харах хүнгүй, доён, ах дүү-төрөл садангүй, удам сударгүй, уг удамгүй, язгуур бүгт, эрэг шорооноос гарсан мэт, галын ганц цуцал мэт.

Она девушка бедная, без роду, без племени Ах дүү, төрөл садангүй (түших тулах хүнгүй), ядуу зүдүү хүүхэн дээ хөөрхий.

90. БЕЗ РУЛЯ И БЕЗ ВЕТРИЛ [*ирон.*] Салхин дэвүүр савдаг элээ; дороо сууригүй дотроо бодлогогүй; галзуугийн аманд гараа, хөлчүүгийн аманд хөлөө; цог үмхэж чоно зайдалж мэдэх; цайчихсан амьтандаа, зорьсон зорил, санасан саналгүй; жолоогүй, хамхуул шиг, хий хуар, хайнга хуунга дөргүй, чиг баггүй.

В рядах нашей молодёжи вы не найдете скитающихся без руля и без ветрил Та манай залуусын дундаас зорьсон зорил санасан саналгүй ийм хүн олохгүй.

91. БЕЗ СЕРДЦА Мөсөн дотортой, хүйтэн санаатай, өөрөөрөө зүйрлэдэггүй, хатуу сэтгэлтэй, чулуун зүрхтэй, цэвдэг сэтгэлтэй, өр нь нимгэрээгүй, хүний арьсанд нохойн мах чихсэн, хүнийг хэлэхдээ хүрэн эрээн бүргэд шиг.

Гадкая, отвратительная женщина, без сердца—сказала мать (Л. Толстой) Хатуу сэтгэлтэй, өөдгүй муу эм гэж ээж хөөрөв.

92. БЕЗ СМЕХУ [*разг*] Инээх ч юмгүй, чамд инээд надад ханнад, хаа хаа хээ хээ ч гэх юмгүй,инээх юм биш, тоглоом тохуу биш.

93. БЕЗ СПОРА *буюу* **БЕЗ СПОРУ** [*разг*] Иймээ тиймээ гэх юм алга, яриангүй, хэлцээнгүй, ийн уунгүй хэл амгүй, хэрүүл цуугиантүй, чих хангинуулах (хэл ам цуулах) юмгүй.

94. БЕЗ СУЧКА И ЗАДОРИНКИ *буюу* **БЕЗ СУЧКА, БЕЗ ЗАДОРИНКИ** [*прост.*] Онгод нь орсон юм шиг, булуу нь халах, юу болов гэмээр..., сайн дур нь хүрэх, хөөрчихөж

95. БЕЗ СЧЁТУ Тоогүй, тоолшгүй, аймайгүй, тоо томшгүй, үй түм, өдүй төдүй, тоймгүй, газрын үндэс тэнгэрийн од

Охотники набили зайцев без счёту Анчид тоймгүй олон туулай алжээ. (Анчид туулай гэдгийг хядчихжээ.)

96. БЕЗ ТОГО Тэртэй тэргүй, угаасаа

97. БЕЗ ТОЛКУ хамаа намаагүй, эх захгүй, учир жанцангүй, ундуй сундуй, эв дүйгүй, олиггүй, нэмэргүй.

98. БЕЗ ТРУДА НЕ ВЫНЕШЬ И РЫБКУ ИЗ ПРУДА Гар хөдөлбөл ам хөдөлнө. Нохой алжуу бол баас олж идэхгүй. Гар хөдлөхгүй бол ам тосдохгүй, зовохгүй бол зоос олохгүй, зодохгүй бол ном сурахгүй.

99. БЕЗ ТРУДА НЕТ ОТДЫХА Эзэн хичээвэл. заяа хичээнэ. Жаргая гэвэл зов.

100. БЕЗ УДЕРЖУ [*разг.*] Тэснэ тэснэ гэхэд яаж тэсэх вэ? Тэвчээр алдан, өөрийн эрхгүй, тэсэлгүй, тэвчилгүй, яаж ч чадалгүй биеэ барилгүй, салхин дүүгүүр шиг.

Дулма плачет без удержу Дулмаа тэсэлгүй уйлав.

Без всякого удержу Яаж ч чадалгүй, түрүүлж дуугарсан хөхөөний ам хөлдөнө. (Цаасан дарцаг шиг.)

101. БЕЗ УЗЛОВ ЖИТЬ Өө сэвгүй, яг таг (хий-), өөлөх өөгүй,өрвийх сэвгүй, жин тан бол-

102. БЕЗ УМА (быть) 1. Урмас хөгжөө- 2. Арааны шүлс асгара-, 3. Хорхой хүрэ-; ухаангүй (сонирхо-, дурла-, нүд хужирла-, магта-), шагши-, их шохоорхо-, аманд нь орчих шахалүүхэд юм чагна-, сонор мялаачих тавин, амьсгаа даран, нүд бүлтийн чих дэлдийн

От твоих прелестных песен все без ума Таны яруухан сайхан хоолойг амьтан бүр шагшнам.

Все мужчины, посещавшие её дом, были от неё без ума... (Тургенев) Тэднийд ирсэн харцуул (тэр эмэг-

тэйг) ухаангүй шохоорхдог (хараа салгаж чаддаггүй) байв. (Морьтой хүн бууж хармаар, явган хүн сууж хармаар, туурга нэвт туяатай дуран хар нүдтэй хүүхэн гэдэгтэй төсөрхүү санаа), бууж мордсон бүстэй хүн хэн боловч эрхгүй тэр эмэгтэйг хүсэхгүй нь үгүй.

103. БЕЗ УСТАЛИ зогсоо зайгүй л, үргэлж л;... саар, сээр, уйгагүй цуцалгүй,

Без устали повторять одно и тоже Домогтоо улигласаар, далан долоо дахих, нэг үгээ арван гурав дахих, өнөө л ярьдгаа л үглэсээр л, улигтаа домоглосоор

Мы все работаем без устали Бид нар эцэж цуцахаа мэдэхгүй ажиллаж л байна.

104. БЕЗ УЩЕРБА *для кого чего* Хор хүргэхгүйн тулд, ... -уулахгүйн (-үүлэхгүйн) тулд, хохироохгүйг хичээн, алдагдалгүй, гай тарихгүй, төвөг удахгүй, ажил удахгүй, яршиг болохгүй. халгүй.

Без ущерба для здоровья Биеэ муутгахгүйн тулд

105. БЕЗ ХОЗЯИНА ДВОР И СИР И ВДОВ [*посл.*] Эзнээ алдсан, эзэнгүй хонинд чоно орох мэт, өрхийн тэргүүлэгч эзгүй айл азаргагүй адуу лугаа адилхан. Хэлхээ тасарсан эрх шиг, талаар тарсан хонь шиг, цацсан будаа шиг.

106. БЕЗ ЦАРЯ В ГОЛОВЕ [*разг.*] Ухаан сэхээ муутай, ав живгүй, унтарсан галд урагүй, толгойд нь элс чихсэн юм шиг мулгуу тулгуу, донгио, ухаанд нь ухна үхсэн, сэхээнд нь сэрх үхсэн, айхын бараа, идэхийн нэмэр, хүнээс цаашгүй, усан тэнэг, адгуус шиг, сарлаг шиг, үхэр шиг, ухаан нь уландаа орсон.

Ты человек без царя в голове, стало быть, должен слушаться, когда тебе говорят. Чи ухаан сэхээ муутай хүн, хүн амьтны хэлж байгааг сайн гэгч нь чагнан авч байвал таарах байлаа (Усан тэнэг минь хүн юм хэлэхэд дүлий дүмбэ шиг байж болдоггүй юм).

107. БЕЗ ЦЕРЕМОНИИ цэрвэх явдалгүй, ёсорхохгүй, эрээлэхгүй, хээгүй, эрээ цээргүй, нэрэлхэхгүй хороолгүй, хямсайлгүй, цэрвэлгүй, цээрлэж паарлалгүй, нэрлэж бараалалгүй, эр хүн эрээгүй нь дээр

108. БЕЗ ЧИНОВ өөриймсүү, хүнийрхэлгүй, ёсорхохгүй, дураараа, эрээ цээргүй, эх захгүй; дээрээ дэлгүй, доороо сүүлгүй, ах захгүй, айж ичихгүй; нд нд гэхэд тамшаалах нь эвгүй, ор ор гэхэд шагайх нь эвгүй.

109. БЕЗ ЧИСЛА тоо томшгүй, үй түм, нүд эрээлжлэм, багцаалахын эцэсгүй, тоо алдсан, учир тоймгүй, хир хэмжээгүй,учир начиргүй, шарсан мах анддаггүй шар зурхайч будилмаар.

110. БЕЗ ШАПОК [*разг*] толгой нүцгэн, толгой дээрээ юмгүй.

111. БЕЗ ШУТОК К—542

112. БЕЗ ЯЗЫКА үгний солиогүй, дуугарах тэнхээгүй, хэл нь татах, хэлгүй болох.

113. БЕЗВЕСТНОЕ ОТСУТСТВИЕ [*стих.*] Нүдэн далд, ор сураггүй болох, мөр алдах, чимээ тасрах, бараа туруугүй, тоос нь харагдахгүй, чихэнд дуулдахгүй, нүдэнд үзэгдэхгүй.

114. БЕЗГРЕШНЫЕ ДОХОДЫ [*ирон.*] Хахууль авах, бэлэн зууш, барьц тавьц авах, гар харах

115. БЕЗДНА (кладезь) ПРЕМУДРОСТИ [*шутл. ,ирон.*] Үлгэргүй эрдэмтэн (эрдэмтэй), эгэлгүй эрдэмтэй, ижилгүй эрдэмтэй, эрдмийн далай, билгийн далай бичгийн багш, эрдмийн тулам, хосгүй ухаантан, суу билэгтэн,

116. БЕЗДНА РАЗВЕРЗЛАСЬ ПОД ЕГО НОГАМИ [*перен*]. Мохрох, мухардах, гарах замгүй болох, ягтах, цөхрөх, арга тасрах, арга барагдах, яцан шаанд орох, хаашаа ч үгүй болох.

117. БЕЗДОННАЯ БОЧКА [*перен., шутл*] Ангасан монголын үнээ шиг, ёроолгүй юм шиг, бүрхээр шиг, ёроолгүй хувин, сувидаг, тэнэмгий, их уудаг, цадахаа мэддэггүй, цаддаггүй бор ходоод (хүүхэд), мангас шиг, идэх тусам араа нь халж өмсөх тусам мөр нь халж, хоолны хэнхэг, хэнхмэл.

118. БЕЗДОННУЮ КАДКУ НЕ НАПОЛНИТЬ Бүтэшгүй юм, харганы ноосоор эсгий хийх, ёроолгүй хувингаар ус ав-, эр үхэр сааж элгэн тараг бүрэ-, санаад санааны гарз, санахын халцгай, чоно махнаас гара-, санаад санаад сачий хүрэхгүй, нэгэн төрөлд хүйс хувира-, санасаар яваад сарьсла-, сэрчихгүй бол сайхан зүүд,

119. БЕЗЗУБАЯ КРИТИКА Ултасан шүүмжлэл, бохно шүүмжлэл, хавтгай шүүмжлэл, шүүмжлэл гэхээс цаашгүй.

120. БЕЗОБЛАЧНОЕ СЧАСТЬЕ Энх жаргал, энх тунх

121. БЕЗОПАСНАЯ БРИТВА 1. Мохоо тонгорог, ир амгүй тонгорог, дөш болсон тонгорог, ир мөр нь мэдэгдэхгүй тонгорог, билүүнд хүрээгүй тонгорог. 2. Үсний тонгорог.

122. БЕЗУЗДЫЙ САВРАС С-169

123. БЕЗЫМЯННЫЙ ПАЛЕЦ Ядам хуруу; нанчид өргөдөг, ариун хуруу, бичиг наадаг, хиргүй бэргэн

124. БЕЙ ВРАГА ВИНТОВКОЙ, БЕЙ И СНОРОВКОЙ Идэмхий дайсантай ирт мэсээрээ ч далайн тулалд, идэт ухаанаа ч гарган үзэлц; эр биеэр ч үз, ирт мэсээрч үз; эзэн хааны хайрласан ирт мэсээрч үз, эзэж аавын хайрласан эр биеэр ч үз.

125. БЕЛАЯ ВОРОНА Цагаан хэрээ, хүн хүнээс этгээд мужийн амьтан, гаж буруу, зөрүү мугуйд, ад үзэгдсэн амьтан, нүдэнд орсон хог, шүдэнд орсон мах. Хүнээс гадуур тэмээнээс гэдгэр амьтан. Б-135

126. БЕЛАЯ ГОРЯЧКА Архины галзуу, архины цагаан солио.

127. БЕЛАЯ КОСТЬ [*устар*] Цагаан ястай, тэнгэр язгууртай, алтан ураг, удам сурвалжтай, дээд заяаны, сайн заяаны.

128. БЕЛАЯ НОЧЬ Сүүн шөнө, туйлын шөнө, цагаан шөнө.

129. БЕЛЕНЫ ОБЪЕЛСЯ [*разг. прост.*] Солиорсон, цагаан солиотой, галзуурсан юм шиг, догшров, агсрав, агсамнав.

Испугался старик, взмолился: «что ты, баба, белены объелась?» (Пушкин) Өвгөн цочоод наманчлан «Үгүй, чавганцаа чи чинь яаж байна аа? Солиоров уу?» гэв. К-45

130. **БЕЛОЕ ДУХОВЕНСТВО** Сангийн лам

131. **БЕЛОЕ МЯСО** (Тугал, унага,хурга, загас, тахиа зэргийн) зөөлөн мах. Нялх малын мах, зулбадайн мах.

132. **БЕЛОЕ ПЯТНО (место)** Үгнилбээс цагаан толбо судлаагүй (юм) газар, хоосон зай, сул газар, онгорхой хоосон чөлөө

133. **БЕЛЫЕ МУХИ** Тэмээн туйлаадас

134. **БЕЛЫЙ БИЛЕТ** [*устар.*] (Цэргийн албанаас) хэлтрүүлэх үнэмлэх. Цэргээс халагдсан бичиг

135. **БЕЛЫЙ ВОЛК** Б—125

136. **БЕЛЫЙ КАК ЛУНЬ** Азай буурал, мөнгөн буурал, цал буурал

137. **БЕЛЫЙ (божий) СВЕТ** Нарт ертөнц, замбуулин, замбатив, өнгөт ертөнций, ертөнц орчлон, хорвоо, бөөрөнхий орчлон, дэлхий дээр, газар дээр, нарт замбуулинд

На белом свете не найти другой красавицы такой Энэ ертөнцөд үүн шиг гоо сайхан хүүхэн байхгүй (олдохгүй). (Хорвоод хосгүй)

138. **БЕЛЫЙ УГОЛЬ** Ус, усны хүчин

139. **БЕЛЬМО В (на) ГЛАЗУ** К-47

140. **БЕЛЬМО НА ГЛАЗУ** К-47

141. **БЕНГАЛЬСКИЕ ОГНИ** 1. Хөх дөл, хөх гал; 2. Сүүмэг гал, сүүмэн гал 3. Чөтгөрийн гал; 4. албины гал

142. **БЕРЕГИ ДЕНЕЖКУ ПРО (на) ЧЁРНЫЙ ДЕНЬ** [*посл.*] Барж идэхээр мэрж нд,

143. **БЕРЕГИ ПЛАТЬЕ С НОВУ, А ЧЕСТЬ СМОЛОДУ** [*сказ.*] Хувцсыг шинээс нь нэрийг залуугаас нь; нэр хугарахаар яс хугар, хүн нэрээ тогос өдөө, хүн болох багаасаа, хөлөг болох унаганаасаа;

144. **БЕРЕГИСЬ БЕД ПОКА ИХ НЕТ** Айж явбал аминд өлзийтэй, жаргах цагт зовлонг сана; жаргалдаа бүү ташуур.

145. **БЕРЕДИТЬ ДУШЕВНУЮ РАНУ** Б-146

146. **БЕРЕДИТЬ РАНЫ (сердечные)** [*перен.*] Сэтгэлийн шархыг хөндө-, сэтгэлийн зовлонг сэдэ-, мартсан гунигийг сэргээ-, сэтгэлийг зовоо-, сэтгэлийг хөндө-.

Не бередите раны матерей, дети которых погибли в прошлой войне, разговорами о возможности новой войны. Шинэ дайн дэгдэх, барих гэж ярьж, өнгөрсөн дайнаар үр хүүхдээ алдсан эхчүүдийн санаа сэтгэлийг үймээгээд яах нь вэ.

147. **БЕРЕЖЁНАЯ КОПЕЙКА РУБЛЬ БЕРЕЖЁТ** [*посл.*] Дуслыг хураавал далай болдог, дуулсныг хураавал эрдэмтэй болдог; зүү хураавал сүх болдог, сүх хураавал сүм болдог; нэгээс мянга, хураасан нь баян, тараасан нь доён.

148. **БЕРЕЖЛИВАЯ АГНЕСА** Аривч, гамтай

149. **БЕРЕГИСЬ КОЗЛА СПЕРЕДИ, ЛОШАДИ СЗАДИ, А ЛИХОГО ЧЕЛОВЕКА СО ВСЕХ СТОРОН** Муу хүнтэй нөхөрлөвөл могойн хорлол, эр хүнийг итгэхээр эрхий хуруугаа итгэ. Айж явбал аминд тустай.

150. **БЕРЕЗОВАЯ КАША** Б—151

151. **БЕРЁЗОВАЯ ЛАПША** Ташуурдах, жанчих, бэрээдэх, торлогдох, таван салаа боов, татам бурам идэх, маханд нь хэлэх, алгаар хэлэх.

152. **БЕРЕЧЬ, КАК ЗЕНИЦУ ОКА** Амь мэт хайрлах, энхрийлэн нандигнах, өндгөө дарсан шувуу (бүргэд) шиг хамгаалах, утсан чинээ улаан гол шигээ хайрлах.

153. **БЕРЕЧЬ** *чье* **САМОЛЮБИЕ** Дургүйг нь битгий хүргэ, аяы нь дагуулах, юу сайхан дур сайхан; албадахаар илбэд. Дургүй ламыг дарж байж сахил хүртээх-гэгч шиг бүү хий. Дургүйд хүчгүй, дуры нь дагуул.

154. **БЕРИСЬ ДРУЖНО, НЕ БУДЕТЬ ГРУЗНО** Цувж явсан бараас цуглаж суусан шаазгай дээр; эвийн үзүүрт тос, ховын өвөрт цус; арааран нийлэхээр өврөөрөө нийл; эвээ нэг хий, эвээ хоёр хий; эвгүй бол эвдэрхий хүрээ, эвтэй бол нэвтэршгүй цайз; эвлэвэл бүтнэ, ховловол гутна; эвт шаазгай буга барина.

155. **БЕС (господь, аллах, черт, леший, шут, пес, хрен) ЕГО (тебя, ее, вас, их) ЗНАЕТ** Б-244

156. **БЕС ЗНАЕТ** Б-242

157. **БЕС МЕНЯ ДЕРНУЛ** [*прост.*]. Сүнс минь зайлав, таван ухаан минь талд гартал айв; оройны минь үс босов. Л-67

158. **БЕС (нелегкая) НОСИТ (унес)** *кого* [*прост*] 1. Хаашаа алга болж хоцров. Хаашаа тэнээд алга болчихоо вэ? Ямар эрлэг нь аваад арилав. 2.Арилж өглөө, шилий нь харлаадаа,ашгүй нэг далд орлоо.

159. **БЕС ПОПУТАЛ** Ч-79, В-933,

160. **БЕС С НИМ** Ч-82

161. **БЕСА ЛЫСОГО** Ч-75

162. **БЕСЕДА НЕ ВЯЖЕТСЯ** [*разг.*] Ярна таарахгүй, хэл амаа мэдэлцэхгүй, мэндийн харилгүй, үг нийлэхгүй, арааран нийлэх, зээр гэхэд бөөр, тэмээ гэхэд ямаа гэлцэх

163. **БЕСИТЬСЯ С ЖИРУ** [*разг.*] Илжиг модон худрагандаа, хүн жаргал даахгүй (зовлон даадаг), жаргалд ташуура-; өөх өгсөн хүнтэй өглөө босоод заргалда-, булгаар илэхэд уйлж, булаар жанчихад инээ-, зөв нь буруудаж, зөөлөн нь хатууда-, тамын амьтан тамдаа жаргалтай, нигэж байх нь таарсан, жаргалтай газар хүн тогтохгүй, өвстэй газар мал тогтохгүй.

164. **БЕСОВСКОЕ НАВАЖДЕНИЕ** [*устар., прост.*] ад адлах, элиг, сигод чөтгөд

165. **БЕСПЛОДНАЯ СМОКОВИЦА** Сувай, сувай эм, хуурай, үргүй

166. **БЕССЛОВЕСНАЯ РОЛЬ** (*жүжигт*) дуугүй жүжигчин

167. **БЕС СМУЩАЕТ** (мутить, попутал, овладел и. т. п.) Донтой болох, дон нэхцэх, дон (ад) шүглэх, донтох

168. **БЕССМЫСЛЕННЫЙ ВЗГЛЯД** Гөлрөн харах, гөлийсөн харц, мэлэрсэн нүд, зэргэлээ харж байгаа юм шиг

169. **БЕССТРУННАЯ БАЛАЛАЙКА** (*пренебр.*) Үглээ хүн, нуриа хүн, нойтон хамуу шиг ярианай хүн. Яншаа хүн, гоншгоног байдаг хүн, үгээр аргамждаг (чалчаатах), цагаан хөөс нь цахрах; чихний чийр, улиг домог, нэг ярьснаа арван гурав дахих, нэг ярьснаа далан долоо дахих.

170. **БЕССТЫЖИЕ ГЛАЗА** (*бран.*) Ичих нүүрэндээ илэг наасан амьтан, ичихээ байсан гайхал, нүд улаан мөнгө цагаан.

Ах ты, бесстыжие глаза, как ты смеешь так говорить Чи чинь яасан ичих нүүрэндээ илэг нааж айх нүүрэндээ адсага наасан амьтан бэ. Яаж ийн зүрхлэж хэлнэ вэ.

171. **БЕСЦЕННАЯ ПОСЫЛКА** Бэлэгийн морины шүдийг татдаггүй.

172. **БЕШЕНАЯ СКОРОСТЬ** Айхавтар хурдан, сүрхий хурдан, галзуутай хурдан, хар хурд, хуй салхи шиг хурдан, юманд хө гдсөн юм шиг.

173. **БЕШЕНАЯ ЦЕНА** Үнэ гэж галзуу, тархиар татам үнэтэй, хадсан үнэтэй, хирээс хэтэрсэн үнэтэй, амин сүнс, амлашгүй үнэ, үнэ гэдэг үнэмлэхүй, дааж давашгүй үнэ, толгойтой үсээ тоолж өгөөд ч дийлэхгүй, гэрээрээ нүүж очоод ч дийлэхгүй, амандаа орсныг хэлэх, тэнгэрт тулсан үнэтэй.

174. **БЕШЕНЫЕ ДЕНЬГИ** Буяны бус хөрөнгө (*олбор*)

175 **БЕШЕНЫЙ СКАЧОК** (дулааны хэмжээ, юмны үнэ зэрэг) суга нэмэгдэх, гэнэт ойх (цойлох), үнэ хадах, биегүй үнэ, цог шиг цонгох, халуу дүүгэх.

176. **БИБЛИОГРАФИЧЕСКАЯ РЕДКОСТЬ** Ховор ном, чухаг ном, хосгүй ном судар, газар дээр ганц (хоёр) ном, цоохор цаас биш, ертөнцөд ховордсон.

177. **БИЕНИЕ ЖИЗНИ** Өөдрөг хийморьтой, сүр сүлдтэй, амны хишигтэй, нүүрийн буянтай, золбоотой, гуниган янзгүй, заяа нь дэлгэрэх, эр хүн шиг эрвэлзэж эмзэлтэй морь шиг дэрвэлзэж явах.

В течение всей блокады в Ленинграде ни на минуту не прекращалось биение жизни Ленинградынхан бүслэлтэнд байхдаа огтхон ч гутарч гуниган (өөдрөг хийморьтой) байсан билээ.

178. **БИЛЛОННАЯ МОНЕТА** үйл мөнгөн зоос (үйл мөнгө гэж холиотой, цэвэр бус мөнгийг хэлдэг үг, үүнчлэн *үйл алт* гэж бас болдог)

179. **БИРЖА ТРУДА** Хөдөлмөрийн товчоо, хөдөлмөрийн зах

180. **БИРЖЕВАЯ ИГРА** (Наймааны) үнэ бүхий

181. **БИТАЯ ПОСУДА ДВА ВЕКА ЖИВЁТ** (*посл.*) Хуучны юм хуудуугүй. Тарчиг залуугаас тартай хөгшин. Өвчин ужигсаа

амь нас бөх. Хуучин юм (хүн) гэсэндээ. **Муу шинийг тоохгүй сайн хуучин,** Хуучин юмны хуйх, **хуучин бууны хугархай.**

182. **БИТКОВЫЙ СБОР** Төгс орлого

183. **БИТКОМ НАБИТЬ** (*разг.*) Пиг дүүрэн (хүн), хөл гишгэх зайгүй, хүнээс биш юмгүй, бөгс эргэх зайгүй, хөлд дарагдах-, батганын хошуу багтахгүй,

184. **БИТЫЙ ЧАС** (ждать) (*разг.*) Бүтэн нэг цаг, их удаан, ооаж чадахгүй нохойн хөл хөлдөөх, мээмээ хавдтал, дээлтэйгээ дэрийтэл, гуталтайгаа гурийтал.

Битый час стоял я на остановке, ожидая автобуса Би бүүдал дээр бүтэн нэг цаг автобус хүлээж зогсов. **Я сидел у книгини битый час** (Лермонтов) Би хатны өргөөнд бүтэн цаг суулаа.

185. **БИТЬ БАКЛУШИ** (*разг.*) Дархан тавьж, тошин харв-, дэмий бай-, сул бай-, ажлаа алда-,цаг нөгчөө-, хоосон сэлгүүцэ-, **сул сунха-,** сэтэртэй мал шиг, гэрээ умартсан гэсэр шиг.

Папа сказал, что будет нам в деревне баклуши бить (Л. Н. Толстой) Бид нар хөдөө тосгонд очоод хийх барих юмгүй сайхан сул байх болно гэж аав хэлэв.

Баклуши ты, что ль, бить сюда, приехал? (Островский) Чи чинь энд дэмий сууж жаргах гэж ирсэн үү?

186. **БИТЬ В ГЛАЗА** Харахад содон, нүдэн дээр тусахаар, онц ялгавартай, нүд хатгам, Б-196.

187. **БИТЬ В НАБАТ** Бажигадуула-, аюул нөмрө-, түгшүүр, түгшүүрийн дохио, сүйд майд бол-, тэвдүүлэ-, сандарга-, шуугиан дэгдээ-,

Ночью в деревне случился пожар-стали бить в набат Шөнө тосгонд түймэр гарч сүйд майд боллоо. (Орьд шөнө тосгонд түймэр гарч их тэвдүүллээ.)

Не надо бить в набат, шуметь и греметь-этого не надо (Кочетов) (Шагшаан шуугиан) шуугиан тавиад сүйд болоод байхын хэрэг юу байна. (Шуугиан пичигнээн болж сандраад байхын хэрэг алга.)

188. **БИТЬ В ОДНУ ТОЧКУ** Нэг юманд улай-(махра-, зүтгэ-), эр хүн зорьсондоо чөно зуусандаа, нэгэн үрүүрт сэтгэл, шөвгөрөн хичээ-, амандаа хүр-, за гэвэл ёогүй, нэр байна хор байна.

189. **БИТЬ ЗАДОМ** (Морь) өшиглө-, тангара-, тийр-,

190. **БИТЬ ИЗ ПУШКИ ПО ВОРОБЬЯМ** (*разг.*) Бөөсөнд хутга, баасанд халбага, алахаасаа өлгөх нь, ишгэнд эр гаргав гэгч, Муу эр эхнэртээ эр гарга-, шаазанд сүх,

191. **БИТЬ КАК ОБУХОМ ПО ГОЛОВЕ** У-47

192. **БИТЬ КАРТУ** (Хөзөр) дара-, идэ-,

193. **БИТЬ** (кипеть) **КЛЮЧОМ** (*книжн.*) Ид, оргилом, ид дундаа оволзо- өнгөрө-, ундар-

Когда мы прибыли, работа уже кипела ключом Бидний очиход (ирэхэд) ажил ид дундаа л байв.

194. БИТЬ МИМО ЦЕЛИ Онохгүй, байнд байтугай ванданд ч үгүй. Алдаж бууда-, чихлэ-, мэндгүй зөрө-, санасандаа хүрэхгүй, уул оно-, тэнгэр бууда-, дүмбажаанамхай (огторгуй) намна-,

195. БИТЬ ОТБОЙ 1. Цэрэг хураах дохио өг-, 2. хулчгар, туйл баргүй, 3. Үгээ буца-, буцаж буха-, саналаасаа няца-, найр тави-, буцамхай, амаа буца-, хэлснээ буца-, эм зан гарга-, тугалган жад шиг, унтах дохио өг-,

Раньше он с пеной у рта доказывал правоту своего мнения, а теперь бьёт отбой. Түрүүн (эртүүд, эртхэнтэйгээ), (тэр нөхөр) хэлснээ миний зөв гээд л улаан зүтгээд байсан, одоо болохоор амаа бухаж орхисон байж байна.

196. БИТЬ ПО ГЛАЗАМ Б-186

197. БИТЬ ПО КАРМАНУ *кого* Мөнгө их бүрэлгэ-, өврөө хоосло-, нанз нь хүнз бол-, хусмы нь долоо-, бэл алда-, хэтэвчээ хооело-, оёоры нь үзэ-, түрийвчээ гөвө-, шалдаа буу-, Б-541, У-42

198. БИТЬ ПО РУКАМ П-310

199. БИТЬ ПОКЛОНЫ (поклон) **кому** 1. Мөргөн ёсло-, 2. Хөл алдан хүндэлэ-, хөл малгайгүй хүндэлэ-,

200. БИТЬ ПРОТИВНИКА ЕГО ЖЕ (его собственным) ОРУЖИЕМ Хорыг хороор, ерөндгөөр нь өөрий нь өөртэй нь барилдуула-, өөдөө хаясан чулуу өөрийн толгойд гэгч болго-,

201. БИТЬ ПРЯМО В ЦЕЛЬ Онож бууда-, санасандаа хүрэ-, санаснаараа бол-, цүдий нь ол-, ончий нь ол-

202. БИТЬ С КОЗЛА Морь ухасхий-, гэнэт авч давхи-, бусга-, шурхий-, Д-18

203. БИТЬ СМЕРТНЫМ БОЕМ Үхтэл нь жанчи-, салам зодо-, нэвширтэл зодо-, нойтон голтой нохой сүүлтэй үлдээ-, хуурай модыг хугартал нойтон модыг эгитэл жанчи-, арьсы нь хуул-, махы нь зулгаа-, босч чадахгүй болго-, үхэхээс арай наахнуур болго-,

204. БИТЬ ТРЕВОГУ 1. Түгшүүр зарла-, 2. Өгдөө-, дэгтрэ-, турхира-, нижигнүүл-, урналан дууда-, бусинула-, урнала-, хөдөлгө-

В казармах забили тревогу Цэргийн хүрээнээ (хуарнаа) түгшүүр зарлав.

205. БИТЬ ЧЕЛОМ *кому чем* Хошуу цорвой-, ард нь гарч алгаа тосож урд нь гарч уруулаа унжуул-, царай алда-, мөргө-, гүйж гувчи-, гүйж най-, хишиг хүртэ-, эрүү өвдгөө дэвсэ-, 2. Тогтоож хайрлана уу, өргөн бари-, хөл алдан хүндлэ-,

Челом бьём вашей милости Хайр хишгий тэнь хүртэс.

206. БИТЬ ЧЕРЕЗ КРАЙ Сэтгэл догдло-, ухаангүй (баяса-, хөөрө-), өөрийн эрхгүй хөөрө-,

207. БИТЬСЯ ГОЛОВОЙ ОБ (в) СТЕНКУ Заяаны нүдэнд нь зүү нааж залааны нь үзүүрт идээ бугла-, зовсон сүүгээ хөхө-, үсээ урж үйлээ үзэ-, тахиацы өндгөөр хад цохи-, хоосоор, талаар, хүчээ дэмий бара-, тамаа эдлэ-, үйлээ үзэ-, санасандаа хүрэлгүй сажала- төлгөн хүц элгэн хад мөргө-

208. БИТЬСЯ ИЗ-ЗА КУСКА ХЛЕБА Хоног төөрүүлэх гэж, амь тэмцэж гэж зово-, аяга хоолны төлөө амь тави-, ядуу зүдүү амь зууухчаан бол-, улаан хоолой тэжээх гэж; шар наран бор хоног өнгөрөө-; бор ходоодоо тэжээх гэж, хэд хоног хоол хоохгэж; тогоонд гэдсээ хөөдө-, хорвоогийн тоос хөдөлгө-

209. БИТЬСЯ, КАК РЫБА ОБ ЛЁД Өтгөн шүлсээрээ хоол хийж шингэн шүлсээрээ унд хийж, шүүдрийн усаар унд хийж шүдний махаар хоол хийж ява-, гадиаа нэр тэмцэж дотроо амь тэмцэж ява-, ядаж зүдэж амь зуу-, үйлээ эдэлж үсээ тооло-, үнсэнд хаягдсан шалз шиг, махаа идэж ява-, үйл тамаа цай-, хар хөлсөө цувуулж хатан ясаа уярааж, хад мөргөсөн нинигний толгой хагарав гэгч бол-, арван хурууныхаа арыг барж, таван хурууныхаа тарыг бара-.

Вдова билась, как рыба об лёд, стремясь дать образование своим детям Бэлбэсэн эхнэр хэдэн хүүхдээ боловсролтой хүн болгох гэж үйл тамаа цайж байв.

210. БИТЬСЯ ОБ ЗАКЛАД [*разг., устар.*] Мөрийцө-, мөрий тави-, азаа сори-, азаа үзэ-, эз турши-, бооцолдо- В-249

211. БЛАГАЯ МУХА ЕГО УКУСИЛА Тэнэглэв, маанагтав, мэдэн будилав, айварлав.

212. БЛАГИМ МАТОМ (кричать, заорать, заплакать) ВОПИТЬ, зареветь и. т. п. прост. Орь дуу тави-, байдгаараа орило-, бархира-, орило-, чарла-, хашгира-, гуугла-, цурхиран, мэгшин, ангинан, хахаж цацан, багалзуурдуулсан юм шиг, тэнхээ мэдэн, нэг дуу тэнгэрт, нэг дуу газарт:

Медведь с испугу катит благим матом куда попало. Баавгай айсандаа толгойгоо хандсан зүг рүү л тэнхээ мэдэн довтоллоо, цойлон зайллаа.

Женщина кричала благим матом, зовя на помощь. Тэр эхнэр авраарай гэж орь дуу тавив.

213. БЛАГИМИ НАМЕРЕНИЯМИ АД ВЫМОЩЕН [*посл.*] Ниргэсэн хойно нь хашгирах, гэм нь урдаа гэмшил нь хойноо, мордсон хойно нь таваг тавих, гоо ам, гурил хошуу. Өнгөрсөн боroоны хойноос цув нөмрөх,

214. БЛАГОВИДНЫЙ ПРЕДЛОГ Сайхан шалтаг, морий нь эмээллэчихлээ, аян шалтаг, морий нь унуулах, сайн юм болж дээ, нэрмэх, нэмрий нь өгчихлөө, салхий нь тавих, түймэрт салхи,

215. БЛАГОРОДНОЕ РАССТОЯНИЕ Хөөрхөн зайтай, овоо хол, алсхан; чимгүй зайтай, (явган хүн дээр бол: нилээн алхуулна шуу. зэргэн зайтай, нилээд зайтай, нилээд зүтгүү, хирдээ зүтгүү,) бас ч яггүй зайтай, нилээн шогшуулна шуу.

216. БЛАГОРОДНЫЕ МЕТАЛЛЫ Үнэт төмөрлөг, эрдэнэт төмөрлөг

217. БЛАГОРОДНЫЙ МУЖ [*устар.*] Сайн эр, сайн хүн, уг сайт хүн, номг хүн, боловсон хүн, буянтай төрсөн эр, буянтай хүн, заяатай хүн,

218. **БЛАГОРОДНЫЙ СВИДЕТЕЛЬ** [*разг.*] Амь гэрч, бие гэрч, сайн гэрч, [*перен., перенеб р.*] Хөндлөнгөөс харагч

219. **БЛАГУЮ ЧАСТЬ ИЗБИРАТЬ** [*устар.*] **(избрать)...** тэгсэн нь дээр гэж,... тогто-

200. **БЛАЖЕН, КТО ВЕРУЕТ** Загатнасан газар нь маажих, сайн л биз, болох нь тэр, хөх инээд хүрэх, тэх тусмаа сайн, тун сайн юм, **уухайн** тас, уухайн хужир.

221. **БЛАЖЕН, КТО ВО-ВРЕМЯ СОЗРЕЛ** Б-223

222. **БЛАЖЕН, КТО СМОЛОДУ БЫЛ МОЛОД** Хүн болох багаасаа хөлөг болох унаганаасаа, эрхийг сурахаар бэрхийг сур, эх нь булингартай бол адаг булингартай, эх нь хээр алаг бол хүүхэн нь хөл алаг

223. **БЛАЖЕННОЙ (незабвенной, светлой) ПАМЯТИ** [*ирон., устар*] Хэдийн, аль дивангарын (дивангалбын), эрт урьд элэр балрын үед, өөд болсон, талийгаачийн, сайн цагийн эхэнд, улирсан баларсан, элэнц хуланцын

224. **БЛАТНАЯ МУЗЫКА** Битүү үг, далд утгатай үг, нуудгай яриа, хөвөнд боосон чулуу, амничхан үг, хүнд хэлмээр юм биш, задруулж болохгүй яриа.

225. **БЛЕДЕН КАК СМЕРТЬ** Үхээд боссон юм шиг, нүднээс гара-, хүн аймаар, сэтгэл зовмоор, өр өвдмөөр, үхсэн хүний царай шиг, үнсэн царайла-, хувхай царайтай, өгөр даа, зэвхий царайла-газар дооронос гарч ирсэн юм шиг, есөн шөнө хоосон хоносон юм шиг танигдахгүй болох-, андуурам болох-, хөхөлбий царайтай, гандмал царайтай, газар царайла-, шороон царайла-, царай нь бөрзийж

226. **БЛЕДНАЯ НЕМОЧЬ** Хулгана өвчин,

227. **БЛЁСТКИ ОСТРОУМИЯ** Хурц мэргэн, билэг ташхай, номун хаан, саруул мэргэн, цоор (*он*) хой толгойтой, гаргуун ойтой, билгийн далай, тасархай ухаантай, анги хүн.

228. **БЛИЖЕ К ДЕЛУ** Ярих л юмаа ярья, гол юмаа ярь.

229. **БЛИЗКИЙ СОСЕД ЛУЧШЕ ДАЛЬНЕЙ РОДНИ** Мунхаг янагаас сэцэн дайсан дээр, муу садангаас сайн хар элэгтэн дээр, төөрсөн төрлөөс төрсөн нутаг дээр

230. **БЛИЗКО ЛЕЖИТЬ** П-197

231. **БЛИЗКО ПРИНЯТЬ К СЕРДЦУ** Их өрөвдө-,тоо-,таала-,амиа тави-,амин сүнс.

> **Я близко приняла к сердцу его горе** Гансран шанала-хад нь би эрхгүй өрөвдөж байлаа.
>
> **Кажется, Иван Иванович не очень-то принял к сердцу мои слова** Яваан гуай миний үгнийг ч нэг их үгэнд авахгүй байх шиг байна. (Миний үг Яваан гуайн нэг чихээр нь ороод нөгөө чихээр нь гарах шиг боллоо).

232. **БЛИЗКО ЛОКОТЬ, ДА НЕ УКУСИШЬ** 1. Хазъя гэхэд алга хол, харъя гэхэд чих хол; 2. [*перен.*] Хэлэхэд амархан хийхэд хэцүү; харахад ойр хазахад хол; хонуу нэмэхэд амархан, хуруу нэмэхэд хэцүү; үгээр өгүүлснийг өвчиж болохгүй, амаар алсныг мэдэж болдоггүй.

233. **БЛИСТАТЬ ОТСУТСВИЕМ** [*ирон.*] Зорнуд үл оролцо-,саналтай ажлаас чаргууца-,тэгэхээс тэгэх гэж байхгүй бай-,баашилж ес ирэ-, цааргала-, хойш суу-,

> **Желая подчеркнуть свою занятность, он часто блистал отсутствием на наших заседаниях** Ажилдаа дарагдсан завгүй хүн болох гэж манайхны хуралд ерөөсөө ирдэггүй юм.

234. **БЛУДЛИВ КАК КОШКА, ТРУСЛИВ КАК ЗАЯЦ** [*устар.*] Үгчидбээс муур шиг хулгайч, туулай шиг аймтгай Утга нь: зүрх нь үхсэн, хулчгар, зальхай амьтан, зүрхгүй эр, бэртэгчин, зүрхээ зүсүүлсэн, муур үзсэн хулгана шиг, хулгайч царайтай харцаа бууруулсан, сүү долоосон гөлөг шиг, хүний нүүр харж чадахгүй; ар худрагаар нүд харнулах; бөгс өндиймэгц, нүднээс далдуур, эчнээгээр.

235. **БЛУДНЫЙ СЫН** [*устар.*] (Богдсын сударт) гэрээ мартсан гэсэр, замаа алдсан хүн, нохойн замаар орох, алдуул мал шиг, эзнээ алдсан, замаа алдсан жамьянмядаг (үлгэр), золигоор гармар

236. **БЛУЖДАТЬ (бродить) В ПОТЕМКАХ** Мангартан хоцор-,аль ч учраа олохгүй, мэдэн будила- Б-392

237. **БЛУЖДАЮЩИЕ ОГНИ** *буюу* **БЛУЖДАЮЩИЙ ОГОНЁК** Чөтгөрийн гал, алибаны гал, бүгийн гал. хээрийн гал.

238. **БЛЮСТИ СЕБЯ** [*устар.*] Бат журамтай, бат, чин журамтай журмаа бат сахидаг-, ах (эх) захтай, цэвэр ичимтгий

239. **БЛЮСТИТЕЛЬ ПОРЯДКА** Цагдаа, журам сахиулагч, зохицуулагч, номын ёсоор байлгагч, цаазыг баригч, цагдан сэргийлэгч, эв номд нь оруулагч

240. **БОБЫ РАЗВОДИТЬ** [*разг.*] Дэмий яри-,сул чалчла яриа, хоосон чалчи-далан долоон юм донгосо-,эсэн бусын юм чалчи-,амаа одохгүй, хэлэх хэлэхгүй үг яри-,авч давхи-,хадуура-, мэдэмхийрэ- бура-, аманд орсноо чалчи-,амны хэмжээгээр яри-.

> **Ну, хватит тебе бобы разводить, займись-ка вот этим делом** За за таны дэмий ярих чинь мундахгүй боллоо. Үг олдож үхэр холдох нь. Одоо энэ ажлаа л хийгээд орхи. (За за яриандаа тань согтохоороо л нэг боллоо, одоо хийхий чинь харъя, хэлсэндээ хүрч үз).

241. **БОГ ВЕСТЬ** Бүү мэд, хэн мэдэх вэ, тэнгэр мэдэг-,Г-186

242. **БОГ ЕГО ЗНАЕТ (ведает)** Тэнгэр мэдэг. Хэн мэдэх вэ, бүү мэд, дээр тэнгэр Б-155, Г-187, 188

243. **БОГ ДАЛ (привел)** [*устар.*] за тэр, харахгүй юү. за боллоо.

244. **БОГ (господь, аллах, черт, бес леший, пес тебя её, вас, их) ЗНАЕТ** Хэн мэдэх вэ, бүү мэдэг, тэнгэр мэдэг. Г-186

> **Ходит бог знает куда и бог знает чем занимается** Хаашаа ч явчихсан юм, юугаа ч хийж явдаг юм, хүдлаа хэлэх юм алга.
>
> **Сделано бог знает как плохо** Ингэж хийх гэж, ийм өөдгүй хийнээ бас, (оромдож дээ нэг.)

Возвращается бог знает когда Хэзээ эргэж ирэхийг тэр зүгийн тэнгэр нь мэдэж дээ.

245. **БОГ ЗНАЕТ КАК ДОРОГА** Сонсоод яах вэ, дуулаад сууж байхаас өөр арга алгаа, тэнгэр минь булай үнэтэй юм байна, тархиар татсан үнэтэй, доороос нь босохын эрхгүй үнэтэй; энэ чинь тэнгэр минь үнэ гэж тэнгэрт хадсан юм байна; с нсохоос цааш харну хийхийн эрхгүй үнэтэй; энэ насандаа хүч хүрэхгүй юм байна; хоттойгоо холбоод ч хүрэхгүй юм байна, буян амлаад дийлэхгүй юм байна.

246. **БОГ (чєрт) ЗНАЕТ ЧТО** Юу ч мэдэхгүй, ухааны нь олохгүй. Ч—73

247. **БОГ МИЛОВАЛ** Тэнгэр өршөөв. Тэнгэр ивээв.

248. **БОГ МОЙ!** Тэнгэр минь

249. **БОГ НЕ ОБИДЕЛ** *кого чем* чадахтай, дөнгөчихөөр,...-аар хүний дор орохгүй, авъяас ойрхонтой.

250. **БОГ НЕСЕТ** Ч-77

251. **БОГ ПОСЕТИЛ** Г-189

252. **БОГ ПОСЛАЛ** [*прост.*] Хүн өгсөн юм шиг, хангай тэнгэр минь хайрласан юм шиг, хаанаасаа гараад ирэв; тэнгэр тэгшилжээ, эзний минь ивээл, ийм амны хишиг байжээ, бөөн олз, ингэж гялаадгаа бас; төрий минь сүлд, эзний минь хишиг; хангай дэлхийн хишиг залбирч хүртэе.

253. **БОГ ПРИБРАЛ** *кого* [*прост.*] Тэнгэр болсон, эрлэгт дуудагдсан, эрлэгийн элч аваад явсан, авдаг юм нь прээд аваад явсан, цаг нь болсон, насных нь тоо гүйцсэн, амьсгалах тоо нь гүйцсэн, өөд болсон, сажилсан, мажийсан, талийсан, бүрэлсэн, эргэж ирэхгүй, тэнгэр болсон, орондоо орсон, бүр нойрссон, тэр чигтээ болсон.

254. **БОГ С НИМ с ней, с вами, с ними** Мөрөөрөө болог, яавал ч яаг, дураараа болтугай, буянаараа болог, тэнгэр мэджээ, одоо яана гэх вэ, хэндээ хэлэх вэ дээ.

255. **БОГ С ТОБОЙ** 1. Тэнгэрээ, хөх тэнгэрээ 2. За юу болов оо яав та

Бог с тобой, что ты говоришь За та тань юу болов оо Юугаа ярьж байгаа тань энэ вэ?

256. **БОГ УБИЛ** *кого* [*разг.*] Дорой төрсөн, мулгуу тулгуу, жаахан ороотой гараатай, адууснаас доор, хүний оронцог, дуурнамал хүн, харахад л хүн, хүнээс цаашгүй, муу мулгуй, мунхаг тэнэг, хүний тоо, хүний сүг, турь муутай турсган дээлтэй, арван сараа гүйцээж ангир шараа хөхөөгүй, уруу дорой төрсөн, хүн юм байгаа даа; үзэхэд үрчгэр, харахад, харчгар; орой гарч дорой төрсөн; бяр муутай бяруун дээлтэй. Б-256, У-422

257. **БОГ ШЕЛЬМУ МЕТИТ** [*посл.*] Нүгэл нүдээ олох, үйлийн үрээ, хар санаа нь хар толгойд нь, тэнгэр тэгшлэх, санаа муут яван хатах, хүнцэл идвэл араанд, үйлт хүн үйлээрээ; өөд нь хаясан чулуу өөрийн нь толгойд, идсэн эрүү хувхайрдаг, муу санаа өөрийгөө отно, үйл эзнээ олдог, үмхий хүрэн нүхээ олдог, үйл эзнээ дагаж үнээ тугалаа дагадаг.

258. **БОГАТОМУ НЕ СПИТСЯ: БОГАТЫЙ ВОРА БОИТСЯ** [*посл.*] Хонь зуу хүрэхэд алж идэх юм олдохгүй; баян хүн малын боол, хоосон хүн хүний боол; бирдийн нүдэнд далай харам; баян турдаг, буян арилдаг; юмтай хүний зовлон их; баян явах харамнахын зовлон; доён явах ганцаардахын зовлон; таян явах өлсөхийн зовлон; бага гэдсээ баглаж их гэдсээ эвхэх; юмтай хүн хулгайчаас айдаг, хоосон хүн хулгайчид янаг; гадаахи нь гэртээ ороогүй, гэртэхи нь гэдсэндээ ороогүй.

259. **БОГАТЫМ БЫТЬ** *кому* (Орос ардын ярианд удтал уулзаагүй танил нөхөртэйгээ гэнэт учран эс таньснаа танимагц) чи баяжчих нээ гэж хэлдэг наргиа үг. Энэ нь манай монгол хэлнээ «өө чи байсан юм уу», «чи хаанаас гараад ирэв» гэдэгтэй утга төсөрхүү; ямар сонин хүн газар доороос гараад ирэв үү, тэнгэрээс буугаад ирэв үү,

Быть вам богатым, Я вас не узнал Өө та байсан юм уу, би огт таньсангүй шүү (та тань төрөл арилжаад ирэв үү).

260. **БОГАТЫРСКИЙ СОН** Сур шиг сунаж сухай шиг улайж; нам унтах, бөх унтах, дуг нойрсох, таг унтах, дууритлаа унтжээ, хутгалсан ч сэрэхгүй, үхсэн юм шиг унтах, нэг унтвал гурван жил сэрэхгүй,

261. **БОГОМ ОБИЖЕННЫЙ** Золгүй,өлзий бус, явцгүй, өөдгүй, урагшгүй

262. **БОГОМ УБИТЫЙ** Б-256

263. **БОДЛИВОЙ КОРОВЕ БОГ РОГ НЕ ДАЕТ** 1. Сүүгүй мал сүж, ахар дээс уяа хүрэхгүй, өөрийгөө магтсан хүн өөдгүй, мухар үхэр сэжээч. 2. Сайн хүнд (юманд) садаа мундахгүй, санаа байнч соёо (сачий) хүрэхгүй, санаа уулын чинээ сачий туулайн чинээ.

264. **БОЕВАЯ СТРАДА** Үхэх сэхэхээ үзэх, эрэгчин эмэгчнээ үзэлцэх, эр охиноо үзэлцэх, нэгийгээ үзэж нэхий дээлээ уралцах, сайн муугаа үзэлцэж сармай дээлээ уралцах, үзэж алдаж үсэрч наалдах, хамрынхаа хатуу зөөлнийг үзэх.

265. **БОЕВОЕ КРЕЩЕНИЕ** 1. [*сказ*] Дайны ухнал, дайны зам арнутгах тахих; 2. Юманд гар хүрэх, эхлэх.

266. **БОЕК НА ЯЗЫК** (на слова) Бардам ам шалдан гуя, ам гэж алт, сайхан амтай,

267. **БОЖЕ ИЗБАВИ** Б-269

268. **БОЖЕ МОЙ** Хөх тэнгэр! Ээ өршөөж хайрла! Ээ тэнгэр минь Ай тэнгэр минь! Ээ сахиус минь! Ээ аварч өршөө!

269. **БОЖЕ СОХРАНИ** Тэнгэр минь ивээж хайрла! Бүү үзэгд таминь тэгж үхэхээр тээглэж үх! болгоож хайрла!

270. **БОЖЕ УПАСИ** (сохрани, оборони) Хар толгойгоороо дүүрэе, дүүрсэндээ дүүрэе; үхсэн ч дүүрсэн ингээд дуусая; хэлэх юм бишш, хэрхэвч... болохгүй, ээ дээ тэгэвээ үгүй чиш, хээцэс У-106

Только боже упаси, никому не говори Ээ дээ хүнд

хэлэв дээ! (Хүн л битгий дуулаасай, хүний чихнээс холуур өнгөрөг, салхи авчих бий, чимээ авчих вий, чимээ цохичих вий, бүх хүн дүлийрээсэй.)
Вы, кажется, в Крым ездили?-Боже упаси, сидел всё лето в городе Та Крымд очиж амарсан уу? Үгүй чиш, ёстой хот сахиж зуссан даа (гэрийн мухар сахиж зуссан даа).

271. **БОЖЕСКИЕ ЦЕНЫ** Ханасан үнэ, үнэ нь номоороо, таарсан үнэ, дүйсэн үнэ, таарсан өртөг, эхий нь эцээж тугалы нь тураахгүй үнэ; алдаа хожоогүй тохирсон үнэ.

272. **БОЖЕСКОЕ НАКАЗАНИЕ** [*разг*] Үзээгүйгээ үзэж үхэр цамаа харайх, аль муугаа үзэх үйлээ үзэж үсээ тоолох, тамаа эдлэх, тарчилах, юмаа үзэх, ингэж ч явах гэж; одоо барцад арилсан байхаа, үхэхээс бусдыг үзэх.

273. **БОЖИЕЙ МИЛОСТЬЮ** М-129

274. **БОЖИЙ СВЕТ** Б-137

275. **БОЖИЙ ЧЕЛОВЕК** [*фольк.*] Ёр ч хүн, далдын мэдэлтэй хүн.

276. **БОЖЬЯ КОРОВКА** [*перен., резг.*] Хонь шиг хүн, түмэн зөвийн зээ, бодь амьтан, хүний аяар хүн, амархан хүн, хүүхэд элэг баримаар, хүний аясаар, хүнээс гаждаггүй, харцаар амьтан, нүдний харцаар, хэвтээ хонь ч босгохгүй, ноолойсон амьтан, мөрөөрөө амьтан, хүний зөнгөөр, хорхойд хоргүй,

277. **БОЙ БАБА** Сүрхий хүүхэн, айхавтар хүүхэн, сүв нь солигдчихсон эм, улаан хөлтийг урдуураа гаргадаггүй эм, яггүй хүүхэн, гадаа гарч эр болсон, гэрт орж эм болсон, муу эрийг тоохгүй, даан ч эм болоод төрчихсөн юм [*ирон.*] гэм нь л охин.
Наш бригадир бой баба Манай багийн ахлагч муу эрийг дагуулахгүй хүүхэн шүү.

278. **БОЙ-ДЕВКА** Б-277

279. **БОЙКОЕ ПЕРО**, *у кого* Бичнэ гэмээ бичдэг, бийрийн ид чадал суусан И-217

280. **БОЙ КРАСЕН МУЖЕСТВОМ, А ПРИЯТЕЛЬСТВО-ДРУЖЕСТВОМ** Айл зуураа явахад алаг бяруу мэт ааштай, алалдах дайсанд амь бие үл хайрлагч; хайлсхүй нагт хашин хар бяруу мэт ааштай, харьтан дайсанд харцага шувуу мэт... (*Алтан товч*)-Ахан дүүдээ алаг бяруу, алалдах дайсанд арслан барс, зөв юмарт хонь, зөрүү юманд чоно.

281. **БОЙ ПАРЕНЬ** Сүрхий хархүү, хэцүүхэн эр, лут эр, лут хүн.

282. **БОК О БОК** [*разг.*] Бөөр нийлүүлэн, онь холбон, ихэрлэх, мөр зэрэгцэн, суудал зэрэгцэн, хаяа дэрлэн, хөтөлцөх, айл саахалт, айл айлчлал, айл зэргэлдээ, сэр зэргэлдээ, хажуу хажууд, зах нийлэн; дэм дэмээрээ, дээс эрчээрээ; хаяа хадаж, зуузай холбох, айл буух.
Жить бок о бок Дэм дэмээрээ, дээс эрчээрээ; (бөөрөө нийлүүлэн, айл буух, саахалт буух.)
Стоять бок о бок Зэрэгцэн зогсох, хөтөлцө-

283. **БОЛВАН СТОЕРОСОВЫЙ** Д-444

284. **БОЛЕЕ ВСЕГО** Туйлын, хамгийн, нэн, түн, эрхий дарахаар, нэн ялангуяа, эхлэж аваад, бусдаас илүү, эн тэргүүн, дав дээр, давын өмнө.

285. **БОЛЕЕ ИЛИ МЕНЕЕ** Нилээд овоо, баахан, их бага ч гэсэн, ямар ч гэсэн, ер нь л, хир зэргээр нь (урамшуулах), хирээрээ, болох бүтэхээр нь, чадах ядахаар нь, чадах чинээгээр нь.
Об этом более или менее известно всем Улс их ч бага ч гэсэн энэнийг гадарлаад байгаа юм.
Более или менее похож Баахан төстэй юмаа.

286. **БОЛЕЕ ТОГО**... нь байтугай,..., тэр ч байтугай..., үл барам,...-аар зогсохгүй, тэгэх тусмаа улам ч..., барахгүй...,... бүр ч...,... байтугай... нь бүү хэл...,... нь битгий хэл...,... харин ч...
Я не согласен, более того, я протестую Би зөвшөөрах нь байтугай дургүй байна.
Излишнее курение не полезно, более того, даже вредно. Тамхи их татах ашиг байхгүй байтлаа хортой шүү

287. **БОЛЕЕ ЧЕМ** Мөн чиг, тун, маш, туйлын, хамгийн
Его поведение более чем возмутительно. Явдал хийдэл нь дургүй хүргэм (ой гутаам) амьтан.

288. **БОЛЕЕ, ЧЕМ ДОСТАТОЧНО** Өлхөн ханхалзах, бардаагаар, уужуухан, зовсолтгүй, илүү гарна уу гэхээс биш..., элбэг дэлбэг, илүү дэлүү, дэндэнэ үү гэхээс биш..., ихдэнэ үү гэхээс биш... баавгай, эр бар

289. **БОЛЕЗНЬ ВХОДИТ ПУДАМИ, А ВЫХОДИТ ЗОЛОТНИКАМИ** [*посл.*] Өвчин гэдэг хэлж ирдэггүй хийсч ирдэг. Өвчин тусахдаа төө төөгөөр ирдэг эдгэхдээ туя тунгаар гардаг.

290. **БОЛЕТЬ ДУШОЙ (сердцем)** Сэтгэл зово-, сэтгэл түгши-(сандра-), санаа зово-.

291. **БОЛИТ. (сосет, щемит) ПОД ЛОЖЕЧКОЙ** Зүрх шимшрэх, гол харлах, өр зүрх өвдөх, бүлх залгисан юм шиг болох, амиа амандаа зуух, хамаг бие мэдээ алдах. С-715, Щ-4
У Якова Лукича начинало сосать под ложечкой, движения становились вялыми, несказанная усталь борола тело... (Шолохов) Яков Лукич зүрх нь шимширч, хөдлөх бүрих нь алгуурлан, хамаг бие нь ядран улбайж орхив. (Яков Лукич өр нь өмрөн хамаг бие нь эзгүйрэн сулдайж хөдлөхийн сөхөөгүй тэнхээ тамир тасрав).

292. **БОЛТАТЬ ЯЗЫКОМ** [*прост.*] Дэмий чалчи-, чалчи-, донгос-, бура-, амаа ура-, үгээ олохгүй донгос-, амаа урчих гээд бай-
Неболтай языком. Битгий донгос

293. **БОЛЬНО НУЖНО!** [*ирон*]. Яах аргагүй хэрэгтэй, аргагүй хэрэг болсон.

294. **БОЛЬНОЕ МЕСТО** Эвэршээлтэй газар, эмзэг газар, согоггой тал, төвөгтэй зүйл, эгзэгтэй газар, амиддөрхон, цоорхой зулай шиг.

295. **БОЛЬНОЙ ВОПРОС** Амин чухал асуудал, (юм,) эгзэгтэй асуудал юм, эмзэг асуудал.

Вопрос о разоружении-больной вопрос современности. Зэвсгийг үгүй хийх асуудал бол орчин үеийн хамгийн эгзэгтэй (тулсан) асуудал мөн.

296. **БОЛЬШАЯ ДОРОГА** [*перен., разг.*] 1. Дардан зам. 2. Бартаагүй зам, зэмын оглуур, замын уулзвар, зам тосох, зам оглох.

Промышлять на большой дороге. Замын уулзвар дээр ганцаран суу-, эзгүй хээр гэгэлзэ-.

297. **БОЛЬШАЯ ЗЕМЛЯ** Олон хөлийн газар, төв газар, төв нутаг, төв орон, их замын уулзвар газар.

298. **БОЛЬШАЯ ПУБЛИКА** Өргөн түмэн, түмэн олон, хотол түмэн, ай түмэн, зон олон, дая олон, нийт даяараа, сум хотлоороо, хотол даяраа, аймаг хошуугаараа, хошуу хотлоороо.

299. **БОЛЬШАЯ РАЗНИЦА** [*разг., перен*]. Зүйргүй, шал ондоо, бүр анги, огт өөр, тэс өөр, тэмээ ямаа хоёр шиг, газар тэнгэр хоёр шиг, буян нүгэл хоёр шиг, **бурхан чөтгөр хоёр шиг**, гал ус хоёр шиг, ус сүү хоёр шиг, өдөр шөнө хоёр шиг.

Вы должны знать, что работать без плана и работать по плану-большая разница. Төлөвлөгөөтэй ажиллах, төлөвлөгөөгүй ажиллах хоёр зүйцэхгүй гэдгийг мэдүүштэй юм шүү. (Урьдаас занаатай ажилдах урсгалаар ажилдах хоёр хэлэх юмгүй өөр гэдгийг ухаарууштай.)

300. **БОЛЬШАЯ РУКА** Их гарын хүн (амьтан), нудрагатай хүн.

301. **БОЛЬШЕ ВЕРЬ ДЕЛАМ, ЧЕМ СЛОВАМ** Ам ч яах вэ ажил, бүтэхээр нь л бүтлээ гэж мэд. Хэлсний нь итгэхээр хийсний нь итгэ. Хэлэх хийх хоёрын дунд хэд хэдэн даваа учирдаг; хэлсий нь мэдвэл хэргий нь шүү. Хэлэхэд бэлгүй хийхэд байх.

302. **БОЛЬШЕ НЕ ЕЗДОК** *куда* Дахин зүглэхгүй, жолоо залахгүй, морийхоо амьг эргүүлэхгүй, гишгэхгүй, хавьтахгүй, хөл тавихгүй, ясан ч зүглэхгүй (хэндахгүй)

Я сюда больше не ездок Энэ рүү би дахин зүглэхгүй.

303. **БОЛЬШЕ ТОГО** Б-286

304. **БОЛЬШЕЙ ЧАСТЬЮ** Ихэнх, дийлэнх, голцуу, баранхи, зонхи, олонхи, их төлөв, бараглаж л, голдуу, цөмөөрөө шахам, ер нь л, цугаараа шахам, бүгдээрээ шахам, нийтээрээ шахам. П-211.

305. **БОЛЬШИМИ ГЛАЗАМИ** С-575

306. **БОЛЬШОГО СЕРДЦА** *о ком либо* Халуун сэтгэлтэй, уужим дотортой.

307. **БОЛЬШОЕ СЕРДЦЕ у кого, в ком** Уужим дотортой, гудигүй, хан уул шиг

308. **БОЛЬШОЙ ПАЛЕЦ** Эрхий хуруу, бандаарай, эрхий мэргэн

309. **БОЛЬШОЙ РУКИ** Их гарын, дээд зэргийн, толгой цохихоор, сайчуулын, дээгүүр зиндааны, ахдахаар, айргийн тавын, шөвгийн, үзүүрийн, эрхий, дарам.

310. **БОЛЬШОМУ КОРАБЛЮ БОЛЬШОЕ ПЛАВАНИЕ** [*посл.*]. Хүн хирээрээ төмөө тэнгээрээ (тэнхээгээрээ); гар томтын төө их, ханцуй ихтийн нудрага их, хамар томтын (ихтийн) нус их; хөл томтын гутал том; цх мод их сүүдэртэй, бага мод бага сүүдэртэй; их тогооны хусам гурван жил хүсуулдаг; их айл их зараатай, бага айл бага зараатай; их ойн сүүдэр их, их өвсний шүүдэр их; их өтөг гурван жил шатдаг.

311. **БОРОДА ЛОПАТОЙ** [*разг*]. Ухнан сахал

312. **БОРОТЬСЯ С (самим) СОБОЙ** Тэвчээр заа-, биеэ барих гэж оролдо-,хэлээ хаза-,амаа жимий-, сэтгэлээ бари-, тэвчи-, сэтгэлд юм уяатай бай-, яая нийе гэ-, шүд зуу-, утаагаа хамраараа гарга-, нэг гараараа нөгөө гараа бари-.

Он долго борется с самим собой, прежде чем решиться на это. Энэ явдлыг (хэргийг) нэг тийш хэлтгийрэхээс өмнө (тэр хүн) дотроо яах вэ ийх вэ гэж чимгүй бодсон билээ.

313. **БОРТ О БОРТ** Бөөр бөөрөө нийлүүлээд, хөл хэрээтэй хүзүү холбоотой, хэлхэлдээд, холбоотой юм шиг, зэрэгцэх, эгнэн, зэллэн, зээглэн.

Вся эскадра борт о борт проходила перед нашими глазами Усан онгоцны (бүрэн, иж, их) цуваа бидний өмнүүр зэл татан өнгөрөв.

314. **БОРЬБА С ВЕТРЯНЫМИ МЕЛЬНИЦАМИ** [*ирон.*] Сүүдрээ **хөөх**, солонго барьж явах

315. **БОСАЯ КОМАНДА** Хөл нүцгэн жаалууд, нусан журуул, **хөх гүзээнүүд**, бор ходоодтон, санаа амар амьтад, сайран хөлтөн

316. **БОЧКА ДАНАЙД** Үүлгэртсэн ажил, бүтсэн ч юмгүй бүтээгүй ч юмгүй, нороо холхво тасардаггүй, өвстэй шороотой ажил.

317. **БОЮСЬ ДАНАЙЦЕВ, ДАЖЬ ДАРЫ ПРИНОСЯЩИХ** [*посл.*] бэлиг барихдаг ирсэн дайсан ч дайсан шүү. Муу нохойн санаа талын гурван зээрэнд; хорт могойн санаа эргэхгүй; инээсэн болгон нөхөр биш; сайхан амраг боловч санаагий нь тань.

318. **БОЯТЬСЯ КАК ОГНЯ** Түймэрт хөөгдсөн мэт, ухаангүй ай-, сүнс нь халь-, үнхэлцэг нь хагара-, унгай нь ухэ, мий үзсэн хулгана шиг, үстэн толгойгоо барь, нүүрээ бууруула-, нүдний зовхи нь буу- таван махбодь нь шархира-.

Он боится как огня встречи со мной Надтай уулзана гэхээсээ л сүнс нь зайлдаг хүн дээ.

319. **БОЯТЬСЯ, КАК ЧЁРТ ЛАДАНА** Орсон буур харсан чоно; харцага харсан болжмор шиг; их айх, таван ухаан нь талд гартал ай-, үнхэлцэг нь хагарахаа шаха-,

320. **БОЯТЬСЯ НЕСЧАСТЬЯ-И СЧАСТЬЯ НЕ ВИДАТЬ** [*посл.*] Жаргалын түрүү зовлон, зовлон үзэхгүйгээр жаргал олдохгүй, зовлонгоос айвал зол ирэхгүй, зовлонгүй жаргал байдаггүй; зовлон зуу, зол нэг, зол зовоож ирдэг

321. **БОЯТЬСЯ НОС ПОКАЗАТЬ** Уулзаж эс зүрхлэ-, зүсээ буруула-, царайгаа үзүүлэхээс эмээ-, хүний цаагуур шурга-, ороо морь шиг

322. **БРАЗДЫ ПРАВЛЕНИЯ** Захиргаа, эрх мэдэл, хазаар

323. **БРАТ (сестра) ПО ДУХУ** Нэг эхийн хүүхэд шиг, халуун ам бүл шиг, ах дүүс адил, сэтгэл нэгтэн.

Социалист-наш брат по духу всегда (Горький) Нийгэм жүрэмтэн бол насад бидний сэтгэл нэгтэн мөн.

324. **БРАТСКАЯ МОГИЛА** Дайнд амь үрэгдэгсдийн булш бунхан, нөгчсөн зоригтны булш.

325. **БРАТЬ БЫКА ЗА РОГА** [*посл*]. Халдвал хар халзандаа, гол судсы нь атга-, эвий нь ол-, эгзгий нь ол-, хөлд нь суу-, ончий нь тааруул-, нохойн аманд гараа хий-, түлхүүр тааруул-, гарах заслалы нь хий-, азрага сүүлдэ-, бар үнэс-, баавгайн нүцээнд нэвтрэ-.

Наш прораб толковый работник, он в любой работе умеет взять быка за рога. Манай ээлжийн ахлагч аль ч ажлын эгзгий нь нэг олж дөнгөдөг элдэвтэй хүн шүү.

326. **БРАТЬ В ЕЖОВЫЕ РУКОВИЦЫ** хатуу гараар бари-,

327. **БРАТЬ В ЖЁНЫ** Эхнэрээ болго-, эхнэрээ хий-, эрхэндээ хий-, өөрийн болго-

328. **БРАТЬ В ОБОРОТ** *кого* [*разг.*] Эзэн мэдэ-, дур мэдэн, зоргоороо шийтгэн явуул-, захиран чандала-, гартаа атга-, хатуу бари-, харын албаар, албан хүчээр,хүч түрэ-, дур зоргоор, санаснаараа.

329. **БРАТЬ** *кого* **В СВИДЕТЕЛИ** Гэрч тата-, гэрч гэгээ хий-, гэрч болго-.

330. **БРАТЬ В СВОЙ РУКИ** Хариуца-, хамаара-, эрхлэ-, жолоод-, жолоог атга-, удирда-, толгойгоороо даа-, толгойгоороо хариуца-,

Пошло куда лучше, когда наш небольшой драматический кружок взял дело в свой руки. Манай яриан жүжгийн дугуйланг туршлагатай найруулагч гардан удирдсанаас хойш ажил урагштай байх болж шүү.

331. **БРАТЬ В СООБРАЖЕНИЕ** Хужры нь тунгаа-, бодолцо-, харгалзан үзэ-, бодож үзэ-, шүүн тунгаа-, нягтлан шүү-, байры нь танда-

332. **БРАТЬ В ШОРЫ** *кого* Шийдэн буулга-, эрс оро-, үзээд орхи-

333. **БРАТЬ В ШТЫКИ** [*перен.*] Эрслэн довтол-, халдан дайра-, ноцо-, дайрч давши-. нүд үзүүрлэ-, хялай-, хүйтэн ханда-, цэвдэг ханда-

334. **БРАТЬ ВАННУ** Халуун усанд оро-, усанд оро-, ухиал хий-, булха-

335. **БРАТЬ ВЕРХ** *под кем* Түрүүлэ-, үзүүрлэ-, толгой цохи-, толгойло-, дүйдэ-, шовхой-, шигшигдэ-, шилэгдэ-, туна-,

К концу игры сборная команда начала брать верх Тэмцээний шувтарганд шигшээ баг түрүүлэх (шүүх) чигтэй боллоо.

336. **БРАТЬ ВО ВНИМАНИЕ** Анхаара-, анзаара-, тоомсоро-, санаандаа ав-, хичээж үзэ-

337. **БРАТЬ ВОЛЮ** Дурааараа дургиж дунд чөмгөөрөө жиргэ-; намайг хэн хэлэх вэ, нохойг хэн саах вэ. В-587

338. **БРАТЬ ВСЕМ** Төрд нэртэй түмэнд нүүртэй; найрын гурван дуутай, наадмын гурван даваатай. Арван хуруу тэгш, тэгшхэн төрсөн; муу юмгүй, өв тэгш; (бүсгүй хүнд бол) бүсгүй хүний таван эрхэм бүрдсэн; үнэрлэх үртэй өмсөх хувцастай; идэх хоолтой юүлэх унаатай; нүүх гэртэй нутаглах газартай;

Эта девушка всем берёт: и красотой и умом Энэ хүүхэн цэвэрхэн төрсөн цээлхэн ухаантай арван хуруу тэгш хүн юмаа. В-588

339. **БРАТЬ ГОЛЫМИ РУКАМИ** *кого, что* Гарын үзүүрээр ол-, зовлонгүй ол-, хүйтэн цай, зайдан морь, юу амархан тэр амархан, тэгс ингэс хийгээд, чигчий хуруугаараа, нохойн наадам, хүүхдийн тоглоом, юухан хээхнээр.

340. **БРАТЬ ГОРЛОМ** [*прост*] Орь дуу тави-, хараал ерөөл тавибагалзууруаа хөөлгө- В-591

341. **БРАТЬ ГРЕХ НА ДУШУ** [*разг.*] Муу юм хий-, муу юм сана-, сэтгэлээрээ нүгэл хураа-, өөр дээрээ тата-, хий бэртэ-.

342. **БРАТЬ ЗА БОКА** В-593

343. **БРАТЬ ЗА ГОРЛО** В-594

344. **БРАТЬ ЗА ДУШУ** Б-346

345. **БРАТЬ ЗА ЖИВОЕ** Б-346

346. **БРАТЬ ЗА СЕРДЦЕ** сэтгэл хөдөлгө-; догдлом Б-344, 345

347. **БРАТЬ ЗА СКОБКИ** [*мат*] Хаалтнаас гарга-,

Это число возьмите за скобки Энэ тоог хаалтнаас гарга.

348. **БРАТЬ ИЗМОРОМ** В-597

349. **БРАТЬ ИНИЦИАТИВУ** санаачила-, хөдөл-, морио ташуурда-, эрвэлзэ-, эрчимлэ-

350. **БРАТЬ КУРС** Б-363

351. **БРАТЬ НА АБОРДАЖ** *кого, что* В-598

352. **БРАТЬ НА АРАПА** В-599

353. **БРАТЬ НА БУКСИР** В-601

354. **БРАТЬ НА ДУШУ** что Бодож бай-, санаж үзэ-, хичээ-, бодолцо-, хичээж базаа-, марталгүй сана-,

355. **БРАТЬ НА КАРАНДАШ** В-603

356. **БРАТЬ НА МУШКУ** Овоо хараа чиглүүл-, буу шагай-, онило

357. **БРАТЬ НА ПОРУКИ** Дааж ав-, даа-, толгойгоороо хариуца-, толгойдоо арандаг хураа-.

Друзья взяли его на поруки и он был освобождён Найз нар нь дааж аваад суллууллээ.

358. **БРАТЬ НА ПРИЦЕЛ** (на мушку) *кого, что* В-605

359. **БРАТЬ НА ПУШКУ** *кого* В-606

360. **БРАТЬ НА СЕБЯ** Даа-, хариуца-, биедээ хүлээ-

361. **БРАТЬ НА СЕБЯ СМЕЛОСТЬ** Тэгж ингэж зүрхлэ-, ... зоригло-; үзээд алда-

362. **БРАТЬ НА СЕБЯ ТРУД** В-609

363. **БРАТЬ НАПРАВЛЕНИЕ** 1. чиглэ-, зүглэ, чиг чиглэ-, зүг зүглэ-, аяс ханда-, зүг чиглэ-, чиг зүглэ-,зүг барн-, зүг ханда-; 2. Талд оро-, чиглэл баримтла-, талыг бари-

Наш самолёт взял направление на восток Онгоц маань зүүн тийшээ нисэв;

364. **БРАТЬ НАЧАЛО** Эхлэ-, үүсэ-, үүсгэ-, үүсвэрлэ-, тэрлэ-, шав тави-, үүдэ-, үүсгэж эхлэ-

365. **БРАТЬ НОТУ** Дуулж (хөгжимдөж) эхлэ-,дуу гарга-, эхий нь гарга-, ая барн-, түрүүлэ-, хөгжим өргө-, хөгжим үүсгэ-, дуу ав-, дуу эхлэ-, дуу үүсгэ-, дуу дуул-, дуу аяла-, хөгжим хөгжимдө-, ая аяла-

366. **БРАТЬ ПОД, ЗАЩИТУ** Хамгаала-, өмгөөлө-, өмөг бол-, ивээ-, ивээлдээ ав-, асралдаа ав-, нөмөртөө оруул- нөмөр нөөлгөндөө ав-, нөмөр нөөлгөндөө багтаа-, үзэж хайрла-, ивээж хайрла-, болгож хайрла-, бодож хайрла-гэх мэт.

367. **БРАТЬ ПОД ОБСТРЕЛ** В-612

368. **БРАТЬ ПОД ПОДОЗРЕНИЕ** Сэжиг ав-, сэжиглэ-, ажиг сэжиг ав-. чимээ ав-, сэрдэ-, харда-, эргэлзэ-, салхи ав-, чих цохи- сэжиг мэдэ-, сураг дуул-, хар ав-, хар буу-, чихраа дуула-

369. **БРАТЬ ПОД РУКУ** Сугада-, сугадаж ява-, дэмнэ-, түшиж ява-

370. **БРАТЬ ПОД** (свое) **КРЫЛЫШКО** В-613

371. **БРАТЬ ПОД СОМНЕНИЕ** Б-368

372. **БРАТЬ ПОД СТРАЖУ** В-614

373. **БРАТЬ ПРИМЕР** *с кого* Үлгэр ав-, дууриа-, үлгэр болго-, үлгэр хий-, жишээ ав-, дага-, даган дууриа- В-618

374. **БРАТЬ ПРИЦЕЛ** Овоо хараа тааруул-, шагай-, онил-

Бойцы взяли прицел и ждали команды Байлдагчид овоо хараагаа хэдийн чиглүүлээд тушаал хүлээн бүлгээ.

375. **БРАТЬ С БОЮ** Эрийн сайнд, бяраа үзэ-, тэмцэн ол-, дээр доро оро-, дажин бол-, амь наана там цаана, алалда-, үзээд алда-, үзээд ав-, нэр нүүргүй.

В театре было так много народу, что места приходилось брать с бою. Театрт, (эрийн сайнаар л) үзэлцэж байж суудал олохгүй бол болохооргүй олон хүн байв. (Театрт, хүн гэж учиргүй, эр охиндоо хүрч байж суудлын бараа харахаар байсан).

376. **БРАТЬ СВОЁ** 1. Санасандаа хүрэ-, санаснаа гүйцээ-, санаснаа хий-; 2. Хийх юмаа хий-, дара-, дарагда-, угна- угнуул-, дийлэ-, дийлдэ-

Наконец-то мой брат взял свое Ах минь явж явж санасандаа хүрлээ дээ (ах минь арайхийж нэг санасандаа хүрлээ дээ).

Он не мог уже работать долго: старость брала свое. (Тэр хүн) нэг их удаан ажил хийж чадахаасаа өнгөрөө биз дээ, эрийг нас дарж уулыг цас дарна гэдэг энэ дээ (одоо ч нас нь дараад он удаан зүтгэж чадахгүй бий дээ. Нас дээр гарсан тэр хүн одоо ч олон жил зүтгэж чадахгүйгээр болжээ)

377. **БРАТЬ СВОИ СЛОВА** (слово) **ОБРАТНО** (назад) В-617

378. **БРАТЬ СЕБЯ В РУКИ** Биеэ барн-, тэс-, тэвчи-,

Пора остепениться и взять себя в руки Хангир зааж биеэ барина байгаа.

379. **БРАТЬ СЛОВО** Амла-, ам өг- 1. Хуралд үг хэлэ- 2. Үг аваам ав-, за гэлгүүл-, за хүлээлгэ-

Обсуждающийся вопрос интересовал всех, слово брали и старые опытные работники и молодёжь Хэлэлцэж буй эл асуудлыг хэн хүнгүй сонирхон хуралд ахмад хангир ажилчин, залуус бүгд үг хэлэв.

380. **БРАТЬ СЛОВО НАЗАД** Б-381

381. **БРАТЬ СЛОВО ОБРАТНО** Амаа буца-, би буруу үг хэлчихжээ, хэлснээ буца-, би дэмий юм ярьчихжээ, дэмий юм хэлчихэж, хэлсэн үг буруу болог (байж).

Я могу вас просить и беру свои слова обратно. Тоогүй юм боллоо, би дэмий юм хэлчихжээ, өршөөж хайрла.

382. **БРАТЬ** *чью* **СТОРОНУ** Бүүрэлхэ-, нэгсэ-, бөөрлө-, . . . ны талд оро-, тал барн-, өмөөрө-, -тай талца-, (нэг) тал бол-, элбэ-, нэг бол-, нийл-, элэг бөлөг бол-, бооро-,

Старший брат всегда брал сторону младшего Ах нь нь дүүгээ дандаа өмөөрдөг байв.

383. **БРАТЬ УРОК** Хичээллэ-, хичээл хий-, хичээл заалга-, ном заалга-,

Брать два урока английского языка в неделю Долоо хоногт хоёр цаг англи хэлний хичээл хий-

Она берет уроки монгольского языка у профессора Улзийта Тэр эмэгтэй Өлзийт профессороор монгол хэлний хичээл заалгадаг.

385. **БРАТЬСЯ ЗА РУКИ** Гар гараасаа барилца-, хөтчи-, хөтөлцө-

386. **БРАТЬСЯ ЗА УМ** [*разг.*] Ухаан суу-, ухаан оро-, сүв нь онгой-, Нүдээ нээ-, хамраа мэдэ-, томоожи-, ухаажи-, хэрсүүжи-

Наконец-то он взялся за ум (Тэр хүн) хожим нь жаахан ухаан орсон (маань хүн сүүлдээ л жаахан ухаажих шиг боллоо).

387. **БРЕННЫЕ ОСТАНКИ** Хүүр, үхдэл, амигүй мах, шарил, яс

388. **БРЕЮЩИЙ ПОЛЁТ** Шунган нисэх, шунгах нислэг

389. **БРИЛЛИАНТОВАЯ (алмазная) СВАДЬБА** очир эрдэнийн хурим. (Европ зүгийн улс анх хуримласан цагаас авааД 75 жил болсны ойд хийх хуримын баяр).

390. **БРИТЬ ЛОБ** З-88

391. **БРОВЬЮ НЕ ПОВЁЛ** Эс хайхрав, эс тоов, огтхон ч тоохгүй байв. Үл тоомсорлов, санаанд ч үгүй байв, тоосон ч үгүй өнгөгөв, эс хэрэгсэв, хяламхийх ч үгүй, харах ч үгүй

392. **БРОДИТЬ В ПОТЁМКАХ-** Б-236

393. **БРОДЯЧИЙ ОБРАЗ ЖИЗНИ** Гүрэн хэсэж гүзээ тэжээх, олныг хэсэж олгой тэжээх; малгай тавивал манайх, маргааш бол хүнийх; хээрээр гэр хийж хэцээр дэр хийх; тэр гэх гэргүй, тэнд гэх оронгүй; орсингүй оргодол, сүчлэнгүй бадарчин; оронгүй оргодол, замгүй завхуул; гэр оронгүй, сүрэн гэргүй, тэнүүчлэн явахуй, хэсэн тэнүүчлэхүй, хэрэн хэсэхүй, орох оронгүй оочих усгүй, бадарчин шиг, үүрэг үүрч таяг тулах

394. **БРОНЗОВЫЙ ВЕК** Хүрэл зэвсгийн үе

395. **БРОНЗОВЫЙ ВЕКСЕЛЬ** [*устар. разг.*] Баталгаа бичиг

396. **БРОНИРОВАННЫЙ КУЛАК** [*газет*] Эзэрхэх цэрэг, түрэмхий цэрэг, их цэрэг

397. **БРОСАТЬ ВЗГЛЯД** *на что* Хараад ав-, ширэв татан хара-, хара-

Бросив на нас укоризненный взгляд, она вышла из комнаты Цаад хүүхэн чинь (тэр эмэгтэй) бид нарыг ширэв татан харчихаад л тасалгаанаасаа гараад явчихмуухай лаа.

398. **БРОСАТЬ ДЕНЬГИ НАПРАВО И НАЛЕВА** Мөнгө хамаа намаагүй үрэ-, мөнгөөр гараа угаа-, мөнгөөр зодо-, мөнгө зоос бүрэлгэ-, мөнгийг ус цас шиг зара-, мөнгөөр хамаагүй загна- мөнгөний баруул бол-, мөнгөөр туйла-, гар султай, мөнгийг гарын салаагаар аса-(гоожуул, мөнгө үрэмтгий, мөнгө үрж зарах нь их) мөнгөндөө гамгүй (хямгагүй, халгаатай, хайргүй), мөнгөө зөв зардаггүй, мөнгөө буруу зардаг. Б-402, Ш-19

399. **БРОСАТЬ ЗА БОРТ** В-1094.

400. **БРОСАТЬ (кидать, пускать) КАМЕНЬ (камешки) В ОГОРОД** Гоочло-, хөвөнд боосон чулуугаар цохи-, үгээр шөвгдөөмхий үгээр ута-, хөөрхөн шогло-, егөөдө- Б-418, К-344, П-1231

Это он в мой огород бросил камешек. Цаадахи чинь намайг л хөвөнд боосон чулуугаар цохисон юм. (цаадахи чинь намайг егөөдөж байсан юм).

401. **БРОСАТЬ (швырять, кидать, пускать) КАМНЕМ** *в кого* Зүхэ-, зэмлэ-, чичи-, адла-, хашраа-

402. **БРОСАТЬ НА ВЕТЕР ДЕНЬГИ** Б-398

403. **БРОСАТЬ НА ВЕТЕР СЛОВА** Ам мэдэн чалчи-, олон үгтэй, илүү үгтэй илүүр хушуутай, амныхаа зоргоор донгосо-, хамар доор хагархай ам хэмээн яри-, илүү дутуу үг яри-

404. **БРОСАТЬ ОРУЖИЕ** Бууж өг-, хулцэн дага-, дага-, зэвсгээ хураала-

405. **БРОСАТЬ СЛОВА НА ВЕТЕР** Б-403

406. **БРОСАТЬ (набрасывать) ТЕНЬ** *на кого* 1. Сүүдэр туса- 2. Алдар нэрийг гутаа- К-345

Сосны бросали тень на поляну Нарсны сүүдэр тал руу сунан тусав. (Нарсны сүүдэр талаа даган хүүшлэв).

Эта история бросила тень на его отца Энэ хэрэг эцгийн нь нэрийг гутааж байна даа.

407. **БРОСАТЬ ЯКОРЬ** 1. Зангуу орхи-, зангуу зоо-, бархаг хая-, 2. байрши-, байрагши-. К-350

408. **БРОСАТЬСЯ В ГЛАЗА** *кому* Нүднээ туса-, нүднээ өртө-, харагда-, нүдний үзүүрт тор-, нүд булаа-, К-343, 346, 349, М-117

409. **БРОСАТЬСЯ В ГОЛОВУ** Согтоо-, халаа-, сочоо-, сэрээ-, сэргээ-, сочроо К-347

410. **БРОСАТЬСЯ В НОС** Хамар цоргим үнэртэ-, ханхий-, хамар сэтэл-, сэнхий-, нэлхий- У-46

511. **БРОСАТЬСЯ СЛОВАМИ** За гэсэн бол-, дуртай дургүй хэдэн үг хэлэ-

412. **БРОСАТЬСЯ (кидаться) СО ВСЕХ НОГ** Хөл мэдэн харайхар хурдаараа, хар эрчээрээ. К-348

413. **БРОСИТЬ В ЖАР** 1. Гал цог шиг халуура-, их халуура- 2. [*перен*] (уур нь) шата-, дээлэндээ багтахгүй болтол уурла-, ямаан омог нь хөдөл-, омог нь шата-, шар нь гозой-, уур нь дүрэлзэ-, дүрсхий- К-342

414. **БРОСИТЬ В КРАСКУ** (Ичин) нүүр улай-, нүүр хала-,

415. **БРОСИТЬ** (кидать) **В ЛИЦО** (в глаза) *кому* Улаан хэлэ-, палайтал хэлэ-, улаан нүүрэн дээр нь хэлэ-, харж байхад нь хэлэ-

416. **БРОСИТЬ ВЗГЛЯД** Б-397

417. **БРОСИТЬ ВЫЗОВ** 1. Дайн зарла-; 2. Дургүй хүргэ-, зэвүү хүргэ-, шар хөдөлгө-, өдө-, хатга-, жөтө-, өдөж сөдө- С-313

418. **БРОСИТЬ ГРЯЗЬЮ** Б-400

419. **БРОСИТЬ ДЕЛО НА СЕРЕДИНЕ** [*перен*] Дутуу хая-, дутуу зуурмаг, хагас дутуу орхи-, алды нь аваад дэлэм дээр нь, атгы аваад чимх дээр нь; талы нь аваад хөтөл дээр нь

420. **БРОСИТЬ** (метать, кинуть) **ЖРЕБИЙ** 1. Эцсийн шийдвэр гарга-, цаг нь бол-, нэг тийшээ бол-, 2. шоо орхи-, шавга хая-, аз үзсэн хэрэг бол-

421. **БРОСИТЬ КОСТЬ** Гар цайлгах төдий юм өг-, өгсөн бол-, нохойд юм өх шиг

422. **БРОСИТЬ НА ВЕТЕР** Дэмий үрэ-, талаар үрэ-, гарзда-, үрэн таран хий-, аяы нь ол-, бодий нь хөтөл-, замы нь эрэ-, хэдэн тийш нь цаца-, шийш тийш нь цаца-

423. БРОСИТЬ НА КАРТУ *[перен]* П-835 С-385

424. БРОСИТЬ НА ЮЛПУТИ Н-230

425. БРОСИТЬ НА ЧАШКУ ВЕСОВ П-697

426. БРОСИТЬ ОБВИНЕНИЕ Гэмлэ-, гэм зэм тохо-

427. БРОСИТЬ (бросать) **ПЕРЧАТКУ** *кому* Хаашуй шамла- (үзэлцэхээр давшла-), хормой шуу-, хутга сугал-

428. БРОСИТЬ СВЕТ П-1142

429. БРОСИТЬ ЯКОРЬ 1. Зангуу хая, бархаг хая-; 2. Байрши-, тогто-

430. БРОСИТЬСЯ В НОГИ . . . ны өлмийд мөргө-, . . . ийн өмнө сөхрө-, сөгдө-, Б-469

431. БРОСИТЬСЯ В ОБЬЯТИЯ Тэврэлдэ-,

432. БРОСИТЬСЯ НА ПОМОЩЬ Тус хүргэ-, гар сунга-, ачила-

433. БРОСОВАЯ ЦЕНА Буусан үнэ, хямдарсан үнэ, саасан үнэ

434. БРОСОВЫЙ ЭКСПОРТ (Зорилуд) үнэ бууруулан гаргасан юм, хямдруулан гаргах юм.

435. БРЫЗЖЕТ ВЕСЕЛЬЕМ Хөл нь газар хүрэхгүй, цовоо, сэргэлэн, цог хийморьтой, эрвэлзэх, золбоотон.

436. БРЫЗЖЕТ ЗДОРОВЬЕМ Эв эрүүл, жавхаалиг, гялалзаж буй, эрүүл дорнуул, эрүүл саруул, эсэн энх, цоо эрүүл

437. БРЮКИ НА ВЫПУСК Шалбуур өмд, тавьдаг өмд, өмдөө тавьж өмсө-

438. БРЯЦАТЬ ОРУЖИЕМ Мэс хангинуул-, мэс хөдөлгө-, хутга сугал-, мэс гарга-, зэвлэхийл- П-870

439. БУБНОВЫЙ ТУЗ *[перен]* Дөрвөлжний тамга

440. БУДЕТ *кому* **ЗА ЭТО** Гор нь гарах, эз нь татах, жавтий хүртэх, урт авахуулах, хосоо сугалуулах

Будет ему за это от жены Мань эр ч одоо эхнэртээ нэг урт авахуулах болж дээ. (Эхнэртээ нэг болгуулна вий.)

441. БУДЕТ И НА НАШЕЙ (вашей, их) **УЛИЦЕ ПРАЗДНИК** Эргэх наран ээлжилдэг шүү, болох байлгүй дээ, санаа зоволтгүй, хүссэн юм хүзүүгээр чинь татна; алзахгүй, дажгүй (болно), давгүй (болно).

442. БУДЕТ С ВАС (с него, с тебя и. т. п) Ханавал ханахаар боллоо, болно доо; шавца тань ханав уу.

Будет тебе плакать, слёзы все равно не помогут. Уйлаад одоо юу хийх вэ, нулимс хаашдаа нэмэртэй юм бии дээ (уйлаад уйлаад олны шившиг, орилоод орилоод олны шившиг).

443. БУДТО БЕЛЕНЫ ОБЬЕЛСЯ Солиотой юм шиг, галзуу юм шиг; маанаг ,эр вэ?, өвчтэй юм шиг, хийтэй юм шиг.

444. БУДТО БЫ Тийм гэж үү, цээрээ үү, тиим байх, мэдэшгүй, болзошгүй, магадгүй.

445. БУДЬ ДОБР буюу **БУДЬТЕ ДОБРЫ** Хүн гуай, ах гуай; та хичээж үзээрэй, ай хөө, сайн хүү болдоо, хайрламуу.

Будьте добры, одолжите мне эту книгу Энэ номоо надад хэд хоног бариулж хайрлаач Б-456

446. БУДЬ ДРУГ (ом) Б-444

447. БУДЬ ЗДОРОВ *буюу* **БУДЬТЕ ЗДОРОВЫ** Урт насалж удаан жаргах болтугай, өлмий тэнь бат орштугай, эсэн мэнд болтугай, сайн сууж байгаарай, (найтаахад) дара эх өршөө, бурхан өршөө.

„Прощай будь здоров" сказал он мне, садясь в вагон поезда За баяртай, сайн сууж байгаарай гэж над руу хэлээд галт тэргэндээ суув.

448. БУДЬ ОН (она, оно, они) **НЕЛАДЕН** (-на, -но, -ны) Дэмий юм, дураараа болог цаашаа, яавал ч яаг, тэгвэл тэгэхээс биш, яах вэ яах вэ өөрөө мэдэг, заяа нь мэдэг.

449. БУДЬ ПОКОЕН буюу **БУДЬТЕ ПОКОЙНЫ** Санаа зоволтгүй, сэтгэлээ бүү зов гэмгүй, дажгүй, алцахгүй, давгүй.

Будьте покойны, я сдержу свое обещание Санаа зоволтгүй, би хэлсэн үгэндээ эзэн болно, (бүү зовогтун, би амандаа хүрнэ.)

450. БУДЬ ПРОКЛЯТ буюу **БУДЬТЕ ПРОКЛЯТЫ** *[прост]* Үхэж байх нь таарсан, үхээр золиг, болж хуна

451. БУДЬ ТО Юу ч гэсэн, юу ч болтугай, юу ч атугай

452. БУДЬ ТЫ ПРОКЛЯТ *[прост]* Ямар үг шүү юм бэ? Яана гэнэ ээ? Яаж байгаа нь тэр вэ?

153. БУДЬ УВЕРЕН (а) *буюу* **БУДЬТЕ УВЕРЕНЫ.** Санаа зоволтгүй лавтай, магадгүй, ярнан байхгүй, бүү зов, Сэтгэлээ зовоолтгүй, юугий нь зовох юм бэ?

454. БУДЬ, ЧТО БУДЕТ Яамай, давгүй, дажгүй, яавал ч яаг, юу ч гэсэн л, яадаг ч атугай, яадаг ч болтугай, яадаг ч байсан, дүүргэсэн хэрэг, яасан ч, дүмбийсэн толгой, яадгаа л үзье, үзээд алдах.

Будь, что будет, а на охоту все же поеду Юу ч болтугай ан гөрөөндөө л явъя.

455. БУДЬТЕ БЛАГОНАДЁЖНЫ Гэмгүй, санаа зоволтгүй, найдаж болно.

456. БУДЬТЕ ДОБРЫ Тэгж нигэж өгөөч, тэгж нигэж хайрла. Б-445

457. БУДЬТЕ КАК ДОМА Гэртээ байгаа шиг л бай, гэрэлхээд гэрээ идэхгүй, нэрлэхээд нэрээ идэхгүй, битгий нэрлэх, өөриймсүү бай.

458. БУДЬТЕ ЛЮБЕЗНЫ хичээж үзээрэй, танд л даатгая, (тэгж нигэж) хайрла, бодож үзээрэй, хичээж базаарай

459. БУЙНАЯ ГОЛОВА (головушка) цовоо хүн, хүйхэр амьтан, элдэвтэй амьтан, сүрхий толгой

450. БУКВА В БУКВУ Үгчлэн, үг үсэгчлэн, махчлан, үг үгээр нь, үсэг үсгээр нь.

Сделать перевод буква в букву Үгчилсэн орчуулга хий- (ганц үг газар гээлгүй орчуула-)

461. **БУЛАВОЧНУЮ ГОЛОВКУ** бяцхан, жижигхэн, цэг шиг, мэнгэ шиг, үрэл шиг

462 **БУЛЬВАРНЫЙ ЛИСТОК** шалиг сонин, бэртэгчний сонин

436. **БУМАГА ВСЁ ТЕРПИТ** Цааснаас биш л юм алга, юу байна вэ цаас л байна. Цаас ёо гэх юм биш, гар чилэхгүй бол бичигтүн, цаасаар өтөх;

Пусть пишут, бумага всё терпит Бичээд бай. цаас байхгүй гэх биш.

464. **БУМАЖНАЯ ДУША** [*ирон*] Үг үсгээр хөөцөлдөгч, хоосон номлогч, хэлбэрдэгч

465. **БУРИДАНОВ ОСЁЛ** [*книжн.*] 1. Номхон морины ногт, догшин морины чөдөр; дуулгавартай хүн, номой амьтан, бөхгүй тэмээ, номхон тэмээ ноолоход сайхан (амар) гэгчээр; зөөлөн хамартай хүн. зөөлөн чихтэй, үнэгүй зарц, бэлэн зарц, гар хөлийн үзүүр. 2. Гуйвамтгай, туйлбаргүй,

466. **БУРЫЙ УГОЛЬ** Хүрэн (чулуун) нүүрс (эн)

467. **БУРЯ В СТАКАНЕ ВОДЫ** Бага юманд сүр бадаргах алахаасаа өлгөх, хий дөвчигнөх, уул үзээгүй хормой . . . ус үзээгүй гутал . . . ; дайнаасаа дажин нь, нохойгоосоо гинж нь, барилдахаасаа таахалзах, зүгээр байхад зүг гаргаж зүлгэн дээгүүр тоос хадуулах

Вся их ссора-буря в стакане воды Тэднүүсийн хэрүүл ер нь ялигүй юман дээр нэг их сүржигнэцгээгээд байгаагаас өөрц юмгүй. (—Ялигүй юманд хадандаа гардаг улс); — Өчүүхэн юманд наана цаана даа тулдаг, хэрэггүй юманд хэрэлддэг улс, -жаахан юмнаас түр тар хийдэг улс)

468. **БУТЕРБРОДНЫЙ ПИСАКА** [*пренебр*] Биеэ худалдсан сэтгүүлч, бэртэгчин сэтгүүлч, ховч шаазгай шиг.

469. **БУХ В НОГИ Б—430**

470. **БЫ НИ** ч (гэсэн), ч болтугай

Кто бы ни хэн ч гэсэн, хэн бугай ч гэсэн
Что бы ни юу ч гэсэн (болтугай)
Какой бы ни Аль нь ч гэсэн, ямар нь атугай
Где бы ни хаа ч гээд, **когда бы ни** хэзээ ч гэсэн

471. **БЫВАТЬ В ОБЩЕСТВЕ** Нийлэ-, нэгдэ

Он редко бывает в обществе Хүнтэй нийлэх нь тунховор хүн шүү. (Хүнтэй нийлдэггүй амьтан, хүнтэй нийлснэ гэж байхгүй.)

472. **БЫВШИЕ ЛЮДИ** Зүрх нь үхсэн улс, зүрхээ авахуулсан улс, буурсан улс, уруудаж яваа улс, зэвэрч яваа улс, харьж яваа эрс, айсан бухлаас зорьсон бяруу дээр, хулхи нь буусан амьтан шалдаа буусан улс, бэлдээ буусан эр, аймхай улс, үхсэн буурын толгой,

473. **БЫЛ БЫ ПОКОС, ДА ПРИШЁЛ МОРОЗ** Цагийн юмыг цагт нь, бороотой ч болов болзоондоо, хуртай ч болов хугацаандаа, оройтвол доройтох, гэм нь урдаа гэмшил нь хойноо

474. **БЫЛ ТАКОВ И-4**

475. **БЫЛА БЕЗРАДОСТЕЙ ЛЮБОВЬ РАЗЛУКА БУДЕТ БЕЗ ПЕЧАЛИ (Лермонтов)** Муу нөхөрлөхөөр сайхан сал, тэн тэнгүй ачаа тэмээ малын зовлон, тэнцвэргүй амраг сэтгэл санааны зовлон, ухаангүй хүний үрд дурлаж учирсан сэтгэлээ үрсэнд орвол ууланд яваа зээрний янзгыг өрөвдөж явах минь яалаа даа, эегүй амрагаас хагацахад элэг эс эмтрэнэ, дуртай чээж, үргүй бөгс байхаар зам замаа хөөсөн нь дээр; хуурамч амрагийн салах нь амархан, эр эм хоёр байтугай эрүү толгой хоёр салдаг, дургүй ламыг дарж байж сахил хүртээснээс байсан нь дээр.

476. **БЫЛА НЕ БЫЛА** Дүүрсэн хэрэг үзээд алдах, тэртэй тэргүй айсан ч ойчно, алцайсан ч ойчно, дүүрсэн хэрэг дүмбийсэн толгой

Была не была, пойду Дүүрсэн хэрэг яваад үзье.
Знаю что это трудно, но была не была попробую Бэрхтэй гэдгий нь ч мэдээд л байна тэглээ ч гэсэн үзээд алддаг хэрэг ээ.

477. **БЫЛО БЫ БОЛОТО, А ЧЕРТИ НАЙДУТСЯ** [*прост.*] Хог дагаж хор, эх нь хээр алаг бол унага нь шийр алаг; нуур амар бол нугас амгалан; дээд хүн суудлаа олбол доод хүн гүйдлээ олно; хүн цагаа дагадаг, хун усаа дагадаг; нүх гаргаваас хүн шургана.

478. **БЫЛО БЫ КОРЫТО, А СВИНЬИ НАЙДУТСЯ** Олзонд дургүй хэн байх вэ, чөмөгнөөс хутгаа, нойрноос морио; мөнгө цагаан нүд улаан; олз эхийн сүүнээс амттай; аавын хүү олзонд үхдэг, алтан эрвээхий зуланд үхдэг; мал дагавал тос; хээрийн галуу нисэн үл хүрэх газраа хүний хүү нэр ашгийн төлөөнөө чирэгдэнэ (нэрт сайчуулын хураасан бичиг), сааль хураахаар сав хураа.

479. **БЫЛО ДА СПЛЫЛО** [*прост*] Сааль хураахаар сав хураа, хоол олдоно, хутга олдохгүй; өнгөрсөн хорвоо, өнгөрсөн юм эргэж ирэх биш дээ; дүүрсэн хэрэг дүмбийсэн толгой.

Есть деньги? -Были да сплыли Мөнгө гэнэ үү? -байх нь байсан одоо мулт.
Все это было да сплыли Энэ бүх юм өнгөрсөн хорвоо болжээ.

480. **БЫЛО И ПРОШЛО И БЫЛЬЁМ ПОРОСЛО** Нэгнээ өнгөрсөн юмыг одоо юу хийх вэ; өнгөрсөн борооны хойноос эсгий нөмрөөд яах вэ; ниргэсэн хойно нь хашгирах

481. **БЫЛЬ МОЛОДЦУ НЕ УКОР** [*посл*] Сайн эрийг өнгөрсөн муу юмаар бүү буруутга, урьдахаа бүү элэглэ, усанд унаснаа бүү шоол, цаг цагаараа цахилдаг хөхөөрөө; эрийг бүү бас далайг бүү янд;

482. **БЫЛЬЁМ (былью) ПОРОСЛО** Өнгөрсөн юм, аль дивангарын юм, үхсэн хатсаны, мартагдсан, элин галавын, галав галчингийн

илүү балрын, эрт цагийн, аль цагийн, аль язгуурын, хэзээ язаа-ны П-908

483. **БЫТОВОЁ ЯВЛЕНИЕ** Алийг тэр гэх вэ нийэрхүү юм биш-гүй л байдаг, тэгж л байдаг юм, байхаараа л нэг байдаг.

484. **БЫТЬ БЕЗ УМА**

485. **БЫТЬ БЕЛЬМОМ В (на) ГЛАЗУ** К-47, Б-139, 140

486. **БЫТЬ В ВЫИГРЫШЕ** 1. Мөрий ав-, мөнгө хожи-, 2. Сайн юм бол-, ... нь оно-, нь болж, ... нь хожиж; ... нь дээр бай-на, ... нь таарчээ.

К концу игры старик был выигрыше Тоглоом шув-тарахад өвгөн мөрий авлээ.

Мы не поехали за город и в результате оказались в выигрыше, так как весь день лил дождь (Бид нар) хотоос гараагүй нь ганц оной, өдержингөө усан борОо цутгасан шүү дээ.

487. **БЫТЬ В ГОЛОСЕ** [*разг*] Хоолой сайн гара-, хоолой цээлхэн бай-, хоолой цэргүй, хоолой цангина-, сайхан хоолойтой, сай-хан дуула.

488. **БЫТЬ В ГОСТЯХ** Зочило-, айлчила-, айлд нрэ-, (очи-), айлчин хийж ява-

Вчера были в гостях у нас все мои сослуживцы Миний ажлын газрынхан өчигдөр цөмөөрөө манайд ирцгээсэн.

489. **БЫТЬ В ЖИВЫХ** Золтой амьд гар-, жанч халах дөхө, гэ дэс нороодох шаха-, хоолныхоо савнаас хагацах шаха-, амь зулба-

490. **БЫТЬ В ЗАГОНИЕ** 1. Шал тоохгүй, жишиг ч үгүй, эс эр-хэмлэ-, юман чинээнд бодохгүй, хэрэгссэн шинжгүй. 2. Хадгал-, хураа-, хэрэгссэн янзгүй, үтээрсэн янзгүй, нүдэнд орсон мах, нүдэнд орсон хог бол- шоовдорлуул-

Книг было много, но у него они были в загоне Тэд-нийх ном ихтэй ч идий нь хийдэггүй байхаа

Сколько ещё у нас сырья в загоне? Танайх хэдий хирийн түүхий эд (хадгалж) байна?

491. **БЫТЬ В КУРСЕ** Сайн мэдэ-, нэвтэрхий, таван хуруу шигээ мэдэ-, нэгд нэгэнгүй андахгүй, андахгүй, гаргаахгүй.

Молодёжь должна быть в курсе международной по-литики Залуучууд олон улсын улс төрийн байдлыг нэв-тэрхий мэдэж байгуунтай.

Он в курсе всей работы над новым станком. Шинэ суурь машинаа ажиллуулах бүх аргаа нэгд нэгэнгүй мэднэ.

492. **БЫТЬ В ОБОЗЕ** [*перен., разг.*] Хоцро-, хаягда-, гүйцэхгүй бол-, сүүл бари-, тоосгүй алда-, хөөгөөд гүйцэхгүй, хөлд нь суугаад барихгүй, түүвир гүйцэхээ бай- П-187

493. **БЫТЬ В ОСНОВЕ** *чего* ... ыг үндэс болго-, суурила-, дэвс-гэр хий-, ... -аар үл хий-, ... -ыг нш болго-,

494. **БЫТЬ В ОТСУТСТВИИ** Байхгүй бай-, эзгүй бай-, хоосон бай-, гар-, алга (цулгуй) бай-, сул бай-, үгүй, нүднээс далд,

Брат теперь в отсутствии Ах одоо эзгүй байна (ах одоо байхгүй байна).

495. **БЫТЬ В ПОЛОЖЕНИИ** Бие давхар, жирэмсэн, хөл хүнд (мал бол) хээлтэй, боос

496. **БЫТЬ В ПРЕТЕНЗИИ** *на кого* Муу сана-, зэвүүцэ-, эвгүй-бол-, тийм бай-, тиймэрхүү бай-, дургүйцэ-, гомдо-, атаа-, ав-, өшөө-, тааламжгүй, зана-, зүхэ-, туни-, юм бодо-, И-233

Он на вас в претензии Цаадах чинь танд баахан дур-гүй.

Если до отъезда не зайдете ко мне, буду на вас в претензии Намайг явахаас өмнө нрж уулзахгүй бол би танд гомдоно шүү.

497. **БЫТЬ В ФАВОРЕ** Амраг хайрыг булаа-, янаг сэтгэлийг тата-,

Он у неё в фаворе Цаадах чинь, мэнь хүний зүрхийг су-галчихаж (Тэр хүн) түүний сэтгэлийг хөвсөлзүүлчих-жээ.

498. **БЫТЬ В ФАРВАТЕРЕ** *кого чего буюу чьей* (политики) П-201

499. **БЫТЬ ВЕРНЫМ СЕБЕ** Цуцалтгүй, шантаршгүй, тууштай, махруу, улаамтгай, буцдаггүй.

500. **БЫТЬ ВНЕ СЕБЯ** Байж яда-, тэчияда-,

501. **БЫТЬ ВЫСОКОГО МНЕНИЯ** Таал-, эрхэмлэ-, хүндэтгэ-, биш-рэ-, ойшоо-, тоо-, дээдлэ-.

Быть не очень высокого мнения Нэг их таалагддаггүй юм.

Быть высокого мнения о себе Өөрийгөө их дээгүүрт үзэ-,

Я был высокого мнения о нём, но ошибся Тэр хүний тэнь олигтой хүн гэж их тоодог байсан минь буруу байжээ. В-1228

502. **БЫТЬ ГЛАЗАМИ И УШАМИ** *чьими, кого* нүд чих бол-,

Он был полном смысле слоза глазами и ушами глав ного командования Тэр хүн чухамдаа жанжны ёстой л нэг нүд чих түшээ түшиг нь болсон хүн бүлгээ.

503. **БЫТЬ ГОЛОВОЙ ВЫШЕ** Хүзүүгээр илүү, цоорсон, хүн хү-нээс ухаантай, эгнэхгүй ухаантай, жишишгүй ухаантай, эгэл биш, эгэлгүй, эгнэшгүй толгойтой, хосгүй, өөр хүн, жичдээ. хүн, яггүй ухаантай, таггүй хүн, зүгээргүй, ухаантай, анги,

504. **БЫТЬ ЗАНЯТЫМ СОБОЙ** 3-223

505. **БЫТЬ И СИТЕ И В РЕШЕТЕ** Хал үзэж хашир тани-, хал үзэж халуун чулуу долоо-, хол ойр явж хал доль цохи-, үхэхээс буусдыг үзэ-, зовлон жаргал үзэ-, юм юм үзэ-.

506. **БЫТЬ ИГРУШКОЙ в чьих-либо рукак** Хүний гар хөл бол-, хэн хүний нохойны мод бол-, хүний тогооны алчуур бол-, боо-лын боол бол-, сайхан зарц бол-, номхон морины нь ногт, дог-шин морины нь чөдөр бол-,

507. БЫТЬ ИЛИ НЕ БЫТЬ Түдгэлзэ-, эргэлзэ-, шийдэж цөхө-, . . . нэг хэцүү, байх нэг хэцүү, дүлэгнэ-, нэг бол-, . . . эсхүл за үгүй хоёрын хооронд улцагана-, үхсэн амьд нь мэдэгдэхгүй, бий үгүй хоёр нь мэдэгдэхгүй, бааж чадахгүй нохойн хөл хөлдөө-, гүйх нохойн өмнө гүйхгүй нохой саад; явна явна гэж ямааны мах; үхнэ үхнэ гэж үхрийн мах; иг маг хий-,

508. БЫТЬ (видным), КАК НА ЛАДОНИ Ив ил, нүдэн дээр
С горы вся деревня видна, как на ладони Уулан дээрээс гацаа тосгод, алган дээр байгаа юм шиг харагдана К-185, 134

509. БЫТЬ КАТОЛИЧНЕЕ ПАПЫ Гүзээнд наалдсан дэлүү шиг, сүүл шиг, сүүдэр шиг, нойтон хамуу шиг, зангуу айтай,

509. а. БЫТЬ МЕРТВОЙ БУКВОЙ Балархай үсэг

510. БЫТЬ МОЖЕТ Юмыг яаж мэдэх вэ, мэдэшгүй, магадгүй, болох юм.

511. БЫТЬ НА ВИДУ Их санаатай, буурь суурь хөөцөлдө-, зэрэг хэргэм хөөцөлдө-, цамаан, сайрхуу, юман түрүүнд самбаганахөгшөд хөлөө хөндлөнд хүзүүгээ; сүүгүй хонь холбоонд, дур эзнээ голдоггүй, дунд чөмөг сүүжээ голдоггүй

512. БЫТЬ НА ВЫСОТЕ Додигор, дээгүүр зантай, хээнцэр ихэмсэг, их зандааны (эр), их гарын эд, баргийн нөхөр биш, саваагүй нохой, их зангай сээмсгэр зангай, хямсгар, биеэ үгүйлдэггүй.

513. БЫТЬ НА ГРАНИЦЕ (грань) *чего* . . . ын даваан дээр, . . . даг[4] дээр, . . . -ын толгой дээр; дэш дуй дээсэн дөрөөн дээр: ам мөлтөс, золтой л (тэгэн нигэн) алда-, хариугүй (тэгэх, нигэх), хутганы ир дээр, заяатай, л дөнгөн данган.

На границе безумия Галзуурахад ганц хуруу дутуу.

514. БЫТЬ НА ИСХОДЕ Нохойн дуу ойрто-, шувтрах (дуусах) тийшээ ханда-, модоо барихын даваан дээр бай-, сүүлий нь мушгих л гэж байна, шилий нь харах л гэж бай-.

Патроны на исходе Сум дуусах тийшээ хандаж байна. **День уже на исходе** Энэ өдөр нигээд шувтрах тийшээ хандаж байна, (нар таших байна, нар унь өөд өгсөж явна.)

515. БЫТЬ НА КРАЮ МОГИЛЫ (гроба гибели) Үхэх сэхэхийн даваан дээр, үхдэгийн (сенөдгийн) даваан дээр, нэг хөл дөрөөнд, нэг хөл шороонд, гол нь тасран алда-, үхэж гүйцээд, өнгөрдгийн даваан дээр, хоногоо хүлээж байтал, үхдэг дээр шийдээд байтал, үхдэг дээр ишлээд байгал.

516. БЫТЬ НА НОЖАХ *с кем* . . .тай хутагтын дайсан, тангараг нь тонгорог болсон, хонь чоно хоёр шиг, шуудайд хийсэн үхрийн эвэр шиг, тангараг тасра-, гал ус хоёр шиг, гэрт нь морьтойгоо гэдсэнд нь хутгатайгаа оро-.

Соседи были на ножах Айл саахалтынхан хоорондоо шуу дайд хийсэн үхрийн эвэр шиг байв. Хөршүүд хонь чоно болжээ.

517. БЫТЬ НА ОТЛЕТЕ [*разг.*] (Мод ваадан) морь эмээлтэй байдөрөөгөө дөрөөлчөөд байх-, мордохын даваан дээр бай-, хариугүй л, жин тан бол-, яг таг бол-.

Вы уезжаете? -Да я уже на отлете. Та явах гэж байна уу? -Ээд ээ хариугүй л мордох гээд байж байна

518. БЫТЬ НА ПОМОЧАХ *у кого* хүний гар хара-, хүний царай хара-, толгойгоо даахгүй, өргүүлж бариулж бай-, хүний хүчинд, хүний дэмэнд шүтэ- Н-559.

519. БЫТЬ НА ПОСЫЛКАХ *у кого* Гарын үзүүрээр зарагда-, хар, бор ажил хийж өг-, тогооны алчуур бол-, номхон морины ногт дошгин морины чөдөр; бөхгүй тэмээ бол-, хүний (бусдын) гар хөл бол-,хүний ташуур бол-, гар хөлийн үзүүр,

Охота быть тебе лишь на посылках? (Грибоедов) Гар хөлийн үзүүрийн зарц болохсон гээд байгаа юм уу чи чинь?

520. БЫТЬ НА ПУТИ [*книжн.*] шаха-, дөхө-,хариугүй даваандээр.

Художник этот на пути к славе Энэ зураач нэрд гарч байгаа хүн дээ.

Быть на пути к окончательной победе Хариугүй төгс ялдаг дээрээ.

521. БЫТЬ НА СЕДМОМ НЕБЕ хөл хөөрцөг бол-, хөл нь газар хүрэхгүй бол-, магнайгаа хагартал баярла-, баярын магнай тэний-, тэсгэлгүй баярла-

522. БЫТЬ НА СТРАЖЕ ИНТЕРЕСОВ Тусд зори-, элэг тат-

523. БЫТЬ НАКОРОТКЕ *с кем* [*разг.*] Шадар бай-, үй зайгүй ява-, нэг дээлтэй нэг морьтой; орсон ч цуг гарсан ч цуг; холбоотой (хэлхээтэй) юм шиг. Ижий ахай, аман дахиа хуваадаг, чиний миний үгүй, гарын наймз, төө зайгүй,

524. БЫТЬ НАЧЕКУ Сонор сторгог, сэргэмжтэй бай-, мэдээтэй бай (ява-,) чих тави-, дотроо бодолтой, гаднаа суурьтай; дотроо ухаантай, доороо суурьтай; урт чихтэй хурц нүдтэй.

525. БЫТЬ НЕ В СВОЕЙ ТАРЕЛКЕ [*разг.*] Н-618

526. БЫТЬ НЕ В ДУХЕ Цухалдуу бай-, муухай ааштай бай-хүйгээнүүр бай-,

527. БЫТЬ НЕЧИСТЫМ НА РУКУ Юм хумсалдаг, хуруу хумстай, гартаа цавуутай, юм нуудаг; [*ирон*] Уран гартай, гартаа дүйтэй, урт гартай, юм чимхдэг.

528. БЫТЬ ОДНИХ ВКУСОВ Гар нийлэ-, санаа нийлэ-, шаа нийлэ-, ганзага нийлэ-, дуу дуугаа авалца-,

529. БЫТЬ ОДНОГО ВКУСА Аятайхан амттай, идэхэд аятайхан, хорхой асмаар, арааны шүлс асгарсан, чихэр уусаад л.

530. БЫТЬ ПОД МУХОЙ Б-537

531. БЫТЬ ПОД ПОДОЗРЕНИЕМ Сэрэмжтэй, сэжиглэгдэ-, харцуул, юу ч бол доо, ээ мэдэхгүй дээ, нэг л жигтэй, нэг л хачин.

532. БЫТЬ ПОД РУЖЬЁМ 1. Дайн дажинтай бай-, 2. Цэргийн албан хааж бай-, цаг төр үймээнтэй, цэрэгт бай-, одтой тэнгэр орчиж орондоо унтах завгүй, хөрст дэлхий хөрөөж, хөнжилдөө орох завгүй. Н-555

С 1941-ого по 1945-ый год я был под ружьём 1941 оноос 1945 оны хооронд би цэргийн албан хааж байлаа.

533. **БЫТЬ ПОД СЕМУ** [*ист.*] Ёсоор болго-, ёсчлон гүйцэтгэ-, [*перен.*] нигэж шийдэ-, яг таг бол-

534. **БЫТЬ РАЗНОГО ВКУСА** Идэнги муутай, идэхэд эвгүй, хоёр чихнээс хойш гарахгүй (орохгүй). Аминаас ойчих (унтчих) гэ-

535. **БЫТЬ РАЗНЫХ ВКУСОВ** Санаа ул нийлэ-, нийлэмжгүй, дур дураараа., хүн хүний дур, гүзээ гүзээний булан.

536. **БЫТЬ С кем НА ВЫ** Бие биеэ та та гэлцэ-, та гэж дууда-, та-ла-

537. **БЫТЬ С МУХОЙ** Шал согтуу бай-, мал болтол согто-, нохойд амаа долоолго-, Б-530

538. **БЫТЬ САМ СОБОЮ** Байгаагаараа л байдаг янзаараа л нэг л янзаараа, нэг л зайгаараа, байгаа нь л тэр, ердөө л ийм хүн.

539. **БЫТЬ У КОРМИЛА ВЛАСТИ** Төрийн жолоо бари-, төр бари-,

540. **БЫТЬ У ПРАЗДНИКА** 1. [*разг.*] Найр наадамд очи-, 2. [*ирон*] Хөгөө тари-, сүйд бол-, наяшгаа хутга- байдгаа дэлгэ-, шившигээ дэлгэ-, мундраа хутгаж муугаа тануул-,

541. **БЬЁТ ПО КАРМАНУ** Б-197 У-42

В

1. **В АВАНТАЖЕ (обретаться, быть)** Сайхан харагда-, хий морьтой, өнгөтэй, харахад гоёмсог. нүд (хараа) булаасан, нүдэнд дулаахан

   Она вчера была не в авантаже (Тэр эмэгтэй) өчигдөр явай муутайхан харагдаж байна билээ. (Энэ хүүхэн өчигдөр царай муутай (хийморьгүй) харагдлаа. (Тэр бүсгүй өчигдөр доожоо муутай харагдсан).

2. **В АДРЕС** (Хэн хүнд) хандан; хэн хүний тухайгай, . . , -д (т)

3. **В АЖУРЕ** [*прост.*] Ёсоороо, ном дагуу; зүй ёсоороо, жам ёсоороо

4. **В АККУРАТЕ** [*прост.*] Яг, яг таг, жин тан, шахсан бяслаг шаасан гадас шиг, чамбай.

   Все в аккурате Юм болгон жин тан, Яг яг тан жимбийн тав

5. **(В АРТЕЛЕ КАША ГУЩЕ БЫВАЕТ** Олны олон тавган нэн; бүгдээрээ хэлэлцвэл буруугүй, бүлээн усаар угаавал хиргүй;

6. **В БЕГАХ** [*разг.*]. Борив бохис хийхгүй, шээх завгүй, хавир битэр гэх жорсо холхио тасрахгүй

   Сегодня у меня весь день прошёл в бегах Өнөөдөржингөө би нэг ч борив бохис хийж чадсангүй.

7. **В БЛИЗКИХ ОТНОШЕНИЯХ** Сэтгэлтэй бай-, янагийн сэтгэлтэй, ойр дотно бол-, шахам шадар бай-.

8. **В БОЛЬШИМ И МАЛЮМ** ямар ч юманд, их бага алин боловч юунд ч

9. **В БОЛЬШИНСТВЕ СЛУЧАЕВ** Голцуухан, ихэвчлэн, ер нь л; зонхилон, дийлэнхдээ, ихэнхдээ, их төлөв, гол төлөв, бараглаж л, голдуу л, баахан, олонхидоо

10. **В (большом) ХОДУ** 1. Амархан борлодог, дорхноо алга болдог, гүйлгээтэй; 2. Заншилтай, заншил, дэлгэр

    Этот ситец в большом ходу Иймэрээн даавуу их сайн гүйдэг юм шүү.

    Такой товар у нас не в ходу Ийнай энд ийм бараа ер борлож өгдөггүй юм.

11. **В БОРОДУ** С—567

12. **В БУКВАЛЬНОМ СМЫСЛЕ СЛОВА** Ер нь л, шулуухан л, чухамдаа л, ний нуугүй хэлэхэд, үнэндээ л, улаан цайм хэлэхэд, нэмж хасалгүй хэлэхэд, нууж хаалгүй хэлэхэд, ганц ч газар гээлгүй.

13. **В БЫТНОСТЬ** . . . Үед, . . . байхад, ахуй цагт, . . . нийн өнгөн дээр

    В бытность мою в Москве Намайг Москвад байхад **В бытность его министром** Тэр хүнийг сайд ахуй үес (Тэр хүнийг сайд сууж байхад).

14. **В ВИДАХ** Санаатай, зорилгоор, бодолтой, тэгэхээс тэгэх гэж зориуд

15. **В ВИДЕ** Болох зүйл, болох

    В виде исключения Тайлагдал болох зүйл, (жичдээ бас учиртай, өөр шалтгаантай, жич, жичлэх нь)

16. **В ВИДУ** Санаанд, бодолд, бодож байгаад

    У меня нет ничего подходящего в виду Миний санаанд тохирох юм огт алга.

17. **В Воду** Х-88

18. **В ВОЗДУХЕ (носится *духу* чувствуется)** Олонд, олны дотор, түмэнд, нийгэмд, хэнд ч гэсэн; хөдөө гадаагүй, хэн хүнгүй хэний янаагүй, хэнг янтгүй, хэний мэнэйгүй, амьтан, улс

    В воздухе чувствовалась война Хэн хүнгүй л дайн гарах тухай бодох болжээ.

19. **В ВОЛЮ** [*разг.*] Аль байлгаараа, аль чадахаараа л, чадах чинээгээрээ л, аль болохоор, хичээх, улайх, эрвий дэрвийхээрээ, дэм дэмээрээ дээс эрчээрээ, хирээрээ л, хир чадлаараа, байдаг чадлаараа, хир баргаараа.

20. **В ВЫГОДНОМ ОСВЕЩЕНИИ** В-21

21. **В ВЫГОДНОМ СВЕТЕ (освещении) (представлять, выставлять)** *кого-что* болох бүхнээр нь, болох л талаас нь

22. **В ВЫСШЕЙ СТЕПЕНИ** Тун, даан, сүрхий, жигтэй, асар, үлэмж, луг,гойд, гоц, сайн, маш сайн

Кассир наш был в высшей степени порядочным человеком. Манай мөнгөний нярав сүрхий чамбай хүн байж билээ.

23. **В ГЛАЗА** Нүүрэн дээр нь харж байхад нь, нүдэн дээр нь

24. **В ГЛАЗА ВЫХВАЛИВАЮТ, А ЗА ОЧИ РУГАЮТ** Нүүрэн дээр нь магтаад нүдэн далд муулдаг; ил магтаж далд муулдаг, хэлэн дээр нь чихэр шилэн дээр нь хутга.

25. **В ГЛАЗА ЛАСКАЕТ, А ЗА ГЛАЗА ЛАЕТ** Нүүрэн дээр нь хөөрхий хөөрхий нүдэн далд нь уруул шүд

26. **В ГЛАЗА НЕ ВИДАЛ** [*разг.*] Үзэж явааг үй, бараагий нь огт хараагүй, нүдний гэм, бүү мэд, өдрийн од шиг, ор бараагүй оготны чимээгүй

27. **В ГЛАЗА НЕ ВИДЕТЬ (не видать)** Огт үзэгдээгүй, ер харагдахгүй

28. **В ГЛАЗА (сказать)** Улаан нүүрэн дээр нь (хэлэ-), улайтал хэлэ-, палайтал хэлээд тавьж орхи-, нүдэнд нь хуруу чичи-

29. **В ГЛАЗАХ** 1 . . .-ийн өмнө илхэн; 2. . . .-ний нүдээр харахад, бодоход, санахад

Он высоко стоял в наших глазах Маны санахад тэр хүн ч овоо юм шиг байдаг юм.

Разоблачить себя в глазах всего мира Дэвэн дэлхийн амьтны (нүдний) өмнө гуулна цухуйлга- ногоо зэсээ цухуйлга-

30. **В ГЛАЗАХ СТЫДА НЕТ** Ичих нүүрээ барсан, айх ичихээ байсан, ичих нүүрэндээ илэг нааж айх нүүрэндээ адсага наасан; цагаандаа гарсан амьтан; уйлахдаа тулсан эд

31. **В ГЛАЗАХ ТЕМНЕЕТ (мутится, зеленеет)** *у кого* Цог нь буурсан, жавхаа нь тасарсан, нүднийх нь гал буурсан, тамирдсан, сулдсан, унан алдаж, жалхгүй, явайгүй, уруу царайлсан, үхээнц, гал цоггүй.

32. **В ГЛУБИНЕ ДУШИ (из глубины души, до глубины души, сердца, от глубины души)** Дотроо, аминдаа, санаанихаа мухарт, цаанаа бол ч, цээжиндээ,

В глубине души старик был согласен Өвгөн (гуай) дотроо дуртай нь аргагүй байв.

33. **в чьи ГОДЫ** . . .-ны насан дээр, (тань) чам шиг байхдаа, . . . насандаа, . . . -ийн үед

В твой годы я уже работал на заводе Чиний насан дээр би үйлдвэрт ажил хийж явлаа шүү дээ.

34. **В ГОЛОВАХ** [*разг.*] Дэргэд нь, хөл дор нь, дэрэн дээр нь, хаяанд нь, гадаа нь

Дурак спит, а счастье в головах лежит Завдаа муут заяан дээгүүрээ гишиглэж байдаг.

35. **В ГОЛОВЕ КАКОЙ-ТО (одной) КЛЁПКИ НЕХВАТЕТ** [*погов.*] мунхаг хүний мунгинаа мундахгүй, тэнэг хүн тэр энийг ялгахгүй.

36. **В ГОЛОВЫ (голову)** Хар толгойдоо, хар биендээ, өөртөө тэндээ, эндээ

37. **В ГОЛОС** Чанга (хашгирах), орь дуу (тавих), тэнхээ мэдэн.

38. **В ГОЛОСЕ** Хоолой гарах, хоолойтой, хоолой цэргүй гарах, сайхан хоолойтой.

Певец в голосе Дуучны хоолой сайн гарч байна.

39. **В ГОРУ** 1. Уул өөд авирах, 2. [*перен*]. Тушаал хэргэм дэвших, мандах, дээр гарах

Лошади с трудом поднимались в гору Морь газрын өөд арай чарай өгсөж байв.

Дэчин по службе пошёл в гору Дэчин ч их дэвшиж байна.

40. **В ГОСТЯХ ХОРОШО, А ДОМА ЛУЧЩЕ** [*посл*] Хар гэртээ хаан, бор гэртээ богд; хүний эрхээр тос уухаар, өөрийн эрхээр ус уу; айлд идсэн хоол хоол болдоггүй; айлын хоол амттай ч гэрийн хоолны зай гэдсэнд үлддэг.

41. **В ГРАДУСЕ** П-410

42. **В ГРОШ НЕ СТАВИТЬ** Н-1074

43. **В ДАЛЬНЕЙШЕМ** Хэт нь, хойшдоо, цаашдаа, алс нь, үүнээс хойш, түүнээс цааш, яваа яваандаа, тэгэж тэгэж, сүүл сүүлдээ, хожим хойш доо.

44. **В ДВА СВЕТА** Хоёр мөр цонхтой, хоёр эгнээ цонхтой

Зал в два света Хоёр мөр цонхтой их танхим

45. **В ДВА СЧЁТА** [*прост*] Тэр дор нь, зогсоогоор, даруй, одоохон, цөхөлтгүй, төдөлгүй,зовлонгүй хийх, дороо л, яах ийхийн зуургүй В-385

В два счёта с хожу на почту Даруйхан шуудан руу очъё (одоохон шуудан дээр очлоо).

Ехать недалеко, в два счёта доедем Унаагаар явахад юуных нь холдох юм бэ? Одоохон л хүрчихнэ.

46. **В ДВУХ** (в трех и,нескольких) **ШАГАХ** хоёр гуравхан алхмын газар, хэдхэн алхаад, хэдхэн алхмын цаана, энүүхэнд, хаяанд, айл

47. **В ДЕВКАХ** [*прост.*] Эрд гараагүй, хүүхнээрээ, ус хагалаагүй

48. **В ДИКОВИНКУ** В—49.

49. **В ДИКОВИНУ** [*разг.*] Этгээд сонин, жигтэй, гайхалтай, сонин, хүн болсоор дайралдаж байгаа нь энэ, анх үзэх, эхлэж үзэх

Известно, что слоны в диковинку у нас (Крылов) Манай энд заан их сонин гэдэг нь мэдээж.

Это мне не в диковину Би үүнийг анх үзэж байгаа бишээ.

50. **В ДОБРЫЙ ЧАС** Сайн яваарай, үйлс тэнь урагшгай болтугай, санасан бүхэн чинь номын ёсоор болтугай, заа мэндсайхан цайгаа чанаад тавьж байя, санасан чинь сэтгэлчлэн бүттүгэй

51. **В ДОБРЫЙ ЧАС МОЛВИТЬ, В ХУДОЙ ПОМОЛЧАТЬ** [*погов.*] Уйлсныг бүү асуу, инээснийг асуу.

52. **В ДОВЕРШЕНИЕ (всего)** . . . Мууд муу нэмэр, муухайд улцан нэмэр; нэмэр дээр нэмээс болох, уруудахад буруутах гэж, ядсан нохойд хатсан баас; оройтоход доройтох, ядрахад яр

53. **В ДОЛБЕЖКУ** Хоосон цээжлэх, дэмий их цээжлэх, хий бясалгах

54. **В ДОЛГ** 1. Зээлэх, өр тавих, өрөнд орох;

55. **В ДОЛГИЙ ЯЩИК ОТКЛАДЫВАТЬ** Хойш тавк-,арга саам хий-,хоног түлхэ-,цааргала-,цаг алда-,

Хотелось поскорее кончать все, не откладывая в долгий ящик (Гоголь. Мертвые души) Хойш тавьж хоног түлхэлгүй юутай хүүтэй нь шалавхан гүйцээчих юмсандаа.

56. **В ДОЛЕ** Хуруу дүрэлцсэн, хийлцэгч

57. **В ДОЛГУ, КАК В ШЁЛКУ** [*посл.*] Өр гэдэг үстэй толгойноос их, өр мянган лан хүрэхээр тайжийн санаа амардаг гэгч болоод байна. Өрөндөө баригдаж, өтөндөө таталдах, өрнийхөө доороос босохгүй болох.

58 **В ДОПОЛНЕНИЕ К** . . . Үүнээс гадна, бас, тэрний дээрээс үгүй бас, мартсанаас, бас нэг юм, бас, басхүү, тэрчлэн, улмаар, мөн, үүн чацуу, үүний зэрэгцээ, нөгөөтэйгүүр, мөнхүү, тэгээд, цааш нь

59. **В ДОРОГУ** Замдаа хэрэглэхээр Н-93

В дорогу мы набрали с собой много книг и журналов. Бид замдаа унших гэж зөндөө ном сэтгүүл авсан

60. **В ДОСКУ** [*прост*] Бүрмөсөн. гүйцэд, шал, ог, огт, огоот

Пьян в доску Шал согтуу (мал болтол согтсон).

61. **В ДРЕБЕЗГИ** [*разг*] Бут ниргэх, зад цохих, ямбий болтол нь, үй цохих, яй цохих, хэмх цохих, бяц цохих

62. **В ДРУГИХ ОТНОШЕНИЯХ** Ондооноороо, бусдаараа

63. **В ДУХЕ** Урамтай, цовоо, хийморилог

64. **В ДУШЕ** 1. Дотроо; 2. Сэтгэлээрээ, угаасаа, яснаасаа, үнэнээсээ, үнэнхээрийн, цаанаа, дотроо, битүүдээ

В душе Содов не был согласен. Содов дотроо дурамж хан байв.

Он поэт в душе Тэр хүн сэтгэлээрээ яруу найрагч юм (Энэ ч ясны яруу найрагч хүн юмаа. Тэр хүн ч нэг төрсөн шүлэгч дээ. Тэр заяаны яруу найрагч.)

65. **В ДЫМ** Хөлчүүрэх, сархад толгойд гарах, улаан зээрд болох толгой эргэх, согтох, мэнэрэх, манарах

66. **В ЕЖОВЫХ РУКАВИЦАХ (держать)** *кого* [*разг.*] Хатуу гараар атгах, шүүсий нь шахах, голы нь самнах

67. **В ЖИВОТЕ И СМЕРТИ БОГ ВОЛЕН** Үхэх сэхэх тэнгэрийн таалалд, ус уух, яс хөсрөхийг тэнгэр мэднэ; хүний гарт орох, өөрийн мэдрэлгүй (ухаангүй)

Он очень плох, иногда заговариваестся и весь день сидит как дитя глупое-а в животе и смерти бог волен (Пушкин, Дубровский) Түүний бие их муу, заримдаа солнорон донгосож, заримдаа өдөр турш балчир хүүхэд шиг дэмий алмайран суудаг болчихжээ

— Үхэх сэхэх нь цөм тэнгэрийн таалалд . . .

68. **В ЗАВЕРШЕНИЕ (всего)** Сүүлий нь мушгих, дуусгах, цааш нь харуулах, шувтлах, шилий нь харах

69. **В ЗАВОДЕ НЕТ** [*разг.*] Ерөөсөө байхгүй, угаасаа байдаггүй, цаанаасаа байхгүй, байх газаргүй

70. **В ЗАГОНЕ** [*разг.*] Доорд үзэгдэх, жижиглүүлэх, шоовдорлуулах, шоодогдох, нүд үзүүрлүүлэх, нүдэнд орсон хог, шүдэнд орсон мах шиг, доорд үзэгдэх, өврөөс нь гараагүй араас нь гарсан юм шиг, адлагдах, элэг бариулах

71. **В ЗАПАСЕ** Байж байхад хэрэг болно, байж байхад хоол нэхэх юм биш, илүүтэй юм биш, тээртэй юм биш

72. **В ЗАТЫЛОК (становиться)** Шил шилээ хараад, хойно хойноосоо, сүүл дарач, жингийн тэмээ шиг, нүүдлийн шувуу шиг, зэл татан зэллэн, зээглэн, эгнэн, цувран, хөврөн, жирийн

73. **В ЗАЧЁТ** *чего* тооцох, тооцоонд авах,

74. **В ЗДОРОВОМ ТЕЛЕ-ЗДОРОВЫЙ ДУХ** Эрүүл биенд саруул ухаан оршино.

75. **В ЗЕМЛЕ СЫРОЙ (лежать, спать, находиться и т. д.)** Үхэ-, энгэр түши-,булш бунханд орши-,оршлын оронд бай-,нутаг сахи-,ханат гэрээс хагацаж хадан гэрт очи-,өвгөдийн хойноос одо-,бүрлээч бол-

76. **В ЗНАК** Үзүүлэх гэж, харуулж мэдэгдэх гэж; илтгэхийн тул, илчлэх гэж, тэмдэг болгож, таниулах гэж

В знак дружбы Найрсаг байгаагаа үзүүлэх гэж, найрсгийн тэмдэг болгон.

В знах протеста Эсэргүүцэж байгаагаа мэдэгдэх гэж

77. **В ЗУБАХ НАВЯЗЛО** [*разг*] Зэвүүцэх, залхах, ярьшигтай, төвөгшөөх, хөмхий зуух, шазуур зуух, нүд үзүүрлэх, тээр шаах уйдах, сонь буурах, шүд зуух, занах, зүхэх

Бесконечные споры об одном и том же-это мне уже в зубах навязло Зогсоо зайгүй хэрүүл уруул хийгээд шал яршигтай санагдах юм.

Эту картину я видел уже четыре раза. Она мне в зубах навязла. Энэ киног би дөрөв дахин үзчихллээ. Одоо ч залхаж гүйцлээ.

78. **В ЗУБЫ** Мөнгөөр зодох, хээл цутгах, хахуульдах

Я ему трёшницу в зубы Би түүнд гурван рублийн хээл цутгав.

79. **В ИЗБЫТКЕ БЛАГОДАРНОСТИ (признательности, чувств и. т. п.)** Тэсгэлгүй баярлан, чин сэтгэлээсээ талархан, магнай хагартлаа баярлах, баярлаад хөл газар хүрэхгүй явах

В избытке благодарности он даже чуть не заплакал. Тэр вэвр баярласандаа арай л уйлсангүй (Мань хүн баярласандаа болоод доголон нулимстай л байлаа).

80. **В ИНТЕРЕСНОМ ПОЛОЖЕНИИ** Бие шалтгаантай (болох), хөл хүнд (болох) бие эрүүлгүй, бие давхар, бие муутай, гэдэстэй, их гэдэстэй, цүдгэр, гэдсэндээ юмтай, олз олсон үе, гэдсэндээ хүүхэдтэй

81. **В ИСПОЛНЕНИЕ (во исполнение)** *чего* (Албан бичиг тэргүүтнийг) дагаж шийтгүүлэх, мөрдөн баримтлах, дагаж мөрдөх

82. **В КАВЫЧКАХ** *[разг.,ирон.]* Юм биздээ, шуу юм, бид хоёр ч дээ, ухаантай юм, . . . гэгч, нэрнээс цаашгүй

Учёный в кавычках Эрдэмтэн шүү юм, (эрдэмтэн ухаантай юм). Бид хоёрын эрдэмтэн ч дээ.

83. **В КАПУСТУ РУБИТЬ (изрубить)** Хэсэг бусаг болго-, өөдөс залтас болго-,жиргэ-

84. **В КАРАНДАШЕ** Харандаагаар

85. **В КАРМАН ЗА СЛОВОМ НЕ ЛЕЗТЬ (не ходить)** Амтай аманцар, хэлтэй амтай, түгдрэхгүй, шилээ маажихгүй, үг гэдгийг урсга-, хэлэмгий, шаламгай; ам гэж улаан хазаар; ус цас шиг; хэлнэ ч гэж хэлж байна; *[ирон]* Амаа үрж идчихээ шахсан; ам хамар гэж яана; бэлэн зэлэн, бэлэн үгтэй,

86. **В КАРМАНЕ СВИСТИТ** Өвөр хоосон, улаан мөнгө ч үгүй, сохор зоос ч үгүй, уутаа гүвчихсэн, хорголоо хатаажээ, өвөр түрийгээ хооссолжээ, түрийвч хоосон, хэтэвч хоосон С-258, В-547

У меня, брат, в кармане свистит Ээ (ах) дүү минь би улаан мөнгө ч үгүй болоод явж байна.

87. **В КАЧЕСТВЕ** *кого-чего [книжн.]* болох, болгон,

В качестве друга Нехрийн ёсоор, нөхөр болох, тулж түших

В качестве примера Жишээ болгох, үлгэр болгох

88. **В КАЧЕСТВЕ ТАКОВОГО** *[книжн.]* Өөрийнхөөрөө, өөртөө, хирэндээ, аминдаа

89. **В КВАДРАТЕ** *[шутл.]* Давхар давхар, хувь илүү, илүүтэй давхцан, . . . гэмээ нэг . . . ;- ийн цаад . . . ; хаанаасаа ч харсан нэг . . . ,

Дурак в квадрате Тэнэг гэмээ нэг тэнэг (тэнэгийн цаад тэнэг).

90. **В КОГТЯХ** гарт орсон, дөнгөлүүлсэн, дөнгөнд орсонтой адил, . . . -аа атгуулсан, базуулсан, бүргэдийн саварт орсон болжмор шиг болсон, эрхэнд нь орсон

91. **В КОИ-ТО ВЕКИ** *[разг.]* Удаж удаж, арайхийж, хэзээ хойно, байж байж, тээр сүүлд, гүйцсэн хойно

Сегодня в кои веки мы собрались в театр Бид өнөөдөр л арайхийж нэг жүжгийн хүрээлэнд очихоор боллоо.

92. **В КОМПАНИИ** *с кем* Хавсайдах, нам нийлэх, нэгсэх, шадарлах, нэгдэх, (элэг) бүлэглэх, найзан дундаа

93. **В КОНЕЦ** Бүр, бүрэн, төгс, яг, хуу, ханги, онхи нь, ор тас

94. **В КОНЕЧНОМ СЧЁТЕ** (итоге) Дүндээ, явж явж, эцсийн бүлэгт, адаг сүүлд нь, ингэж дуусдаг байж, шувтаргандаа, бөгсөндөө, тэгэж тэгэж

В конечном счёте мы остались в выигрыш Дүндээ бид хожив шив дээ.

95. **В КОНЦЕ КОНЦОВ*** Явж явж, тэгэж тэгэж байж, адаг сүүлдээ, эцсийн бөлөгт, үр нь, шувтаргандаа, эцэс сүүлдээ

Перерыли весь архив и в конце концов нашли нужную нам бумагу Хамаг даанс харааг нэгэд нэгэнгүй онгичиж байж эрсэн хайсан (олох гэсэн) бичгээ оллоо.

96. **В КОПЕЕЧКУ СТАТЬ (вскочить, обоитись, влететь)** Мөнгө их үрэ-,мөнгө идэ-,мөнгө гүвэ-

Этот обед влетел в копеечку Энэ хоол хамаг мөнгө идчихлээ. Хоолонд мөнгө их орж**ээ** —

Этот дом ему станет в копеечку Мань эр энэ байшинд мөн иххэн мөнгө үрнэ биздээ (Энэ байшин, байдаг мөнгий нь ууна бизээ).

97. **В КОРЕНЬ (запрячь)** *буюу* **В КОРНЮ (быть запряжённым)** Морь тэргэнд хөллө-,

98. **В КОРЕНЬ СМОТРЕТЬ** Хэрэг явдлын (уг улбааг нягтла-, (заншла-, хара-),улы нь төнхөж үзэ-

99. **В КОРНЕ** Угтаа, огт, ерөөсөө, бүр, уг нь, язгуураас, хэтээсээ онхи нь ,ер нь л, ямар ч гэсэн, ёстой, аргагүй, яахын ч аргагүй, үзтэл, хартал

Это решение вопроса в корне неправильное Асуудлыг ингэж шийдэх нь огт (ерөөсөө) ёстой буруу болжээ.

100. **В КОРНЮ (ходить)** Морь тэргэнд хөллө- (оруул-)

101. **В КОРОВЕ МОЛОКО НЕ ПРОКИСАЕТ** үгчилбэлсүү дэлэндээ гашилдаггүй

102. **В КОРОТКИХ СЛОВАХ (передать, сказать)** Товчхон яри-(хэлэ-), хоёр гуравхан үгээр хэлэ-

Ну, расскажите нам в коротких словах всю эту историю За за юу юу болсон бүгдий нь бид нарт товчхон шиг яриад орхиоч.

103. **В КОСТЮМЕ АДАМА** *[шутл.]* Чармай нүцгэн, шав шалдан, нүв нүцгэн (эрэгтэй хүнийг зааган утга)

Он быстро разделся и в костюме Адама бросился в реку и поплыл. Тэр вэвр хамаг хувцсаа тайлж нүцгэлээд гол руу үсрэн орж сэлж эхлэв.

104. **В КОСТЮМЕ ЕВЫ (адама)** Аав ээжийн хайрласан дээлээр чармай нүцгэн, шалдан (эмэгтэй хүнийг зааган үг).

* Орос хэлний энэ хэллэгийг зарим үед тухайн өгүүлбэрийн дотор өгүүлбэр зүйн утгаар нь орчуулж ч болохын дээр анхаарууштай нь: «эцсийн эцэст» гэж орчуулбаас үгийн гадаад бүрхүүлд хуурагсан учир дутагдалтай орчуулга болчих нь монгол хэлнээ «хамгийн түрүүнд» гэх санаар «эхний эхэнд» хэмээвээс өвгүй болохтой учир нэгэн бүлгээ.

105. В КОСУЮ САЖЕНЬ тэнгэр багануадсан (хүн), их өндөр, тэмээ шиг, тэмээ л гэсэн үг, тэнгэр тулсан

106. В КРАЙНЕМ СЛУЧАЕ Ядлаа гэхэд, ядахдаа л, үгүй гэхэд, болохоо байвал; болохгүй бол, эс болбол, нэг болбол, болдоггүй юм гэхэд, арга ядахад, ёнгаттаа тулбал, доор хаяж, тун болдоггүй юмаа гэхэд

Сегодня или в крайнем случае завтра, в десять утра. Пойдёшь ко мне, говори? Өнөөдөр ч юм уу за их л оройтлоо гэхдээ маргаан өглөөний арван цагийн наана чи надтай ирж уулзаарай, тэгэх үү? **Я обращусь к вам за помощью только в самом крайнем случае** Бүр болохоо байвал би танаас тусламж эрнэ.

107. В. КРАЙНОСТИ В-106

В крайности дадите нам телеграмму Хэрэг гарвал наана нь цахилгаан өгөөрэй.

108. В КРЕДИТ зээлээр, зээл

109. В КРЕПКИ ИГРАТЬ (дааманд) идүүлж хожи-, сул өгч хожи-

110. В КРИВОМ ЗЕРКАЛЕ И РОТ НА БОКУ Уг муутын тугал муу, урагшгүй нөёнд ухаангүй албат, эх нь хээр алаг бол хүү нь шийр алаг.

111. В КРОВИ ... төрсөн, хөвөөний, ясны, заганы, эхээс гарахын

Правдивость у него в крови Шударга төрсөн эр шүү. **Храбрость у него в крови** Тэр хүн ч ясны хатан зоригтой хүн дээ.

112. В КРОВЬ (избить, разбить) Цус гарга-, цусы нь шүүрүүлэ-

113. В КРУЖОК (стричься) [*разг.*] (Үснийг) бөмбийлгөн заса-

114. В КУЛАК Эрхэнд, нөлөөнд, эрхшээлд, арганд Д-206

115. В КУРСЕ (быть, находиться, держать и. т. п.) (Сайн) мэдэ-, нэвтэрхий, ёстой нэг мэдэ-

Он уже в курсе Тэр хүн мэджээ.

Он ещё не в курсе Тэр хүн хараахан мэдээгүй.

116. В КУСТЫ (спрятаться, схорониться) нуугда-, сэм зайла-, орго-; бууруул-, босо-, дүрвэ-

117. В ЛАД Эвтэй, эстэй, эвтэйхэн, янз маяг нь таарангуй

118. В ЛАДОШИ БИТЬ (ударять, хлопать) [*разг.*] Алга таши-

119. В ЛАДУ (ладах) *с кем-чем* [*разг.*] эвтэй, нийцвэртэй байх, төө зайгүй; эв тэнцинтэй

Жить в ладу с кем (Хэн хүнтэй) эвтэй суу- (бай-

Она с ним не в ладах. Тэр хоёр нийцвэр муутай (Энэ хүүхэн цаадахтайгаа таарахгүй нь,)

120. В ЛАПАХ Гарт нь, занганд нь, бүрэн эрхэнд нь, мэдэлд нь

121. В ЛЁТ (бить *буюу* стрелять в птицу) [*охот.*] (Шувууг) нисэж явахад нь буудa- (харва-)

122. В ЛЕТАХ [*разг.*] Насжих, өглөх, насанд дарагдах, нас дээр гарах, эрийг нас дарж уулыг цас дарах; хөгшрөх, өвгөрөх

123. В ЛИЦЕ *кого* (Хамгийн ойр) дотнын, тулсан, ойрын, төө зайгүй

В лице комсомола партия имеет верного помощника. Эв хамт залуучуудын эвлэл бол намын хамгийн дотно үнэнч туслагч.

124. В ЛИЦО (говорить) Нүүрэн дээр нь (хэлэ-), нүүр тулж (хэлэ-), улаан нүүрэн дээр нь (хэлэ-), улаан цайм (хэлэ-), улаан хэлэ-), ил (хэтэ-) шууд (хэлэ-).

Выбранить в лицо Улаан нүүрэн дээр нь хараа-

125. В ЛОБ. Хэлэ, халз өөдөөс, чиих урдаас, эгц өөдөөс, эгц урдаас нь, нүүр луу нь, толгой руу нь

Мы атаковали противника в лоб (Дайсны) халз өөдөөс нь, (эсэргүүцэл этгээдийн халз өөдөөс нь) дайрав.

126. В ЛОЖКЕ ВОДЫ УТОПИТЬ *кого* Ус уруу түлхэ-, цусгүй ал-, улаа хады нь мөргүүл-

127. В ЛОЖНОМ СВЕТЕ буруу бодох, этгээд үзэх, буруу үзэх

128. В ЛОСК [*прост. фам.*] Шал, шувт, хуу, тамтаггүй, найгүй, найргүй болтол, юм үлдээлгүй

Износить сапоги в лоск Гутлыг тамтаггүй болтол чирэ- (эдлэ-)

В лоск пьяный Шал согтуу (ноогоортол согтсон)

129. В ЛУЧШЕМ СЛУЧАЕ Сайн даа л, -бал[4] дээд (нийн заяа), цаа на хэлэхэд

В лучшем случае он приедет завтра Цаатах чинь (тэр эрэгтэй) гайгүй сайн даа л маргаан ирвэл дээд.

130. В ЛЮДЯХ Олны дунд (өмнө), амьтан дотор (өмнө), нийтийн өмнө, тумний өмнө.

131. В МАЛИНЕ (быть, оказаться) Менге (зэос) хонжи-, менге од-

132. В (общей) МАССЕ В-133

133. В МАССЕ Ихэнх, зонхи, голдуу, баранги, нэлинхийдээ, ер нь л, их төлөв, бараглаж

В массе люди-трудолюбивы Хүн голдуу, ажилласаг байдаг.

134. В МГНОВЕНИЕ ОКА Нүд ирмэхийн (цавчрахын) зуур (хооронд); агшин зуур, эгшин зуур, хоромхон зуур

135. В МЕЛКИЕ ДРЕБЕЗГИ [*разг.*] Бут цохих, яйртал, үй цохих, яй цохих, хэмхи цохих, хамха цохих,

136. В МЕРУ 1. Яг таарах, цав хэмээн, хэлэлцсэн юм шиг, хир таарууг 2. Дагуу, ёсчлон, ёсоор; ...-ны хүрээнд

За ужином все пили в меру и пьяных не было. Оройн хоолноор хүн болгон хир хэрдээ тааруухан (архи) ууж нэг ч хүн согтож барьсангүй (Оройн хоолонд бид архина сайхан тааруулсан шүү).

137. В МЕСТА НЕ СТОЛЬ ОТДАЛЁННЫЕ [*разг. шутл.*] Цөлөгөнөө, голүүлээд

138. В МЕШКЕ (оказаться, очутиться, быть находиться и. т.п.) [*воен.*] Хүрээлэгдэ-, бүслүүл-

139. В МЕШОЧЕК (сварить, яйцо) [*разг.*] Өндгийг тааруухан чана- (болго-)

141. В МИНИАТЮРЕ Бага шиг, жижгэвтэр, бэсрэгхэн, бичилхэн, давжаа, юмгүй, авсаархан

Настоящий паровоз в миниатюре Одоо ч бух тэрэг авсаархан болжээ

142. В МИНУТУ Мөн одоо, дор нь хэвтэр нь хөрөөгүй дээр нь

143. В МОЮ ГОЛОВУ (что сделать) [*разг.*] Би толгойгоороо даая. Би хар толгойгоороо харнуцая.

144. В МУТНОЙ ВОДЕ РЫБУ ЛОВИТЬ Муу хүн самбаанд, чоно бороонд

145. В МЫСЛЯХ бодолтой, бодлоготой, бодох, сэтгэх

146. В НАЗИДАНИЕ ПОТОМСТВУ [*ирон.*] ач үрдээ сургамж болгон, үр хүүхэдтэй бол үр хүүхэддээ үр хүүхэдгүй бол гал голомтондоо

147. В НАКЛАДЕ [*прост*] Хохирол амсах, муугаа үзэх, сүйд болох, үйлийн үр гарз гарах

В накладе не будешь Чи сүйд болохгүй

148. В НАРЯДЕ ХОРОШ, А БЕЗ НЕГО НА ПЕНЬ ПОХОЖ Хувцас бурхан, бие чөтгөр; манай авгайг майдраар үзээрэй

149. В НАСТОЯЩЕМ СВЕТЕ (видеть, представлять и. т. п) Судсы нь атга-, үнэн мөний ол-, хэн болохы нь танимөсий нь тани-, үнэн нүүрий нь тани-

150. В НАТУРЕ [*разг, шутл.*] Чармай шалдан, улаан нүцгэн, ха, маг юмаа гаргаад, шалдан нүцгэн, нүв нүцгэн

151. В НАХЛЁСТКУ (зэгэсыг) живүүргүй гөхидөх

152. В НАШИХ (их, его, ваших ... и. т. п.) **РУКАХ** Маний (тэдний, түүний, таны) гарт, мэдэлд, атганд захиргаанд

153, В НЕДОБРЫЙ ЧАС [*разг*] Өлзий бусын цагт, цөвүүн цагт

154. В НЕКОТОРОМ РОДЕ [*разг.*] Жаал зугаа, аахар шаахар; бага сага, нилээд, дэмийгээс дээр, эглээс бүгэл, уснаас цийдэм, жижиг сажиг, жаал жуул оргүйгээс охинтой

155. В НЕРЕШИМОСТИ Шийдэж цөхөх, дүлэгнэх, гайхалзах, яахаа мэдэхгүй, ам хамраас юм ойчих гэсэн, эргэлзэх

156. В НЕСКОЛЬКИХ (двух трёх) **ШАГАХ** Ойрхон, хариугүй дэргэд, үнсэн дээр; үүдэн хоймрын зайд; гадаа, энүүхэндхэдхэн алхмын цаана

157. В НЕТЯХ [*шутл.ирон.*] Хааг бүү мэд; сохор номинг аль өргөөндөө гэж ниргэх билээ гэдэг шиг болоод байна.

158. В НОВИНКУ Шинэ. сонин, анх удаа, хүн болсоор

Вам уж это надоело, а мне в новинку Танд энэ их залхуутай ч, надад бол сонин л доо.

Всё в городе ему было в новинку Хот орны хамаг юм түүнд сонин хачин санагднам.

159. В НОГАХ (орны) хөлд

160. В НОГАХ ПРАВДЫ НЕТ [*разг шутл*] Модон өмд өмссөн биш суугаач

161. В НОС (говорить, произносить) Хамраараа (яри-,) гуниш ганан (яри-,) гуншаа, гун гун гэж (яри-)

162. В ОБА КОНЦА Нзашаа цаашаа, өөдөө уруугаа, нийшээ тийшээ

163. В ОБЖИМКУ [*прост*] Бариад шидчихсэн юм шиг (хувцас) бие барьсан буюу барну (хувцас). жадгар (жодгор), жадайсан жодойсон хувцас; амаар гарчихаа алдсан, биенээр бие болсон (хувцас), тожийсон

164. В ОБЛАКАХ БЫТЬ (видать, носиться) хий бодол сайхан зүүд, бүтэшгүй санаа, хий санаарха-, их санаж есөн шөнө хоосон хонох гэгч, хий мөрөөдөлд умбах, У-104

165. В ОБЛАКАХ ВИТАТЬ Мөрөөдө-, хий санаарха-, хоосон бодо-

166. В ОБНИМКУ [*разг*] Хүзүүдэлцэн, хөтлөлцөн, тэврэлцэн; хөл нь хэрээтэй хүзүү нь холбоотой шиг; хэлхэлдэж

Идти в обнимку Хүзүүдэлцэн (тэврэлцэн), хэлхэлдэн хөлхөлдөн, хөтлөлцөн) явах

Сидеть в обнимку Хүзүүдэлцэн (тэврэлцэн, хэлхэлдэн, (хөлхөлдөн, хөтлөлцөн) суу-

167. В ОБОРОТ ПУСТИТЬ (ввести, вовлечь) Олноороо хэрэг-, лэ-, их дэлгэрэ-,

168. В ОБРАЗЕ *кого . . .*-нийн дүртэй, төстөй

169. В ОБРЕЗ [*разг*] Мөчиг тачиг (хүрэх), өл мөлхөн байх, өлөн зөмөг; хоёр идэхгүй, хоосон хонохгүй; **2.** [*перен.*] боож үхэх гэж байна, суух (нээх) завгүй, муу эмд уйлах завгүй гэгч шиг

Денег у меня в обрез Миний мөнгө ч яах вэ дээ мөчиг тачигхан л хүрдэг дээ.

Работа в обрез Ажил гэдэг толгой дарж байна (ажил гэдэг ч толгойтой үснээс их ээ).

170. В ОБТЯЖКУ Бие барьсан, бариад оёчихсон шиг (хувцас), биенээр бие болсон, тажгар тожгор

Церма носила платья в обтяжку Цэрмаа бие барьсан хувцас (платья) өмсжээ (Цэрмаа нэг жадгар юм өмсчээ).

171. В ОБЩЕЙ СЛОЖНОСТИ Ер нь, одоо ер нь, ерөнхийд нь хэлбэл, дүндээ, тоймы нь хэлбэл, ноён нуруу нь, ерөнхий төлөв нь

В общей сложности денег у меня осталось очень мало. Одоо нигэхэд би бага шиг мөнгөтэй болжээ.

172. В ОБЩЕМ Ерөнхийдөө, дүндээ, дүн нуруу нь, гол нуруу нь, нигээд л, ер нь тэгээд (нигээд)

В общем я согласен Ерөнхийд нь би зөвшөөрч л байна (уг нь ч тийм л дээ).

В общем всё кончилось хорошо Гол нуруу нь зүгээр болжээ. (ер нь аятайхан болсондоо)

173. **В ОБЩЕМ И ЦЕЛОМ** Ерөнхийд нь хэлэхэд, дүн нуруу нь бол, гол төлөв нь; их бие нь

174. **В ОБЩИХ ЧЕРТАХ** Гол тойм нь, тоймлон, багцааг нь, дүн тойм нь

Рассказывать что в общих чертах Тоймы нь өгүүлэх
Я рассказал ему это в общих чертах Би энэний тоймы нь түүнд ярьсан.

175. **В ОБЫЧАЕ** *кого, у кого, где* {*разг*} дандаа, дассан, сурсан заншилтай,... даг[4]; гэм биш зан, гэнэт биш хууч; зуршсан, дадсан, сургууль болсон

Это у нас в обычае. Манай эндэхнийн заншил (иймээ манайхан дандаа ингэдэг).
В его обычае работать по ночам Шөнө ажиллаж сурсан хүн.

176. **В ОГНЕ НЕ ГОРИТ И В ВОДЕ НЕ ТОНЕТ** (гаснет) Галд хийсэн ч шатахгүй газар булсан ч дарагдахгүй; даравч дардайдаг, булавч булталдаг, алт хайлах тутам өнгө ордог; эрдэнэ элгдэх тусам өнгө ордог.

Да, истинная слава-она и в огне не горит и в воде не гаснет (Полевой, Современники, эстафета) Тийм ээ, үнэн алдар гэдэг дарсан ч дардайна, булсан ч булталдана.

177. **В ОГОНЬ И В ВОДУ** (готов лезть, пойти и. т. п) Оволзсон галаас ч мятрахгүй, оломгүй уснаас ч буцахгүй; гал усны гашуун зовлонд ч ажрахгүй, ална гэсэн ч айхгүй; эрлэгийн өөдөөс ч эгц хардаг; нэг үхэхээс олон үхдэггүй хэмээгчийн үлгэрээр

178. **В ОГОРОД** *чей* Битүү хэлэх, хөвөнд боосон чулуугаар цохих, үгээр шөвөгдөх, битүү өгөх, явуулах, егөөдөх, битүү идэх, цаагуур нь явуулах

179. **В ОДИН ГОЛОС** Санал нэгтэй, нэгэн дуугаар, нэгэн саналаар, дуугарвал дуу нэг, дугтарвал хүч нэг; дуу дуугаа авалцах

Все в один голос запротестовали Цөм санал нэгтэй эсэргүүцэв. (Булгаараа ам амандаа дургүйцэв)

180. **В ОДИН ПРЕКРАСНЫЙ ВЕЧЕР** буюу **В ОДНУ ПРЕКРАСНУЮ НОЧЬ** эсхүл **В ОДНО ПРЕКРАСНОЕ УТРО** {*разг*} Гайгүй нэг л өдөр, нэг л мэдэхэд, нэг л өлзийтэй сайхан өдөр, нэг л цагт, цаг нь болоод цай нь буцлахад, эрэмбэ ёсоор ээлж нь болоход, түүх нь прэхэд; сарын сайныг саатан хүлээж, өдрийн сайныг өнжин хүлээж; цаг нь прэхлээр

181. **В (за) ОДИН ПРИСЕСТ** {*разг.*} Нэг амнар, нэг барнагаар, нэг бариад л, амьсгаагаар, нэгмөсөн, нэг доор, 3-43

Съесть все в один присест Бүгдийнь ганц амнар идэх
В один присест написал статью Өгүүллийг нэг бариад л биччихсэн.

182. **В ОДИНОЧКУ** Гав ганцаараа, цор ганцаараа, дан биеэр, гон биеэр, ор ганцаар; ер ганцаар; ганийн хүү ганцаараа, ганц тэмээ зангаараа сул бие сунхаж ганц бие ганхаж, сүүдрээс өөр нөхөргүй, сүүлээс өөр ташуургүй гэгчээр

Трудно действовать в одиночку Ганцаархнаа юм бүтээхэд хэцүү (ганц хүн хүн болдоггүй ганц мод гал болдоггүй).

183. **В ОДНИ РУКИ** Нэг хүнд, хүн нэг бүрт, хүн хүнд

184. **В ОДНО СЛОВО** {*разг.*} Нэгэн дуугаар, зэрэг зэрэг, ам амандаа, дуу дуунаараа; амьсгаа нэгтэй, нэгэн амаар (нэг амтай)

185. **В ОДНО УХО ВОШЛО, В ДРУГОЕ ВЫШЛО** Нэг чихээр ороод нөгөө чихээр гарах, баруун чихээр ороод зүүн чихээр гарах; илжигний чихэнд ус хийсэн ч сэгсрэнэ, алт хийсэн ч сэгсрэнэ; сайн ч юм хэлсэн адил, муу ч юм хэлсэн ч адил; чих нь алт болсон; дөжирчихсөн, нохой хуцсан эс хуцсан адилхан; нохой хуцсан чинээнд ч үгүй; чихгүй толгой, хүний үг хор болж нохойн юу шор болсон;

186. **В ОДНУ ДУДУ** (дудку) **ДУДЕТЬ** ус хаашаа бол эрэг тийшээ, зүү хаашаа бол утас тийшээ, дуугарвал дуу нэг дугтарвал хүч нэг, амьсгаа нэгтэй, амь нэгтэй, дуу дуугаа авалца-

187. **В ОЖИДАНИИ** {*разг.*} Бие шалтгаантай, хөл хүнд, бие давхар, давхар биетэй, бие муутай, бие эрүүлгүй, гэдэстэй; (шахсан бол) хэзээ хэзээгүй, шахуу

188. **В ОКРУЖЕНИИ** *кого* дагалдан явах, бараа болоцуулан

Приехал генерал в окружении офицеров Генерал, цэргийн дарга нараар бараа болгуулсаар ирэв.

189. **В ОНЫ ДНИ** Аль дивангарын, өнө эртний, дээр үенийн

190. **В ОСНОВНОМ** Ер нь л, тэгэж тэгэж л, дүндийдээ, дүндээ

В основном Доздон прав Тэгэж тэгэж Довдонгийн л зөв байна даа (Үндсэндээ Довдонгийн л зөв байна даа).

191. **В ОСОБЕННОСТИ** Ялангуяа, тэр дундаа, тэр тусмаа, бүр онцлоход, бүр тэгэхэд, онцлоход, тэгэхдээ, тэгэх тусмаа, нэн ялангуяа

Я интересуюсь многим, в особенности музыкой. Би өөрөө олон юм сонирхдог, тэр дундаа хөгжимд л их дуртай даа;

192. **В ОСТАЛЬНОМ** Нөгөөтэйгүүр, бусдаараа ч, тэрчлэн, басхүү

193. **В ОТДЕЛЬНОСТИ** Тус тусдаа, дан данд нь, дан дандаа, өөр өөртөө, нэг нэгээр нь, нэг бүрчлэн

Объяснить каждому в отдельности (Хүн хүнд) өөр өөрт нь хэлж өг-

194. **В ОТКРЫТУЮ** {*перен*} ил, илэн далангүй, нууж хаалгүй; ний нуугүй

195. **В ОТЛИЧИЕ ОТ** *кого-чего* Үгүй мөн яах вэ дээ; хаа очиж; чононд нэг бодь гэж;... аас өөр,...-нйг бодвол;...нд орвол; онцлог тал нь, санасныг бодвол

В отличие от старшего брата Дорж поступил в педагогический институт Дорж ахыгаа бодвол багшийн дээд сургуульд орчихжээ.

196. **В ОТМЕНУ** *чего*...-ны оронд....-ны орон төлөөс болгон, зодиос болгон,... ний өмнөөс,...-ний тулд,...-нйг л гэж

197. **В ОТМЕСТКУ** Мечөөрхөн, хувиа тавихгүй, өшөөлөн, хорондоо

198. **В ОТНОШЕНИИ** *кого-чего*...-д,-т;...-ны хувьд,...-ын тухайд,... ын тухайтайд,... дээр гэвэл

199. **В ОТСУТСТВИЕ** *кого* Үгүйд, эзгүйд, байхгүйгээр,... сан хойгуур, ...хооронд, араар нь, бөгсөөр, ар хударгаар нь, хойгуур

200. **В ОХАПКУ** тэврэх, элгэндээ авах

Схватить что в охапку Юмыг хоёр гардан тэврэ-

201. **В ОХОТКУ (ОХОТУ)** 1. Дуртайяа, дургүй ч үгүй, дуртай нь аргагүй, дуртай гэгч нь, амтархан, таашаан, уриалгахан

В охотку поел Дуртай нь аргагүй идсэн

202. **В ПАМЯТИ** [*разг.*] Сүрхий ойтой, сэргэлэн, юм мартдаггүй, сийрэгхэн овсгоотой, сэлүүхэн, ухаантай, гүйлгүү ухаантай

203. **В ПАНДАН** Таарсан таар шуудай; ижилдээ нийлэх, дүй дүйндээ болох, тааруч дээ, дүйз дүйзээрээ, ёоз ёозоороо, ёоз дүйзээрээ, ороо морь ижлээ олдог, ороо нь ороогоо, жороо нь жороогоо

204. **В ПАРЕ** *с кем*...-тай хоёул,...тай хамт (цуг) шаа нийлсэн

205. **В ПЕЛЕНКАХ** хар багадаа, нялхдаа, нэг настай нялх үсгэйдээ,

206. **В ПЕРВИНКУ** Анх л, нэг л, хүн болсоор

Это мне не в первинку Надад анх л энэ биш (энэ ч гэм биш зан).

207. **В ПЕРВУЮ ГОЛОВУ (очередь)** Эн тэргүүн, хамгийн түрүүн, толгойд нь, эхэнд нь, оройд нь, юун түрүүн, дав дээр, давын өмнө, юу ч л гэсэн

В первую голову мы взялись за улучшение жилищных условий Орон байрыг сайжруулах явдлыг л бид эн тэргүүн авч үзлээ.

208. **В ПЕРВЫХ РЯДАХ** Эхний мөрөнд, тэргүүний эгнээнд,...-ны манлайд, тэргүүн ээлжинд.

209. **В ПЕРЕБИВКУ** Өрсөлдөн ярих, ам амандаа ярих, зэрэг зэрэг ярих, ам уралдан, ам булаалдан ярих, ам амандаа шуугих

Ребята в перебивку рассказывали эту новость Хүүхэд энэнийг бие биенээсээ өрсөлдөөд л ярьж гарав

210. **В ПЕРЕВАЛКУ (идти)** Салгалан явах, гуйван гуйван хийгээд, сажлах, дэн дун явах, гуйван дайван, чөдөр галзуу туссан юм шиг

211. **В ПЕРЕПЛЕТ (попасть, влипнуть)** буюу **В ПЕРЕПЛЕТЕ (оказаться, быть и. т. п)** Арга мухарда-, гацаж гүйцэ-, ацан шалаанд суу-, ягта-, хаашаа ч үгүй бол-, яадгаа алда-, яг мухардаж таг суу-

Ох, попали мы в крепкий переплёт с этим делом. Едва с трудом решили его Бэзарваань, энэнд чинь нэг яадгаа алдаад арай чуу гэж нэг учраа олж саллаа шүү.

212. **В ПЕРСПЕКТИВЕ ЕСТЬ** (быть, будет) Тэгэхгүй гэдэггүй юм хэлэх юм алга тун, магадгүй,... ж мэдмээр, мэдэшгүй, болзошгүй; уг нь болох л учиртай юмдаг, юмыг яаж мэдэх вэ

У него в перспективе командировка в Москву (Тэр хүн) цаадахь чинь Москва руу томилолтоор явж мэдмээр байна.

Вот кончу институт, а в перспективе работа на заводе Би дээд сургуулиа төгсөөд л хөдөө явж магадгүй дээ.

213. **В ПЕТЛЮ ЛЕЗТЬ** *кому* Боож үхмээр л, арга мухарда-, цөхрөнгөө бара-, бодоод бодоод бодын шийр дөрөв, яадгаа алда-, бодлого биш дүүрлэг бол-

214. **В ПИКУ (сделать что)** [*разг.*] Хүнийг цаашлуула-, яах нь вэ гэж зориуд айлга-, хашраах гэж, зоворх гэж, тэвдүүлэх гэж, эрүүлэх гэж, янзы нь үзэж гонзы нь тани-

Это мне в пику сделал Энэ намайг айлгах гэж ингэж л дээ

215. **В ПОВЕСТКЕ ДНЯ** [*разг., перен.*] 1. Хэлэлцэх асуудал шийдвэрлэвээс зохих асуудал; 2. Ээлжит зорилт, тулсан асуудал, тулгарсан зорилт, дав дээр ярих асуудал, чухалчлах зүйл

216. **В ПОДМЁТКИ НЕ ГОДИТСЯ (не станет)** *кому* [*разг.*] Зохиогүй, тараагүй, гурвалжин нүхэнд дөрвөлжин мод тааруулах гэх шиг, тормонд тооно ачсан гэх шиг, хөл нүцгэн гэлэн малгай өмсө-

217. **В ПОДПИТИИ** халмаг, хөлчүү шиг, дөрөө нь чангахан,

218. **В ПОДТВЕРЖДЕНИЕ** Улы нь олох гэж, лавшруулахын тулд, нутлах гэж, бат нут болгох гэж, уг мухарт нь тулгах гэж, эш мухры нь олох гэж, уг учры нь мэдэх гэж, лавлах гэж

219. **В ПОДЪЁМ** *что кому* [*разг.*] Эр бар, баавгай, барах, дийлэх, амбан явах, хүч хүрэх, нохой хорих (гүй), шаа хүрэх (гүй) шон хүрэх (гүй)

Это Шагдару не в подъём Энийг ч Шагдар барахгүй бизээ.

220. **В ПОЖАРНОМ ПОРЯДКЕ** [*разг-, фам. шутл.*] Хойноос нь хөөсөн юм шиг, ухаан нь ууланд гарсан, санд мэнд, амь наана там цаана, ухаан жолоогүй, бажигадан, чацга хавчин

221. **В ПОЛ ГЛАЗА ПОСМОТРЕТЬ (взглянуть и. т. п.)** Харасхийхяланхий, нэг хараад, сөрөм хараад

222. **В ПОЛЕ ЗА ВЕТРОМ НЕ УГОНИШЬСЯ** Санадаггүй санаа давдаггүй даваа санаад санаад санааны гарз, хийгээд хийгээд гарын гарз; гүйгээд гүйгээд хөлийн гарз; сэдээд сээрнийхээ махыг барах хэрэггүй

223. **В ПОЛНОЙ МЕРЕ** Бүрэн, бүтэн, төгс, гүйцэд нэг, иж, иж бүрэн, цогц,

224. **В ПОЛНОМ ПОРЯДКЕ** Гажиггүй, номын ёсоор, хэлэх юмгүй бүх юм жигдэрсэн, өвтэгш, өөгүй, дутуу юмгүй, бэлэн зэлэн-

өө сэвгүй, согоггүй, эв эрүүл, хэлэх өөгүй, яг таг, жин тань зөв зүгээр, [*перен.*] зөв зүгээр онц сайн

Машина в полном порядке Машин жин тань

Ваше сердце в полном порядке Таны зүрх зөв зүгээр байна

225. **В ПОЛНОМ (здровом, твердом) РАССУДКЕ** Эв эрүүл, эрүүл саруул ухаантай, зөв зүгээр, бүрэн бүтэн ухаантай

В полном смысле (этого) слова Нэр нь нидэртээ таарсан, нэрэндээ зохисон, яг мөн

226. **В ПОЛНОМ (во всем) ПАРАДЕ** ямбаныхаа өмсгөлтэй, гоёж гоодчихсон, төр төмбөгөр ёс ёмбогорооров, наадмын улс шиг,

227. **В ПОЛНОМ СОКУ** 1. (ургамал) цэцэг навч нь дэлгэрэх, хөх ногоо жигдрэх; 2. [*перен.*] Орь залуугийн цог бадарсан, цэцэг цэврүү шиг, ид насан дээрээ, согоо шиг, идэр залуу настай нсгэлэн халуун бнетэй (цаг), хавтай залуу нас, залуу халуун нас, улаа бутарсан В-233, 335

Женщина в полном соку Цэцэг цэврүү шиг хүүхэн, (уулын согоо шиг хүүхэн, яая даа гэмээр хүүхэн), усан дагина шиг бүсгүй.

228. **В ПОЛНУЮ СИЛУ** Хамаг хүчээрээ, чадан ядан, байдаг чадлаараа, эрвийх дэрвийхээрээ, эр хүний арван гурван мэхээрээ, болох бүтэхээрээ, байдгаараа, **чадлаараа, хүчээрээ**

Машина работает в полную силу Машин ч хамаг хүчээрээ эргэж (хөдөлж) байна.

Старик прожил жизнь в полную силу Өвгөнч чадах ядахаараа л зүтгэн амь зууж нэг насыг өнгөрөөв.

229. **В ПОЛНЫЙ ХОД** (*перен*). Ид бужигнан, ид дундаа, халуун дээрээ, шуурхай, гялзлзуур, булуу халах, цэгцрээд явж байна. П-679

Смех и пляски в полный ход Инээдэм наргиан, бүжиг хөг ид дундаа байна.

230. **В ПОЛОЖЕНИИ** (*разг.*) Бие шалтгаантай, хөл хүнд, бие давхар, бие эрүүлгүй, бие муутай.

Церма в положении. Цэрмаа бие шалтгаантай

231. **В ПОЛЬЗУ** *чью, чего* 1. Ашигтай, тустай, тусын тулд, олзтой, ачтай, тустай; 2. Дэмжих, тэтгэх, өрөөх, дэгтрэх, өгдөөх

Положение изменилось в нашу пользу Байдал бидэнд ашигтайгаар эргэв шүү.

Движение в пользу реформ. Шинэтгэлийг тэтгэсэн хөдөлгөөн

3. Дийлэх, хожих

Счёт 1 : 0 в пользу (команды) „Соёл" Соёл нийгэмлэгийн баг 1: 0-оор хожив.

232. **В ПОМИНЕ НЕТ** *кого-чего* [*разг.*] Сураггүй арилсан, бараа туруугүй болох, арилсан, бүрмөсөн үгүй болох, сэг сэвсгүй арилах, ор мөргүй,ор сураггүй, юу ч үгүй.

Его давно и в помине нет Тэр вээр хэдий үгүй болсон.

Любви в помине больше нет Өчүүхэн ч хайр сэтгэлгүй болсоон (хайр сэтгэл ч бүр өнгөрлөө л дөө).

233. **В (самой) ПОРЕ** [*разг.*] 1. (Хүнд бол) идэр залуу настай нсгэлэн халуун бнетэй: дөч хүрсэн эр, дөрвөө дарсан ат, дээр бүрэн морь; галтай цогтой, орь залуугийн цог бадарсан; уул шиг, хангай шиг, уулын чинээн эр; эрийн цээнд хүрсэн

Мужчина в поре. Орь залуугийн цог бадарсан эр (идэр эр)

2. (Амьтан адуусанд бол) арьс мах нь тэнцсэн (гүйцсэн); жагсасан (шар, морь); сүмбэ шиг (тэмээ морь), цэл залуу

234. **В ПОРЯДКЕ** 1. Эмх журамтай, цэгцтэй, гэм согоггүй, үйлс урагштай, хөндөлгүй, аятайхан, яв цав, цэвхийгээд, хаш хайрцаг шиг, хад шиг, шахсан бяслаг шиг

Все в порядке Хамаг юм үйлстэй (бүгд эмх цэгцтэй)

Груз прибыл в порядке. Ачаа аятайхан хүрсэн, ачсан янзаараа хөдлөлгүй.

Не в порядке. Согоггой цэгцгүй, урагш муутай

235. **В. ПОРЯДКЕ** *чего буюу* **В КАКОМ ПОРЯДКЕ** . . .-ын журмаар, . . .-ын дагуу, . . .-ын ёсоор, ёсоороо, . . .-хан шиг, номоороо, номын ёсоор, . . .-д зорнулан, . . .-ын тулд, . . . хэмээн

Статья печатается в порядке обсуждения. Тус өгүүлэгийг олноор хэлэлцүүлэхэд зорнулан нийтлэв.

В административном порядке Засаг захиргаатай, (захиргааны журмаар, засаглах ёсоороо, засаг засаглалаар, дэгтэй, эмх журамтай, эмх цэгцтэй, захиргаатай, замбараатай.)

В организованном порядке. Зохион байгуулалттайгаар

В спешном порядке Шалавхан, (яаруухан, сандруу шиг, үтэр түргэн, түргэн шуурхай, хөнгөн шуурхай, шулуун шуурхай, тэвдүүвтэр, аахи уухи болон, уушги зүрх амаар гарах шахан)

В массовом порядке их их, бөөн цөөнөөр, бөлөг цөлгөөр

Победа приходит не в порядке самотёка, а добывается в борьбе Ялалт гэдэг чинь өөрөө хүрээд ирдэггүй, тэмцэж байж олдог юм.

236. **В ПОРЯДКЕ ВЕЩЕЙ.** Зүй ёсны, аргагүй хэрэг, долоон зөв, зүйн хэрэг, зүй зохисын, жам ёсны

Всё это в порядке вещей Энэ ч долоон зөв өө (энэ зүйн хэрэг ээ)

237. **В ПОСЛЕДНЕМ ВКУСЕ.** Хамгийн шинэ маягийн, хамгийн сүүлийн үеийн, шинэ дэлгэрч байгаа, шинээр газар авч яваа

238. **В ПОСЛЕДНЕМ ГРАДУСЕ** [*устар.*] Хөсөг нь явчихсан, хоногоо хүлээх, өдрөө хүлээх, наашаа эргэлтгүй, горь тасарсан, хөг нь өнгөрсөн, хэлтгийрсэн, нэг тийшээ болсон.

239. **В ПОСЛЕДНЕМ СЧЁТЕ.** Эцсийн бөлөгт, адаг сүүлдээ, явж явж, очиж очиж, тэг тэгсээр, чинээ чинээсээр, алс нь бөгсөндөө, шувтаргандаа

240. **В ПОТЕ ЛИЦА (трудиться)** Хар хөлсөө цувуулж хатан ясаа хавталзуулж, (махаа) идэн, хөлс баасаа гоожуулан байж, үхэхээс наагуур явж, арвыхаа арыг тавыхаа тарыг барж, үхэхээс бусдыг үзэн байж, хөлсөө шавхан байж, бөхгүй тэмээ шиг зүтгэн байж

241. **В. ПОТЕМКАХ** аль ч учраа мэдэхгүй, дүйнгэртэж байх, үүлгэртэж хоцрох, нүдэн балай чихэн дүлий, халалдах, зүггүй, үзэггүй

242. **В ПОТ УДАРИЛО** Ухаан алдан (айх, баярлах, гомдох зэрэг), хүйтэн хөлс гарах, айхавтар сандрах, амь наана там цаана гэж явж

243. **В ПОЧЕТЕ** хүлээж хүндлүүл, нэртэй хүндтэй, хүнд ямбатай

244. **В ПРЕДМЕТЕ** *У кого* Бодох, санах, төрөх, завдах, хорхойсох, хүсэх, мөрөөсөх

У нас теперь не то в предмете: мы лучше поспешим на бал (Пушкин) Бүжиг рүү бушуухан очвол дээр байгаа гэсэн саная одоо бидэнд үгүй байнам (бүжигт л бушуухан шиг очиж л байвал сайхан гэдэг бодол (хөг) ч өнгөрч дээ).

245. **В ПРЕДШЕСТВИИ** *кого* . . .-ны буянаар, . . .-ны хүчинд . . .-нд дулдуйдаж, . . .-ны ачаар (тусаар)

246. **В ПРЕТЕНЗИИ** *на кого* голох, эс тоох, үл ойшоох, голонги, сэтгэл дундуур, санаанд хүрэхгүй,

247. **В ПРИДАЧУ**. Бас чингээд, дээрээс нь, тэрнээс гадна

Выгнали меня и в придачу надавали тумаков. (Тэд нүүс) намайг хөөж гараад бас хэд хэд алгадаад авсан.

248. **В ПРИМЕНЕНИИ** *к чему* зохирох, зохицох, нийцэх, идээшихийн тулд, хоног ужуурах, гандаа ороод байх, нийлэх, таарах, ягших, тохирох

В применении к новым условиям. Шинэ нөхцөлд зохирохын тул

249. **В (на) ПРИСТЯЖКЕ** Б-210

250. **В ПРИРОДЕ (порядке) ВЕЩЕЙ** [*разг.*] юм ийм л байдаг, жам нь болсон хойно, орчлонгийн ёс доо, тойрч гарахгүй дайрч л гардаг юм хойно, тэртэй тэргүй, . . . , нигэж заясан, тэгэж заясан, хэн ч өөрчлөхгүй, заагаад өгсөн зам,

251. **В ПРОДОЛЖЕНИЕ** *чего* . . . хугацаанд, . . . хооронд, . . .-ын дотор турш, дувтан, шувтан, . . . нгаа[4], . . .-ийн энгээр

В продолжение дня нашего пребывания в Москве. Бид Москвад байх хугацаандаа

252. **В ПРОТИВНОМ СЛУЧАЕ.** Тэгэхгүй бол, ингэхгүй бол, эс тэгвээс, эсхүл, үгүй дээ гэхэд, эс чингэвээс, эс чингэх аваас

Опишите подробно, в противном случае останется много неясного. Тод томруун товчоолон гаргахгүй бол нэг их учир нь олдохгой юм болчихно шүү.

253. **В ПРОТИВОПОЛОЖНОСТЬ** *кому чему* . . .-ыг бодвол,...-аас шал өөр, зүйрлэхгүй, хавьгүй, ижилгүй, тэс өөр, ов ондоо

В противоположность брату он очень трудолюбив. Ахыгаа бодвол энэ чинь хамаагүй хичээнгүй хүн

254. **В ПРЯМОМ СМЫСЛЕ СЛОВА** [*разг.*] үнэний нь гэхэд, ний нуугүй хэлэхэд, шулуухан хэлэхэд, ёстой нэг, чухам л, бүр л нэг санаснаа хэлэхэд, үнэн дээ л, ер нь л, бас л мөн ч;

Лодой в прямом смысле слова чудак. Ний нуугүй хэлэхэд Лодой ч мөн этгээд хүн шүү дээ.

255. **В ПУХ И (в) ПРАХ.** Голомты нь тэгшлэх, голомты нь бүрэл гэх, бут (цохих), зад (цохих), товрог болгох, үнсэн товрог болгох, үнсий нь хийсгэх

Разбить в пух и прах зад цохи-

256. **В ПЫЛУ (сраженье, спора, битвы . . . и. т. п)** (Тулалдаан, маргаан, тулаан г. м) ид дундаа, улаан галзуу (үедээ), ухаан сэхээгүй, гэдсэндээ хөлөө хийлцэх, булуу нь халах, чи үх би сэх дээрээ, чи би-дээ тулах, улаан малгайгаа өмсөх;

257. **В РАЗБИВКУ** тасаг бусаг, алаг цоог, хэсэг хэсэг, газрын ганц (нэг) эрийн нэг, тэнд эндээс, хойно урдаас, тус тусдаа, хөрөөний ир шиг.

Спрашивать в разбивку урд хойноос, (энд тэндээс), шалгаа-

Продавать в разбивку хэсэг хэсгээр нь зара-, (жижиглэн худалда-)

Действовать в разбивку. Амь амиа хөө; мөр мөрөө хөө-, хувиа бодож довоо шарлуула-

258. **В РАЗБРОД** саланги сарниун, ундуй, сундуй, талын нэг, армаг тармаг, эв дүйгүй, эв найрамтгүй, шуудайд хийсэн эвэр шиг, яйралдсан, хадам бэр хоёр шиг, харз ямааны арьс шиг,

259. **В РАЗБРОС** [*прост.*] дэл сул, задгай зайдан, ундуй, сундуй, зуун задгай жаран хагархай, эрээвэр хураавар, энд тэндгүй, хайш яйш, хам хум;

260. **В РАЗВАЛКУ** дайваганан, гонжигонон, шулдагансан, найган ганхаж, чөдөр галзуу, нахилзаж ганхасан.

261. **В РАЗВЕС ПРОДАВАТЬ** жингээр худалда-,жин жингээр зара-

262. **В РАЗГОНЕ** [*разг.*] юманд, ажилд явсан, ийш нь тийш нь явуулчихсан, тийш нь, зүг зүгт, тал бүрлүү,

Все лошади в разгоне байдаг агтаа, юм юманд явуулчихсан (тохчихсон)

Нет свободной машины-все в разгоне сул машин алга цөмий нь ийш тийш нь явуулчихсан.

263. **В РАЗНОБОЙ** *прост* саланги, тус тусдаа, анги ангидаа, зохирогүй бус, мөр мөрөөрөө, зам замаараа, чиг чигээрээ, хувь хувираа, ижил ижлээрээ,

264. **В РАЗНОС** дамнуургачин, ганзгын худалдаа, шуугиур маймаа доошуур наймаа,

265. **В РАЗРЕЗ** эсрэг, зөрүү, харш, гал ус болох
Идти в разрез түнжин хагарах, арьш замаар шогших, шаазан хагара-, сөргүүлэн тави-

266. **В РАЗРЕЗЕ** *чего буюу каком* [*разг.*] үзлийн үүднээс, ... ийш нүдээр үзэ-
Видеть в новом разрезе шинэ үзлээр (нүдээр) үзэ- (*буюу*) шал өөрөөр үзэ-

267. **В РАСПОРЯЖЕНИИ** *кого-чего* ...-ын атганд, ...-нд буранг гаа атгуулсан; ...-ны эрхэнд, ...-ын эрхшээлд, жолоогоо атгуулсан, бнеэ мэдүүлсэн, ...-ны мэдлийн, ...-ны хамаашы, ...-ны харьяаны, амаа мэдүүлсэн
В его распряжении имеется самолёт. Тэр хүний мэдлийн нэг писэх онгоц бий.

268. **В РАССУЖДЕНИИ** *кого-чего* ...-ны тухайтайд, ...-ны хувьд

269. **В РАССУЖДЕНИИ СЕГО** [*канцл.*] Учир нймийн тулд, учир тухай ниймээс, ниймийн учирт, чингэхлээр, ингэхлээр, ийм болохоор

270. **В РАССЫПНУЮ.** Газрын ганц, бут, зад, зад үсрэх, зүг зүгтээ, ийш тийшээ үйрэх, цацсан тарна шиг, цацсан будаа шиг, газрын нэг, талын нэг

271. **В РАСТРЁПАННЫХ ЧУВСТВАХ** [*разг.*] Санд мэнд, уймраа, ухаан жолоогүй, ухаан нь ууланд, амь наана там цана, халаг, хоохой, ум хумгүй, сэтгэл уймран, нүд нь орой дээрээ гарах,

272. **В РАСТЯЖКУ** [*разг.*] Цэх шулуун, бие нуруу тэгш, голшиг гооногор, асхан, гоолиг нуруутай, нуруу туруу сайхантай. гуухгар, гунагар, гунхсан

272. **В РАСХОДЕ** [*разг*]. Гадуур байх, гэрт эзгүй, эзэнгүй, гадуур дотуур байх, даян дээгүүр, энд тэнд
Все люди в расходе. Улс амьтан цөмөөрөө эзэнгүй, байна.

274. **В РЕДКОСТЬ** [*прост*]. Нүдний гэм, хаяа нэг, өдрийн од шиг

275. **В РЕЗУЛЬТАТЕ** ...-ний үрд, ...-ний үрээр, ...-ний дүнд ...-ний эцсийн дүнд, ...-ний хүчээр, ...-ын ачаар, ...-ны тул

276. **В РЕЗУЛЬТАТЕ** *чего* ... учир иймд, ниймийн тул, ...-аас, ...-аас болж, ... болоход

277. **В РЕЧАХ ПО СОЛОВЬИНОМУ, А В ДЕЛАХ ПО ЗМЕИНОМУ** Аман дээрээ ачтай ажил дээрээ бүчтай, хэлдэг нь бад, хийдэг нь хор

278. **В РЕШЕТЬ ВОДУ НЕ УДЕРЖИСЬ** Аргийн цоорхойгоор хоцро-, шүүрээр ус шүүх гэгч бол-

279. **Б РОЗОВОМ СВЕТЕ** (цвете) зөв үзэх, тэрнээс сайн юмгүй гэж үзэх, үзлийн сайнаар үзэх, ойшаах,

280. **В РОЛИ** *кого-чего* Болох, орлох, хийх, дууриах, элэглэх
В роли судьй Шүүгч хийх (болох), шүүгчээр

Я выступал в роли переводчика Би хэлмэрчилсэн

281. **В РОСТ** Хүүгээр хувь өгсөн

282. **В РОТ НЕ ВОЗЬМЁШЬ** [*разг*]. Идээд баймаар үгүй, идэнги муутай (үгүй) амнаас унаних гэсэн, хоёр чихнээс хойш явахгүй (өнгөрөхгүй, орохгүй) огидос хүрмээр, нохой ч тоож идмээргүй, аманд ч хийх аргагүй, ой гутмаар, ам руу зүглүүлэмгүй

283. **В РОТ НЕИДЁТ** *что* 1. амаараа гартал идэв, их цадах, голийтлоо чихэх, тэсэртлээ идэх, зоогийн сав зогсоолдоо хүрэх, чигжиртэл идэх, ивэртэл идэх, гэдийтэл цадах, хагартал идэх; тултлаа идэх, савaa дүүргэх, дургүйгээ хүртэл идэх, байя гэтлээ идэх 2. Хоол орохгүй

284. **В РУЖЬЁ** [*воен.*] Зэвсэглэн, зэвсгээ агсан, цэрэглэн, өвч зэмсэгтэй, нум сумаа агсан

285. **В РУЖЬЁ СТАТЬ** [*воен.*] Цэргээ заса-, зэвсгээ агса-, дайнд зэхэ-, цэрэг агт дайнд жигдрэ-, байр байрандаа

286. **В РУКАВ (в рукавицу)** Байсан сууриндаа

287. **В РУКАХ ДЕРЖАТЬ** *кого* Гартаа атга-, эрхэндээ атга-, мэдэлдээ ав-, би мэдэ-, оруул-, оруулж ав-, гарын доор, хөлийн доор, улны доор, хараандаа, эрхшээлдээ

288. **В РУКАХ** *что у кого* [*перен.*] Эзэмших, өөрийн болгон авах. сайтар сурах, гартаа оруулах,

289. **В РУКИ ВЗЯТЬ** *кого* Эрхэндээ оруул-, жолоог нь атга-, мэдэлдээ ав-, авааль эхнэр шигээ болго

290. **В РУКИ ОТДАТЬ** *кому* 1. (что) өг-, гар сунга-, гар тэнийхий-, хялайхий-, гардуул-, 2. (перен.) *кого-что* Хэн нэг хүнээр мэдүүл-, жолоогоо атгуул-, толгойгоо мэдүүл-, аяыг дага-

291. **В РУКИ ПРОСИТСЯ** (плывет, идет) Гарг сул орж ирэх, зөөлөн хоол идэх,

292. **В РУКУ** *кому* тусын тул, ... ны тул, ...-ний төлөө

293. **В РЯДЕ** *кого-чего* Өдүй тодүй, зөндөө олон, бишгүй, аван саван, эллэв шалдав
В ряде деревень есть уже электрическое освещение Олон олон тосгон хэдийн цахилгаан гэрэлтэй болжээ.

294. **В РЯДУ** *кого—чего* ...-ын дотор, дунд, —д, —т
В ряду любителей есть хорошие фотографы Гэрэл зураг сонирхогчдын дотор ч сайн сайн зурагчин бий.

295. **В (самое) ПОСЛЕДНЕЕ ВРЕМЯ** буюу **В ПОСЛЕДНИЕ ДНИ** Сүүлийн үед, сүүлийн хэдэн өдөр, ойрноос, саявтар, сүүлийн хэд хоногт, саяын хэдэн өдөр, хоёр гурван хоногоос, сүүл хирд, ойрдоо

296. **В САМОМ ДЕЛЕ** Үнэндээ, үнээр, чухамдаа, нээрэн, ингэхэд, яг л, баараггүй, мадаггүй, хийгүй, гарцаагүй

В самом деле Дорлиг не обманул и приехал во время Дорлиг ч үнээр хуураагүй яг л хэлсэн цагтаа ирсэн шүү.
Вы в самом деле, сами это видели? Ингэхэд та нар тэрнийгээ нүдээрээ үзсэн үү үгүй юү? (Ингэхэд та нар тэрнийгээ үзсэн л юм биз дээ?)

297. **В (самом) РАЗГАРЕ** *буюу* **В (самый) РАЗГАР** Ид дундаа, ид . . . ж байх, улаан галзуу дээрээ, яг оволзох, ойн дээрээ явах В-723
В разгаре боёв Тулаан ид дундаа; (тулаан чи үх би амьд байя дээрээ)
В разгаре лета Юутай хүүтэйгээ урсчихмаар аагим зун, (нохой гаслам зун, нозоором, амь тэмцэм халуун, зуны ид халуун, ясны хөлс гарсан, нүү халуун, лүгхийм халуун)
В разгаре работы Ажил ид дундаа, ажил яг оволзох, ажил амь наана там цаана, алба ширүүн, зогсолтгүй

298. **В (самом) СОКУ** В—227, 233

299. **В (самую) ПОРУ** [*разг*]. Яг, чухам, болдог цагтаа, хэрэгтэй цагтаа, ирье гэж иржээ, сайн хүн санаагаараа, морь сайтай
Самбу пришёл в самую пору Самбуу ч болдог цагтаа ирлээ дээ

300. **В (самую) ТОЧКУ (попасть)** [*разг*]. Яг, чухам, нүдээ ол-, голы нь ол-, цохонд нь буу-, (гай шалтгаантай юманд бол) мэнгий нь голло-, судсы нь атга-, ганц оно-, яг оно-, хар, хулхиар нь, амин голы нь

301. **В САМЫЙ РАЗ** [*разг*]. Яг цагтаа, болдог ч цагтаа, нүдээ олцав хэмээн, яг таара-

302. **В САПОЖКАХ ХОДИТЬ (щеголять)** [*прост, перен*]. Үзээд өгье ч гэсэн үгүй; нүдний гэм бол-, эрээд олддоггүй эрдэнэ, сураад олддоггүй сувд; хужирса-, эрдэнэ бол-, ховордо-, пэлдэн бол, өлзийлө-
Дорога нынче рыбка—то стала, в сапожках ходит. Одоо ч загас гэдэг юм үнэд ороод нүдний гэм болчихжээ.

303. **В СБОРЕ** Жигдрэх, гүйцэх, бэв бэлэн болох, яг жагсчихлаа.
Все в сборе Бүгд жигдрэвээ.

304. **В СВЕТЕ (каком) (видеть, представлять и. т. п).** (Юмыг) тийм ийм хэмээн (үзэ-, бодо-)
Представить, что в мрачном свете Юуг ч юм өөд муутай хэмээн (үзэ-, юманд цөхөрсөн бодол, өөд нар үзэхгүй хэмээх, горь тасрах тийшээ ханда-, сэтгэлээр уна-

305. **В СВЕТЕ** *чего* . . . -ын үүднээс харваас, . . . -аас хянавал, . . .-ын тусыг бодвоос, . . .-аан гэвэл
В свете марксизма Марксын сургаалын үүднээс үзэхүл
В свете последних данных Сүүл сүүдийн мэдээ сэлтээс хянаваас
В свете очередных задач Өнөөгийн ээлжит зорилтын тусыг бодохул

306. **В СВЕТУ** [*разг*]. Гэгээнд, ил, гэрэлтэй газар, харагдах газар

307. **В СВОЁ ВРЕМЯ** Цагтаа, хирдээ, тухайнхаа цагт, ямарваа юм цагтаа, цагийн юм цагтаа, цаг цагтаа, цаг нь тэр хойно, цагтаа цалги-

309. **В СВОЕЙ ТАРЕЛКЕ (быть)** [*разг*]. Бах нь ханасан байртай, ганц болж байгаа бололтой, их маадгар (бай-), хөх инээд нь хүрэ-, додигор (бай-) хэвлүүн нь аргагүй, загатнасан газар нь маажсан шиг, тав нь ханасан янзтай, тэнүүхэндээ поодой—, моосгор, (хүүхэд бол) аавын цээж орги-, бадлиа авсан янзтай

310. **В СВОЁМ ВИДЕ** Байдгаараа л, бахи л байдгаараа, байдаг байдгаараа, хуучин хэвэндээ, хэв янзаараа, өнөө л янзаараа, яв янзаараа, огт хэвээрээ, хуучин янздаа

311. **В СВОЕМ ДОМУ И СТЕНЫ ПОМОГАЮТ** Сиймхий ч гэсэн гэр минь сэгсгэр ч гэсэн ээж минь; дассан газрын даавуу зөөлөн; хар гэртээ хаан бор гэртээ богд, өөрийн юм өлзийтэй, өөрийн юм өргүй

312. **В СВОЁМ РАСПОРЯЖЕНИИ (иметь)** что Хүн байна даа бас, өөрийн гэсэн. . . -тай, өөрийн . . . -тай бол-, толгой мэдэх юмтай бол-, өөртөө оронтой бол-, өөрийн юм өргүй, . . . ч бас хувьдаа

313. **В СВОЁМ РОДЕ** [*разг*]. 1. Нэгэн бодлын, нэг бодоход, бас чиг гэж, нэг андаа
Онон в своём роде талантлив Онон бас ч гэж авьяастай хүн шүү.
2. Аль алинд нь . . . бий, гүзээ гүзээний булан
И осень и весна хороши каждая в своём роде Хаварт хаврын нэг сайхан бий; намарт намрын нэг сайхан бий. (Хаврын наран нь хө хавартаа дулаан даа, намрын наран нь хө намартаа дулаан даа хө)
Два брата, и каждый в своём роде Хүн болгон адилгүй хүлэг болгон жороогүй гэгчээр ахан дүү хоёрт алаг цоог юм бий дээ (ах дүү хоёр гэхэд шал ондоо).

314. **В СВОЁМ УМЕ** [*разг, перен*]. Өөрийн ухаантай (байх), эрүүл ухаантай (байх), ухаан саруул В-393
Не в своём уме Өөрийн ухаангүй, ухааны чилээтэй, ухаан нь ууланд гарсан, элий балай
В своём ли ты уме Чи чинь өөрийн ухаантай байна уу үгүй юү?

315. **В СВОЙ ЧАС** [*разг*]. Эрт орой нэгэн цагт, цагаа болоход, цаг ирвээс, хэзээ боловч

316. **В СВОЮ ОЧЕРЕДЬ (голову)** [*перен*]. Бас, түүнчлэн, . . . -ны хувьд, . . . дээрээ хүрвэл, . . . тэх дээрээ тулбал, хэрэв заяа тэгэх юм бол; өөрөө ч бас..., мөчөөгөө өгөхгүй, хувиа тавихгүй

317. **В СВЯЗИ** *с чем* Учир иймээс, иймийн учирт
В связи с этим Учир иймээс, энэ учраас, . . . -аар[4], . . . -аас[4]

318. **В СЕМЬЕ НЕ БЕЗ УРОДА** [*погов*] Зууд нэг бамбуу, олон хүн сайнтай муутай, ойн мод урттай богинотой; арван хуруу тэгш

гүй; сайнтай муутайгаа гэр дүүрдэг; сархинаг гүзээтэйгээ тогоо дүүрдэг; хүн болгон адилгүй, хөлөг болгон жороогүй

319. В СЕРДЦАХ [*разг*]. Уур манасхийх, (дүрсхийх), чочмог уур хүрэх, ууранда, хар ууранр, уурын мунхаг, уур гэдэг юм бадраад явчих, шатаад явчих, ямаан омог хөдлөх, зүрх нь хөөрөх

320. В СИЛАХ Чадахтай, дийлэхтэй, даах, . . . -д аврага, . . . -д эр бар, барах, гарын дор, бардан дөнгөх, (би) түүнтэйгээ, чоно өтлөөч нигэндээ зөв,

Старик не хотел уходить и пока был в силах, продолжал работать Өвгөн биеийн тэнхэлтэйдээ ажлаа орхилгүй хийх гээд л байх санаатай (буурал маань түрүүлгээ унатал ажилласаар л байв, өвгөн гуай бүүр шондоо тултал ажиллав), (өвгөн гуай ч сүгтээ тултал (унатал) зүтгэсээр л байв). **Я не в силах долее сносить этой пытки (Гончаров)** Энэ зүдгүүрийг ч би тэсэж байж яасан ч чадахгүй боллоо.

321. В СИЛЕ Сүр давуу, хүч түрэнги, нд чадруу, эр хүчин төгөлдөр, нд, дүн (өвөл), аваргадуу, баавгай, эр бар

Зима еще в силе, но пахнет уже весной Хэдийвээр дүн өвөл боловч хаврын шинжтэй (хэдий дүн өвлөөрөө авач хаврын урь ханхалсаар).

322. В СИЛУ 1. Учир, учраас, болох тул. 2.

Я не смог выполнить вашего поручения в силу создавшихся условий Байдал хувирсны учир таны өгсөн үүргийг би гүйцэтгэж чадсангүй ээ.

323. В СИЛУ ВЕЩЕЙ С-422

324. В СКОБКАХ Чухамдаа тийм биш, нээрээл тийм байх чи.

325. В СКОБКАХ ГОВОРЯ (будь сказано, заметить и. т. п). Дашрамд хэлэхэд, далимаар нь хэлчихэд, ялдамд өгүүлбээс, үг дайхад, ярианыхаа завсар хавчуудахад, ам нээснийх гээд хэлчихэд, ам нээвэл уушги нээнэ гэгчээр

В скобках заметим, что он угадал совершенно (Достоевский) Дашрамд хэлэхэд таах нь ч сайн таалаа.

326. В СКОРОСТИ Нэн даруй, даруйхан, удахгүй, нигэсхийгээд, зогсоогоор, одоохон, мөн одсо, бэлэн, туп түргэн, дор нь, дороо л, эхэлж аваад л, дав даруй

327. В СЛАСТЬ Дуртайяа, урианлгахан, уухайн тас, бахаа ханга-, хүслээ гүйцээж, сэтгэл дүүрэн, зол зэхээ, хөх инээд хүрэх

328. В СЛЕПОМ ЦАРСТВЕ КРИВОЙ КОРОЛЬ Ухаангүй ноёнд урагшгүй албат, мах багадахад бохи чөмөг ахлах, мах ховордоход богтос түрүү; хадаг ховордоход самбай ахлах, нохой үгүйд гахай хүцах, бурхангүй газар бомбо галзуурах, ламгүй газрын банди галзуурах, бухгүй газрын бяруу галзуурах,

329. В СЛЕПУЮ Нүдэн балай чихэн дүлий, дүй баазын, гөрөөр, хар гүжрээр, сохор нохой дүйвээнээр, олны дүйвээнд бүдүүн баргаар, сохор таамгаар, хар муйхраар, харын албаар, албын хүчээр (хүчинд), аргагүйн эрхэнд

Пришлось действовать в слепую Бүдүүн баргаар л тэгэс нигэс хийхээс өөр яалт ч үгүй болов.

330. В СЛУЧАЕ *чего* Болбол, . . . болдог бол, дээр хүрвэл, . . . гарвал, хэрэгтэй бол, чингэхүл, тэгэхүл, нигэхүл, чингэх юм гэхэд, хэрвээ . . . бол, тийм . . . бол

В случае воины все мои сыновья пойдут защищать родину Дайн дэгдвэл миний хөвүүд цөм эх орноо хамгаалаар мордоно.

В случае необходимость телеграфируй мне Хэрэгтэй болбол надад цахилгаан өгөөрэй.

331. В СЛУЧАЕ *чего* [*разг*]. Хэрэг явдал гарвал, юм болбол, санаандгүй юм болбол, анзааралгүй байтал, зүүдлээчгүй байтал

В случае чего, сообщи мне Хэрэг явдал гарвал надад мэдэгдээрэй.

332. В СМЕХ [*разг*]. Тоглож байна, илүү үг хэлж байна, зүгээр л наргиаж л, инээд ханнад болгож, наадсан юм шуу, юм бодуузай

333. В СМЫСЛЕ *чего перен.* Ухаандаа . . . -ны хувьд, . . . -ны тухайд, . . . -ны нь хэлбэл ч, . . . -ийн утгаар, . . . гэсэн санаагаар, . . . гэсэн ухаантай, . . . гэсэн шиг, тиймэрхүү, иймэрхүү

334. В СОБСТВЕННЫЕ РУКИ Гарт нь, биед нь, өөрт нь

335. В СОКУ В-227, 233, 298

Летами он был еще в самом соку Насныхаа хувнар ч нд дундаа л даа.

336. В СОГЛАСНОМ СТАДЕ И ВОЛК НЕ СТРАШЕН Эвт шаазгай буга барина. Цувж явсан барснаас цуглаж суусан шаазгай дээр. Эвлэвэл бүтнэ. Ганцын сайнаас гарын олон. Бүгдээрээ зөвлөвөл буруугүй, бүлээн усаар угаавал хиргүй. Хорин хүн эвгүй бол эвдэрхий хүрээ мэт, хоёр хүн эвтэй бол төмөр хүрээ мэт.

337. В СОГЛАСИИ *с чем* Ёсоор, дагуу, . . . чилэн . . . аар[4] . . .-д нийцүүлэн, толгой дохих, зөвшөөрснөөр

В согласии с правилами Дүрмийн ёсоор

В согласии моего брата у г ч и л с х и й в э л ахы миць зөвшөөрснөөр, у т г а нь ах тэгвэл тэг гэсэн үг.

338. В СОГЛАСНОСТЬ *с чем* . . . -ыг баримтлан, . . . -ын ёсоор, . . . -ын дагуу

339. В СОПРОВОЖДЕНИИ *кого—чего* . . . тай цуг, . . . -ын хамт, . . . лугаа нэгэн хамт, . . . -аар бараа бололцуулан; дагуулан

340. В СОСТАВЕ *чего* . . . -ийн бүрэлдэхүүн, . . . -тай, . . . -ын найрлагатай, дотор нь бий, тогтцонд нь

В составе комиссии произошли изменения Комиссын бүрэлдэхүүн өөрдөв.

Комиссия в составе трёх человек Гурваи хүнтэй комисс

341. В СОСТОЯНИИ Тоохгүй, юу ч болохгүй, гудиглахгүй, дийлэх, барах, чадах, дөнгөх, ...-д эр бар, уймуухан, бардаагаар, юман чинээнд бодохгүй.

Нурем в состоянии обмануть нас Нүрэм ч мангайгаа араар нь тавьж дөнгөнө шүү.

Не быть в состоянии Чадахгүй (хир нь болох, чадал хүрэхгүй, барахгүй, шон хүрэхгүй, таваглахгүй, нохой хорихгүй, сачий хүрэхгүй)

Еще рюмку! — Нет, благодарю, я больше не в состоянии Дахиад нэг хундага тогтоочих—Үгүй үгүй, сайхан болсон, би одоо бүр барахгүй болоод байна.

342. В СРЕДНЕМ Дунджаар, дунд баазын, дунд зэргийн, дундын л, барагтайхан, бэсрэг С-765

343. В СТАРИНУ Эрт урд цагт, дээр үед, урьд, элэг балар цагт, галав галчингийн, эрт дивангарын, элэг галавын үеийн

344. В СТЕНАХ *чего* ...-д (-т), ...-ын дотор

В стенах нашего клуба предполагается встреча нового года Манай клубт шинэ жилийн баяр найр болох гэж байна.

В стенах университета Их сургуульд

345. В СТОРОНЕ (оставить) *кого-что* Зоргонд нь орхих, талаар өнгөрөөх, эс хэлэлцэх, үл анзаарах К-17

346. В СТОРОНЕ ОСТАТЬСЯ Хэн хүнд үл анзаарагдах, амьтан харахгүй (ажигламгүй), (хүн) тоохгүй, талаар болох; хуруу дүрэхгүй, хөндлөнгөөс хөлөө оруулахгүй, араар сугарч үлдэх, сүүл барьж үлдэх; зожигрохох; ар худрагаар нь хийдүүлэх, хийгий нь тааруулах, зэсрэх, зэс тавих, тэг, умаа хум болох

Вопрос о музыкальных инструментах опять остался в стороне Хөгжмийн (зэвсгийн) асуудал бас л талаар өнгөрөв, хөгжим гэдэг шонгүй болсон

Только одна бригада осталось в стороне от участия в субботнике. Ганцхан бригад л хөдөлмөрт ороогүй дээ.

347. В СТОРОНУ Орхизнох, орхих, хойш тавих, байзнах,... лгүй, сүүлд болох, хожим тэгэх

Пошёл гулять, а дело-в сторону Ажил мажлаа орхиод зугаацан явж сэтгэлийн чилээ гаргая.

Отбросим в сторону все условности и поговорим откровенно. Тэгвэл ингэвэл гэж олон юм нуршилгүй илэн далангүй ярилцацгаая.

348. В СТОРОНУ СКАЗАТЬ *жужигт* үзэгчдэд хандан өгүүлэ-, өөр тийшээ ярь-

349. В СТОЯЧЕЙ ВОДЕ МНОГО ТИНЫ [*погов.*] **(В ТИХОМ ОМУТЕ ЧЕРТЫ ВОДЯТСЯ)** үгчилбээс Тогтмол усны лай их, дуугүй хүний доотох нойтон, хонь идсэн чоно хонгилд В-369

350. В СТОЯЧКУ [*прост.*] Босоо, зогсоо, модон өмд өмссөн юм шиг

Есть в стоячку Босоо зогсоогоороо юм идэ-

351. В СТРАХЕ (держать, воспитывать, жить) Хүний царай харан, хүн царайчлан, номхон морины ногт догшин морины чөдөр бол-, далайсан газар нь далд орж, далалсан газар нь ил

гарч; хэн нэг хүний өмнө тоодог шиг тонголзож, галуу шиг ганганаж; хүний ая хара-, дуулгавартай, зөөлөн чихтэй, гэрийн боол; гэдэсний нь уяа; гарын боол ганзаганы уяа; боолын боол босгоны шороо, номхон мориных нь ногт, догшин мориных нь чөдөр

Всю жизнь в страхе жила (М. Горький) Нэг насаар хүний царай харж амь зууваа.

Держать всю семью в страхе Гэрийнхнийгээ засаглаж чаддаг (гэрийнхнийгээ жанжила-)

Детей своих он воспитывал в страхе Хүүхдээ тун зөөлөн чихтэй болгон хүмүүжүүлэв.

352. В СТРОГОМ СМЫСЛЕ СЛОВА Ний нуугүй хэлэхэд, чин үнэнээр нь хэлэхэд, илэн далангүй хэлэхэд, нээрээ шүү, үнэндээ

Это не критика в строгом смысле слова, а личный выпад Энэ ч шударга шүүмжлэл биш чухамдаа ул шагайсан хэрэг байна.

353. В СТРУНКУ СТАТЬ (В СТРУНКУ ВЫТЯНУТЬСЯ) Модон өмдтэй мэт зогсо-, төв зогсо-, мод шиг зогсо-, хүгдийтлээ зогсо-, жаа хүлээхэд бэлэн зогсо-; шаасан гадас шиг зогсо-, номхон зогсо-, хөшөө чулуу шиг, хөшчихсөн юм шиг зогсо-, чих тавин зогсо-

354. В СУК ПОПАСТЬ [*прост*] Яг, яв цав хэмээн, санасан газар болсон будаа, ярьсан юм шиг, хэлцээтэй юм шиг

355. В СУММЕ (взятое, взятые) Дүн нь, нийтдээ, бүгд, нийлээд, нэлэнхүйдээ, нийдэмдээ, цараараа, зангаргаараа, олны олон таван цэн гэж, цугаараа, нэмэр нэмэрлэсээр, бөөнөөрөө, дүн багцаа нь, базаж үзвэл

356. В СУХЕ ДА В ТЕПЛЕ [*погов*] пүн хийсэн, халуу дүүгсэн,

357. В СУЩНОСТИ (В СУЩНОСТИ ГОВОРЯ) [вводное слово] Чухамдаа, чанартаа, нидэр дээрээ, үнэн чанартаа, хэрэг дээрээ, яс цохиод ирэхийн тэнд, ачир дээрээ, үнэндээ гэхэд, нэг их ч

В сущности, это не удивительно Чухамдаа гэхэд үүнд гайхаад байх юм алга.

Это его, в сущности, не удивляло (Тургенев) Тэрүүнд ер чиг гайхсангүй

358. В СЧЁТ *чего* **(выдать, получить и. т. п.)** [*канц.*] ... ны зардлаар, ... ны хөрөнгө тооцоогоор, ... ны хишгээр,

Выдать деньги в счёт зарплаты Мөнгийг цалинд зарлагада- (зарцуула-)

359. В ТАЙНОСТИ П-336

360. В ТАКОМ ПОЛОЖЕНИИ [*разг.*] [*эвф.*] Юмтай (хүүхэдтэй) болох, олз олох, бие хүнд болох, гэдэстэй болох, бие шалтгаантай болох, бие давхар, жирэмслэх, таргалах, цүдгэр болох, хөл хүнд болох

361. В ТАКОМ СЛУЧАЕ гэх *буюу* хар хэлнээ **В ТАКОМ РАЗЕ** Тийм бол, чингэвэл, өө тийм юм бол, тэгэж байгаа бол, тэх дээр хүрвэл, тэгдэг бол

362. В ТАКТ Айзмаар, айзамд таарууллан

Он слушая песню, качал в такт головой Сонсож байгаа дууныхаа айзмаар толгойгоо бөнжигнүүлэн дохилхийлээм.

363. В ТЕ ПОРЫ [*диалект.*] Тэр (энэ) үед, цагтаа, тухайнхаа үед төдүйд, эдүйд, тэгэхэд нь, тухай тухайд нь, тэр тухайд нь

364. В ТЕЛЕ (В ТЕЛАХ) [*разг.*] Өөхлөсөн, тарга авсан, харвин суусан, гүзээлсэн, шалхайсан, бандайсан, бэндийсэн, пандгар, пэндгэр, бүдүүрсэн

365. В ТЕНИ 1. Далд, дарагдан, ажиглагдамгүй; 2. Оюц анхааралгдамгүй, эс тоох, үл ойшоох, эс шимтэн

366. В ТЕСНОМ СМЫСЛЕ СЛОВА Үгчилбээс, махчилбаас, үг үгээр нь хөөвөл, үгийхээ өнгөөөс бол

367. В ТЕСНОТЕ, ДА НЕ В ОБИДЕ Дотор сэтгэл уужим бол өвсөн овсохой ч давчдахгүй.

368. В ТЕЧЕНИЕ -д, -т, ...-ийн дотор, ... -ын хооронд, (бүтэн долоо хоног, жил, ...), хугацаанд, ...-ын турш, ... хиртэй

В течение дня Нэг хоногт, нэг хоногийн дотор

Мы не встречались в течение недели Бид нар бүтэн долоо хоног уулзалдаагүй л байна.

369. В ТИХОМ ОМУТЕ ЧЕРТИ ВОДЯТСЯ [*погов*] Дуугүй хүний доотох нойтон, өнгөө нааная, өргөсөө цааная; сумаа харваад нумаа нуух, гадаа нэр тэмцэх дотроо амь тэмцэх; гадаа багтай дотноо бүгтай В-349

370. В ТИШИ 1. Буйд, аглаг, буйд булан газарт, зэлүүд, зэрлэг өвгүй

Жить в тиши Буйд булан газар аж төрө-, аглаг бараада-,

2. [*разг.*] Сэм, дув дуугүй, сэмээр, далдуур, чив чимээгүй, нам гүм, анир чимээгүй

371. В ТО ВРЕМЯ, КАК [*разг.*] Хэдийгээр ... боловч, гэсэн хэдий боловч, ... ч ... гэсэн, тэгэхийн хажуугаар, ... авач, ... гэвч, ... гэлээ ч ...

372. В ТО ЖЕ ВРЕМЯ Түүнчлэн, үүнчлэн, ...-ын хамт, ... бас үүний зэрэгцээ, үүний гадна, цаашлбал, нөгөөтэйгүүр, үүн чацуу, мөн, бас, басхүү, жич

373. В ТОЙ МЕРЕ, КАК ... ...-ний хирээр, ...-ний хэмжээнд, ...ны савны хэмжээ нь, ... чинээнд тултал, нэг багцаанд, нэг анзаанд, ...ний дүнгийн, ...-ны дайны

374. В ТОЛЧКИ (выгнать, прогнать и. т. п.) [*разг.*] Түлхилэ-, түлхиләэд ав-, нудчи-, ёвчи-

375. В ТОМ-ТО И БЕДА ... нь л зовлонтой байна... л байна, дээ, ... л төвөгтэй байна, ...-аас[4] л болоод байна... л гай бол... л хэцүү байна,... л жого байна, ... л жиг ургалаа; харин нигээд л болохгүй байгаа юм, хамаг учир үүнд л байгаа юм.

376. В ТОН Өнгөт, аят

377. В ТОТ РАЗ Тэр үес, тэгэхэд, тэдүйд, эдүйд

378. В ТОЧНОСТИ [*разг.*] Яг, яв цав, яг таг, цав хэмээн, хялгасны төдүй зөрөөгүй, дэрсхэн

379. В ТРЕТЬЕМ ГОДУ Уржнан

380. В ТРЕТЬИ РУКИ (отдать, продать, перейти и. т. п.) Дамжуул-, дамжуулан өг-, хүнээр явуул-, дам өг-, дамла-, өгүүлэ-, дам дамаа. гар дамжуулан

381. В ТРИ ГОРЛА (кричать, вопить, горланить и. т. п.) Дуу тавьж гуу цохих, орь дуу тави-, орило-, бархира-, багаазуурда-, нэг дуу тэнгэрт нэг дуу газарт, хашгира-, байдгаараа чарла-

382. В ТРИ ПОГИБЕЛИ ГНУТЬ *кого-что* [*разг.*] Хайр найргүй, нэрмэ-, талхи-, нухчин дарла-, хорло-, хахсан дээр нь гударч хазайсан дээр нь түлхэ-, багалзуурдан дара-

383. В ТРИ ПОГИБЕЛИ ГНУТЬСЯ (согнуться) Малгай аван толгой дохин сөгдө- (хяра-, эвхрэ-), нэхэд бөхөлзө- (мэхий-) нуруунд нь нугас ургасан юм шиг; тонгос тонгос хий-, нахилзан тахилза-, атира-, эвхрэн атиран, баримжаа шиг атиран, атгын чинээ боло-

Спать приходилось в тесноте, согнувшись в три погибели (Тохмын чинээ газар тугдайн унтах болов) Давчхан газар эвхрэн атиран унтахаас өөр аргагүй болов.

384. В ТРИ РУЧЬЯ (заплакать, зарыдать, слёзы, льются и. т. п.) Мэгшин, мэгшин уйла-, мэлмэрэн уйла-, мэлмэрүүлэн уйла-, цорхирон уйла-, асгаруулан хан уйла-, мэлмэлзэн уйла-, мэлтэлзүүлэн уйла-, усан нүдлэ-

385. В ТРИ СЧЕТА *редко* В-45

386. В ТРИ ШЕИ ГНАТЬ (В ШЕЮ ГНАТЬ ВЫГОНЯТЬ) *кого-что* Хөөн гарга-, үлдэн хөө-,сэг сэвсгүй зайлуул-, хөөж туу-, долоон уулын цаагуур оруул-, нүднээс далд оруул-

387. В ТРУБЫ ТРУБИТЬ *о ком-чем* [*разг.*] Сүр бадруулан ярийн тийн гэж хашгичи-,том ярь-, хөөрцөгдө-, омойто-, сүржигнэн хашгичи-, зүг бүрт үсчи-, зүг бүрт шүлсээрээ була-, муу хүний дуу их, дүлий хүн байгаа юм шиг, би л гэсэн шиг

388. В ТЫСЯЧУ РАЗ [*прост.*] ...-аас[4] хамаагүй дээр (хавьгүй илүү), мянга дахин илүү дээр, жишээгүй дээр, эгнүүлшгүй, ... хол илүү (дээр), өдөр шөнө шиг зөрөөтэй; зүйргүй дээр, хавьтахгүй

По мне арбуз в тысячу раз вкуснее дыни Миний бодохоод, тарвас чинь гуанзас хамаагүй (хавьгүй илүү амтай) сайхан амттай байхгүй юу.

389. В ТЯГОСТЬ *кому* Тээртэй, садаатай, дарамт, тээр

390. В УГОДУ (В УГОДНОСТЬ) *кому-чему* [*устар.*] (Тэгэх ингэх) гэж; ...-ийн төлөө, саймсрах-, тал олох гэж, ая засах гэж, долигонох-, бялдуучил, өргөн магтах-

Такие люди готовы сделать в угоду империалистам. Иймэрхүү этгээд (амьтад) эзэрхэг түрэмгийчүүдэд тал олох гэхээрээ юу ч хийхээсээ сийхгүй.

391. В УГОН [*охот.*] (халин нисэж яваа жигүүртэн болон гүйн дэгдэж яваа ан араатныг) бөгс рүү нь буюу бөгсөөр нь харвах (буудах), олон ясы нь дайруулан буудах, хошногоор нь сувлэх, хар хошногоор нь харвах

Выстрелить в угон в зайца Дэгдэн яваа туулайн бөгс рүү нь хаван харва-

392. В УДАРЕ (быть) [*разг*] Додигор, урамтай, урмас төрө-, тав хана-, сэтгэл хангалуун, таалалтай, сэтгэл дүүрэн, дотор сайхан, сэтгэл уужим

Этот шахматист сегодня в ударе, играет очень хорошо. Тэр шатарчин сайн нүүгээд өнөөдөр их урамтай байна.

Я сегодня не в ударе, не буду рисовать Өнөөдөр (би) сэтгэл дундуур (гонсгор) байна. Юм (зураг) зурахгүй

393. В УМЕ 1. *что делать* Дотроо (бодо-), цээжээр, дотор хүлтэйгээ (зөвлөх) **В-314**

Решить эту задачу в уме Энэ бодлогыг цээжээр бод доо.

Считать в уме Дотроо бодо-, цээжээр бодо-

Он сразу же прикинул в уме, сколько это будет стоить Ямар үнэтэй болохы нь цээжээр бодож гаргав.

2. [*разг.*] **В-314**

3. *у кого* **Н-344**

394. В УНИСОН (петь *буюу* **действовать** [*перен*] [*разг.*] Сохор нохой дүүвээнээр (чимээпээр)

395. В УПОР шахам тулгуу, дэв дэргэд, халз тулан, чанх өөдөөс, халз урдаас, халз, тулгаж, шаанги **Д-371**

396. В УПОР ВЫСТРЕЛИТЬ (стрелять) *в кого-что* Тулган буу-да-, тулган харва-,

Он выстрелил в упор, и человек упал. Тулган буудмагц хүн нь унав.

397. В УПОР СКАЗАТЬ (говорит) *что* Илэн далангүй хэлэ-, (өгүүлэ-), илэн далангүй яри-, халз хэлэ-,улаан хэлэ-, палайтал хэлэ-, улаан цайм хэлэ-,хэлсэн шиг хэлэ-, хэлнэ гэмээ нэг хэлэ-

Я ему в упор сказал, что он бесчестный человек Үнэнч журмын хүн биш байна гэдгий нь би бүр өөрт нь хэлээд тавьчихсан

398. В УПОР СМОТРЕТЬ (глядеть) *на кого* Эгц гөлрө-, дүрлий тэл ширтэ- нүд чавчилгүй хара-

Она глядела на него в упор, открыто, немного надменно и вызывающе (Федин, Братья, Одна ночь, гл. 4)

(Тэр эмэгтэй) (тэр эрэгтэйг) нүд чавчилгүй ихэмсэг өдсөн янзтай ширтэв.

399. В УПОР СТАТЬ [*разг.*] Зөрүүд, мугуйд, мужийн, зөрүүдлэчигээрээ зан, муйхар, дөргүй сарлаг, зөрөөгүй зөрүүд, хэдэр, ярдаг, шил нь тата-бодсоноороо зүтгэ-, этгээд зан гарга-, ад мөрийн ааш гарга-, амаа мэдэхгүй даага шиг, илжиг шиг зөрүүд, гахай шиг зөрүүд; хүний үг хор болсон

400. В УРОВЕНЬ *с чем* **1.** ... тай чацуу, тийм нийм юмаар ... тай зуузай холбо-, эн зэрэгцүү, бялхуулан, дүв дүрэн

Вода в ведре в уровень с краями Хувинд амсар нь бялхам ус байна.

2, [*перен.*] ... -тай таара-, ...-тай нийцэ-, мөр чацуу

Жить в уровень с веком Эрин үетэйгээ мөр чацуу бай-, (ахуй үетэйгээ зуузай холбож ява-, цагтаа цалгиж ява-)

401. В УС (ухмыляться, улыбаться, посмеиваться и. т. п). Жуумалзах, жуумаганах, инээдээ барьж ядах, Шарвалзах, жаатганах, инээвхийлэх, инээлхийлэх, инээмсэглэх, тохуурхах,

402. В УС И В РЫЛО (*быть кого*) (Хүнийг) алгада-, (хүнд) таван салаа боов хүртээ-, жавтий хүртээ-,)

403. В УС (себе) НЕ ДУТЬ [*разг.*] Жихэм ч үгүй, нүдэн балай чихэн дүлий бай-,; нохой хуцсан чинээнд гүй; огт хайхрахгүй; огт тоохгүй, чихгүй толгой орги-, дүн дүлий орги-,

Он себе в ус не дует. Огт тоохгүй байна (орос монгол толь, 395-р нүүр)

404. В УСТАХ *кого, чьих* ... (ингэж) хэлж байгаа нь, ... үг нь, битүүдээ, цааная,

Такое замечание в его устах равносильно строгому предупреждению. Ингэж зэмлэж байгаа нь, битүүдээ, тэгвээ чи гэж ятгаж байгаа үгээ (Энэ зэмлэл ч мань хүнд чамбайхан сануулга болсон юмаа).

405. В УХО ДАТЬ (Съездить, заехать, ударить, въехать) [*прост*]. (дэлбэ, зад, тас буутал) үсэртэл алгада-; гүйж очи-, давхиж хүрэ-, дайрч оро-, цөм дайра-, шунгинаж хүр-, сум шиг дүүлэ-, чихий нь дүлийртэл; хүлхида-; чихний нь хэпгэргийг хага, дүлийртэл нь алгада- муужиртал нь алгада- алгада-,

406. В УШИ (Нашептать, наговорить, надуть, и. т. п) [*разг., неодобр.*] Чихэнд хонх уя-, улигла-, янши-, нури-, гонжигоно-, нурши-, бавтнаад салахгүй, ам хуурай байхгүй, үглэ-, ам хамхихгүй, жор жор гэ-,

407. В ФАВОРЕ *у кого.* Ивгээл дор, асрамжаар, ... ны нөмөрт

408. В ФОРМЕ Гараа гаргах, ид шидээ үзүүлэх, хутгаа сугалах, хүчээ гаргах, чадлаа гаргах, олигтой өөдтэй үзэлцээд алдах, мэрийх; чармайх, шүд зуух; мачийх; мяхайх;

Наша команда сегодня не в форме. Манай баг өнөөдөр (чадлаа) хүчээ гаргаж чадсангүй. Өнөөдөр манай баг мэрийсэнгүй (л дээ)

409. **В ХАРАКТЕРЕ** *чьём* чухам таарах, ... д таарах, өөрт нь таарах, авъяасанд нь зохих, эзнээ олох
Не в вашем характере об этом сожалеть. Тоогүй, энэ танд тааралгүй (ажил) юм байна даа

410. **В ХВАЛЕНОЙ КАПУСТЕ МНОГО ГНИЛЫХ КОЧАНОВ.** Магтсан хүүхэн хуриман дээрээ...

411. **В ХВОСТ И В ГРИВУ И—8**

412. **В ХВОСТЕ (быть, идти, плестись и. т. п.)** [*перен.*] баас түү-, (хама-) адаг, сүүлдэ-, дулихан яваа, сүүл мушги, хоргол түү-, (дүлэ-) Хомоол хормойлох; Баян ходоод; шонгүй хоцрох; уяатай юм шиг;
В классе он плетётся в хвосте. Ангидаа дулихан яваа нь тэр
На сей раз, товарищи, вы остались в хвосте. Нөгдөө, энэ удаа ч, та нар баас хамлаа шүү.

413. **В ХЛОПОЧКАХ** (хлопцах) Өөхөнд хучсан бөөр шиг, амандаа үнхвэл хайлах бий гэж алган дээрээ тавивал бөмбөрөх бий гэж; энхэр дэвээ хатаж

414. **В ХОД ПОЙТИ,** ... нд орох, төлөөлүүлэх
Стаканов не хватило, пошли в ход кружки, даже стекляные банки. Шил аяга нь хүртэлцэхгүйн учир аяганд ороод бүр сүүлдээ шилэн сав хэрэглэв.

415. **В ХОД ПУСТИТЬ** 1 Асаа-, явуул-, хөдөлгө-, давира-, мордо-,
Пустить в ход машину. Машинаа асаа!
2 [*перен*] их хэрэглэ-, дэлгэрэ-

416. **В ХОДУ** Хэргэлж байгаа; эдэлгээтэй

417. **В (большом) ХОДУ** дэлгэрэх, уяаны болох, зуршил тогтох, муу зан сурах, их гарах, их болох, цагаандаа гарчээ; улайм цайм болжээ; ерийн хэрэг болжээ
Из преступлений одно, именно: Кража гороху, моркови и репы по огородам, было, в большом ходу... (Гончаров, Обломов, ч. 1, гл. д) Ногооны газраас буурцаг, луувай, манжин хулгаж авах нэг гэм бүр зуршил болж дэлгэрээд байна аа;

418. **В ХОРОШИЕ (плохие) РУКИ) отдать, продать, гм.)** Хямд, сул, их үнэ гэхгүй; үнэрхэхгүй
Эту лошадь в хорошие руки продам очень дёшево. Морио санаа таарсан хүнд хямдхаан өгчихкө.

419. **В ХОРОШИХ (плохих) РУКАХ (быть, на ходиться)**

420. **В ХРИСТИАНСКИЙ ВИД ПРИВЕСТИ** *кому, чему* [*разг.*] Үнэн дүрээрээ залра-, царай оро-, өөрийнхөө царай ол-, Үнэн биеэ биелж; царай зэса-; жинхэнэ биеэ биелэ-; X-133

421. **В ХУДШЕМ СЛУЧАЕ** Ядахдаа, дор хаяхад, наад зах нь, цөөндөө л, үгүй дээ л, адаглаад л, байг гэхэд, даан ч дээ; яав даа дээнч г. м.

422. **В ЦВЕТЕ** В-745

423. **В ЦВЕТУ** Навч цэцэг дэлгэрээх, цэцэглэх,
Сад весь в цвету Цэцэрлэг нд цэцэг навчаа дэлгэж байна.

424. **В ЦЕЛОМ** бүхэл, нийтдээ, даяар, цугаар г. м.

425. **В ЦЕЛЯХ** *чего* - . . нийг тулд, . . . (тэгэх нигэх) зорилгоор,. . (тэгэх нигэх) гэж, (тэгэх нигэх) санаатай.

426. **В ЦЕНЕ** Үнэтэй, үнэ хүрэх, үнэ ихтэй, гүйлгээтэй,
Этот товар нынче в цене Энэ таваар одоо их үнэтэй байгаа.

428. **В ЧАСТНОСТИ** 1. Гэх мэтсийн, тэр дундаа, ч хүртэл 2. Олонтаа, ихэнхдээ
Деятельность многих великих людей в частности Пушкина, была стеснена современными или общественными условиями Олонхи сууг хүмүүсийн үйл ажиллагаа, нэн ялангуяа Пушкины үйл ажиллагаа бол тэр үеийн нийгмийн нөхцөлд их хавчигдаж байсан юм.

429. **В ЧЕМ ДЕЛО** Юу болоо вэ? Яагаа вэ? Яах нь тэр вэ?

430. **В ЧЁМ (только) ДУША ДЕРЖИТСЯ** [*разг.*] Дөнгөж нэг амьсгаатай, дөнгөж нэг голтой, зүүд зэрэглээ шиг, амьдаас цаашгүй, үлэн салган, нэг амьсгаа л, сүг төдүй, голтой төдүй, хоногоо хүлээх, хүний гарт орсон.

431. **В ЧЁМ МАТЬ РОДИЛА** [*разг., шутл.*] Аав ээжээс заяаж хайрласан бисэрээ л, улаан нүцгэн, шалдан, мич шиг шалдан чармай нүцгэл

432. **В ЧЕРНОМ ЦВЕТЕ** Явайгүй, хийморгүй, доожоохон, уруу царайтай, царай даранги, өөдгүй, жалхгүй

433. **В ЧЕСТЬ** *кого-чего* буюу *кому-чему* . . . -ыг дурсан, . . . -ын дурсгалд, . . . -ыг хүндэтгэн, . . . -ийг нэхэн санаж
Назвал сына Владимиром в честь Ленина Ленинийг дурсгалд зорилуулан хүүдээ Владимир гэдэг нэр өгөв.

434. **В ЧЕТЫРЁХ СТЕНАХ (сидеть, жить)** Гэрийн мухар сахи-, гэрээс гарахгүй, гэрээс цухуйхгүй; гэрээс гарахгүй, гэдэс алдахгүй

435. **В ЧУЖОЙ МОНАСТЫРЬ СО СВОИМ УСТАВОМ НЕ ХОДЯТ** Усны нь уувал ёсы нь дага; сохрын газар сохроор, доголонгийн газар доголон; ёс ёмбогор, төр төмбөгөр; ёс ёсондоо, ёл ууландаа

436. **В ЧУЖОМ ГЛАЗУ СОЛОМИНКУ ВИДИТ, А В СВОЁМ БРЕВНО НЕ ЗАМЕЧАЕТ.** Хүний толгой дээрх өвс үзээд өөрийн толгой дээрх тэмээг үзэхгүй; хүнийг хэлэхдээ хүрэн эрээн барс шиг; өөрийгөө хэлэхдээ өндгөө дарсан шувуу шиг; өөрийн толгой дээрх өлөн бугыг харахгүй, хүний толгой дээрх өлөн өвсийг шоолох; муугаа мэдэхгүй өмдгүй байж өвдөг цоорхойг шоолох

437. **В ЧУЖОМ ПИРУ ПОХМЕЛЬЕ** Хоморгонд орох, хонь идсэн чоно хонгилд, хоосон гүйсэн чоно хоморгонд, авсан нэг тамтай, алдсан нь арван тамтай

438. **В ЧУЖУЮ ДУШУ НЕ ВЛЕЗЕШЬ (разве влезешь и. т. п.)** [*разг.*] Хүний дотор орж үзсэн биш, хүний эрээн дотроо . . .

439. **В ШАГУ** Өмдний салтаа (гаар),өмдний халхнаг, өмдний алганаг
Брюки узки в шагу Өмдний салтаа барнуджээ, өмдний салтаа нь барну (давч), өмдний салтаа тушуу (цухал)

440. **В ШАПКАХ** [*разг.*] Малгайтай (байх), малгайгаа өмсөөтэй

441. **В ШЕРСТИ (быть)** Үсэн бөөндгий бол-, үс ургачихсан, бавайгаад, сангас шиг, үс сахалдаа баригда-, (сахал ам нь) ухна шиг, дээсэн ноттой, шоронгийн хоригдол шиг, үсэн өргөс, сахал самбайны нь байж байгаа

442. **В ШЕЮ** [*дать г. м*] П-351

443. **В ШКУРЕ** *чьей* **БЫТЬ** [*разг.*] . . . -ны байдалд оро-, . . -ны дүрээр бай-, дүрээр хувила-, зүсээ хувилга-

444. **В ШКУРУ** *чью* **ПОПАСТЬ** [*разг*] Хүний байр суурий нь эзлэдаварсаар даварсаар Дагвын суурынд гэгч бол-, оры нь орогнож, гэрий нь гэрлэ-

445. **В ШТЫКИ (встретить, принять г. м).** *кого-что* [*перен.*] Араараа золго-, араараа нийлэ-, араараа уулза-

446. **В ЮБКЕ** [*разг., шутл., ирон.*] 1. Эм, эмэгтэй; 2. Банзалтай, банзал өмссөн; 3. Эрэмгий эм, эрмэг эм; эршүүд эм; гэрт эм гадна эр; муу эрийг тоохгүй эм, сүв нь солигдсон эм
Профессор в юбке Эмэгтэй профессор

447. **В ЭТОЙ СВЯЗИ** Үүнээс болж, энэ шалтгаанаас, үүнээс, . . . -аас[4] (-аас, -ээс, -оос, -өөс), . . . -аас[4] болж, энэ учраас

448. **В ЭТОМ ВСЯ СОЛЬ** Ухаан нь эндээ байж, гол гогцоо нь эндээ байж

449. **В ЭТОМ ОТНОШЕНИИ** 1. Үүнээс, иймд, нигээд, чигээд энэ учраас; 2. Үүний (энэний) хувьд, энэ тухайд

450. **В ЭТОМ (таком) РОДЕ** [*разг.*] Иймэрхүү л, энэ дайны, энэ дайтай, энүүн шиг, энэрхүү, бараг энэ анзааны, энэ багцааны өөрцгүй, нэг үг, нэг янзын, ижилдээ ижил, адилдаа адил, дүндээ дүн
Он в этом роде и выразился Иймэрхүү л юм дурдчихаж байна билээ.
Я в этом роде и написал ему Би ч бараг иймэрхүү л юм тэрүүнд бичиж явуулсан даа.

451. **В ЭТУ ПОРУ** [*разг.*] Эдүгээ, одоо, өдгөө, өдүйд, өнөө, өнөөдөндөө, одоо хир, энэ зуур, энэ хир, энэ үес, сая, одоо бол

452. **В ЯБЛОКАХ** Сэвхтэй бор (морь), толботой цоохор (морь) **конь серий в яблоках** (Будэнт бор) сэвхтэй бор морь, толбот бор, сэвхэт бор

453. **ВАВИЛОНСКАЯ БЛУДНИЦА** [*книжн.*] Ужид эм, садар эхнэр;

454. **ВАВИЛОНСКОЕ СТОЛПОТВОРЕНИЕ** Самуун, самуун байдал, эмх замбараагүй, дажин болох, самуун дэгдэх

455. **ВАЖНАЯ ПТИЦА** [*разг.*] Их хүн, том хүн, цуутай хүн, их гарын хүн, дээгүүр зиндааны

456. **ВАЛААМОВА ОСЛИЦА ЗАГОВОРИЛА (прорекла)** (Уг нь библээс гаралтай хэллэг) 1. Дуугүй хүн дуу оров; дуугүй хүний амны үдээс тасрав; 2. Мугуйд (зөрүүд) эм

457. **ВАЛИ КУЛЁМ-ТАМ РАЗБЕРЁМ** [*разг.*] Дүүрсэн хэрэг үзээд алда-, дүүрсэн хэрэг думбийсэн толгой; яадгий нь үзэ-, сайн ч муу ч дүүрч, аз л мэдсэн хэрэг, хамаа намаагүй, их барьсан ч үмхий, бага барьсан ч үмхий.

458. **ВАЛИТЬ (метать, сваливать) В (одну) КУЧУ (в одно)** Будлиа-, хольж хутга-

459. **ВАЛИТЬ ВАЛОМ (Валом валить)** Бөөн бөөн, бөлөг цөлөг, сүрэг сүргээр, элэг бөлгөөр, баг багаар, суман сумангаар, хороо хороогоор, хэсэг хэсгээр, тасаг тасгаар П-392

460. **ВАЛИТЬ С БОЛЬНОЙ ГОЛОВЫ НА ЗДРОВУЮ** Гэмгүй хүнд гэм чихэ-, улаан гүжирдэ-, хэрэг тохо- С-214

461. **ВАЛИТЬ С НОГ** С-215

462. **ВАЛИТЬ ЧЕРЕЗ ПЕНЬ КОЛОДУ** [*разг.*] Хуудам, хуумгай, хам хум, ингэс тэнгэс хий-, нүглийн нүдийг нүхээр хуура-, бухын хамрыг нударгаар, ор нэр болго-, хайш яйш, алмайда-, хийсэн л бол-, хуламда-

463. **ВАЛИТЬ** *что* **В ОДНУ КУЧУ** [*разг.*] Холиж хутга-, хутгалдуул-, холион бантан болго-, хоормог шиг холилдо-, үчир жунцангүй, үчир замбараагүй, холион сүлээн, үчир намбаагүй үчир дүрсгүй
Валить всё в одну кучу Хамаг юмыг холион бантан болго-

464. **ВАЛИТЬСЯ В НОГИ** [*разг.*] Мөргө-, сөхрө-

465. **ВАЛИТЬСЯ ИЗ РУК** [*разг., перен.*] Гар сал хийгээд, урамгүй, урмас төрөхгүй, дургүй хүргээд, сүлдгүй оргих, хийморьгүй, сэхээ алга, хариу тасраад, бие шалдаагаад, сөгөөгүй
Сегодня у меня всё валится из рук Өнөөдөр би бүр юу ч хийх урам алгаа.

466. **ВАЛИТЬСЯ НА ПЛЕЧИ** *кого, чьи* толгой дээр ирэ-, хийх албатай бол-, чарганд оро-, гарцаагүй хийх бол-,

467. **ВАЛИТЬСЯ С НОГ (от усталости)** (Ядраад) хоёр хөл сөхөрчихмөөр, унаад л өгмөөр байх, унаж ойчихын даваан дээр, хамаг бие сал гээд, таван махбодь харшаад

468. **ВАЛОМ ВАЛИТЬ** В-459

469. **ВАЛЯТЬ ДУРАКА** [*прост*] 1. Цааш муула-, цаагуур нь оротоглоом тохуу хий-, 2. Хамаагүй загна-, мангарла-,
Бросьте валять дурака, я говорю с вами серьёзно, За битгий тоглоом тохуу хийгээд бай. Би танд хэлэх л гэж хэлж байна шүү.
Не валяйте дурака Это дело требует большого внимания. Битгий эрваат, Тун хянамгай байхгүй бол болохгүй.

470. ВАЛЯТЬСЯ В НОГАХ [*разг*] Гуйж гувших, гуйж гунших, хормой дэвсэн гуйх, доотхий нь долоох шахах, гуйж мөргөж байж, хошуу цорвойх, царай алдах

471. ВАЛЯТЬСЯ (кататься) СО СМЕХУ (от смеха) [*прост.*] Элгээ хөштөл инээ-, өнхөрч дүгэртлээ инээ-

472. ВАРИТЬСЯ В СОБСТВЕННОМ СОКУ [*перен.*] Хувна борлуулж довоо шарлуула-, мөрөө хөө-, мөр мөрөөрөө, өөрийн санаа өөртөө зөв, мөр мөртөө, мөндөл дошиндоо

473. ВАРИТЬСЯ (как) В КОТЛЕ [*разг.*] Толгой дээш татах завгүй, ухаан сэхээгүй, аман хүзүү сээр хоёр шийлэх гээд бай-, таван завгүй

474. ВАРФОЛОМЕЕВСКАЯ НОЧЬ Их аллага хядлага, алаан хядаан, хүйс тэмтрэх, голы нь самарч голомты нь хийсгэх

475. ВАС (тебя, его г.м.) ОБЫЩЕШЬСЯ Яасан олддоггүй улс вэ? та нар тань хаа орчихдог улс вэ Газрын гаваар орчихсон улс уу

476. ВАС ПРОСЯТ ЧЕСТЬЮ [*ирон.*] Гайгүй, гуйя л даа, та морилчих л доо, та тэгэж хайрлах, шигэж хайрлах, соёрхоно уу ажаамуу, соёрхож ажаамуу; (хоолон дээр бол) зохихгүй шингэхгүй гэх биш Т-58

477. ВАША ВЛАСТЬ [*разг.*] Таны таалал мэдэг, та өөртөө мэдтүгэй, таны мэдлийн хэрэг, та таалаараа болтугай, таалаар тань болтугай, хэрхэхийг таны сэтгэл оюун мэдтүгэй, таны дурын хэрэг, та өөрөө мэдтүгэй

478. ВАША ДОБРАЯ ВОЛЯ Таны таалаар болъё, таны таалал мэдэг, таны дураар болъё, таны өөрийн зориг мэдэх хэрэг, мунхаг би үл мэднэ, жаа

479. ВАШ БРАТ... [*перен., разг., фам.*] Та нар, тан шиг, таны мэт аххүү чинь, ахан дүү нар

Ваш брат студент... Оюутан танар..., оюутан ах дүү

Вашему брату еще на о много учиться Танар минь номоо сайн үзэгтүн.

На вашего брата не угодишь Тан шиг хүнийг эсрэх арга нь олдохгүй байна.

480. ВАШ ПОКОРНЫЙ (покорнейший) СЛУГА [*офиц. и теперь редко ирон.*] (Захианы сүүлд бичих үг) Гүнээ мэхийн ёсолсон таны үнэнч боол, таны өлмийд мэхийн ёслов нөгөө муу чинь

481. ВАША (твоя, его и. т. п.) **ВЗЯЛА** Та түрүүллээ, та давлаа, та дийлэв ээ, та хожлоо, таны ажил болжээ, хожил таных болов оо, таных боллоо

482. ВАША (твоя, его г. м.) МИЛОСТЬ Эзэнтэн, ноёнтон, авгай та, жаа ноёгтой, авгай, хатагтай, хатантан, ахайтан

Как ваша милость прикажет Эзэн таны зарлигийг дуулъя, эзэн юу айлтгасан бол, болгоож хайрлана уу, жаа болгоож хайрла

Что вашей милости угодно? Танд хэрэгтэй юмсан бол? (таны зарлигийг дагая), таны таалал юусан бол?, та юу таалах асан бол?

483. ВАША СЕСТРА... [*перен., разг.*] Та нар, тан шиг, таны мэтийн, та бүхэн (эмэгтэй хүнд хандан хэлэх үг)

Ваша сестра студентка... Оюутан та бүхэн

484. ВАШЕ (моё, их и. т. п.) **ДЕЛО СТОРОНА** [*разг.*] Таны (миний) явдал (надад надгүй) миний явдэл (танд надгүй, хамаагүй) таных хүртэл ярихгүй, хэяа хүртэл жийгээгүй; танд хамаагүй хаданд чимээгүй, хүний явдал хүнд хамаагүй

485. ВАШЕ ЗДОРОВЬЕ (Наичнд) сархад (өргөхөд ерөөн хэлэх үг) Таны эрүүл мэндийн төлөө! Таны өлмий бат орших болтугай! Таны лагийн тунгалаг орштугай Таны эсэн энхийн төлөө!

486. ВАШИМИ ВЫ УСТАМИ ДА МЁД ПИТЬ [*погов.*] **1.** Амч гэж алт, сайхан ч амтай бол доо, амаараа гийгүүлэх, ам гэж атлага шиг; **3.** Ерөөл бат сайхан орших болтугай, уухайн шар тос, мөр зохитугай

487. ВАШИМИ МОЛИТВАМИ [*устар., разг.*] Таны адистдын ачаар, таны жанлавын хүчээр, таны ачинд, таны ивээлд, таны асралд

488. ВБИВАТЬ В БАШКУ *кому* В-490

489. ВБИТЬ В СВОЮ ГОЛОВУ В-490

490. ВБИТЬ (вбивать) КЛИН МЕЖДУ *кем-чем* Товлон бодо-, бат бодо-, бат сана-, бат итгэ-

491. ВБИТЬ (забивать, вбивать) ОСИНОВЫЙ КОЛ [*разг.*] Хор хүргүүлэхгүй, хорлоя болгохгүй, муу юм хариула-, төвөг удахгүй, гай тарихгүй, гэмгүй

492. ВБИТЬ СЕБЕ В ГОЛОВУ Санаандаа санаж шанаандаа зууж ав-, цээжиндээ хадгалаж ав-, ягштал тогтоо-

493. ВВЕРХ ДНОМ [*разг.*] **1.** Өөд уруугаа харан, ундуй сундуй, түрүүлгээ харах, толгойгоороо хөл хийх, хөлөөрөө толгой хийх, бөгсөө тэнгэр өөд харуул шил нь тат, тас гэдэргээ харах; **2.** Нэгмөсөн хөмрө-, нэгмөсөн балра-, ээ хөмрөө

494. ВВЕРХ НОГАМИ Дөрвөн (*хоёр*) хөл дээшээ, уруу түрүүлгээ, эх толгойгүй, доошоо хараад, хөл нь гозойгоод, эх адаггүй болох, хөмрөх, балрах К-339

Скамья лежала вверх ногами Урт сандал доошоо хараад хэвтэж байв. (ванданг бүгдий нь эргүүлээд хаяжээ)

Перевернуть (поставить) вверх ногами хөмрө-, эргүү-, уруу нь харуул-, доош нь харуул-, түрүүлгэ нь харуул-, онхолдо-, онх уна-, тонгорцогло-

Стоять вверх ногами годройто-

495. ВВЕРХ ТОРМАШКИ (тормашками) 1. полететь, спустить и. т. п.) [*прост.*] Түрүүлгээ хара-, годройто-, тонгорцогло-, онхолдо-, тонголдо-, ондройдо- **2. (пойти г. м.)** [*перен.*] Уруу түрүүлгээ хара-, ундуй сундуй

496. ВВЕСТИ В СТРОЙ *что* Нээх, нээн ажиллуул-

Два новых завода введены в строй Хоёр шинэ үйлдвэр нээн ажиллуулав.

497. **ВВЕСТИ ВО ГРЕХ** *кого* [*шутл.*] Уруу тата-

498. **ВВЕСТИ** (вводить) *кого* **В КУРС** *чего* Мэдүүл-, хэлж өг-, танилц-, сэнхрүүл-

Они ввели меня в курс последних событии в нашем городе Манай хотын сүүлийн үеийн байдлыг надад хэлж өгөв.

499. **ВВЯЗАТЬСЯ В БОЙ** [*воен.*] Тулаанд оро, дайнд оро

Подоспевшие танки немедленно ввязались в бой. Ирсэн танк дорхоноо л тулаанд оров. (Танк ирэнгүүтээ л тулаанд оров).

500. **ВГОНЯТЬ В ГРОБ** *кого* В-748

501. **ВГОНЯТЬ** (вводить) **В КРАСКУ** В-748 б

502. **ВГОНЯТЬ В ПОТ** В-749

503. **ВДОЛЬ И ПОПЕРЁК** Хөндлөн гулд, энд тэндгүй, үүгээр түүгээр, ундуй сундуй, яваагүй газаргүй болох, ойр хавийг дуглуйлах, толь гэндэн шиг явах

Исходил страну вдоль и поперёк Орон даяар хөндлөн гулдгүй явлаа.

504. **ВЕДЬ НАДО ЖЕ** [*разг.*] 1. Үгүй одоо; гай болоход, ядахнаа, тоогүй, үгүй мөн хачин юм, жигтэй юм; 2. Үгүй ер, үгүй тээр, хараач хөө, хясахад, хяслантай, аз хаяхад **Н**-439

Ведь надо же, как раз в этот момент поднялась буря Ядахнаа, салхи шуурга таарчихдаг нь бас.

Ведь надо же, опоздал всего на две минуты. Даанч тоогүй, хоёрхон л минут хожигдсон юмсан л даа (хоёр минут ч гэсэн хожигддог нь тоогүй).

Ведь надо же, было ему сделать такую глупость Үгүй мөн жигтэй, мань эр нигэж мал оргидог юм аа.

505. **ВЕК БЕКОВАТЬ** . . . -ж насыг бара-, насыг элээ-, . . . нэгэн насыг бара-, насыг насла- (Та бид нар мөнхийн усыг уусан биш).

Не век нам с тобой здесь вековать Та бид нэгэн насаар энд нигээд л байхгүй шүү дээ (Та бид үхдэггүй насан хутгийг олсон биш).

506. **ВЕК ЖИВИ-ВЕК УЧИСЬ** Эрдэмд оройгүй; насан турш юм сур, мэдэе гэвэл мэрий, чадая гэвэл чармай

507. **ВЕКИ ВЕЧНЫЕ** Үеийн үед; ашид; эгнэгт, өнөд; хэзээ ямагт; цаг үргэлж; насад;

508. **ВЕЛИКА БЕДА** Тэр яах вэ! тэр зэрэг юу ч биш; тэрүүхэн зэрэг гайгүй **Н**-626

509. **ВЕЛИКА ВАЖНОСТЬ** [*разг.*] Битгий хэрэгт ав! хамаатай юу, юуны хамаа байх вэ? тоохын хэрэггүй, хайхрах юмгүй, бүү хэрэгсэ! Битгий аизаар! Мэдээгүй юм шиг байх **Э**-3

Тебя ругают-ну и пусть, велика важность. Амьтан чамайг зүхэж л байна-Зүхдэг нь зүхэж л байг, хамаатай юу.

510. **ВЕЛИКА ФЕДОРА, ДА ДУРА** Нэр их гэвч нидэр нь бага, алдар нь их ч ачир нь бага

511. **ВЕЛИКА ЧЕСТЬ, ДА НЕЧЕГО ЕСТЬ** Хоосон сүр; нэрнээс цаашгүй; хий их нэр; нэр нь их ч нидэр нь бага.

512. **ВЕЛИКИЕ МИРА СЕГО** Ихэс, дээдэс, эрхтэн дархтан, эвэртэн туурайтан,

513. **ВЕЛИКИЙ НЕМОЙ** 1. Хэлгүй том хүн; хэлгүй махан овоо 2. Дуугүй кино

514. **ВЕЛИКИЙ ОКЕАН** Номхон дөлгөөн гадаад далай; нуур намаг шиг

515. **ВЕНЗЕЛЯ ПИСАТЬ** [*разг. фам. шутл.*] Найган ганхан алха-, гуйван дайван, согтуу юм шиг, чөдөр галзуутсан юм шиг **П**-155

517. **ВЕРЁВКИ ПЛАЧЕТ** *по ком* [*разг.*] Үхэж байх нь таарсан (олиггүй хүн)

518. **ВЕРЁВКИ ВИТЬ** *из кого* [*разг.*] Номхон морины ногт дошгин морины чөдөр шиг байлга-, үлээвэл цаашаа, сорвол наашаа байх

519. **ВЕРИТЬ НА СЛОВО** *кому* Үгий нь үнэмши-, үгэнд оро-, үгийг итгэ-, үгээр үг хий-, хэлснийг үнэмши-, Үгий нь итгэүгий нь бишрэ-

Я тебя не обману, поверь мне на слово. Би чамайг хуурахгүй, үгий минь үнэмши!

520. **ВЕРНАЯ ГИБЕЛЬ** Үхдэгийн даваан дээр байх, амь наана, там цаана, үхлийн аманд, амь алдаж мэдэх, хутганы ир дээр амь гарах

Послать на верную гибель. Үхлийн ам руу аваачи-, (золиосонд аваачи-,)

521. **ВЕРНЕЕ ГОВОРЯ** Үнэний нь хэлэхэд, ний нуугүй хэлэхэд, чухамдаа, үнэндээ, илэн далангүй хэлэхэд;

522. **ВЕРНОМУ СЛУЖИТЕЛЮ СУГУБЫЙ ДАР** Тэнгэрийн умдаг атгав, хишиг хүртэх

523. **ВЕРНУТЬ В ПЕРВОБЫТНОЕ СОСТОЯНИЕ** [*шутл.*] Ажил албанаас халагда-, хөөгдө-, буу; огцро-, ирсэн замаараа сурсан дуугаа дуулаад л . . . хуучин буудалдаа эргэж ирэ-, албанаасаа огцро-, ширээнээсээ шилжиж ширдэгнээсээ гулса-,

524. **ВЕРНУТЬ ЖИЗНЬ** 1) *кому* Үхээд бос-, үхээд сэхэ-, эргэж төрсөн адил; төрөл арилжсан юм шиг, үхэж дүүрээд сэхэ-, хүн бол-, амий нь авра-, босго-, үхэж гүйцэ- 2. *Чему* (тэрэг чарга) заса-, босго-, сэлбэ-, 3. *Кого* нибуд хүний аминд оро-,

525. **ВЕРОЙ И ПРАВДОЙ (жить, служить)** Үнэн шудрагаар (сууж алба хаа-) Үнэн цагаанаар; төв шудрагаар; үнэн зөвөөр мөрөөрөө; журам зүйгээр; зүй зохисоор нь:

526. **ВЕРТЕТЬ ВОЛА** [*прост*] дэмий яри-, донгосо- дэмий мэтгэлцэ- К-556

527. **ВЕРТЕТЬ ХВОСТОМ** [*Перен.*] Сүүлээрээ хуура-, упатал тустал хуура-, малла-, залила-, үнэг шиг хуура-, нүд шүдээрээ хуура-, толгой эргүүл-, үүдэн шүдээр хуура-, араар нь тави-, В-643, З-101, К-566

Хвостом-то не верти, истинную правду мне сказывай Битгий хөөрхөн маллах гээд бай чухам нидрий нь над хэлээд орхи.

528. **ВЕРТЕТЬСЯ ВЬЮНОМ** [*разг.*] Дэвүүр шиг, салхин дүүгүүр шиг; өд шиг; савдаг элээ шиг; шарваганах; цаасан дарцаг шиг; хүрд шиг эргэлдэх, гулбаганан шулбаганан, ээрүүлдэх, хөлд ороолдох, тушаа болох,

Собака вертелась вьюном у ног охотника. Нохой анчныхаа өмнө хойно нь орон гаран эрэгцнэм (Гөрөөчний нохой эзэндээ шарвалзана) Анчны нохой нь эзэндээ шарвалзмуй. Анчны нохой эзэндээ эрэгцэн шарвалзана. Гөрөөчний нохой нь эзэндээ шарвалзан эргэлдэнэ.

529. **ВЕРТЕТЬСЯ КАК БЕЛКА В КОЛЕСЕ** шороо хөлхөө тасрахгүй, борив бохис хийхгүй, хийхгүй юмгүй, байхгүй юмгүй, бүтэж цөхөж л, зогсоо чөлөөгүй, ингэс тэнгэс хийсээр л,

530. **ВЕРТЕТЬСЯ НА ГЛАЗАХ** Өөрөө өөртөө зовох шиг болох, тун тоогүй боллоо

531. **ВЕРТЕТЬСЯ ПЕРЕД ГЛАЗАМИ** *у кого* лай болохоор зай болмор, гээр удсан, яс амраахгүй, нойтон хамуу шиг

532. **ВЕРТЕТЬСЯ (ПУТАТЬСЯ) ПОД НОГАМИ ПЕРЕД ГЛАЗАМИ** [*разг. фам.*] 1. өмнө хойно нь гүй-, өмнө хойно бөртөгнө-, ээрүүлдэ-, ороо шала- сүүдэр бол- Ард нь гарч алгаа тосч, урд нь гарч уруулаа унжуулах; 2. Долигоно-, Хоол горьдсон нохой шиг; эрх хав шиг; П-1265

533. **ВЕРТЕТЬСЯ ЮЛОЙ** [*разг.*] Ээрүүл шиг эргэлдэ-, дороо суурьгүй бөндөгнө-, бөмбөрө-, Дугуй ээрүүл шиг; салхин дүүгүүр шиг; тээрмийн сэнс шиг; хүрд шиг; хөнгөмсүү;

534. **ВЕРТИТСЯ В ГОЛОВЕ** Мартачиж, санаанд орохгүй бай-, санахгүй бай-, эргүүтэ-, бодоод бодоод бодын шийр дөрөв, ухаанд нь ухна үхсэн, энүүхэнд байна таг мартаж; ор тас мартах; таг идэх,

Его фамилия вертится у меня в голове, но я никак немогу вспомнить её, Нэрий нь бодоод бодоод орж ирэхгүй л байна даа.

535. **ВЕРТИТСЯ НА ЯЗЫКЕ** *у кого что* Хэл ам загатанах, аман дээр гарч ирэх, хэлэн алдах,

536. **ВЕРТИТЬ СУДЬБУ** Толгойгий нь эргүүл-, ёсы нь хувиргазамы нь өөрчилө-,

537. **ВЕСЁЛЫМИ НОГАМИ (идти, стоять н. т. п.)** Халчихсан, хөлчүүрчихсэн, гуйванхан, халуухан; халмагхан, согтуу нь хөлдөө орсон; чөдөр галзуутсан юм шиг

538. **ВЕСТИ ЗА НОС** [*прост*] Малла-, мэхлэ-, араар нь тави-,

539. **ВЕСТИ КАНИТЕЛЬ** Хойш суух, хойшлуулах, хоног түлхэх, саатуул -, удаашруул -, хойш тави-, тэн хий-, садаа бол-, цаг нөгчөө-; алгуурла-, наазгайра-,

540. **ВЕСТИ НАЧАЛО** Эхлэх, гарах, үүсэх, үүдэх,

541. **ВЕСТИ СВОЙ РОД** *от кого...* -аас гарсан, ...-аас үүссэн,...-ны сурвалжтай, ...-ны улбаа, ...-ны садан сүлбээ ... -ныхны юм.

542. **ВЕСТИ СВОЮ ЛИНИЮ** Өөрийнхөө санаснаар, хүнд нэг санаа гэж байдаг гэгчээр; хий, дураараа, юу сайхан дур сайхан, өөрийн санаа өөртөө зөв,

Несмотря на то, что на каждом шагу встречались препятствия, он упорно проводил свою линию. Хэдийвээр хөдлөх бүр өдүй төдүй саад тулгарч байсан боловч, хийнэ гэснээрээ л зүтгэж бөлгөө.

543. **ВЕСТИ СЕБЯ (хорошо, дурно н. т. п)** қақ (тийм ийм) ява-, (ёс, зүй) сахи- (тийм ийм) бай-, ... янзтай, ... байдалтай

Вести себя хорошо ёс сахи-, төв төвшин бай-, төв шулуун бай- (ява-). Нуруутай бай-, төлөв бай-.

Нельзя вести себя так, неосторожно Ийм гоомой долгон, явж үл болно

Вести себя неприлично Ёсон бус ява-, зүй бус ява-, овилгогүй ява-. П-373

544. **ВЕСЬ ВЫШЕЛ** [*шутл*] 1. Эзгүй (буюу эзэнгүй) 2.

545. **ВЕСЬ НАРУЖУ** Хамаг байдгаа ярих, байдгаа дэлгэх, сархинагныхаа баасыг гүвэх, долоон булчирхай найман найлзуурхайгаа тоочих.

546. **ВЕТЕР В ГОЛОВЕ** *у кого* Хуумгай; хөнгөн хийсэглэн зан, гал дээр гишигчихгэсэн зантай; омтгой, долгонцог, тогтвор суугаагүй, салхин дэвхчүүр, хийсвэр хөөсөрхүү. Галзуугийн аманд гараа хөлчүүгийн аманд хөлөө; савдаг элээ шиг;

547. **ВЕТЕР СВИСТИТ В КАРМАНАХ** (қармане) *чьих, у кого,* С-258

548. **ВЕТРЕНАЯ ГОЛОВА (головушка)** Их хөнгөн хүн; салхи шиг амьтан, сэнс шиг амьтан; дэнгийн эрвээхэй шиг, өд шиг хөнгөхөн, өндөг шиг тогтворгүй

549. **ВЕТРЯНАЯ МЕЛЬНИЦА** [*неодобр.*] салхи шиг хөнгөн амьтан, цаас шиг хөнгөхөн, буурь суурьгүй амьтан, гал дээр гишигчихгэсэн, хөнгөмсөг хуумгай, шалдар балдар, гоомой

550. **ВЕЧЕР ЖИЗНИ** Насны наран хэлбийх (тонгойх), ханан гэр холдож, хадан гэр ойртох, хөгшин хонины насгүй болох, насан зүг болох, нас өтлөх, уулыг цас дарж эрийг нас дарах, нас дээр гарах; өтлөх; хөгшрөх; эсгий гэр холдож, энгэр газар ойртох;

551. **ВЕЧНАЯ ИСТОРИЯ** [*разг., фам.*] Гэм биш зан; (сэтгэл дундуур байгааг илтгэх үг) дандаа л ийм, бахи л байдаг, өнөөх, гэнэт биш хууч

л, улигт л, дов дош болсон; даг дош болсон; домогт; сурснаараа; **өнөөх л,** аанай л

С ним вечная история—всегда всё забывает. Тэр бид хоёр болсон хойно яах вэ дээ мартдагаараа л мартчихаа л биз; (тэр бид хоёр хойно доо, хоолтойгоо холиод идчихээ биз.)

552. **ВЕЧНАЯ ПАМЯТЬ** 1. (уг нь шашны номд үхсэн хүний хойноос) унших ерөөл, хойтохыг нь унших, 2. *кому* [*перен.*] мөнхийн дурсгалд, гэгээн дурсгалд

553. **ВЕЧНЫЙ ЖИД** [*лит.*] Бадарчин, тэнүүлчин, хээрээр гэр хийж хэцээр дэр хийгч, орох оронгүй оочих аягагүй хүн. Оронгүй оргодол орчлонгүй бадарчин

554. **ВЕЧНЫЙ ПОКОЙ** (Үхэх) мөнх нойрсох, нүд аних, уртын аянд явах, хол юманд явна. Өөд болох, тэнгэрт одох, тонилох, таалал төгсөх, нас элээх бүрлээч болох; талийгаач болох;

553. **ВЕЧНЫЙ СОН** (Үхэх) мөнхөд нойрсох, уртын аянд одох, хол юманд явна.

556. **ВЕЧНЫЙ СТУДЕНТ** 1. Бууриа сэлдэггүй оюутан 2. Номын ногоон (олон жил улирсан), насад шавь

557. **ВЕШАТЬ ГОЛОВУ** Толгойгоо ганзгала-, уруу царайла-, хунш нь үхэ-, хулхи нь буу-,

Нечего вешать голову при первом же препятствии! ганцхан зовлон болоход л ингэж уруу царайлж толгойгоо ганзагалаад юугаа хийх вэ!

558. **ВЕШАТЬ НОС (на квинту)** П—372

559. **ВЕШАТЬ СОБАК на шею** *на кого.* [*разг.*] Хэлэх хэлэхгүйгээр хэлэ-, зад хараа-, хараалаа бара-, хэлэхийн муугаар хэлэаль муугаар хэлэ, хэлээ билүүдэ-, зэмлэ-, гэмийг өгүүлэ-, хараал урсгаж гара-, хэл амаа угаа-;

Прежде, чем вешать собак на других, надо уметь относиться критически к самому себе. Бусдын гэмийг өгүүлэхээсээ урьд өөрийгөө л сайн хичээ.

560. **ВЕШАТЬСЯ НА ШЕЮ** [*разг. шутл. фам.*] *кому, к кому* хүзүү толгой холбо-, наалдаж алда-, ... -ийг долоох шаха-, аманд нь орчих гэ- үлхээлцэлд-

561. **ВЗАД И ВПЕРЁД** (ходить, шагать, двигаться и. т. п.) Хойш урагшаа; дэвсэгнэх, ийшээ тийшээ; эрэгцэх, хайш ч үгүй савдах, холхих; ядаг юм билээ; За байз хө.

562. **ВЗБРЕДАТЬ** (ударять) **В ГОЛОВУ** (в башку) *кому* гэнэт санаанд оро-, юу юугүй санагда-, ив ив гэтэл бодогдо-,

563. **ВЗБРЕДАТЬ НА УМ (ВЗБРЕСТИ НА УМ.)** Гэнэт санаанд оро-, өөрийн эрхгүй бодогдо-, санаанд буу-,

564. **ВЗБРЕСТИ В ГОЛОВУ (НА УМ)** [*разг.*] Юу юугүй санаанд оро-, гэнэт бодогдо-, хүн хэлээд өгч байгаа юм шиг, бодол төрө-, дотор сэрхий-; санаанд оро-; П-1008, С-929

Откуда тебе взбрело это в голову? Чамд яагаад гэнэтхэн ийм бодол ордог билээ?

Взбрело ёму на ум, что ему необходимо отсюда уехать. Эндээс л нэг холдоё та минь гэдэг бодол (ухаанд нь) орж ирэв.

565. **ВЗВАЛИВАТЬ класть НА ПЛЕЧИ** (Ажил явдал, юм хуманд) дарагда-, ажлыхаа дороос босохгүй бол-

566. **ВЗГЛЯД НЕ ОТРЫВАЕТСЯ** Нүд салгахгүй, хараа салгахгүй

567. **ВЗГЛЯНУТЬ ОДНИМ ГЛАЗКОМ** [*разг.*] Сөрөм хара-, хялан хий-, хяламхий-, харасхий-, ширвэсхий-, ганц хара-, нэг хараа, бараагий нь хара- царайг нь хара- зүсийг нь хара-,

К больному никого не пускали, а мне так хотелось взглянуть на него одним глазком. Өвчтөнтэй огт хүн уулзуулахгүй гээд байх юм. Би тэр хүнийг нэг бараагий нь харах юмсан.

568. **ВЗДЁРНУТЫЙ НОС** Шантгар хамартай, сойлттой хамар, шантайчихаад, сойлгон хамартай, яравгар; ээтгэр хамартай, баас түрхчихсэн юм шиг;

569. **ВЗДЁРНУТЬ НОС** [*прост.*] Яравгар, яравгар даравгар, маадгар, хамарт нь баас түрхчихсэн юм шиг, зэргэлээ харсан юм шиг өлийгөөд, сээрдүү, хямсгар, уулын толгой хара-,

570. **ВЗДОХНУТЬ СВОБОДНО** [*разг.*] Сэтгэл амар-, хоёр яс сала-, урт амьсгаа ав-, яс амра-, буулгаа мултла-, дөрөө мултлаамасхий-, сэгхий-, дотор онгой-, дотор тавира-, сэтгэл тавира-, дотор далай бол-, (арайхийж нэг) амьсгаа ав-, цээж тэний-, даруулаад хэхэрсэн юм шиг бол-, амсхий-.

571. **ВЗЛЕТЕТЬ НА ВОЗДУХ** 1. Зад үсрэ-, зад буу-, пяц буу-; пяц үсрэ-, дэлбэ буу- (үсрэ-), заадал болгоноороо дэлбэ цохи-; зад тави-; сал- 2. Талаар бол-, сайхан зүүд бол-, хоосон хоцро-, аманд ч үгүй, хамарт ч үгүй;

Пароход, наскочив на мину, взлетел на воздух. Усан онгоц дэлбэлүүлэг мөргөмцөө зад буув.

При столкновении с действительностью все мои мечты взлетели на воздух. (Энэ) цагийн эрхээр хамаг мөрөөсөл минь талаар болж хоцров оо.

572. **ВЗЛЕТЕТЬ НА ГЕЛИКОН** Яруу найрагч бол-,

574. **ВЗЯВШИСЬ ЗА ГУЖ, НЕ ГОВОРИ, ЧТО НЕ ДЮЖ** [*посл*] За гэвэл ёо гүй; ажил хийвэл дуустал, давс хийвэл уустал; Хэлсэн үгэндээ эзэн болж, идсэн хоолондоо сав бол-, Айвал бүү хий, хийвэл бүү ай! Хийвэл хийсэн шиг, хэлбэл хэлсэн шиг; Ам ч ам, ажил ч ажил бай-, үг ч үг, үйл ч үйл бай, хэлж ч чаддаг хийж ч чаддаг;

575. **ВЗЯТКИ ГЛАДКИ** *с кого—чего* [*разг.*] Мэдэхгүй хүнээс горьдож мээмээ хавтгах гэгч; горьдсон чинь голдоо, санахын

халцгай; мээмээ хавтгахын нэмэр; үхсэн эмгэнээс унгас гүйн гэх шиг; горьдоод горьдоод горьдсоны гарлага, их санасан газар есөн шөнө хоосон хонох, гар хоосон байх,

С нашего брата взятки гладки недам ничего. юм хум авна гэж горьдоод горьдсоны гарлага, (юу ч хялам хийхгүй шүү)

576. ВЗЯТЬ БЫКА ЗА РОГА (СХВАТИТЬ) *буюу* брать быка за рога халдвал хар халзандаа, бага барьсан ч умхий их барьсан ч умхий; хийвэл бүү ай, айвал бүү хий. Сүүлтэй нь нолдохоор толгойтой нь, үхэж хэвтэн нэр хугарахаар, үзэж, алдаж яс хугар С-960

577. ВЗЯТЬ ВЕРХ түрүүлэ-, дээгүүр ява-, магнайла- хошуучила-,

578. ВЗЯТЬ В (СВОЮ) ГОЛОВУ *буюу* Себе в голову

579. ВЗЯТЬ В ДОМ өөрийн хүн шиг байлга-, өөрийн... аас[4] өөрцгүй, тэдний өсгө-,

580. ВЗЯТЬ В КЛЕЩИ *кого* [*воен.*] Хавсайдан цохи-,

581. ВЗЯТЬ В ОБОРОТ работу *буюу* брать в оборот *кого*, [*разг.*] [*фам.*] Чандлан захир-, цагда-, хатуу гараар бари-, албада-, дуртай дургүйг асуухгүй.

582. ВЗЯТЬ В РАСЧЁТ П—1040

583 ВЗЯТЬ В РУКИ 1. Гартаа атга-, өөрөө гарда-, толгойгий нь мэдэ-, жолоогий нь мэдэ-, дөрий нь мэдэ-, 2. дагуула-, угнатогооны алчуур болго-, бөхгүй тэмээчилэ-

585. ВЗЯТЬ В СВОИ РУКИ *кого, что* Гартаа атга-, захиртолгой мэдэ-,

586. ВЗЯТЬ В ТОЛК *что* [*разг.*] (в соображение) Ухааны нь ол-, учры нь ол- ухаара-, судсы нь ол-, ой тойнд оро-,

Никак не возьму я в толк, чего он от меня добивается Надаас чухам ямар юм нааш гээд байгаагий нь ухааныг би мэдэхгүй л оргиод байна шүү.

587. ВЗЯТЬ ВОЛЮ Б—337

588. ВЗЯТЬ ВСЕМ Б—338

589. ВЗЯТЬ (себе) В УМ [*прост.*] Ухаара-, ухааны нь ол-, учры нь мэдэ-,

590. ВЗЯТЬ ГОЛЫМИ РУКАМИ *кого—что* Төвөггүй ол-, зовлонгүй ол-, хүйтэн цай зайдан морь, гарын үзүүрээр ол-, саваны зоргоор ол- (гүйцээ-), Гарын ганган хөлийн хөнгөөөр ол-; Чигчийгээ чилээлгүй ол-, Нохойн гуяар далла-,

591. ВЗЯТЬ ГОРЛОМ Б—340

592. ВЗЯТЬ ГРЕХ НА ДУШУ [*разг.*] Нүгэл хий-, хилэнц хий- сэтгэлийн нүгэл хий-,

593. ВЗЯТЬ ЗА БОКА *кого* [*прост., фам.*] 1. Дуртайгаа ав-, 2. Хэрэгтэйгээ хий-, Б-342

594. ВЗЯТЬ ЗА ГОРЛО (за глодку, за жабры) *кого* [*разг.*] [*перен*]—Ацан шалаанд оруул-, хаашаа ч үгүй болго-, албада-, цөхрөө-, үйлий нь үзэ-, дуртай ч дургүй ч өөр аргагүй бол-, хоолой дээр хутга бол-, элэг рүү нь өшигле-

595 ВЗЯТЬ ЗА (забрать) ДУШУ Сэтгэл хөдлөн, догдлом, сэтгэл уярам, сэтгэл хөөрөм, урмас бадрамаар

596. ВЗЯТЬ ЗА ЖАБРЫ* *кого* [*прост., вульг.*] Багалзуурда-, хоолой дээр хутга бол-, хар муйхраар, хар гүжрээр; бол, албын хүчээр, хар хүчээр, харын албаар;

597. ВЗЯТЬ ИЗМОРОМ *кого—что* 1 бүслэн гацаа-,

Взять осаждённый город измором. хотыг бүслэн гацааж эзлэ- Б-438 2. Нял нал гэсэн зантай, яриг нуриа, авад зантай, нойтон хамуу шиг

598. ВЗЯТЬ НА АБОРДАЖ Шийдэмгий оро-, нялуунаас шулуун тэгчээр Б-351

599. ВЗЯТЬ НА АРАПА [*прост.*] Малла-, хуурч ав-, араар нь тави-, Б-352

600. ВЗЯТЬ НА БОРТ хөлөг онгоцноо ачи-, хөлөг онгоцонд гарга-, онгоцондоо ав-, хоргодуул-

Наш пароход взял на борт всех, потерпевших крушение. Манай хөлөг онгоц аюулд орсон бүх зорчигчдыг авран авч амь хоргуулав.

601. ВЗЯТЬ НА БУКСИР *кого-н.* [*разг, перен.*] Хамжилца-, хамжуу хавиргандаа ав-, хормой нөмөртөө байлга-, хаяагаа түшүүл-, нэмэр сэлбэг хий-, нөмөр нөөлгөндөө ав- Б-353

602. ВЗЯТЬ НА ВЫДЕРЖКУ номоос аль нэгий нь хэсэглэн ав-

603. ВЗЯТЬ НА КАРАНДАШ Бичи-, үсэг тави- Б-355

604. ВЗЯТЬ НА КАРАУЛ Буугаа өргөн ёслo-

605. ВЗЯТЬ НА ПРИЦЕЛ (на мушку) *кого-что* 1. Чиглүүлэ-, . . . руу онил-, шагай-, хараала-; 2. [*перен.*] . . . -ын гол барин шүүмжилэ- . . . дара- . . . хөрөөдө- Б-358

Писатель взял на прицел целую галерею типов. Зохиолч нэг л хэсэг тнймэрхүү (хэв шинжит) улсыг гол барин шүүмжилжээ.

606 ВЗЯТЬ НА ПУШКУ *кого* [*прост.*] Хуура-, мэхлэ-, молиго умхүүл-, араар нь тави-, залила- Б-359

607. ВЗЯТЬ НА СЕБЯ Б-360

608. ВЗЯТЬ НА СЕБЯ ВИД [*устар.*] Байдлыг мэдрэ-, тары нь тани-

609. ВЗЯТЬ (принять) НА СЕБЯ ТРУД Юм хийх бол-, хийх гэ- Б-362

610 ВЗЯТЬ ПОД КАРАУЛ В-614

---

* Энэ хэллэгийн утга нь Взять за горло (*кого*) гэдэг хэллэгтэй бараг адил.

611. **ВЗЯТЬ ПОД КОЗЫРЁК** (гараар) ёсло-, мэхийн ёсло-

612. **ВЗЯТЬ ПОД ОБСТРЕЛ** *кого* [*перен.*] Сүрэг чонон дунд орсон мэт, тал талаас нь дайра-, зэрэг зэрэг, зөгийн үүрэнд орсон мэт; давшил-, хошууран дайра-, хошуу билүүдэ-, ангаалан давшил-, боргоо-, ганцаар дуул-, хөхөлзүүл-, харва-, намна-, дайра-, буудa- Б-367

613. **ВЗЯТЬ ПОД (свое) КРЫЛЫШКО** Халамжлан ивээ- харж үзэ-, хормой дороо багтаа- Б-370

614. **ВЗЯТЬ ПОД СТРАЖУ** Баривчла-, барьж хори-, битүүлэ-, хар гэртээ хий-, [*устар.*] Хүйтэн гэрт хий-, нарсанд суу-, мүглэнд суу-, нар үзэхгүй бол-, гав гинжинд хата- Б-372

615. **ВЗЯТЬ (несов. брать) С БОЮ** Гуйж авахгүй гуядаж авна. Дайчлан ав-, байлдан ол-, эрээрээ ав-, эртэйдээ ол-, хар хөлсөө цувуулж хатан ясаа уярааж ол-

616. **ВЗЯТЬ СВОЕ** Эзэмдэ-, өөрийнхөөрөө болго-, хүсэл нь хана-, хүслээ ханга-, аяы нь ол-, гарын доор оруул-, аргы нь эрэ-, шавай нь хана-, дурандаа бол-, амы нь, мэдүүл-

617. **ВЗЯТЬ (свои) СЛОВА (слово) ОБРАТНО (назад)** Ам буцаүгээ буцаа-, үгэндээ эс хүрэ-, тэвчи- Б-377

618. **ВЗЯТЬ ПРИМЕР** Б-373

619. **ВЗЯТЬ СЕБЕ** *что* **ЗА ПРАВИЛО** Ёс болго- ёс шиг, албатай юм шиг, уяаны бол, (тэгдэг ингэдэг) нь ёс, . . . -даг[4] сургуультай

Надо взять себе за правило спать не меньше восьми часов Наад зах нь найман цаг унтахыг ёс болго.

Он взял себе за правило каждый раз опаздывать на службу Хэзээ цагт (ажилдаа) хожимдож ирдэг нь тэрний ёс доо (энэний ингэж хожимддог нь гэм биш зан болж дээ).

620. **ВЗЯТЬ СЕБЯ В РУКИ** Биеэ бари-, тэвчи-, амаа жимий-, чээжиндээ түймэр шатсан ч утаагаа хамраараа бүү гарга-, ямар ч юм болсон хөдөлдөггүй-, мөрөөрөө мөргөж замаараа залбира-, хүртсэн хувиа болго-, хөндлөнгийн хэрэгт хуруу дүрдэггүй, ичээндээ орсон тарвага шиг, хэлээ оглуулсан үхэр шиг, өнгөө наанаа өргөсөө цааная; биеэ дайчил-, чармай-, зүтгэ-, мэрий-, хичээ-, мачий-, өөртөйгөө зодолдо-,

621. **ВЗЯТЬ (забрать) СИЛУ** [*прост.*] Аз нь гозой-, бадра-, манда-, өөдлө-, өнгө оро-, одтой бай-, хийморьтой бай-, өөдрөг бай-,

Большую силу взял наш Семёныч, вот-вот в председатель выйдет. Манай Семёныч улам л мандаад байна, ээ дээ мөдхөн дарга болно байхаа.

622. **ВИД НА ЖИТЕЛЬСТВО** Суух бичиг, биенийн үнэмлэх

623. **ВЗЯТЬ СЛОВО** Дурааараа бол-, дур хүслээрээ бол-, сэтгэл шулууда-, үнэнээ хэлэ-, улай-, шийдэ- хуралд үг хэлэ-.

624. **ВЗЯТЬ СЛОВО** *с кого* Үгий нь ав-, өчгий нь ав-, амы нь ав- ам шавы нь ав-, ам хэлий нь ав-, юу гэдгий нь дуул-, үгий нь дуул-

625. **ВЗЯТЬ С МЕСТА** Уулыг тал болгож талыг там болго-; хүй салхи шиг, хуу татах шиг, ховх тата-

626. **ВЗЯТЬ СТОРОНУ** *кого, чью* Тал бол-, талд оро-, хоршоо бол-, нэг амь бол-, нам нэг бол-, нам нэгс-, нэг тэрэгний арал бол-, нэг тэрэгний дугуй бол-

627. **КАПЛИ (маковой росинки) В РОТ НЕ ВЗЯТЬ** Архи дарс амсдаггүй, эс амсах, архи дарс балгадаггүй, эс балгах, ам эс хүрэх, хошуу хүргэдэггүй, эс хүрэх, цээртэй, хориотой

628. **ВЗЯТЬСЯ ЗА УМ** Ухаара-, ухаан оро-, (ухааран ойлго-) тогтно-, тогто-, хүн бол-, ухаан суу-, хэрсүүжи-, наад цаадахыг ялгадаг бол-, томоожи- [*устар.*] Ухаан сийлэ-, ухаан ургуул-, бодож ол-, шийдэ-

629. **ВИД ПОКАЗАТЬ** Хүнд мэдэгдэ-

Он и виду не показал, что он недоволен Сэтгэл дундуур байгаагаа хүнд мэдэгдэхгүй л байв.

630. **ВИДАТЬ (видывать) ВИДЫ** [*разг.*] Юм үзэ-, хал үзэ-, долоохи- хал үзэж халуун чулуу долоо-, үхэж юугаа долоохоос бусдыг үзсэн, юу эс үзэх вэ, үхэхээс бусдыг үзлээ.

Да, отец видал виды Муу эцэг маань хал үзэж халуун чулуу долоосон хүн юм шүү.

631. **ВИДЕТЬ** (*буюу*) **(знать) НАСКВОЗЬ** *кого-что* [*разг.*] Нэвт харсан юмшиг, нэвт шувт хара-, хараад л мэдэ-, наад цаадахы нь мэдэ-, дотор нь орсон юм шиг П-734

Не хитри, я тебя насквозь вижу Бага шиг малла, би чамайг нэвт харж байгаа юм шиг л мэдэж байна (чамайг мэдэхгүй хэн байх юм бэ?)

632. **ВИДЕТЬ НА ТРИ** (четыре) **АРШИНА В** (под) **ЗЕМЛЮ** Онцын ялгавартай, нэвт хара-

663. **ВИДЕТЬ ТОЛК** З-344 П-735

634. **ВИДИМО-НЕВИДИМО** [*разг.*] Хумхийн тоос шиг, тоо тоомшгүй, үй түмэн, түг түмэн, өдүй төдүй, пиг дүүрэн, хүй олон, ай түмэн, шороон түмэн, эцэс төгсгөлгүй, шоргоолж шиг, ой мод шиг, хар ялаа шиг

Там видимо-невидимо народу [Некрасов] Тэнд (зээлд) хүн амьтан гэдэг хөл тавих (хийх) зайгүй.

635. **ВИДИМОЕ ДЕЛО** Мэдээжийн хэрэг, хараажаар ил юм.

636. **ВИДИТ БОГ** [*разг.*] (Юмыг лав гэдгээ хүнд батлан хэлэхэд тэнгэрээр гэрч барин зарах үг). Дээр тэнгэр доор газар байна. Худал үнэн нь хойноо хусран боос нь хавартаа, худлаа хэлэх бүдүүн зүрх над үгүй.

(Любовь Андреевна) Видит бог, я люблю родину, люблю нежно Тэнгэр мэднэ. Би эх орондоо хайртай, ер зүрхнээсээ хайртай . . .

637. **ВИДИТ ОКО ДА ЗУБ НЕЙМЁТ** Харахад ойр хазахад хол, болмоор ч юм шиг, эс болмоор ч юм шиг; хясаантай, санаа байвч соёо хүрэхгүй; санаа байвч сачий хүрэхгүй, хэлэхэд амар хийхэд хэцүү, санаанд багтавч чухам дээрээ ахдах

638. ВИДИШЬ ЛИ (видите ли) За тэр, . . . шүү, харахгүй юү, эс мэдэв үү, эс хэллүү, тэгнээ тэр, энэ чинь байна шүү дээ . . ., байз байз

Я видите ли, не знаком с ним Өө, би тэрний чинь танихгүй шүү дээ

639. ВИДНА ПТИЦА ПО ПОЛЁТУ Хүний сайныг ханилан байж мэддэг, хөлгийн сайныг унан байж мэддэг: тураг шувууг дэвэлгээр нь, туурайг хөлгийг явдлаар нь

640. ВИДНЕЕ *кому* Харваас нь, нь илхэн байна, өөрөө мэд ээ, өөрөө болгоо, нүдэн дээр, нүдний өмнө, мэдээжийн, үзгэл.

Не буду спорить-вам виднее Би юу гэх вэ, харваас танд нь билхэн байна шүү дээ.

Таково моё мнение, но дело ваше и вам виднее Миний бодлоор бол ийм л байна, өөрийн тэнь хэрэг болохоор, тааллаараа л болгоо доо

641. ВИДОМ НЕ ВИДАНО Үзэж яваагүй, хүн болсоор үзээгүй.

642. ВИЛАМИ ПО (на) ВОДЕ ПИСАНО Сэрэхгүй бол сайхан зүүд, санасны гарз, санахын гарз, санахын халцгай, усан дээр өрөм тогтоо-, үлгаа үдээрээр үдэ-, ганц ямааны сүү тогоо дүүрэх зангууны үлгэр шиг, элсэнд ус асгах мэт, зүүд зэрэглээ шиг, хөхөөг хүйдээр цохилсо гэгчээр, батганы унгас гэдэг шиг, харганын ноос, энэ насанд үгүй

643. ВИЛЯТЬ ХВОСТОМ В-527 З-101

644. ВИННЫЙ КАМЕНЬ 1. Чулуу 2. Шүдний хөгц.

645. ВИНОВАТЫЙ ВИНИТСЯ, А ПРАВЫЙ НИЧЕГО НЕ БОЙТСЯ Гэмт хүн гэлбэлзэнэ, үнэнээр явбал үхэр тэрэг тууладаг гүйцнэ.

646. ВИНТИКА (клепок) НЕ ХВАТАЕТ (недостаёт) [*разг*] Доингно, дүйнгэ, ороотой гараатай юм шиг, зүүлэг, маанаг, маягуу, мунгинуу, орон гаран зөнөсөн

647. ВИСЕТЬ (повисать) В ВОЗДУХЕ [*перен.*] 1. Алцан цойцон сананаанас цаашгүй, зөөр хөвсөн нохой шиг, олон санаат оргож чаддаггүй/, (олон санаа санасан хүн оргож чаддаггүй), бодохоос цаашгүй аль нь ч үгүй, аль ч учраа олохгүй, бөл цөлгэй, 2. Дутуу алсан могой шиг, талаар бол-, алцагчин балцагчин бол-

Все это дело с самого начала уже висело в воздухе Анхнаасаа л үйлс хазайна гэгч болоод байсан юм (Энэ ч анхнаасаа л нэг мордохын хазгай гэгч болоод байсан юм).

648. ВИСЕТЬ НА (держаться) ВОЛОСКЕ (на ниточке) [*прост.*] Дэн дүн дээсэн дөрвөн дээр, хутганы нр дээр, тэгэх нигэхийн даваан дээр, арай чамай л гэж дөнгөн данган, дөнгөн ядан, өл залган, амьтай голтой, хоногоо хүлээсэн. П-378

649. ВИСЕТЬ НА НОГАХ у *кого-чего* Хойш татаж хормойноос нь чангаа-, сүүлдэ-, ажлыг садаа, ажил чагтла-, хойш суу-, ажлын тээг, бул чулуу шиг, ажил чөдөрлө-

650. ВИСЕТЬ НА НОСУ *у кого* [*прост.*] В-656

651. ВИСЕТЬ НА ПЛЕЧАХ *у кого* [*прост.*] Халуун мөрөөр нь оро-, мөрий нь мөшгө-, мөшгө-, сүүл дара- П-696

652. ВИСЕТЬ НА ТЕЛЕФОНЕ Утсаар ярих гэж жил бол-, утаснаас салахаа бай-, утсаар аргамжи-, утаснаас салах заяагүй

653. ВИСЕТЬ НА УХЕ (ушке) *у кого* [*устар.*] Шивэгнэ-, чихэнд нь наалда-, хүзүү толгой нь салахаа бай-

654. ВИСЕТЬ НА ХВОСТЕ *у кого* [*прост.*] Дээрээс нь оро-, хуримын дээр буу-, болзсон юм шиг учра-, хэлцээтэй юм шиг

655. ВИСЕТЬ НА ШЕЕ *у кого* [*разг.*] Толгой холбо-, салахаа бай-, үнсэж үнгэлэ-, үнсэлцэж үнгэлдээд салахаа бай-, салж чадахаа боли-, хөл хэрээтэй хүзүү холбоотой, шар цавуу-гаар наасан юм шиг шалзан хадаасаар хадсан юм шиг, тэднийхээс салахаа байжээ. П-379

656. ВИСЕТЬ НАД ГОЛОВОЙ 1. Мөдхөн одоохон. 2. Багалзуур дээр ирээд бай-, аман хүзүү сээр хоёр нийлэх гээд бай-, боож үхэх гээд бай-

657. ВИСЕТЬ НАД *чьей* **ДУШОЙ** Сэтгэлийн зовлон, сэтгэлийн тээг, сэтгэлээс гарахгүй; толгойд тог, дотор яг; цээжний мах идэ-, өдрийн бодол шөнийн зүүд, сэтгэлийн уяа бол

658. ВИТАТЬ В ВОЗДУХЕ (облаках) [*разг.,ирон*] Санаа нь дэлхий, сачий нь мэлхий; санаа нь шамбалд, бодол нь тэнгэрт гара-, хадуура,- мэндгүй зөрө-, солиотой юм шиг, үлгэр шиг л юм яри-, санах нь сарнаар, явах нь нарнаар

659. ВИТАТЬ (парить) В ОБЛАКАХ (в эмпиреях, между небом и землей) Бодлого бишдүүрэл бол-, дүнсий-, алсын уулын толгой хара- П-27

660. ВКОЛОТИТЬ В ГОЛОВУ *кому* (*прост.*) Чадан ядан ухааруул-, сая л захаас нь гэгэ-

661. ВКОЛОТИТЬ В ГРОБ [*прост.*] Махла-, тамла-, үйлий нь үзэ-, цусгүй ал-, сүнсгүй ал-, тамла-, махла-, тарчилга-, махы нь ид, цусы нь уу, тамы нь цайлга, амьдаар нь ал-

662. ВКОЛОТИТЬ СЕБЕ В ГОЛОВУ [*прост.*] албаар (тэгэж нигэж) бодо-, лав бодо-, чанга бодо-, хэргээр бодо-, тэгэхээс тэгэх гэ-, харын албаар бодо-, шаалтаар бодо-, хар хүчээр, хар гүжрээр

Она вколотила себе в голову, что не сможет прожить самостоятельно. Толгойгоо даан аж төрж барахгүй нь ээ гэдэг чанга бодол төрөв.

663. ВКОСЬ И ВПРЯМЬ 1. Элдвээр, элдэвлэн, янз янзаар, нигэж чигэж 2. Буруу гажуу, олну солиу; 3. В-665

664. ВКРИВЬ И ВКОСЬ Муруй саруй, гуйван дайван, санжиганан, цунжиганан; ундуй сундуй; шудрагагүй, гүйвуулах, мушгих, дигэстэйхэн, хамаа намаагүй, хайш яйш, тэмээ туйлчихсан юм шиг, ганхаж гунхан, тогтож ядан, улаан амлах, улаан чулуу мах гэх, цагаан чулуу өөх гэх

Чужих и вкривь и вкось не рубит-вот я за что его люблю (Грибоедов) Хүн рүү хамаа намаагүй дайрч давшилдаггүйд нь л би түүнд сайн байдаг юм.

665. **ВКРИВЬ И ВПРЯМЬ** ийшээ тийшээ, хөндлөн гулд, хойш урагшаа, муриг сариг, В-663

666. **ВКУСИТЬ ОТ ДРЕВА ПОЗНАНИЯ ДОБРА И ЗЛА** (Христосын библи хэмээх их хөлгөн судраас гаралтай үг) Зовол жаргал андахгүй, зовлон жаргал мэдэ-, сайн муу юм их мэддэг, магтаал муушаал хоёрыг зэрэг даа- (жаргал зовлон хоёрын амтыг тэгш даа-),

667. **ВКУШАТЬ ОТ ПИЩИ СВЯТОГО** Өлсөж зүдрэ-, өтгөн шүлсээрээ хоол хийж шингэн шүлсээрээ унд хий-

668. **ВКУШАТЬ ПЛОДЫ** Үрий нь амса-, идий нь хий-, идий- нь гарга-, хэрэг нь бүтэ-, явсан нохой яс зуу- зовсон сүүгээ хөхө- П-571

669. **ВЛАДЕТЬ ПЕРОМ** Бичигт сайн (сүрхий), бичигтэй бичээч хүн, эх сайн зохиодог, юм сүрхий бичдэг хүн

670. **ВЛАДЕТЬ СЛОВОМ (даром слова)** Хэлэмгий шаламгай, хэлэмгий үлэмгий, цэцэн цэлмэг, бэлэн үгтэй, ус цас шиг, урсгаж алддаг Д-57

671. **ВЛАДЕТЬ СОБОЙ (своими чувствами)** Биеэ бари-, сэтгэлээ тогтоо-, тэвчиж чада-, хүлээцтэй байж сур-, хүлцэж сура-

Каждый должен научиться владеть собой Хүн ер нь ямарч юманд биеэ барьж (хүлээцтэй байж) сурууштай

672. **ВЛАСТИТЕЛЬ ДУМ** *кого* Төрийн аав.

673. **ВЛАЧИТЬ ЖАЛКОЕ СУЩЕСТВОВАНИЕ** [*книжн*] Хоног төөрүүлэх, өлөн зөмөг хоолтой, хоёр идэлгүй хоосон хонолгүй; хөөрхийлэлтэй амь зуу-, ядаж зүдэж аж төрө-, амь зуухчаан бол-, өтгөн шүлсээрээ хоол хийж, шингэн шүлсээрээ унд хий-, гаднаа нэр тэмцэвч дотноо амь тэмцэ-, арван хурууныхаа арыг барж таван хурууныхаа тарыг барж; хар хөлсөө цувуулж хатан ясаа уяраа-

674. **ВЛЕЗАТЬ В ДОВЕРИЕ** В-1051

675. **ВЛЕЗТЬ (залезать, входить) В ДОЛГИ** [*прост*] Өр үстэй толгойноос их, хойт насандаа хагасы нь төлөхөөр өртсөн, өрөнд баригдаж өтөнд идүүлсэн, өрний тулам бол-,

Он по уши влез в долги. Өрөн дооросоо босохоо болив.

676. **ВЛЕЗТЬ В ДУШУ** З-201

677. **ВЛЕЗТЬ В ЧУЖОЙ КАРМАН** [*прост*] Завши-, илүү хара-, илүү харж билүү долоо-, юманд өнгөлзө-, хүний юманд тачаасүүнд нь хуруу дүрж сүрэгт нь уурга бари-, эд юманд нь хурица-, чи хоёр ёотонтой, би хоёрхон ёотонтой гэгч; айлын хоол нь амттай, авгай нь хүртэл дагина шиг;

678. **ВЛЕЗТЬ В ШКУРУ** (*кому*) Оронд нь оро-, оронд нь суу-, ширээгий нь эзлэ-, олбогий нь эзлэ-

679. **ВЛЕПИТЬ ГОРЯЧИХ** В-1031

680. **ВЛЕПИТЬ ПОЩЁЧИНУ** *кому* [*разг вульг*] Таван салаа боов өг-, алгада-, жавтий хүртээ-, алганы амт үзүүл-

Говорят, что вчера в театре она влепила кому—то пошёчину Өчигдөр өнөөх төнь жүжгийн хүрээлэнд нэг хүнд таван салаа боов өгсөн гэнэ.

681. **ВЛЕТЕЛО (вскочить, обойтись, стать) В КОПЕЙКУ** Ус цас шиг зара-, мөнгө уу-, их мөнгө бүрэлгэ-, бэл алда-, мөнгөө үрж гүйцэ-, хогоо гүвэ-, шүүр шанага шиг гоожуул-, өврөө хоосло-

682. **ВЛЕТЕТЬ БОМБОЙ** *бүюу* **КАК БОМБА** [*разг*] Хүүе хааяыг мэдэхгүй орж ирэ-, уухирдан орж ирэ-, ум хумгүй гүйж оро-, (шурга-), хоёр нүд нь орой дээрээ гарчихсан орж ирэ-, сандан мэндэн

С этой новостью он бомбой (как бомба) влетел к нам в комнату Энэ мэдээг дуулгах гэж манай өрөө рүү ухаан жолоогүй гүйж орж ирэв.

683. **ВЛЕТЕТЬ В ИСТОРИЮ** [*прост*] Төвөг уда-, хэцүү юмтайгаа учра-, бойтогло-, үйлээ үзэ-, хөглө-, яаж үхдэг билээ, даахгүй хоол байна даа, давдаггүй даваагаараа оро-, гайтай юмтайгаа учра-

684. **ВЛЕЧЬ** (сов повлечь) **ЗА СОБОЙ** *что* 1. татагда-, тата-, хорхойтс-, хорхой аса-, арааны шүлс асгаруул-, нүд хужирла-

Его влечёт к искусству Ур урлалын юманд хорхой нь асаж байна.

2. Уршиг болох, үйлийнхээ үрийг эдлэх, тэгвэл тэгэлгүй яах вэ, нүгэл нь нүдээрээ гарах

Преступление влечёт за собой наказание Гэмт хэрэг хийвэл ял янханд ордог (хэрэг хийвэл ялтай). П-380

685. **ВЛОЖИТЬ В УСТА** *чьи что* Хүнээр хэлүүл-, хүний амаар хэлүүл-, дам хэлүүл-, буєдын амаар будаа идэ-, хүний гараар могой бари-

Автор вложил в уста героя свои заветные мысли Зохиогч санаж явдаг санаагаа баатрынхаа амаар хэлүүлжээ.

686. **ВЛОЖИТЬ ДУШУ** (жизнь, сердце) *во что* Хамаг (байдаг чадлаа гарга-

687. **ВЛОМИТЬСЯ В АМБИЦИЮ** [*разг*] Шар нь гозой-, хорсон уурлазэвүүцэн уурла-, эгдүү нь хөдөл-, дайран дээр нь давс хийсэн юм шиг бол-, уур нь шата-, уур нь улаан галзуу, их гомдох гомдоо-, ямаан омог нь хөдлө-, хор нь буцал-, шар нь хөөрө- В-1061, У-48

Вломиться в амбицию-легко, а признать свои недостатки трудно Шил татаж уурлах цөхөлтгүй шинж гэмээ мэдэх амаргүй.

688. **ВЛОСК ПЬЯНЫЙ** [*прост. фам*] Шал согтуу, ногоортол согтох мал болтол согтох, ухаангүй согтуу, нохойд амаа долоолгох; нохой гурав харагдтал уух; савнаасаа хэтэртэл балгах; хөл нь дэлхийг онохгүй хэл нь тагнай онохгүй

689. **ВЛЮБЛЁН В СЕБЯ** [*ирон*] Биеэ гоодох, өөгүй.

690. **ВЛЮБЛЁН ПО УШИ** (*пренебр*) (Нэг юмтай толгой холбох, хошуу холбох, бие биенээн барьж, идчихээ шахах, нэг нэгнийгээ долоочихоон алдах, хагацаж чадахаа больчих, салж ядах;

691. **ВМЕСТЕ ВЗЯТЫЕ** . . . , . . . нийтдээ, дүндээн нийлээд, хам хамдаан, базаараа, явж явж яваандаа, алсаараа, хэтээрээ, тэгэж тэгэж, бөгсөндөө, эцэнийн бөлөгт

692. **ВМЕСТЕ С ТЕМ** . . . аад тэгээд түүнчлэн тэрчлэн улмаар, цаашилбал, мөн нөгөөтэйгүүр,

Мы утвердили план и вместе с тем распределили наши нагрузки Төлөвлөгөөгөө батлаад ноогдлоо хуваав

693. **ВМЕСТЕ ТЕСНО А ВРОЗЬ СКУЧНО** (үхэр) ойр байвал мөргөлддөг, хол байвал мөөрөлддөг, ах дүүгийн хол, аргал усны ойр; ураг төрлийн хол нь, үл усны ойр нь дээр

694. **ВНЕ ВРЕМЕНИ И ПРОСТРАНСТВА** Тэр гэх тэмдэггүй хийморь лүндаа нь ухсэн, тамтагтүй эзнээ алдсан элий балай, өөдгүй, учраа элдсэн, пай нь тасчсан, гоч нь барагдсан (тасарсан) тэнгэр нь хаясан (арилсан), өөдөө барж өмдөндөө шээс алдсан; унтарсан галд урнагүй, үйлс нь цайсан; яадгаа алдах; үхэр долоож үнэг шинших юмгүй, тартаг нь цайх, тартагтаа тулсан; шагтаа тулсан,

Он прожил жизнь свою вне времени и пространства Унтарсан галд урнагүй гэгчийн амь зуулгатай явлаа (Яахаа алдсан амь зуулгатай явлаа).

695. **ВНЕ** (всякого) **СОМНЕНИЯ** лав, магад, гарцаагүй тов, товтой

Вне всякого сомнения мы закончим нашу работу к сроку Бид нар ажлаа лав хугацаанд нь дуусгана (Бидний ажил лав хугацаандаа дуусах бий).

696. **ВНЕ ЗАКОНА** [*сфиц прав*] Хуулиар хамгаалагдаагүй, хуулийн зүгээс эс хамгаалах, төр хуулийн соёрхол үл эдлэх; цагаадах заяагүй, өршөөл үзэхгүй, хэлтрэх заяагүй, хатуу гараар орох,

Объявить кого-нибудь вне закона. хуулиар хамгаалахгүйг зарла- (зар тараа).

В июле 1794 г. Робеспьер и все его сторонники были объявлены вне закона. Аргын мянга есөн зуун ерэн дөрөвдүгээр оны долдугаар сард, Робеспьер болон түүн лүгээ нам шийдэгчдийг хуулийн зүгээс эс хамгаална хэмээн олноо зар тараав.

697. **ВНЕ КОНКУРЕНЦИИ** (конкурса) [*разг*] Сонголгогүй, сонсон шалгахад хамаагүй, дархан, (бөх дээр бол) босоо; дагуулахгүй хавьгүй эгнэшгүй, үлишгүй үлэргүй; гаргуутай

Товар вне конкуренции Шилмэл бараа, эд шүүлэггүй бараа; үлгэргүй бараа; хосгүй эд, эдийн сор, эдийн дээд

698. **ВНЕ ОЧЕРЕДИ** Эелжит бус, чамд хамаагүй, хаданд чимээгүй, чамайг хүргэл ярнагүй хаяа хүртэл жийгээгүй. Хөндлөнгөөс хөгнөө; чамд надгүй, чамаар дутаагүй; дуртай хүшуу вэ? ямар урт хүшуу вэ? Илүү хүшуутай амьтан бэ? хувиа хичээвэл бэртэ; биеэ хичээ; хүнд заах гайгүй;

699. **ВНЕ СЕБЯ** (сэтгэл их хөөрч хөдөлснөөс) жигтэй болох, тэнхээ алдах, учраа алдах, байж ядах, их хөөрөх хөлөө хугалчих шахах, нисэхээ шахах, нар нь гарах

Дети были в не себя от радости. Багацуул баярлаад хөл нь газар хүрэхгүй байцгаав.

700. **ВНОСИТЬ СВОЙ ВКЛАД** (**вносить свою лепту**) Хувиа оруул-, нэмэр хандив бол-, хуруу нэмэ- П-1032

701. **ВНОВЬ ИСПЕЧЁННЫЙ** [*разг., шутл*] *Заримдаан* [*ирон*] Шал хүүхдээрээ, хар нялхаараа, амны салай арилаагүй хүүхэд, онхи нь томоожоогүй; сая унасан нойтон нишиг, юм үзээгүй бага хүн, гэнэн цагаанаараа; бурхан гэсэн үг; гэнэн хонгор нас, хүний үгний учрыг олох болоогүй нялх амьтан; нялх нялзрай; зулай нь битүүрээгүй; гал руу ч орчихож мэдэх; яавал яадаг дээрээ; хэрсүүжээгүй, муу санаа суугаагүй; дол цохиогүй; хал үзээгүй; зүггүй;

702. **ВНУШАТЬ СЕБЕ** Өөртөө товло-, лавлан бодож ав-, итгэмжилэ-, цээжний хонжоо; үхтлээ үнэмшин-, ягштал итгэ-, үхэн хатан итгэ-; эргэлтгүй бодо-, наана цана бодохгүй; үхширтлээ итгэ-.

703. **ВО ВЕКИ ВЕКОВ** [*устар. книжн.*] Үеийн үед үрийн үрд хэзээ ямагт, үүрд, эгүүрид, ашид, эгнэгт, мөнхөд, насандаа, өнө мөнх, өнө үүрд;

Да живёт во веки веков память об этих людях (Фадеев, Молодая гвардия, ч. 1 гл. 3) Энэ хүмүүсийг үрийн үрд дурсана.

704. **ВО ВЕСЬ** (**вполный**) **ГОЛОС** (**кричать, вопить, петь и. т. п.**) 1. Дүлий хүн байгаа юм шиг; 2. хоолойгоо сөөтөл, хошногоо түмбийтэл; хоолой мэдэн (хашгира-,), би л ийм дуутай гэсэн шиг, чанга (бахира-), чарла-; хангинатал (дуул-,) нижигнүүлэ-, цангинуул-, орило-, бахира-, багалзуурда-, багалзуураа хөөлгө-, орь дуу тави-

705. **ВО ВЕСЬ ДУХ** (*мах, опор*) [*разг*] Хар гүйхээр нь, хар эрчээрээ нь; Байдаг чадлаар нь . . . Хар хурдаараа гүйх, хөл мэдэн, сарвайтал давхих, ухаан жолоогүй давхих, тоостой нь хуйлах, ухасхийн, парадхийн, ум хумгүй давхих, жолоо хумхилгүй, амьгүй нь таталгүй; хурдны морь шиг; уяа нь таарсан морь шиг; тоос татуулах, тоос нь гозойх, усан хулгана болтлоо; нисэх мэт; дүүлэх мэт; жигүүргэй мэт; шувуу шиг;

Несётся в гору во весь дух (Пушкин) Уул өөд ухасхийн гарав.

706. **ВО ВЕСЬ МАХ** В-731

707. **ВО ВЕСЬ ОПОР** (**скакать, мчаться, нестит, лететь**) **В—705**

708. **ВО ВЕСЬ РОСТ** 1. Бов босоо, цэвцэгц, мод шиг гозойх тэхийтэл босох, бие цэх болох, данагар сайхан (зогсох) цондог шиг анайтал; зандан мод шиг; уулын согоо шиг; шилийн мод шиг; хярын овоо шиг; ширээ ат шиг; 2. [*перен*] байдгаараа юутай хээтэйгээ, бишгүй нэг чинээнд нь тулгал, тэнгэр бөганадтал

Во весь рост встали новые важные проблемы. Шинэ шинэ чухал хэрэг явдал бишгүй л нэг гарч ирж байна даа.

Он встал во весь рост Босоод сайхан зогсов.

709. ВО ВЕСЬ РОТ (*орать*) Ам мэдэн (хашгирах, бахирах) багалзууpаа хөөтөл бархирах, хоолойгоо сөөтөл бархирах.. багалзууpаа тасартал;

710. ВО ВКУСЕ .. ны маягаар, . . . ны маягтай, . . . маягийн . . . рхуу (тийм ийм) барилтай, барилаар ийм жишээтэй, ийм янзаар, энүүнрэхүү;

711. ВО ВЛАСТИ 1. *чего* . . . ын гарт, эрхэнд; эрхээр, . . . ын эрхэнд болж.

Во власти страстей Тачаангуйн эрхээр, 2. *чьей* чадахтай, эрхтэй, дийлэх, давах мэдэлтэй, санааны, дурны, боломжоот,

712. ВО ВРЕМЯ ОНО буюу **ВО ВРЕМЕНА ОНЫ** *буюу* ВО ДНИ ОНЫ [*перен. разг.*] Элэн галавын, аль нас, аль дивангарын, үхсэн хатсаны, эрт балрын, балрын, аль дээр үеийн, аль хэзээний, урьд төрлийн шахам; элэнц хуланцын В-738

Я говорю так было прежде во время оно и со мной (Пушкин) Айн гэж бай, Би ч хэзээний л тийм байсан юм. Дуулвал дуул л даа. Би ч хэзээ ёзооны л тийм байсан юм гэдгээ хэлчихье.

713. ВО ВСЕ ГЛАЗА (смотреть, глядеть) [*разг*] Нүдээ орой дээрээ гаргаад (хара-,) нүдээ том гэгч нь болгоод, нүдээ бүлтийтэл, нүд ам нь орой дээрээ гараад

714. ВО ВСЁ ГОРЛО [*разг*] хоолой мэдэн (хашгира-, бахира-багалзуурда-, тэнхээгээрээ хашгира-, байдаг хоолойгоороо, байдаг дуугаараа;

715. ВО ВСЕ ЛОПАТКИ БЕЖАТЬ (удирать, гнать) [*разг. фам.*] Хааны морьд үзэгдэв үү гэдэг шиг хурдлах, хоёр зээрдээ хорстол, туламтай элсээ хагалсан мэт; ухаан жолоогүй, хатиртай харын хурдаар; хар хурдаараа, хөл мэдэн, аахи уухи, хурдаа гарга-, хөлөө нэг гарга-, хөлийнхөө шандсыг үзүүл-, маахайгаа эргэтэл; хөлөө гуйвтал; хөлөө сульдтал;

Слушайте: Вы побегите, да бегом во все лопатки, и снесите две записки (Гоголь). За та айн гээд уун гэж бай: За харин нэг гүйж алдана да, хөлийнхөө шандсыг үзүүлээд, энэ хоёр зурвасыг хүргэж өг.

716. ВО ВСЕ НОГИ Хар хурдаараа, сунан сарвайн, ум хумгүй, хөл мэдэн

Заяц . . . поняв опасность приложил уши и понёсся во все ноги (Л. Толстой, Война и мир) Туулай . . . чимээ авуут (ажиг сэжиг цохиут) чихээ хулмайлгасnаа дэгдэн дүүлэв.

717. ВО ВСЕ УШИ СЛЫШАТЬ [*разг*] Чих тавин сонс-, (амаа) ангайн сонс-, байдаг чихээрээ дуул-, чих дэлбийлгэн сонсо-,

718. ВО ВСЕЙ НАГОТЕ Гууль (зэс) нь цухуйх мөс (яс, тар) нь танигдах, ваадан нь задрах, байдгаа дэлгэх, [*Ирон*] Хөөрхнөө үзүүлэн (харуулан), муугаа хаяалах; сайхнаа үзүүлэх; шившгээ хутгах, хөгөө тарих, мундраа дэлгэх, чанар нь танигдах, жудаг нь танигдах, муугаа гаргах, гуулиа цухуйлгах

719. ВО ВСЕЙ СВОЕЙ КРАСЕ 1) Ястайгаа үзүүлэ-, шил заа-, яс заа эр заа-, чадал заа-, эрээ гарга-, 2. [*перен. ирон.*] Гууль (зэс) цухуйлга-, судсаа атгуула-, тараа таниула-,

720. ВО ВСЕЙ ФОРМЕ 1. Ёсоороо, зүй зохисоороо, 2. Ёстой жинхэнэ, үнэн

721. ВО ВСЁМ БЛЕСКЕ Цог жавхаа, цог заль сүр жавхланг (бадруула-,) хийморь лүндаа; цог золбоо; цовоо цоргиун

Наши войска показали себя во всём блеске мужества и патриотизма. Манай цэрэг эр зоригт эх орончийнхоо цог жавхааг бадруулав.

722. ВО ВСЕМ *буюу* **ВО ВСЕХ ОТНОШЕНИЯХ** Алинаараа ч, юугаараа ч, хаанаас нь ч аваад үзсэн.

Дело выгодное во всех отношениях. Энэ ч чухам алиугаараа ч л эрхэм шүү.

723. ВО ВСЁМ РАЗГАРЕ В-297

Хлебная уборка во всём разгаре. Тариа будаа хураах ажил ид дундаа байна.

724. ВО ВСЕ ОРУЖИИ *чего* өвч бүрэн, бүрэн зэмсэгтэй өвч зэвсэглэсэн, хуяг дуулгаа өмсч хурц зэвсгээ агссан, илд жадаа агссан; бүрэн зэвсгээ агссан;

725. ВО ВСЕ ОРУЖИИ ЗНАНИЙ Номоор цээжээ хавтасласан эрдмээр бие чимсэн, номын хураар ундаалсан, Билгийн далай цалгиулсан, эрдмийн мөрөн бялхуулсан, уудам мэдлэгтэй, эрдэм төгс

726. ВО ВСЕ УСЛЫШАНИЕ Хаа ч дуулдахаар, чанга, чих дөжрөм, чихний хэнгэрэг хагарам, өндөр дуугаар, газрын хаанаас дуулдахаар;

Объявить во все услышание. Өндөр дуугаар зарлан дууда-, (Нэгэн амаар) мянган сонорт дэвшүүлэн айлтга-; содон цээл хоолойгоор сонор мялаан айлтга-;

727. ВО ВСЕХ КОНЦАХ Газар бүрт, хаа хаагүй, зах хязгааргүй, газар сайгүй, энд тэндгүй, нутаг нуга болгонд, аймаг хошуу бүрд; дөрвөн зүг найман зовхист, хаяагүй, хотол даяар, улс хотлоор, дая олноор;

728. ВО ВСЮ [*прост*] Байдгаараа, байдаг (хүч) чадлаараа, тэнхээ мэдэн, хүчээ шавхан, бааш бодолгүй үнэн санаанаасаа, чадах чинээгээрээ, аль байдгаараа амь хайргүй, бие хайргүй;

Бежить во всю. Тэнхээ мэдэн харайлга-, хурда үзэжийгүүл-, тэмүүл-, довтолго-, буухиала-, галтай нь буулга-, шуурга шиг-, салхи шиг;

729. ВО ВСЮ ГЛОТКУ Хоолой мэдэн; байдаг хоолойгоороо

730. **ВО ВСЮ ИВАНОВСКУЮ** [*разг. фам.*] Чанга дуутай, тархи толгой хагачнчих гэсэн, чих дөжгөм, нэг дуу газарт нэг дуу тэнгэрт, чих дүлийрэм

Кричать во всю ивановскую Чих дөжиртөл бахира-
Храпеть во всю ивановскую Хамраа сэтэртэл хурхира-, нэхий хэдрэгдэ-, арьс элдэ-, давсанд ява-, манжаа чана-, паржигнуул-, ээзгий бүцалга-, дүнгэнэтэл хурхира-, тэнгэр дуугарга-, ган хайпаг мөөрө-,

731. **ВО ВСЮ ПРЫТЬ** (*бежать*) [*разг.*] Ухаан жолоогүй харайлга-, ум хумгүй давхи-, юманд хөөгдсөн юм шиг чононд хөөлгөсөн юм шиг; хүйхүүн дүрвээн шиг, хүйхүй-д хөөгдсөн юм шиг газар товчлон ганийх; түймэрт хөөгдсөн мэт, хүй салхи мэт; В-706

732. **ВО ВСЮ СИЛУ** (**мочь**) байдаг хүчээрээ, бүх хүчээрээ, хамаг тэнхээгээрээ

733. **ВО ВСЮ ШИРЬ** Элчилгүй, цараа ихтэй, цэлгэр уужим, энгүй их, нүд алдам

734. **ВО ВСЯКОЙ ЗЕМЛЕ СВОЙ ОБЫЧАИ** Газар газрын зан (заншил) гүзээ гүзээний булан, газар газрын хэрээний, га-га-га-га гэх нь ондоо; айл нутгийн ая зан ондоо; ой мод урттай богинотой олон хүн сайхтай муутай.

735 **ВО ВСЯКОМ СЛУЧАЕ** Юу ч болсон, ямарч гэсэн, яадаг ч болтугай, ер нь л, яах ч атугай, яалаа ч гэсэн;

736. **ВО ГЛАВЕ 1** *с кем* Удирдан, уруу татан, магнай нь, манлай, магнайн түрүү:, . . . толгойлон, тэргүүлэн; . . . тэргүүтэй, . . . хошуучлан, . . . түүшийн түрүү түнхэрцгийн ам 2. *чего* түрүүнд нь, эхэнд нь голлон, магнайлан

737. **ВО ГЛАВУ УГЛА СТАВИТЬ** *что* Гол болгон, гол хийн, чухаг хэмээн, хүндэд үзэн, онцлон тусгайлан

738. **ВО ДНИ ОНЫ** В-712

739. **ВО ИЗБЕЖАНИЕ** *чего* (Тэгэх ингэх) бий гэж, тэгүүзэй нигүүзэй хэмээн, . . . гүйсэн гэж, . . . нийн тул, . . . ний учир, бүү . . . сэй гэж, амаа барих юм хийгүүжин гэж,

Во избежание неприятностей Эвгүй юм болох бий гэж (эвгүй юм гаргачихгүйсэн гэхдээ.)
Во избежание ошибок Алдаа алдуузай хэмээн . . . алдах бий гэж, буруудав, (андуурав) омтгойдов (үүзай, хэмээн
Во избежание недоразумений Андуурах бий гэж андуруузай хэмээн, бүү эндүүрээсэй гэж.

740. **ВО ИМЯ** *кого чего* [*книжн*] . . . ын төлөө, . . . тулд

Мы не щадим сил во имя победы. Ялаалтын төлөө бид хүч хайрлахгүй.
Во имя славы Родины Эх орны алдрын төлөө (улс гэрийн нэр төрийн тул)
Во имя дружбы. Найрамдлын төлөө (эв найртай байхын учир)

741. **ВО МРАКЕ НЕИЗВЕСТНОСТИ** Таг, таг чиг, хүн мэдэхгүй, чих чимээгүй, сураг ажиггүй арилсан юм шиг, газар дор орсон юм шиг

742. **ВО ПЛОТИ** [*устар.*] Хувилгаан, хувилгаан дүр, . . . ны хойтохи, . . . ны урдахи,

743. **ВО СЛЕД (В СЛЕД)** Дагах, сүүл дарах, мөр хөөх, сүүдэр шиг дагах, салахгүй

744. **ВО ХМЕЛЮ** согтуудаа, юм уухаараа, халахаараа

Он буен во хмелю Согтохоороо агсан шүү.

745. **ВО ЦВЕТЕ** *чего* Ид дундаа, гал дөл шиг нас; орь залуу нас, цэцэг цэврүү шиг нас; галтай цогтой, юунаас ч харьдаггүй нас, идрийн цог бүрдсэн;

Во цвете лет Орь залуугийн цог бадарсан (идрийн гал бадарсан) цэцэг цэврүү шиг нас; идэр залуу настай исгэлэн халуун бистэй.
Во цвете юности живой. Идэр залуу настай исгэлэн халуун бистэй наг

746. **ВО ЧРЕВЕ МАТЕРИ** Эхийн гэдсэнд явахад, эхийн умайд байхад, гэдсэнд байх,

747. **ВО ЧТО БЫ то НИ СТАЛО** [*разг.*] Юу ч болсон, яадаг ч атугай, уйлсан ч дуулсан ч; . . . үгүй бол болохгүй (горьгүй) эрхбиш

Во что бы то ни стало надо выполнить план. Төлөвлөгөөгөө л биелүүлэхгүй бол горьгүй.
Во что бы то ни стала, добьюсь своего! Юу ч л болтугай Зорьсондоо хүрье!

748. **ВОГНАТЬ (загнать) В ГРОБ** [*прост.*] Тарчилга-, махы нь идэ-, уйлнй нь үзэ-, тамын түлш болго-, тамын төхөөрөө болго-, В-500

748. б **ВОГНАТЬ (ввести) В КРАСКУ** *кого* Нүүрий нь түлэ-, бажигадуул-, нүүр хийх газар олдохгүй бол-

749. **ВОГНАТЬ В ПОТ** *кого-что чем* [*разг. фам.*] Уйлий нь үзэ-, махы нь зулгаа-, тамы нь цайлга-, хөлс баасы нь гоожуул-, сүнс сүлдгүй болтол нь, шар маханд нь түлтал

Профессор химии на экзамене вогнал в пот всех студентов своими вопросами. Хувилахуй ухааны профессорын шалгалтын асуулт бүх сюутны хөлс баасы нь гоожуулсан (шавхсан)

750. **ВОЕННАЯ КОСТОЧКА** [*разг.*] Чухам цэргийн хүн, ёстой цэргийн хүн, ясны цэргийн эр, цаанаа нэг цэргийн хүн, хэзээ язааны цэрэг хүн, хашир цэргийн хүн, хуучин бууны хугархай.

751. **ВОДИТЬ ЗА НОС** *кого-что* [*разг.*] Сүрхий малла-, эвтэйхэн малла-, хуурч, мэхлэж сурсан, сайхан шиг хуура; араар нь тавьж сур-, молиго үмхүүл-,

752. **ВОДИТЬ КОМПАНИЮ** *с кем* Ханила-, үерхэ-, нөхөрлөнийлэ-, найзла-, ирж очи-, ганзага нийлэ-, онь холбо-, хоёр биендээ дэнлүү бол-, андалда-, түнш бол-,

753. **ВОДИТЬ НА ПОМОЧАХ** *кого* [*перен. разг.*] (Хэн хүний) татаж түлхэж ява-, эрхий барьдаг хүн, хажуу сувээндээ авч ява-,

754. **ВОДИТЬ НОСОМ** [*разг.*] 1. (Ном) их ойрхон шагайж үзэ- 2. Үзэн яда-,

755. **ВОДИТЬ ХЛЕБ-СОЛЬ** Х-27

756. **ВОДОЙ НЕ РАЗОЛЬЁШЬ кого-н** [*разг.*] Зүүний үзүүр орохгүй; нэг дээлтэй нэг морьтой, үй зайгүй үерхэх: өвөр түрүйндээ орж явах; миний чинийгүй, үүд хойморгүй, ижий ахай, холбоотой юм шиг, салдаггүй. Үхрийн бөөр шиг, эмээлийн бүүрэг шиг; Буйл шүд шиг, өргөс цоож шиг;

Такая дружба у них, что водой не разольёшь. Тэд нар ч үй зайгүй үерхдэг улсаа.

754. **ВОДУ ТОЛОЧЬ -ВОДА И БУДЕТ** үргүй юмаар үйлээ бараселонго хөө-

758. **ВОДЫ (водой) НЕ ЗАМУТИТ** [*разг.*] Хэвтээ хонь босгохгүй (үргээхгүй) (хүн), нуур намаг шиг (хүн, хүүхэд,) эвийн цавуу шиг (хүн, хүүхэд)

Два брата совсем не были похожи: старший-воды не замутит, а младший отличался своим бойким характером. Нэг эхээс унасан ах дүү хоёр гэхэд ах нь нуур намаг шиг, дүү нь дарь шиг (савдаг элээ шиг) амьтан юм.

759. **ВОДЫ УТЕКЛО (много, немало, сколько и. т. п)** Он уджээ, хуучны юм болж дээ, .. .аас хойш удаж шүү. Аль дивангарын юм болж, их уджээ, аль насны юм бэ дээ.

Много воды утекло с тех пор, как мы расстались. Тээр нэг жил уулзсанаас хойш ч он уджээ удаж.

760. **ВОЖЖА ПОД ХВОСТ ПОПАЛА** [*вульг. разг.*] Дороос нь ноцсон юм шиг; жигшүүхсэн морь шиг юм хатгасан юм шиг, гал дээр гишгэсэн юм шиг (огло үсчих, уурлаж уймрах, тэвдэх) галзуурахад ганц хуруу дутуу байх, адгаж гүйцэх, аль ч учраа олохгүй юу болчив гэмээр; Гижиг нь гараагүй юм шиг; эмээлээ хөглүүлсэн морь шиг; гижигдүүлсэн юм шиг; сугаруу нь гар орсон юм шиг. могойд хатгуулсан юм шиг; могой гишгэсэн юм шиг; уулгамч юм шиг; годгодуулсан (гижигдүүлсэн) юм шиг;

Обычно он не был вспыльчивым, но сегодня ведёт себя, словно ему вожжа под хвост попала. Ёстой гүндүүгүй хүн юм сан, өнөөдөр юу болсон юм, галзуурахад ганц хуруу дутуу л байна шүү дээ.

761. **ВОЗ И НЫНЕ ТАМ** Бахи байдагтаа л, ургаа хад шиг; мэлхий харайвч мэн дороон., газартайгаа үргэлжлээд л, шаасан гадас шиг л, аргамжаатай юм шиг.,дөш л гэсэн үг, үхэр тэргээ үхэр тэрэг. Улигтаа домоглоод л, нөгөө л янзаараа, байдгийнхаа баруун хаяанд, мөн тэр янзаараа, нэг зангаараа, онхи нь хувираагүй, хуучин хэв янзандаа

762. **ВОЗВЕСТИ В ПРИНЦИП** *что* . . . ыг зарчим болгох, ... журамтай . . . ийг ёс болгох . . . ийг дагах, зуршуулах, хэвшүүлэх, заншуулах,

763. **ВОЗВОДИТЬ В КВАДРАТ** Дэндүү дэвэргэ-, дэгсдүүл-, сүр бадруул-,

764. **ВОЗВОДИТЬ В ПЕРЛ СОЗДАНИЯ** Гоё ганган болго-, Дошжий нь ол-,

765. **ВОЗВРАТИТЬ К ЖИЗНИ** В-766

766. **ВОЗВРАЩАТЬ К ЖИЗНИ** 1. Ухаан оро-, (оруул-,) сэхээ- 2. Эдгээ; илаарь болго-, 3. Аминд оро-,

767. **ВОЗВРАЩАТЬСЯ (Возвратиться, вернуться) К РАЗБИТОМУ КОРЫТУ** Хэвдээ оро-, бэлдээ шалдаа буу-

768. **ВОЗВЫСИТЬ ДО СЕБЯ** Өөрийнхөө дүнд хүргэ-, өөрийнхөө жишээний болго-, дээш нь татан ав-; өөд нь татаж ав-, өөрийнхөө хиртэй болго-, хүн хийж ав-,

769. **ВОЗДАТЬ СТОРИЦЕЮ** *кому за что* 1. үлэмж шан соёрхо-, их хишиг хайрла-, өгөөмөр хишиг хүртээ-, хайр хишиг соёрхо-, Буянаасаа хайрла-, ивээлийн гараа сунга-; тунгалаг мэлмийдээ соёрхо-; 2. [*ирон.*] Хосы нь урт ав-, хосы нь хоёр ав-, жавтий хүртээ-, сайн чимхи-, хосы нь арчи-; Горы нь гарга-;

За все его труды воздадут ему сторицею. Бүх ажил бүтээлд нь их шан хишиг хүртээнэ дээ.

За все его козни воздам ему сторицею. Оволж л байг даа, сайн чимхээд тавчихнаа гайгүй.

770. **ВОЗДЕТЬ РУКИ** [*устар.*] Орой дээрээ залбира-, хормой дэвсэ-, зулай дээрээ наминчла-,

771. **ВОЗИТЬ ВОДУ** *на кому* Бөхгүй тэмээ хий-, тогооны алчуур хий-, номхон морины ногт, дошгин морины чөдөр болго-, ард нь араг, гарт нь савар хада-;

Уступи им, так они, готовы на нас хоть воду возить (А. Островский, Доходное место д IV. яв. 4) Нүүр өгмөгц, цаадуул тань уухайн тос гээд л маныг тань тогооны алчуур болгочихно доо. Цаадуул чинь нүүр өгөхөд бөгс өгдөг улс.

772. **ВОЗДУШНЫЕ ЗАМКИ** Гандирсын балгас, хоосон санаа, хий л бодол, тэгнэ л гэснээс цааш юмгүй. [*Бран.*] Хий ам, хамсан хорвоо ачаалах; цасанд цэцэг ургуулах; харганы ноос; өдрийн од, өвлийн цэцэг;

Увлекаясь, он строил воздушные замки, охладев, сам же разрушал их. Хөөрцөрөхөөрөө тэрнийг ч тэгчихнэ энийг ч ингэчихнэ гээд л өдүй төдүй гандирсын балгас цогцлоочихоод, тогтож ирэхээрээ гүзээний хий гарсан юм шиг болцордог, (онгирохоороо буга буулгаж согоо суулгана гэж амлаад онгод нь гарахын тэнд хий нь гарсан гүзээ шиг . . .)

773. **ВОЗДУШНЫЙ ОКЕАН** [*стих.*] Хий мандал, огторгуйн уудам, хөх тэнгэр, охьюу тэнгэр. Э-27

774. **ВОЗДУШНЫЙ ПОЦЕЛУЙ** [*разг.*] Дохин үнсэх, хий үнсэх, хоосон үнсэх,

775. **ВОЗИТЬ ВОДУ** *на ком* Бөхгүй тэмээ болго-, номхон морины ногт, догшин морины чөдөр болго-, тогооны бариул

(алчуур) болго-, ганц чавганцын ажил хийлгэ-, ард нь араг гарт нь савар хада-,

776. ВОЗЛОЖИТЬ ВИНУ ОТВЕТСТВЕННОСТЬ *на кого* [*книжн.*] Буруугаа буха-, хөмрө-, эргэ-, аргаа ядахад аавыгаа барьж өг-, буруугаа (хүнд) тохо-, В-778

Всю вину они возложили на руководство. Тэд нэр хамаг буруугаа удирдлаганд тохов.

777. ВОЗЛОЖИТЬ НАДЕЖДУ (*на кого-что*) [*книжн.*] Түшиг түшээ хий-, нөмөр бараада-, хаяа түши-, . . . д санаж сарвай-, . . . ыг наад харах байгаа гэх, гол тасартал горь тасрахгүй, горь тасрахгүй бай-, горьдо-, горил-, -аасай, ээсэй.

Я возлагаю большие надежды на его приезд. (Тэр хүнийг) ирээсэй гэж л горидож суунам би.

Все свои надежды мать возлагала на сына. Эх нь хүүгээ л гэж санаж сарвайдаг (Эх хүн үхтэл үрээ; үгүйртэл малаа).

778. ВОЗЛОЖИТЬ ОТВЕТСТВЕННОСТЬ *на кого* В-776

779. ВОЗМЕЧТАТЬ О СЕБЕ [*ирон.*] Биеэ ихэд бодо-, сээр нь овой-, сүүл сэрвээн дээр тави-, бнерхэ-, биеэ тоо-, толгой нь том бол-, цус нь хавиргаан дэлсэ-,

780. ВОЗНАГРАДИТЬ СЕБЯ *за что нибудь* Ясаа амраа-, хөлөө жий-, өөрийгөө жаргаа-, буянаа эдлэ-, шавайгаа ханга-борив бохисхий-, хүүрээ жаргаа-, биеэ бодо-

Вернувшись домой, вознаградил себя хорошим ужином. Гэртээ харнад, орой шавайгаа ханатал нэг сайхан хоол идэж авлаа даа.

781. ВОЗНОСИТЬ (превозносить) **ДО НЕБЕС** Д-321 П-80

782. ВОЗОМНИТЬ О СЕБЕ [*ирон, неодобр.*] Биеэ хэтэрхий тоо-, лавлиун зантай, дэл дээгүүр зантай-, уулын толгой харсан (хүн) шил нь тата-, хирээсээ хэтэрсэн; биеэ мэдэхгүй; толгойгоо өрө-.

Вы возомнили о себе слишком много. Та баахан дэл, дээгүүр зан гаргажээ

783. ВОЗОМНИТЬ СЕБЯ *кем-чем.* биеэ тоо-, биеэ биед бод-өөрийгөө ийм тийм гэж бодо-,

784. ВОЗЫМЕТЬ ДЕЙСТВИЕ (силу) Хүчин төгөлдөр бол-,

785. ВОЗЬМЁШЬ ЛЫЧКО, А ОТДАТЬ РЕМЕШОК Дэлмийг аваад алтыг өг-, чимхиг аваад атгыг өг-,

786. ВОЙНА НА НЕРВАХ Дотор элдвийн эрээн бараан юм бодогдох, элдвийн юм бодох, сэтгэл хямрах, сэтгэл түвшингүй, сайн муу юм бодогдоод амар заяа үзэхгүй, сэтгэлээ үймүүлэх, долоон жорын юм бодох, есөн жорын юм бодох; тархна гашилгах, есөн өнгийн юм бодох, дэвэн дэлхийн юм бодох, тархиа (толгойгоо) эргүүлэх:,

787. ВОЙТИ В АЗАРТ Дур нь оро-, хорхой асах, хорхойтой бол-, булуу нь хала-, бурмын амт ав-, шөрмөс оро-, арааны шүлс асгах

788. ВОЙТИ (входить) **В ВОЗРАСТ** Насанд хүрэ-, эрийн цээнд хүр-, биед хүр-, эр бол-, хүн бол-, эр өсч эсгий суна-, гар нь ганзганд хөл нь дөрөөнд хүр-, тэр гэрдэ-, гэргий хүүхэд тэжээ-, эвэр нь урга-, эр цээлэ-, гэр орон толгойло-, орон гэр толгойлж өмч хөрөнгө захир- В-1021

Он вошёл в возраст и у него появились другие интересы Тэр бээр эр болж энэ тэрийг бодохтой болов.

789. ВОЙТИ В ГОЛОВУ В-1063

790. ВОЙТИ В ДОЛЮ В-1065

791. ВОЙТИ (входить) **В ДОЛГИ** Өртө-, өрөнд оро-, өрөнд идүүл-, өрөнд баригда-, өр мянган лан хүрэхэд тайжийн саная амрах гээч бол-, өрт хүн өөдөлдөггүй, өттэй ямаа амардаггүй; хэдэн төрөлдөө өртө-, диваажинд очиж хагасы нь төлө-

792. ВОЙТИ В ЖИЗНЬ В-1068

793. ВОЙТИ В ИСТОРИЮ Цасан дээр мөртэй, цаасан дээр нэртэй; нэртэй хүний зүстэй хүү, зартай аавын хүү, нэртэй зартай, нэртэй түүхтэй В П-743

794. ВОЙТИ (попасть) **В** (прежнюю, привычную, старую и. т. п.) **КОЛЕЮ** Хуучин хэвэндээ оро-, байраа олж авч, одоо л нэг хоногтоо оро- (өвчтөн) үхээд бос-, овоо эргэ- В-1069 П-744

795. ВОЙТИ В КУРС *чего* (Юманд) дадамгай бол-, гарши-, баруун солгойгүй бол-, элдүүр нь оро-, өөриймших, гүнд нь хөлөө хий- (шургуулах. шаах) элдүүр нь хана-, хувиа бодож довоо шарлуул-, хүн царайчилж гар харахгүй В-1070

Я не успел еще войти в курс дела Энэнийхээ гүнд нь хөлөө олигтой хийж бүтээгүй л байна даа (хүн цайрайчлахгүй болох өдий л байна).

796. ВОЙТИ В ЛЕТА Хөгшин хонины насгүй бол-, насны наран хэлбий-, насан зүг бол-, нас дээр гар-, өвгөрө-, өтлө-, нас өндөр бол-, ханат гэр холдож, хадан гэр ойрто-, эсгий гэрээсээ холдож энгэр газартаа очи-, эрхтэн бүгд мохо-

797. ВОЙТИ В МИЛОСТЬ *к кому* Таалалд нийцэ-, таалалд нь багта-, хайры нь ав-, энхрийлүүлэн, дур булаа-, хайр булаа-, хүний аман дахийг булаа- В-1072

798. ВОЙТИ В ПЛОТЬ И КРОВЬ *кого, чью* Яс маханд нь шин гэ-, араншин нь бол-, зан дадгаал бол-,

799. ВОЙТИ В ПЛОДЬ И КРОВЬ Яс маханд нь шингэ-, голд нь оро-, ясны бол-, арьс маханд нь шингэ-, голд нь оро-

800. ВОЙТИ В ПОЛОЖЕНИЕ *кого* Төлөөнөө арьс мах тасрах шиг бол-, өрөвөд-, өрөвдөөд яая даа гэмээр бол- байж яда-, яс хавтай-, халширa-, зүрх үхэ-, зүрхий нь шимшрүүл-, элэг эмтрэ-, бие зарасхий-, дотор хирджий-, [*прост.*] Хөл хүнд

бол-, бие шалтгаантай- бол-, бие давхар бол-, гэдэстэй бол-, цүдий-, жирэмслэ- олз ол-, юм ол-, юмтай бол-, маамаатай бол- В-1076 а.

801. ВОЙТИ В ПОСЛОВИЦУ Амтай бүгд хэлдэг юм бол-, (муу гаар) амьтны доог элэг, амны уншлага, зуун хүний хэлэн дээр, зуудаг нохойн шүдэн дээр, хүний хэлэл, нохойн хуцал, (сайнаар) нэрд гар-, шагши-; амьтанд ад адуунд чоно, амьтны хэл ам угаа-, амны зугаа бол-, хүүхэд нохойн доог бол-, хар хэл ам хүр-

Осёл глупостью в пословицу вошёл (Крылов) Тэнэг илжиг (илжигний тэнэг нь) хүний хэлэл нохойн хуцал болов

802. ВОЙТИ В СВОИ ПРАВА В-1028

803. ВОЙТИ В ПРЕТЕНЗИЮ В-1076

804. ВОЙТИ В РАЖ [*разг.*] Уур манас хий-, уур шата-, дээлэндээ багтахгүй бол-, уур нь хүрч уушги нь сагсай-, ямаан омог, хөдлө- шар гозой-, хилэн бадра-, шар буцла-, дүрс дүрс хий-, гал шата- П-1001

805. ВОЙТИ В РАЗУМ В-1077

806. ВОЙТИ В РОЛЬ 1. . . болж гар-, болж жүжиглэ-, үнэн сана-, санаа . . . боло-, яг . . . шиг жүжиглэ-, элэглэ-, доогло-, дуурай-, болж үзүүл-, 2. Чаддаг мэддэг бол-, гаршиОн так вошёл в роль, что по-настоя щему с силой ударил меня кулаком Мань эр жүжиглэж байгаагаа мартаад намайг байдгаараа дулаад авах нь тэр; (жүжгийнхээ юманд гарч байгаагаа мартаад намайг хар хүчээрээ шаагаад авч байхгүй юу.)

Она вошла в роль супруги посла, держала себя с большим достоинством Үнэнээсээ нэг элчин сайдын гэргий болж гарч, хэн ч чохом ийм л байдаг даа гэхээр гарч дөнгөж байна шүү. (Хэн ч харсан энэ бүсгүй аргагүй л элчний авгай гэхээр жүжиглэж байна шүү)

807. ВОЙТИ В РУСЛО В-1079

808. ВОЙТИ В СЕРДЦЕ (в душу) 1. Хайртай бол-, дотно бол-, шадар бол-, хайр булаа-, 2. Бодлого бол-, сэтгэл догдло- В-1067

809. ВОЙТИ В СИЛУ [*разг.*] 1. Хүчин төгөлдөр бол-, 2. [*перен.*] Эрх мэдэлтэй, нэр сүртэй, хүн өөдөөс нь ширүүн дуугарахааргүй, ангайснаар нь, хэлснээр нь,зангаснаар нь; 3. Өсөж том бол-, лагсар бол-, мах шөл суу-, сайхан урга-, төлжи-,

Закон вошёл в силу (Энэ, тэр) Хууль хүчин төгөлдөр болов.

Рожьуж в силу вошла Хар тарна боловсорчихжээ.

810. ВОЙТИ В ТЕЛО [*разг.*] 1. Бие илаарь бол-, хүч ав-, таргала-, махла-, өнгөө заса-, хурла-, дүүрээд ирэ-, мяраала-, тэвээрэ-, (тарвага) элэглэ-, хүч суу-, үсээ хая-, зооло-, 2. [*Спец., охотн.*] Нүдээс гара-, арьс яс боло-, хэдэргэ бол-, тасам бол-, ташаанд нь ташуур өлгөмөөр бол- хүч алда-, хайла-, шуугда-, гуринГата- В-1083

После лечения он поправился, вошёл в тело Эмчлүүлээд овоо засал авч таргалсан байна.

Собаки . . . охотника Ростова уже . . . вошли в охотничье тело Анчин Ростовын нохой нь бүр гуринГатаад (гурнатаад) . . .

811. ВОЙТИ ВО ВКУС *чего и без доп.* Дуртай нь аргагүй, дур оро-, сонирхо-, таала-, салахгүй бол- амтанд нь оро-, амты нь ав-, дунд дунд гэсээр долоон дунд

Левин и рад был бы войти во вкус, не мог понять в чём дело . . . (Л. Толстой. Анна Каренина, ч. VI, гл. 27) Левин дотроо дуртай нь аргагүй боловч чохом учры нь олохгүй л байв.

812. ВОКРУГ ДА ОКОЛО [*разг.*] Голы нь олохгүй, дайруулаад л, мэдэн будилах, нугасы нь онолгүй нууры нь онох, нүдий нь онодгүй нүүрий нь онох, шилбэ загатнахад түрийгээ маажих, үгээ олж хэлэхгүй үхрээ олж мөөрөхгүй, зээр гэхэд бөөр, зэс гэхэд гууль, судсы нь олохгүй, байгаа онохгүй, шаваа онохгүй тэнгэр онох, оночий нь олохгүй. Байнд ч үгүй байзанд ч үгүй.

На лекции лектор говорил много, но все вокруг да окологлавного так и не объяснил. Лекц уншсан хүн энэ тэр эсэн бусын юм ярнад л байсан гээд гол юмаа олж ярнагүй

813. ВОЛЕЙ-НЕВОЛЕЙ [*разг.*] Дуртай ч дургүй ч, уйлсан ч дуулсан ч, тэртэй тэргүй, эрхбиш, арга буюу, хаанаа ч, ямар ч гэсэн, нэгэнт, яасан ч, дур сонгохгүй, харын албаар, албан хүчээр, албын зам цусаар уйлсан ч.

Волей-неволей ей пришлось согласиться с нами Дуртай ч дургүй маны хэлсэнд за хүлээх болов.

814. ВОЛЕЮ СУДЕБ (случая) Заяагаар, заяан, санаандгүй, азаар, сохор азаар, хувь байснаар, ерөөл байснаар, учрал байснаар, тавиланГаар, урдын хийсэн ерөөлөөр, тэнэсэн сум тархинд гэгчээр, төөрсөөр төрөлдөө

Через много лет я волею судеб снова встретился с ней Олон он болсны хойно, заяагаар би түүнтэй нэг дайралдсан шүү.

815. ВОЛК В ОВЕЧЬЕЙ ШКУРЕ үгчилбээс: Хонины арьс нөмөрсөн чоно, монголоор хүний арьс нөмөрсөн чоно нохой), сүүлгүй нохой (чоно), инээдэг дайсан, хүний арьс нөмөрсөн хээрийн зэрлэг чоно... (Д. Нацандорж), хэлэн дээр чихир, шилэн дээр хутга; өнгөө нааНаа өргөсөө цааНаа, бурхан дүртэй буг, тэнгэр дүртэй тийрэн, гэмгүй царайтай, дотуур тамиртай, муу санаатай, хогийн мөөг, муур багш хүний арьсанд нохойн мах чихсэн

816. **ВОЛК ПО УТРОБЕ ВОР, А ЧЕЛОВЕК ПО ЗАВИСТИ** [*посл.*] үгчилбээс: Чоно өлсөхдөө хулгайч болдог хүн атаархахдаа ховлооч болдог монголоор: Хүн ядарвал хууль давдаг нохой ядарвал хэрэм харайдаг. Өшихдээ хэрүүлч өлсөхдөө хулгайч, нохой хамартаа хүрэхээр усч, хүн шагтаа тулахаар хөч

817. **ВОЛКА НОГИ КОРМЯТ** Чоно эрийнхээ сайнд амь тээдэг, Хөх чоно хөлийн сайнаар, саарал чоно санааны муугаар, чоно зуусандаа морь харайсандаа

818. **ВОЛКОВ БОЯТЬСЯ В ЛЕС НЕ ХОДИТЬ** Барын ичээнд эс орохгүй бол барын зулзагыг барьдаггүй,айвал бүү хий,хийвэл бүү ай; чоно цавиндаа хүрвэл хонь,аймхай нь мянга үхнэ, айдаггүй нь нэг үхнэ. Зааныг унагаж заан болох, аврагыг хаяж аврага болох, эр хүн зоригтой бол чоно чацга алдана. Байлдаж байж баатар болно байж сууж байж баатар болдоггүй, ялж байж баатар болно ямбалж байж баатар болохгүй.

819. **ВОЛКОМ ВЫТЬ (взвыть)** [*разг.*] Зовлонгоо тоочи-, хангинан гонгонон- уйлан донгодо-, долоон булчирхай найман найлзархайгаа тоочи-, үглэж дуула-, уйлж дуула-, хошуу цорвой-, цөхрөнгөө бара-, шагтаа тулж шагаа бара-В-1249

Он волком выл, жалуясь на свою горькую судьбу Заяа муутайгаа үглэж зовлонгоо тоочив.

820. **ВОЛКОМ СМОТРЕТЬ** [*разг.*] Хүйтэн харцаар хара-, занаатай хара-, муухай хара-, цэхийн хара-, өшсөн янзтай хара-, хялбалза-, нүд буланда-,

Попав в детдом, мальчик волком смотрел на всех окружающих Жаалхүү өнчний газар очоод хажуу хавирганыхаа улсыг хүйтэн харцаар (буландан) харав.

821. **ВОЛОКОВОЕ ОКНО** Өрх, өрхний нүх, тооно

822. **ВОЛОС В ВОЛОС** Ав адилхан, ихэр юм шиг, эгээ нэг

Это был родной брат покойника и похож на него волос в волос, голос в голос Мань хүн бүрлээчтэйгээ үс зүс, дуу шүү эгээ нэг.

823. **ВОЛОСЫ РВАТЬ НА СЕБЕ** [*разг.*] Толгойгоороо ус уу-, ээ дээ би бас дүүрсэн толгой, яав аа даан ч гэж гэмши-, үйлээ цайж үсээ зулгай-, түмэнтээ гэмши-, ээлээ яалаа даанч, гэм нь урдаа гэмшил нь хойноо, өөрөөрөө наада-, амаа бари-, гэмт хүн гэдсээ маажи-, гэтэгч хүн сүүдрээ харна, ээ халаг бол-, ингэж явахаар үхээсэй, ингэж ч явах гэж дээ, эрлэг ч тоодог болоосой, өөрийгөө чада-, өөрийгөө өрлө-,

В отчаянии, что так глупо поступил, он готов был рвать на себе волосы Үгүй, ийм дүүрсэн тэнэг юм хийх гэж дээ даанч гэж гэмшихийн ихээр гэмшив (Би гэдэг хүн ингэж толгойгоороо ус уух гэж байх уу хэмээн ухилан донгодов).

824. **ВОЛОСИ ВСТАЛИ (становятся, встают, поднимаются) ДЫБОМ** [*разг.*] (айх, цочих зэргээс) толгойтой үс арзасхийв,

гол руу хүйт оргих, бие зарасхийх, хамаг биенээс хүйтэн хөлс гарах, ар нуруу руу хүйт оргив, голд хүйт орох шиг болов, хоолой зангирч нулимс бүрхэх шиг болов.

825. **ВОЛЧИЙ АППЕТИТ** [*разг.*] Их л юм идэж уумаар байна. Бүхэл хүн ч идчихмээр байна. Үнэг гүйцмээр, гуталтай гуя залгих нь холгүй, гэдэс нуруунд наалдах, өлөн гэдэс тасрах нь, харнугүй унах нь, шил нь татах, хий харгах, гол харлах, хар шүлс асгах, өлбөрөх, харангатах, өлөн бугын эвэр зөөлрөх, нүүрний арьс хөдөлгөх юм байна уу, эрүү толгой зодолдуулах юм байна уу, цээжний хөндий рүү хаячих юм байна уу, гол зогоох юм байна уу.

У меня сегодня волчий аппетит Би ч өнөөдөр бүхэл хүн ч залгичихмаар байна шүү.

826. **ВОЛЧИЙ ПАСПОРТ (билет)** * [*Устар.,доревөлюц.*] Үгчилс хийвэл: Боохой данст, боохойн бүртгэл, боохойн данстан

827. **ВОЛЧЬЯ ЖИЗНЬ** [*разг.*] Боолын боол, элс үмхэж, эрэг мэрж ява-, үнсэнд хаясан шалз шиг, заяа нь хаясан (орхи-)

Ты... пожалей меня Несладко живу... волчья жизнь-мало радует (Горький. На дне, д. Ш.) Чи... намайг өрөвдөөч дээ Үнсэнд хаясан шалз шиг үйл тамаа цайж өөд нар үзэхгүй явж явнам би.

828. **ВОЛЧЬЯ ХВАТКА** *у кого* [*разг.*] Хутга сугалах, хорон аргаар, багалзуурдалдах, голы нь гогодох, өрий нь тэмтрэх

829. **ВОЛШЕБНАЯ ПАЛОЧКА** Шидэт бэрээ

830. **ВОЛШЕБНОЕ ЦАРСТВО** Үлгэрийн орон, лусын хааных

831. **ВОЛШЕБНЫЙ ФОНАРЬ** [*устар*] илбийн дэнлүү, ховосын дэн.

832. **ВОЛЬНАЯ ГАВАНЬ** Сул булан, чөлөөтэй хоолой

833. **ВОЛЬНАЯ ПТИЦА (пташка)** [*разг.*] Сул хүн, дураараа хүн. өөрөө өөртөө эзэн хүн, зоргоороо хүн, дархан тавьж дашин харавсан, уяа нь алдуурсан нохой, торноос мултарсан шувуу шиг, салхи залгисан, сул бие сунхсан ганц бие ганхсан,алдуул мал шиг

834. **ВОЛЬНЫЕ ДВИЖЕНИЯ** Чөлөөтэй сул хөдөлгөөн, (биенийн тамирын тусгай хэрэгсэлгүйгээр дан биеэрээ хийх тамирын дасгалын хөдөлгөөн болой), үегүй юм шиг, нугасгүй юм шиг, сайн биелээчин шиг

835. **ВОЛЬНЫЕ СТИХИ** чөлөөт шүлэг, цагаан шүлэг

836. **ВОЛЬНЫЙ КАЗАК** [*разг.*] Жолоогүй морь, сул хүн, толгойгоо мэдсэн хүн, дураараа хүн, зоргоороо хүн, хүнээр мэдүүлдэггүй хүн, жоль хүн, татлаа түлхээгүй хүн, хар толгойгоороо дүүрсэн, гэдсээ маажсан амьтан, намайг хэн хэлэх вэ, нохойг хэн саах вэ, хэлсэн ч миний дур эс хэлсэн ч миний дур, хий-

*Цагаан хаант оросын үес хувьсгалчдад тусгайлан олгосон бичиг. Энэ бичигтэй хүн ямар нэг алба хаах, сургуульд орох эрхгүй байдаг бүлгээ. Монгол хэлний луу нөртэй лууд данстай гэдэг шиг үгээ.

сэн ч миний дур эс хийсэн чминий дур, ган хар толгой, алба ахуйгүй, авгай хүүхэдгүй.

Я вольный казак и могу выехать хоть завтра Би толгойгоо өөрөө мэднэ, маргааш мордлоо л бол мордлоо.

837. ВОЛЬНЫЙ ПАР (жар, дух) [*прост.*] Халуун зуух

838. ВОЛЬНЫЙ ПЕРЕВОД Утгачилсан орчуулга, тоймлосон орчуулга

839. ВОЛЬНЫЙ СТИЛЬ (Усанд шумбах сэлэхэд) чөлөөт маяг,чөлөөт сэллэг

840. ВОЛЮ ДАВАТЬ РУКАМ [*разг.*] (Юм л бол) гар хөдөлбөл л хүн зоддог, сав л хийвэл гар хүрчихдэг, махлах дуртай, гар нь загатнасан, алга нь загатнасан Д-13 Д-70

Волю давать рукам я тебе не позволю Тэгэж чамаар сав л хийвэл хүн зодуулахгүй.

Языком болтай, а рукам волю не давай (пословица) Гар хүрэхээр учир хэлэлц. (Ташуур далайхаар учир хэлэлц). (Хүн хэлэхээ мал хөлөөрөө)

841 ВОЛЯ БАТЮШКИНА, НЕГА МАТУШКИНА (Зүйр үг) Эцгийн зориг эхийн хайр

842. ВОЛЯ ВАША (твоя) *буюу* **ВАША (твоя) ДОБРАЯ ВОЛЯ** [*разг.*] Таны таалал мэдэг, таны таалаар болтугай, та болгоо доо, нигүүлсэхий тэнь хүртэе.

843. ВОЛЯ ВАША Тааллаараа болгоо, өөрөө л мэд, та л болгоо, дураараа л бол доо

844. ВОЛЯ НЕБЕС [*устар.*] Одоо хаана [*ирон.*] Тэнгэрийн зоригтэнгэрийн ивээл

845. ВООБЩЕ ГОВОРЯ [*разг., ввод. сл.*] Ер нь, уг нь, жир, чухамдаа, уулаасаа

846. ВООРУЖАТЬСЯ ТЕРПЕНИЕМ [*книжн.*] Хүлцэл эдлэ-, тэвчээр барин-

847. ВООРУЖЁННОЙ РУКОЙ Дайнаар, зэвсгийн хүчээр, ирт мэсээр, бороохойгоор, хүч түрэн, сүр хүчээр далайлган, нум сум илд жадаар

848. ВООРУЖЁННЫЙ ДО ЗУБОВ [*книжн.*] Өвч зэвсэглэсэн, бүрэн зэвсэгтэй, хумсаа хүртэл шөвхлөх, хошуугаа хүртэл билүүдэх

849. ВООРУЖЁННЫМ ГЛАЗОМ Дуран авайгаар, шил дурангаар, татах тусгах хэрэгслэлээр шилээр ширтэж (ширмээр цутгаж)

850. ВОПЛОЩАТЬ В ЖИЗНЬ Санаснаа хий-, хийнэ гэснээ хийхэлдэг ч хийдэг ч П-951

851. ВОПЛОЩАТЬ (воплотить) В СЕБЕ-даа[4] шингээсэн,...шинж бүхий, шинж бүрдэ-

852. ВОПРЕКИ *чьим* ОЖИДАНИЯМ Санаснаас..., санасныг бодвол..., их санасан газар есөн (долоон, гурван) шөнө хоосон хонох гэгч, Их санасан ууланд (газар) гөрөөсгүй

853. ВОПРОС ВИСИТ [*перен.*] ... товлоогүй, шийдээгүй, шийдэж цөхөөд л, нэг тийшээ болоогүй, яахаа ч мэдээгүй, алцан цойцон

854. ВОПРОС ЖИЗНИ И СМЕРТИ Үхдэг сэхдэгийг нэг болох, нэн чухал, чи би дээрээ тулсан, чухаг, нэгийгээ үзэх (нэхий дээлээ уралцах) Хутганы ир дээр, гал мэсийн дунд, үхэх сэхээхийн зааган дээр

Разрешение этого спора-вопрос жизни и смерти. Энэ маргааныг нэгэн тийш болгох гэдэг их чухаг хэрэг ээ.

855. ВОР ОБШАРИТ, ХОТЬ СТЕНЫ ОСТАВИТЬ, А ОГОНЬ И ВСЕ ПРИБЕРЁТ Зүйр үг үгчилбээс: Хулгайч ухавч ханхай орны нь үлдээдэг, гал гарвал юутай хүүтэй нь хуйхалдаг, монголын: Гал үер хоёр, гай ядрал хоёр гэдэгтэй утга нэг, бас ганц гэр галаа хичээ, хоёр гэр ховсо хичээ, гадагш явах хүн амаа хичээ, гэрт суух хүн галаа хичээ

856. ВОР У ВОРА ДУБИНКУ УКРАЛ [*погов.*] Чоно чоноо идэх, бар бараа идэх, лам ламдаа муу, ямаа хамуундаа муу дээрэмчинд луйварчин учрав гэгч, хатуу нь хатуу тайгаа, мэхтийг мэхт

857. ВОРОБЬИНАЯ НОЧЬ Усан бороо асгарсан шөнө, аадар бороо гоожсон шөнө; зуны шөнө, шөнийн богинод

858. ВОРОН ВОРОНУ ГЛАЗ НЕ ВЫКЛЮЕТ Чоно үүрэндээ (хотондоо) өлзийтэй, хар хардаа харшилдаггүй

859. ВОРОН СЧИТАТЬ [*разг., фам.*] Үсээ тооло-, мэлрээ, аламгай, ангайч...

Что ты ворон считаешь и теряешь время Чи юу гэж дэмий аламгайдаж цаг нөгцөөдөг юм бэ?

860. ВОРОНА В ПАВЛИНЬИХ ПЕРЬЯХ. [*пренебр., прост.*] Хувцас бурхан бие чөтгөр, гаднаа гяланцаг, дотроо паланцаг, гадаад үзэгдэл нь тоть тогос шиг, дотоод байдал нь намаг шалбааг шиг; гадна тал нь өдөр шиг, дотно тал нь шөнө шиг, гаднаа гялан цалан, дотроо палан цалан, ам нь шар алт, ачир нь шар чацга: гоо үзэсгэлэн хэмээгч мунхаг тархины халхавч болдог нь цөөнгүй (С. Эрдэнэ)

Вы восхищаетесь им, а, по-моему, он просто ворона в павлиньих перьях. Та нар тэрнийг шагшаад л байх юм даа, миний бодоход цаадахь чинь гаднаа гяланцаг дотроо паланцаг л амьтан шүү дээ.

861. ВОРОТИТЬ ГОРЫ (гору) Уул өргө-, хийхийн ихийг хийшаварт унасан шарын эзэн хүчтэй гэгчээр. В-865 С-280

862. ВОРОТИТЬ НОС Хамарт нь баас түрхчихсэн юм шиг (ихэрхэг), хамар нь мондой-, сүүлээ сэрвээн дээрээ хая-, ярвагар доровгор, зэрэглээ харсан юм шиг, уулын толгой хараад, давилуун, дээгүүр зантай

863. ВОРОТНИК ШАЛЬЮ Хиаз зах,

864. ВОРОЧАТЬ ГЛАЗАМИ [*разг.*] Цагаанаар эргэлдэ-, цөхөн цөхөн хий-, хялав хялав хий-, хялав цалав хий-

Как рассердится, так и начинает глазами ворочать

Ууряахаараа л нүд нь цэхэн цэхэн хийгээд л гарч өгнө дөө

865. **ВОРОЧАТЬ** (двигать) **ГОРАМИ** В-861

866. **ВОРОЧАТЬ ТЫСЯЧАМИ** (миллионами) [*разг.*] Бэл мөнгийг ус цас шиг зара-, мөнгөөр тогло-, мөнгөөр гараа угаа-, дураараа туйла-

Отец его ворочал миллионами, однако сыну ничего не оставил. Эцэг нь мөнгөөр тоглож явсан хүн юмаа, хүүдээ л даан ч юу ч үлдээсэнгүй дээ.

867. **ВО-СВОЯСИ** (восвояси) **ПОЕХАТЬ** (пойти, направиться, отправиться) [*разг., ирон.*] Гэртээ хари-, буца-, ирсэн замаараа сурсан дуугаа дуулаад... байдгийнхаа баруун хаяанд очи-

868 **ВОСКЛИЦАТЬ ОСАННУ** *кому* Магтахын дээдээр магт-, бүр умайтал орж өг-, мөргөх шаха-, хэлэх сайн үгээ олохгүй амаа одохгүй магта-, тэнгэрт тултал хөөргө-, сүнс зовмоор магта-, магтаад сайн үгээ бара-

869. **ВОСКУРИТЬ ФИМИАМ** *кому* [*ирон.*] Тэнгэрт тултал магта-, хөөргөй магта-, магтах сайн үгээ олж яда-, нар сараар зүйрлэн магта-, ертөнцөд үгүй юм хийсэн шиг магта-, хүнд үгүй юм хийчихсэн шиг

870. **ВОСПАРЯТЬ** (воспарить) **ДУХОМ** (душью, мыслью) Зориг оро-, урам сэргээ-, уртасла-, хөхөн бадраа-, хөхүүлэн бадраа-, урам хөгжөө-

871. **ВОСПРЯНУТЬ ДУХОМ** Урам сэргэ-, зориг оро-, сэтгэл сэрг

872. **ВОСПРЯНУТЬ ОТ СНА** [*устар.*] Гэнэт сэрэ-, ясныг ч мэ дэхгүй сэр-, нэг сэрэхнээ нь

873. **ВОССТАНОВИТЬ ДОБРОЕ ИМЯ** *чьё, кого* Нэрий нь сэргээ-, нэрий нь гаргаж мандаа-, буяны нь дурас-, ачий нь сана-

874. **ВОССТАТЬ ОТ СНА** Сэрэ-, нойрноос сэрэ-

875. **ВОСХОДЯЩАЯ ВЕЛИЧИНА** Шинэ гарч ирж байгаа хүн; шинэ хүн, шинэ мандсан хүн, цоорч ирсэн хүн, од нь орсон хүн

876. **ВОСХОДЯЩАЯ ЗВЕЗДА** (Шинжлэх ухаан, урлаг зэрэгт) нэрд гарч яваа хүн, мандаж яваа хүн, цоорч яваа хүн, толгой нь цоорч яваа хүн, нэмд нэвтэрсэн хүн В-877

Вы, не знаете его Это профессор Никитин, восходящее наше светило. Та танихгүй юу энэ хүнийг? Манай мандаж яваа Никитин профессор гэдэг хүн энэ дээ.

877. **ВОСХОДЯЩЕЕ СВЕТИЛО** В-876

878. **ВОСШЕСТВИЕ НА ПРЕСТОЛ** [*устар.*] Хаан ширээнд залрах, хаан ширээ эзлэх, хаан ширээнээ залрах

Вот бог *бую* А бот порог Зайл! тонил! арилаад өг!

879. **ВОТ-ВОТ** [*разг.*] Одоохон, даруйхан, харигүй, ердөө нигээд л, юу юугүй, мөд

Тучи собрались, вот-вот польёт дождь. Үүл хөшиглөөд юу юугүй бороо цутгах нь л даа.

Стена вот-вот свалится Хана (туурга, хэрэм) ойчих нь ээ ойчихно (хана уналаса шүү хөөш).

Картина плохо висит, вот-вот упадёт Энэ зургийг яасан муу өлгөсөн юм дээ, унаачих нь дээ.

Подождите, пожалуйста, она вот-вот придёт. (Та) нэг бяцхан саатагту, (тэр эмэгтэй) одоохон хүрээд ирнэ.

880. **ВОТ ГДЕ СИДИТ** *кто-что у кого* [*разг.*] Зовлонтой, яршигтай, (санаа зовоосон хүн буюу юм) Байж ядахаар, төвөгтэй, байж сууж болохгүй сэтгэл дэнслүүлсэн, бодолд нэг юм уяатай бай-, амар заяа үзүүлэхгүй, сэтгэлийн бөөдий, цээжний мах идсэн

Ах, уж эта мне ваша халатность вот где сидит Ээ дээ таны энэ хайш яйш зан уу миний сэтгэлийг ихээхэн шүү зовоож байх юм даа.

881. **ВОТ ГДЕ СОБАКА ЗАРЫТА** [*разг.*] Хамаг учир энд (энүүнд) онис нь энүүнд, зангилаа нь энд байгаа юм. Юмны эзэн сумны занги. С-648

882. **ВОТ ЕШЁ** [*разг.*] Ярвиг, яах юм? юугаа хийх юм? ямар үлийгээ хийх гэсэн юм? ямар пад байна? Нохойн ноолуур, хар төвөг, хэнд ч хэрэггүй, авшгүй хаяшгүй, гайгүй байна даа, бас л, аанай л, дэмий, тэр дэмий, авах найдаагүй асгах шааргүй,

Дай мне это-вот ещё Аль эннийгээ надад өгөөд орхи- (ац нааш нь)-чи яах гэсэн юм, бас санаатай юу, өгөөд орхи нааш нь).

Вот еще никогда не соглашусь с вами в том вопросе. Бас л энэний тухайд би яасан ч танд тэгээ гэж чадахгүй.

Пойдём в парк-Вот еще, в такую погоду Үүсгэмэл цэцэрлиг рүү явцгаая -Тэнгэр ийм байхад юугаа хийх юм бэ? (Тэнгэр ийм байхад яах юм!)

Ты поедешь со мной-не поеду. Вот еще Чи надтай явах уу-үгүй, яах юм.

883. **ВОТ ЕЩЕ НОВОСТИ** Яасан хачин юм ямар жигтэй хачин хэрэг байна даа, санаанд багтамгүй (оромгүй) юм байна хэн тэгэж санах вэ, гайхмаар юм.

884. **ВОТ ЗАЧЕМ** Хэлээгүй юү тэр, ингэх л гэж, ингэж л, учир нь энэ, за тэр, энэ дээ, өнгө нь ороод байсан юм, ингэнэ гэж эс хэллүү

Вот зачем он пришёл За ингэх л гэж ирсэн байхгүй юү.

885. **ВОТ И ВСЯ НЕДОЛГА** И-12

886. **ВОТ ИМЕННО** Дүрээрээ, яг ийм, яг тийм, ээдээ чохом, мөн дөө. Үйлийн үргүй, байна даа хө, чухам аа, чухам нэг, ёстой нэг, бүр нэг

887. **ВОТ КАК** *буюу* **ВОТ ЧТО** Яаж байгаа нь тэр вэ? Тэглээ гэж үү? яалаа гэж, айн? арай үгүй байлгүй; Нээрээ үү, тийм гэж үү

Вот как почему же никто не предупредил меня об этом? Тэглээ гэж үү, над түрүү нь хэлэхгүй яасан юм бэ? (тэглээ гэж үү, яаж байгаа нь тэр вэ над түрүү нь хэлэхгүй?)

888. **ВОТ НЕ БЫЛО ПЕЧАЛИ, ТАК ЧЕРТИ НАКАЧАЛИ** Гай газар доороос гахай модон дотроос

889. **ВОТ НЕВИДАЛЬ** *буюу* **ЭКАЯ (эка) НЕВИДАЛЬ** *буюу* **ЧТО ЗА НЕВИДАЛЬ** *буюу* **КАКАЯ НЕВИДАЛЬ** Тэр тоглоом оо, нохойн наадам,...нь байтугай,... ч биш үй нэг, хэн мэдэх (гүй) үзэхгүй байх вэ?, юухан байх вэ? Э-4

Вот невидаль-на автомобиле, а я летал на самолёте Машинд суух тэр тоглоомоо, би нисдэгт ч сууж явсан.

890. **ВОТ ОН** [*разг.*] Харахгүй юү,хэлээгүй юу, за тэр, харж байгаа биз дээ, за ... шүү дээ, орой руу нь орсон байгаа биз дээ.

Вот он я пришёл За би ирлээ шүү дээ (Бид хүрээд ирлээ)

А вот он и я Харахгүй юү би л байна даа, за би ирлээ (бэлээн)

891. **ВОТ ОНА** (Эм хүн өөрийгөө өгүүлэхдээ **он** гэдгийгээ **она** болгож солиод л хэрэглэдэг, утга нь **вот он** лугаа адил).

А вот она и я Харахгүй юү би л байна.

892. **ВОТ ОНИ** (Олон хүн өөрсдийнхөө өмнөөс өгүүлэхэд **он** гэдгийгээ **они** болгон солиод л хэрэглэдэг утга нь **вот он** лугаа адил).

Вот они мы харахгүй юү бид нар л байна.

893. **ВОТ ОНО ЧТО** Үгүй ер, хээ бас, хээ гээ

894. **ВОТ ПОДИ Ж ТЫ** Ямар хачин юм бэ? Яасан жигтэй хэрэг вэ?

895. **ВОТ ПОТЕХА** [*прост*] Хөгтэй инээдтэй, элэг хөнчихмөөр, элэг авчихмаар, инээд барчихмаар, паргинтай юм, зугаатай юм, цэнгэлтэй юм.

Он анекдот рассказал, -вот потеха Мань эр завхай яриа яриад элэг авчих шахлаа.

896. **ВОТ ТАК . . .** [*разг, фам., ирон.*] Доршаах, эс тоомсорлох санаа, гайгүй дээ, гайгүй байлгүй дээ, үхсэн хойноо, (тэгэх ингэхээ) хат, ямар юмных нь . . . , тэгнэ байхаа, тэгнэ бий,

Вот так спел Дуулахаа хат.

897. **ВОТ ТАК КЛЮКВА** [*прост.*] Жигтэй юм, дүүрсэн, яадгаа алдсан, замарсан, илжиг толгойлсон эрүүд В-902,903

898. **ВОТ ТАК ТАК** Жигтэй юм, хэн ингэж санах вэ? Юутай хачин

899. **ВОТ ТАК ФУНТ** [*прост.*] Ээ чааваас, даан ч яваа, (ингэнэ) тэгнэ гэж бодсонгүй, тийм юм болно гэж бодсонгүй, яаж үхдэг билээ, үхвэл таарчээ, тэгэж байсан дорхноо үхсэн нь дээр, тэгэж байх нь таарсан, тэгнэ гэж байх уу, юу гэсэн үг вэ?

Вот так фуит да неужели я вчера был так пьян Даан ч яав аа, өчигдөр би мөн ч булай согтжээ.

900. **ВОТ ТАК ШТУКА** Пээ яасан хачин, ямар жигтэй, ямар сонин, үгүй бас

901. **ВОТ ТЕ И ЗДРАВСТВУЙ** [*разг.*] Үгүй харж байна уу, өө хөөрхий дээ, яаж байна аа, Ээ зайлуул аа, ээ байж байгаагий нь ээ өвс идэж ус ууж байсан юм шиг, таарч дээ мөн, чи ч ингэх л хүн л дээ, мөн дөө дүрээрээ, өнгөө олох нь тэр, ганц болж . . .

902. **ВОТ ТЕ (тебе) И НА** В-897

903. **ВОТ ТЕ (тебе) И РАЗ** В-897

904. **ВОТ ТЕ (тебе) КРЕСТ** [*прост.*] 1. Нээрээ шүү. 2. Тэнгэр мэд, тэнгэр таалаг

905. **ВОТ ТЕ ХРИТОС** В-899

906. **ВОТ ТЕБЕ** [*разг.*] (Хүн, нохой зодоход хэлэх үг) ингээд чи тэг, хохь чинь ээ, хохь чинь тэр ээ, яана гэнэ ээ хөө чи, байх уу, уухай чи, май тэг чи, май чи,

907 **ВОТ ТЕБЕ, БАБУШКА, И ЮРЬЕВ ДЕНЬ** Дүүрчээ дүүрч, одоо яана гэх вэ дээ, даан ч арга алга боллоо, цохож гүйцлээ, нигээд л дүүрье, дүүрсэндээ дүүрье.

908. **ВОТ ТЕБЕ И ВЕСЬ (последний мой) СКАЗ** [*разг.*] юу ч гэх вэ дээ, одоо хэлэх ч үг алгаа, яа ч гэх вэ дээ, хэлэх нь энэ, олон үггүй, нялуунаас шулуун нь, олон таван үггүй

Глупый ты-вот тебе и весь сказ Үгүй мөн тэнэг ээ, юу ч гэх вэ дээ одоо,

Не согласен я-вот тебе и сказ весь Би л за (тэг) гэхгүй-зүгээр олон үггүй.

909. **ВОТ ТЕБЕ (и) НА** *буюу* **ВОТ ТАК ТАК** *буюу* **ВОТ ТЕБЕ И** *что* [*разг.*] Ээ чааваас аа, яаж байгаа нь тэр вэ? Өө тэгчихэв үү, яагаад нигэчихэв ээ, заяа нь тэр, арай ч дээ, юу болж байгаа нь энэ вэ, яах нь тэр вэ, ээ харал аа тэгээ юү, таарч дээ ганц

Вот тебе и начумал сегодня поехать за-город, оказывается нельзя-срочная работа. Ээ чааваас аа, хөдөө гарах юм билүү гэж байсан юмсан, өнгөрөх шиг боллоо, яаруу ажил гарч.

910. **ВОТ ТЕБЕ (и) РАЗ** В-897

911. **ВОТ ТЕБЕ КРЕСТ** [*прост., устар.*] Дээр тэнгэр, доор газар байна үнэндээ, үнэнээсээ тэхэд, би худлаа хэлэхгүй эргэж уулзахгүй нүүр биш, хардаг юм харж л байгаа байх, худал үнэн нь хойноо хуєран боос нь хавартаа, үйлийн үргүй, юманд нэгээрээ биш, хаанаас тэгэж буяндаа бузар оруулах вэ, хүн байна даа дааич, би чинь хүн шүү дээ

912. **ВОТ ТО-ТО И ЕСТЬ** Т-154, 155

913. **ВОТ ТО-ТО И ОНО (и есть)** Т-154

914. **ВОТ УЖ** 1. [*разг.*] Нээрэн, үнэндээ . . . шүү, өмөөрөхийн эцэсгүй, маргашгүй, яах аргагүй, яахын ч эцэсгүй, дааич . . ., үйлийн үргүй, . . . ээ мөн . . . , хүний урманд, 2. В-

Вот уж скоро весна Хавар хаяанд ирлээ.

Вот уж нет Үнэндээ байхгүй шүү.
Вот уж неправда Үйлийн үргүй буруу (бишээ биш, худлаа худлаа).
Вот уж не думал Даанч санасангүй дээ (хүний урманд санасангүй)
Вот уж болван Ээ мөн дүүрсэн мануухай, унтарсан галд урнагүй золиг, үйлс нь хаясан амьтан, үйлс нь цайсан сухай.

915. **ВОТ УЖЕ** (Өдгөө, эдүүгээ) хэдийн, нэгэнт, аль язгуурын
Мы не видались вот уже пять лет Бид нар таван жил бараа бараагаа харсангүй (уулзсангүй дээ).
Вот уже десять лет прошло Арван жил өнгөрлөө дөө (арван жил өнгөрчихөж шүү).

916. **ВОТ ЧТО** [*разг.*] 1. Энүүнийг л, ердөө л . . . -ийг
Вы сделайте вот что . , . Та ердөө л энийг хий, 2. Та сайн санаж авагту, айн гэж бай.

917. **ВОТ ЧТО** Ийм байсан юм уу, өө энэ үү, иймдээ (энэдээ) тулсан уу (хүрсэн үү), ийм юм бий, мөөн мөн, пөөх ийм хэрэг үү

918. **ВОТ ЧТО ТЫ ХОЧЕШЬ (вы хотите)** [*разг.*] Яаж ч гуйсан юу ч гэсэн, тэгнэ вий чи, буян амалсан ч, үгүй бол . . . , юуны хүү болдог бол ..., цусаар уйлсан ч, мөргөсөн ч ...(үгүй) ...Ч-175
Вот ты что хочешь, я не могу сказать Чамайг цусаар уйлсан ч би хэлэхгүй

919. **ВОТ ЭТО ДЕЛО** Ийм л байгаа юм, за энэ дээ, ингэвэл зөв, одоо л салхи нь зөвдөө, ингэх л байсан юм, одоо л зөв замын тэргэнд суулаа

920. **ВОТ ЭТО Я ПОНИМАЮ** [*разг.*] Зөвдөө, мөн дөө, ёстой доо хэлээд яах вэ, ээ дээ, тийм тийм, чохом оо чохом оо Э-23

921. **ВПАДАТЬ В ПРОТИВОРЕЧИЕ** Хөхөө хүйдсээр цохих гээч бол-, далан банага, далан худалч, ярьж дуусаагүй зөрө-, худалчийн тулам, аваад уна-, үхэр хэдгэнэ бугуйлда-,
Он легко впадал в противоречие. Мань эр тэгэсхийгээд л хөхөө хүйдсээр цохих гээч болно доо.

922. **В ПАДАТЬ (впасть) В РЕБЯЧЕСТВО В-923**

923. **ВПАСТЬ (впадать) В ДЕТСТВО** Насжаад буцаад хүүхэддээ оро-, (хүн хөгширч хүүхэдрэхүү бол-), зөнөг залга-, аргнад хүүхэд шиг бол-
На 93-ем году старик начал впадать в детство. Өвгөн 93 хүрээд яг л хүүхэд шиг болох тийшээ хандав.

924. **ВПЕРЕД НЕ СУЙСЯ, НАЗАДИ НЕ ОСТАВАЙСЯ** [*посл*] үгчилбээс: Битгий ч түрүүл, битгий ч хоцор, утга нь чандага шиг цагаан биш хэрээ шиг хар биш шаазгай шиг алаг яв, сохрын газар сохор, доголонгийн газар доголон, эхий нь эцээж туглы нь тураахгүй

925. **ВПЕРИТЬ ВЗОР (взгляд)** [*книжн.*] юм ширтэ-, гөлрө-, нүд нь мөлтөрмөр

Женщина, вперив взор в одну точку, продолжала хранить молчание Тэр эм чив чигээрээ гөлөрч дуугүй байсаар байв.

926. **ВПИВАТЬСЯ (впиться) ГЛАЗАМИ** Гөлрөн хара-, ширтэ-, нүд цавчилгүй хара-

927. **ВПИСЫВАТЬ (вписать) НОВУЮ СТРАНИЦУ** *во что* Шинэ юм буй болго-, шавы нь тави-, тулгы нь тула-, шинэ хэрэг үүсгэ-, шинэ үг өгүүлэ-, шинэ явдал бол-

928. **ВПИТЫВАТЬ КАК ГУБКА** [*разг.*] ховх соро-, их уу-, уумхай, сархинаг нь хатсан юм шиг, шингээмхэй

929. **ВПИТЬСЯ ВЗГЛЯДОМ В-926**

930. **ВПРАВИТЬ (вправлять) МОЗГИ** *кому* [*прост.*] Дарж байж сахил хүртээх гэгч бол-, мунхагийг мунаар, яртай модны ярандундуур, ярдаг бандийн шилэн дундуур (ярдаг хүний тархин дундуур), дуртай цээж дургүй бөгс, дургүйд хүчгүй

931. **ВПРЕДЬ ДО** *чего* Тэр болтол, хэдий болтол, . . . хүртэл, -тал[4], одооноос аваад . . . хүртэл
Впредь до заключения нового соглашения Шинэ гэрээ богтоотол л,
Впредь до окончания дела Одооноос аваад ажлаа дуустал

932. **ВПУХ И ВПРАХ** Бутцохих, няц цохих, үлдээлгүй, үнсэн товрог болгох, хнар цохих, хүйс тэмтрэх, голомты нь хийсгэх, нуга дарах, хядах, ясан овоо цусан далай болтол
Разбить впух и впрах Бутцохи-, задцохи-, сөнөө-

933. **ВРАГ ПОПУТАЛ Ч-79**

934. **ВРАСТАТЬ В ЗЕМЛЮ** [*перен.*] Газар суу-, газар шигдэ-газартайгаа үргэлж болчих шахсан, навтайсан, далд ормор хавтайсан
Домик покосился и врос в землю Байшин маажийгаад газартаа суучихжээ.

935. **ВРАСТАТЬ (прирастать) КОРНЯМИ** Сурч орхи-, дасаж дада-, идээшил ав- П-1067

936. **ВРАЧУ, ИСЦЕЛИСЯ САМ** [*прост.*] өөрийгөө засаж байж өрөөлийг засдаг, хүнийг хэлэхээр өөрийгөө хар, бнеэ хичээ-

937. **ВРАЩАТЬСЯ В КРУГУ (кругах)** *кого, каком, каких* [*книжн.*] . . . -ний дүнд, . , . тангуудын дунд . . . -тай холилдож, бүслэлтэнд

938. **ВРЕЗАТЬСЯ В ПАМЯТЬ** Ой тойндоо оруулж ав-, санаандаа санаж шанаандаа зуу-, үхсэн ч мартахгүй бол-, насандаа мартахгүй яс чөмгөндөө ортол сана-

939. **ВРЕЗАТЬСЯ ПО УШИ** *в кого* [*прост.*] (Ямар нэг эрд буюу эмд) ухаангүй сэтгэлтэй бол-, бүр унаж ойчи-, унаж үхэ-, үнээ дагасан бух шиг, боддог нь нөгөөтөх, байн байн санаа алда-, зүүдлээд босон харайх шаха-, хоолноосоо гара-, тэр зүгийн тангэр нь хүртэл сайхан,(зүгээр зүгээр сууяа нь гэтэл зүүдэнд ороод болдоггүй, зүү хуруувчаа барнад үйл мэтгэх гэтэл зө-

рүү буруу хатгаад болдоггүй нь гэж ардын дуунд байдгийг сонаа.)

940. ВРЕМЁН ОЧАКОВА И ПОКОРЕНЬЯ КРЫМА Хуучны, ул болсон, элэр балрын, элэнц хуланцын, элэн хулангийн, дөш (дош) болсон

941. ВРЕМЯ КРАСИТ, БЕЗВРЕМЕНЬЕ СТАРИТ Цаг нь болоход цай нь буцлах, өөдлөхөд өнчин ишиг, уруудахад атан тэмээ, цаг цагаараа цахилдаг хөхөөрөө.

942. ВРЕМЯ НЕ ЖДЁТ Өдөр талийлаа, цаг талийлаа, цаг маныг хүлээх биш, түргэлэхгүй бол горигүй, үг олдож үхэр холдлоо

Время не ждёт, мы должны усилить темпы нашей работы Үг олдож үхэр холдлоо шүү, ажлаа түргэлцгээе (ажлаа шамдахгүй бол цаг маныг хүлээхгүй шүү).

943. ВРЕМЯ НЕ ТЕРПИТ Бушуулъя,түргэлье, шалвалзъя, цаг боллоо, цаг талийлаа. хөдөлж үзье, суугаад бүтэх биш, хүн хийгээд өгөх биш

944. ВРЕМЯ ОНО Элэнцгийн чинь (үхсэн элэнцгийн чинь), улирмал балармал

945. ВРЕМЯ ОТ ВРЕМЕНИ (ОТ ВРЕМЕНИ ДО ВРЕМЕНИ) Хааяа, заримдаа, хаа нэг, мэр сэр, байн байн, яваандаа, яваа яваандаа, алсдаа, тэгэж тэгэж, мөч өнгөрөх тусам, алдаг оног, ганц хоёр, тоотой,

Он время от времени заходит к нам Манайхаар хааяа ирдэг л юм

946. ВРЕМЯ ПОКАЖЕТ Яваандаа мэдэгдэнэ, аяндаа, сүүлдээ, эцэстээ, гайгүй цаг нь ирэхлээр, учрыг олж хужрыг тунгаана, цаг нь болох, цаг нь болж цай нь буцлах гэж бий

Кто прав, кто виноват-время покажет. Хэнийх нь буруу хэнийх нь зөв болохыг цаг л заагаад өгнө.

947. ВРЕМЯ РАБОТАЕТ НА НАС Цаг улирч л байвал манд ашигтай, улирах цаг манд л ашигтай, яаралгүй харж л бай.

948. ВРЕМЯ ТЕРПИТ Амжина, завдана, багтана, гайгүй байх, яарах юмгүй, юманд хөөгдсөн биш, ямар өнөө маргаашдаа гэсэн биш, шөнөд орой гүй, яваандаа, завандаа, гуйгаад ирнэ гайгүй, юу юугүй тулчихаа биш, цаг нь болоогүй байна, хүлээзнэ, байзна, азна, ингэсхийж бай

С этим вопросом время терпит, возьмёмся за следующий. Энэ асуудлыг нэг их яарах юмгүй, дараачийхы нь ярилцъя.

949. ВРЕТ (брешет, наврет, набрешет) КАК СИВЫЙ МЕРИН [*прост.*] Сүнсгүй худлаа хэлэх, далан худалч далан Чоймбоддох, гудиггүй (хэнэггүй) залах, балансэнгээ шиг, худалчийн хувилгаан хув ямааны цахилгаан, үнэмшихийн эцэсгүй, сонсоны гарз

950. ВРИ, ДА ЗНАЙ ЖЕ МЕРЫ Хирээ мэдэж, бяраа таних, (буухиа ч гэсэн бууж морддог шүү), буур ч гэсэн алцайж шээдэг

шүү, үзэж байж болох, байры нь таних, хирээ мэдэж бяраа таних, хөнжлийнхөө хирээр жий

951. ВРОДЕ КАК [*прост.*] . . . рхуу, . . . мэт, . . . шиг, . . . хэвтэй

После болезни его качало, вроде как пьяного Энэ эмгэг туссанаас л хойш согтуу хүн шиг л бие нь гуйвж дайваад (салгалаад) л байх болжээ. Энэ эмгэг туссанаас болоод үлгэн салган зүүд зэрэглээ шиг амьтан боллоо. Хөл дээрээ өндийж чадахгүй (тогтож чадахгүй)

952. ВРОЗЬ ИДЁТ ПОШЛО Саланга, тусдаа, алс хол, шал хөндлөн, этгээд мужийн

И снова дело врозь (Пушкин) Бас л хэрэг бишдлээ (дахиад л бүтсэнгүй).

953. ВСАДИТЬ НОЖ В СПИНУ Хэлэн дээр нь чихэр, шилэн дээр нь хутга. араар нь тави-,нүүрий нь үзээд долоох шаха-, нүд далд холио-, ард нь хутга билүүдэ-, наашаа харж инээх цаашаа харж хутга билүүдэ-, бөгсий нь уха-, жин тави-, улы нь шагай-, гэнэ аашилж гэм үйлдэ-

954. ВСАСЫВАТЬ С МОЛОКОМ В-1003

955. ВСЁ БОЛЕЕ И БОЛЕЕ Улам улам, улам л, шөнө хоногоор ихсэх, даамжрах, бүр, өдөр ирэх тусам, гар бариад бугуй барих, газар авах, хадандаа гарах, толгой дээр гарах,гүйцэгдэхгүй болох

Бой всё более и более разгорался Тулаан улам ширүүсэв (чангарав).

956. ВСЕ ВДРУГ Цугаараа, найзан дундаа, гангар гунгар хийгээд, хам хамдаа, хань ханиндаа,дэм дэмэндээ, дээс эрчиндээ олон гар хорон гэгчээр

257. ВСЁ ВДРУГ Бөөнөөр нь, нэгмөсөн, нэг доор, юутай хүүтэй нь нэг амьсгаагаар, нэгэн зэрэг

958. ВСЁ ВМЕСТЕ ВЗЯТОЕ Нийгэмдээ, нийтдээ, дүндээ, бөөндөө, хуудаа, цугаараа, бөөнөөрөө

Всё это вместе взятое Энэ буй бөөндөө

959. ВСЁ ВРЕМЯ [*разг.*] Ямагт, хэзээ дөрвөн цагт, насад, хэзээд хэзээ цагт, аварид, цаг ямагт, үргэлжид, цаг үргэлж, эгүүрид, ашид, түвт, завсарлагаагүй, байнга, эгнэгт, цагийн цагт завсар зайгүй, дандаа

Он старался рассказать нам, но мы всё время перебивали его вопросами Бидэнд бузгай нарийн ярьж өгөх гээд байхад нь (бид нар) олон юм асууж шалаад ярианий нь таслаад л байв.

960. ВСЕ ГЛАЗА ПРОГЛЯДЕТЬ [*перен.*] Юм эрж бэдрэн харж гөлрөх- нүдээ чилтэл эрэ-, нүдээ гөлөртөл хай-, баахан хараад, харж харж (олсонгүй),байдгаараа эрээд алагаараа хараад, арваараа тэмтрээд (олсонгүй) П-1107

961. ВСЕ ДО ОДНОГО (единого) Нэгэд нэгэнгүй, булгаар, (тэгээгүй). нэг ч үгүй, юутай хүүтэйгээ, нэг ч үлдэлгүй, хүүгий нь цөмийг сэтэрхий зүү сиймхий самбай, ханын ёроолд

өнөчин хүүхэд, харганы ёроолд өнчин ишиг үлдээлгүй гэг чээр гагц үг газар гээлгүй

962. **ВСЕ ДРУЗЬЯ-ПРИЯТЕЛИ ДО ЧЕРНОГО ЛИШЬ ДНЯ** Сайн явахад садан олон, саар явахад дайсан олон

963. **ВСЁ ЕДИНО** [*разг.*] Ив ижил, ав адил, эгээ нэг, огоот адил яг өвчнихсэн, хуулчихсан, гэрэлтүүлчихсэн

964. **ВСЁ ЕШЁ** Тувт, одоо болтол, өдгөө хүртэл, огт ... өдүй болтол, хэвээрээ л,-саар⁴, -аа⁴ (гүй), бас л, янзаараа, байдгаараа, өглөөгүүр, дээр нартай, залуугаараа, нялхаараа бахь, байдгаараа, ялгаагүй

Всё еще не приехал. Одоо болтол ирээгүй л байна.

965. **ВСЁ ЖЕ (ВСЕ Ж)** Тэгэж тэгэж, явж явж, тэгсээр байгаад, -сан⁴дээ, адаг сүүл дээ л, сүүлдээ, тэгээд сүүлдээ,яваандаа, шогто тулахад

Всё же вы неправы Тэгж тэгэж та л буруут шүү.

Он всё же согласился Тэгээд сүүлдээ (бөгсөндөө) тэгэх болсон.

А все ж он не в убытке (Пушкин) Тэгсэндээ ч амь хохироогүй гарсан

966. **ВСЕ ЗАВИСЯЩИЕ МЕРЫ** Арга бүхнээ хэрэглээд, чадах бүхнээрээ,хазахаас бусдаар, эр хүний арван гурван мэхийг дуусч байж, арван гурвынхаа адаг сүүлий нь үзэж байж.

967. **ВСЕ И ВСЯЧЕСКИЕ (ВСЕ И ВСЯ)** Тэр чигээр нь, эрс шууд, яах ийх гэх юмгүй, хамаг байдаг, хотол, хуу, аливаа, бүх, дая, зон элдэв зүсэн зүйлийн, эсэн бусын, элдэв дээдийн

Срывать всё и всяческие маски с врага Дайсны али ваа багийг хуулж хая-

Действуйте смелей, громите все и вся мешающее вам в работе, не стесняйтесь. (Кочетов, Журбины) Зорьсон юмаа эр хүн шиг хий, явдал хийдэлд тэнь түйтгэр болдог бүхнийг зад татаад гар, бүү мятрагтун.

968. **ВСЕ ИДЁТ СВОИМ ПОРЯДКОМ** Байдгаараа л байж байна, хонины ээлж шиг л, хуучин хэвийн мэнд л, цөм зүй номоороо л, жамтай юм жамаараа л байна.

969. **ВСЁ К ЛУЧШЕМУ** Яах вэ болно болно, бүтэхээ л нэг бүтнэ нэг өөх үмхэх цаг бий, долоо дордож найм сэхнэ.

970. **ВСЁ КАК ОДИН** Нэг хүн шиг, дуугарвал дуу нэг, дугтарвал хүч нэг, нэг амьсгаатай, нэг морьтой, нэг дээлтэй, үхрийн бөөр шиг, санаа нийлж самбаа хослуулах

971. **ВСЕ, КОМУ НЕ ЛЕНЬ...** [*разг., фам*] Тэгье гэсэн болгон, юу сайхан, дур сайхан, өөрийн зориг мэдэг, дурд шаргүй, дур өзнээ голдоггүй, дунд чөмөг сүүжээ голдоггүй

Его обижали все, кому не лень Тэрнийг хууръя гэсэн хүн болгон л хуурчихна (мань эрийг маллаж чадахгүй хүн гэж байхгүй).

Присоединяйтесь к нам все, кому не лень Нэгдэе гэсэн болгон нэгдэгтү. Юу сайхан дур сайхан.

972. **ВСЕ МЫ ЛЮДИ** *буюу* **ВСЕ (мы) ЧЕЛОВЕКИ** [*прост.преннебр.*] Ямарч аавын хүү, хэний хэн гуай ч, дээр дооргүй,Гэм бүхнээ барсан хэн байх вэ, хэн нь ч хүн болсон хойно алдаж онолгүй яах вэ, цөмөөрөө л яс маханд төрсөн юм хойно, сайтай муутайгаа сархинаггай баастайгаа холимог байлгүйдээ

973. **ВСЕ НАРУЖУ** Ив ил, илэн далангүй, нуух хаах юмгүй

974. **ВСЕ ОДНО** [*прост*] **ВСЁ РАВНО** Адилдаа адил, годилдоо годил, тэртэй тэргүй (адил), нэг үг, дүндээ дүн, эгээ нэг, ив ижил, ямарч атугай, ялгалгүй

Мне все равно Би (надад) хамаагүй, над аль нь ч яах вэ?

Ей все равно, что бы ей ни говорили. Юу гэж хэлсэн (цаатахи чинь) адил даа (сайн ч бай, муу ч бай ив ижил) Илжигний чихэнд ус хийсэн ч адил, алт хийсэнч адил сэгсрэнэ

Я все равно, я не соглашусь с вами Юу ч атугай би л тэг гэхгүй.

Я все равно не пойду Тэртэй тэргүй би явахгүй л юм хойно (чинь)

975. **ВСЕ ОДНО РАВНО (едино) ЧТО (как)** Мэт, шиг, хэвтэй,

976. **ВСЕ (мы) ПОД БОГОМ ХОДИМ** Үхлээс даваж гарах хэн байх вэ? тэнгэрийн тааллыг нугалж хэн чадах вэ? Мөнхийн усыг уусан биш, Насан шидийг (хутгийг) олсон биш, эрлэгийн өөдөөс эгц харах хэн байх вэ?

977. **ВСЁ ПРО ВСЁ** Хамаг байдгийг, бүхлээр нь, хуу тажаар нь

978. **ВСЕ ТАК** [*разг*]. За яах вэ тийм л байж, тэгж л байг, тийм л болог, тэглээ ч гэсэн, за тийм л болог

Всё так,однако и вы виноваты Тийм бол тийм л биз, тийм л байлаа ч гэсэн, ер нь л таны буруу даа

979. **ВСЁ ТЕЧЁТ, ВСЕ ИЗМЕНЯЕТСЯ** Юм бүхэн улхирч, юм бүхэн хувьсч байдаг, орчлон мөнх бишдээ, цаг цагаараа цахилдаг хөхөөрөө байдаггүй.

980. **ВСЕ УШИ ПРОГУДЕТЬ** *кому* Чихэнд чийртэй, чих дөжрүүлэ-, чих амар байлгахгүй, тархи толгой хагачичих гэдандаа шал нал хийгээд чихэнд хонх уя, чих халамцуул, чихний үдээр тасалсан

981. **ВСЕ ХОДЫ И ВЫХОДЫ (ходы-выходы)** 3-328

982. **ВСЕ ХОРОШО, ЧТО ХОРОШО КОНЧАЕТСЯ** [*посл*] Шидий нь үзэж байж л мэдэхээс биш, тэгсэн хойно нь л үзье, ид шидий нь үзэж мэдье

983. **ВСЕ ШИШКИ ВАЛЯТСЯ** *на кога* Муугаа үзэж мундраа хутгаж байх, үйлээ үзэж, үсээ тоолох-, тарчлах гэдгийг үзэж явах

984. ВСЕГО ДОБРОГО (лучшего)* [*разг.*] (салж явахдаа ерөөж өгүүлэх ёсны үг) баяртай, сайн сууж байгаарай, мэнд сайхан, цайгаа чанаад тавьж байя, за сайхан сайхан,

Всего доброго Я должен торопиться, иначе опаздаю. За сайн сууж байгаарай. Би түрэгл ахгүй бол хожимдчих нь байна.

985. ВСЕГО-НАВСЕГО [*разг.*] Буйгаараа л, байгаа нь л, ердөө л ... хан, өдүйхэн, уртаашаа л хэдхэн

У меня осталось всего-на всего несколько рублей. Над хэдхэн л рубль үлдээд байна.

986. ВСЕГО ХОРОШЕГО Баяртай (явж байгаа хүн бол)сайн сууж байгаарай, сайн морилж байгаарай (ард нь хоцорч байгаа хүн бол) сайн яваарай, аян замдаа сайн яваарай,сайн мори лоорой, сайн морилогту-, зам чинь өлзийтэй болог, сааталгүй яваад сайн хүрээрэй, сааталгүй явж сааралгүй жаргаарай

987. ВСЕ ДУШОЙ (сердцем) (всем сердцем) Чин сэтгэлээсээ, үнэн дураар, толь зүрхнийхээ угаас, үнэн голоосоо

988. ВСЕМ ВЗЯЛ (взяла и. т. п.) Хирээрээ, гараа гаргаж, эрвийх дэрвийхээрээ, сайн юм бүгдийг, олигтой болгон, чадах чинээгээрээ, чадахынхаа хирээр, өнгөтэй тоотыг, өнгөтэй өдтэйгээ

989. ВСЕМ И КАЖДОМУ Хүн бүрд, толгойтой бүгдэд, нэг ч хүн хоцроолгүй, хүн дутаагуузай, толгой дараалан

990. ВСЕМ МИРОМ Нийтээрээ, нийгмээрээ, нийлээд, нэгмөсөн,бөөнөөрөө, олуулаа, хотлоороо, даяараа, булталараа

991. ВСЕМИ ПЕЧЕНКАМИ [*прост.*] Үнэн голоосоо (жигших) бүр яснаасаа, дотор зүрхнээсээ

992. ВСЕМИ ПРАВДАМИ И НЕПРАВДАМИ (добиваться) *чего* [*разг.*] Элдэвлэж байгаад, зөв ч бай буруу ч бай зүтгээд л, баруун солгоогүй, учир начиргүй, нэр нүүргүй (зүтгэх), улайдаа тулах, улаан цайм, ичиж зовохгүй, ичих нүүргүй, шүлдгэнэн халдаганан

Он всеми правдами и неправдами добивался повышения по службе (Тэр эрэгтэй) нэр нүүргүй хөөцөлдөж байгаад хэргэм дэвшиж авсандаа

993. ВСЕМИ СИЛАМИ ДУШИ [*разг.*] Үнэн голоосоо, яснаасаа

994. ВСЕМИ ФИБРАМИ (силами) ДУШИ үнэн голоосоо, яснаасаа

Ненавидеть всеми фибрами души яснаасаа үзэн ядах

995. ВСЕМИРНЫЙ ПОТОП Усан галав, усаар галав юүлэх

996. ВСЕНАРОДНЫЙ ОПРОС Түмний шийд олны зориг, бүлээн усаар угаахул хиргүй, бүгдээрээ хэлэлцэхүл буруугүй

* Монголын энэ үг төлөв баахан үртын аянд одох хүн хэлдэг үг боловч түр салахад ч үлдэж байгаа хүнд хэлэхэд утга шилжүүлсхийн орос хэлний энэ хэллэгт снооход болохгүй гэх газаргүй.

997. ВСЕХ БЛАГ [*разг.*] Дараа баяртай, сайн сууж байгаарай, сайн яваарай.

998. ВСЕХ И КАЖДОГО Бүх хүнийг, хүн болгоныг, толгойтой бүрийг, цемийг, толгой дараалан, толгойтой тоотыг, толгой тоолонг,

999. ВСЕХ НАВСЕХ Ердөө л ганц, уртаашаа, байгаа нь л

1000. ВСКИДЫВАТЬ ГЛАЗАМИ (глаза) Өдөө хара-, өөдөөс нь хара-.

1001. ВСКОЧИТЬ В КОПЕЙКУ [*разг.*] Мөнгө бара-, мөнгөө идэ-, мөнгө дайргада-, мөнгө бүрэлгэ-, үрэн таран хий-, мөнгөөр туйла-, мөнгөөр гараа угаа-

1002. ВСКРУЖИТЬ ГОЛОВУ *кому чему* Толгой нь эргэ-, толгойгий нь эргүүл-, сага-,сагсуура-,тархи гашла-, ташуура- З-184

Успех вскружил ему голову Амжилт нь толгойгий нь эргүүлжээ, овоо болохтойгоо зэрэг сүс нь хавиргаа дэлсжээ (шилбэ нь тэнийхэд цөс нь бөсчээ).

1003. ВСОСАТЬ (впитывать) *что* **С МОЛОКОМ МАТЕРИ** Нэг настай нялх үстэйгээсээ (үстэйгээсээ) (сурсан сургуультай, дадсан мэдсэн) хар багаасаа, хар нялхаасаа, хүн болж хүзүү толгой зүүснээсээ хойш, мэдээ орохоосоо, цоорхой зулаагаасаа, зулаа нь битүүрэхээсээ, хөлд орохоосоо, хөлд орохоосоо В-954

1004. ВСПЛЕСНУТЬ РУКАМИ (в ладоши) (Гайхах-, арамсах-, шагших- зэргээс монгол хүн гараараа өвдөг гуяа зөөлөн алгадан дэлсдэг шиг европ хүн хоёр алгаа нэг ташин салгадаг үүнийг хэлж буй) шагшин гайха-, сүүрс алдан гайха-

1005. ВСПЛЫВАТЬ (в памяти) Санаанд оро-, санагда-

1006. ВСПЛЫТЬ (всплывать) НА ПОВЕРХНОСТЬ (наружу) [*разг. перен*] Эрхбиш ил гар-, дарсанч дардай-, булсанч булгай-, уулын чинээ харыг туулайн чинээн цагаан гүйцнэ, алгаар нарыг халхла-, ил байгаа нарыг алгаар хаагаад дэмий, сүрийг ухуулахад сүнс нь дэгдэ-,

Правда всплыла на поверхность, как её ни старались скрыть Үнэн юмыг яаж ч дарах гээд дарсан ч дардайж булсан ч булгайлаа.

1007. ВСТАВАТЬ (встать) ПЕРЕД ГЛАЗАМИ Ил бол-, тулж ирэ-өмнө нь ил бол

1008. ВСТАВЛЯТЬ (ставить, втыкать) ПАЛКИ В КОЛЕСА [*разг.*] Саад тави-, саад хий-, төвөг уда-, тотгор хий-, түйтгэр бол-, хориг тави-, чагтла-, чөдөр тави-, гүйх нохойд гүйхгүй нохой саад, мөр дээр тээглэ-С-191, В-1059

1009. В ТАТЬ (стать) ГРУДЬЮ С-871

1010. ВСТАТЬ НА ДОРОГЕ (пути) *буюу* **СТАТЬ НА ДОРОГЕ (пути)** Замын саад, чөдөр бол-, саад бол-, тотгор бол-, мөр дээр тээглэ-, гүйх нохойд гүйхгүй нохой саад С-835

1011. ВСТАТЬ (стать) НА ДЫБЫ Пээ пүү гэ-, их дургүйцэ- хавьтуулахгүй, халгахгүй, зангүй, тэгж үхсэнээс тээглэж үхсэн

нь дээр, -.. хол байна, ... өдүй байна, ... ч зай байна, үстэй толгой нь арзай-, нэг нүдээр үзэхгүй, дуулах ч үгүй, холоо хэвтэнэ, санахын халцгай, яснаасаа цээрлэ-С-1011

1012. **ВСТАТЬ НА НОГИ** 1. Зогсо-, бос-, 2. Толгойгоо даа-, биеэ даа- өөрийн эрхтэй бол-, өөрийнхөө хийморийг өөрөө хийсгэ-

1013. **ВСТАТЬ ПОРАНЬШЕ, ДА ШАГНУТЬ ПОДАЛЬШЕ** Эрт босвол нэгийг үздэг орой унтвал нэгийг дуулдаг.

1014. **ВСТАТЬ** (вставать) **С ЛЕВОЙ** (не с той) **НОГИ** [*разг. ирон.*] Уруу царайла-, урвайж гүйцэ-, дотор гонсгор, урам муутай, бүлх залгисан юм шиг, гутал нь хавчаа юу, хоёр эхнэртэй юү гэгч бол- гуниж гуншиж яв, царай алда-, урам хугара-

1015. **ВСТРЕТИТЬ В ШТЫКИ** П-1043

1016. **ВСТРЕТИТЬ ПО ПЛАТЬЮ** *кого* Өнгөдүү зан гарга-, царайчла-, зусарда-, өнгө тал хара-, өнгө хара-, дээлийн өнгөөр бол-, өнгөнд хуурта-хувцас бурхан, бие яөтгөр гэгч бол- өнгийг хүндэд үзэ-

1017. **ВСТРЕТИТЬ С РАСПРОСТЁРТЫМИ ОБЪЯТИЯМИ** Хүнд тэйеэ морилуул-, их ямба ёстойгоор угта-, хүнд ихтэй хүлээн ав-

162. **ЗАЖИМАТЬ (зажать) В КУЛАК (кулаке)** Эрхэндээ байлга-, гартаа атга-, зад атга-

163. **ЗАЙТИ В ГОЛОВУ** Сэтгэгээс нэг юм уяатай, үргэлж бодогдо-, .. (юм) санааны мухарт л бай-, гиюүрэн санагалза-санаанаас (сэтгэлээс, бодлоос) гарахгүи, сэтгэлд хоногши-

164. **ЗАКАДЫЧНЫЙ ДРУГ (приятель)** [*разг*] Дотны хань, баруун гарын нөхөр, бат журамтан нөхөр, анд нөхөр, анд найз, сайн түнш, ганц ходий хүн, их ходий, амь хүн, сайн нөхөр.

165. **ЗАКАЗЫВАТЬ (заказать) ПУТЬ (дорогу)** [*прост*] Оруулахгүй, хавьтуулахгүи, халгаахгүй, хорио хий-.

166. **ЗАКАТИЛАСЬ ЗВЕЗДА** *чья, кого* Одгүй болох, заяа муудах, тэнгэр нь хаях (орхих), заяа нь хаях, мэнгэ нь голлох, аз хаях, хийморь үхэх, өөдлөхөө байх (болих), өөд нарын бараа харах заяагүй, өөд нар үзэх заяагүй

167. **ЗАКАТИТЬ ГЛАЗА** [*перен*] Нүдээ цагаанаар эргэлдүүл-, нүд цэхий,- тогтворгүй нүдтэй, нүдээ бүлтэлзүүл-

168. **ЗАКАТИТЬ ПЛЮХУ** З—157, Д-91

169. **ЗАКАТИТЬСЯ СМЕХОМ** З—208

170. **ЗАКИДАТЬ ГРЯЗЬЮ** З—89 С-565

171. **ЗАКИНУТЬ (закидывать) СЛОВЕЧКО (слово)** [*разг*] Бултаганууллаад өнгөрө-, цухас дурда-, цухайлгасхии-, дурдаад өнгөрө-, далимаар хэлэсхий-, дурдаад өнгөрө-, товч өгүүл-,

Будете у ректора, закиньте словечко обо мне. Захиралд бараалхахдаа, далимаар нь намайг нэг цухас хэлээд орхиорой. З-218

172. **ЗАКИНУТЬ УДОЧКУ** [*разг перен*] (Дотроо бодолтой байгаад) янзы нь мэдээд орхи-, нэг үзээд орхи-, асуугаад (хэлээд) үзэ-, нэг үзээд алда-, болбоо нь нэг тэгээд орхи-, түншээд орхи-, юу гэх нь вэ? туршаад үзэ-, янзы нь үзэ-, яадаг юм гэж сори-, танд..-, янзы нь тани-

В разговоре, между прочим, закинули удочку и о возможности получения добавочного угля. Ярьж байх хоорондоо, далимаар нь, нэмэж нүүрс авч болох уу үгүи юү гэж нэг янзы нь мэдээд орхив

173. **ЗАКЛЕЙМИТЬ ПОЗОРОМ** *кого* [*книжн.*] Шившгий нь дууда-, зад загна-, улаитал хэлэ-, гүжирмэглэн өгүүлэ-

174. **ЗАКЛИНАТЬ ВСЕМ, ЧТО ЕСТЬ СВЯТОГО НА СВЕТЕ** *кого, кем-чем* [*высок*] хормои дэвсэн гүи-, хошуу цорвоин гуй-, гуйна гэмээ гүи, духаа цоортол мөргөж гүи-, ард нь гарч алгаа тосч, урд нь гарч уруулаа унжуулч-.

175. **ЗАКЛЮЧАТЬ В СЕБЕ** д баина, (тиим юманд иим юм байна гэсэн санаа илгэнэ)

Письмо заключает в себе важные сведения. Захидалд (бичиг) чухал мэдээ баина

Вопрос заключает в себе трудности. Энэ явдалд зовлон баина

176. **ЗАКЛЮЧИТЕЛЬНЫЙ АККОРД** [*книжн перен*] *чего, к чему* . ий сүүл нь болох, ын шувтрага, ын отго,-аар[4] шувтрах

177. **ЗАКЛЮЧИТЬ ПОД СТРАЖУ-ВЗЯТЬ ПОД СТРАЖУ.**

178. **ЗАКОВАТЬ В ЖЕЛЕЗО** *кого* Гинжлэ-, (гарт нь) гав торго-, гарт нь гав хөлд нь дөнгө зүү-,

179. **ЗАКОЛДОВАННЫЙ (порочный) КРУГ** [*филос.*] орчих ес орчлонд орчиж, хорвоод хоргох, [*перен*] мухардах, гарах замгүй болох, хагацашгүи зовлонд орох, хөмөрсөн тогоонд, ... ны хавханд

Попасть в заколдованный круг. Зовлонгийн талхинд лав шин оро

180. **ЗАКОН ДЖУНГЛЕЙ** бөөсөнд хутга, бөлдгөнд сэлэм, шаазанд сүх, диилдэг нь дэрвиисээ барьж идэх, хүчтэний дэргэд хүчгүй нь буруутан

181. **ЗАКОН НЕ ПИСАН** *кому буюу для кого* [*разг*] Хуульгүй, (хүн), ес мэдэхгүи (эр), цагдлагагүй (хүн), захиргаагүи, хөлөөрөө толгой хинсэн (эр), цадигаа алдсан, цадиггүи, танхай балмад, дэглүй, аих ичихээ алдсан, эх захгүй, гурим журимгүи, дүрэм журамгүй, ах захгүй, замбараа замбараагүй, салхи зангисан, будлианы хөрөнгө, хэргийн эзэн, хэнгэргийн дохиур

182. **ЗАКРАДЫВАТЬСЯ (закрасться) В ДУШУ (в сердце)** *кого, чью к кому* санаанд юм оро-, сэтгэлд урга-, сэтгэлд . төрө-, юу юугүй бодогдо-, дотор хачин бол-

183. **ЗАКРУЖИЛО В ГОЛОВЕ** Толгой эргэв, дотор балартав, дотор муухаирав, дотор харанхуйлав, толгои дүүрэв, толгой мансуурав, ухаан балартав, дотор муухай оргив, тархи дүүрэв.

184. **ЗАКРУЖИТЬ ГОЛОВУ** В—1002

185. **ЗАКРУТИТЬ (завинтить) ГАЙКИ** [*прост.*] Чандлан бари-, чангалан тулга-

186. **ЗАКРУЧИВАТЬ (завинчивать) ГАЙКИ** З—185

187. **ЗАКРЫВАТЬ ГЛАЗА (на что)** Нүдэнд (нь) өртөхгүй, огт тоохгүи, хэнэггүй юман чинээд бодохгүи, үл оишоо, хаихрахгүи бан-, үзсэн шинжгүи, харсан шинжгүи, тоохгүй, тоомсоргүи, тоосон шинжгүи

188. **ЗАКРЫЛАСЬ ЛАВОЧКА-К**—437

189. **ЗАКРЫТЬ ДУШУ НА ЗАМОК** Битүү бай-, дотроо хадгала, далд байлга

190. **ЗАКРЫТОЕ МОРЕ** Битүү тэнгис

191. **ЗАКРЫТОЕ УЧЕБНОЕ ЗАВЕДЕНИЕ** Битүү сургууль

192. **ЗАКРЫТЬ (закрывать) ГЛАЗА** *на что* [*перен.*] Хаиш яиш, алмаира, үл үзэгч бол эс хараачин бол, нүдэн балан чихэн дүлии тэгсэн ингэсэн бол-, нэг юм тэгэмшээ бол- 2. хөндии хүнтэн хүниирхүү

193. **ЗАКРЫТЬ ГЛАЗА** *кому* 1. (үхсэн хүний) нүдий нь анна, 2 [*разг. перен.*] оршуул, хөдөөлүүл-

194. **ЗАКРЫТЬ ДВЕРИ ДОМА** *кому буюу для кого* ирж очихгүи бол, хөл хорн-, хүн урьж золгохгүи, урилга заллага хинхгүи, заллага аилтгахаа бан-

195. **ЗАКРЫТЬ КЛАПАН** [*груб. прост.*] Амаа тата-, яриагаа боли-, яриагаа тата-,

196. **ЗАКУСИТЬ УДИЛА** [*разг.*] Амгай жолоогүй аашла-, амаа мэдэхгүй морь шиг, захиргаагүй, дураараа тонгочдог, ихээхэн туил, зоригоороо аашла-, ядгаир

197. **ЗАКУСИТЬ ЯЗЫК (ПРИКУСИТЬ ЯЗЫК)** Амаа тата, үгээ цөөлө, юм ярьж баиснаа бай, хэл нь татаж байгаа юм шиг дуугүи бол-, хэлээ огтлуулсан үхэр шиг, дуугаа хураа- амаа хамхи-, хэлээ хаза-, амаа жимии, үг дуугүи, чимээ чирээгүи, ганц ганхийхгүи, амандаа ус балгасан юм шиг, амнаас нь алт (юм) уначих гээд байгаа юм шиг, үгээ залги-

198. **ЗАЛАДИЛА СОРОКА ЯКОВА (одно про всякого)** Улиглах, бахь байдгаа ярив, хивдсээ хивэв, нэг юмаа яриад салахгүи, нэг ярьснаа долоо (арван гурав, түм) дахив, домогтоо улиглав, улигтаа улиглав,

199. **ЗАЛЕЗАТЬ В КАРМАН** *чей, к кому* [*прост.*] Завши-, хүний юмаар хүүдэгнэ, хүний юманд хүнтэн гар оруул-.

200. **ЗАЛЕЗТЬ В ДОЛГИ** өр үстэй толгойноос их бол өрөнд баригда, өртөж хоцоро-, өр гэж үстэн толгои, үснээсээ олон өртэй, дороос нь босошгүй өртэй, дороос нь өндийшгүи өртэй, хойт насан аа ч төлшгүи өртэй, өр мянга хүрэхэд санаа амрана гэгч бол

201. **ЗАЛЕЗТЬ В ДУШУ** *кому* [*прост.*] 1.(хүнийг) сүрхий тойгло-, өөртөө итгүүл, өөрингөө саин хүнд бодуул-, ятгалагандаа оруул-, толгоигии нь эргүүл, биедээ элсүүл, 2. Үгии нь гаргуул-, санаагий нь мэдэ, бодлы нь төсөөлө-. В 676, 1051

202. **ЗАЛЕТЕЛА ВОРОНА В ЦАРСКИЕ ХОРОМЫ** 1. Тэнгэрийн умдаг атгав 2. Хирээ мэдэж бяраа т инхгүи загнав Дэндүү дөвчигнөв Сачии нь хүрэхгүи байж санаархав Шал чөмөггүй туг ширээ, саваагүи нохои саранд хуцав

203. **ЗАЛЕТЕТЬ ВЫСОКО (далеко)** [*разг. фам.*] (Хэргэм тушаал) дээр гар- их дэвши суудал ахи-

204 **ЗАЛИВАТЬ (залить) ГЛАЗА** [*груб-прост.*] Согттол уу-, хөлчүүртэл уу

205. **ЗАЛИВАТЬ (залить) ШАРЫ** З—204

206. **ЗАЛИВАТЬСЯ (разливаться) СОЛОВЬЁМ** [разг.] Сайхан үг хэлэ, гоо ам, гоодо, бэлэн ам хэлэ, цээжнии хонжоо, гоечло-, манж үг хэлэ манжирха Р 74

207 **ЗАЛИТЬ ГОРЕ** Архиар уи гашуу таила, архиар уитгар сэргээ-, архиар сэтгэл билчээ, сэтгэлиин зовлонгоо архиар хуура-, сархадаар санаагаа сатааруул, уйтгараа архиар мяла, гаслангаа гашуунаар даруул

208. **ЗАЛИТЬСЯ (закатиться) СМЕХОМ** Элгээ хөштөл инээ элэг хатан инээ их инээ, бэгдрин инээ тамираа тасартал инээ-, дуугарч чадахгүй болтлоо инээ З-169

209 **ЗАЛОЖИТЬ (закладывать) ЗА ГАЛСТУК** [*прост. шутл.*] Архинд халж ирэ-, улаан зээрд бол, яҫны хөлс гар-, зориг оро-, дөрөө чангала

210. **ЗАЛОЖИТЬ СКЛАДКУ** (үнл хийхэд юманд) нугалаа гарга-,

211. **ЗАЛОЖИТЬ ЧЁРТУ ДУШУ** [*шутл. неодобр.*] арчаагүй бэртэгчлэ-, сэтгэлээ хиртээ-, нисванисын эрхэнд авта-, хар амиа хичээ-, хар амиа бодо-, буруу авьяасаар нэрвэгдэ-

212. **ЗАЛОМИТЬ ЦЕНУ** Үнии нь дээр гарга-, үний нь хадаа-, үнэ арилаад (талингаад) өг, үнэ дийлдэхгүй болго-.

213. **ЗАЛОМИТЬ ШАПКУ** малгай хэлтгии тави-, малгай духдуул-

214. **ЗАМАЗАТЬ РОТ** З—270

215. **ЗАМАЗЫВАТЬ (замазать) ГЛАЗА** *кому* (*груб-прост.*) Нүд хуура-, араар нь тави-, нүд хариул-, хуура-.

216. **ЗАМЕСТИ (заметать) СЛЕДЫ** Зам битүүрэ-, мөр булагда-, мөр балла, мөр мэдэгдэхгүй бол барих баримтгүй болго-, буух эзэн буцах мөргүи болго-, гэрчлэх гэрчгүи болго,

Вьюга замела все следы и мы заблудились. Цасан шуурга огт зам мөр мэдэгдэхгүй болгочихоод бид төөрөв. **Замести следы преступления.** Хэргийнхээ мөрийг балла

217, **ЗАМКНУТЬСЯ (замыкаться) В (самом) СЕБЕ** хүнээс даажихүнээс буруул-, хөлөөс зайл, хар толгойгоо хөө, амиа хөө-.

218. **ЗАМОЛВИТЬ СЛОВО (словечко)** *у кого перед кем, за кого, что* З—171

219. **ЗАМОЛОТЬ ЧЕПУХУ** Дэмий чалчи-, донгос-, амныхаа хэмжээ гээр бура-, амаа ура-, салхи зажил-.

220. **ЗАМОРИТЬ ЧЕРВЯЧКА** [*разг*] Хоол болтол шийр зугаа, хоол болтол гол зогоох юм, хүнс гаргатал эргүү маагуу;

221. **ЗАМУЖ ВЫХОДИ-В ОБА ГЛЯДИ** Хэнийд очихыг хэрсүүгээс, хадмын болохыг хашраас

222. **ЗАНИМАТЬ ПОЛОЖЕНИЕ** (Ниигэмд) байр суурьтаи бол-, эрх мэдэлтэй баи-, хүний тоонд оро-, өөрийн мэдэлгэи бол-

223. **ЗАНИМАТЬСЯ СОБОЙ** Цэмцэгнэ, хялгас ч халдаахгүй. Б-504

224. **ЗАНИМАТЬСЯ ТОЛЬКО СОБОЙ** Амиа бодо-, хувиа бодо-, амиа хөө-, хар толгоигоо бодо-, хашир тулдаа амиа авч явах гэгч, хувиа бодож довоо шарлуул, хар амиа хичээ мөрөөрөө мөргө-, хүртсэн хувиа борлуу-, хувиа аргацаа, хувиа хичээ-.

225 **ЗАНЯТ ТОЛЬКО СОБОЙ** Амиа хөө-, аминыхаа ажлыг хөөцөлдө- хар толгоигоо бодо- хар амиа хоохоил-, амь зулба амиа аргацаа-

226. **ЗАНЯТ-ПЕРЕЗАНЯТ** Борви бохисхийх завгүи, ажил гэж аяганы амсар зуух завгүй, ажил зогсоо чөлөөгүи, зогсоо заигүй шээх завгүй, хоер нарны хооронд холхин, нойр хоолгүй зүтгэж, муу эмд уйлах завгүи гэгчээр

227. **ЗАПАС ХОДА** (аян даины их тэрэг) зорчих зам гудас

228. **ЗАПАСТИСЬ ТЕРПЕНИЕМ** Тэвчихэд бэлэн, хэзээ ч тэвчихээр хүлцэе хэмээн, сүмэр (сүмбэр) уул шиг, шүд зуун, бул чулуу шиг

229. **ЗАПАХЛО ПОРОХОМ** Даин хөлийн шинжтэй болов, дайн болохын шинж оров, цаг төр үймэхиин ер ерлов.

230. **ЗАПАЧКАТЬ РЕПУТАЦИЮ** (доброе имя) П-40

231. **ЗАПЕЛИ ПЕТУХИ** В-1058

232. **ЗАПЕЧАТАННАЯ КНИГА** Битүү дэвтэр, дармал нууц, таг дарсан нууц, задраагүи хэрэг

233. **ЗАПЕЧАТЛЕТЬ ПОЦЕЛУЙ** (*на чём*) Адис ав-, магнайд хүргэ-, (Европын соелд үлэмж нөлөө өгсөн Христосын шашны холбогдлоос болж, Европ нар юмыг хүндэтгэн авах, éслох, цэргийн тангараг тангараглах зэрэгтээ үнсдэг заншилтай, монгол хүн энэ мэтэст магнайн баяр болгож магнайдаа уул хүндэтгэсэн юмаа хүргэх буюу магнайн тус газар ойртуулсхийдэг заншилтай Цэргиин тангараг өргөхдөө ч тугаа магнайдаа хүргэвэл хүндэтгэл нь улам их болно)

234. **ЗАПЛАТИТЬ ГОЛОВОЙ** *за что* Толгойгоо өг-, амиа золиамиа өг-.

235. **ЗАПЛЕЧНЫЙ МАСТЕР (ЗАПЛЕЧНЫХ ДЕЛ МАСТЕР)** Зандалчин, алуурчин, яргачин, хядаачин, нүгэлт хар гөрөөчин шиг, хороогч, амьтан хөнөөхийн донтон, улайд дуртай хэрээ шиг.

236. **ЗАПРАВЛЯТЬ АРАПА** [*прост.*] дэгс дэгс яриа яри-, хийтэй яри-, даваадуулж давс хужры нь нэмэ-, дутуу дуулаад гүйцээж яри-

237. **ЗАПРЕТНЫЙ ПЛОД** горь төдүй, гол тасартал горь тасрахгүй гэгч, ерөөл тавиад л суух юм,

238. **ЗАПРЯЧЬ В ОДНУ УПРЯЖКУ** [*прост*] Багла-, зангида-, нэг бөөн боо-, багцал, хуйл-, баадагна-, завхайл-, тэн хий-. бөөмнүүл-.

239. **ЗАПУСТИТЬ БРАНДЕР** (брандера) [*перен разг*] хэрүүл өдө-, яс хая хооронд нь ура-, хоерыг хагалж гурвыг гутаа- П-547

240. **ЗАПУСТИТЬ В ПОЕ ГУСАРА** (Дүрсгүитэж) чихэнд (цаас) өвс имрэ-, цог үмхэ-, чоно зайдла-, сормосоо хярга-, хүйсээ хатга-, хамарт нь тамхи татуул-, сүүлэн доогуур нь чичи-

241. **ЗАПУСТИТЬ ГЛАЗА** *куда* [*разг*] Хулгайгаар хара-, нууцгаигаар хара-, нүд хариулж хара, нүдний булангаар үзэ-

242. **ЗАПУСТИТЬ КОГТИ** (руку. лапы) *во что* [*разг*] Базаж ав-, самардаж база-, гараа шургуулан чимхэж ав-, [*перен*] гар дүрэ-, хуруу дүрэ-, сүүнд нь хормой дүрж, сүрэгт нь уурга бари-,

243. **ЗАРАСТИ МОХОМ** О-38

244. **ЗАРЕКОМЕНДОВАТЬ СЕБЯ** Юу чаддагаа үзүүл-, чаддагаа гайхуул-, эрдмээ үзүүл-, эрээ гайхуул-, ид шидээ үзүүл-.

245. **ЗАРОНИТЬ ИСКРУ** (зерно, семя) [*книжн*] сэтгэл татасэтгэл хөдөлгө-, хорхой хүргэ-, нүд булаа, нүд сугала-

246. **ЗАРУБИТЬ НА СТЕНКЕ** Санаандаа санаж шанаандаа зууж ав-, бодлынхоо мухарт хий.

247. **ЗАРУБИТЬ СЕБЕ НА НОСУ** (буюу на стене на лбу) [*разг. фам.*] За чи сайн санаж аваарай! Мартваа чи!

Зарубить себе на носу, что я не потерплю халатного отношения к делу. Ажилд хам хум байвал би ер даахгүй шүү! (Ажилд хайш яйш байгаад баивал тэсч байж чадахгүй шүү!)

248. **ЗАРЫТЬ ТАЛАНТ В ЗЕМЛЮ 1** Авьяасныхаа хэргий нь хийсэнгүй Авьяасныхаа идий нь хийгээгүй, эрдмээ (сурснаа) мийн хумс мэт нуу- 2 [*ирон*] Гэлэнгээ гэр дээрээ тавьсан

У него большие способности к живописи, но он зарыл талант в землю. Зургийн дүйтэй байсныхаа идий нь хийсэнгүй.

249. **ЗАСВИДЕТЕЛЬСТВОВАТЬ ПОЧТЕНИЕ** *кому* Хүндлэ-, дээдлэ-, өргөн хүндлэ-, оройн чимэг болго-,

250. **ЗАСЕТЬ В БЕСТ** Далдын далд нуугда-, хүн олмооргүй газар хоргодо-, харах бараагүй хайх мөргүй.

251. **ЗАСЕТЬ В ГОЛОВЕ** Дотроо бодоод ява-, санаандаа санаж (шанаандаа зуу-), сэтгэлдээ хадаж ав-, цээжиндээ хадаас болго-

252. **ЗАСИДЕТЬСЯ В ДЕВКАХ** Гүүний жороо чавганцын охин (хоер хүнд хэрэггүй) Нохойн тарга, нохойн гуяны тарган, нохойн жороо.

253. **ЗАСНУТЬ ВЕЧНЫМ СНОМ** Мөнх нойрсо-, уртын аянд ява-, нэгмөсөн унта-, амин юүлэ-.

254. **ЗАСНУТЬ, КАК УБИТЫЙ** С 734
255. **ЗАСНУТЬ МЁРТВЫМ СНОМ** С 735
256. **ЗАСТАТЬ В ЖИВЫХ- БЫТЬ В ЖИВЫХ**
257. **ЗАСТРЕВАТЬ** (застрять) **В ГОРЛЕ** [*прост*] Дутуу хэлэ-, хэлэлгүи орхи, араандаа юм үлдээ-, үгниихээ хагасыг залги-
258. **ЗАСТУПАТЬ ДОРОГУ** *кому* [*прост*] Саад бол-, хориг тави тээг бол
259. **ЗАСУЧИВ РУКАВА** Ханцуй шамлан, зоримог, хичээн
260. **ЗАСУЩИТЬ СЕРДЦЕ** *чьё кого* [*разг*] урмы нь хугала- урамгүй болго-, хүслий нь үгүй хий, гал дээр ус хий-, урмы нь хугалахаар ууцы нь хугал-
261. **ЗАТАПТЫВАТЬ В ГРЯЗЬ** З 271
262. **ЗАТАИТЬ ДЫХАНИЕ** Амьсгаагаа түгжи- амьсгаагаа бари-, амьсгаагаа тата
263. **ЗАТАИТЬСЯ В СЕБЕ** Цээжиндээ түймэр шатсан ч утаагий нь хамраараа гаргахгүй ямар бодолтой нь мэдэгдэхгүй, сайн муу нь мэдэгдэхгүй, хүнии дотор орж үзсэн биш гэгчээр, ямар нь мэдэгдэхгүи, хүнд мэдэгддэггүи, ямар нь мэдэгддэггүй, авсаар юманд хөдөлдөггүи
264. **ЗАТВЕРДИТЬ ОДНО И ТО ЖЕ** Бахь байдгаа яри-, улиг болсноо үглэ домогтоо улигла-, нэг хэлснээ долоо (далан долоо, түм, арван гурав) дахи-, (зөнөглөж үгээ дахин давтахыг) чалчаага-
265. **ЗАТЕМ ЧТО** ны учир нь бол, .. даг (дог,-дэг,-дөг)-ийн шалтгаан бол , нин тулд, нь юун хэмээвээс . . . ийн учирт, яагаад гэвэл иймиин тулд
266. **ЗАТЕМ, ЧТОБЫ** ын тулд, . ийн төлөө, (тэгэх) гэж, -хаар (хоор, -хээр, -хөөр), тэгэе (ингэе) гэсэндээ, учир иймээс, юу гэвэл
267. **ЗАТКНИ ФОНТАН!** Амаа тат! Дуугаа тат! Амаа хамхи!
268. **ЗАТКНУТЬ ГЛОТКУ** (рот) *кому* [*прост вульг*] амы нь хамхи-, үг дугарахгүи бай, амы нь бари-, дуугүй байлга-, дуугий нь хори,

Заткни глотку! Амаа тат! Дуугүй бай! Дуу! Цөг! Хош! Тат! Чи дут!

269. **ЗАТКНУТЬ ЗА ПОЯС** З-52
270. **ЗАТКНУТЬ** (затыкать) **РОТ** Дуугүй болго-, амы нь тагла-, амы нь бари, мадла- аман дээр нь алгада- З-214
271. **ЗАТОПАТЬ** (втоптать) **В ГРЯЗЬ** Шившгий нь дэлгэ-, нэрий нь хугала, нэрий нь гутаа-, сүргүй болго-, нэргүй болго-, үнэ хүндгүй болго-, нэрии нь хөөдө-, нэр сүрий нь унага-, нэрий нь баа да- В 1050, З-254
272. **ЗАТРАГИВАТЬ ЗА ЖИВОЕ** З-145
273. **ЗАТРЕПАТЬ** *чьё* **ИМЯ** [*разг*] Эзгүйгээр нь муу хэлэ-, эзгүид нь бөгсий нь уха хоигуур нь тави-, нүд далдуур нүгэл хий, алга хоигуур нь амла угаа-, халж ядахдаа хаяанд нь

хар чацга алда-, байхгүид нь бардамна-, далдуур дайсагна-, хамрын цаанаас тархида, бөгсөөр нь жин тави-, чөдөртэй морий нь тавьж туу-,
274. **ЗАТЫКАТЬ** (заткнуть) **ГЛОТКУ** амы нь тагла-, аман дээр нь алгада, дуугүи болго
275. **ЗАХЛЕСТНУЛО В ПАМЯТИ** *у кого* [*прост*] Таг мартжээ. идчихжээ
276. **ЗАХОДИТ** (зайти) **В ТУПИК** Ягтаж хоцрох, хаашаа ч үгүй болох, гаца,
277. **ЗАЯВИТЬ СЕБЯ** нь хэн хүнд мэдэгдэ, олонд аа үзүүл, нь мэдэгдэ-, олноороо мэдэ, хэн бүхэн мэдэ-, амьтан ангахгүи

Заявить себя хорошим оратором. Сайн илтгэгч мөн нь хэн хүнд ил бол-

278. **ЗАЯЧЬЯ ГУБА** Сэтэрхий уруул, тэмээний уруул шиг,
279. **ЗАЯЧЬЯ ДУША** Аимхаи, хулчгар, сүс багатай, зүрх муутай, хулгана шиг аимхаи, зүрх гэж тугалга
280. **ЗВАНИЯ НЕТ** [*прост*] сураг ажиггүи болох, алга болох, сүүдэр ч үгүи болох
281. **ЗВАНЫХ МНОГО, МАЛО ИЗБРАННЫХ** олон боловч оночтой нь үгүи, нэр нь олон ч нидэр нь бага, олноос цаашгүи
282. **ЗВАТЬ БЕЛОЕ ЧЁРНЫМ** харыг цагаан гэ, тэмээг ямла гэ-, улаан чулууг мах гэж (зажилж) цагаан чулууг өөх гэж үмхэ-, сүүг ус гэ-
283. **ЗВЁЗД С НЕБА НЕ ХВАТАЕТ** [*разг. ирон*] Гойд ухаантай ч биш, хэтүидсэн мэргэн биш, ухаанаар гишүүлэх юмгүи, ухаанаар гавихгүи, он муутай

Звезд он с неба не хватает, но очень энергичный и исполнительный работник. Ухаан нь хурц биш ч гэсэн тун махруу хичээнгүи хүн шүү.

284. **ЗВЕЗДА ПАДУЧАЯ** Солир, харвамал од
285. **ЗВЕЗДА ПЕРВОЙ ВЕЛИЧИНЫ** дээгүүр хүн, төрийн том хүн, их албын хүн,
286. **ЗВЕЗДА ПЕРВОЙ ВЕЛИЧИНЫ** Цуутай хүн, олонд алдартай хүн, том хүнии нэг, арвуухан хүн их дээгүүр хүн, зартай аавын хүү, санчуулын нэг, нэртэй хүнии зүстэй хүү, шимтэй эриин нэг, сүүт хүнии нэг
287. **ЗВЕРЬ-ЗВЕРЕМ** [*разг*] Араатан шиг амьтан, чоно шиг, сүүлгүй чоно, хүн хар гөрөөс шиг, хүн биш хүлтгэр
288. **ЗВОНИТЬ** (раззвонить) **ВО ВСЕ КОЛОКОЛА** Амтай бүхэн яри-, шагшаан шуугиан бол, ярьж шуугиа
289. **ЗВУК ПУСТОЙ** Хоосон үг, хоосон яриа, унгас, дэмий яриа, нэг их саихан үгтэи, гоо ам гурил хошуу
290. **ЗГИ НЕ ВИДАТЬ** Н-1094
291. **ЗДОРОВ НА ЕДУ, ДА ХИЛ НА РАБОТУ** Идэхдээ идэрхэн, хийхдээ хэдэргэн, ууж идэхдээ ууртын морь шиг, урагшаа

гишгэхдээ ургаа хад, идэх нь идэр, явах нь ядар, идэх нь өмнөө, хийх нь хойноо, идэхэд эр ботго шиг, явахад охин ботго шиг, хийхдээ хашин бух шиг, идэхдээ эр бар шиг, идэхдээ ялдам, хийхдээ ядам (хуудам), мах гэхээр магнай нь, мал гэхээр хөмсөг нь, мах гэхээр арааны нь шүлс, мал гэхээр ороины нь үс

292. **ЗДОРОВАЯ ГЛОТКА** [*прост*] Цээл (шингэн) хоолонтой, цээл саихан дуутай, цангинасан хоолон, хадаадаг хоолон, саихан дуу, эрдүү хоолон, чавцлуухан хоолонтон, цээл тунгалаг хоолойтой, булингаргүй хоолонтон

Ну и здоровая глотка у него-до сих пор в ушах звенит! Мөн ч хадаасан хоолонтон шүү, одоо ч гэсэн чихэнд хоногшоостон байх юм

293. **ЗДОРОВО ЖИВЁШЬ** [*прост*] Хар аяндаа л, зүв зүгээр байгаад, яагаа ч үгүй байж байснаа, эв эрүүл байгаад, гэмгүй байгаад, яасан ч юмгүй, тиим ним гэх юмгүй, гиим нимгүй, тэглээ гэх юмгүй

Пострадал здорово живешь. Хар аяндаа байж байснаа л ним зовлон болчихлоо

294. **ЗДРАВИЯ ЖЕЛАЮ!** [*воен*] Амрыг эрье, амрыг аилтгая, амар аилдаж байна уу?

295. **ЗЕВАТЬ ВО ВЕС РОТ** Ам мэдэн эвшээ-, амны хэмжээ авамныхаа чинээгээр эвшээ-, эрүүгээ мулгартал эвшээ-, амаараа ор дэрээ заса-

296. **ЗЕВАТЬ НА ПОТОЛОК** [*разг*] Хий алмайра-, хиих юмаа олж яда-, мангангаад бай-, өдөр өнгөрөөж яда-, хий дэмий холхи-, гаихшаа бара-

297. **ЗЕЛЕН ВИНОГРАД** 1. Болоогүй усан үзэм, ногооноороо үзэм 2. [*перен*] Шал нялхаараа, шал түүхнигээрээ, өглөөгүүрээ, тиихнээрээ, үс нь хатаагүй, амны салай арилаагүй

298. **ЗЕЛЁНАЯ МОЛОДЁЖЬ** З 300

299. **ЗЕЛЁНАЯ УЛИЦА** Гудамжны ногоон гэрэл, ногоон гэрэл асаатай бай-, осол аюулгүй зам, зам саадгүй, зам саихан, зам шулуун

300. **ЗЕЛЁНЫЙ ЮНОША** [*разг*] Цэл залуу нас, идэр залуу, ухаан суугаагүй, гэнэн хонгор нас, шал хүүхдээрээ, хонгор залуу нас, хар нялхаараа, өглөөгүүрээ, нас нь бага цус нь шингэн, шал нялхаараа З-298

301. **ЗЕМЛЮ РЫТЬ** [*разг*] 1. Гялалзтал хий-, хурдан шалмаг хий-, 2. Аврагаа-, баавгаила-, эр бар шиг хий-, зүрх нь үхээгүй, хийсэн шиг хий-, эр хүн шиг эрвэлзэж эмээлтэй морь шиг дэрвэлзэ-

302. **ЗЕМЛЯ ГОРИТ ПОД НОГАМИ** *кого буюу у кого* Дороос нь юм хатгасан юм шиг, гал дээр гишгэсэн юм шиг, цавь руу нь чичсэн юм шиг, оломны цанхтай юм шиг, цанх нь хөдөлсөн юм шиг. Байх суух аргагүй бол-

303. **ЗЕМЛЯ УХОДИТ ИЗ ПОД НОГ** тулгуургүй болох, багана нь оичих, таяггүй болох, ганц наашаа гэдэг юмнаасаа салах, түшиг түшээгээ алдах.

304. **ЗЕМНАЯ ЮДОЛЬ** тоост орчлонгийн явдал (аж), зовлонт орчлонгийн аж төрөл С-433

305. **ЗЕМНО КЛАНЯТЬСЯ** (Духаараа) газар мөргө-, 2. Сунаж мөргө-, газар элэглэ-

306. **ЗЕМНОЙ ПОКЛОН** Мөргө-, сөгдө-, мэхийн есло-, нуруунд нь нугас ургасан мэт бөхий-, дохилзож нахилзан, мэхэлзэх бөхөлзө-, духалзаж нахилза-.

307. **ЗЕМНОЙ РАЙ** Ертөнцийн амгалан орон, диваажин, хүний орны арилсан орон, цэнгэлийн орон Р-92

308. **ЗЛАЧНОЕ МЕСТО** [*шутл*] Наргиан самууны газар, самуурал согтуурлын газар, садар самууны газар, янхлах ямбалах газар, уун садарлах газар, сархад зооглож садраар элийрэх газар, дууч эмийн ордон

309. **ЗЛО БЕРЁТ (взяло, разбирает)** *кого* [*разг*] Хорсол буцлав. шээс (нь) гоожив, байж ядтал занав, дотор арзганав, хор буцлав, зэвүү хүрэв, шар буцлав, ямаан омог нь хөдлөв, шар нь гозойв, уур нь шатав, байж цөхөв.

Зло меня берёт, когда вспомню свою оплошность. Салангаа (гоомоидсоноо, долдоигоо, долгонцгоо) бодохноо л дотор арзганах юм.

310. **ЗЛОБА ДНЯ** Амьтны амнаас салахаа байсан яриа (явдал), толгойтой бүр ярьж байгаа юм, цагийн явдал, улирлын онц явдал (хэрэг), улиг болсон яриа, улиг домог болсон яриа, цуудам яриа, амьтны амны уншилга.

311. **ЗЛОЙ ДУХ** муу юм, хий юм, үзэгдэхгүй юм, далдын юм, ад, муу амьтан, шулам, шумнас

312. **ЗЛОЙ НА ЯЗЫК** [*разг*] ам хатуу (тай), ам гэж улаан хазаар хэлэхийг ч хэлж чаддаг, гашуун үгтэй, хорон үгтэй, үмхий үгтэй, егөөтэй яриатай, муухай хэлдэг, яс хавтаймаар (хавтал) хэлдэг, хаиргүй хэлдэг, хэл амаа угаадаг, хэлсэн шиг хэлдэг, үг нь бяртай, сэтгэл зовмоор хэлдэг, хорон үгтэй, ингүүхэн үг

313. **ЗЛОЙ ЯЗЫК** [*перен*] Ховын хэрээ жорын бошиго, хоер үзүүртэй зүү, хутгадаг хүн, хүн урдаг хүн, хов хөөдөг хүн, үг их хөөдөг, ховын тулам, үг зөөдөг, алтан хошуу өргөдөг, зэс хошуутай

314. **ЗЛЫЕ ЯЗЫКИ.** Ховын хэрээ жорын бошиго, хоер үзүүртэй зүү, ховын хаан, ховны эзэн, ховын тулам, ам султай, ам задгайтай үг тогтоодоггүй, чихээрээ оруулаад амаараа гаргадаг.

315. **ЗМЕИНАЯ МУДРОСТЬ** Хорон санаа, нарийн ов, хүний санаанд багтмааргүй заль, хүний санаа хөрст газраас зузаан гэж, хошногоны муу санаа, үмхий санаа, үмхий дотортой, санаа гэж чинжүү, сахал гэж туужуу, дотуур тамиртай.

316. **ЗМЕЯ ПОДКОЛОДНАЯ** Хорт могой (их муу санаатай хүн) олиггүй хүн, хүний адаг, юу ч хийхээс буцахгүй хүн, салхины нь доогуур ормооргүй хүн, холхон явмаар хүн, нэхий нөмөрсөн чоно, саная гэж чинжүү, өөдгүй дотортой.

317. **ЗНАЕТ КОШКА, ЧЬЁ МЯСО СЪЕЛА** Авсан хүн нэг нүгэлтэй (тамтай). идсэн чоно хонгилд, гэмгүй царайлах, мэдээ ч үгүй царай гаргадаг. Ч-193

318. **ЗНАЕШЬ, ЗНАЕТЕ, ЛИ, (ЗНАЕТЕ ЛИ, ЗНАЕШЬ ЧТО; ЗНАЕТЕ) ЧТО** [*разг.*] Үгүй яагаав өнөө . . . . . биздээ, айн гэж бай! . . . гэдгийг та андахгүй шүүдэв, та юу эс андах вэ.

319. **ЗНАЙ НАШИХ!** [*разг. шутл.*] Харахгүй юу! За тэр! Харж байгаа биздээ! Ийм сүрхий!

320. **ЗНАЙ** (себе) . . . Хайхрахгүй, анзаарахгүй, хэнээгүй хэв нэг, тоох ч үгүй, үтээрхэхгүй, хэрэгсэхгүй.

Все сидит в халате, да трубку знай себе покуривает. Халаазтайгаа суудгаараа суугаад л хэв нэг л, гансаараа гал улаанаа нэрсээр л суунам.

321. **ЗНАЙ** (знайте) **СВОЁ ДЕЛО** [*разг.*] Хирээ мэдэж бяраа таних, адууныхаа хирээр исгэрэх, хөнжлийнхөө хирээр хөлөө жийх, хирээ мэдсэн нь дээр шүү, хүн ахтай дээл захтай!

322. **ЗНАК РАЗЛИЧИЯ** Зэргийн тэмдэг, ялгах тэмдэг

323. **ЗНАКОМАЯ ПЕСНЯ** 1. Сайн мэдэх дуу, хуучин дуу 2. [*перен. ирон.*] Хуучин дуугаа л дуулж байх, улиг болсон яриа, бахи байдаг, өнөөх л, улигтаа улиглах.

324. **ЗНАМЕНИЕ ВРЕМЕНИ** Цагийн шинж, улирлын бэлэг, цагийн ёр, цагийн байдал, цагийн янз.

325. **ЗНАТНЫЕ ЛЮДИ** Цуутан, алдартан, нэртэй зартай.

326. **ЗНАТОК СВОЕГО ДЕЛА** Тэр юмандаа гаршмал (дадмаг) өөриймсөн, гартаа оруулаад авсан, арван хуруу шигээ мэдэх, ажилдаа эзэн, түүндээ зөв, хүртсэн хувиа хүнд өгөхгүй хувиа борлуулдаг

327. **ЗНАТЬ В ЛИЦО** *кого* Нүүр тани-, зүс тани-, царайг нь харазуслэ-, нүдлэ-,

Всюду его знали в лицо и кое-где он стал уже надоедать (Леонов, соть, гл 2(1) Хаа ч явсан тэр хүний зүсийг танихгүй хүн байхгүй, зарим газрынх нь хараад л дургүй нь хүрдэг болчихсон байгаа юм.

Я вашего отца знаю в лицо, но не знаком с ним. Таны эцгийг би зүс танихаас цаашгүй.

328. **ЗНАТЬ ВСЕ ХОДЫ И ВЫХОДЫ** *где* [*разг.*] Илэд мэдэ-нэвт мэдэ-, дотор нь орсон юм шиг мэдэ-, толинд харж байгаа юм шиг мэдэ-, нүх сүвий нь андахгүй, В-981

329. **ЗНАТЬ, ГДЕ РАКИ ЗИМУЮТ** [*разг.*] Орох гарах нүх сүвээ анддаггүй, онисы нь олдог, эгэгий нь тааруулдаг, арга заль нь ар өврөөр нь чихээстэй, зайгий нь олдог, сүйхээтэй, овсгоотой, олби оготно шиг, шар сүүлт шиг.

330. **ЗНАТЬ ДЕНЬГАМ СЧЁТ** 1. мөнгө сайн барьдаг, сохор зоос газар унагахгүй, мөнгөнд гамтай, мөнгө аргилж чаддаг, 2. энгүй баян, мөнгө гэж ус шиг.

Он не знает деньгам счёта, он безрассудно и глупо тратит их. Мөнгөө сайн барьж чаддаггүй хамаагүй бодлогогүй үрэн таран хийчихдэг.

331. **ЗНАТЬ ДОРОГУ** *куда* [*перен.*] учраа ол-, нүхээ ол-, замаа мэдэ-, намбы нь тааруул-, зайгий нь ол, -эв дүйгий нь ол-, эв гавы нь ол-.

Поручите сделать это ему, он знает туда дорогу. Энэ ажлыг тэр хүнд хий гээд өгч орхи, цаадах чинь яаж нийж хийхий нь мэднэ ээ!

332. **ЗНАТЬ ЖЕНЩИН** Эм хүнтэй хавита-, эм хүнтэй ойрто-, өвдөг зөрө-, хормой зөгө-, юм үзэ-, сура-, амты нь ава-.

До 25 лет он не знал женщин. 25 нас хүртлээ эм хүнтэй хавьтаагүй явсан.

333. **ЗНАТЬ ЗА СОБОЙ** *что* Гэмээ мэдэ-, нүглээ мэдэ-, болдоггүйг мэдэ-, муугаа мэдэ-, биеэ мэдэ-, хирээ мэдэ-, янзаа тани-.

Он знал за собой не мало грехов. Олон муу муухай юм (нүгэл) хийж явснаа мэдэв.

334. **ЗНАТЬ КАК ОБЛУПЛЕННОГО** [*разг.*] Төгс мэдэ-, арван хуруу шигээ мэдэ-, нэвтэрхий мэдэ-.

335. **ЗНАТЬ КАК СВОЙ ПЯТЬ ПАЛЬЦЕВ** арван хуруу шигээ мэдэсайн мэдэ-.

Я это потом всё, как пять пальцев узнал (Достоевский) Үүний чинь би сүүлд л арван хуруу шигээ мэддэг боллоо шүү дээ.

336. **ЗНАТЬ НА ЗУБОК** [*разг.*] Сайн цээжлэ-, цээжтэй бол-, хуу цээжлэ-, тангад ном шиг цээжлэ-, юу ч үгүй цээжлэ-, нэгт нэггүй цээжлэ-, маань шиг цээжлэ-, амны үишлага болго-.

337. **ЗНАТЬ НАСКВОЗЬ** В-631 П-734

338. **ЗНАТЬ ПРО СЕБЯ** [*провт.*] Дуугүй өнгөрө-, дотроо санаад орхи-, үг дуутүй, хариу хэлэхгүй

339. **ЗНАТЬ СВОЁ МЕСТО** Буурь алдахгүй- буурьтай, суурьтай, буурь заа-, хирээ мэддэг- хэрсүү, бууриа хадгала-, хэмжээгээ мэдэ-, чадлаа мэдэ-.

Он знает своё место и некуда не сует свой нос. (Тэр хүн) Буурь алдахгүй хүн, илүү дутуу юманд хөндлөнгөөс хөлөө хийхгүй (хүрүү хожуу дүрэхгүй)

340. **ЗНАТЬ СВОЮ РОЛЬ** (жүжигт) үгээ сайн цээжил-, (ажилд) дадмаг чадмаг, баруун солгойгүй хийдэг, хаана нь ч гаргахгүй бол-, нүүр удайхгүй бол-, ёстой нэг ягшуул-, аргагүй л нэг мөндөө гэхээр бол-,

Не мешайте ему, он знает свою роль. (Түүнд) бүү саад бол, цаадах чинь юу хийхээ нэгд нэгэнгүй мэднэ.

341. **ЗНАТЬ СЕБЕ ЦЕНУ** Хирээ мэдэ-, чинээгээ мэдэ, чадлаа мэдэ.

342. **ЗНАТЬ СЕРДЦЕМ** мэдэ-. мэдрэ-.

343. ЗНАТЬ СЕРЕДИНУ Д—250

344. ЗНАТЬ (понимать) ТОЛК *в чём* Сүрхий мэдэ-, нэвтэрхий мэдэ-, андахгүй, баруун солгонгүй мэдэ-, саин мэдэ-, гаргуутай, гаргууд, хачин мэддэг П-735

Он знает толк в винах. Дарсныхаа тал дээр ч хүнээс асуухгүй шүү (Дарсыг ч сайн мэднээ)

345. ЗНАТЬ ЦЕНУ *кому чему* Үнии нь андахгүй, үнэ цэний нь нэгд нэгэнгүй мэдэ-

346. ЗНАТЬ ЦЕНУ СЕБЕ [*перен.*] Хирээ мэдэ-, өөрийнхөө хэмжээг мэдэ-, өөрийнхөө савны хэмжээг андахгүй, биеэ мэдэ-.

Он знал себе цену. Өөрийнхөө хир хэмжээг сайн мэддэг хүн шүү

Все знали цену его льстивым словам и не обращали внимания на его повалу. Зусар зугуй үгтэнгий нь хэн хүнгүй мэддэг болохоор, нялуурахы нь амьтан ер тоосонгүй

347. ЗНАЧИТЕЛЬНОЕ ЛИЦО Хэтүйдсэн мэргэн, мэдэлтэй хүн, их мэдлийн хүн, эрхтэй дархтай хүн, шиир томтой хүн, их гарын эр, хэнхэр эд, энтэй хүн

348. ЗОЛОТАЯ ДУША Сайхан сэтгэлтэй хүн, сүү шиг сэтгэлтэй хүн, цагаан сэтгэлтэй хүн, дотор сайтай хүн, цагаан санаатай, хүн шиг хүн, жудаг гэж яана, мөс сайтай хүн, хүнээр сайн (хүн), хүн сайтай, хүнии нуруу сайтай хүн

349. ЗОЛОТАЯ МОЛОДЕЖЬ (ЗОЛОЧЁНАЯ МОЛОДЁЖЬ) [*презр.*] 1. эрх танхи залуу, ардаг зантай үр сад, танхил янзалган залуус, шаавай залуус, ганган шаавай залуус, сул бие сунхсан залуус, ганц бие ганхсан залуус, яанаа иннээ гэх юмгүй залуус, нялцрай багачуул, эрхээрээ хатсан амьтад, эрх нь дэндсэн амьтад 2. Сагасан залуус

350. ЗОЛОТАЯ ОСЕНЬ намрын шар наран, тое даасан намар, налгар намар

351. ЗОЛОТАЯ РОТА [*прост. бран.*] Тэнүүлчин, хэсүүлчин, хээрээр гэр хийж хэцээр дэр хийсэн, оронгүй оргодол, бадарчин, тэр гэх нэргүй тэнд гэх оронгүй, нэрлэх нэргүй нэг цэнгийн үнэгүй, гэрээ мартсан Гэсэр, малган тавибал манаих, түмнийг хэсч түнгэрцгээ дүүргэсэн, олныг хэсч олгонгоо дүүргэсэн, үүд өрхтэй болгоныг шагансан, доншуул

352. ЗОЛОТАЯ СВАДЬБА (Ураг барилдсаны тавин жилиин ой) **үгчилбээс** алтан хурим

353 ЗОЛОТАЯ СЕРЕДИНА [*книжн. ирон. неодобр.*] Хэвийг сахих, тэг дундуур нь явах, төвийн мөр, олны жишгээр (явах), хэний нь ч хэн гэдэггүй, хээр алгиг ч ялгадагүй, эхий нь эцэлгүй тугалы нь тураалгүй

354. ЗОЛОТИТЬ ПИЛЮЛЮ-П-581

355. ЗОЛОТОЕ ДНО [*разг.*] 1. Эрдинин ундраа, шавхагдашгүй олзвор, 2. Алтны сан, олзтой газар, их савны ероол, бууршгүй буяны хөрөнгө

356. ЗОЛОТОЕ СЕРДЦЕ *у кого* Сайхан сэтгэлтэй хүн, сүү шиг сэтгэлтэй хүн, ариун санаатан, нинжин сэтгэлт, наана цаанагүй хүн,

357. ЗОЛОТОЙ ДОЖДЬ Их мөнгө, их зоос, их бэл

358. ЗОЛОТОЙ (денежный) МЕШОК [*разг.*]-**ДЕНЕЖНЫЙ МЕШОК**

359. ЗОЛОТОЙ (златой) ТЕЛЕЦ [*перен.*] Эдээр түрээ барих, баянаараа түрээ барих, мөнгөөр зодох, баярхах, юмтаирхах.

360. ЗОЛОТОЙ ФОНД 1. Алтны хөмрөг, 2. (Юмны) шилдэг нь, дээж, шижир нь, хамгийн дөмөг нь, чарамхиих юм, урдаа барьдаг юм (хүн), сор нь, охи, сор, аль олигтой (хүнии) шилмэл.

361. ЗОЛОТОЙ ЧЕЛОВЕК Саин хүн, хүнии саин, хүний хайлан, хүн сайтан мөстэй хүн, гүндүүгүй хүн, зохилгон зантай нөхөр, хүний дээд

362. ЗОЛОТЫЕ (златые) ГОРЫ Барагдашгүй сан, яндашгүй хөмрөг, эрдинин уурхай, баян хангай, алтан дэлхий

363. ЗОЛОТЫЕ РУКИ Уран гартан гартаа дүйтэй, гарын уртай.

364. ЗОЛОТЫХ ДЕЛ МАСТЕР 1. Толгоин чимэгчин, толгойн гоелчин, толгой гоеогч, толгой засагч, 2. Толгоин чимгийн дэлгүүр (пүүз), эрднэсийн дэлгүүр

365. ЗОНДИРОВАТЬ ПОЧВУ Яадгий нь үзэ-, тэнсэж үзэ-, туршиж үзэ-, янзы нь үзэ-, турши-, янзы нь үзэж гонзы нь тани яадаг юм гэж янзы нь үзэ-, сори-, шинжи-

366. ЗУБ ЗА ЗУБ [*прост.*] Ач тач хэрэлдэх, уралцах, уралцаж алдах, чи би дээ хүрэлцэх, нохой гахайдаа хүрэх

367. ЗУБ НА ЗУБ НЕ ПОПАДАЕТ [*разг.*] (Даарч бээрснээс) дав жигнатал чичрэ, эрүү ам эвлэхгүй бөмбөлзтөл чичрэ-, ам нь бээрэ-, дээлтэйгээ дэрийж гуталтайгаа гурий-, (айснаас) санд ран мэгдрэ, хормой нь чичрэ, аин салгана-, эрүү хавчигнадагжин чичрэ, эрүү нь дагжи-,

Ну и морозы, зуб на зуб не попадает! Эрүү ам эвсхээргүй хүйтэн байлаа (Эрүү ам хавчигнуулаад мөн ч хүйтэн ээ!)

368. ЗУБЫ ЗАГОВАРИВАТЬ Үүдэн шүдээрээ хуура-, ямхын төдүй хэлээр аргала, үгээр хуура-, гое үгээр хуура-

369. ЗУБЫ ПРОЕСТЬ (счесть) *на чем* [*разг.*] Хий нь арилсан, олон оймс элээсэн, хал үзэж хашир суусан, юу эс үзэх вэ, үхэж хошногоо доохоос бусдыг үзсэн, шүдээн настайгаасаа аваад шүдээ унатал юу эс үзэхэв, доль цохьсон нуруун дээрээ гал түлүүлэхээс бусдыг үзсэн

370. ЗУБЫ ЧЕСАТЬ [*разг.*] Амаа ура-, дэмий донгос-, эх захгүй чалчи-, ам мэдэн бура-, тагнайгаа чилтэл чалчи-, амьсгалын тоогоо гүйцтэл, завжаараа цагаан хөөс цахруул-.

И

1. **И БЕЗ ТОГО** .. Тэр ч байтугай .., тэхтээ мантай, тэх нь бүү хэл юу чинь тэгэх, тэртэй тэргүй, хаашдаа,

Не надо ему об этом говорить, ему и без этого очень тяжело. Эниг ч тэрүүнд хэлээд юу хиих вэ, тэр ч байтугай юм болоод байгаа юм

У нас и без того большой перерасход. Тэх нь бүү хэл зарлага хамаагүй хэтрээд байгаа,

2. **И БРОВЬЮ НЕ ПОВЁЛ (шевельнул)** Чихэмчгүй, хэнэггүй, хэв нэг, даанч тоомсоргүй, ажигтүй (байв), давхиих ч үгүй, И 38, 60 И-2

3. **И (даже) БРОВЬЮ НЕ ШЕВЕЛЬНУЛ**

4. **И БЫЛ (была, было) ТАКОВ (такова, таково)** [*разг*] Хур га авсан юно шиг арилаад өгөв, шалавхан зүг буруулав, бушуухан зулбав Б 474

Стащил у кого-то бумажник и был таков. Түрийбчин нь сунгж аваад арилж өгөв

5. **И В ЗАВОДЕ НЕТ** [*разг*] Хэтээсээ байгаагүй, угаасаа байгаагүй, газар дээр гараагүй, ертөнцөд байхгүй, язгуураас байгаагүй, үзээд өгье гэсэн ч алга, нүдэндээ хине гэсэн ч алга, цааннаасаа байхгүй, ерөөсөө байгаагүй, шөнийн солонг.

6. **И В ПОМЫСЛАХ НЕ БЫЛО** *чего* Даанч ингэж бодоогүй, огт санаагүй, ингэнэ чинээ бодоогүй,

7. **И В УМЕ НЕТ (не было)** *чего* [*разг*] Огт санаанд орсонгүй, анзаарсангүй, зүүд зөнд ч орсонгүй, (тиим, ним) санаа огт байсангүй,

У меня в уме не было обманывать вас. Таныг хуурья гэсэн санаа надад огт байгаагүй

8. **И В ХВОСТ И В ГРИВУ (гнать, дуть, погонять)** Байдаг хүчээрээ (давхи,) хар хуудаараа хөө, хар гүйхээрээ, ухаан жолоогүй, ум хумгүй харайлгах, бүрхирэн бүржигнэ-, В-411

9. **И ВОЛКИ СЫТЫ И ОВЦЫ ЦЕЛЫ** Эхий нь энээлгүй, тугалы нь гураалгүй хэн хэндээ гомдолгүй, өгөөний аваанны, хэн хэндээ хал балгүй, хэн хэндээ болсон,

10. **И ВСЁ ТАКОЕ** [*прост*] Юм юм л болж байв, гэх мэт, энэ тэр, зүсэн зүплийн, есөн жорын

На свадьбе плясали, пели и всё такое. Аилын хуриман дээр бүжиг хиих нь бүжиг хиигээд л дуу дуулах нь дуулаад л юм юм болж байв (Хуриман дээр бүжиг дуу гээд л юм юм болж байв)

11. **И ВСЁ ТУТ** [*разг, фам*] 1. Ингээд л энэ, ердөөл энэ, за дүүрлээ, ингээд өнгөрч, болох нь тэр, 2. Яана гэхэв ээ, арга алга

Уволили-и всё тут. Хөөгдсөндөө, одоо яана гэхэв.

12. **И ВСЯ НЕДОЛГА** *буюу* **ВОТ И ВСЯ (тут) НЕДОЛГА** [*разг*] За өөр юмгүй дээ, ингээд л энэ, за болох нь энэ. В-885

Не стоит много говорить: отказать и вся недолга! Иим тийм гээд байх юу байх вэ? Тэхгүй (чадахгүй ээ) гээд л болох нь тэр

Заплати пять рублей и вся недолга. Таван рубль л өгвөл болох нь тэр (Үүнээ тайлбарлах нь **Заплатить** гэдгийг монголоор боддог хүн *төлөх* гэж орчуулахгүй шүү Монгол хэлний найруулга зүйн ёсоор хүнии юмыг үгүи хийчихсэн эвдэлж хэмхэлчихсэн хүн өр төлөөсөнд нь төлөх гэхээс биш, авсан юмныхаа үнийг *төлөх* гэж ярихгүй Хэрэв дэлгүүрийн юмыг авах гэж үзэж байгаад хэмхэлчихсэн бол оронд нь төлөх болно, мөнгөний няравтбуюу худалдагчид авсан юмныхаа **үнийг бол өгөх** л гэвэл зохино. Байшингийн **хөлсийг ч өх**, тушаах гэж ярих нь зөв юм Байшингийн хөлс төлөх гэвэл шал өөр ухагдахуун болно Гэр юу вэ? гэвэл байшингийн хөлсөнд өх гэж байсан мөнгий нь үгүй хийчихээд оронд нь *төлөх* гэсэн санаа болно)

13. **(И) ГЛАЗОМ НЕ СМОРГНУТЬ (ведёт)** [*разг.*] Доль цохисон шинжтэй, хэнэггүй, гудиггүй, чихэмчгүй,

Он соврёт и глазом не сморгнёт. Гүлдийчихээд гудиггүй худлаа дэлсэж байна шүү

14. **И ГОРЮШКА (горя) МАЛО (нет)** *кому* [*разг*] гудиггүй, тоомсоргүй, хэв нэг хэнэггүй

15 **И ДЕЛО С КОНЦОМ** [*разг, прост*] За ингээд дууслаа, сүүлий нь мушгив шувтрах нь энэ ээ, шор мулталваа, дөрөөнөөс хөл салгав аа,за хоер яс салав, зүйл дуусах нь тэр.

Заплати ему деньги, которые он требует, и дело с концом. Авах гэсэн мөнгий нь л өгчих, тэгээд л хоер яс салах нь тэр

16. **И ДЕЛУ КОНЕЦ** [*прост*] за боллоо, дуухаа, шилий нь харлаа сүүлий нь мушгилаа.

17. **И ДРУГИЕ** (хураангуигаар и др.) энэ тэр, гэх мэт, бас бус, жич бас, гэх зэрэг, тэргүүтэн, энэчлэн, тэрчлэн, энүүнрэхүү,

18. **И ДУМАТЬ НЕ СМЕЙ!** Амлах юм биш, (тэгж) бүү бод,тэгэх юм биш, тэр санашгүй хэрэг ээ, санахын халцгай, И-39

19. **И ДЫМ ОТЕЧЕСТВА НАМ СЛАДОК И ПРИЯТЕН** Өргөстэй ч гэсэн өөрийн нутаг, сиймхий ч болсон орон минь, сэгсгэр ч болсон эх минь, утаатай ч болсон гэр минь, ууртай ч гэсэн аав минь, дассан газрын даавуу зөөлөн, хүний нутгийн бурхнаас өөрийн нутгийн чөтгөр дээр, хар гэртээ хаан бор гэртээ богд

20. **И ЕСТЬ** [*прост*] Ээ дээ, мөн дөө, үйлийн үргүй, дүрээрээ яг, чухам, зүсээрээ, естон мөн, нээрээ гээч, нээрээ мөн, мөн байна, мадаггүй мөн,

Кто идёт? мама? мама и есть. Хэн ирж явна вэ? ээж үү дээ, дүрээрээ ээж байна даа.

21. И ЗАБОТЫ МАЛО *кому* Тоомооргүй, юман чинээнд бодохгүй, хайхрамжгүи, халамжгүи, хөндии, хүйтэн

22. И ИЖЕ С НИМ (с ними) Тэднүүс, тэдний өрөөсөн бөөрнүүд, тай нэг амьсгааны улс таи нэг хэвийн боов өрөөсөн гутал, ороо нь ороогооро, жороо нь жороогооро гэгчээр улс, таарсан таар шуудай, таарсан амьтад

23. И КНИГИ В РУКУ *кому* Ганц мэддэг хүн нь, толгой дээр нь сууж баигаа хүн, -ииг гартаа атгаж баигаа,түүнии дур, юмны эзэн сумны занги,

14. И МАЛ, ДА УДАЛ [*прост*] Чөтгөрийн бага нь адтай, под хийсэн хүүхэд (банди), хэвлүүхэн (хүү)

25. И МЫ ПАХАЛИ [*разг ирон*] уут ч болдог, араар нь суудаг, хүнии юмаар хүүдэгнэдэг, хонгильн ч по болов,

26 И НА СОЛНЦЕ ЕСТЬ ПЯТНА Арван хуруу гэгшгүй, гэмээн барсан хүн гэж хаана байх вэ? мэргэн боловч алддаг, мэлхий боловч шаварддаг, саинтаи муутаи сав дүүрдэг, эр хүн энддэг, эрэг шороо нурдаг, саин гэвч алдаж болно, саар гэьч онож болно

27. И НА СТАРУХУ БЫВАЕТ ПРОРУХА Бөх хүн бүдүүн өвсөнд, баян хүн нэг шуурганд, баатар хүн нэг сумэнд,

28. И НАШИМ И ВАШИМ [*разг*] Хэнд ч тал алддаггүй, хаашаа ч хөлбөрч мэдэх, нөхөр даисангүи, бөөрөнхийлдөг (хүн), хэний нь ч хэн гэдэггүй, хээр алгии нь ч алаг гэдэггүй,

29. И НЕ ДУМАЮ Ингэсэн юм биш, тэгсэн үг бишээ, чингэж бодоогүи, огт үгүи, тэхгүй,

30. И НЕ МЕЧТАЛ Зүүд зөнд ч ороогүй, зүүдлээч үгүй,

О такой чести я и не мечтал. Иим алдар цууг би зүүдлээ ч үгүи

31. И НЕ ПОДУМАЛ Санаанд огт ороогүй, огт хиигээгүй, огт анзаараагүй, санаанд ч үгүй баих

Я ему велел убрать комнату, а он и не подумал (это сделать). Өрөөний юмыг янзал, цэгцэл гэж би захисан чинь юу ч хиигээгүй байж байна

Он и не подумал уплатить деньги. Мөнгөө огт өх янзгүй баина

32. И НЕ НЮХАЛ. *кого чего* [*разг*] Үзэг ч үгүй, А ч үгүй,умаа хум, таг, дааич зүггүй, дөргүй,

Они химий и не нюхали. Тэд пар хувилахуй ухаанд үзэг ч үгүй

33. И НЕ ПОДУМАЮ [*разг*] Үгүи, үгүй яршиг, болье оо! санадаггүй хэрэг ээ тэгж үхэхээр тээглэж үхэе! Байж үхэе!

Пойди, извинись перед ним! -И не подумаю. Очиж өршөөл гуй, гуй! -Санадаггүи хэрэг ээ!

Дай ему немного денег! -И не подумаю. Түүнд хэдэн мөнгө хайрла! -Яршиг даа!

34. И НЕ ПОШЕВЕЛЬНУТСЯ 1. [*разг перен*] Яаж ч чадахгүй хөдөлж ч чадахгүи яах ч аргагүи лионгүи, үхсэн юм шиг, бээрсэн юм шиг, яах ч сөгөөгүи, унгаи нь үхсэн

35. И НЕ РАД *буюу* **САМ НЕ РАД** [*разг*] Өөрөө ойчсон хүүхэд уилдаггүй, гэмээ мэдэх гэмших тоогүи юм болсноо мэдэх, өөриин хийсэн өөрт, өөриин хийсэн лаи энэ г зар, хүн хий гэсэн биш, гэм нь урдаа гэмшил нь хойчоо, өөд нь хаясан чулуу өөриин толгой дээр, гоомоидсондоо гонсойх, хэрэггүй хар юм боллоо, хэндээ ч гомдох вэ? С 181

И не рад, что напоил его. Согтоочихсон нь тоогүй юм боллоо, (дэмии л согтоочихлоо, хэрэггүи согтоолоо)

Заварил кашу, а теперь сам не рад. Өөрийн хийсэн өөрт одоо яахав, тиим л болж!

36. И НЕ УДИВИТЕЛЬНО [*разг*] Гайхаад байх юм юу байх вэ гэх л баисан юм

Никто не простудился. И не удивительно все былит пло одеты. Салхи цохиул ан хүн баихгүи Цөмөөрөө хувцас сантаи юм чинь тэгэлгүи яахав

Никто не пришел. И не удивительно все заняты. Хүн огт ирээгүи Цөмөөрөө чөлөөгүи (завгүи) юм чинь тэгж л таарна даа (Нэг нь ч ирээгүи, дор бүрнээ завгүи юм чинь өөр яах вэ)

37. И НИКАКИХ! буюу **И НИ КАКИХ ГВОЗДЕЙ!** хэлцээнгүй, яриангүи, тэгээд л болох нь тэр

Скажи ему, чтобы он ровно в восемь был здесь, никаких гвоздей! Яг найман цагт л энд бай гэж хэл, өөр хэлээд баих юмгүй (Олон таван үггүй, яг найман цагт энд байж бай гэж хэл ц адахдаа)

Отдай мне вещь обратно и никаких гвоздей! Юмы минь л надад өгөөдөх, өөр яриад баих юм алга

Я все сказал больше никаких гвоздей! Би бүгдий нь хэлээ ингээд болох нь энэ (Би хэлдгээ хэлсэн өөр яах в)

38. И (даже) НОСОМ НЕ ВЕДЕТ И—2

39. И ПОДУМАТЬ НЕ СМЕЙ И—18

40. И ПОМИН ПРОСТЫЛ Ор мөргүй болов Үзэгдэхгүй болов, Үсгүи арилав Сураг ажиггүи болжээ, Харах бараагүй хайх мөргүи болжээ С 493

41. И ПОМИНУ НЕТ *о ком, о чем*

42. И ПОЛНО [*разг*] .. л юм даа, (тийм) болжээ, (тэгдэг) байжээ

43. И ПРОЧИЕ (хураангуйгаар **и пр**, буюу **и проч**)

(И прочая ч гэж хэрэглэдэг есон баив) гэх мэт,гэх зэрэг, тэргүүтэн,

44. **И РАЗГОВОРУ БЫТЬ НЕ МОЖЕТЬ** *о чём буюу* **РАЗГОВОРУ НЕТ** 1. Хэлцээнгүй, гарцаагүй, ... ч бүр хууль, ... ч бүр гонж,

45. **И С БОРУ И С СОСЕНКИ С.**-11

46. **И СКОМОРОХ ИНУ ПОРУ ПЛАЧЕТ** Наашаа харж инээж цаашаа харж уйлах, дуртай дургүй,

47. **И СМЕХ И ГРЕХ** [*разг*] Инээх ч хэцүү, байх ч хэцүү, инээх уйлах хоерын хооронд, инээх хэцүү уйлах хэцүү, доголон пулимастан инээх гэгч, наашаа харж инээж цаашаа харж уйлах

48. **И СТАР, ДА УДАЛ** Талтай хөгшин, хуучин бууны хугархай, өтөлсөн болохоос үхсэн биш, цартай хөгшин, тартай хөгшин шүү, хуучны хуучин, турсан нь их ч сурсан нь их, цорж өтлөвч бандид зөв, ануухан, царигтан

49. **И СТАР И МЛАД** Хөгшин хөвөөгүй, хүүхэд үүхэдгүй цөмөөрөө, найман настан балчраас аваад, наян настан хөгшид хүртэл,

50. **И ТАК** [*разг*] 1. Уг нь, угаасаа, язгуураас, анхнаас, гуттамаас, 2. Инмд ингэхлээр, гэхлээр,

Мне больше не надо, у меня и так много. Надад нэг их олон хэрэггүй, уг нь ч надад олон бий

51. **И ТАК ДАЛЕЕ** (хураангуйгаар и. т. д.) гэх мэт, энэ тэр, гэх зэрэг, тэргүүтэн, бас бус, жич, бас,

52. **И ТАК И ИНАЧЕ** *буюу* **И ТАК И ТАК** *буюу* **И ТАК И ЭТАК** [*разг*] ингэж чингэж, инн, тиин, элдвээр, яаж ииж, янз янзаар,

Я уговаривал его и так и иначе, но он не соглашался. Би элдвээр ятгаж үзсэн, ердөө санал ниилдэггүй (Хичнээн яривч хэлхээ ниилэхгүй).

53. **И ТАК И СЯК Т**—13

54. **И ТО** .. чингэсэн, чингэвэл, тэгэвч,

Два только деревца. И то из них одно дождливой осенью совсем обнажено. Хоерхон зулзган мод байсны (байсан боловч) нэг нь намрын усан бороонд шалав цохиулжээ

Он редко приходит на собрание и то каждый раз опаздывает. Хуралд ирнэ гэж байхгүй, ирвэл л хожиг дож байдаг (Тэр хүн) ирдэггүй мөртөө ирэхээрээ бас хожигдож ирнэ

55. **И ТО БЫВАЕТ, ЧТО ОВЦА ВОЛКА СЪЕДАЕТ** паст уулын цагаан арслан, цагаа ирэхэд шорооолжиид баригдах, энэ болж эцсэн морины янгиа болох, цагтаа цалгиж явсан, цагаа ирэхэд талгиж яваа,

56. **И ТО СКАЗАТЬ** учир тодорхой, ... учраас тэр, ... ялгуун тодорхон

57. **И ТО ХЛЕБ.** Олдохгүйд мундахгүй, оргүйгээс дээр, хаа мундах вэ, чамлахаар чанга барь!

58. **И тому ПОДОБНОЕ** (подобные) (хураангуйгаар и. т. п.) гэх мэт, гэх зэрэг, энэ тэр, бас бус, тэргүүтэн, жич

59. **И ТОТ** (та, то, те гэх мэт) чихсэн, ч хүртэл,

Ребёнок и тот поймёт, что это не выгодно. Энэнийг дэмий гэдгийг хүүхэд ч андахгүй.

60. **И УСАМИ НЕ ВЕДЁТ И**—2

61. **И УХОМ НЕ ВЕДЁТ** Илжигний чихэнд ус хийсэнч адил, алт хийсэнч адил, чихгүй толгой оргиод, дүлий дүмбэ оргиод, нэг чихээрээ оруулаад нөгөө чихээрээ гаргах, нүдэн балай, чих дүлий (оргиод)

62. **И ШАТКО И ВАЛКО** (и на сторону) Муугийн муу, адгийн адаг, аль муу Н-1162

63. **И ШВЕЦ, И ЖНЕЦ, И В ДУДУ ИГРЕЦ** Чадахгүй юмгүй; үилэнд уран үгэнд цэцэн, далаид усч, дайнд баатар.., наадмын гурван даваатай, найрын гурван дуутай, арван хуруу тэгш

64. **ИВАН КИВАЕТ НА ПЕТРА** Чиний буруу, миний зөв гэцгээх, бие бие рүүгээ түлхэцгээх, гоохсйг гайхах, хэрээ хэрээнийхээ харыг гайхах

65. **ИВАН, НЕ ПОМНЯЩИЙ РОДСТВА** [*пренебр.*] (Эх орон, ард түмнээ боддоггүй садан төрөл угсаа удам, овог, омог, яс элгэнээ мэддэггүй хүний хэлдэг үг) төрлөө мэдэхгүй нохой, төмрөө мэдэхгүй хуурай, дээдэх дээл, доодох сүүлээ барагсад, эрэг шорооноос гарсан юм шиг, доен царайтай, үнэрлэх үргүй, үржих удамгүй.

66. **ИГОЛКИ НЕ ПОДПУСТИШЬ** (подточить) [*устар*]. өөлөх өөгүй, өө сэвгүй, хий зайгүй, хиигүй

67. **ИГОЛКУ** (иголки) **НЕГДЕ** (некуда) **воткнуть** хөл хийх (гишгэх, орох) зайгүй, пиг дүүрэн, үй түм

68. **ИГРА В БИРЮЛЬКИ** Дэмий юмаар оролдох, ашиггүй юмаар алгасрах И—85

69. **ИГРА В ЗАГАДКИ И**-86

70. **ИГРА В КОШКИ-МЫШКИ И**-87

71. **ИГРА В МОЛЧАНКУ** (молчанки) жимийлцэх, ширтэлцэх

72. **ИГРА В ПРЯТКИ** (в жмурки) И-89

73. **ИГРА В СЛОВА** [*неодобр*] Ам мэдэн магтах, хэт магтах, цаасан малгай өмсгөх, хөвөн чихэх, үгээр нисгэх, магтах үгээ олохгүй

74. **ИГРА ВООБРАЖЕНИЯ** Хоосон санаа, хөлхиндог гутал, хий бодол, зангууны үлгэр, харганы ноос, сэрэхгүй бол сайхан зүүд

75. **ИГРА ЖИЗНЬЮ И СМЕРТЬЮ И**-94

76. **ИГРА НА НЕРВАХ И**-100

77. **ИГРА НЕ СТОИТ СВЕЧ** (свечей) Чимхээр олж атгаар гээх, хайран юм яйран болох, хийсний гарлага болох, гарын гарз болох, цэнгээр олж лангаар гээх,

78. **ИГРА ПРИРОДЫ** Этгээд сонин дүрс, хачин сонин хэв хэлбэр,
79. **ИГРА С ОГНЁМ** Ш-49, И-106
80. **ИГРА СЛОВ** үг нин наадам, хошигнох,
81. **ИГРА СЛУЧАЯ** И-83
82. **ИГРА СТОИТ СВЕЧ** (свечей) И-77 (-ийн эсэргүүцэл утга)
83. **ИГРА СУДЬБЫ** Заяа мэдсэн хэрэг болжээ, заяанаас зайлж болдоггүй, заяа нь энэ, аз мэдэг, азхүү мэдэг, эз мэдэг
84. **ИГРАТЬ БОЛЬШУЮ ИГРУ** [*перен*] Их санаа сана-, ихэд сэвж ява-,
85. **ИГРАТЬ В БИРЮЛЬКИ** [*перен*] Дэмий юмаар оролдо-, үсээ тоол- И-68
86. **ИГРАТЬ В ЗАГАДКИ** Битүү хайүү хэлэ-, егөөдө-, хөвөнд боосон чулуугаар цохи-, цаашлуул И-69
87. **ИГРАТЬ В КОШКИ-МЫШКИ** *с кем* Хөөрхөн малла (молигодо-)-, молиго үмхүүл-, И-70
88. **ИГРАТЬ В МОЛЧАНКУ** (молчанки) [*разг шутл*] 1. Ширтэлцэ-, бие биенээ үзээгүй шиг харалца-, хэлээ хазсан юм шиг, хэл нь татсан юм шиг, 2. Жимийлцэ-, ширтэлцэ-, И-71
89. **ИГРАТЬ В ПРЯТКИ** (в шмурки) [*перен*] Булташ булзааруул-, мэлзэж мэтгэ-, биеэсээ тоируул-, И-72
90. **ИГРАТЬ В РУКУ** И-101
91. **ИГРАТЬ** (идти) **ВА-БАНК** [*перен*] Бүдүүн зүрх гарга-, мангарла-, хар муйхраар, И-118
92. **ИГРАТЬ ВТОРУЮ СКРИПКУ** Бараа сүүдэр бол-, дайвар бол-,
93. **ИГРАТЬ ГЛАЗАМИ** Нүд ирмэ-, жоотгоно-, нүдээрээ дохи-, Жинбагана-
94. **ИГРАТЬ ЖИЗНЬЮ И СМЕРТЬЮ** Үхэх сэхэхээ үзэ-, нэгийгээ үзэ-, эрэгчин эмэгчнээ үзэ- И-75
95. **ИГРАТЬ КОМЕДИЮ** [*перен*] 1. Хиймэл зан гарга-, хүн маллах гэж (хуура-), 2. Жимийлцэж тогло-, Л-114
96. **ИГРАТЬ НА БИРЖЕ** мөрийтэй арилжаа хий-
97. **ИГРАТЬ НА ИНТЕРЕС** Мөрийтэй наада-, Мөнгөөр тогло-, зооc, наада-,
98. **ИГРАТЬ НА КВИТ** даагы нь нэхүүл-, шороогоо нэхэх гэ-
99. **ИГРАТЬ НА МЕЛОК** [*разг*] 1. Өр тавьж мөрийцө-, 2. *шутл.* Өрөө мэлзэ-, өрөнд орооло-, өрөө өхгүй,
100. **ИГРАТЬ НА НЕРВАХ** (*чейх*) (хүний) сэтгэлийг хөдөлгө-, төвшин биш болго-, сэтгэлий нь зовоо-, сэтгэлий нь хөөрүүл-, уймруула-, уулгамчий нь хөдөлгө-, сэтгэлий нь догдлуул-,
101. **ИГРАТЬ НА РУКУ** (в руку) *кому*... (тэрэнд энэнд) хүч гарга-, зүтгэ-, (тийм ийм хүнд буюу юманд) хүчин зүтгэ-, няцахгүй зоригло- С-986
102. **ИГРАТЬ НАЗАД** [*прост*] Ам буца-, хөрөм эргэ-, хэлснээ буха-, эргэж гүтгэ-, үгээ буца-, бултгануур,

103. **ИГРАТЬ ПЕРВУЮ СКРИПКУ** [*перен*] Магнайл-, магнайд байхошуу тата-, хошуучла-, голло-, ангида-
104. **ИГРАТЬ РОЛЬ** (Жүжиг зэрэгт бол тийм хүн юм *болж гар*-гэсэн утгатай, үүнийг зарим орчуулагч нар хэт үгчлэн **играть** гэдгийг нь **тоглох** гэдэг, уг зүи нь тийм ийм юм *бол*- гэвэл зохилтой *Юндэн болж гар*-, *Нансалмаа болж гар*- гэх мэт, **роль** гэдэг нь тун олон утгатай Хүүхэд чоно тарвагацан наадахдаа (Завхан зэрэг газар чоно тарвага буцлах ч гэдэг) *чи чоно бол би тарвага болъё* гэхээс биш, чи чоныи рольд тоглож, бид нар тарвганы рольд тоглоё гэдэггүи. **В роли мальчика была моя дочь** гэдгийг монгольчилбоос Бүсгэи хүүхэд болж гарч байгаа нь миний охин шүү. **Это девочка у них играет няню.** Энэ бүсгүи тэдний хүүхдийн асрагч эх нь юм **Большой ящик играл роль стола** үгчилж орчуулдаг албатаи бол Том авдар ширээний рольд тоглов болчихно Үтгань Том авдрыг ширээ болгон (мэт) (ширээний оронд авдар оруулан) хэрэглэв Учир нийлээс **играть роль** л байвал *рольд тогло*-гэж үгчилж болшгүи нь ив ил Дор дурьдах хэдэч жишээнээс ч давхар нотлож болно
    Он там играет роль Тэр хүн чинь тэндээ чухаг хүний нэг шүү
    В этом деле большую роль играет терпение. Эл ажлыг бүтээхэд тэвчээр л нэн их хэрэгтэи дээ
    Это никакой роли не играет. Энэ (буюу тэр) огт нэмэргүи юм
    Играть роль старухи. Эмгэн болж гар-,
106. **ИГРАТЬ С ОГНЁМ** Ш-49
107. **ИГРАТЬ С СУДЬБОЙ** (**ИГРАЕТ СУДЬБА**) Хувь заяагаараа тогло-, хувь заяагаараа гараа угаа-, заяагаа заглаа-,
108. **ИГРАТЬ СВАДЬБУ** Бэр буулга-, хурим хий, хуримла, бие бүтээ-, бие холбо-,
109. **ИГРАТЬ СЛОВАМИ** (*в слова*) үгээр наада-, хошигно-, шогло-
110. **ИГРАТЬ СТОЛБНЯКА** Мэл гайхаж цэл хөхрө-, мангар юм шиг, дүингэ оргих, цочисхийн гайха-
111. **ИДЁТ КАК** (*к*) **КОРОВЕ СЕДЛО** хэн ч биш, юу ч биш, аль ч үгүи бол-
112. **ИДТИ** (лезть, переть) **В ГОРУ** (в верх) өөдлө-, манда-, дэгжин дээшлэ-, өөдрөг ява- П-591, П-116
112а. **ИДТИ В ГОСТИ** Зочло-, гийчлэ-, айлчилж очи-, айлчин хий-, айлчла-,
    Завтра мы всем семейством пойдём в гости. Маргааш манайхан гэрээрээ айлд айлчилж очно.
113. **ИДТИ В ДЕЛО** П-592
114. **ИДТИ В ДОЛЖНОСТЬ** Албанд суу-, албанд оро-, (тийм ийм) тушаалд тохоон томилогдо-,
115. **ИДТИ В КАНОССУ** [*книжн.*] Алдсанаа мэдэ-, бурууд санаа хүлээ-, бууж өг-, П-594

116. **ИДТИ В НОГУ** *с чем* [*перен*] Эн чацуу ява, мөр чацуу бай зуузай холбо-, онь холбо, хараа бараандаа, нааа нийлэ-, бөө нийлэ-

Идти в ногу с эпохой. Тухайн цагтаигаа мөр чацуу ява, (цагтаа цалги)

117. **ИДТИ В ОГОНЬ И В ВОДУ** *за кого, за что за кем* Яахаас ч сниxгүи бай буцаж няцахгүй, үелзсэн гал үерлэсэн усгаас ч харихгүи, П 595

118. **ИДТИ ВА-БАНК И** 91

119. **ИДТИ В ПРОК** (Тиим ийм юм нд) ашигтай тустай нэмэртэй ийгөэс дээр, нэмэр сэлбэг тус нэмэр **Это ему впрок не пойдёт** тэрүүнд (энэ) нэмэргүи

120. **ИДТИ ВРАЗРЕЗ** *с чем* Харш гал ус шиг, хонь чоно шиг, тас (тэс) хөндлөн мужиин зан гарга- Зөгөөгүи зөрүүд, наашаа гэвэл цаашаа, тэмээ гэвэл ямаа гэ хөндлөн зан гарга, ишигнии эвэр шиг, үг (ярна) ниилдэггүй, хүнтэи нийлдэггүй, ханын толгои шиг, зожиг зантай буруу ишилсэн сүх шиг, ад мөрийн ааштаи, санаанаас гажи зөрөлтгий чигээрээ нүдгүй хар лус шиг, хүнии үг хор болсон, илжигний чихэнд ус хийсэн, алт хийсэн ч сэгсрээстэи

Он всегда шёл вразрез с мнением большинства. Олныхоо санаанаас гаждаг хүн дээ (хүн хүнээс эггээд эр шүү)

Все его поступки всегда идут вразрез с его словами. Ам ажил хоер нь ар зоогоороо нийлсэн хүн

121. **ИДТИ ЗАМУЖ** *за кого* Эрд гар-, хадамд очи, айлын хүн бол, айлын өрхнии оосор тата, айлын бэр бол, хүргэнд мордо, хүнии хүн боло, нэг хүнтэн (эртэй) толгой холбох, ханьтаи боло, нэг юм дагаад ява-, хүнд очи,

Старшая дочь его вышла замуж ещё в прошлом году. Их хүүхэн нь аль ноднин эрд гарсан

122. **ИДТИ К ДЕЛУ** холбогдол бүхий, хэлхээ холбоотой

123. **ИДТИ КО ДНУ** 1. **живэ-**, ероолд хүр- 2. [*разг перен.*] Хиймор нь үхэх, заяа нь хая, уутны ам уруугаа хара, доройто, буура, уут модоо бари-, таяара, гуйлгамчийн 33 уутаа (хүүдий) бари уруудаж бурууда толгоигоороо ус уу-,

223а. **ИДТИ, КУДА ВЕТЕР ДУЕТ** [*разг ирон*] Салхин дүүгүүр, салхины аяар салхи хаашаа бол тиишээ, савдаг элээ, эрэг хаашаа бол ус тиишээ гэгч шиг, хиисч явдаг, зүгээ алдсан, улааныг үзэж урваж шарыг үзэж шарвасан, өөрийн мэдэлгүй, хий хуар, соотон нохой чимээнээр, сохор нохой дүйвээнээр, хараалалгүй бууда, бодолгүй бура-, цаасан дарцаг,

Молодежь не должна идти, куда ветер дует. Залуу хүн салхи хаашаа бол тиишээ гэгчээр явж болохгүй (Залуучуул хии хуар (дүивээнээр) явж болохгүй шүү. Залуу хүн цаасан дарцаг шиг (хөөгдөж) байж яаж болох вэ)

Она сознательно идёт ко дну. (тэр эмэгтэй) Өөрөө өөрийгөө уруу нь татчихаж баигаа юм (Биеэ уруу нь татсан хүүхэн дээ. Толгойгоороо ус уусан хүүхэн)

536. КРОВЬ С МОЛОКОМ [*разг.*] Улаан цагаанаараа ялгарсан (эрүүл цэрэй), улаа бутарсан, цэцэг цэврүү шиг, булбарай (цэрэй).

537. КРОВЬ СТЫНЕТ (леденеет) (в жилах) (цочир айгаад) дотор налас хийх, дотор нал хийх, үнхэлцэг хагачих шахах, үүшиг зүрх амаар гарах шахах, дотор хиртхийх, бие зарсхийх, оройн үс өрөсхийх,

538. КРОВЬ УДАРИЛА (бросилась) В ГОЛОВУ *кому* уур манас хийв, уур шатаад явчихав, дотор манас хийв, дотор арзас хийв нүүр нь минчийв, ямаан омог хөдлөв,

Кровь бросилась мне в голову, но я сдержал себя и не ударил его. Уур манас гээд л явчихлаа, би биеэ барнад арай гар хөдөлгөлгүй тогтов.

539. КРОВЬЮ СЕРДЦЕ ОБЛИВАЕТСЯ өрөвдөх, төлөөнөөс нь үстэй толгой арзайх шиг болох, гол харлах, элэг эмтрэх, зүрх шимшрэх

Кровью сердце обливается при виде несчастных голодных детей. Өлөн бирдийн зовлон эдэлсэн багацуулыг хараад өрөвдлөө байна.

540. КРОКОДИЛОВЫ СЛЁЗЫ [*разг. ирон.*] нулимсаараа хуурах, уйлахаараа айлгах. Л-84

541. КРОМЕ КАК [*разг.*] . . . аас[4] өөр, . . аас[4] гадна,

Никуда не хожу, кроме как на службу. Албаныхаа газраас өөр газар явдаггүй (зүглэдэггүй).

542. КРОМЕ ШУТОК [*разг.*] тоглоом биш, инээдэм биш, инээх юм биш, нээрэн шүү. Б-111

543. КРУГ ЖИЗНИ [*книжн.*] нэг насаар, насан турш, энэ яваадаа энэ сүүдэртээ.

544. КРУГЛЕНЬКАЯ СУММА овоо мөнгө, нилээд мөнгө, хэтэвч дүүрэн мөнгө.

545. КРУГЛЫЕ СУТКИ өдөр шөнө хоёр, өдөржин шөнөжин, бүтэн хоног, нэг хоног, өдөр шөнөгүй.

На заводе круглые сутки кипит работа. Үйлдвэрт өдөр шөнөгүй ажил оволзож байдаг.

546. КРУГЛЫЙ ГОД жил тойрон, бүтэн жил, жилжин, жилийн турш, жилээр,

Мы живём в городе круглый год. Бид нар энэ хотод бүтэн жил сууж байна.

547. КРУГЛЫЙ НЕВЕЖДА үзэг ч үгүй хүн, а ч үгүй амьтан, умаа хум амьтан, а-гийн ацаггүй арвын тэггүй.

548. КРУГЛЫЙ СИРОТА өнчин, өнчин өрөөсөн, эцэг эхгүй, гон бие гөвөн толгой, доёл, элэг нь хатсан, элэх ээжгүй энэрэх эцэггүй, түших тулах хүнгүй, үнсэнд хаясан шалз.

549. КРУГОВАЯ ПОРУКА бөөрөөрөө нийлсэн, бүүрэлхүү, бие биенээ хаацайлаад, элэг бүлгээрээ, хань хамсаагаараа.

550. КРУГОМ ШЕСТНАДЦАТЬ Долоо дордов, доордохын долоо болох, авах юм алга.

551. КРУЖИТЬ ГОЛОВУ *кому* [*разг.*] толгой эргэ-, толгойгий нь эргүүл-, малла-,

552. КРУЖИТЬСЯ В ВИХРЕ *чего* (тийм ийм юманд) шунаж гүйц, ухаангүй шохоорхо-, унаж үхэ-, хөл алда-, амь тави-, ухаж үхэ-,

553. КРУЖИТЬСЯ, КАК БЕЛКА В КОЛЕСЕ хий сандчи-, дэмий уймра-, учраа олохгүй үймэ-, дороо эргэлдэ-, эргүү мал шиг.

554. **КРУЖНЫЙ ПУТЬ 1.** Тойруу зам, холуур, **2.** Дам, холуур, тойруулсхийгээд.

Ехать кружным путём. Тойруу замаар ява-,

Узнать (что) кружным путём. Дам сонсо-, дамаас мэдэ-, хүнээс дуула-,

555. **КРУПНЫЙ РАЗГОВОР** [*разг*] халз маргах (тулах), толхилцох, чи би дээ хүрэх, энэ тэрүүндээ хүрэх, их зөрөх, хамар муруйх, тэх тэхгүйдээ хүрэх.

Вчера я имел крупный разговор с отцом. Өчигдөр би аавтайгаа зөрж зөрж орхив.

556. **КРУТИТЬ ВОЛА В**—526

557. **КРУЖИТЬ ГОЛОВУ** толгой эргүүл-, уруу тата-, төөрөлдуул-,

558. **КРУТИТЬ НОСОМ** мятран хулга-, хулалза-, арга саам хий- (мий шиг) хумсаа нуу-,

559. **КРУТИТЬ РОМАН (любовь)** *с кем* [*прост*] сэртэндэ-, сээ тэн хая-, учиртай бололцо-, хагацахаа бай-

560. **КРУТИТЬ РУКИ** *кому* [*разг*] гары нь ард нь хүлэ-, хүл гэнд оруул-,

566. **КРУТИТЬ ХВОСТОМ В**-527, 643, **З**-101

567. **КРУТИТЬ ШАРМАНКУ** ягиж яншин-, амныхаа уншлагыуншин-, улигла-,

568. **КРУТОЙ КИПЯТОК** ус даргилан буцлах, даргилж байгаа ус

569. **КРЫЛАТЫЕ СЛОВА** мэргэн үг, оновчтой үг.

570. **КРЫЛЬЯ ОБРЕЗАНЫ** *у кого* далавчаа хугалчихсан шувуу шиг, үнсэнд хаясан шалз шиг, нам цохнулсан, эврээ хугалуулсан

571. **КРЫТЬ НЕЧЕМ** *кому* хэлэх үг олдохгүй, үггүй бол-, аман дээрээ алгадуулсан юм шиг, амаа таглуул-, баалуул-,

572. **КРЫШКА** *кому* баларчээ, дүүрчээ, өнгөрчээ, хөгөө тарьж хөгнөө чиржээ.

573. **КТО БЫ МОГ ПОДУМАТЬ** хэн тэгэж мэдэх вэ? Хэн мэдэх вэ? Хэн тэхийн чинээ бодох вэ?

574. **КТО БЫ НИ** хэн ч гэсэн, хэн ч атугай, хэний хэнбугай ч хэний хүү ч, хэн эс вэ,

575. **КТО В ЛЕС, КТО ПО ДРОВА** мөр мөрөө хөөх, амь амиа харах, хувна борлуулж довоо шарлуулах, мөр мөртөө мөндөл дошиндоо,

Кто всегда бережется, тот никогда не обожжется. Айж явбал аминд ээлтэй. (өлзийтэй)

Кто вчера солгал, тому завтра не поверят. Нэр хугарахаар яс хугар.

576. **КТО ВО ЧТО ГОРАЗД** дур дураараа, өөр өөрийнхөөрөө, санасан санаснаараа, хувь хувийн тааллаар.

577. **КТО ДО ДЕНЕГ ОХОТ ТОТ НЕ СПИТ И НОЧЬ** хонь мянга хүрвэл идэх хонь олдохгүй, адуу мянга хүрвэл унах морь олдохгүй, шунал ихэдвэл шулам болно, баян хүн малын боол, ядуу хүн хүний боол.

579. **КТО ЖЕ БЕЗ ГРЕХА** нүглээ барсан хэн байх вэ?

580. **КТО ЗАВАРИЛ, ТОТ И РАСХЛЁБЫВАЙ** өөрийн хийснийг өөрөө, өөрөө хийсэн лай, өөрөө ойчсон хүүхэд уйлдаггүй, үйлийн чинь үр, үхсэн хар заяа чинь!

581. **КТО КОГО** хэн нь хэнийг дийлэх нь вэ, хэн нь давах нь вэ, хэн нь түрүүлэх нь вэ?

582. **КТО КУДА (разбежались, разошлись и. т. п).** тал тал тийшээ явах, чиг чигтээ, зүг зүгтээ, ийшээ тийшээ.

583. **КТО НИ НА ЕСТЬ** хэн ч байсан, хэн ч гэсэн, хэн бүхэн, хэн маань ч,

584. **КТО МНОГО ЗНАЕТ, С ТОГО МНОГО И СПРОСИТСЯ К**—422

585. **КТО ПАХАТЬ ЛЕНИТСЯ** *у того* **И ХЛЕБ НЕ РОДИТСЯ** залхуугийн гадаа аргалгүй, залгидгийн гэрт хоолгүй, залхуу эмгэн завагтаа махандаа хүрдэггүй,

586. **КТО ПОСЕЕТ ВЕТЕР, ПОЖНЁТ БУРЮ** өөрийн хийсэн өөрт, өөд нь хаясан чулуу өөрийн толгой дээр

587. **КТО С ЯРЫЖКОЙ ПОВОДИТСЯ, БЕЗ РУБАХИ НАХОДИТСЯ** Муу хүнтэй нөхөрлөвөл могойн хорлол, мууг дагавал ядаж, муугаас муу модноос хөө, ороо ороогоороо жороо жороогоороо,

588. **КТО СКАЗАЛ А, (тот) ДОЛЖЕН СКАЗАТЬ И Б** Эхэлвэл дуусга-, ажил хийвэл дуустал, давс хийвэл уустал, за гэвэл ёогүй, хэлсэндээ хүрч, хэрчсэнээ ид! Их барьсан ч үмхий, бага барьсан ч үмхий,

589. **КТО СТАРОЕ ПОМЯНЕТ, ТОМУ ГЛАЗ ВОН** Ховч өөрийгөө ховолдог, хүний мууд дуртай хүний шилийг дар!

590. **КТО ТАКОЙ (КТО ТАКИЕ)** Хэн байна? Ингэхэд хэн бэ тэр чинь? Чи хэн болоод? . . , Хэн гэгч байна? Хэн тэр вэ? Юу болоод?

Кто вы такой, что приказываете мне? Та хэн болоод намайг нэг их тэг ингэ гээд байна? (Та тань ингэхэд хэн гэгч болоод ингэтэл зарлиг буулгаад байна вэ?)

591. **КТО ТУТ?** Хэн бэ та?

592. **КУДА БОГ НЕСЁТ?** Хаана очиж явна? Хаа хүрэх нь вэ?

593. **КУДА ВЕТЕР ДУЕТ** [*ирон*] салхины ая дагах, салхи хаанаасаа бол тийшээ, хөвж дэвсэн, хамхуул шиг,

594. **КУДА ВОРОН КОСТЕЙ НЕ ЗАНОСИЛ** газрын мухарт, холын холд, тэнгэрийн хаяанд.

595. **КУДА ГЛАЗА ГЛЯДЯТ (идти, бежать и. т. п).** [*разг.*] Хаашаа ч хамаагүй, салхи хаанаас бол тийшээ, чиггүй

596. **КУДА ГНЁТ** [*разг, фам.*] Юу гэсэн шиг? Яах санаатай? Ямар ухаантай?

597. **КУДА ЗРЯ (разбежались)** Арван зүгтээ, зүг зүгтээ, толгой чиглэсэн зүгтээ, хаашаа хамаагүй, харсан зүгтээ, бутрах, задрах, бут үсрэх, тал бүр тийшээ,

598. **КУДА КАК** [*прост. ирон*] яасан, юутай, үлэмж, мөн ч.
Куда как приятно его слушать! Зарлигий нь сонсох мөн ч сайхан даа (Үгий нь сонсох мөн ч хавтай юм. Үгий нь дуулахад урамтай).

599. **КУДА КРИВАЯ ВЫВЕЗЁТ** аз мэдсэн хэрэг, дүүрсэн хэрэг, дүнхийсэн толгой.

600. **КУДА МАКАР ТЕЛЯТ НЕ ГОНЯЛ (послать, упечь и. т. п).** (Айлгаж далайлгах үг) газрын мухарт, долоон уулын цаагуур, нүдэнд үл үзэгдэх чихэнд эс дуулдах газар, хүнгүй газар.
Я вас туда упеку, куда Макар телят не гонял (Салтыков-Шедрин). Би чамайг долоон уулын цаагуур аваачна.

601. **КУДА МАХНУЛ (хватил)** [*прост.*] хамаа намаагүй ярив. Пүл пал юм хэлэв. Эв хавгүй ярив (чалчив). Палчуулж гарав. Бурж алдав. Булчимгүй ярив. Амгайгүй загнав.

602. **КУДА НИ КИНЬ (везде клин)** [*разг.*] 1. Хаашаа ч харсан, эргэн тойрон, хаана л бол, нүд эрээлжлэм, 2. Яалт ч үгүй, ацан шаанд орох, хаашаа харж үхэх вэ бүү мэд! Бүтлээ бүлээн усаар угаах
Куда ни кинь, везде народ. Хаа л бол хүн (Хаашаа ч харсан л хүн).

603. **КУДА НИ СУНЬСЯ** [*разг*] Хаа ч очсон, хаа ч гэсэн, газар сайгүй.
Куда ни сунься, всюду отказ. Хаана ч очсон болохгүй л гэвд болохгүй.

604. **КУДА НИ ШЛО!** [*прост*] Тэгвэл тэгэг цаашаа! За яршиг даа. За нохой долоо! Тэгэж ингэхээс биш! Одоо яая гэх вэ! Ингэж чингэж үзэхээс дээ (гэх мэт дуртай дургүй за хүлээх саная). Тэгсэн ингэсэн шүү болохоос доо! За яахав.
Поеду уж, куда ни шло! За явъя даа, явахаас л биш, явмар болохоос доо.

605. **КУДА НОГИ НЕСУТ** Хаашаа хамаагүй явдаг, харсан зүгтээ явдаг, чиг баггүй бэдэрдэг, чиггүй явдалтай

607. **КУДА ТАМ** [*разг.*] Яаж болох вэ! Хаанаас даа, яалаа гэж! Тийм юм хаа байх вэ?

608. **КУДА ХВАТАЕТ ГЛАЗ** Нүд хүрэх газар, хараа хүрэх газар, хараа гүйцэх газар.

609. **КУДА ЭТО ГОДИТСЯ** Яаж ингэж болох вэ? Энэ ч зохилдохгүй ээ!

610. **КУЙ ЖЕЛЕЗО, ПОКА ГОРЯЧО** Ямарваа юм сонин дээрээ, ямааны мах халуун дээрээ, сонин дээрээ соохолзох, эхэн даруйдаа, шинэхэн дээрээ, анхны юм амттай.

611. **КУКИШ В КАРМАНЕ (держать, показывать)** [*прост.*] Уулын цаанаас тархиндах, халж ядахдаа хаяанд нь хар чацга алдах, байж ядаж барьж алдах.

612. **КУКИШ С МАСЛОМ** санадаггүй саная, амбан явахгүй, даахгүй булуу, баршгүй хоол, цусаар уйлаад ч нэмэргүй, тавгалдаггүй ажил, санахын халцгай, санасны гарз. Ф-4

613. **КУКОЛЬНАЯ КОМЕДИЯ** [*перен.*] засдаг ааль, хиймэл зан, үүдэн шүдээрээ хуурах, хоосон ёс, ёс төдүй болгох, тэгсэн болох,

614. **КУЛАК В ДЕЛО (пустить)** [*прост.*] гар хүрэх (хүн зодох), зодоо хийх,

615. **КУМА—ЛИСА** үнэг, овт шар, сүүлээрээ хуурдаг.

616. **КУПАТЬСЯ (утонать) В КРОВИ** (олны) цусаар гараа угаа-, хүн ардыг яргала,- хүйс тэмтрэ-,

617. **КУПИ КОНЯ—И ХОДА ТВОЯ** За гэвэл ёогүй.

618. **КУГНАЯ КРЕПОСТЬ (устар)** Тамгын бичиг, зар бичиг.

619. **КУРАМ НА СМЕХ** [*разг*] шал дэмий, хөх инээд хүрмээр, учир утгагүй, инээд хүрмээр, элэг хөшөөчмөөр.

620. **КУРИНАЯ ПАМЯТЬ** [*разг*] үнэг шиг мартамхай, баавгай тарвага сугавчлах гэх шиг, мартана гэдэг нь ёроолгүй сав шиг, ой муутай, нэг чихээрээ оруулаад нөгөөгөөрөө гарга-,

621. **КУРИНАЯ СЛЕПОТА (КУРЬЯ СЛЕПОТА)** [*прост*] 1. Холтойсон цэцэг; (*бот*) 2. Харалган, хараа муутай.

622. **КУРИТЬ ВЗАТЯЖКУ** шимтэн соро-, ангасан монголын үнээ шиг, гурван жил юмны бараа хараагүй юм шиг.

623. **КУРИТЬ ФИМИАМ** бялдуучла-, тойгло-, ая заса-, тал заса-,

624. **КУРИЦА НЕ ОБИДИТ** хорхойд хоргүй (хүн), хэвтээ хонь бөсгохгүй, хонь шиг номхон, бурхан шиг.

625. **КУСАТЬ ГУБЫ (себе)** уур хүрэ-, дургүй нь хүрэ-, шазуур зуу-, шүд зуу-, хөмхийгөө зуу-,

626. **КУСАТЬ СЕБЕ ЛОКТИ** шагшра-, хар буу-, гол харла-, даан ч яав аа гэж гэмши-, амаа бари-, гасла-, толгойруугаа шаа-, өр алдсан хятад шиг,

627. **КУСОК В ГОРЛО (в глотку) НЕ ИДЁТ** *кому* Юу ч ам руу орж өгөхгүй, идэхтэй манатай, аман дээр тэмээ тийрчихээд,

628. **КУСОК ХЛЕБА** [*разг*] аяга хоол, улаан хоолой, атга ээзгий, зүсэм бяслаг, аяга будаа, таваг тариа.

629. **КУХОННАЯ ЛАТЫНЬ** [*шутл.*] эрээнтэй бараантай сурсан (латин хэл), сурсан сураагүй хоёрын хооронд, дулимагхан сурсан.

630. **КУЧА МАЛА** (хүүхдийн тоглоомын) унагах уухай, хожих уухай,

Л

1. **ЛАВРОВЫЙ ВЕНОК (венец)** лавар эрхи-, (ялалтын тэмдэг). Эртний Герег Римчүүд үлэмжийн ялалт гавъяа байгуулагсадад лавр цэцгийн эрхи хүзүүнд нь өргөдөг заншилтай байжээ.
2. **ЛАВРЫ ГЕРОСТРАТА Г—30**
3. **ЛАВРЫ СПАТЬНЕ ДАЮТ** *кого чьи, кому* хор нь буцлах, атаархах, атаа жөтөө болох, жөтөөрхөх,
4. **ЛАГЕРЬ СМЕРТИ** Хүний бой, энэ насны тамын орон, алуурын газар, цаазын газар,
5. **ЛАЗАРЯ ПЕТЬ** [*разг.*] зовлонгоо тоочих, үглэж дуулах, арга учраа ярих, уйлан донгодох,
   Со мной Лазаря петь не чего. меня не провёдёшь. (Тургенев). Зовлонгоо тоочиж байгаа янз гаргаад намайг хуурч чадахгүй шүү (Цусаар уйлсан ч би хууртахгүй).
6. **ЛАКОМЫЙ (жирный) КУСОК (кусочек)** [*разг.*] хорхой хүрэм (юм) дээд уруулд хүргэмгүй, шүлс гоожмоор, дур булаам, бурам шиг, чихэр шиг, зөөлөн хоол, уухайн хужир, уухайн шар тос.
7. **ЛАПТЕМ ЩИ ХЛЕБАТЬ** [*прост.*] өлөн живэр амь зуу-, өлөн хээлээр бай-, ядуу зүдүү ява-, шар нар бор хоног өнгөрөө-, шалдар балдар бай-, най нь тачсан шиг бай-
8. **ЛАПТЫ ПЛЕСТИ** [*перен.*] эв хавгүй яриа, хойно өмнө нь оруулж ярих, нүл пал хийсэн, хэл ам нь эвлэхгүй,
9. **ЛАСКОВЫЙ ТЕЛЁНОК ДВУХ МАТОК СОСЁТ** үгчилбээс: эрх тугал тэлээлдэг, утга нь: талтай бол бүлтэй, талтай бол талын чинээ, талгүй бол аягын чинээ, хайры нь булаавал амандахий нь булаана.
10. **ЛАТИНСКАЯ КУХНЯ** [*разг, шутл*] Эмийн сан.
11. **ЛБОМ СТЕНЫ НЕ ПРОШИБЁШЬ** өндгөөр хадыг хага цохидоггүй, төлгөн хуц элгэн хад мөргөх гээч, хад мөргөсөн ишигний толгой хагарна.
12. **ЛЕБЕДИНАЯ ПЕСНЯ** сүүлчийн нь зохиол, эцсийн нь бүтээл, бүтээлий нь шувтрага, зохиолы нь отго.
13. **ЛЕВАЯ СТОРОНА** (бөс бараны) ар, дотор, (нэхийний) хөрс.
14. **ЛЕГКАЯ ЖИЗНЬ** гэдэс цатгалан мөр бүтэн аж төрөх, зовлон гэзчийг мэдэхгүй суух, таваараа аж төрөх, гарын ганган, хөлийн хөнгөнөөр, бие зүдрэлгүй амь зуух, яс амар суух, бие амар суух
15. **ЛЕГКАЯ РУКА** *у кого* [*разг*] Буянаа дэлгэрсэн хүн, өлзий хаяатай айл (хүн), амны хишигтэй (хүн), заяа нь дэлгэрсэн.
16. **ЛЕГКИЙ ХЛЕБ** зөөлөн хоол, зөөлөн хуурга, бэлэн хоол.
17. **ЛЕГКО СКАЗАТЬ** хэлэхэд амархан, тийм ч гарын үзүүрээр хийчих юм биш, хэлээд л болчих юм биш, дуртай болгон чадахгүй.

18. **ЛЁГКОСТЬ В МЫСЛЯХ** [*шутл*] хуудам хөнгөн, хам хум, нигэс тэгэс хийгээд, оромдоод, хуламдаад.
19. **ЛЕГОК НА НОГУ** ухаангүй хурдлах, ядарч үхэхээ мэдэхгүй явах,
20. **ЛЕГОК НА ПОДЪЕМ** хөнгөн шингэн, хөнгөхөн, хөл хөнгөн.
21. **ЛЕГОК НА ПОМИНЕ** сайн хүн санаагаар, өгье гэвэл ганцаасаа, уйлья гэвэл сохроосоо.
22. **ЛЕГОК НА РУКУ** Ирье гэж санаж, гар султай, хөл хөнгөн.
23. **ЛЕГЧЕ ВЕРБЛЮДУ ПРОЙТИ СКВОЗЬ ИГОЛЬНОЕ УШКО** тэвний чинээ сүвэгчээр тэмээн чинээ салхи, тэвний сүвэгчээр тэмээн ачаа, олон голын жавраас орны хөндий жавар.
24. **ЛЕГЧЕ ЛЁГКОГО** [*разг*] нохойн наадам, юу амархан бэ тэр амархан, хүүхэд нохойн наадам, юухан байх вэ?
25. **ЛЕГЧЕ НА ПОВОРОТАХ!** [*разг*] Амаа мэд! Хирээ мэдэж ярь! Амаа тат! Бодож ярь! Хараалалгүй буудах гэгч болуузай! Урт хошуу хүзүү ороохо.
26. **ЛЁД РАЗБИТ (сломан)** [*прост*] Бэтэг хагарах, уяа тайлагдах, зангилаа гарах, хөндүүр нь гарах
27. **ЛЁД ТАЕТ (растаял)** Тайвширав, учир зүгээ олов, сэтгэл уужрав, санаа амрав.
28. **ЛЁД ТРОНУЛСЯ** нохойн дуу соносдов, хэрэг мандав, баярлах цаг ойртлоо.
29. **ЛЕЖАТЬ БЕЗ ДВИЖЕНИЯ** [*перен*] (бичиг хараа) хав дараастай, зөөвөртөө хэвтээ, гар хүрээгүй, салхи ч оруулаагүй, (үзүүлээгүй).
30. **ЛЕЖАТЬ В ЛЁЖКУ** хэвтэрт оро-, хэвтрээс босохгүй, хавтгайгаараа бол-, хүний гарт оро-, бөгс нь бяцарсан хорхой аятай, дутуу алсан могой шиг; үхдэггүй сэхдэггүй.
31. **ЛЕЖАТЬ В ОСНОВЕ** *чего* . . . ны үндэс бол-, . . . ны суурь бол- , . . . дэвсгэр бол-, таргийн хөрөнгө-, эх эсгий, үр үндэс,
32. **ЛЕЖАТЬ НА БОКУ (на печи)** сул суу-, сунаж унтаж суйлж маажи-, алцайгаад л хэвтэ-, алмайран суу-, ангайж идэж алцайж хэвтэ-, цаг нөгцөөж насаа элээ-, гар хумхиж суу-, гэрийн мухар сахи-,
33. **ЛЕЖАТЬ ПЛАСТОМ (как пласт)** гулдийтал хэвтэн, засаа идсэн нохой шиг хэвтэ-, хэвтээжүү, хээл хаясан юм шиг, халгай идсэн тэмээ шиг, сунаж уна-, тарайж хэвтэ-, бөөр нь уначихсан тэмээ шиг,
34. **ЛЕЖАТЬ НА ПЛЕЧАХ** *кого чьих у кого* тэжээн тэтгэгч.
35. **ЛЕЖАТЬ ПОД СУКНОМ** хөсөрдө-, хөсөрдүүл-, хайран юмыг яйран болго-, дарагдуул-, гараар аваад хөлөөр өшигл-,
36. **ЛЕЖАЧЕГО НЕ БЬЮТ** үхсэн хүнээс өшөө авдаггүй, хахсан дээр нь бүү гудар, хазайсан дээр нь битгий түлхэ,
37. **ЛЕЖИТ НА ДУШЕ** [*разг.*] санаа зовох, сэтгэл зовох, санаанаас гарахгүй, санааны мухарт байх, цээжний мах идэх,

38. **ЛЕЖИТ НА СОЛОМЕ, ГОВОРИТ С КОВРА** гуймтгай байж голомтгой, гувшамтгай байж нудрамтгай; чөмөггүй байж туг ширээ; санаа нь хярд, сачий нь бэлд; саваагүй нохой саранд хуцах; их санаатай, бяраа мэдэхгүй, хирээ танихгүй.

39. **ЛЕЖИТ НА СТОЛЕ** [*разг. перен.*] гэр ганцаараа сахих, ханхай гэр сахих, гэрийн мухар сахих, ор ганцаар орон сахих,

40. **ЛЕЖИТ ПЕЧАТЬ** *чего* **(ЛЕЖИТ ОТПЕЧАТОК)** *чего* ... -ийн шинж мэдэгдэ-, -ийн ор мөртэй, . . . ийн шинжтэй

41. **ЛЁЖМЯ ЛЕЖАТЬ** [*разг.*] хэвтэрт бай-, хэвтэрт оро-, хавтгайлаараа, сүүжилдэ-, сүүж нь чилэ- (цооро-).

42. **ЛЕЗТЬ В БУТЫЛКУ (в пузырь)** дэмий уурла-, уурламааргүй юманд уурла-,

43. **ЛЕЗТЬ В ГЛАЗА** [*разг.*] Юу болов гэмээр, хармаар.

44. **ЛЕЗТЬ В ГОЛОВУ** санаанаас гарахгүй, өдрийн бодол шөнийн зүүд, орсон ч гарсан ч бодолд.

45. **ЛЕЗТЬ В ГОРУ И**-112

46. **ЛЕЗТЬ В ПЕТЛЮ** [*разг.*] боож үхэ-, боомилж үхэ-, өөртөө лай хураа-, толгойдоо булуу хураа-

47. **ЛЕЗТЬ ВО ВСЕ ЩЕЛИ** хөндлөнгөөс хөлөө, хөгнөнд хөлөө, хөндлөнд хүзүүгээ.

48. **ЛЕЗТЬ ИЗ КИШОК** улаймсуу хий-, махруу хий-, тавихгүй хий-, улайрган, ядрахаа мэдэхгүй, үхэн зүтгэ-,

49. **ЛЕЗТЬ ИЗ КОЖИ (вон)** [*разг.*] амь тавин, байдаг чадлаараа, хар хүчээрээ, арвынхаа арыг барж зүтгэ-.

50. **ЛЕЗТЬ НА ГЛАЗА** *кому* хүний нүдэнд харагдах гэж, хүний урдуур хойгуур гүйж, өөрийгөө харуулах гэж.

51. **ЛЕЗТЬ (идти, переть) НА РОЖОН** төлгөн хуц элгэн хад мөргө-, өндгөөр хад цохи-, голио азаа үзэ-, тулгаа үдээрээр үдэ-, өөрийгөө хуура-, сэтгэлээ хуура-, биеэ хуура-, И-131, П-664

52. **ЛЕЗТЬ НА СТЕНУ (от боли, от волнения, от возбуждения, от гнева)** [*разг.*] (Уурлаад тэвдээд) боож үхэх шаха-, уур нь хагачи-, шээс гоожтол өвдө-, уур нь шата-,

53. **ЛЕЛЕЯТЬ, КАК ЗЕНИЦУ ОКА** амь мэт хайрла-, хар нүд шигээ хайрла-, үнэн голоосоо хайрла-, нүд мэт хайрла-, амь шигээ энхрийлэх, үр шигээ бөөцийлө- амин гол л гэсэн үг,

54. **ЛЕНИВЫЕ ЩИ** байцааны шөл, шийжүү, ногооны усан шөл.

55. **ЛЕС РУБЯТ-ЩЕПКИ ЛЕТЯТ** дайны хажуугаар дажин, гарзгүй олз гэж байдаггүй, лангаар олоод цэнгээр хаядаг, аахилаачингийн дэргэд уухилаачин,

56. **ЛЕТЕТЬ (полететь) ВВЕРХ ТОРМАШКАМИ** нэгмөсөн хөмрө-, ёроолоороо эргэ-, бүрмөсөн балра-,

57. **ЛЕТО ОТ СОТВОРЕНИЯ МИРА . . .** тэргүүлэшгүй цагаас наанш, эрт урьд элэр балар цагаас (монгол хэлний, дэлхийг дээврийн чинээ байхад, алтайг алгын чинээ байхад, загал булгыг

янзаг байхад, захын модыг зулзаг байхад, сүмбэр уулыг гүвээ байхад, сүн далайг шалбааг байхад, далай ламыг банди байхад зэрэгтэй төсөрхүү

58. **ЛЕТУЧИЙ ЛИСТОК** ухуулга хуудас, тармал хуудас, наалдуулсан бичиг, ятгах зурвас,

59. **ЛЕЧЬ В ОСНОВУ** *чего* дэвсгэр бол-, ул бол-, иш бол-, суурь нь бол-, шав тави-, тэрлэ-, үүсгэ-,

60. **ЛЕЧЬ КОСТЬМИ** цэрэг дарагда-, дайнд амиа алда-,

61. **ЛЕЧЬ НА БУМАГУ** Л-106.

62. **ЛЕЧЬ НА ПЛЕЧИ** *кому* (. . . тэрний) толгой дээр ирэ-, (тэр хүн) дээр буу-, зайлах замгүй бол-.

63. **ЛЕЧЬ НА СЕРДЦЕ** санааг нь зовоо-, сэтгэлий нь гонсойлго-, шээсий нь гоожуул-, хоры нь маажи-, зүрхий нь шимшрүүл-,

64. **ЛЕЧЬ НА СОВЕСТЬ** учир ёсыг хөсөрдүүл-, хүний сайхан сэтгэл рүү ус хий-, урмыг хугала-, хүн тэгэж сайхан байхад... ний байгаа нь энэ, амар байна уу гэсэн биш гай бол-, сэтгэлий нь ээдүүлж итгэлий нь хөсөрдүүл-, тусыг усаар, нүүр өгөхэд бөгс өгөх гэгч, өрөвдсөний өрийг өшигдө-, өөх өглөө гэж өглөө босоод заргалдав гэгч.

65. **ЛЕЧЬ СВИНЦОМ НА СЕРДЦЕ (душу)** [*перен.*] дотор палхийгээд явчи-, дотор харанхуйла-, хоолой дээр нэг юм тээглэ-, бүлх залгичихсан юм шиг бол-, дотор гонсой, дотор хиртхий-, зүрх зүсэ-, гол гонсой-, дотор хахуулда-.

Это известие легло мне свинцом на душу. Ийм мэдээ дуулаад бүлх залгичихсан юм шиг боллоо байна (Гол гонсойцорлоо).

66. **ЛЕЧЬ ТЕНЬЮ** (*на кого-что*) *бүүр* **ЛЕЧЬ (чёрном) ПЯТНОМ** *на кого-что* сэв суу-, муу юм бол-, буртагла-, гутаа.

67. **ЛЕШИЙ (меня) ДЕРНУЛ** Б-157

68. **ЛЕШИЙ ДЕРНУЛ (меня) ЗА ЯЗЫК** Ч-69

69. **ЛИБО ПАН, ЛИБО ПРОПАЛ** нэг бол үхнэ, нэг бол сэхнэ, алддаг онодгийн нэг болох, давдаг давдаггүйгээ үзэж, сайжрах муужрахаа үзэж; боол болох, богд болохоо үзэж; харц болох, хаан болохоо үзэж,

70. **ЛИВМЯ ЛИТЬ (литься)** [*разг.*] (бороо) хувингаар асгасан юм шиг цутга-, (бороо) цутга-, шааги-; (нүдний нулимс) мэлмэрэн асгара-.

71. **ЛИЗАТЬ ПЯТКИ (сапоги, ботинки и. т. п)** нүүрдэ-, нялгана-долоох нь халаг.

72. **ЛИЗАТЬ РУКИ (ноги, пятки)** *кому* хав шиг эрхлэ (долигоно) долоочих шаха-, доотохы нь долоо-, бөхөлзөж нөхилза-, сүүдэр шиг бөнжигнө-, нялуура-, бялдуучла-, зусарда-, долигоно-, зуйра-, бөхөлзөж тонголзо-, дохилзож нахилза-.

73. **ЛИНИЯ ВЫХОДИТ (подошла)** *кому* [*прост.*] нөхцөл бүрэлдэх, үүд нь нээгдэх, зам нь шулуудах

74. **ЛИНИЯ ЖИЗНИ** (амны хишгий нь) алгаар нь шинжих, гарын хуараар заягий нь шинжих, насы нь үзэх.

75. **ЛИРИЧЕСКИЙ БЕСПОРЯДОК** 1. Хэм айзамгүй, 2. Замбараагүй, эмх цэгцгүй, хөглөрсөн, захиргаагүй, эх толгойгүй, эх адаггүй, номонд хазгай, ёсонд хазгай.

На его столе всегда был лирический беспорядок и только он один знал, где что лежит. Ширээн дээр нь юм хум нь ундуй сундуй байдаг сан. Өөрөө л хаана нь юу байгаагаа анддагүй билээ.

76. **ЛИРИЧЕСКОЕ ОТСТУПЛЕНИЕ** [*перен. шутл.*] яриа хадуурах, амгайгүй морь шиг, голы нь олохгүй, ам халах, яриандаа улайрах, амаа авсан морь шиг.

77. **ЛИСА ПАТРИКЕЕВНА** үнэгшин бэргэн, зальт шар, сүүлээрээ хуурдаг.

78. **ЛИСОЙ ПРИКИДЫВАТЬСЯ** долигоно-, долоон алда-, урдуур хойгуур нь гүй-, хав шиг.

79. **ЛИТЕРАТУРНЫЙ ЯЗЫК** бичгийн хэл,

Пушкин-основоположник современного русского литературного языка. Пушкин бол орчин үеийн орос бичгийн хэлний суурийг тавигч мөн.

80. **ЛИТЬ ВОДУ НА** *чью* **МЕЛЬНИЦУ** ташуур бол-, морий нь гуядаж өг-, галы нь түлж өг-, хүчин зүтгэ-, түймэрт салхи нэмэр, галзуу нохойд салхи нэмэр, морий нь унуул-, дэгтрэ-, өгдөө-, гааруул-, нэмрий нь өг-,

81. **ЛИТЬ КАК ИЗ ВЕДРА** К-107

82. **ЛИТЬ КОЛОКОЛА** цуу тараа-, хов жив уда-, хов дэлгэ-

83. **ЛИТЬ (проливать) КРОВЬ** *за кого за что* 1. Амь насаараа хамгаала-, биеэ золиосло-, 2. Алан хяда-, амьтны цусаар гараа угаа-.

84. **ЛИТЬ (пролить) КРОКОДИЛОВЫ СЛЁЗЫ** худлаа уйла-, уйлсан хүн бол-, харамссан хүн бол-. К-540

85. **ЛИТЬ МАСЛО В ОГОНЬ** галы нь түлж өг-, галд аргал нэмэдайран дээр нь давс хий-, нэмрий нь өгө-, галд тос өргөсөн юм шиг.

86. **ЛИТЬ ПУЛИ (ОТЛИВАТЬ ПУЛИ)** 1. Сум цутга-, 2. [*перен. разг.*]эмойто-, хөөрцөглө-, 3. Цуурхал дэгдээ-, О-332

87. **ЛИТЬ (пролить) СЛЁЗЫ** нулимсаа шавха-, эхэр татан уйла-, сигнэтэл уйла-, гашуудлын нулимс асгаруул-.

88. **ЛИХА БЕДА НАЧАЛО (начать)** [*разг.*] хошуу татах л хэцүү эхлэх нь л явдалтай, ам нээх л хэцүү, нэг л эхлээд авбал . . . нэг л үүсгээд авбал . . . , (гар) хүрч ядаад байх.

89. **ЛИЦА НЕТ** *на ком* царай дарах, царай алдах, үнсэн царайлах, зүс нь барайх, барс гээд явчих, царай нь жигтэйхэн болох.

90. **ЛИЦО В ЛИЦО** Л-93

91. **ЛИЦО ВЫТЯНУЛОСЬ** *у кого* 1. Уруу царайла-, царай дара-, гонсойцро-, толгойгоо ганзагала-, 2. Тура-, ядарч шумайж хоцро-, нүдээс гар-.

92. **ЛИЦОМ К** *чему* . . . **нйг ихэд анхаарах, . . . нйг онцгой харах, . . .-нйг эрхэмлэх,**

Лицом к деревне. Тосгоныг ихэд анхаарах,

93. **ЛИЦОМ К ЛИЦУ** *с кем- чем* 1. Нүүр тулах, уулзах, харгалзах, 2. Тулгарах, учрах, нүүр нүүрээрээ, улаан нүүрээрээ, **Л-90**

Лицом к лицу встретиться. халз тула-,

Лицом к лицу с опасностью. Аюул тулгарав (Гай нүүрлэв).

94. **ЛИШАТЬСЯ (лишиться) УМА (рассудка)-Ухаан солио бол-,** хэнээ тус-, галзуурахад ганц хуруу дута-, 2. Галзуура-, солио тус-

95. **ЛИШИТЬСЯ ПАМЯТИ** чяг багаа алда-, энэ тэрээ мэдэхээ бай-, бүр төөрөлдөж хоцор-, аль ч учраа олохоо бай-, ээдэй буудай юм шиг бол-, бүү мэдээ бүү мэд.

96. **ЛИШНИЕ ЛЮДИ** хэнд ч хэрэггүй улс, могой алахад модны нэмэргүй хүн, байхын бараа идэхийн нэмэр, хоолны сав, эсгий хийхэд хүүхэд нохой гэгч, олдохгүйд мундахгүй, дээлийн гол.

97. **ЛИШНИЙ РОТ** шүдтэй тулам, идэхээс өөр идгүй, тэжээмэл, тэжээвэр, хоолны сав.

98. **ЛИШЬ ПО СКОЛЬКУ** . . . гагцхүү . . . төдүй, . . . төдүйхэн.

99. **ЛИШЬ ТОЛЬКО** гагцхүү, зөвхөн, төдүй л, ердөө л, ерөөсөө л уртаашаа.

100. **ЛОБ В ЛОБ** мөргөлдөх, халз тулах.

101. **ЛОВИТЬ НА ЛЕТУ** (с лету) уухайн тас, шүүрэн ав-, юутай хүүтэй нь хама-,

102. **ЛОВИТЬ** *кого* **НА СЛОВЕ** [*разг.*] 1. Үг ав-, үгний нь өнгийг мэдэ-, үгний нь өргөсийг мэдэ-, ярианы нь өнгөөр, ярианы нь байрыг ажи-, үгний нь дуула-, амы нь мэдэ-, амны нь хөмхийг мэдэ-, 2. Ам ото-, үг ото-, үг мушги-, үгний нь өө хара-, хэлсний нь гуйвуул-,

103. **ЛОВИТЬ РЫБУ В МУТНОЙ ВОДЕ** муу хүн самбаанд, чоно бороонд, хий (аяс) таруул-, сиймхийгий нь ото-, нүд хариула-,

104. **ЛОВИТЬ СЕБЯ НА** *какой* **МЫСЛИ** [*разг.*] гэнэт санаанд оро-, санаа урга-, (санаж байсан юм) ивэс ивэс хийтэл бодогдо-, толгойд орж ирэ-, санаанд буу, цээжиндээ найрал хий-, ухаан сийл-, гэнэт шарла-, П-590

105. **ЛОДЫРЯ ГОНЯТЬ** Г-159

106. **ЛОЖИТЬСЯ НА БУМАГУ** (под перо) бийр бэхэс учруул-, саналгаа бийр бэхэс лугээ хэлэлцэ-, Л-61

107. **ЛОЖКА ДЁГТЯ В БОЧКЕ МЁДА** нэг үхрийн эвэр дэлсвэл мянган үхрийн эвэр доргино, муугаас муу модноос хөө, цуцал гал ойг шатаана, муугийн, уршиг олонд, могойн цус тэнгэрт баатар гэвч нэг суманд, баян гэвч нэг шуурганд, бөх хүн бүдүүн өвсөнд.

108. ЛОЖЬ РЕЗВА, ПРАВДА ЕЕ ВСЕГДА ПОЙМАЕТ худал үнэн нь: хойноо хусран боос нь хавраа, худал үгийг хөөвөл баригдана, мухар нүхийг ухвал мухардана.

109. ЛОКОТЬ К ЛОКТЮ [*разг.*] бие биендээ хань болон, бөөр бөөрөөрөө нийлэн, өвгөнцөөд, бараа бараандаа, хань ханиндаа, бие биенээ үнэрдүү, хана хаяагаа дэрлээд, дэм дэмдээ дээс эрчиндээ.

110. ЛОМАНОГО ГРОША (не стоит и. т. п) сохор зоос хүрэхгүй, улаан мөнгөний ч үнэгүй, нэрлэх нэргүй, нэг цэнгийн үнэгүй.

111. ЛОМАНЫЙ ЯЗЫК *над чем* эрлийз хэл, молхи толхи хэл, модон хэл,

112. ЛОМАТЬ ВАНЬКУ үл мэдээч бол-, хэнэгүй царайла-, доль цохисон юм шиг, эс мэдээчин бол-, гэмгүй царайла-, С-219

113. ЛОМАТЬ ГОЛОВУ [*разг.*] духаа үрчийлгэ-, тархна гашилтал ухааная ширгэтэл бодо-, толгойгоо эргэтэл-, их ухаан зара-, бодохын ихээр бодо-,

114. ЛОМАТЬ КОМЕДИЮ И-95

115. ЛОМАТЬ РУКИ [*перен.*] амаа бари-, гэм нь урьдаа, гэмшил нь хойноо, гаслахын ихээр гасла-, гэдсэндээ гэгэлцэ-, толгойруугаа шаа-, гоомойдсондоо гонсой-.

116 (1). ЛОМАТЬ ШАПКУ *перед кем* [*разг.*] нахилзаж тахилза-, нуруунд нь нугас ургасан юм шиг-, хормой дэвсэн алда-,

116. (2). ЛОМАТЬ (поломать) КОПЬЯ гэдсэндээ хөлөө хийлцэ-, цэц булаацалда-, марган сайрхалца-.

116. (3). ЛОМАТЬ ПОДУШКУ [*прост.*] дугжра-, [*Неодобр.*] ухархайгаа ширгээ-,

117. ЛОМБЕРНЫЙ СТОЛ хезрийн ширээ, наадмын дэвжээ, наадмын хөлөг,

118. ЛОМИТЬСЯ В ОТКРЫТУЮ ДВЕРЬ хий цэцэрхэ-, мэдээжийн юманд мэдэмгийрэхэ-, бөлэн юманд ухасхий-, аахилаачийн хажууд уухилаачин, С-932

119. ЛОПАТЬСЯ ОТ ЖИРУ язартлаа таргала-, зүрх нь өөхлө-, (адуу) онооло-, оноо суу-, (тэмээ) хомло-(нохой) зооло-.

120. ЛОПНИ МОИ ГЛАЗА [*прост. вульг.*] Андгайлая, тангараг! Яасан ч (тэхгүй, ингэхгүй), амлая, ам өгөе, ам өчгөө өгөх П-1100

121. ЛОШАДИНАЯ ДОЗА [*шутл.*] 1. Их тун эм, 2. Туг, богц, хуй, толгой.

122. ЛУЖЁННАЯ ГЛОТКА *у кого* [*прост.*] 1. Архины лүү, архины хөнөг, архинаас буцдаггүй хүн, 2. Бяртай хоолой, эцэж цуцашгүй хоолой.

123. ЛУННЫЙ СЕРП хавирган сар, хөмсгөн сар, шинийн сар,

124. ЛУПИТЬ ГЛАЗА [*прост.*] Нүдээ орой дээрээ гарга-, нүдээ ормойлго-,

125. ЛУПИТЬ, КАК СИДОРОВУ КОЗУ Д-426

126. ЛУЧШЕ БЫТЬ ПЕРВЫМ В ДЕРЕВНЕ, ЧЕМ ПОСЛЕДНИМ В ГОРЕ Говьд хүн болохоор хангайд бух бол, мянган өдөр

сүүдэр явахаар нэг өдөр хүн яв! Барын сүүл болохоор, батганын толгой бол, буурай улсын жанжин суухаар, мандсан улсын боол бол.

127. ЛУЧШЕ ГОЛОДАЙ, А ДОБРЫМ СЕМЕНЕМ ЗАСЕВАЙ. арвун явбал ашид тустай, үнэнээр явбал үхэр тэргээр туулай гүйцнэ. Хүний эрхээр тос уухаар өөрийн эрхээр ус уу, хулгай хийсэнд орвол гуйсан нь дээр, уулын чинээ харыг туулай чинээ цагаан,

128. ЛУЧШЕ МЕНЬШЕ, ДА ЛУЧШЕ аяга уснаас балга сүү дээр, бага ч болсон бахим нь дээр, шанага уснаас шагайн чинээ шар тос дээр, олзны бага нь амттай, чамлахаар чанга барь!

129. ЛУЧШЕ НЕ [*прост.*] . . . тэгэх бий, . . . тэгэхгүй бол,
Запиши в книжку. лучше не будешь. Дэвтэртээ бичээд ав тэгэхгүй бол мартана.
Лучше недосказать, чем пересказать. олон үгэнд олзгүй, ганц үгэнд гарзгүй, үгний цөөн үхрийн олон.

130. ЛУЧШЕ ПОЗДНО, ЧЕМ НИКОГДА оргүйгээс охинтой нь дээр, уснаас цийдэм, дэмийгээс дээр, оргүйд ор, мянгыг бодохоор нэгийг болго! дуугүй суухаар дуулж суу.

131. ЛУЧШЕ СКАЗАТЬ . . . гэж хэлвэл ч дээр,. . . хэлсэн нь л дээр,

132. ЛУЧШЕ УМЕРЕТЬ СТОЯ, ЧЕМ ЖИТЬ НА КОЛЕНЯХ. Муу амьд явахаар сайн үх, хүний эрхээр жаргахаар, өөрийн эрхээр зов.

133. ЛЫЖНАЯ ВЫЛАЗКА 1. Цанын аян, 2. Цанын зугаалга.

134. ЛЫКА НЕ ВЯЖЕТ (хөлчүүрээд) хэл нь ороолдох, хэл нь ээдрэх, толь таль хийх, шал пал хийх, хэлээ хазах, пүл пал хийх, наль наль хийх, дээгүүр хэл нь ороолдож доогуур хөл нь солбих

135. ЛЫКОМ ШИТ [*прост.*] Молхи толхи, болхи бүдүүлэг, бүдүүн бараг, мэдэх чадах ч юмгүй, амандаа А үгүй алгандаа пад үгүй.

136. ЛЬВИНАЯ ДОЛЯ [*перен.*] сор нь, чарам хийх юм нь, олигтой нь энэ, дөмөг нь, арай дээр, дөнгүүр нь, гайгүй нь, охь манлай нь, сор нь, дээж нь, овоо нь, бузгай нь, толгой нь.

137. ЛЬСТИТЬ СЕБЯ НАДЕЖДОЙ . . . дэмий горьдо-, хий сэтгэлээ зогоо-, өөрийгөө хуура-

138. ЛЮБИШЬ КАТАТЬСЯ-ЛЮБИ И САНОЧКИ ВОЗИТЬ Маханд дуртай бол мал малла, аргал түүхийн өмнө араг савраа, ажил хийхийн өмнө арга ухаанаа, хүссэндээ хүрье гэвэл хяссаны нь дав!

139. ЛЮБОВЬ ЗЛА, ПОЛЮБИШЬ И КОЗЛА янагийн нүд сохор, дур эзнээ голдоггүй, дунд чөмөг сүүжээ голдоггүй,

140. ЛЮБА-ДОРОГО уухлайи шар тос, яасан сайн юм! Тун сайн хэрэг, ээ гялай, ингэж гялайх гэж, ашгүй ашгүй!

141. ЛЮБО-ДОРОГО [*прост.*] хайр хүрэм, шагшим, урам сэргэм, бахдам, овоо нэг, баярлам.

142. ЛЮБОЙ ЦЕНОЙ үнэ хайргүй, ямар ч үнээр хамаагүй, үнээр зодож байгаад, үнээр цохиж,

143. **ЛЮДИ ДВАДЦАТОГО ЧИСЛА** [*ирон.*] фүнлүү хүртээчин-, (хувьсгалын өмнө сар бүрийн хоринд цалин фүнлүүгээ авдаг түшмэдийг ийн өгүүлжээ).

144. **ЛЮДИ ДОБРОИ ВОЛИ** [*высок.*] шудрага хүн, сайн хүн, ачтан улс,

145. **ЛЮДСКАЯ МОЛВА, ЧТО МОРСКАЯ ВОЛНА** муу үг модон улаатай, түмний амыг төмрөөр боодоггүй. М-141

146. **ЛЮДСКИХ ПЕРЕСУДОВ НЕ ПЕРЕСЛУШАЕШЬ** нохойн хуцал хүнд хамаагүй, хүний явдал хүнд хамаагүй, хүн хүний дур, гүзээ гүзээний булан.

М

1. **МАВР СДЕЛАЛ СВОЁ ДЕЛО МАВР МОЖЕТ УЙТИ (уходит)** гаргуундаа гарсан амьтан; золиосонд гарсан хүн

2. **МАГ И ВОЛШЕБНИК** [*разг., шутл.*] арван талтай эр; найман талтай хүн; зайтай зальтай амьтан; хирийн хүнийг зажлалгүй залгичихаар; оготнын нүхээр орон гаран; таринаар хуурч байгаа юм шиг аргатай хүн, үхэхээс бусдыг үзсэн; барагтайд бардаггүй даваа; арван гурван мэхтэй.

3. **МАЗАТЬ ПО ГУБАМ** амаараа гялайлга-; хэлсэндээ хүрэхгүй; сайхан амтай; ам гэж алт. П-716, 233

4. **МАКОВОЙ РОСИНКИ ВО РТУ НЕ БЫЛО** [*разг.*] хэлэн дээр юм тавиагүй, өлөн элгээ ч тайлаагүй; чээжний хөндий рүү юм хаяагүй; амны заваа ч гаргаагүй; нүүрний арьс хөдөлгөөнгүй; эрүү толгой зодолдуулаагүй; шор ч долоогоогүй

5. **МАЛ ЗОЛОТНИК, ДА ДОРОГ** чөтгөрийн бага нь адтай; дахан дор эр, даахин дор хөлөг; түрүү ургасан чихнээс сүүлд ургасан эвэр.

6. **МАЛ МАЛА МЕНЬШЕ** [*разг.*] нэг нэгнээсээ арай арай бага

   Всех семеро-мал мала меньше нэг нэгнээсээ арай арай багахан долоон хүүхэд.

7. **МАЛАЯ ЗЕМЛЯ** зах хязгаар нутаг; нутгийн зах; хөдөө гадаа нутгийн сэжүүр; алс зайдуу; бөглүү хязгаар; аглаг тэртээ.

8. **МАЛАЯ ТОЛИКА (НЕКОТОРОЯ ТОЛИКА)** цөөхөн; (мал дээр бол) гэрт багтахгүй хотонд тогтохгүй хэдхэн; ялигүй; шалигүй; хуруу дарам, цөөн буурай; юм ч гүй; гавихгүй; базаахгүй; шальгүй.

   Самую малую толику денег израсходовол. өчүүхэн мөнгө зарсан.

9. **МАЛЕНЬКАЯ СОБАЧКА ДО СТАРОСТИ ЩЕНОК** [*прост. шутл.*] 1. Давжаахан, хүний овор бага 2. Бие нь бага, шанх нь гүйцсэн

10. **МАЛИНОВЫИ ЗВОН** Аялгуу сайхан; уянгат дуун; сонсхолонт хонхон дуун; чихнээ чимэгтэй дуун, чихний чимэг болсон.

11. **МАЛО КАШИ ЕЛ (Мало каши съел)** [*прост., шутл.*] (хүнийг нас бага юм мэдэхгүй балчирдуу байна гэхэд хэлэх үг) нас бага нар эрт; нас бага цус шингэн; юм үзэх өдүй байна; боривны нь баас арилаагүй байна; хар нялхаараа; амны нь салнас арилаагүй, шал нялхаараа; бойдоо нь арилаагүй; хүүхдээрээ; сая унасан шал нойтон ишиг, оймс элээгээгүй, юм үзээгүй.

12. **МАЛО ЛИ** (ард нь голцуухан *кто, что, как, где, когда*, гэх мэт үгс орно) [*разг.*]... аар[4] нь яах юм;... нь ямар хамаа байна? Ямар ямар; хэн хэн; юугаа яана вэ (ийнэ вэ?) юу эс; хаана... тэгдэг...; эсэн бусангийн элдэв дээдийн; элдвийн:, бишгүй; хамаагүй; падгүй

   Кто пришёл?-Мало ли кто пришёл! Делай своё дело! Хэн ирээ вэ? Хэн ирснээр нь яах нь вэ? Хийдгээ л хий.

   Мало ли кто живёт в этом доме, я не могу всех знать энд (энэ гэрт) ямар ямар улс байдаг юм би тэр болгоныг мэдэхгүй юм даа.

   Мало ли что говорят, не обращай внимания Тэднүүс ямар юмаа ярина вэ, юманд аваад яахав (элдэв хангайн л юм ярьдаг юм байгаа биз тэрнийг үгэнд аваад яахав.)

   Мало ли что бывает на свете? Ертөнцөд ер юу эс болох вэ дээ! (Орчлон гэдэг бөөрөнхий шүү!)

   Где ты был?-Мало ли где я был, не твоё дело! Чи чинь хаа очив оо?-Миний хаана очих ямар хамаатай юм чамд падгүй!

   Мало ли что может присниться Зүүдэнд эсэн бусангийн юм орох доо (Зүүдэнд ер юу эс орох вэ?)

   Мало ли где я бывал за свою жизнь энэхэн насандаа элдвийн ч газраар явж үзлээ дээ (бишгүйдээ нэг газраар явлаа даа таминь)

13. **МАЛО ЛИ ЧТО** хамаагүй, падгүй хүртээлгүй, лийний төдий ч падгүй; өчүүхэн ч хамаагүй; хуруу дүрэлтгүй; хошуу дүрэлтгүй:

   Мало ли что ты говоришь, я не согласен Чи юу ч гэж ярьсан, би л тэг гэхгүй

14. **МАЛО ТОГО** [*разг.*]... аар барахгүй;.. бас; чингээд... аар[4] зогсоогүй;... аар[4] үл барам; тэр ч байтугай;

   Мало того, что он пришёл сам, он пригласил ещё товарищей Өөрөө ирснээр барахгүй нөхдийгөө залаад ирсэн байна билээ.

15. **МАЛО-МАЛО** 1. арай л...;... тэгэх шахлаа;... тэгэж алдлаа; тэгэж дүүрлээ, юун ашгүй эс... 2. Адаглаад л, дор хаяхад; бага гэхэд л тэгэхээ дөхлөө; бараг шахлаа; бараг тэглээ; золтой л; гүйдээ л, оргүйдээ л;

   Мало-мало не упал Арай л ойчсонгүй (ойчин алдлаа ойчих шахлаа, ойчиж дүүрлээ)

   Мало-мало тысячу зарабатывает Дор хаяхад нэгэн мянган төгрөг олдог байх.

16. **МАЛО-МАЛЬСКИ** [*разг.*] жаахан; бяцхан; багахан;... гадарладаг; ор юу ч үгүйг бодвол; оргүйн дэргэд

Это понятно всякому мало-мальски грамотному человеку Жаахан л юм гадарладаг хүнд бол энэ ч ухаарч цөхөх юм алга шүү дээ.

17. **МАЛО-ПОМАЛУ** Ягуухан; дас дассаар; оролд оролдсоор; бага шиг бага шиг; тасаг тасаг; хэсэг хэсгээр; бага багаар; барь барьсаар; ахиулсаар; зугуу зугуухан; бага сагаар; жаал жаалхаар; жижгээр; жоолхон жоолхноор г. м.)

Мало-помалому он начал входить в дело Хий хийсээр ажил явдлаа юм болгов.

18. **МАЛУЮ ТОЛИКУ** М-8

19. **МАЛЫЕ МИРА СЕГО** [*устар.*] Будааны улс; будааны хүн; ар жавдангийн амьтад, доогуур зиндааныхан; бага гарын хүмүүс; доод гарын хүн.

20. **МАЛЫЕ ФОРМЫ** Бэсрэг жүжиг; богинохон жүжиг

21. **МАЛЫЙ ХОД** (галт онгоц мэтэс) зугуухан хөвөх; аажим шиг; явах; алгуур явах; явж буй гүй нь мэдэгдэхгүй; зөөлөн явах; аяар явах; аажуу явах.

22. **МАЛЫМ ДЕЛОМ** [*прост.*] бага шиг; жаахан; ялигүй бяцхан

23. **МАЛЬЧИК С ПАЛЬЧИК** Хумсын чинээ амьтан, чигчийн чинээ хүү, (үлгэр) чихэн чинээ хүү (үлгэр) хуруун чинээ хүүхэд; хуруун чинээ амьтан; тохойн чинээ амьтан; эрхийн чинээ биетэй; хуруувчийн чинээ бнетэй; шалсай шиг биетэй.

24. **МАМАЕВО НАШЕСТВИЕ** Газрын хаанахын юм цугларах; эсэн бусын амьтад ирэх; хань хамаагүй хүмүүс ирэх

25. **МАМАЕВО ПОБОИЩЕ** (дайн тулаанд) цэрэг агт ихэд хохирох; эр бие, зэр зэвсэг хохирох; хөсөг хөтөл хохирох

26. **МАМЕНЬКИН СЫНОК** [*разг. ирон.*] эрх хүү; өөхөнд хучсан бөөр шиг өссөн хүү; дураараа хүүхэд; зарилгаа нугалуулж яваагүй хүү; өндөг бол хагарах бий гэж, өөх бол хайлах бий гэж өсгүүлсэн хүү; зоргоороо хүү; эрхээрээ хатсан; айлын шүтээн болсон, ширүүн үг хэлүүлж (дуулж) яваагүй.

27. **МАМЕНЬКИНА ДОЧКА** эрх ганхил хүүхэн; хал үзээгүй хүүхэн; эрх булбарай амьтан М-26

28. **МАНДАРИНСКАЯ УТКА** уран хажин

29. **МАНЕРОМ (каким)** (орчуулгыг дорхи жишээнээс үзэгтүн)

Живым манером түргэн; даруйхан; хурдан; гялалзтал; шав шув хийтэл; шалавхан.

Таким манером ингэж; чингэж; нийхүү; тийнхүү,

30. **МАНИЯ ВЕЛИЧИЯ** [*ирон*] Сээр нь овойсон; толгой нь хавдсан; биеэ ихэд бодсон; сүүлээ сөхсөн; маадгар; биеэ биед бэгтгээ цатгаланд бодсон; бяруу болоогүй байж бухын баадлаар баадаг; аавархуу; авын цээж; төрийн аав; их аав; додигор.

31. **МАННА НЕБЕСНАЯ** ус агаар шиг чухаг, ховор хомор, гачаатай

32. **МАННАЯ КАША** Хүүхдийн будаа; бантангийн будаа; үр будаа; шийжүү; зутангийн будаа.

33. **МАННАЯ КРУПА** Зарам, зарман гурил; талхалсан буудай; хүүхдийн будаа.

34. **МАННОЙ НЕБЕСНОЙ ПИТАТЬСЯ** өлөн бирдийн зовлон эдлэ-, өлөн зэлмүүгүүр (бай-) мөчиг тачиг суу-, ховор живэр бай-, ядуу даржин хурхагла-, өл залгах төдүй хоног төөрүүл-; шар наран бор хоног өнгөрөө-, өмөж цөмөж, зэлмүүрийн юм шиг бай-

35. **МАРАТЬ БУМАГУ** [*разг.*] цаас эрээчи-; цаасаар нэг сараала-(сараачи-) [*бран.*] цаас бузарла-; цаас цоохорло-.

36. **МАРАТЬ РУКЫ**, *об кого, обо что* дэмий юманд хуруу дүрэ-; олигшийн юмтай ороолцолдо-; гараа бузарла-; [*перен*] нэнэрээ хөөдө-; гараа цустаж нэрээ бааста-;

37. **МАРАФОНСКИЙ БЕГ** холын явган уралдаан (42 км, 95 км газар) (эртний грекийн марафон гэдэг сууринги йн нэрээр тийнхүү нэрлэжээ)

38. **МАРТОВСКИЙ КОТ** [*шутл.*] 1. Орсон мий; азаргалсан мий 2. [*перен.*] Мунаг туссан; гүймхий, хөөмхий; шар сэмжилсэн; азраган үрээ шиг, бухан бяруу шиг, зул сарын нохой зүргаан сарын бух шиг

40. **МАСЛО МАСЛЯНОЕ** бахи л байдаг (үг, яриа), хүний ой тойнд оромгүй яриа, улигт л, мэлхий харайвч мэн дороо гэгч шиг тайлбар

41. **МАСТЕР (мастерица) НА ВСЕ РУКИ** хийх гүй юм гэж байхгүй, юм юманд тэгш, хүн хүний хийдгийг л хийдэг хүн. Юм юманд дүйтэй хүн; чадахгүй юмгүй хүн; арван хуруу тэгш; алтан гартай хүн; элдэвтэй хүн; есөн шид нь бүрдсэн хүн. Н-44

Матушка моя была мастерица на все руки Ижий минь арван хуруу тэгш хүн байж билээ.

42. **МАСТЕР СВОЕГО ДЕЛА** Хийдэгтээ хийгүй; тэр юмандаа ч эр бар л хүн:, тэрэндээ чөлхөн л дөө; тэрэндээ ч зөв л хүн; хэлсэн үгэндээ эзэн, идсэн хоолондоо сав болдог хүн; хирээ мэлдэг хүн, хүнээс л гуйхгүй хүн, хийснээ болгож тавьдаг;... дээ ч хувиа тавихгүй ээ! (түүнийгээ) дөнгөдөг хүн дээ! хувиа хүнд өгдөггүй, хүртсэн хувиа борлуулдаг; хүний гар хардаггүй; хүний нарай хардаггүй.

43. **МАТУШКИ (мой)** [*разг.*] (цочин уулга алдахдаа хэлэх үг) Ижий минь

44. **МАТЬ ЧЕСТНАЯ** (сандрах, баясах зэрэгт хэлэх үг) Ижий минь! Ээ халаг! Халаг хоохой. Хөх тэнгэр ээ!

45. **МАХНУТЬ РУКОЙ** *на кого что* шал тоохгүй; нэг нүдээр үзэхгүй; юманд бодохгүй; юман чинээнд бодохгүй; нүд үзүүрлэ-; шоовдорло-.

46. **МАФУСАИЛОВ (ы) (года, лета) ВЕК (жить)** Өнө удаан, урт удаан

47. **МАЯЧИТЬ ЖИЗНЬ** [*прост.*] хоёр нарны хооронд хоног төөрүүл-; шороо холхно тасрахгүй; өнөө маргаашийг өнгөрөөж л явна.

48. **МЕБЛИРОВАННЫЕ КОМНАТЫ** тавилгатай нь хөлслөх өрөө (сууц)

49. **МЕДВЕДЬ (слон) НА УХО НАСТУПИЛ (кому)** чи юу мэдээ илжгээ юу дааная; чих нь хацартайгаа адилхан; сохор хүнд толь хэрэггүй.

50. **МЕДВЕЖИЙ УГОЛ** эли хули газар; газрын мухар; алс аглаг газар; уулын таг усны эх эзгүй хээр; хүн амьтангүй газар; хүн явдаггүй газар.

51. **МЕДВЕЖЬЯ БОЛЕЗНЬ** [*шутл. прост.*] айгаад чацга хавчих, санаа алдах; үнхэлцэг нь хагарах; дуу гарахгүй болох; сүнс нь зайлах; цөс нь халих; оройны нь үс орвосхийх; бие нь зарсхийх.

52. **МЕДВЕЖЬЯ УСЛУГА** нуухы нь авах гээд нүдий нь сохлов; тус хийх гээд ус хийв; муу хүнийг зар зарсан хойноо өр.

Оказать медвежью услугу (кому) нуухы нь авах гээд нүдий нь сохлов гэгч болов

53. **МЕДНАЯ ГЛОТКА** цуцдаггүй хоолой; бяртай хоолой

54. **МЕДНЫЙ ЛОБ** маанаг толгой; цул толгойт; эргүү амьтан; гүндүү толгойт; усан толгойтой; голгүй мах

55. **МЕДОВЫЙ РЕЧИ** гоо ам гурил хошуу; уран үг; сайхан ам; чихэр шиг үг; чихэнд чимэг цээжинд хадаас болох үг.

56. **МЕДОВЫЙ МЕСЯЦ** хоёр банзан дээр (унтахад) холдоод байдаг (сар) үе (хөгшрөхөөрөө хоёр хаяанд байхад бие биендээ дэраа болох) бураман сар

57. **МЕЖДУ ГЛАЗ** [*прост.*] нүд ирмэхийн хооронд; яах ийхийн завдалгүй; төдөлгүй; эгшин зуур; нүд цавчрахын зуур

Деревня между сгорела (крылов) тосгон яах ийхийн завдалгүй шатаж хоцров.

58. **МЕЖДУ ДВУХ ОГНЕЙ** хойноо ч үгүй урагшаа ч үгүй; алцан цойчин; алцагчин балцагчин; хаашаа ч үгүй; хонгилдсон тарвага; давч газар дайсантай золгох; дээшээ тэнгэр хол; доошоо газар хатуу; хутганы ир дээр; үхэх сэхэхийн заяг дээр.

Находиться между двух огней хаашаа ч үгүй бол-

59. **МЕЖДУ ДЕЛОМ** [*разг.*] Дашрамд, явдлын далимаар; ажлын далимаар; далимаар нь; тэрүүхэн хооронд; зав гаргаад; ухас-хийгээд

60. **МЕЖДУ ЖИЗНЬЮ И СМЕРТЬЮ** үхэх сэхэхийн даваан дээр; үхдэг сэхдэгийн нэг бол-; цаашилдаг цаашилдагийн хооронд; нэг бол үхэх нэг бол сэхэх; амь наана там цаана.

61. **МЕЖДУ МОЛОТОМ И НАКОВАЛЬНЕЙ** дээшээ тэнгэр хол доошоо газар хатуу; хавханд хатах гэгч; амьдын тамаа эдлэх

62. **МЕЖДУ НАМИ** эндээ гэж ярихад; хүнд хэлэх юм биш; танд л гэхэд; итгэж хэлэхэд; чамд л гэж хэлэхэд; энүүхэндээ ярихад.

Пусть это останется между нами Энүүхэндээ гэхэд л ийм байна.

63. **МЕЖДУ НАМИ ГОВОРЯ** эндээ гэхэд; хүнд хэлэх юм биш тамнинь. хэдэн хар толгойдоо шингээхэд

64. **МЕЖДУ НЕБОМ И ЗЕМЛЕЙ ЖИТЬ (быть, находиться)** [*разг.*] хээрээр гэр хийж хэцээр дэр хий-, гурнийг хэсэж гүзээ тэжээж-, олцыг хэсэж олгой тэжээ-; айлын тогоо өнгийж; малгай тавибал манайх, маргааш болвол хүнийх гэгчээр

65. **МЕЖДУ ПРОЧИМ** [*разг.*] далимаар, далиманд, дашрамд; ялдамд; шигээхэд.

66. **МЕЖДУ СОБОЙ** хоорондоо; нэг нэгтэйгээ; бие биендээ; өөснөө.

67. **МЕЖДУ СТРОК ЧИТАТЬ** битүү мэдэ-, битүү тары нь тани-; санаагий нь гадарла-; танда-; янзы нь үзэж гоцы нь тани-; яадаг юм гэж янзы нь үзэ-. Ч-120

68. **МЕЖДУ ТЕМ** 1. Бас, түүнчлэн; чингээд; үүн чацуу; ухаандаа; түүн сацуу; үүний зэрэгцээгээр; цаашилбал; басхүү; бас; тэрчлэн;... аас[4] гадна;... ын дээр улмаар; 2. Чухамдаа чухамлаваас

69. **МЕЖДУ ТЕМ. КАК...** 1. Тэхэд; тэх хооронд; 2. үнэндээ

Между тем, как вы купались в реке, я приготовил обед Та нарыг усанд шунгаж байхад би үдийнхээ хоолыг хийчихэв.

Ты говоришь, что я ничего не делал, между тем как я приготовил обед. Та намайг юу ч хийсэнгүй гэж байх шиг байна. Үнэндээ би хоол хийсэн шүү дээ.

70. **МЕЖДУ (меж) ЧЕТЫРЕХ ГЛАЗ** энүүхэндээ гэхэд; эндээ гэхэд. хоёр хар толгойдоо гэхэд

71. **МЕЛИ, ЕМЕЛЯ, ТВОЕ НЕДЕЛЯ** ам чинь л цангахгүй бол бурж л бай. Нойр чинь хүрээгүй бол эрүү толгой зодолдуулж л бай!

72. **МЕЛКАЯ СОШКА** [*разг.*] дөдгүй эр; бэртэгчин амьтан, өөрийн толгойгүй хүн; хүний нохойны мод болсон амьтан; гүзээнд наалдсан дэлүү.

73. **МЕЛКИМ БЕСОМ (рассыпаться)** [*разг.*] арга учраа тоочи-; уйлж дуула-; долоочих шаха-;

74. **МЕЛКИМ ГОРОШКОМ РАССЫПАТЬСЯ** (*перед кем*) [*разг.*] доотохы нь долоочих шаха-.

75. **МЕЛКО ПЛАВАТЬ** [*разг.*] могой алахад модны нэмэргүй (хүн) айхын бараа; наалчгар эр; морь нь явахгүй эр; хийморгүй амьтан; унтарсан галд уриагүй.

76. **МЕНЯТЬ ГНЕВ НА МИЛОСТЬ** С-554

77. **МЕНЯТЬ ДЕКОРАЦИИ** П-103

78. **МЕНЯТЬ КУКУШКУ НА ЯСТРЕБА** Хуцаа ухнаас; гутлаа шаахайнаас; хүндээ хөнгөнөөс; хөхүүрээ борвиноос; сүхээ тэвнээс өг; хадгаа самбайнаас өг-.

79. **МЕНЯТЬСЯ В ЛИЦЕ И**-205, П-104

80. **МЕРЗОСТЬ ЗАПУСТЕНИЯ** [*ирон.*] эли хули орги-; ганцаардасүүдрээрээ нөхөр хий- зэвэр даа- (орги-); ханхай-; хүйтэн орги-; хөсрий даа-

В доме было мерзость запустения гэрт эли хули оргиж (ханхай) байв.

81. **МЕРИТЬ В ТУ ЖЕ МЕРУ тою же мерою** хорыг хороор; усыг усаар.

82. **МЕРИТЬ (мерять, смерить, смерять) ГЛАЗАМИ (взглядом)** *кого* цоо ширтэ-; нүдээрээ цорги-.

83. **МЕРИТЬ ВЁРСТЫ** [*шутл.*] тавхайгаа элэгдтэл ява-, улдтал ява-, сунатлаа ява-; хөлөө бара-; ул тавхайгаа бара-; гутлаа эргэтэл ява-; эцтэлээ тэнэ-; хавийн газрыг дугуйла- сульдталаа ява-; цуцталаа ява-; маахайгаа эргэтэл ява-;

84. **МЕРИТЬ НА ОДИН АРШИН (мерку, меру)** М-86

85. **МЕРИТЬ (мерять) ТОЮ ЖЕ МЕРОЮ** [*книжн.*] ярдаг хүний шилэн дундуур гэгчээр; өсийг өсөөр гэгчээр; ачийг ачаар; ачийг бачаар.

86. **МЕРИТЬ НА СВОЙ АРШИН** өөрийнхөө савны хэмжээгээр хэмжи-; хүнийг өөртэйгээ адил бодо-; мухар сөөмөөрөө хэмжи-; бүхнийг өөр шигээ бодо-

87. **МЕРИТЬ ОБШИМ (обычным, обыкновенным и. т. п.) АРШИНОМ** [*разг.*] нэг хэвээр үзэ-; боовны хэв шиг; дангийн жаа шигээ бодо-. өөрийнхөө саваар савла-

88. **МЕРИТЬ ШАГАМИ 1.** Том том алха-; гулилзтал алха-; **2.** Хойш урагшаа гүй-; наашаа цаашаа алхала-.

89. **МЕРНАЯ РЕЧЬ 1.** Аажуухан ярих; үгээ зөөж тавьж ярих; эвлэг тавлаг яриа. **2.** Зүйрхэн үг; гулгаж тэшсэн яриа.

90. **МЁРТВАЯ ВОДА 1.** Тогтоол (ын) ус. **2.** Рашаан.

91. **МЁРТВАЯ ЗЫБА** (гадаад далайд далайн шуурга болоод тогтох үест гардаг) урт урт давалгаа; дэвлэг долгион.

92. **МЁРТВАЯ ТИШИНА** Чив чимээгүй; нам гүм; ялаа ч ниссэн мэдэгдмээр; анир чимээгүй; нам жим; намхийсэн; таг чиг; дүн пад.

93. **МЁРТВАЯ ТОЧКА 1.** Тавласан; үхүүлсэн; занги уясан; **2.** [*разг*] Үхширмэл; хөшүү; мод шиг; амьгүй юм шиг; үхсэн юм шиг; хаашаа ч үгүй; гацмал; оршмол.

Дело стоит на мёртвой точке өнөө хэрэг хаашаа ч үгүй болоод байна (ажил маань паг суусан).

94. **МЁРТВАЯ ХВАТКА** тавихгүй зуух; зуугаад тавихгүй; бахь шиг хазах; адуу шиг хазах; чоно зуусандаа гэх шиг зуух; шанаатай (зананатай) шиг зуух, араандаа зуух, тас зуух, ам (нь) зууртал зуух.

95. **МЕРТВЕЦКИ ПЬЯН** [*разг*]. шал согтуу, мал болсон, ногоортлоо согтсон.

96. **МЕРТВОЕ МОЛЧАНИЕ 1.** Нам жим, чив чимээгүй, **2.** Дув дуугүй; үг дуугүй.

97. **МЕРТВОЕ ПРОСТРАНСТВО, МЁРТВЫЙ СЕКТОР** [*воён*] **1.** Битүү газар, [*цэрг.*] **2.** Задгай гал нээх боломжгүй газар.

98. **МЕРТВОРОЖДЕННОЕ ДЕТИЩЕ** [*перен.*] дэмий бодол, хоосон төлөвлөгөө, хий санаа.

99. **МЁРТВЫЕ СРАМУ НЕ ИМУТ** үхнэ гэдэг нүрээ барахын нэр үхсэн хүнд сайн муу ялгуургүй (ялгаваргүй).

100. **МЁРТВЫЙ ИНВЕНТАРЬ** гарын багаж, нохойны мод, номхон морины ногт, дошгин морины чөдөр, боолын боол, босгоны шороо, гар хөлийн үзүүр, гарын дорхи хүн.

101. **МЁРТВЫЙ КАПИТАЛ 1.** ашиггүй агуурс, хүүгүй хөрөнгө, бирдийн нүдэнд далай харам; даахгүй нохойд булуу, **2.** [*перен*]. Хэрэг болохгүй мэдлэг, улзваргүй ухаан, нохойн тарга шиг юм, нохойн жороо.

102. **МЁРТВЫЙ (тихий) ЧАС** үдийн унтлага.

103. **МЁРТВЫЙ ЯЗЫК** сөнөсөн хэл, мөхсөн хэл, эзнээ алдсан хэл.

104. **МЕСИТЬ ГРЯЗЬ (по грязи)** [*разг*, *шутл.*] шавар дундуур шалчиг палчиг болж явз, жонхуу зуурэ, лагалдуулж алда.

105. **МЕСТА (себе) НЕ НАХОДИТЬ** [*разг*]. сэтгэл түвшингүй, саная амаргүй, байж сууж чадахгүй, уралдах гэж байгаа морь шиг, сэтгэл доноголзо-, сэтгэл тогтворгүйдэ-.

106. **МЕСТА НЕ СТОЛЬ ОТДАЛЁННЫЕ** цөллөгийн газар, цөллөгөнд, алс бүглүү газарт.

107. **МЕСТО ПОД СОЛНЦЕМ** (нийгэмлэгт) их дээгүүр суурь, их мэ[illegible]ийн байранд.

108. **МЕСЯЦ НАРОДИЛСЯ** шинэ сар гарав.

109. **МЕТАТЬ БАНК** П-1147

110. **МЕТАТЬ БИСЕР ПЕРЕД СВИНЬЯМИ** илжигний чихэнд ус хийсэн ч адил, алт хийсэн ч адил, нэг чихээрээ оруулаад, нөгөө чихээрээ гаргах, нохой хуцсан чинээнд гүй, дүлий думбэ, чихгүй толгой, тоосон шинжгүй, хэргэссэн янзгүй, чихэнд нь юм наалдахгүй болсон

111. **МЕТАТЬ ГРОМЫ И МОЛНИИ (МЕТАТЬ ПЕРУНЫ) 1.** Цахилгаан цахи-, тэнгэр тачигна-, тэнгэр тас цис хий- **2.** (Хилэгнэ-, уур шата-, шата -, зүс хувилга -, царай барайлга -.

112. **МЕТАТЬ ИКРУ** шагшиан шуугиан бол-,

113. **МЕТАТЬ ИСКРИ (молнии)** уурла -, эгдүүцэ -, эвгүйрхэ -,

114. **МЕТАТЬ ПЕРУНЫ** (хүнд) уурла -, шарлаха -, янзгүйрхэ-.

115. **МЕТАТЬ ПЕТЛИ 1.** Мөрөө балла-, хэнд ч мэдэгдэхгүй болго-, зам буруула-, мөр буруула-, төөрүүлэ-, займчуула-, зэмруула-гэмгүй царайла-, тэгсэн сандаагүй, жишим ч үгүй, сайхан амьтан дүр үзүүлэ-.

116. **МЕТАТЬ СТОГ** өвс нуруулда-, нуруу тави-.

117. **МЕТАТЬСЯ В ГЛАЗА** Б-408

118. **МЕТИЛ В ВОРОНУ ПОПАЛ В КОРОВУ** тэрэгний гол хийх гээд шүдний чигчлүүр болгов гэгч, тогооны халив хийх гээд ээрүүлийн дугуй хийв гэгч, барууи тийшээ очих хүн, зүүн тийшээ явав гэгч Ц-10

119. **МЕЧ ПРАВОСУДИЯ 1.** Шударга ёсны хууль цааз, үнэнч шударга хууль зүй, **2.** Хуулиар хүмүүжсэн, цээрлэл үзсэн, учраа мэдэж суртлаа таньсан.

Меч правосудия теперь в руках народа шударга хууль, нэгэнт ард түмний гарт байнам (хувьсгалт хуулийг эдүгээ ард түмэн гартаа атгажээ).

120. **МЕЧТАТЬ О СЕБЕ (много, высоко и. т. п.)** биеэ тоо-, биеэ ихэд үзэ-, дээгүүр толгойтой, том толгой гарга-

121. **МЕШАТЬСЯ В УМЕ (В рассудке)** [*прост*]. ухаан солиоро-, галзуура-, ухаан жолоогүй бол-, ороотой гараатай. П-718

122. **МЕШКИ ПОД ГЛАЗАМИ** нүд нь зэлхийрсэн (зэлхэрсэн). нүд нь дов бол-

123. **МЕШ К С СОЛОМОЙ** хүний сүг, мануухай, дээлийн гол, өлгойтон ус шиг амьтан.

124. **МИЛОЕ ДЕЛО** санасан газар болсон будаа, ганц дуртай юм нь.

125. **МИЛОСТИ ПРОСИМ (прошу)** [*разг*]. тэгэгтүн, нигэгтүн, тэгэж нигэж морило (морилогтун), тэгэж, нигэж хайрла! тэгэж нигэж ажаамуу, тэгэмүү, нигэмүү.

Милости просим почаще к нам! манайхаар морилон ирж байгаарай.

Милости просим к столу ширээнд сууж морилогтун (наашаа морил!)

126. **МИЛОСТИВАЯ ГОСУДАРЫНЯ** өршөөлт эзэгтэй

127. **МИЛОСТИВЫЕ ГОСУДАРИ И МИЛОСТИВЫЕ ГОСУДАРЫНИ**! өршөөлт эзэнтэн эзэгтэй нэр ээ!

128. **МИЛОСТИВЫЙ ГОСУДАРЬ** эрхэм эзэнтэн, өршөөлт эзэнтэн

129. **МИЛОСТЬЮ БОЖИЕЙ** [*ирон., шутл.*] зорьж төрсөн, тэнгэрээс заяатай, ясны авъяастай төрсөн. Б-273

Художник милостью божией авъяастай төрсөн уран зураач (алтан гартай зураач), дархан хүн бурхан ухаантай.

130. **МИЛЫЕ БРАНЯТСЯ, ТОЛЬКО ТЕШАТСЯ** (эр эм) өдөр нь цусаа гартал зодолдож, шөнө нь тосоо гартал тэврэлддэг.

131. **МИМО РТА ПРОШЛО (пронести, пролетело)** [*шутл.*] аманд орсонгүй, хувь дутав, амны хишиг дутав, сав дутав, эс шингэв, амны нь хишиг ар дээрээ гарчээ, амы нь тэмээ тийрчээ, ам ихтийг ангайхад буян ихэт булаав, аманд ортол арван даваа.

Бабушкино богатство пролетело мимо его рта эмэг эзэжийн өвийг идэх амны хишиг дутжээ (эмэг эхийн буянг хүртэх амны нь хишиг ар дээрээ гарчээ).

132. **МИНУ ПОДВЕСТИ (подложить)** *кому* [*перен. разг.*] сэм хорлох, далдуур муу хийх, араар нь тавих, хүйтэн жин тавих.

133. **МИНУЕТ (миновала) ЭТА (сия) ЧАША** [*книжн.*] яс амрах боллоо, дөрөө мултлах болжээ, зовсон хүн жаргаж золбин нохой зоолох болжээ.

134. **МИНУТА В МИНУТУ** яг цагт нь; цагийн юмыг цагт нь, ганц хормын ч зөрүүгүй.

135. **МИНУТУ ВНИМАНИЯ**! За чи харж бай! айн гэж бай! Чихээн онгойлгож бай! Хөөш! Түр тогтож хайрла! Аан гээд уун гэж бай!

136. **МИР ДОМУ СЕМУ** (хүнийг айлд ороход тосгуулж хэлдэг хүндлэлийн үг) тавтай морилогтун! Өөдөө морил! Дээшээ морил! Манай муу овоохойг гийгүүлж морил! Морилж ажаамуу, өөд болж ажаамуу, хоймор өөд залрана уу! Морилогту морилогту!

137. **МИР ПРАХУ ЕГО** хөөрхий зайлуул, эвий зайлуул.

138. **МИР ТЕСЕН** санасандгүй дайралда- (учира-), энд (тэнд) уулзана гэж санасангүй.

139. **МИРНАЯ (тихая) ПРИСТАНЬ** [*ирон.*] амарлингүй, санаа амар, хөл жийн, зовох юмгүй, бие сэтгэл тэнийж. Т-98

140. **МИРОВАЯ СКОРБЬ** [*разг., ирон*] сэтгэл гансрах, уй гашууд автах, сэтгэл атгахан болох.

141. **МИРСКАЯ МОЛВА, ЧТО МОРСКАЯ ВОЛНА** Л-145.

142. **МИРСКАЯ СЛАВА СИЛЬНА (звонка)** олны амыг олсоор боож болдоггүй, түмний амыг төмрөөр боож болдоггүй. Олны олон таван цэн, олноороо зөвшөөл омтгойгүй, бүгдээрээ хэлэлцвэл буруугүй, олон хүчтэй, олны үг ортой, цөөний зөвөөс олны буруу дээр, олонтой бол баянтай.

143. **МНЕ С НИМ НЕ ДЕТЕЙ КРЕСТИТЬ** [*разг.*] Би цаадахтай чинь ямарч хамаа байхгүй, ямар үлийний нь хамаа байх вэ дээ!

144. **МНЕ ЭТО НРАВИТСЯ**! Ямар ёс вэ? юу болж байгаа нь энэ вэ? даанч дээ.

Мне это нравится! ни слово не сказал, уехал и оставил нас без машины! үг ч үгүй дуу ч үгүй явган орхиод явчихдаг ямар ёс вэ (хар цагаан дуугарах ч гүй нохой нүдгэн гахай явган орхидог нь ч юу вэ)?

145. **МНИТЬ О СЕБЕ** биеэ тоо-, өөрийгөө ихэд бодо-, толгой нь хавд-, сүүлээ өргө-, маадгар зан гарга-,

146. **МНОГАЯ ЛЕТА (МНОГИЕ ЛЕТА)** *буюу* **МНОГОЕ ЛЕТО** зуун насыг наслаж зургаадай таягийг тулах, урт наслаж удаан жаргах, зуун намрыг үзээрэй түм насал! Өлмий тань өнөд батдах болтугай.

147. **МНОГО (многое) БРАТЬ НА СЕБЯ** биеэ дээгүүрт ав-, өөрийгөө ихэд бодо-,

148. **МНОГО ВЗЯТЬ НА СЕБЯ** М-147

149. **МНОГО (немного) ВОДЫ УТЕКЛО** [*разг.*] он уджээ, уджээ удаж, олон жил боллоо доо. Н-995

150. **МНОГО ВОЗМЕЧТАТЬ О СЕБЕ** давилуун зантай, уулын орой харсан, биеэ тоохын туйл болсон

151. **МНОГО ЗАБРАТЬ СЕБЕ В ГОЛОВУ** М-150.

152. **МНОГО (долго) НЕ НАДЫШИТ** [*прост.*] амьсгааны тоо нь гүйцэх шахсан,, амьсгаа хураадаг дээрээ байгаа, ханат гэр холдож хадан гэр ойртсон.

153. **МНОГО О СЕБЕ ДУМАТЬ (мыслить)** М-150.

154. **МНОГО ЧЕСТИ** ээ муугаас зайлуул, буруу хойшоо, хүнддэх бий дээ, буян нь зөв шингэг.

155. **МНОГО - МНОГО** [*разг.*] олондоо, ихдээ, цаад тал нь, цаанадаж, цаана хэлж, (их) сайндаа л.
В этом чемодане много - много 20 килограммов Энэ хайрцаг ихдээ л хорин кило юм орно биз дээ.

156. **МОДУС ВИВЕНДИ** [*лат.*]. аргацаах ажил, саатуулах хэлэлцээ, барьзнах арга

157. **МОЁ (*твоё, его, ее, наше, ваше, их*) ДЕЛО МАЛЕНЬКОЕ** их холбогдолгүй, тэдийлэн хамаагүй, холбоо сүлбээ багатай

158. **МОЁ (твоё, его и. т. п.) ДЕЛО СТОРОНА** [*разг.*] чамд (тэнд тэрүүнд) хамаагүй, надгүй, дальжгүй, чамд хамаагүй хаданд чимээгүй.

159. **МОЁ ПОЧТЕНИЕ** [*разг.*] 1. (Уулзахдаан буюу салж явахдаан ёсолж хэлдэг үг) амрыг эрье, сайн морилж байна уу?, сайн морилоорой. 2. Жигтэй хэрэг, санаа саванд багтахгүй хачин юм. эвэртэй туулай шиг юмаа

160. **МОЖЕТ БЫТЬ (БЫТЬ МОЖЕТ)** магадгүй, яаж ч мэднэ, онилгүй мэдэшгүй.

161. **МОЖЕТ СТАТЬСЯ** [*разг.*] Магадгүй, мэдэшгүй, онилгүй, онолгүй, юмыг яаж мэдэх вэ? ... ч юм бил үү! тэхнээ ядахгүй.

162. **МОЖЕТЕ НЕ СОМНЕВАТЬСЯ** саная зоволтгүй, зүв зүгээр, яах болдоо гэх юмгүй, айлтгүй, дажгүй.
Можете не сомневаться, всё будет исполнено саная зоволтгүй бүтчихнэ.

163. **МОЖЕШЬ (можете) СЕБЕ ПРЕДСТАВИТЬ** П - 937.
Можете себе представить, этот старый холостяк женился хараач хөөе! мань хашир гэрэлчихэж (овоо л доо олон жил гоонь явснаа эхнэр авч шүү , үгүй ер, гон бие гозон толгойт маань нэг юмтай толгой холбожээ).

164. **МОЖНО СКАЗАТЬ** ... гэж болох юм, ... юмдаа.
Пятьдесят лет - возраст, можно сказать, почтенный тавин насыг ч их нас гэж болно доо (тавин нас хүрнэ гэдэг ч овоо шүү) тавь хүрсэн хүнийг басаж болохгүй шүү.

165. **МОЖНО ЧЕСТИ ПРИПИСАТЬ** [*разг.*] алдар гавъяа юмдаа. золь хийморь мөндөө.

166. **МОЗГИ НАБЕКРЕНЬ** *У кого* [*прост, шутл.*] баахан эргүү, ухаан муутай юм шиг, ороотой гараатай, цагаан солиотой, ээдэй буудай, элий балай, мунхаг мулгуу, тэнэг дүйнгэ, мангар маанаг, үүлгэр зүүлэг, бохио бойдоо.

167. **МОЗОЛИТЬ ГЛАЗА** *кому* [*разг. неодобр.*] садга (савдаг) элээ шиг, алиа салбадай оргиод, нойтон хамуу шиг, гүзээнд наалдсан дэлүү шиг, хар яршиг оргиод, нойтогноод салахгүй, нойтон нурам шиг, хонхны хэл шиг, хойно урд нь бөртөгнөсөн Н-503

168. **МОЗОЛИТЬ РУКИ** [*прост.*] гартаа эвэр ургатал (юм хий-) шөрмөсөө сунатал. арван хурууныхаа арыг барж, таван хурууныхаа тарыг барж

169. **МОКРАЯ КУРИЦА** [*разг.*] арчаагүй амьтан, хариугүй эр, норсон элээ шиг, гал нь үхсэн амьтан, хийморий нь тугал зажилсан, ухасгүй, үнсэнд хаясан шалз шиг амьтан, найгүй эр, хүний сүг, хүн харахад л хүн
Это не спортсмен а мокрая курица энэ бид хоёр тамирчин байхаан хат, най нь тасарсан эр шүү дээ.

170. **МОКРОЕ МЕСТО ОСТАНЕТСЯ (осталось) (от кого)** *буюу* **ОДНО только) МОКРОЕ МЕСТО ОСТАНЕТСЯ** [*разг.*] нойтон голтой нь үлдээ-, үнсий нь хийсгэ-, голомты нь харлуулняц цохи-, яйруул-, хярамцаг болго-. О-102

171. **МОЛИТЬ БОГА** *за кого* чин сэтгэлээс тал өг-, баяраа илтгэ-ерөөл тави-.

172. **МОЛОДО ЗЕЛЕНО** [*прост.*] юм мэдэхгүй хүүхэд, шал томоогүй жаал, хүүхдээрээ, борвины нь баас хатаагүй, амны нь салай арилаагүй.

173. **МОЛОДОЙ ДА РАННИЙ И** - 263.

174. **МОЛОКО НА ГУБАХ НЕ ОБСОХЛО** [*разг.*] Шар завьжтай амьтан, амны нь салай арилаагүй, хүний гараас гараагүй, шээсэндээ шальчиж баасандаа балчиж байгаа, аавынхаа өврөөс гараагүй, ээжийнхээ хөхнөөс гараагүй. Г-230

175. **МОЛОТЬ ВЗДОР (чушь, ерунду и. т. п)** [*разг., фам.*] Дэмий ярь! Дэмий донгос! Амаа мэд! Амаа тат! Бүү дэмий! Дуг! Цөг! Хош!

176. **МОЛОТЬ ЯЗЫКОМ** [*разг. пренебр.*] хэлээ билүүдэ-, (хэл)

179. **МОЛОЧНЫЙ БРАТ (МОЛОЧНАЯ СЕСТРА)** (эх өөртэй оо ловч) нэг эхийг хөхөж өссөн эгч дүүнэр, нэг хөхийн эгч дүү нэр (ах дүү нар)

180. **МОЛЧАНИЕ-ЗНАК СОГЛАСИЯ** дуугүй байна гэдэг, дургүй ч гүйн тэмдэг.

181. **МОЛЧАТЬ В ТРЯПОЧКУ** [*прост*] амаа жимбий-, дугуй дүмбий- үгээ хураа-

182. **МОРДА КИРПИЧА ПРОСИТ** [*прост., вульг.*] нүдэнд хүйтэн (царай), харахаас зэвүү хүрмээр, нүд хорсмоор, нүүрийн буянгүй, хүүхэд аймаар царайтай, нүдэнд өргөс, нүдний булай, харахаас дургүй хүрмээр.

183. **МОРЕ ПО КОЛЕНЫ (ПО КОЛЕНО)** *кому.* [*разг.*] юуч тоохгүй, юунаас ч айхгүй, бөх зүрхтэй, чулуу шиг зүрхтэй, сайн ч нэг, муу ч нэг, чнхгүй толгой, юу ч болж байсан хайхардаггүй, яахаас ч сийхгүй, юм үзэж нүд тайлсан, хол явж доль цохисон, гудиггүй, хир барагтайд дав хийдэггүй.

184. **МОРКОВКИНО ЗАГОВЕНЬЕ** [*шутл., перен.*] эцэсгүй цаг, төгсвөргүй цаг, мохоолгүй цаг

185. **МОРОВОЕ ПОВЕТРИЕ** халуун хижиг, айхавтар тахал, өвчний аян.

186. МОРОЗ ПО КОЖЕ (по спине) (**подирает, дерёт, пробегает**) [*разг.*] 1.. Чөмөг царцам хүйтэн; үхрийн сүүл хүгарам; гуныи эвэр хүгарам (гурван есийн хүйтэн) 2. Айдас хүрэм; зүрх алдам; айн гэлмэгдэх; толгойтой үс арзайм; дотор зарасхийм.

187. МОРОЧИТЬ (дурить) **ГОЛОВУ** *кому* [*разг.*] толгойгий нь эргүүл-; молиго үмхүүл-; малла-.

188. МОРСКАЯ БОЛЕЗНЬ онгоцонд агсагадах; онгоцонд зайлагдах.

189. МОРСКОЙ ВОЛК [*разг.*] Хашир далайчин; хашир чоно; хашир боохой; далайн чоно, доль цохиж догширсон далайчин.

191. МОТАТЬ (себе) **НА УС** [*перен., разг.*] санаандаа санаж шанаандаа зууж ав-; цээжиндээ хадаж ав-; сайн тогтоож ав- Н-504

Он ничего не говорил, а только слушал и мотал себе на ус Юу ч хэлэлгүй, чагнахын сайнаар чагнаж; санаандаан санаж шанаандаан зууж авав.

192. МОЧЕНЬКИ НЕТ (МОЧЕНЬКИ НЕ СТАЛО) Тэсэхээ байлаа; чаргаан даахгүй нь; тамир алдав; арга барагдав; бүр хир боллоо; чадал барагдлаа; сульдцарлаа. хир боллоо, хөлдүүдээ тулав.

Ох, моченьки моей нет! Эө дээ би ч одоо хир болдоо;

193. МОЧИ НЕТ (как) тэсэхийн аргагүй; тэсэхүйеэ бэрх, арга алга; мэх алга; хачин; нөхцөлгүй; хэцүү; лут.

Мочи нет, как холодно Хүйтэн гэдэг мэхгүй байна.

194. МОШЕЧНИКИ ПЕРА—Р-35

195. МОЯ твоя, его, ее, наша, ваша, их **ХАТА С КРАЮ Я ничего не знаю** [*разг.*] Энэ надад хамаагүй; энэ надад падгүй; би мэдэхгүй; юу юм, яасан юм! над хүртээлгүй.

196. МРАК НЕВЕЖЕСТВА Аль ч учрыг мэдэхгүй; мал оргиулах, дэмий үүлгэртэх.

197. МРУТ (дохнут) **КАК МУХИ** Бөөн хөл, хар туруу шиг (олон), шоргооляж шиг, шороон түм.

198. МУЖИК ТОНУЛ-ТОПОР СУЛИЛ, ВЫТАЩИЛИ-ТОПОРИЩА ЖАЛЬ

у г ч н л ж о р ч у у л б а а с: нэг хөдөөвөр эр голд унаад алтан амий минь аварч; уснаас гаргаж хайрласан хүнд сүхээ баричихна гэж; уснаас татаад гаргачихсан хойно сүхээ байтугай, сүхнийхээ ишийг ч өгч тэвчсэнгүй.

у т г а - ч и л а н о р ч у у л б а а с: Хүн гэдэг амьтан сандран мэгдэж аврал эрэх үедээ юугаа ч хайрлахгүй гэх мөртөө гачаалаасаа ангижирмагц, *айргийг нь нууж ангаа гармагц алаг гүүг мартах гээчийн* үлгэр болдог жамтайг өгүүлжээ. Алтыг нь аваад ачий нь мартах, уулын нөмөрт хоноод уул надгүй боя яах байсан бол гэгч.

199. МУЗЕЙНАЯ РЕДКОСТЬ хуучин үеэ өнгөрөөсөн; ховор үзмэр төдүй болсон; хэрэгцээнээсээ гарсан.

200. МУЗЫКА НЕ ТА [*разг., шутл.*] тэр тийм биш ээ; шал ондоон; үгүй чиш; тэр хавьцаа ярихгүй; төслөхгүй төсгүй; чиний мэддэг дангийн жаа биш.

201. МУЗЫКА СФЕР агаарын хөгжим.

202. МУКА МУЧЕНИЧЕСКАЯ [*разг.*] үйлээ үзэж үсээ тоолох; элс үмхэж эрэг мэрэх; үйл тамаа эдлэх; тамаа цайх; үнсэнд хаягдсан шалз болох; гараараа газар маажих; хөлөөрөө үнсээ малтах, дөшөө гарья тэнгэр хол доошоо оръё газар хатуу,зовсон сүүгээ хөхөх

203. МУКА МУЧЕНСКАЯ [*прост.*] М—202

204. МУКИ ТАНТАЛА М—202 Т-47

205. МУРАШКИ ПО ТЕЛУ (по коже спине) **БЕГАЮТ** (**поползли, пробежали, забегали, пошли**) ар зоо руу хүйт даав (оргив), бие зарсхийв; айдас хүрэв; дотор пал хийв; бие арзайх; нуруу руу ус цацах шиг.

206. МУТИТЬ ВОДУ [*разг.*] хэрэг тари-; буднлаан хутга-; маанагий нь хутга-; үймүүлж сандраа-; амар заяа үзүүлэхгүй; гайгаа чирэ-, мундар хутга-

207. МУТОРНО НА ДУШЕ (**МУТИТ НА ДУШЕ**) сэтгэл зовиуртай; дотор шаналгаатай; сэтгэл тэвшингүй.

208. МУХА УКУСИЛА буюу **БУДТО** (словно, точно) **МУХА УКУСИЛА** санаандгүй юм болов-; тэгдэггүй юм тэгэх

209. МУХИ ДОХНУТ (мрут) уйтхарт дарагдах- уруу унжуу байх; сэтгэл гансрах.

210. МУХИ НЕ ОБИДИТ [*разг.*] хэнтээ хонь босгохгүй; хорхойд хоргүй; хүнд гэмгүй; мөрөөрөө амьтан

211. МУХИ ЗАШИБИТЬ (раздавить) архида-; хөлчүүрэ-; улаан зээрд бол-;

212. МЫКАТЬ ГОРЕ [*разг.*] ядуу зүдүү амь зуу-; шар нараи, бор хоног өнгөрөө-; хоёр идэхгүй хоосон хонохгүй; арай хоосон хоноогүй

213. МЫЛИТЬ ГОЛОВУ *кому* Н—505

214. МЫЛЬНЫЙ ПУЗЫРЬ хөөс шиг; хөөхөр яс мууиай; гэмсхэн; үлээсэн гүзээ шиг; үдээрээр үдсэн тулга шиг; зүүд зэрэглээ шиг; үлээхэд хийсчихмээр; шилэн наадам шиг; өндөг шиг; хонхруудас шиг; уйланхай шиг.

215. МЫСЛЕННО ПЕРЕНЕСТИСЬ [*перен.*]... шиг бодогдо-;... мэт санагда-;... (тийм ийм юм) санаанд оро-

Мысленно перенестись в детские годы бага цаг санаанд оро- (багын юм бодогдо-)

216. МЫСЛИ БЛУЖДАЮТ өөр бодолтой; өөр санаатай; хөөрдмол санаатай, сэтгэлээрээ чулуу хөөх; бодохгүй юмгүй; ам санаатай; Г-50

217. МЫСЛИМОЕ ЛИ ЭТО ДЕЛО? (**МЫСЛИМО ЛИ ЭТО?**) Санаанд яаж багтах вэ? Санаа савааа багтахгүй юу гэсэн үг вэ? Ийм ёс хаа байна? Даанч дээ; арай ч дээ; дэндүү.

Мыслимое ли это дело в один месяц потратить столько денег? Ганц сард ийм их мөнгө бүрэлгэх ёс хаа байна (даанч дээ, ганцхан сард өдүй их мөнгө үрчих гэж!)

218. **МЫСЛЬ ЗАБРЕЛА В ГОЛОВУ** *кому.*, [*разг.*] дотор сэрхийв; сэтгэлд (санаанд) гэнэт оров; юу юугүй бодогдов; (тэгэе) гэж нэг бодогдов.

219. **МЫТЬ (вымыть) ГОЛОВУ** *кому* Тархий нь эргэтэл загна-; зад загна-; зад донгодо-. хосы нь урт ав- шүүсий нь шаха-

220. **МЫШИНАЯ БЕГОТНЯ (возни, суета, сутолока** (сандан мэндэн; хөл үймээн болон; хий бужигнах; зогсоо чөлөөгүй гүйж харайсаар.

День прошёл в беготне по городу хотоор гүйж харайсаар байгаад өдрөө барав.

221. **МЫШИНЫЙ ЖЕРЕБЧИК** шар сэмжилсэн хүн; ороо нь оройтсон хүн; гүймхий хүн; хөөмхий хүн; мунагийн хорхой туссан хүн

222. **МЯГКИЙ, КАК ВОСК** өд шиг зөөлхөн; торго шиг; гурил гэсэн үг; мяндас шиг; хадаг шиг; элдүүртэй нэхий; элдүүр нь ханасан нэхий шиг; хурга торго шиг.

223. **МЯГКО ВЫРАЖАЯСЬ** [*разг., ирон.*] (тийм) рхүү (ийм) рхүү; нэг жаахан; ...шиг; ...мэт; нэг баахан ... уу ... үгүй юү?; ...юм биш биз; ...схийгээд

Это, мягко выражаясь, злоупотребление властью Эрх дархаараа баахан түрээ бариад байна уу үгүй юү? (Эрх ямбаа хэтрүүлэсхийгээд байгаа биш биз!)

224. **МЯГКО СТЕЛЕТ, ДА ЖЁСТКО СПАТЬ** үг нь зөөлөн үйл нь хатуу; үг нь зөөлөн үйл нь чанга; үг нь гурил; зүрх нь цагил; аман дээрээ бал, алс цааная жад; ам чадалтай ажил нь бачтай; ам нь ээж, ачир нь хойт ээж; аман дээрээ ижий ахай, ачир дээрээ атаатай дайсан

225. **МЯКИННАЯ БАШКА** М-226.

226. **МЯКИННАЯ ГОЛОВА** [*прост*]. Мулгуу хүн; мунхаг хүн; мунхаг мал шиг амьтан, тэнэг.

Н

1. **НА АВОСЬ** [*разг.*] азаар, аз нь үхээгүй байгаа, азын тэнгэр харах байгаа, аз дайрвал, аз хүү байвал заяа мэдэг, заяа харгалзаг, хувь байвал

Начинать такое большое дело на авось невозможно да и не годится Ийм том ажлыг аз сорьсон шиг барьж авч болдоггүй хэрэг ээ (Ингэж байж эмнэг азрага сүүлдсэн шиг юм болуузай).

2. **НА АРАПА** [*прост.*] арга залиар, мөнгөөр хуурч, нүд хуурч, аргацааж, нүглийн нүдийг гурилаар хууран, хөөрхөн үнэгчилж

3. **НА АККОРД** Амы нь авахад, өчгий нь сонсоход, хэлцээрийн байдалд

4. **НА БАРСКУЮ НОГУ** Баян тарган, тосон дотор умбан, торгон дотор хөлбөрч, амттыг идэж алтыг эдлэж, хэт бүрэлгэж Ж-84

5. **НА БЕДНОГО МАКАРА ВСЕ ШИШКИ ВАЛЯТСЯ** Үзэж дуусахгүй үйлтэй амьтан, оройтоход дороойтох, уруудахад буруутах, нэг бүдэрвэл долоо бүдрэх, ядсан нохойд хатсан баас, ядрахад яр, муу хүний ноён олон.

6. **НА БЕДУ** [*разг.*] Өлзий бүс чинь, гай болж, үйлс бараантаад, тэнгэр нь хаяж, аз дутахад, ядаж явахад.

На беду, билетов на самолёт не оказалось Үйлс нь харлахад онгоцны билет дуусчихжээ. Н-336

7. **НА БЕЗРЫБЬЕ И РАК РЫБА** Мах ховордоход богтос түрүү, нохойгүйд гахай хуцах, ламгүйд банди, бурхангүй газар бомбо (бумба) галзуурах, лам олдохгүй бол буцахдаа залах, олдохгүйд мундахгүй.

8. **НА БЕЛЮМ СВЕТЕ** ертөнцөд, дэлхийд, орчлонд, хөрст дэлхий дээр, нарт ертөнц дээр, нартад, Замбуулинд, замба тивд Хорвоод аль ч тивд, тив дэлхийд.

9. **НА БИС (сыграть, спеть, исполнить)** Дахин гар-, дахин (дуула-), дахин (бүжи-) дахнулъя, дахиад дахиад,

10. **НА БОБАХ** О-195

11. **НА БОК** хэлтгий, хажиулд, жишүү, хазгай, бөөрөн дээр нь (малгай бол) духдуул, сүүжилдүү, (тэмээ) бөөрөлдөх, хэвгий, налуу, нэг тийшээ, холбируу.

12. **НА БОЛЬШОЙ ПАЛЕЦ** [*прост.*] (юм хийхэд) эрхий өргөм, гаргуутай, баавгай, бэрх сайн, эр бар

13. **НА БОЛЬШУЮ НОГУ** Н-4...

14. **НА БОРТУ** галт онгоцонд, хөлөг онгоцноо

15. **НА БОРТУ САМОЛЁТА** нисэх онгоцноо, нисэх онгоцонд, онгоцонд.

16. **НА БОСУ НОГУ** холхиндог, холихиндог өмсөх

17. **НА БРАТА (по)** Хүн бүрд, тус бүрд

Выдали лишь по десяти рублей на брата Хүн бүрд арав арван төгрөг өгөв (Хүн бүрд арав аравхан рубль түгээв).

18. **НА БУЛАВКИ** [*устар.*] Жижиг зарлага, ойр зуурын мөнгө, өдрийн мөнгө, ахир шахир мөнгө Н-117

19. **НА БУМАГЕ** Хоосон (хийх) яриа болж хоцрох,

20. **НА ВЕКИ ВЕЧНЫЕ** *буюу* **НА ВЕК** *буюу* **НА ВЕКИ** эгүүрид, үүрд, насад, ашид, авирад, эгнэгт, хэзээ ямагт, галав юүлтэл, түмэн он, мянган жил, зуун намар.

21. **НА ВЕРХУ БЛАЖЕНСТВА** Магнайгаа хагартал баярлах, баяр магнай болох, дээдийн жаргал эдлэх, хөл газар хүрэхгүй.

Я только что поступил в университет, чувствую себя на верху блаженства. (Буслаев, Мои воспоминания) Сав сая их сургуульд шавилан ороод, би баярын магнай болж явна даа.

22. **НА ВЕС ЗОЛОТА ЦЕНИТЬ** *что* Алт шиг бодо-, эрдэнэ мэт, эрээд олдохгүй эрдэнэ сураад олдохгүй сувд мэт, алт шиг ховор, эрдэнэ болсон, буга буулгаж, согоо суулгах шиг, хүнд үгүй юм шиг,

В библиотеке находились книги, расценивающиеся на вес золота Номын санд эрдэнэ мэт ховор ном байв.

23. **НА ВЕСУ** Өлгөөтэй, дүүжлээстэй, унжуулаатай, гонжигонон, сугсармал, зүүлттэй, ганзагалаатай, дэнсний нуруун дээр

24. **НА (во) ВЕСЬ НАРОД** [*устар.*] Олны өмнө, түмний нүдэнд, нийтэд.

26. **НА ВЗВОДЕ (НА ВТОРОМ ВЗВОДЕ)** [*разг.*, *шутл.*] хөлчүүхэн, халмаг, халамцуу.

Сосед мой и этой ночью вернулся на взводе Манай айлын хүн урьд шөнө бас л халмагхан харьж ирсэн.

27. **НА ВЗГЛЯД** [*разг.*] 1. харваас, царай нь, янзы нь харвал, байр нь, байдал нь маяг нь, шинж нь, 2. ...ны бодоход, ...ны санаж байгаагаар, харсаар байтал, үзтэл, Н-70

На взгляд он казался старше своих лет Байр нь харахад оворжуу хүн ээ дээ. **На мой взгляд, он изменился к лучшему** Миний бодоход арай зэсарчээ (овоо засарсан даг шүү).

28. **НА ВИД** Н-27.

29. **НА ВКУС И НА ЦВЕТ ТОВАРИЩЕЙ НЕТ** өөрийн санаа өөртөө зөв, хүн хүний бодол өөр, гүзээ гүзээний булан өөр. Миний нүдээр хараач, нутаг нутгийн зан өөр нуга нугын өвс өөр

30. **НА ВОДКУ (дать, получить)** [*разг.*] гар цайлгах мөнгө, тамхины мөнгө.

31. **НА (свежем) ВОЗДУХЕ** *буюу* **ОТКРЫТОМ ВОЗДУХЕ** эрүүл газар, задгай салхинд, хээр, ил, ил задгай,

Пили чай в саду на открытом воздухе гадаа цэцэрлэгт цайлцгаав.

32. **НА ВОЗРАСТЕ** [*разг.*] хүн болсон, том болсон, биед хүрэх эр цээлсэн, насанд хүрсэн, бие гүйцсэн, үс хагалсан

33. **НА ВОЛЕ** [*разг.*] гадаа, хээр, эр хүний жаргал эзгүй хээр, наранд эрх тааваар.

34. **НА ВОЛОС** дөнгөн данган, чүү л гэж, чүү чамай л гэж, арай чамай гэж, хумсын чинээ, үзэгдэхийн төдий.

35. **НА ВОЛОСКЕ (висеть)** дэн дун дээсэн дөрөөн дээр, хутганы ир дээр, ...ны даваан дээр, золтой л, зэяатай л,

Жизнь больного на волоске Өвчтэй хүн амь алддагийн даваан дээр (Амьсгаа хураах дөхжээ).

36. **НА ВОЛОСОК (волосот)** *от чего* (тэх)ийн даваан дээр, (тэг) дэг дээрээ, харнугүй (тэх) дээрээ, амь наана там цаана, хутганы ир дээр, нэг хөл дөрөөнд нэг хөл шороонд

Быть на волосок от смерти Үхдэгийн даваан дээр байх.

37. **НА ВОЛЬНОМ ВОЗДУХЕ** эрүүл агаарт, уудам хээр талд, хотын зах, хээр хөдөө, аглаг газар.

38. **НА ВОЛЮ** [*разг.*] гадаа, хээр, эр хүний жаргал эзгүй хээр, наранд, эрх дураараа

39. **НА ВОРЕ ШАПКА ГОРИТ** гэмт хүн гэлбэлзэнэ, дайрт морь шарвалзана-, гэмт хүн гэрийн цаанаас, дайрт морь даваан цаанаас, пүүрий нь үзэхээр андашгүй, нүд нь заагаад өгнө, нүд буруула-, сүү долоосон гөлөг шиг, хулгайч нохой шиг.

40. **НА ВРЕМЯ** түр, түр зуур, нэг хэсэг, нэг жаахан, азнах,

41. **НА ВСЕ КОРКИ (бранить)** [*прост.*] Харааж зүхэ-, аашилж загна-, тархи толгойгүй загнах, тархий нь эргэтэл загнав, толгойгий нь авах шахах, нүдий нь ухах (чичих)

Отец бранил своего сына на все корки
Эцэг нь хүүгээ тархи толгойгүй загнав (тархий нь эргэтэл загнав).

42. **НА ВСЕ ЛАДЫ** юу байдгий нь, зүйл бүрээр нь, тал талаас нь, хүн буйраар, удам судраар нь, зүг бүхнээс нь.

43. **НА ВСЕ ПРО ВСЕ** бүгд хийлээд, дүндээ, дүнд, бөгсөндөө.

44. **НА ВСЕ РУКИ (мастер, мастерица)** М-41

45. **НА ВСЕ СТО** [*прост*]. зууны зуун хувь, арван хуруу тэгш, хий морьтой, тун сайхан, тун сүрхий, төгс, бүрэн, хийгүй, гар муу гэх юмгүй, дутуу юмгүй, өөлөлтгүй, гололтгүй, чамлалтгүй. шаасан гадас шиг, шахсан бяслаг шиг

Молодцы наши футболисты, сыграли на все сто Манай хөл бөмбөгчин залуус сүрхий сайн тоглов (өшиглөв, наадав).

Мы выполнили план на все сто процентов. (Бид нар) төлөвлөгөөгөө бүрэн биелүүлэв.

46. **НА ВСЕ ЧЕТЫРЕ СТОРОНЫ (отпустить, прогнать и. т. д)** [*разг*]. дураараа болог, юу сайхан дур сайхан, яавал яаг, жолоогий нь эвхээд тавьчих, бурантгий нь эвхээд туучих, дургүй ламыг дарж байж сахил хүртээгээд яах вэ? Буйлы нь шувтлаад тавьчих. Зөнд нь орхичих.

47. **НА ВСЁМ ГОТОВОМ** орогноё орон бэлэн, идье хоол бэлэн; хоол, сууц бүгд бэлэн, дутуу юмгүй, барих гартэй, саах үнээтэй, хотлох хоньтой, хөтлөх ухэртэй, ачих тэмээтэй, унаж морьтой, гэр бүтэн гэдэс цатгалан, мөр бүтэн гэдэс цатгалан.

48. **НА ВСЁМ СКАКУ** хар хурдаараа, морин гүйхээр, жолоо хумхилгүй, хар эрчээрээ, хурд саалгүй, галтайгаа буу, тоостой нь хуйл.

Остановить коня на всём скаку Хар хурдаар нь явснаа амы нь татав) Н-293

49. **НА ВСЕХ ПАРАХ** 1. галт онгоц, галт тэрэг (хар хурдаараа, баидаг тэнхээгээрээ, дээд хурдаа гарган. 2. [*перен*]. Хар хурдаараа, далавч (жигүүр) ургасан мэт, хар гүйхээрээ.
Крейсер идёт на всех парах Их далайн хөлөг онгоц хар хурдаараа зүсэнхэн хөвөв **Поёзд мчался на всех парах** Галт тэрэг хар эрчээрээ жирийлгэв.
50. **НА ВСЕХ ПАРУСАХ** [*разг*] хар хурдаараа, далавчилсан мэт, жигүүртэй юм шиг.
51. **НА ВСЕХ ПЕРЕКРЕСТКАХ** газар сайгүй, гудамж зээл болгонд, урагшаа харсан үүдгэй бүгдэд, үүдтэй өрхтэй бүрд, дөрвөн зүг найман зовхисг, энд тэнд, энүүгээр тэрүүгээр, хүн амьтан, амтай бүр нь.
На всех перекрёстках рассказывать о чём Газар сайгүи . . хэмээн хэлэлцнэм.
52. **НА ВСЮ ЖИЗНЬ** насан турхаруу, насан турш, нэг насаар, насад, амьд яваа насандаа, энэ яваадаа, энэ сүүдэртээ, төрөл арилжтлаа, нүд аньтлаа, насан эцэслэтэл, үхтлээ г. м.
53. **НА ВСЮ (на полную) КАТУШКУ** [*прост*] 1. чинээнд нь тултал, чанга чанд, хатуу гараар 2 санаандаа тултал, таваа ханатал, хутга тавилгүи мах идэж хундага тавилгүй архи ууж . . , цэнгэлийн манланг эдлэх
54. **НА ВСЯКИЙ ПОЖАРНЫЙ СЛУЧАЙ** [*разг*, *шутл*] хэрэг болоход, хэзээ нэг хэрэгтэи цагт, юу ч болтугай, юмыг яаж мэдэх вэ? болоож нь (болж гэм), юм хэцүү шүү, алс нь хэрэг болно. Н-139
55. **НА ВСЯКИЙ СЛУЧАЙ** [*разг*, *шутл*] Н-54
Возмите зонтик на всякий случай Болбоож нь шүхрээн авааД яв
56. **НА ВСЯКОГО МУДРЕЦА ДОВОЛЬНО ПРОСТОТЫ** мэргэн боловч алддаг, мэлхий боловч шаварддаг, хүн сайн боловч (ч) хэлэхээс наашгүи, цаас хичнээн нимгэн болов ч (ч) чичихээс наашгүи
57. **НА ВСЯКОЕ ХОТЕНИЕ ЕСТЬ ТЕРПЕНЬЕ** хүсэхэд хясах, дуран дээр нь хясах.
58. **НА ВСЯКОЕ ЧИХАНЬЕ НЕ НАЗДРАВСТВУЕШЬСЯ** хүний хэлэл нохойн хуцал болгон хүнд хамаатан бишээ, инээснийг үзэж инээх, уилсныг даган уилах, усны үзүүр шиг битгий яв.
59. **НА ВЫ** *с кем* тэр гуай, энэ гуай, чи би болох (чи би дээ хүрэх)
60. **НА ВЫБОР** дураа шилэх, дуртайгаа авах, авъя гэснээ л авах, юу санхан дур саихан.
61. **НА ВЫВОРОТ** тонгорох, хөмрөх, уруу нь харуулах
62. **НА ВЫДАНЬЕ** эрд өгдөг дээрээ, эрд өгдөг насаа, хадамд очдог дээрээ, Биед хүрсэн бүсгүи хүүхэд, шанхтай хүүхэн, хүнд очдог нас, хүнии хүн болох нас. морддог цаг.
63. **НА ВЫЛЕТ** (сум) нэвт цохих, сэнжлэх, сэт цохих, цоо цохих, нэвт шувт, хавах, сүвлэх,

Его ранило в плечо на вылет Сум мөрөөр нь цоо сэнжлэв.
64. **НА ВЫНОС** (сархдыг дэлгүүр пүүзэндээ уулгахгүй гагцхүү гадагш нь зарахыг ийн өгүүлнэ) архины ганзагалан.
65. **НА ВЫПЛАТУ** [*разг.*] цаг цагт нь (мөнгө) өгөх, хугацаатай өгөх.
66. **НА ВЫСОТЕ (положения) (быть, оказаться и. т. п.)** яв цав, цав хэмээн таар, үлгэрээр нь тааруулсан юм шиг, яг таг, хялгасан тэдий ч зөрүүгүи, үзээд өгье хэмээвч зөрүүгүи.
67. **НА ВЫСТРЕЛ** [*разг*] нэг сумын газар, сум тусах газар, суман тусгалын зай, сум онтгодох газар, нумын газар, сум хүрэх газар.
68. **НА ГАЛЁРКЕ** [*прост.*, *шутл*]. тээр тэнд, ар жавданд, хамгийн арын мөрөнд, их хол, төө (тээ) тэнд, зайдуу,
69. **НА ГЛАЗ (глазок)** [*разг*] 1. багцаагий нь харах, нэгд нэгэнгүй ажих, нүдээрээ баримжаалах 2. (хэн нэг хүний) бодлоор.
70. **НА ГЛАЗА** Н-27.
71. **НА ГЛАЗА ПУСТИТЬ** к себе Нүдэнд харагда- (үзэгдэ-), нүдэнд туса-, хараанд өртө-.
72. **НА ГЛАЗАХ** у *кого* нүдээрээ үзэх, өөрөө харах, биеэрээ байж байсан, алга дээрх шиг.
73. **НА ГОЛОВУ ВЫШЕ** *кого* хэтэрхий мэргэн, гоц мэргэжсэн, онцгой чадварлаг, тодорсон, гаргуун, В-137
74. **НА ГОЛОВУ** *чью* **(сыпаться, обрушиться** [*перен.*] (хэн нэг хүний) толгой дээр буу-, булуу бол, лай бол . . . , төвөг уда-, ажил урга-,
75. **НА ГОЛОС** хадтал (хашгирах), хоолой мэдэн орилох, ори дуу тавих
76. **НА ГОТОВЫХ ХАРЧАХ** унд хоол нийлүүлэх, унд хоол өгөх.
77. **НА ГРОШ** Н-1104
78. **НА ГРУДИ (за пазухой) ОТОГРЕТЬ (согреть, пригреть) ЗМЕЮ НА ГРУДИ (за пазухой)** хорыг ачаар хариула-, хутга гаргахад нь шөвөг ч гаргахгүй, усыг тусаар хариула-
79. **НА ДАРОВЩИНУ (НА ДАРОВЩИНКУ)** сул олдсон, заяамал, зүгээр олдсон, зүгээр гарт орж ирсэн, үнэ цэнэ гэх юмгүй, бэлэн хоол, зөөлөн хоол, өртөггүй өөрөө олдсон, аманд орсон шар тос
80. **НА ДАЧЕ** зусланд зусах, зусланд байх.
81. **НА ДАЧУ** зуслан руу (явах, одох) очих
82. **НА ДВОР (пойти сходить)** жорлонд оро-, өтгөн мөр үзэ-, морь хара-,
83. **НА ДВОРЕ** [*разг*] гадаа, тэнгэр, цаг, тэнгэр хангай,
На дворе тепло (холодно) Цаг (тэнгэр. гадаа) дулаарав (хүитэн банна).

На дворе уже весна Хаврын урь унаваа хө.
Уж зима на дворе Хүйтний ам наашаа харж, хөхүүрийн ам цаашаа харлаа.

84. **НА ДЕЛЕ** чухамдаа, ачир дээрээ, хэрэг дээрээ.

85. **НА ДИВО (удивление)** [*разг.*] тун сайхан, жигтэй сайхан, чамин, гайхалтай, гоц, гойд, бузгай, нөхцөлгүй, өө гүй, чамгүй, тэгэнэ, гэмээ тэгсэн, тэгсэн шиг тэгсэн.
На рисовано на диво Жигтэй сайхан зуржээ (зурна гэмээн зуржээ, зурсан шиг зуржээ. гараа гаргаж зуржээ, зурах гэж энийг л хэлдэг байх, бариад авмаар зуржээ).

86. **НА (на дне) ДНЮ** өдөрт, нэг өдөрт.
Два раза на дню Өдөрт хоёр

87. **НА ДНЯХ** 1. энэ хэдэн хоногт, ойрын хэдэн өдөр, сүүлийн хэдэн хоногт, саяны хэдэн хоногт, ойрмогхон. 2. Одоохон, даан удахгүй, ингэсгээд, тэгэсгээд, мөдхөн удахгүй.

88. **НА ДОЛГИХ** [*устар.*] (урт аянд) ганц морь сэлэхгүй (унах) эмээл ховхлохгүй, нуруу амраахгүй, амгай салгахгүй, үргэлж давираастай,

89. **НА ДОЛЮ** тул, . . . ний өмнөөс,- шиг хойноос

90. **НА ДОМ** гэртээ (аваад явсан), гэрээрээ.
Дулама берёт работу на дом. Дулмаа хийх ажлаа гэртээ, аваад явсан.

91. **НА ДОМУ** гэртээ, өөрийнхөө гэрт.

92. **НА ДОРОГЕ (на полу, на улице) НЕ ВАЛЯЕТСЯ** аксаар олдохгүй, тийм ч амаргүй бөлэн хоол биш.

93. **НА ДОРОГУ** (аянд) мордохын өмнө, явахынхаа өмнө, (аянд) гарахын өмнө, замд гарахаасаа урьд, хөдлөхийнхөө түрүүн, хөлгийн жолоо залахын өмнө. заримдаа **В-59**

95. **НА ДОСУГЕ** завандаа, зав гарвал, зав чөлөөндөө, зав зайндаа

96. **НА ДРУЖЕСКОЙ (на короткой) НОГЕ** *с кем* Найзаа дундаа, өвөр түрийндээ оролцож.

97. **НА ДУРАКА (делать)** [*прост.*] хам хум (хий-), сал сул (ажилда-), нэг юм тэгсэн бол-, ер нэр болго-,

98. **НА ДУШЕ** дотроо, санаандаа, цээжиндээ, бодохдоо.

99. **НА ДЫБЫ** 1. Дургүйцэх, царгалах, болж өхгүй, зэ хүлээхгүй, хир халдаахгүй (байх), халгахгүй (байх), үхээрхэх, тээршээх, ядаж цөхөх, гуйлгах.
Встать на дыбы Дургүйцэ-
Я настаивал на этом, а он на дыбы Би тэгэе гэсэн юм, цаадах чинь огт дургүйцээд байв.

100. **НА ЖИВУЮ НИТКУ (шить)** [*разг.*] хам хум. санд мэнд, онгойхоор умай гэгчээр, хүйтэн цай зайдан морь, бушуухан домносон болох, . . . сан[4] нэр хүлээ-, нэр бөглөх, (нэр авах). . . сан[4] нэр зүүх, (оёдол дээр) таваргах, тэмээ тавьсан юм шиг,

шидэх, тэмээ морь харайлсан мэт, дөнгөж тогтоох, утсаар тогтох.

НА ЖИВУЮ РУКУ бушуухан бушуухан, хам хум, яаран сандран, түргэн гэгч нь гарын тоймоор, дээгүүр харж байгаад мүдэн балай чихэн дүлий, гарын үзүүрээр

НА ЗАКАЗ [*разг.*] захиалгаар, захиалан, захна хийлгэсэн, аминар хийлгэсэн, зохих, ургах, дүйх таарах.
Костюм на заказ Захна хийлгэсэн хувцас, таарсан хувцас, зохьсон хувцас.

НА ЗАКАТЕ ДНЕЙ [*книжн*] салхинд байгаа зул шиг, насны наран хэлбийсэн үе, насан зүг болсон, эрүү өвдөг нь нийлсэн, хөсөг нь явчихсан, хат нь харьсан, хөг нь өнгөрсөн, хөгшин хүнийн насгүй болсон, энгэр газраа ойртсон, хадан гэртээ ойртсон, нас нь яваад өгсөн, насан туйлд хүрсэн

НА ЗАКЛАНИЕ тахил тавих, ами золих, биеэ зорнулах, биеэ өгөх, зулын гол болох, биеэ золих, биеэ ганд нь хаях.
Идти на заклание [*шутл.*] Биеэ өгөхөөр, хал үзэхээр

НА ЗАКОРКИ (НА ЗАКОРКАХ) [*прост.*] үүрэх, сээрэн дээрээ, зоон дээрээ, ардаа, мөрөн дээрээ, нуруун дээрээ, бөхөн дээрээ, хүзүүн дээрээ, хондлой дээрээ, уцан дээрээ, далан дээрээ, мөрлөх, мөрөвчлөх.
Сесть на закорки гэдэргээ харж хэвтэ-
Нести на закорках Мөрлөн явах, үүрч явах,

НА ЗАКУСКУ [*разг. фам.*] 1. Түрүү зууш, эер дарах юм. 2. [*перен., шутл.*]Сүүлд нь, адаг сүүлд нь, сонирхуулж, одоо нэг, хоол болтол шийр дарууулга. (зугаа)
На закуску расскажу вам один забавный анекдот
За одоо эцэст нь би нэг хошин юм ярьж өгөе дөө.

НА ЗАМЕТКЕ янз төрхий нь мэдэж, зангий нь юу андахав, юу эс андахав.

НА ЗАМЕТКУ ВЗЯТЬ *кого-что* [*разг.*] сайн санаж (тогтоож) ав-, санаандаа санаж ташаандаа зүүж ява-, үтээрч ав-.

НА ЗАМКЕ цээртэй, ойргүй, далд, хориотой, цоорон шиг.

НА ЗАМЕЧАНИЙ *быть- у кого* зэмлүүлэ-, аашлуула-, жавтий хүртэ-, доңго ав-, ванга ав-, загнуула-, хангинуула-, хэцүүрхэ-.

НА ЗАТЫЧКУ түр орлох, түр хамаарах

НА ЗДОРОВЬЕ! эрээлэхгүй (зоогло-) нэрэлхэхгүй (идэж уу) сайн идэж (ууж) ав! Цадталаа идээрэй, эрээ хангаж ав, бор ходоодоо болгож ав! Цохнод бай! (хүндэтгэвэл) Зоогло зоогло! Гоочил гоочил!
Кушайте на здоровье! Сайн идээд байгаарай!

НА ЗДОРОВЬЕ [*разг. фам.*] ханатлаа, тэгвэл тэгэг, хүслээ хангаг, дураараа болог, яамай яамай! таллаараа л, юу сайхан дур сайхан.

НА ЗЛОБУ ДНЯ олны дуулиа болсон, түмний амьн зугаа болсон, хүний хэл ам татагсан нэр цуу болсон.

115. НА ЗУБОК (выучить) [*разг., фам.*] нэгд нэгэнгүй цээжлэ-, шүлэг шиг цээжлэ-, маань шиг цээжлэ-, сайн тогтоож ав-, цээжтэй бол-, цээжтэй, дуржигнатал унши-, амны уншлага болго-,

116. НА ЗУБОК ПОДАРИТЬ (гарсан хүүхдэд) бэлэг өг-, халзан цагаан хонь аваарай гэгч, өндөөр эр болоорой!

117. НА ЗУБОК ПОПАСТЬ *кому* [*разг.*] амьтны элэг бол-, хүний доог бол-, хороо мануула-, амьтны хэл ам угаа-, хүний хэлэл нохойн хуцал бол-, зуун хүний хэлэн дээр зуудаг нохойн шүдэн дээр, хэлтэй болгонд хэлэгдэж, хэ, хэ, ха, ха болгуула-, амны зугаа бол-,

117. а. НА ИГОЛКИ Н-18

118. НА ИЖДИВЕНИИ *чьём* хүний хаяа түших, хүний хүчинд, (хэн нэг хүний) хормойд хоргодох, . . . ний ачаар, . . .-ний ивээлд, . . . ний өршөөлд, (айлын) нөмөрт нь хоргодох, айлын хаяа бараадах, цагаагий нь уух, нөмөр нөөлгөнд нь явах, унжуурга санжуургы нь хүртэх

119. НА ИМЯ *кого* . . . ийн нэрээр, . . . (хүн)-д

Письмо на моё имя Над ирсэн захиа

Купить дом на имя жены Гэргийнхээ нэрээр байшин (гэр) ав-.

120. НА ИСХОДЕ [*книжн.*] . . . шувтрах шахав, ёроолы нь үзэхболлоо, уутаа гөвөх дөхөв, нуруулдчихлаа, даваан дээрээ гарлаа, сүүл мушгих шахлаа. Нохойн дуу ойртох

121. НА КАЖДОМ ШАГУ алхам бүрд, захаас аван замаас үргэлж, газар сайгүй, энд тэндгүй, хаа хаагүй, бишгүй нэг, учиргүй их, зам дагуу, замын турш, явсан газар бүхэнд, тамтаггүй, тоогүй зөндөө, бишгүй г. м.

В этой книге на каждом шагу опечатки Энэ номонд алдаа ташаа гэж бишгүй их байна (бараг хуудас болгонд байна).

122. НА КАЗЁННЫЙ СЧЁТ Сангийн хөрөнгөөр, сан идэж салхи залгиж, түмний буянгаар, хөдсөн дээлтний хөрөнгөөр, хүний юмаар хүүдэгнэх, сангийн юманд сагах,

Проёхаться на казённый счёт Олны хөрөнгөөр орчин зорчин явах.

123. НА КАКОЙ КОНЕЦ [*устар.*] Юуны тул? Яах гэж? хэрхэх гэж? Яана гэж? Яах санаатай? Ямар хэрэгтэй?

124. НА КАКОЙ *кой* **РОЖОН** [*вульг.*] Яах гэж? юугаа хийж, ямар элэнцгээ хийх гэж, үхсэн үлийгээ хийж, үхсэн хатсанаа хийх гэж, балдуушаа хийх гэж

На какой рожон ты звал меня? Ямар элэнцгээ хийх гэж намайг дуудав аа?

125. НА КАЛАЧИ ДОСТАНЕТСЯ *кому* [*ирон.*] махы нь зулгаах юм хунадаа, арьсы нь хуулж байвал таарах, тэгж байх нь таарсан **мөчий чинь санжуудъя даа байз!** Цусы нь шүүрүүлье дээ байз

Хаана чинь загатнаад байна? Эз нь татаад байна уу, уйлах хүүхдийн юу гэгч болсон бий,

126. НА КАРАЧКАХ (НА КАРАЧКИ) [*прост.*] дөрвөн хөллөсөн, дөрвөн хөллөх, дөрвөн мөчөөрөө газар тулаад мөлхөх, мөлхөх.

Ползать на карачках Дөрвөн хөллө-, мөлхө-

Стать на карачки дөрвөн хөллө-

127. НА КОГО ОСТАВИТЬ *кого-что* (хэнийг, юуг) амьтны үзэл болго-, шившгий нь дууда-, муугий нь үзэ-

На кого ты оставил бедную сироту!

Хөөрхий өнчин өрөөсөн амьтныг юунд нь нэг их хүний үзэл болгоов ээ

128. НА КОЗЕ НЕ ПОДЪЕДЕШЬ давдаггүй хоол, нохой хорихгүй, нэмэр байхгүй, барах юм биш.

129. НА КОЙ ДЬЯВОЛ? К-264

130. НА КОЙ ЛЯД? Ямар хэрэгтэй юм бэ? Ямар элэнцгээ хийх юм бэ? Ямар болууцгаа хийх нь бэ? Ямар балтуушаа хийх нь вэ?

131. НА КОЙ ПРАХ (чёрт) [*вульг.*] Ямар хэрэгтэй юм бэ? Ямар элэнцгээ хийх юм бэ? Ямар хар золигоон хийх юм бэ? Ямар үхсэн үйлээ хийх юм бэ? Ч-86

132. НА КОЛЁСАХ 1. Мордож авах, дөрөөгөө дөрөөлөх, унаан дээрээ гарах, хөдлөх, өнхрүүлж эхлэх, хүчээ авах, 2. Сажилж л явна, гэлдэрч л явна.

133. НА КОРНЮ (тариг) ургаагаар нь худалдах, ногооноор нь зарах, газар дээр нь худалдах.

Продать хлеб на корню Тариг ургаагаар нь худалдах

134. НА КОРОТКОЙ (дружеской) НОГЕ НА КОРОТКУЮ (дружескую) НОГУ *быть с кем* [*разг.*] булгивал нэг даагатай, буцлавал нэг тогоотой,, нэг морьтой нэг дээлтэй! Өвөр түрийндээ орж, эжий ахай, үүд хийморгүй, чи би үгүй, танай манайгүй.

Новый сосед мой мне понравился и мы быстро сошлись с ним на короткую ногу. Манайтай шинэ буусан айл надад аятай санагдаж төдөлгүй бид нар ижий ахай болцгоов.

135. НА КОРТОЧКАХ (сидеть) явган суу, оцойн суу-, нохойн суудлаар суу-.

136. НА КОРТОЧКИ (присесть, опуститься стать) Явган суух-, оцойн суух.

137. НА КОСТЯХ махан овоо цусан далай, ясан уул.

138. НА КРАЙ СВЕТА (земли) газрын мухар

139. НА КРАЙНИЙ СЛУЧАЙ Н-55. ямар ч байсан юу чиг болсон г. м утга буй

140. НА КРАЮ БЕЗДНЫ хутганы ирэ дээр, нэг хөл дөрөөнд, нэг хөл шороонд, амь наана там цаана, хоолой дээр хутга.

141. НА КРАЮ ГИБЕЛИ (пропасти) амь сүйрэ-, сүйрэ-, хөөрхий бол-.

142. **НА КРАЮ МОГИЛЫ (НА КРАЮ ГРОБА)** Үхдэгийн даваан дээр, үхэж дүүрэх, эмээл нь гэдсэн дороо орох, гүзээгээ шороодох шахах, захнагаа захих шахсан, захнагаа захидгийн даваан дээр, нүд аньдгийн даваан дээр, мажийдгийн даваан дээр, золтой л цаашаа харчихсангүй, ам мөлтөс амь гарлаа г.м,

143. **НА КРИВОЙ НЕ ОБЪЕДЕШЬ** *кого* [*разг.*] маллаж дөнгөхгүй, амар маллуулахгүй, барин тавин толгойгий нь эргүүлж чадахгүй, авсаар хууртахгүй, санаан зоргоор мэхлэгдэхгүй, хиртэйд давагдахгүй.

144. **НА КРУГ** [*разг.*] барагцаалбаас, тойм нь дунджаар, . . . хирний . . . нэг анзааны,

145. **НА КРЫЛЬЯХ** [*разг.*] хөл нь газар хүрэхгүй, хөл хөнгөрсөн, шуугуулан, эрвэлзтэл, хийморьтой шиг, гулав шалав хийтэл, удаж төдөлгүй, дэвэлзсэн, нисэн алдсан, нисэх нь халаг,

146. **(как) НА КУРЬЕРСКИХ 1.** буухиа шиг, уургын улаагаар яваа юм шиг, шувуу шиг, түймэрт хөөгдсөн юм шиг, зуларсан морь шиг,

147. **НА ЛАД (идти, пойти)** [*разг.*] урагштай, төлөө цөхөөгүй, торч төлбөрөлтгүй, өөрөө бүтэх, үйлстэй, бүтэлтэй, бүтэл сайтай, аяндаан бүтэх, саад тотгоргүй, торох тээглэх юмгүй, санасанчлан бодсончлон, өөсөө бүтэх,

Дело пошло на лад Хэрэг үйлстэй бүтэв.
Вам не о чём беспокойться, все пойдёт на лад
Та санаа зовох юмгүй ээ (зоволтгүй) хамаг юм аяндаа л бүтнэ.

148. **НА ЛБУ НАПИСАНО** [*перен., разг.*] нэр нь нүүрэн дээрээ, харваас ил, үзүүт мэдэгдэм, тэмээнээс тэмдэгтэй, нүүрийг нь үзэхээр андашгүй, зүс харж нэр бүү асуу.

149. **НА ЛЕТУ 1** [*разг.*] Нисүүт, нислэгэнд нь, нисэж явах хооронд нь, 2. Хурдлан, яаравчлан, морин гүйхээр, сандан мэндэн, дав даруй, тэр дороо, хэлсэн даруй, төдхөн, дороо л.

Он перед уходом на лету отдал приказание
Явахынхаа өмнөхөн яаравчлан зарлиг буулгав.

150. **НА ЛИЦЕ НАПИСАН (-а, -о)** Нэр нь нүүрэн дээрээ, харваас ил, үзүүт мэдэгдэм, тэмээнээс тэмдэгтэй, харваас андашгүй, царай нь бэлхнээ хэлээд өгч байна, харах царайнаасаа, нүүрий нь харахад илхэн.

На лице его написана добрата Их ээ буянтай хүн юм байна гэдгийг царай нь бэлхнээ заагаад өгч байна (харваас буянтай хүн.)

Что ты лжёшь, вот ложь у тебя на лице написана
Юунд чи ингэж худлаа дэлсээд байнаа, худлаа чинь нүүрэн дээр чинь ил байна шүү дээ. Хүн мэдэхгүй юм биш. Юунд ингэж залж байдаг юм бэ,

151. **НА ЛИЦО 1.** Өдгөө, байгаа нь, буйдаа, бэлхнээ, 2. Харах царайнаасаа, андашгүй, харваас, үзтэл, хараажийн г. м.

На лицо только пять человек Одоо бэлэн байгаа тавхан хүн байна.

На лицо очень молод Царайгий нь харваас бага хүн байна шүү дээ (андашгүй бага хүн байна).

152. **НА ЛОВЦА И ЗВЕРЬ БЕЖИТ** алуулах ан нь өмнө нь өрөөтэй хэвтэж байдаг хүн, хүссэн юм хүзүүгээр татах, хүссэн юм хөлд ороолдох, санасан газар болсон будаа. Аз нь гозойсон, ганзага сайтай хүн, олз омогтой хүн, ангийн тэнгэртэй, ангийн үүдтэй,

153. **НА ЛОНЕ** *чьем* өвөр дээр нь, алган дээр нь, халуун илчинд нь, нөмөрт нь,

154. **НА ЛОНЕ ПРИРОДЫ** [*разг. шутл*] хээр хөдөөгийн цэнгэлд, эр хүний жаргал эзгүй хээр, урсгалын захад ургамлын дунд, салхинд.

На лоне матери-природы сладко отдохнуть ему от тревог житейских (Слатыков-Щедрин)
Тоост орчлонгийн өвөр бусдыг зовоогч аливаа амьтнаас даажин цөөлж- ижий минь болсон байгалийн ургамлын дунд, усны нь захад сэтгэл тэнийн хөл жийж амар сайхан жаргав.

155. **НА ЛЮДЕЙ ПОСМОТРЕТЬ, СЕБЯ ПОКАЗАТЬ** Үгчил бээс; Олны дотор оръё, хүн ч намайг шинжиг сонжиг, би ч амьтанд үзэгдье. утгачилбаас: Монгол хэлний газар үзэж хүн тань, агтны бийд газар үз, аавын бийд хүн тань гэсэнтэй утга төсөрхүү, хол ойр явж юм үзэж нүд тайл!

156. **НА ЛЮДЯХ** [*разг.*] хүн харахад, хүний өмнө, ойрыг үзэх холыг дуулах, амьтны дэргэд, хүнтэй газар, хүн байхад, олны нүдэн дээр, хүний нүдний өмнө, гэгээн цагаан өдөр, олны дунд, хүний дэргэд, хүн амьтны дунд, олны үзэлд, түмний үзэлд,

Ссоры происходили ежедневно открыто на людях
Өдөр болгон олны нүүрэн дээр хээгээ бараад хэрэлдэж байдаг болов.

На людях они казались счастливой парой Хүн харахад ч бузгай л (чи минь би минь гэсэн) эр эм хоёр байдаг юм.

На людях и смерть красна Танилтай бол талын чинээ, танилгүй бол алгын чинээ

157. **НА МАЗИ** [*прост. разг.*] нэг их зовлонгүй, бүтчих тийшээ хандав, ер нь нуруутай, овоо гоочтой шүү, тэгс хийгээд болов санасныг бодвол, явдлын далимаар хийморьтой, харин ч бас ч

Дело на мази. зорьсон хэрэг ч овоо шүү.

158. **(НИ) НА МАКОВУЮ РОСИНКУ** юу ч, (үгүй) хэд ч (үгүй). ямар нь ч (үгүй) хүний урманд (үгүй)

159. **НА МАЛАНЬИНУ СВАДЬБУ (наготовить, напечь, нажарить, настряпать)** [*прост.*] идээд идээд барахгүйгээр их, барж идэхгүй, уух юм нь нуур далай шиг, идэх юм нь уул овоо шиг, ходоод мэдэхээр, сав мэдэхээр, ходоод байдаг юм бол харин ч нэг байна, гэдэс мэдэхээр, шингээдэг л юм бол зөндөө сав, (чинь) л тэсвэр дурандаа болохоор хороохооргүй, дундаршгүй, барахааргүй г.м.

160. НА МАНЕР *какой* [*прост.*]. . . маягаар . . . янзтай . . . тэгэж ингэж, дүрээр царайгаар

На новый манер Шинэ маягаар

Парк разбит на английский манер Англи маягаар цог-цолсон үүсэгмэл цэцэглэг

161. НА МЕДНЫЕ ДЕНЬГИ [*устар.*] ховор, нүдний гэм, өдрийн од шиг, бага, цөөхөн.

162. НА МЁРТВОЙ ТОЧКЕ үнсэн дээрээ эргэлдсэн, тулгаа тойрсон, нэг л, хэвдээ, эмнэл авахаа байсан, яаж ч гуядсан тоохоо байсан.

163. НА МЕСТЕ байсан газар (нь), байранд, нэг, газар, нэг дороо, мөн дороо, нэг л байрандаа, тэндээ, нөгөө газраа, байсандаа, нөгөө нэг газраа, нэг газраас, байж байсан газраа, байдагтаа, **нөгөөхдөө**, эндээ.

Книга не на месте Ном байсан газраа байхгүй байна. Ном байрандаа алга, ном байсандаа алга, ном тэндээ алга.

Будь я на вашем месте Би таны энэ тушаалд байсан-сан бол, би та бол, би тань шиг байсан бол,

164. НА МЕСТЕ ИЗГОТОВИТЬ (решить) Тэр дор нь хий-, үйлдэ-(шийдэ-, нэг тийш нь болго-), ам ангайсан дээр нь, ямааны мах халуун дээрээ, нялуунаасаа шулуун нь, барин тавин (тэгье) Юу хүлээх юм бэ? хойш нь тавилтгүй, түс тас шийдэ-, энэ суудал дээрээ шийдье! нэг . . . дээрээ . . . тэгье, дор дор нь, яг дор нь.

165. НА МЕСТЕ ПРЕСТУПЛЕНИЯ (поймать, застать) тэр дор нь бари-, гарсан газар дээр нь.

Воры были пойманы на месте преступления Хулгайч юм хулгайлсан газраа баригдав.

166. НА МЕСТЕ ТОПТАТЬСЯ Бахь байдагтаа л, ахиж дөхөхгүй, аргамжаатай юм шиг, нэг л газраа, хэвээрээ л, буурна сахнад л, буурин дээрээ хоцорсон юм шиг, хэвдсээ хивээд л, мэлхий шиг, **чөдөртэй** юм шиг, ургаа чулуу шиг, үстэй чулуу шиг, хошин, хойрго, лазан, бөгс нь бацарсан хорхой шиг, уяатай юм шиг, дэрээ элээсэн, хүнд бөгстэй, зулзгалаад, хүүхдээ хуурайлаад л

167. НА МЕСТЕ УБИТЬ (положить) тэр дор нь ал-, нам цохи-, дор нь хавтгайла-, газартай нь үргэлж болго-, байсан газар нь л муу хий-, тэнд нь цааш нь харуул-, суудал дээр нь ала-, өндийлгөлгүй ала-, нам бууда-, гэрт нь морьтойгоо гэдсэнд нь хутгатайгаа оро-,

168. НА МЕСТО Байдаг газарт нь, очих газарт нь, их г эрт нь, байдгий нь баруун хаяанд, нөгөө газарт нь, байранд нь, оронд нь, гэр оронд нь, байдагт нь, байсанд нь г. м.

Положить на место Байсан газар нь тави- байр байранд нь тави-, байсан байснаар нь болго-,

169. НА МИРУ И СМЕРТЬ КРАСНА Хань бараа олуул бол хялчийж хулчийх юмгүй. Эвлэвэл бүтнэ, ховловол гутна. Эвт шаазгай буга барьдаг, цувж явсан барнаас, цуглаж суусан шаазгай дээр. Эвтэй бол зөвтэй. Эвийн эхэнд тус. Эвийн эцэст тус. Эвд хязгааргүй, эрдэмд оройгүй. Эвтэй бол золтой. Эвтэй олон элэгнээсээ халуун, эв мянган лан,

170. НА МОЁ (твоё и. т. п.) СЧАСТЬЕ К-7

171. НА МОЁЙ (твоёй и. т. п.) УЛИЦЕ ПРАЗДНИК Б-441

172. НА МОЮ (твой, его и. т. п) ДОЛЮ ВЫПАЛО (досталось) Миний хувь л энэ, миний хувь зохиол энэ, миний үйлийн үр дээ, миний лай даа, заяа нь энэ, төрсөн өдрийн төөрөг минь, гарсан өдрийн гариг минь,

173. НА МЯКИНЕ НЕ ПРОВЕДЁШЬ Мэхлэшгүй, хуурах янзгүй, юм хийх гээд санааны гарз, молигодоно ч гэж ярихгүй,

174. НА НЕСЧАСТЬЕ К-8

175. НА НЕТ И СУДА НЕТ 1. Байхгүй бол одоо яана гэхэв, байвал барьчих юмсан даа. Байвал барьдаг л хүн байна даа. Би махнаасаа тасдаж өгөлтэй биш дээ. 2. Мэдэхгүй гэдэг, мянган үгний хариу. Даан ч алга, байхгүй юмыг яах вэ? Байхгүйд аргагүйд, аргагүйд байхгүй л аргагүй, (одоо) хаанаасаа олох вэ?

176. НА НЕТ СОЙТИ [*разг.*] Үгүй хийх, байхгүй болгох, оргүй болгох, бүр хуурайлах, хүчингүй болгох, бодний нь хөтлөх, умаа хум суухайгий нь унших, ор ч үгүй болгох, зий ч үгүй болгох, хогий нь таслах, шавхруу ч үгүй, юу ч үгүй болгох. ор тас болгох, мухарлах, ор бараагүй болгох. үртэс ч үгүй болгох, хүний урманд нэг ч юм үлдээсэнгүй,

177. НА НИТОЧКЕ (висеть) дэн дун дээсэн дөрөөн дээр, хутганы ирэн дээр, амь наана там цаана, (тэгэх)-ийн даваан дээр.

Его жизнь висела на ниточке Дөнгөж голтой л байна (Үхэх сэхэх нь үйлийн үрийн дэнсэн дээр, цаашаа харах наашаа харахыг магадлашгүй байнаа).

178. НА НОГАХ Босоо, өглөө босох, (хэвтэрт оролгүй) босоо шуу салгалах, шүд зуух, тэсвэрлэх,

Все слушали доклад на ногах Босоогоороо илтгэл сонсцгоов.

Я перенёс грипп у на ногах Би ханиадтай л, хэвтэлгүй шүү л гэлдрээд байгаа.

Он перенёс болезнь на ногах Хэвтэрт оролгүй шүү тэсээд л яваад л байна даа.

Чуть свет уж на ногах Уул завсарламагц босов, (бос гэдгийн хүндэтгэлийн үг нь өөдлө-, дээшлэ-), (гэгээ гарав уу үгүй юу л босчихсон байдаг)

179. НА НОГАХ НЕ СТОИТ (не держится) [*разг. перен.*] (өвчнид хатсан, ядарч туйлдсан, согтоох ундаанд хөлчүүрсэн тэргүүтэнд) зогсож чадахгүй хаашаа л бол хаашаан ойчих гээд, олгойтой ус шиг, савж ойчих гээд байгаа, хөл туйвах, сульдах хавтгайгаар байдаг, салгалах,

180. **НА НОЖАХ** *с кем* [*разг.*] үзэж чадахгүй,...их харш, өстэй хонзонтон юм шиг, гал ус хоёр, хонь чоно хоёр, тангараг нь тонгорог, нэг нүдээр үзэхгүй,

181. **НА НОСУ** [*разг*] харнугүй ойртсон, хаяанд тулаад байгаа, хаяанд ороод ирсэн, айл буучихсан, нохойн дуу ойртох, айлын утаа үнэртэх гадаа ирсэн, нохойн дуу ойртсон, өнөө маргаашгүй, хэзээ хэзээгүй, мөн одоохон,

Зима на носу, надо запастись дровами и углём Өвлийн хүйтэн хаяанд ирлээ түлээ түлшээ бэлээгтүн!

182. **НА НОЧЬ** Хоноглохоор, хонох гэж, унтахаар, нойрсох гэж, хэвтэртээ, ушгахынхаа өмнө, дуг хийх гэж, нүдний хор гаргах гэж, сүүжээ амраах гэж,

Остановиться на ночь Хоно-, буу-, шөнийг өнгөрөө-
Устраиваться на ночь Хоноглохоор бола-
Принять лекарство на ночь Хэвтэртээ эм уу-,

183. **НА НОЧЬ ГЛЯДЯ (НА НОЧЬ ГЛЯДЮЧИ)** [*разг.*] хар сүүдэр буухад, шар (цагаан) гэгээ тасрахын үед, харуй бүрийгээр, үдшийн бүрийгээр, хар сүүдэр унахад

184. **НА ОБЕ КОРКИ (драть, сечь)** нойтон голтой, нохой сүүлтэй үлдээ-, арьс махыг нь тасал-, гуврууг гүйтэл нь, цус нөжий нь холи-, нүүр нүдгүй балба-,

185. **НА ОГОНЁК (зайти)** *к кому* [*разг.*] (унтаагүй) галтай (гэгээтэй, дэнтэй) байгаг харж айлд очих, тулгандаа цоггой, тооноор нь гэрэл гялалзах, тооноор нь гал гялалзах.

186. **НА ОДИН ЗУБ** (хоол), балгахан(цай) үмххэн (хоол), хоолны шавхруу тавагны тах, хоосон яс, махны цөв, бөөвны хэлтэрхий

187. **НА ОДИН ПОКРОЙ** өрөөсөн дугуй нь, ижил нь, ихрийн өрөөсөн, ялгарах юмгүй, бие биеэсээ дээрэлхэх юмгүй, ижилдээ ижил

188. **НА ОДНО ЛИЦО** [*разг*] нэг хэвээр хийсэн (цутгасан) юм шиг, ихэр юм шиг, яасан адилхан, юутай адилхан, адилхан гэж даан ч яавваа, өвчөн, ялгах юмгүй, ижил зүстэй, зүгээр нэгээ нэг.

Все дети у них на одно лицо Хүүхэд нь хоорондоо адилхан гэж дааич яавваа.

189. **НА ОДНОЙ НОГЕ** [*прост.*] Салхи шиг, шүр гээд л, яах нийхийн зуур

190. **НА ОДНУ КОЛОДКУ** [*разг.*] нэг хэвийн, нэг загварын, нэг гарын, өрөөсөн (гутал)

Все они по характеру были сделаны на одну колодку (Шолохов Наука ненависти) нэг хэвээр цутгасан юм шиг зангаг нь адилхан

191. **НА ОДНУ СТАТЬ** Ав адилхан, нэг үг, үзээд өгье. гэсэн ч адилхан, нэг боовны хэвээр дарсан, нэг хүний хоёр гутал

192. **НА ОРЁХИ (достаться, попасть, было, будет)** жавгий хүртэ-, зэм дуула-, хосоо ург авахууя-, ширүүн буулга-, сүйд хий-,

Ему досталось на орёхи Мань эр нэг сайн жавгий хүртэв.

193. **НА ОСНОВАНИИ (основе)** *чего*...ийн суурин дээр,...аар суурилан, уллаи, хөллөн-, үндэслэн, үүдэн, хөрөнгөлөн, шав тавьж

194. **НА ОТКРЫТОМ ВОЗДУХЕ** Гадаа, хээр, хөдөө, эрүүл газар, задгай газар, урсгалын захад ургамлын дунд

195. **НА ОТЛЁТЕ** Тэртээ тэнд, зайдуу шиг, алсхан, холхон,

С горы было видна вся деревня и на отлёте-его домик Уулаи дээрээс гацаа юутай хээтэйгээ харагдаж байгаагаас тээр цаана байгаа нь байшин нь шүү.

196. **НА ОТШИБЕ** [*разг.*] 1. Онцгой, ганц нэгээрээ, тасархай, айл хунаргүй. ганц гэр, ганц хот, хар буудал сахисан, 2. Онцгой, жожиг, хажиг, хүнтэй нийлдэггүй, этгээд, мужийн, шилэрсэн нигэ шиг, дошилсон бух шиг, жожиг ямаа шиг, доён, сондгой, саланги, зэйтай

Изба на отшибе Гацаанаас онцгойдоон байгаа ганц модон байшин.
Жить на отшибе Амихнаараа суу-

197. **НА ОЩУПЬ** Илэх, илж таалах, барьж үзэх, тэмтрэх,

Определить опухоль на ощупь (илж) барьж үзээд хандры нь ийм тийм гэж тухайя- гадарла-,

198. **НА ПАМЯТИ** *чьей* [*разг.*] **амьдад нь, амьд байхад нь,** сэрүүн тунгалаг байхад нь, эсэн мэнд байхад нь,

199. **НА ПАМЯТИ ИСТОРИИ** Аль түүхээс авааД, түүхэнд, түүхийн туршид,

200. **НА ПАМЯТЬ** П-287

201. **НА ПАРУ СЛОВ** П-26

202. **НА ПАЯХ** [*разг.*] Мөнгө нийлүүлж, мөнгө гаргацгааж, дундын мөнгөөр, хувь нийлүүлж, мөнгө татаж, мөнгө хуримтлуулж, мөнгө бөөгнүүлж

Устроить вечеринку на паях Мөнгө нийлүүлж үдэшлэг зохио-,

203. **НА ПЕРВОЕ ВРЕМЯ** Эхлээд, түрүүхэндээ, нэг хэсэгтээ, гараан аа, анхандаа, эхэндээ,

204. **НА ПЕРВЫЙ ВЗГЛЯД** 1. Харангуут, анх үзэхэд. эхлээд харахад, хараагүй байж байгаад харахад, нэг хараад л, 2. Өнгөн дээрээ, үзүүт, уулзуут, дайралдмагц, таармагц, тохиолдмогц, үзмэгц, золгомогц, харамагц, учирмагц,

205. **НА ПЕРВЫЙ СЛУЧАЙ** Эхний, эхний удаа, анхных, үзэж л байгаа нь энэ,

206. **НА ПЕРВЫХ ПОРАХ** Хамгийн эхэнд, хамгийн түрүүнд, анхандаа, эхэндээ, анхан түрүүн, эхэлж авааД, юун түрүүн, юуны өмнө, дав дээр, давын өмнө,

207. **НА ПЕРЕЛОМЕ** Их эргэлтийн өмнөх, их уетуул, цаг төрийн үймээнтэй үе. Эз нь татах, ёр нь орох,

208. НА ПЕРЕПУТЬЕ 1. Тооноложин зам дээр, салаа замын уулзарт, замын билчээрт, 2. [*перен*] хаашаа явахаа мэдэхгүй төөрсөн төлөг шиг, ацан шалаанд байх шиг, эрэгцэх, чиг замаа олохгүй, зээр хөөсөн нохой шиг,

209. НА ПИЩЕ СВЯТОГО АНТОНИЯ [*шутл.*] өлөн живэр, гэдэс хонгиноод, гэдэс нуруутайгаа нийлээд, өлөн гэдэс ороолдох шахаад, үнэг, туулай гүйцэх шахаад, өлвөлзөөд, ходоод хоол нэхээд, өлөн элгээрээ, харангадах шахаад, өлберөх шахаад,

210. НА ПЛЕЧАХ *чьих у кого* (тийм ийм хүн) даасан, мэдэж байгаа, толгой дээр байгаа, толгойгоороо даасан, үүрсэн үүрэг,

На его плечах ответсвенность за целый завод Бүхэл үйлдвэрийг (тэр хүн) толгойгоороо дааж байгаа юмаа.

211. НА ПЛЕЧАХ ГОЛОВА ЛЮБА Амь үнэнч (авгай худалч) бие үнэнч, биш нь худалч.

212. НА ПЛЕЧАХ ПРОТИВНИКА [*воен.*] Зугатсан дайсныг сүүл даран нэхэх, мөшгөн хөөх, тавихгүй нэхэх,

213. НА ПОБЕГУШКИ (НА ПОБЕГУШКАХ) [*разг.*] гар хөл, сайхан зарц, үнэгүй зарц, далайвал далд орж даллавал ил гарч, номхон морины ногт догшин морины чөдөр, нохойны мод, юу л бол за, үгнээс гарахгүй тогооны алчуур, өөдөөс нь шонгүй, амнаас нь гардаггүй, бэлэн зарц, боол, боолын боол

Паренёк был у них на побегушках Тэр хар хүү тэдний тогооны алчуур гэсэн үг. (Тэр хүү цаадуулын чинь нэг гар хөл нь байсан юмаа)

Он у жены на побегушках Мань эр эхнэрээ л яа гэвэл бөндөгнөөд л байх нь тэр эхнэрийнхээ амнаас гардаггүй, (Цаадах чинь эхнэрийнхээ гарт орчихсон амьтан юм билээ) Эхнэрээ толгой дээрээ гаргачихсан, эхнэртээ буйдуулчихсан эр,

214. НА ПОБЫВКУ Түр чөлөө авах, нутгийн чөлөөгөөр харих

Приехать домой на побывку Нутгийн чөлөөгөөр (гэртээ), хари-,

215. НА ПОВЕСТКЕ ДНЯ В-215

216. НА ПОВОДУ *у кого* **БЫТЬ** [*разг.*] үгнээс гарахгүй, хүний зөнгөөр, амнаас гарахгүй (хэн нэг хүний) аяар, харцаар, аясаар, үгний зөнгөөр (байх) янзаар, байдлаар,

Он на поводу у жены Эхнэрээсээ мэдэл байхгүй хүн (эхнэрий нь хэлсэн тэнгэрийн зарлиг болсон хүн)

217. НА ПОГОРЕЛОЕ Галын аюулд өртсөн амьтанд тусламж болгож, түймэрдүүлсэн улсад нэмэр хандив болох гэж,

218. НА ПОДБОР 1. Ав адилхан, эгээ нэг, 2. Хамгийн дөмөг, єор нь болсон, чарам хийх, урдаа барьдаг, ганц олигтой, толгой цохидог, дээр нь, илүү нь, давуу нь, дөнгүүр нь, авдаг нь, єайн нь, сайхан нь г. м. К-137

Все яблоки как на подбор Хамгийн дөмөг алим байна. (дөмөгчлөөд авсан юм шиг, олигтой нь энд байна).

219. НА ПОДЕРЖАНИЕ Түр хэрэглэх, барьж байх, барьзнах, **түр** зуур хэрэглэх, оноо зуур хэрэглэх, нэг онсондоо хэрэглэх,...тал хэрэглэх,

220. (да и) НА ПОДИ [*прост., разг.*] 1. Гайхаш тасрах, арга алга, яахы нь бүү мэд, цөхрөнгөө бармаар, яаж ч болмооргүй, ядаж гүйцэх, махлаж гүйцэх, алцагчин балцагчин, ядаж цөхөх, гайхаш алдах, яая даа байз, яамаар юм бэ дээ, мэдэхээ байх, үйл тамаа идэх,

Начал так буянить, что на поди Ингэж түйвээж бужигнуулаад байхаар ч арга ч алга даа.

Ночью пьяный приехал, развоевался так, что на поди (Островский) Шөнө согтуу хүн ирж, агсан согтуу тавиад бүр цөхрөнгий минь барлаа.

221. НА ПОДЪЁМ ЛЁГОК [*разг.*] Удаж төдөхгүй, үзэгдэж харагдахгүй, хөнгөн шаламгай, эв дүй сайтай, шов шув хийсэн, цахилгаан шиг, шавжигнасан, гялалзуулдаг (хүн) хөнгөн шингэн, шалмаг, шуурхай, түргэн, сурмаг, дадмаг.

222. НА ПОДЪЁМ ТЯЖЁЛ [*разг.*] Молхи, талхи, мунгинуу, хормойгоо өшиглөсөн, бүтэж цөхсөн, гараас нь юм гарахгүй, үйлсгүй, хийморь нь үхсэн, лүндаагүй, лүндаа хийморь нь хаясан, гутлаа чирсэн, хормойгоо унжуулсан, бээвийж бээцийсэн, бээрсэн аалз шиг, хөдөлж цөхсөн, хашин хойрго, мөд бүтэхгүй, бүтэл муутай, утилгүй, унхиагүй, золбоогүй, жавхаагүй г. м.

223. НА ПОЗОР (выставить, отдать) *кого что* Муучлуулах, шившгий нь дэлгэх, хөгөөн чирэх, муугий нь үзүүлэх

224. НА ПОКОЕ тэтгэвэр авч суух, гэртээ суух, чөлөө айлтгах

225. НА ПОКОЙ насжаад ажлаас чөлөөтэй байх, тэтгэвэрт суух

226. НА ПОКРОЙ (какой) [*перен. разг.*] ...-лугаа (лүгээ) адил, ... тай ив ижил

На один покрой эгээ нэг адил, ав адил, ихэр юм шиг, ив ижилхэн

227. НА ПОЛДОРОГЕ [*перен.*] замын дунд, душуу, мухарт нь хүрэлгүй, эцэст нь хүрэлгүй, замын хугаст, яагаа ч үгүй байхад, өглөөгүүрээ, тийхнээрээ

228. НА ПОЛНОМ ГАЗУ [*прост.*] дороо л, сум шиг, салхи шиг, гялсхийгээд, гялс гээд, шурхийх, гялсхийх.

229. НА ПОЛНЫЙ ХОД [*разг.*] хар эрчээрээ, байдаг чадлаараа, жолоо сунгасан, үйхээгээр нь, хар хурдаар нь, хар эрчээр нь.

230. НА ПОЛПУТИ БРОСИТЬ (что) остановиться [*перен.*] хагас орхи-, дутуу хая-, больчиха-, байчиха-, алды нь аваад дэлэм дээр нь, атгы нь аваад чимх дээр нь, алсы нь аваад хөтөл дээр нь, хөндийгий нь аваад хөтөл дээр, үхэр алаад ахар сүүлэн дээр нь (хутга хугал-) нохойн дуу дуулдгийнхаа дааван дээр, айлын утаа үнэрлэдгийнхээ дааван дээр, Б-424

231. НА ПОЛСЛОВА [*разг.*] хэдэн үг, тав арван үг, хоёр гурван үг, хэд гурван үг (солих), ганц хоёр үг ярих, хэдэн үгний солио гаргах,

551. НАТРУБИТЬ В УШИ *кому* [*разг.*] чихэнд хонх уя-, чих, нээс нь татаж чангаа-, үглэж улигла-, зогсоо зайгүй үглэ-, хоёр чихэнд нь хонх уя-, чихний үдээр тасал-, чихэнд чийртэй, чих хангинуула-, чих халуу оргиул-.

552. НАТЯНУТЬ НОС *кому* Н—534

553. НАУЧЕННЫЙ ГОРЬКИМ ОПЫТОМ хал үзэж халуун чулуу долоосноороо, хашир хүн гэж хаширсан хүнийг хэлдэг, юү эс үзэхэв, үхэж хошогоо л үзээгүй бусдыг үзсэн, илүү оймс элээсиээрээ.

Наученный горьким опытом я предупреждаю тебя, будь осторожен. Би хал үзэж халуун чулуу долоосны хувьд чамд хэлж байна, чи мэдээтэй болгоомжтой яв.

554. НАХВАТАТЬСЯ ВЕРХОВ [*разг.*] дутуу мэдэж гүйцэд хэлэ-, шар үсний төдий юм мэдэ-, өнгөцхөн мэдэ-, хагас дутуу гадарла-, хальт мөлт, бага сага мэдэ-, үнэрий нь аваад, захад нь хүрээд, бараагий нь хараад, С-465, Х-1

Нахватавшись верхов, он считал себя в этой области большим специалистом. Хальт мульт гадарлаад, энэ мэрэгжлээр өөрийгөө их сүрхий хүн болсон гэж боджээ.

555. НАХОДИТЬ ПОД РУЖЬЁМ Б—532

556. НАХОДИТЬ (пойти) ДОСТУП (дорогу путь) *кого чьему* хөлд нь суу-, гавы нь тааруул-, эвий нь ол-, онилы нь тааруула-,

557. НАХОДИТЬ (пойти) ОБЩИЙ ЯЗЫК учир зүйгээ мэдэлцэ-, бие биеэ ойлго-, харилцан ойлголцо-.

558. НАХОДИТЬСЯ В ФАРВАТЕРЕ *кого-чего буюу чьей* **(политики)** П—201

559. НАХОДИТЬСЯ НА ПОМОЧАХ Б—518

560. НАХОДИТЬСЯ ПОД (большим) ВОПРОСОМ их явдалтай, тун төвөгтэй, их сэжигтэй, яаж ч магадгүй, тун ярвигтай, их маа-паантай, тун жоготой, жого ургаж бол-, их эгзэгтэй, асар яршигтай, их ороолгон, зэгсэн шорвог, горьгүй, нэг л гоохой-той, яггүй хэцүү, таггүй бэрх, барин тавин болохгүй, авсаргүй, басаж болохгүй.

561. НАЧАТЬ ЗА ЗДРАВИЕ, А КОНЧИТЬ ЗА УПОКОЙ анхандаа ам гэж алт, адаг сүүлд нь аль ч үгүй бол-, өглөө хазаа ророй ташуур, хэнхэр цээж, шувтан бөгс, барын толгойсоор эхлээд могойн сүүлээ шувтрав. Сонин дээрээ соохолзоод, сониноо буухаар хоохолзох.

562. НАЧАТЬ С ТОГО, *что* . . . [*разг.*] эхэндээ, анхандаа . . . түрүүндээ . . . сонин дээрээ, шинэхэн дээрээ, өглөөгүүрээ.

563. НАЧАТЬ СВОЁ [*разг.*] өнөөхийгөө улигла-. улиг болсон, бахи байдаг, аанай л өнөө, бас дахиад л, гозойгоод л байж гэнэ

гозойгоод л байж гэнэ гэдэг шиг, домогтоо улигла-, нэг ярьснаа арван гурав дахи-, нэг ярьсиза нэг зуун долоо дахин, далан долоо дахин).

564. НАЧИНАЯ С АДАМА [*разг.*] хүн гэдэг амьтан гарсан тэр цагаас аваад, хоёр хөлтэй хохимой толгойтой амьтан байдаг болсноос хойш, алтайг алгын чинээ, дэлхийг дээврийн чинээ байхад, бөөрөнхий толгойтой бөгсөөрөө суусан хүн гэдэг амьтан бий болсон цагаас,

565. НАШ БРАТ . . . [*разг, фам.перен.*] Бид, маны мэтийн, мань мэтийн.

Наш брат рабочий . . . Бид ажилчид . . .

Наш брат не боится трудностей. Бид бэрхийг бэрх гэж бэрхшээхгүй (манайхан ер нь буцахгүй шүү).

566. НАША (ваша, их, моя, его, её) ВЗЯЛА! [*разг.фам*] Бид нар түрүүлэв, манайх хожив, манайхан дийлэв (үзүүлэв), манайх магнай цохив. Бид шүүв , . . . манай болов.

567. НАША СЕСТРА . . . [*разг. перен. фам.*] бид нар (эм хүн), мань мэт, маны мэт

568. НАШЕ (ваше, моё, твоё, его) СЧАСТЬЕ, *что* . . . Бид (та би, та нар, чи . . .) их азтай, аз нь гозойсон, аз нь шовойсон, бидний аз болоход, аз дайрч, золоор, хиймортой, хиймор лүндаатай өнгөтэй,

Ваше счастье, что вы приехали во-время. Таны аз шовойсон юм байна. Чухам л болдог цагтаа ирлээ (Та нар их морьтой яваа улс байна даа. Та нарын морь сайн давхиж байна).

569. НАШЕ ВАМ С КИСТОЧКОЙ [*прост.*] амры чинь эрж, хамры чинь чимхэе! За, жигтэйхэн л сайхан байна уу!

470. НАШЕГО (одного *буюу* своего) ПОЛЯ ЯГОДА [*разг.*] ив ижил зантай, нэг гэрийн хүүхэд шиг, нэг дошны мөндөл, нэг боовны хэвээр дарсан юм шиг, (эгч дүү, нэг хэвийн) улс биш бол доо та нар! Манай хүүхэд биш болдоо чи! Эгээ нэг ааштай, эрхний буурцаг шиг, ихэрлэж төрсөн юм шиг г.м.

571. НАШЕГО ПОЛКУ ПРИБЫЛО маны мэтийн амьтад ч бишгүйдээ юм, ийм хүн байхдаа л нэг байх юм, газар оронд миний өрөөсөн байж байх.

572. НАШЁЛ ДУРАКА! Ийм тэнэг амьтан гэж байх гэж! Тэнэг гэхэд ингэж тэнэглэх гэж! Мөн ч усан толгойтой амьтан аа. Өвс идэж ус уудаг адгуусныас долоон дор.

573. НАШЛА КОСА НА КАМЕНЬ эрийн эр, заныг унагаж заан болох гэгчээр, эрийн дээр эр, дээрэмчинд луйварчин таарав гэгч төмөр шиг байвал хуурай шиг, шөвөг гаргавал хутга гаргана гэгч,

574. НАШЛО (найдём, находит) ЗАТМЕНИЕ *на кого* [*разг. перен.*] гэнэтхэн мангартах, толгой эргэж орхих, аль ч учраа олохгүй болов. Толгойд элс чихчихсэн юм шиг болов.

575. НАЩУПЫВАТЬ (нащупать, прощупывать, прощупать) ПОЧВУ учры нь олж хужры нь тунгаах (эртхэн шиг).

576. **НЕ АХТИ КАК (НЕ АХТИ КАКОЙ)** нэг их гойдгүй, захаас аваи замаас үргэлж, ээ яасаи сайхан юм ч гэмээргүй, сүрхий ч үгүй, хүн шагшаад ч баймгүй барагтайхан, бөзаалтай биш, их нүдтэй биш, нэг их гийгүүлэх юмгүй, дуу алдахаар ч юм биш, байдаг л нэг, жирийн нэг,

Он поёт не ахти как. Нэг их гойд ч дуулдаггүй юм шүү (Гийгүүлээд байх ч юм алга л билээ).

Не ахти какой товар. Барагтайхан бараа байна даа (их нүдтэй бараа биш).

577. **НЕ АХТИ СКОЛЬКО** хэдсээд байх юмгүй, барагтайхан цөөхөн

578. **НЕ БЕДА** [*разг.*] Сүйд болсон юм алга! Гайгүй гайгүй! Бүү сандар! Бүү зов! Зоволтгүй, тайвшир, тайвшир! Тайвширч үз! Битгий доцогно! Бүү тэвд! Аминаас хол юм гайгүй! Амь наана там цаана болсон юм алга!

579. **НЕ БЕЗ** *чего* (тийм) үгүй ч биш, ортой нь ортой, оргүй ч биш, бас ч яахав, оргүйд орвол ор.

Доклад слушали не без интереса. Илтгэл ч бас сонир холгүй бишээ (юу юугүй хүн уйдаачихмаар ч үгүй).

580. **НЕ БЕЗ ОСНОВАНИЯ** Иш үндэсгүй ч биш, ортой нь ортой, бас нэг учир бий. Шалгай суух овоотой нь овоотой, арай хоосон биш, оргүйг бодвол ортой, юу ч үгүй бишээ.

581. **НЕ БЕЗ ТОГО** [*разг.*] тийм байхаа, үгүй гэхэд хэцүү, ортой байхаа, тэхээс зайлахгүй, тэх тал нь дийлэх байх.

582. **НЕ БЕРЁТ** [*разг.*] Юм болохгүй, гавихгүй, гийгүүлэхгүй, базаалтай биш.

583. **НЕ БЛИЖНИЙ СВЕТ** [*прост.*] дэмий (тийм) их ойргүй, бас их гадаа биш, хаяанд биш, овоо хол, хөөрхөн зайтай, чамгүй зайтай, нохойн дуу арай дуулдахгүй, зэгсэн зайтай, нилээн шогшуулна.

До города не ближний свет, пожалуй, часа два, три ходьбы. Хот ортол бас хөөрхөн зайтай, хоёр гурван цаг явах байлгүй (Хот ортол бас мундахгүй зайтай шүү, магад хоёр гурван цаг явна).

584. **НЕ БОГ ВЕСТЬ (знает) КАК** гойд биш, гавиагүй, гийгүүлэх юмгүй, барагтайхан, тааруу нэг,

585. **НЕ БОГ ВЕСТЬ (знает) КАКОЙ** гойд юмгүй, гайхуулаад байх юмгүй, их нэртэй зартай юм биш, зүгээр л нэг бор бүдүүн, байдаг л нэг, нэг их бузгай ч үгүй, хүнээс илүү юмгүй ихийг бодвол бага, эхээс гарсныг бодвол их гэдэг шиг.

586. **НЕ БОГ ВЕСТЬ (знает) СКОЛЬКО** нэг их олонгүй, даан их олонгүй, төдий л олонгүй, өдүй, төдүй, гэх юмгүй ээ, хуруу дараад тоолчихоор, уг тоо нь ч гайгүй шүү (л дээ), газар авах юм биш, төгөлдөх юмгүй, олныг бодвол цөөн, цөөнийг бодвол хэд.

587. **НЕ БОГ ВЕСТЬ ЧТО** сүйд болох юмгүй, чухал биш.

588. **НЕ БОГИ ГОРШКИ ОБЖИГАЮТ** зоривол бүтнэ, явбал хүрнэ, санаж явбал бүтнэ, сажилж явбал хүрнэ, явсан нохой яс

зүүдаг, би явж байна, бээжин сууж байна гэдэг шиг, ээлэн хичээвэл заяа хичээнэ, байчихалгүй, бараа тасарчихалгүй.

589. **НЕ БОЙСЯ УБЫТКА, ТАК ПРИДУТ И БАРЫШИ** Эр хүн зоригтой бол чоно чацга алдана, зодохгүй бол юм сурахгүй, зовохгүй бол зоос авахгүй, зорихоо айвал зорьсондоо хүрэхгүй, бэрх зовлонг тэсэж чадвал хатуужил, бэрх үйлийг бүтээж чадвал хүчит.

590. **НЕ БОЛЕЕ** олонгүй, илүүгүй, хэтрэхгүй.

591. **НЕ БОЛЕЕ И НЕ МЕНЕЕ, КАК . . .** яг, чухам, илүү ч үгүй, дутуу ч үгүй, олон ч биш цөөн ч биш, ёстой л нэг чухам тааруухан ихийг бодвол бага, эхээс гарсныг бодвол их, дунд бааз,

Это не более и не менее, как угроза. Энэ ч ёстой л нэг сүр далайлгаж байгаа хэрэг ээ.

592. **НЕ БОЛЬШАЯ (велика) ХИТРОСТЬ** ухаан (арга) ороогүй, заль зохногоод байх юмгүй. Н-628

593. **НЕ БРАТЬ КАПЛИ В РОТ** [*разг.*] архи амсдаггүй, архи сархад урууддаа ч хүргэдэггүй, үнэрлэдэг ч гүй, архинд хавьтдаггүй, уувал хор амссан шаазгай л гэсэн үг.

594. **НЕ БРАТЬ В РОТ** *чего* (тийм нйм) идддэггүй, уудаггүй, амсдаггүй, идэж үзэлгүй өдүй хүрэн, хэл ч хүргэж үзээгүй, үгүй ээ үгүй, амты нь ч авааггүй, үнэрий нь ч авааггүй.

595. **НЕ БРЕЗГАТЬ НИЧЁМ** [*неодобр.*] яахаас ч сийхгүй, айх ичихээ мэдэхгүй, хамаа намаагүй зэгна-, жолоо цулбуургүй аашла-, нүд чичгүй авирла-, яахаасаа ч буцахгүй.

Он не брезгает ничем для достижения цели. Санасандаа хүрэх гэхээрээ цаадах чинь яахаасаа ч буцахгүй амьтан шүү.

596. **НЕ БУДЬ ДУРАК** [*прост.*] ухаанд оро-, санаанд багта-, яахаа мэдэ-,

597. **НЕ БУДЬ ЛАПОТНИКА НЕ БЫЛО БЫ БАРХАТНИКА** зовохгүй бол жаргахгүй, зовиур нь өмнөө, жаргал нь хойноо, зовлон үзэхгүйгээр жаргал олдохгүй, багадаа зовбол өтөлсөн хойноо жаргана, эрхийг сурахаар бэрхийг сур! Хөдөлбөл хөлс, зогсвол зоос, хөлөө явж хөлсөө идэх, борви бохисхийлгүй хөдөлбөл бор ходоод хоолтой гэж мэд! Хүсэл хясал хоёр нь зовлон жаргал хоёр,

598. **НЕ БЫВАТЬ** *чему* хэрхэвч тэгүүлээгүй! Тэгнээ бас удна! Тэгэж таарахгүй, тэгнэ гэж юу гэсэн үг вэ?

599. **НЕ БЫЛО БЫ СЧАСТЬЯ, ДА НЕСЧАСТЬЕ ПОМОГЛО** сохорсон бии завшив, эвдсэн бии ягиив, аяи шалтаг сайн юм болжээ.

600. **НЕ БЫЛО ЗАБОТЫ!** [*разг.*] гай болох гэж! Хар төвөг боллоо! Ээ бас золиг боллоо! Ингэнэ гэж хэн мэдэхэв дээ! Ээ чаваас аа! Ээ халаг минь! Гай болохоор зай бол гэгч боллоо.

601. **НЕ БЫЛО НИ ГРОША, ДА ВДРУГ АЛТЫН** зовсон хүн жаргах, золбин нохой зоолох, гэнэт баяжив, тэрүүхэн хоо-

ронд юмжив. Үүлэн чөлөөний наран шиг, эрдэнэ олсон юм шиг, лусын сан талсан юм шиг тэнгэрээс хишиг хайрлав уу гэмээр, бөөн олз орох, гэрт нь хүн орж ирэх гээд шүргаж унасан юм болов уу, тогоон дахь ходоод нь хагарсан юм бол уу, хоног нь баасан юм болов уу.

602. **НЕ БЫЛО ПЕЧАЛИ** даан ч тусгүй хэрэг! Аа яа яа! Хэрэг алга! Завхарсан юм зүгээр, дүүрчээ дүүрч, гайгүй тэгэж л байг!

603. **НЕ БЫЛО СЛУЧАЯ, ЧТО БЫ** . . . үнэнээсээ . . . гүй, угаасаа тэгэж байгаагүй, огт тэгдэггүй, тэгэж үзээгүй, хүн болж хүзүү толгой залгасаар . . . гүй, хардаг тал байдаг юм бол . . . гүй, төр нүдтэй юм бол . . . гүй, хүний урманд . . . гүй, хүн болсоор . . . гүй, мэдээ орсоор . . . гүй, бааш байдаггүй, . . .

Не было случая, что бы он опоздал на собрание. Хуралд ер нь хожимдож үзээгүй (хуралд огт хожимдож яваагүй л хүн дээ). Хүний урманд хурлаас хоздож яваагүй хүн.

604. **НЕ В БРОВЬ, А В ГЛАЗ** нүдий нь онох, голы нь олох, суд сыг нь атгах, мэнгэн дунд нь буулгах, оньчий нь олох, эгзгий нь олох, гоохойгий нь олох, шар мах анддаггүй шар зурхайч шиг, ганц болж, тэгмээр байсан юм, халдан барин хар халзандаа, банданд төдийгүй байнд, болгож тавих.

605. **НЕ В ДУХАХ** [*прост. шутл.*] Хай яа! Ай, яасан муу байна.

606. **НЕ В ДУХЕ** саная зовиуртай, сэтгэлийн зовлон эдэлж,

607. **НЕ В КОНЯ КОРИ** нохойн хоол шиг юм, угаадас шиг юм, ер идсэн болохгүй, хүний ам руу зүглүүлэмгүй хоол, хүн идэж нохой шинших эд биш, хэлэхэд амар хийхэд хэцүү, бодоход амар болгоход хэцүү, амлахад амар ачир дээрээ хэцүү, ярвигтай, яршигтай, ороолгон, сачий хүрэхгүй.

608. **НЕ В ЛАДУ (ладах)** 1. *с кем* найр тарах, хөөргөө хагалах, түнжин хагарах, 2. *с чем* эврэх, харгах, эв муутай, хамар муруйдаг, гар нийлдэггүй, саная нийлдэггүй,

609. **НЕ В ЛУКОШКЕ КАТАТЬСЯ** [*прост.*] хурууны үзүүрээр дөнгөчих юм биш, амар ажил биш, барин тавин хийлтгүй, босон суун гүйцэх хэрэг биш, зөөлөн хоол биш, хэн хүний дуны юм биш, дуртай нь . . . гүй.

610. **НЕ В МЕРУ** хэмжээ хэтрэн, дэндүү, дэгстэй, давс нь ихэдсэн, ахдуу, давруу даваадуулах, цаашлуулах, давуулах.

611. **НЕ В ОБИДУ БУДЬ СКАЗАНО** энүүнд гайхах юмгүй, энэ хэлснийг битгий юманд бодоорой. Муу санаж хэлээгүй юм шүү. Хор (хар) сануузай! Атга авуузай! Юм сануузай!

612. **НЕ В ПАМЯТЬ** ухаанд нь ухна үхсэн юм чинь ер байдаггүй шүү, идчихжээ, санаанд ордоггүй ээ, ой тойнд үгүй шүү.

613. **НЕ В ПЕРВОЙ** нэг л ингэж байгаа биш, анх ингэж байгаа биш, гэм биш зан, ганц энэ биш, одоо л ингэж байгаа биш, мэдэхгүй юм биш, аль хэзээний, зэгчихсэн юм.

614. **НЕ В ПОМОШЬ** *кому* [*разг.*] огт нэмэргүй, дааны тусгүй, ухаан хүрэхгүй дуур нэмэргүй, могой алахад модны нэмэргүй

эсгий хийсэн газар хүүхэд нохой хэрэггүй, идэхийн нэмэр айхын бараа, салхинд унгас нэмэргүй.

615. **НЕ В ПРИМЕР** жишиггүй, цэцлэлгүй, үлгэргүй, хосгүй, ижилгүй, ганцаараа.

616. **НЕ В ПРИМЕТУ** *кому* [*прост.*] үл мэдэгдэх, учир нь олдохгүй, учры нь олохгүй, мэдэх аргагүй, үзэгдэж харагдахгүй,

617. **НЕ В РАДОСТЬ** *кому* хөөрч хөгжих юмгүй, инээж ханиах юмгүй, магнай тэнэгэргүй, хөмсөг доошоо.

618. **НЕ В СВОЕЙ ТАРЕЛКЕ** *быть* [*разг.*] сэтгэл тогтворгүй, сэтгэл санаа дэнслээд, дотор жигтэйхэн, сэтгэл тогтохгүй оргиод, хоол хоолойгоор давахгүй. Б-525

619. **НЕ В СВОЁМ УМЕ** *быть* өөрийн ухаангүй (юм шиг), галзуу юм шиг л, ухаан орж гараад л, галзуурахад ганц хуруу дутуу, галзуурах шахаад л, ухаанд нь ухна үхсэн, ухаан нь ширгэсэн, тархи нь ширгэсэн,

620. **НЕ В СЕБЕ** [*разг.*] сэтгэл тогтохгүй, зүрх түгшээд, сэтгэл түвшингүй, санаа амрахгүй, сэтгэл доноголзоод, өрх дэвээд л сэтгэл сэвээд л гэдэг шиг.

621. **НЕ В СЛУЖБУ, А В ДРУЖБУ** [*разг.*] Албаар биш амиар, таниын халуун нүүрээр, арын хаалгаар, хувьсгалын биш хувь учраараа,

622. **НЕ В СЧЁТ** [*разг.*] бодоод яахав, санаад санааны гарз, огт хайхрахгүй байвал таарна, юманд бодохгүй байвал дээр.

623. **НЕ В СЧЁТ АБОНЕМЕНТА** [*разг.*] этгээд, жич гойдын, онцын өөр, онцгой, шал ондоо, шал анги, төсгүй, дүйцэхгүй.

624. **НЕ В ШУТКУ** тоглоом биш шүү, инээдэм наадам биш, үнэнээсээ шүү, наадамгүй, тоглоомгүй, тоглоом тохуу биш, нээрээ шүү, наадаагүй шүү, тоглоогүй шүү.

625. **НЕ ВАШЕГО (твоего, моего, и. т. д.) УМА ДЕЛО** [*разг.*] Тан шиг нь давдаггүй даваа, барж идэхгүй, холтлошгүй хэрэг ээ! шон хүрэхгүй, нохой хорихгүй, таны мэддэг дангийн жаа биш, санасаар яваад сарьслана.

626. **НЕ ВЕЛИКА БЕДА** В-508

627. **НЕ ВЕЛИКА ВАЖНОСТЬ** гойд биш, чухал биш, юу ч биш

628. **НЕ ВЕЛИКА ХИТРОСТЬ** Н-592

629. **НЕ ВЕРИТЬ НИ В СОН, НИ В ПОХ** юунд ч итгэдэггүй, эр хүнд байтугай эрхий хуруундаа ч итгэдэггүй.

630. **НЕ ВЕРИТЬ (поверить) СВОИМ УШАМ (глазам)** чихэндээ (нүдэндээ) итгэхгүй, зөв дуулсан болов уу! Зүүд биш байгаа, санаа дагаагүй байгаа, сэтгэл дагасан байлгүй, тийм л болтугай.

Неужели это правда? Прямо-таки своим ушам не верю! Үнэн гэж үү? Би ер нь чихэндээ итгэхгүй байна.

Я как увидел это, своим глазам не поверил. Би хараад (нүдэндээ) итгэхгүй байлаа.

631. **НЕ ВЕСТЬ** Б-45

632. **НЕ ВЗВИДЕТЬ СВЕТА** [*разг.*] (өвдөх, цохих, айх зэргээс) дотор харанхуйла-, дотор пал хий-, дотор хачин боя-, нүд харанхуйла-, манас гээд л, явчи-, оройны үс бос-, дуу нь гарахгүй бол-, бие нь зарсхий-, үнхэлцэг нь хагарах шаха-,

633. **НЕ ВЗДУМАЙ (-те)** . . . [*разг.*] Бүү сана! санахын ч хэрэггүй! Бодох ч хэрэггүй! Санаад санаад санааны гарз! Санахын халзгай, мартсан нь дээр, горьдолтгүй, саналтгүй, бодолтгүй.

Не вздумай здесь курить. Энд тамхи татна гэж бүү сана!

634. **НЕ ВЗИРАЯ** *на что* [*книжн.*] хэдийвээр . . . боловч, . . . ч гэсэн, . . . ийг харгалзахгүй, . . . ийг юманд бодохгүй.

Не взирая ни на какие трудности. Ямар ч хэцүү байсан (хэдүйвээр бэрх хатуу боловч).

635. **НЕ ВЗИРАЯ НА ЛИЦА** нүүр тал харахгүй, танил гэж бодох гүй, тал тохой харалгүй, нэр нүүр бодохгүй, нүүрчлэхгүй, дотуурчлахгүй, дотночлохгүй.

636. **НЕ ВЗЛЮБИТЬ** *кого-что* [*разг.*] дургүй, үзэж ядаж, хорсон занаж, нүд нь хорсон, нүд үзүүрлэн, нэг нүдээр үзэхгүй, жигшин, зүхэн.

637. **НЕ ВЗЫЩИ (-те)** [*прост.*] Битгий юм бодоорой, битгий муу юм санаарай, битгий гомдоорой, битгий иймээ тиймээ юм бодоорой, өшвүүзэй (өшүүзэй), гомдуузай, яая гэх вэ!

Постараюсь, но если не удастся, не взыщите. Хичээе хичээе, хэрэв заяа эс бүтвэл битгий юм санаарай. **Очень простой обед не взыщите!** Барагтайхан хоол болж дээ, битгий юм бодоорой.

638. **НЕ ВИДАТЬ (не видеть) В ГЛАЗА** [*разг.*] өөрөө үзээгүй, нүдээрээ үзээгүй, нүүр тулж үзээгүй.

639. **НЕ ВИДАТЬ (не видеть) КАК СВОИХ УШЕЙ** К-210.

640. **НЕ ВИДЕЛИСЬ ЦЕЛУЮ ВЕЧНОСТЬ** [*разг.*] Ойрд уулзсангүй, хаанахын хүн хаанаас гараад ирэв ээ, үзэгдэж харагдахгүй яагаав ээ, ойр наанад дайралдсангүй дээ, яасан сонин хүн бэ, газар дороос гараад ирэв үү, өнөөдөр чинь хэдэн билээ? Би зүүдлээгүй байгаа даа. Чи мөн гэж үү?

641. **НЕ ВИДЕТЬ ДАЛЬШЕ СВОЕГО НОСА.** [*разг.*] **(собственного)** газар ширтсэн гахай шиг, худгийн мэлхий шиг, холын хараагүй, богинохон бодолтой, маргаашийг хардаггүй, ухаан муу, олгой цухал, харалган,

642. **НЕ ВИДЕТЬ (не видать) СВЕТА (белого)** амар заяагаа үзэхгүй, нажидаа эдэл-

643. **НЕ ВИДНО НИ ЗГИ** [*разг*] **(ЗГИ НЕ ВИДАТЬ)** хав харанхуй, юу ч үзэгдэхгүй, түнэр харанхуй, нүх шиг (харанхуй).

644. **НЕ ВО ГНЕВ БУДЬ СКАЗАНО** *кому* битгий уурлаарай, уурлаад яахав.

645. **НЕ ВОЗЛЮБИТЬ** Н-636.

646. **НЕ ВРЕДНО** ...(тэгэхэд) яахав, үгүй яахав дээ, бололгүйдээ, муу нь юу байх вэ! тэгснийг гэж гэж юу байх вэ?

647. **НЕ ВСЕ ДОМА** у *кого* [*разг., фам.*] толгойд (нь) нэг жаахан жиг бий байх, ухаан нь баахан явдалтай байх, эргүүвтэр юм уу даа, донгио ч юм шиг, хаашаа ч ухаантай хүн юм дээ, зүв зүгээр л арай биш, хольцоотой хүн, ороотой гараатай, зүүлэгцэр, дүүнгэдүү, ээдэй буудай, орон гаран,

648. **НЕ ВСЕ КОТУ МАСЛЕНИЦА, БУДЕТ И ВЕЛИКИЙ ПОСТ** юм нэгээрээ байдаггүй (дуусдаггүй), мандсаны эцэст мөхдөг, өндрийн эцэст буурдаг, жаргалын хойно зовлон, ээлж эргэж ээзгий ааруул хатдаг, баян нэг шуурганд, баатар нэг суманд, баян гэгч мөнх биш, зэрц гэгч зэяа биш, цаг цагаараа, уул нурж мэднэ, ууланд битгий итгэ, ус ширгэж мэднэ, усанд битгий итгэ (М. Цэдэндорж). Эзний алба ээлжтэй, хааны алба халаатай, хорвоо гэдэг чинь хоормог шиг эргэлдэж хошного шиг чихэлдэж байдаг юм.

649. **НЕ ВСЁ ТО ЗОЛОТО, ЧТО БЛЕСТИТ** үгчилбээс: гялалзсан бүхэн алт биш, утгачилбаас: өнгөнд бүү хуурт, өрөнд бүү баригд, «гоо үзэмж гэдэг мунхаг тархины халхавч болдог нь цөөнгүй бөгөөд үнэт сайхан шаахай өмссөн хөл ямар цэвэр тэвэр явдгийг бас л мэдүүштэй» (С. Эрднээ «Малын хөлийн тоос» Н—86). Саруул тал байвч шавры нь, сайхан амраг байвч санаагий нь, сүрий нь шилэхээр бяры нь шил! («Алтаар бичсэн цуурхал үгийг эрх чөлөө гэж бид хэлэхгүй» Д. Пүрэвдорж, Н—15).

650. **НЕ ВСЁ ЦЕПЛЯЙ, ЧТО МИМО ПЛЫВЁТ** авахдаа алд гартай битгий бай! Шунал ихэдвэл шулам болдог, [*бран.*] Савааг үй нохой саранд хуцах, авахдаа аралба өгөхдөө өрөлбө; хүнээс их болох гэвэл долоо дорддог, гэнэт баяжвал насанд цөв, гэнэт цадвал гэдсэнд цөв.

651. **НЕ ВСПОМНЮ!** санахгүй байна, таг мартчихжээ, мэдэхгүй ээ, идчихжээ, хоолтойгоо зэлгичихжээ, бүү мэд, хэн мэдэх вэ, худлаа хэлэх юм алга, юусан билээ, юу тэр вэ, юу юм бол доо, цээжинд юм алга.

652. **НЕ ВСЯКОЕ ЛЫКО В СТРОКУ** Юм бүхэнд битгий гуйж түүж яв! Эзэн хичээвэл заяа хичээнэ! Хормой давсэхээр хойчийгоо бод! Гуйх гутамшиг, гуйлгах гайхамшиг, айлаас эрэхээр авдраа уудал.

653. **НЕ ВЫДАЙ (НЕ ВЫДАЙТЕ!)** Амь авар! Амь наана там цаана! Нааш нааш! Хүүеэ та минь ээ! Яадаг билээ!

654. **НЕ ВЫДЕРЖИВАЕТ КРИТИКИ** шүүмжлэл даахгүй, (хатуу) үг даахгүй, хэлснийг даахгүй, болсон юм нэг ч үгүй, шал хэрэггүй, биеэ өмөөрдөг, хир халдаадаггүй.

655. **НЕ ВЫДУМАЙ** *что делать* [*разг., фам.*] Битгий тэг! Байг! Боль боль! Санах ч хэрэггүй.

656. **НЕ ВЫДУМЫВАЙ!** [*разг.*] битгий тэгэж сана! санах ч хэрэггүй, санаад санааны гарз, битгий дэмий ярь!

Не выдумывай, сиди дома! Битгий тэгэж бод (Дэ-

мий юм бүү бод) гэрийнхээ мухрыг сахиж бай! (Битгий дэмийр дуугүй сууж бай).

657. **НЕ ВЫНОСИТЬ** *кого-чего* огт дургүй, харахаас дургүй хүрдэг, их зэвүүцдэг, харахаас нүд загатнадаг (хорсдог), үзэн яддаг, зэвүүрхэ-,

Не выношу кошек. Би мий харахаас дургүй хүрдэг (Мий бас зэвүүн шүү).

Она не выносит его. (тэр хүүхэн, тэр эрэгтэйг) үзэн яддаг.

658. **НЕ ВЫПРОСИШЬ СНЕГА СРЕДЬ ЗИМЫ** *у кого* [*разг.*] гартахаа алдахгүй, нарийндаа хатсан, лонхонд унгаад нохойдоо зайлж өгөх, гар нь татсан, хүний гар дээш нь харуулж үзээгүй, хорголоо хатаасан, хүнд гар сунгаж үзээгүй, шинж нь харласан, шинийн нэгэнд баншгүй, эвэр гартай, хорголоо тоолсон, хүний гар цайлгаж үзээгүй, харамчийн хар тулам, бирд шиг.

659. **НЕ ВЫПУСКАТЬ ИЗ СВОЕГО ВЗГЛЯДА** хараа салгахгүй, ширтэн хара-, хасад хийлгэхгүй харуулда-,

660. **НЕ ВЫРУБИТЬ ТОПОРОМ** *что, чего* горьдлогогүй, горьдоод горьдсоны гарз, гараас нь юм салгалтгүй, салгаж чадахгүй, хагацуулна гэж ярих юм биш.

661. **НЕ ВЫУЧИТ ШКОЛА, ВЫУЧИТ ОХОТА** үгчилбээс: Сургууль хүнийг сургадаг биш, дур нь хүнийг сургадаг, утгачилбаас: юм сурна гэдэг бол сурдаг хүнээсээ л болдог гэсэн үг, монгол хэлний эзэн хичээвэл заяа хичээнэ гэсэнтэй ойролцоо санаа. Дургүй ламд дарж байж сахил хүртээдэггүй, олон жил үзсэнээрээ биш оролдлого хичээлээрээ сурдаг.

662. **НЕ ВЫХОДИТ** (выйдет) **ИЗ ГОЛОВЫ** (из ума, из памяти) [*разг.*] сэтгэлээс гарахгүй, санаанаас гарахгүй, ямагт бодогдох, бодогдоод болохгүй, бодохгүй гэхнээ бодогдох, мартагдахгүй, дотор төв, толгойд яг, өдрийн бодол шөнийн зүүд, сэтгэлд хоногшсон. Н-726

663. **НЕ ВЫШЕЛ** *чем* [*разг.*] ганц гэм нь, өө нь гэвэл, өөлөх өө юү байна гэвэл, өөлье гэсэн хүнд, өө эрвэл,

Он был очень красив, только ростом не вышел. Тун цэвэрхэн эр байсан юм, өө нь гэвэл нуруу багахантай билээ (эр хүн шиг эр, өө эрвэл намхан л юм).

Лицом не вышел. Гэм нь царай муутайхан билээ.

664. **НЕ ВЫШЛИ ГОДЫ (НЕ ВЫЙТИ ГОДАМИ)** нас нь болоогүй, насандаа хүрээгүй, нас бага, нас болоогүй, эр цээлээгүй, биед хүрээгүй.

665. **НЕ ВЫШЛО!** бүтсэнгүй, болсонгүй, эс бүтэв, байдаггүй ээ!

666. **НЕ ГЛЯДЕЛ БЫ НА СВЕТ (божий)** [*разг.*] Үхмээр санагдав, аминаасаа уйдав, амьд яваад яахав гэж бодогдов, бушуу далд орох юмсан, түргэн шиг хоёр нүд аних юмсан, намайг авах болоогүй юм бол уу, сайхан сайхан амьтад яваад л байх юм, оронд нь явах юмсан, хорвоог үзэхээрээ боллоо!

667. **НЕ ГОВОРИ (не говорите)** ярангүй, ярих юу байх вэ, хэлэлцээнгүй.

668. **НЕ ГОВОРЯ УЖЕ** *о ком-чем* Хэлээд яахав! Яриад юу хийх вэ! Бүү хэл!

669. **НЕ ГОВОРЯ ХУДОГО (дурного) СЛОВА** [*разг., шутл.*] 1. Хар цагаан дуугүй, үг дуу ч үгүй, дув дуугүй, амаа үдүүлчихсэн юм шиг, дуу шуу ч үгүй. 2. Зүгээр байснаа гэнэт, гэв гэнэт.

670. **НЕ ГОДИТСЯ** [*разг.*] болохгүй, таарахгүй, буруу, дэмий шүү, явуургүй, явцгүй, бүтэлгүй, шал дэмий, илүү ажил,

Так поступать не годится. Ингэж хийж болохгүй (Ингэж байж таарахгүй шүү).

671. **НЕ ГОРИТ!** [*разг.*] Бүү сандар! Битгий тэвдэ! Битгий бачимда! Тавир! Тайвшир! Бүү доцогно! Бүү өндөгнө!

672. **НЕ ГРЕХ** *кому* [*разг.*] (тэгэхэд) гэмгүй, чингэхэд юуны буруу байх вэ! Болохгүй нь юу байх вэ! Нүгэл л болохгүй, яана гэж дээ, давгүй биз, дажгүй биз!

Теперь не грех и отдохнуть! Одоо амрахад гэмгүй биздээ!

673. **НЕ ДАВАТЬ** битгий (тэгүүл, нигүүл, чингүүл)

Не давайте запугать себя! Битгий цочиолго!

674. **НЕ ДАВАТЬ (дать) В ОБИДУ** *кого-что* маллуулахгүй, хуурташгүй харж хандаж бай-, өмөг түшиг бол-, үзэж хара-,

675. **НЕ ДАВАТЬ ПРОХОДА** *кому* П-1188.

676. **НЕ ДАВАТЬ СЕБЕ ТРУДА (сделать что)** Биеэ зовоохгүй, биеэ царж, биеэ оторлож, биеэ нөө-, амиа хоохойл-, гар хумхи-, аминдаа арчтай, биеэ хайрла-,

677. **НЕ ДАВАТЬ СПУСКА (спуску)** *кому* зүгээр орхихгүй, толгой илээгүй, өршөөхгүй, уучлахгүй.

Он строгий начальник, провинностям спуску не даёт. Сүрхий чанга дарга шүү. Гэм хийхэд зүгээр орхино ч гэж үгүй дээ.

Кто её обидит, она спуску не даёт. Доромжилсон хүнд ч мөчөөгөө өгдөггүй бүсгүй дээ (Хүнд элэг бариулахгүй эм (хүн).

678. **НЕ ДАВАТЬ** (не дать) **ХОДУ** *кому* саад бол-, чангаа-

679. **НЕ ДАВАТЬ** (не дать) **ШАГУ СДЕЛАТЬ (ступить)** *кому* хааш нь ч гишгүүлэхгүй, огт хөдөлгөхгүй, зад бариад бай-,

680. **НЕ ДАВАТЬСЯ (недаться) ПОД ЛАД** санаа таарахгүй, эвцэхгүй, нийлдэггүй.

681. **НЕ ДАВАЯ (себе)ОТЧЁТА** мэдэлгүй, санаандгүй, өөрөө мэдэлгүй, тэгнэ чинээ саналгүй, санамсаргүй.

682. **НЕ ДАВШИ СЛОВА, КРЕПИСЬ, А ДАВШИ СЛОВО, ДЕРЖИСЬ** за гэвэл ёогүй, үг алдвал барьж болдоггүй, хэлснээ хийж хэрчсэнээ ид, хэлсэн үгэндээ эзэн болж, идсэн хоолондоо сав болж яв! Хэлбэл хийгүй, хийвэл өөгүй бай! Айвал бүү

хий, хийвэл бүү ай! Эр хүн хэлсэндээ чоно зуусандаа; эр хүн хэлсэндээ эс хүрвэл эм шинжийг олдог, эр морь харайсандаа эс хүрвэл гүү шинжийг олдог; үхэж хэвтэж нэр хугарахаар, үзэж алдаж яс хугар.

683. **НЕ ДАЙ БОГ! (ИЗБАВИ БОГ)** [*разг.*] болохоо байлаа, сүйд болох нь, муу юм болох нь ээ, битгий л . . . аасай! . . . х вий дээ бурхан минь! Н-845

Не дай бог, разразится война. Дайн болбол ч баларлаа шүү (Бүү үзэгд дайн л битгий болоосой).

684. **НЕ ДАЙ ГОСПОДИ** бүү үзэгд, битгий тэгээсэй.

685. **НЕ ДАЛЕЕ** ...аас хэтрээгүй (давахгүй, илүүгүй), хэтрээгүй, зайлахгүй, гарахгүй.

До села не далее двух километров. Тосгон хүртэл хоёр мод газраас хэтрэхгүй,

Не далее как месяц тому назад. (нэг) сар (гуч хоног) -аас хэтрэхгүй, өмнө.

686. **НЕ ДАТЬ И ПОНЮХАТЬ** [*разг.*] хүн хавьтуулахгүй, хүн халгаахгүй, хүн ойртуулахгүй, үзвэл үнс болно, харвал хальс болно гэгчээр өөх бол хайлна гэж, өндөг бол хагарна гэж, огт хир халдаахгүй.

687. **НЕ ДАТЬ ПРОХОДУ** *кому чем* [*разг.*] амар заяа үзүүлэхгүй, тав алдуулах, тух алдуулах.

688. **НЕ ДАЮТ СПАТЬ ЛАВРЫ** *чье кому* [*ирон.*] атаа жөтөө нь буцал-, мөчөөрхө-, илүү үзэ-, атаарха-, хордо-.

689. **НЕ ДЕЛО** Тэгж болохгүй, тэгдэг юм бишээ,

690. **НЕ ДЕТЕЙ КРЕСТИТЬ** сүж болоогүй, сүйд майд болоогүй, сүрхий жигтэй болоогүй.

691. **НЕ ДЛЯ ЧЕГО** [*разг.*] хэрэггүй, дэмий, юугаа хийхэв, яахав, үлийгээ хийх вэ.

Не для чего спешить. Яараад юугаа хийх вэ, яараад яахав, яарах юу байхав, юугий нь яарахав, юундаа яарах вэ.

692. **НЕ ДО** *кого-чего кому* тийм зав хаа байх вэ, тэгэж байх завгүй, тэгэхтэй мантай, юу завтай юм, юун сөгөөтэй юм, юун гөгөөтэй юм, ... нь бүү хэл..., ... х нь байтугай...

Он так занят, что ему не до прогулок. Ажил ихтэй юм чинь зугаалахтай мантай.

Мне сейчас не до этого. Би одоо энүүгээр оролдож байх зав хаа байх вэ (Үүгээр оролдохтой мантай).

693. **НЕ ДО ЖИРУ, БЫТЬ БЫ ЖИВУ** эрүүл л байвал тарганы хэрэг юу байх вэ. Өвчингүй л байвал өөхлөхгүй нь хамаа юу.

694. **НЕ ДО СМЕХУ(СМЕХА)** *кому* инээхтэй мантай, инээж хаинаж байх зав хаа байх вэ, тэгэж марзганаж байх юм хаа байсан.

695. **НЕ ДОЕДАТЬ КУСКА** [*разг.*] хоол ундаа сааж, ундаа цөөлж, идшээ багасгаж, бага гэдсээ баглаж, их гэдсээ эвхэж, гэдсээ сойж, гэдсээ татаж, хагсрааж.

696. **НЕ ДОЛГО ДУМАЯ** [*разг.*] Шув шулуун, бөдөж санаж юмгүй, түгдрэхгүй, хэзээ яазаны юм шиг, бэлэн зэлэн, хүн зааж өгөөд байгаа юм шиг, шүлэг шиг, барин танин.

697. **НЕ ДОЛЖНО БЫТЬ МЕСТА** *чему* тэгэж болохгүй, тэгэх ёсгүй. Н-1023

698. **НЕ ДОРОГО ВОЗЬМЁТ** хэрэгтүй, нэмэргүй, ашиггүй, санахын гарз, явдлын нэмэр.

699. **НЕ ДУМАТЬ, НЕ ГАДАТЬ** [*разг.*] зүүд зөнд ороогүй байтал, тэгнэ гэж бодоогүй байтал, ингэнэ гэж хэн санах вэ, санамсаргүй, гэнэ сэнэгүй.

700. **НЕ ДУРАК** [*шутл.*] хувна тавихгүй, эр бар, тэгэх ингэхдээ сурамгай, хүнээр заалгахгүй, уургын морь шиг, тэгэхдээ гарамгай, муу ч үгүй, хүний дор оролгүй, хүнээс хоцрохгүй, хүнээс гуйхгүй, хувна хүнд өгөхгүй, хувиа борлуулна, өөртөө зөв.

Выпить не дурак. Сархад зооглохдоо ч хувна тавихгүй.

701. **НЕ ЖИЛЕЦ НА ЗЕМЛЕ (на белом свете)** [*разг.*] нас богинотой, олон жил амьд явахгүй, мөд үхэх, урт наслахгүй, богино заиатай, хоногоо хүлээсэн, хэзээ л бол доо.

Было ясно, что он-чахоточный и не жилец на земле. (Горький. В людях. гл. 16). Уушигны өвчтэй, харваас нас богинотой амьтан байна даа.

702. **НЕ ЖНУТ, НЕ СЕЮТ, А КОРМЯТСЯ** бэлэн хоол зооглочингууд, гар нь хөдлөхгүй ам нь хөдөлдөг улс, мал гэвэл уравгас гээд, мах гэвэл малгас гээд байдаг улс, ажил гэвэл алмайрчихаад, хоол гэвэл хомхойроод суудаг хүмүүс.

Д. Пүрэвдоржийн түүвэр «Орлогч хүн» 46-р нүүр.

— Нэгэн зүйлийн амьтай юм бий.

В. Инжанаш. «Инжанаш» 24-р нүүр

— Амьд яваа нь өөртөө л хэрэгтэй юм байх даа хөөрхий.

М. Цэдэндорж. «Есөн хүсэл» 63-р нүүр

— Өөрийнхөө тархинд байгаа хог новшийг бусдын сав руу чихэх гэдэг ярьнигтай хүмүүс.

С. Эрднээ «Малын хөлийн тоос» 119-р нүүр

— Идэх нь идэр, явах нь ядар

— Идэх нь гахай, явах нь могой

— Ууж идэхдээ уургын морь, урагшаа гишгэхдээ ургаа хад

— Мал гэхээр хөмсөг нь мах гэхээр магнай нь

— Ажил гэвэл ухарсхийнэ, зажил гэвэл ухасхийнэ

— Хотон доторхи бөөрөнхий цагаан юм юу вэ гэгч үлэ

— Ангайж идэж алцайж унтагч

— Идэхийн нэмэр байхын бараа

— Унтарсан галд уриагүй амьтад

703. **НЕ ЗА ГОРАМИ** *что* [*разг.*] гадаа ороод ирлээ, хаяанд ирлээ, харнугүй туллаа (шахлаа), өнөө маргаашгүй боллоо ай

буулаа, айсүй явна. «Өглөө үдэшгүй боллоо (Инжанаш, «Хөх сударэ»). юу юугүй туллаа. Н-238, 703, У-5

704. НЕ ЗА СТРАХ, А ЗА СОВЕСТЬ сайхан сэтгэлийн угаас, сэвгүй сэтгэлийн угаас, айснаасаа биш ариун санаанаасаа, зүйр-сандаа биш зөв санасандаа, үнэн голоосоо, үнэнээсээ, нөхөр журмын хувиар, хорын албаар биш, халуун сэтгэлээр,

К общей благости работой не за страх, а за совесть. (Маяковский). Олгой тэжээхийн тулдхан биш олныхоо тусын хэрэгт, чинхүү сэтгэлийн угаас зүтгэх нь зүй.

705. НЕ ЗАБЫТЬ СЕБЯ [*разг.*] амиа хичээ-, хувиа бодо-, хар амиа л, өрөөл мөртэй өрөөсөн засаалтай, амиа хоохойл-, амиа аргацаа-, хувиа хичээ-, би үхэхээр чи үхэ-! цустай хутга түрийл-, хувиа борлуулж довоо шарлуул-, аминдаа хайртай, аминдаа арчтай, өөрөө л болж байвал бусад хамаагүй, дотуур тамиртай.

706. НЕ ЗАВИДУЮ *кому* [*разг.*] дааны хөөрхийлөлтэй, өрөвдмөөр, элэг эмтэрмээр, най нь тачисан, аргаа барсан, харахаас нүд хальтрам, хайрлахаас элэг эмтрэм, үзэхээс өр өвдөм, зүүдлэхээс зүрх шимшрэм, нүднээс гарсан гм.

707. НЕ ЗАМАЙ Битгий хөдлөг, битгий хүр, хол бай, битгий гар хүр, битгий оролд, битгий ойрт, битгий хавьт, битгий дөх!

708. НЕ ЗАМЕДЛИТЬ нэн даруй, удалгүй, шалавхан, хойшлуулалгүй, саарууллалгүй, одоохон, үтэр түргэн, бушуу түргэн, цаг алдалгүй, цаг нөхцөөлгүй, мөн одоо, удаж төдөлгүй, мөдхөн,

Я не замедлю сообщить. Би одоохон мэдэгдэе.
Прошу не замедлить с ответом. Даруйхан хариу хайрлаарай.

709. НЕ ЗАНИМАТЬ СТАТЬ [*разг.*] Бишгүй элбэг, юу л байна вэ тэр юм л байна, тэр юмнаас бишид юмгүй, оргилсон, бадарсан, ... аар өтөх, ...аар бөөстөх, бишгүй нэг, бишгүйдээ, хаяягүй, газар сайгүй, захаас аван замаас үргэлж, хөлнөөр хөглөрч байна, (бараан захад) цаг элбэг болж цаасан хэдийг өгөх вэ гэдэг шиг, ус цас шиг, өвс хулс шиг.

710. НЕ ЗАСТАВИТЬ ЖДАТЬ СЕБЯ аяндаа болно, аяндаа бүтнэ, болох нь лав, эрхбиш тэгнэ, сууж байтал бүтнэ, явдал суудалгүй бүтнэ, явдал чирэгдэлгүй болно.

711. НЕ ЗАСТАВИТЬ ПРОСИТЬ СЕБЯ гуйж гувшуулахгүй, юу л бол юу, уриалагхан, уургын морь шиг жа жа гээд л, зөөлөн чихтэй, үг авамтгай, үгэнд оромтгой, хүний амаар, хүний зөнгөөр, хөнгөн шингэн, ташуур хөдөлгөлтгүй, хазаар даран, бурантаг дугтралтгүй.

712. НЕ ЗАСТАВИТЬ СЕБЯ ДОЛГО ЖДАТЬ [*разг.*] цохоо төлөөгүй, урилга дуудлага оролгүй, тэгс хийгээд л, унь тунь гүй, унирхах тунирхах юмгүй, гуйлга түүлэггүй.

713. НЕ ЗАСТАТЬ В ЖИВЫХ *кого* (хүн үхэж) байхгүй бол-, талийгаач бол-, уулзаж чадаагүй, ам мөлтөс, аль язуур, зэгчихсэн хойно, өнгөрсөн хойно.

Придя к ним, мы тетушку в живых уже не застали (Чехов, **Прекрасной должно иметь пределы**). Манийг ирэхэд авга эгч хэдийн талийгаач болсон байв (байхгүй болсон байв).

714. НЕ ЗНАЛА БАБА ГОРЯ, КУПИЛА БАБА ПОРОСЯ өөртөө булуу хураав, хар толгойдоо лай чирэв, даахгүй нохой булуу хураав гэгч, гэм нь урдаа гэмшил нь хойноо болох, угруугаа ус хийх, өөрийн хийсэн нь өөрт нь, өөд нь хаясан чулуу толгой дээр гэгч болох, хийхийн өмнө цэцэн, хийсэн хойноо гэмтэн, өөрөө унасан хүүхэд уйлдагүй гэгч болох.

715. НЕ ЗНАТЬ КУДА ДЕВАТЬ ГЛАЗА (руки, ноги, себя и т. п.) яах учраа мэдэхгүй, сандан мэндэн, хөл малгайгүй, мэдэхгүй, тулгуурлахгүй.

716. НЕ ЗНАТЬ НАД СОБОЙ *кого-чего* эх захгүй, захиргаагүй, цадиггүй, дурааараа, задгай зайдан, барьц алдах, зазгада-, замаа алдсан, хэлбэл миний дур, хийсвэл тэнгэрийн дур, намайг хэн хэлж нохойг хэн саах вэ гэгчдээ тулсан, ихийг их гэдэггүй, багыг бага гэдэггүй.

Не знал над собой никакого начальства. Ямар ч юманд захирагдаггүй.

717. НЕ ЗНАТЬ НИ А, НИ Б амандаа А-гүй, алгандаа падгүй, А үсгийн дүрс мэдэхгүй, арвын хир тоо мэдэхгүй, номгүй хар гөрөөчин гэгч шиг, умаа-хум амьтан, нэрээ ч тавьж чадахгүй, төгрөгний тоо ч мэдэхгүй, насаа ч мэдэхгүй, жилээ ч мэдэхгүй, ном харвал эрээн цоохор, ална гээд бичсэн ч инээж байх, аврана гээд бичсэн ч уйлж байх, ном өнгийвөл хот руу жоодгой өнгийсөн адил...

718. (не знать) С КАКИМИ ГЛАЗАМИ ПОЯВИТЬСЯ (показаться) Яахаа мэдэхгүй, байж байх учраа олохгүй, бүлтэгнэн, гөлөлзөн.

719. НЕ ЗНАТЬ СНОСУ С—618.

720. НЕ ЗНАТЬ СЧЁТА *чему* 1. тоогүй, өдүй төдүй, түг түмэн үй түмэн. 2. Барин тавин бүрэлгэх, байгаагаар нь үрэн таран хийдэг, шороон түм, бум түм, түмэн түмэн, тэнгэрийн од шиг, одноос олон, ой мод шиг, улаан шоргоолж шиг, өвс хулс шиг, хар хятад шиг, хар ялаа шиг, захаас аван замаас үргэлж, тоо томшгүй, хумхийн тоос шиг.

721. НЕ ЗНАТЬ УДЕРЖУ *с чём* учир ёс мэдэхгүй, юмны наана цааныг бодохгүй, салан палан, учир начиргүй, хоёр үгний утга мэдэхгүй, хоймсон дээсний эрч эрхээхгүй, гурван үгний утга тайлахгүй, гурамсан дээсний эрч тайлахгүй, тэнэсэн сум шиг г. м.

722. НЕ ИГОЛКА 2. Хоёрын хооронд юм биш, лүдийн зай шиг юм биш, дориун, 2. Анзааралгүй орхих аргагүй, харалгүй болохгүй.

723. **НЕ ИДЁТ (не пойдет) В ГОЛОВУ** ... ийн сөгөө алга, ... ийн янз алга, ... ээс дургүй хүрээд байна.

724. **НЕ ИДЕТ НА УМ** *кому*. огт дургүй, гуйсан ч хүсэхгүй, дур орохгүй, санаанд багтахгүй Н-833

725. **НЕ ИДТИ (не пойти) ДАЛЬШЕ (далее)** *чего* илүү дутуу юмгүй, ...ээр цэглэ-, ... ээр дуусгар болго-,... ээр шувтра-,

726. **НЕ ИДТИ С УМА (из ума)** Н-662.

727. **НЕ ИЗ ПОСЛЕДНИХ** [*разг.*] жаал зугаа мэдэлтэй, үсэн эвэртэй, надаас дээр, мэдэхээ мэддэг, хийх гэснээ хийдэг, аврах таврахтайгаа, өршөөх өлөхтэйгөө, шагнах шийтгэхтэйгээ, шан, хортойгоо.

728. **НЕ ИЗ ТОЙ ОПЕРЫ И**—156.

729. **НЕ ИЗ ТУЧИ ГРОМ Г**—217, 218

730. **НЕ ИМЕЙ ДРУГА ПОТАТЧИКА, А ИМЕЙ ДРУГА НОПЕРЕЧНИКА** нялуунаас шулуун дээр, чихэр үгтнээс чигч явдалтан дээр

731. **НЕ ИМЕЙ СТО РУБЛЕЙ, А ИМЕЙ СТО ДРУЗЕЙ** танилтай бол талын чинээ танилгүй бол алгын чинээ, зуун төгрөгтэй явснаас зуун нөхөртэй яв, зуун адуутай явснаас зургаан нөхөртэй яв, олонтой бол баянтай.

732. **НЕ ИНАЧЕ КАК** ... ... аас зайлахгүй, гарцаагүй, лав, зайлах замгүй, гарах гарцаагүй, зайлбаргүй, дүрээрээ, яг, мөнөөс зайлахгүй, дамжиггүй,

Не иначе как он это сказал. Тэр хүн хэлсэн нь гарцаагүй,

733. **НЕ ИДТИ В СРАВНЕНИЕ** *с кем, чем* жишишгүй, зүйрлэх юм биш, газар тэнгэр хоёр шиг, гал ус хоёр шиг, хар цагаан хоёр шиг, бурхан чөтгөр хоёр шиг, цус сүү (ус сүү) хоёр шиг, Н-765

734. **НЕ К ДОБРУ** [*разг.*] сайн ёр биш, өлзий бүсын юм, тун базаахгүй юм болох нь дээ, муу ёр, өлзийгүй, эз татах, хонго нь хорсох.

735. **НЕ К МЕСТУ** [*прост.*] зохихгүй, таарахгүй, дүйхгүй, нийцэхгүй, нийлэхгүй, хавьтахгүй.

736. **НЕ К НОЧИ БУДЬ СКАЗАНО** Шөнө муу юм бүү ярь! Унтахаас өмнө зүүдэнд ормоор юм бүү ярь! Унтахад ус хэрэггүй гэгчээр оронд ороод олон юм бүү донгос! Дэр дэрлээд дэмий юм бүү ярь! Орондоо бохь битгий зажил! Орондоо бүү иснэр г. м.,

737. **НЕ К СПЕХУ** яарах юмгүй, яаралтгүй, сандрах юмгүй, юманд хөөгдсөн юм шиг юундаа яарах вэ, яарах юу байх вэ, юунд нь тэвдэх вэ, агадаад яах вэ, юунд нь агадаж мэгдэх вэ, хүн бушуул гээд байгаа биш. Н-740

738. **НЕ К ШУБЕ РУКАВ**]*прост.*] яах ийхээ мэдэхгүй, учир начры нь олохгүй, энэ тэрийг мэдэхгүй, наануу цаануур мэдэхгүй.

739. **НЕ КАЗАТЬ ГЛАЗ (носу)** [*разг.*] үзэгдэхээ бай-, бараа нь харагдахгүй бол-, шагайхгүй, хавьтахгүй, ширээд, зугтаад сураггүй, хэл улгүй, нүдний гэм бол-, долөөд, зугтаад,

Он теперь сюда не кажет носу. Манай энүүгээр шагайхаа байсан.

Не смеет казать глаз. (ирж) үзэгдэхээсээ хулчийж байгаа.

740. **НЕ КАПЛЕТ** [*разг.*] Н-737.

741. **НЕ КАРТОШКИ** [*шутл.*] тоглоомгүй, нээрэн шүү.

742. **НЕ КЛАДИ ПЛОХО, НЕ ВВОДИ ВОРА В ГРЕХ** юмаа хямгадахгүй байж хүнийг (хулгайчлйг) нүгэлд унагах, (юмны) эзний муугаас болж хөөрхий хулгайч хилэнц үйлдэх, цусгүй алах, хий хардаж хэрэг тарих, худлаа хардаж гай тарих, алдсан хүн арван тамтай, авсан нь нэг тамтай гэгч, улаан чулуур мах гэж залгих, цагаан чулуур өөх гэж залгих, цусгүй алдаг цөсгүй нөхөр.

743. **НЕ КЛАНЯТЬСЯ** *с кем* хэн нэг хүнтэй нөхөрлөхгүй бол-, ирж очихоо бай-, бие биендээ шагайхгүй бол-, хамар муруй,

744. **НЕ КО ВРЕМЕНИ** цагаа олоогүй, улирал бусын цагт, муу хүний үхэл бямбад гэгч, ганц цагаа олж дээ!

745. **НЕ КО ДВОРУ** [*разг.*] Таарахгүй, санаанд нийцэхгүй, хүний таалалд нийлэхгүй, амьтан таашаахгүй, амьдралд ад, адуунд чоно, хүний нүдэнд өргөс.

746. **НЕ КОМПАНИЯ** *кому* хань болж чадахгүй, нөхөрлөж чадахгүй, энд нь хүрэхгүй, ... тэй ч сүйд болдоггүй.

747. **НЕ КОРМЯ (ехать)** морио (хэд) хазуулах ч чөлөөгүй (яв-), дөрөө мултлах чөлөөгүй, чөдөрнөөс салгахгүй, тоорцог нь толгойтойгоо наалдаад эдгэрчихсэн, тохом нь нуруутайгаа барилдаад эдгэчихсэн, амны нь завааныг ч гаргах завгүй.

748. **НЕ ЛАДНО СКРОЕН, ДА КРЕПКО СШИТ** [*прост.*] хийц муутай ч гэсэн бөх, үлгэр муу ч гэсэн үдээс сайтай, царай муутай ч гэсэн чийрэг биетэй, ангайж байхаар умайж бай! царай муутай чанар сайтай, үзэхэд үрчгэр ч үйлэнд сайн, харахад харчгар ч хайр булаасан, дорой төрсөн ч хирээ мэддэг.

749. **НЕ ЛЕЖИТ СЕРДЦЕ** *к кому-чему* [*разг.*] санаанд таарахгүй, таалалд нийлэхгүй, сэтгэлд нийцэхгүй.

750. **НЕ ЛЕЗЕТ В ГЛОТКУ (в горло, в рот)** [*прост.*] хоолойгоор орохгүй, хоёр чихнээс хойш өнгөрөхгүй (гарахгүй), доошоо орохгүй, өөдтэй айлын нохой ч тоож идэхгүй, амнаас уначих гэсэн, давсгүй гийдаа шиг, огнудас хүрэм, бөөлжис хутгам, ой гутам, угаадас шиг, үнэг тоож шиншлэхгүй, үхэр тоож долөөхгүй г. м.

751. **НЕ ЛЕЗЕТ ЗА СЛОВОМ В КАРМАН** [*разг., фам.*] хэлэмгий, шаламгай, ухаа нь хурдан гүйдэг, хэлэхийг хэлж чаддаг, хэл ам нь ус цас шиг, цэцэн цэлмэг, таван амтай, амтай хэлтэй,

хэлтэй амтай, аманцар, бэлэн үгтэй, бэлэн зэлэн, ус цас шиг, цэцэн уг цээжинд нь, хүн хүргэдэггүй, сайн заргач.

752. НЕ ЛИХА БЕДА Зовлонгүй, зовох юмгүй, юу нь хэцүү байх вэ! ухаан ороод байх юм алга.

753. НЕ ЛИШЁННЫЙ (не лишён) *чего* гооч нь барагдаагүй, арай ч нэрмээс болчоогүй, арай ч най нь тачиагүй, эрхбиш ... тэй, тэр нь тасраагүй, таг болчоогүй, яагаа ч үгүй, тийхнээ-рээ, бас ч хог дээр хаях болоогүй, хэрэглэхгүй байж болох-гүй, бага ч болов.

Событие, не лишённое известного значения. Эрх биш ач холбогдолтой явдал.

754. НЕ ЛИШНЕ (не лишнее) тэгэхэд яах вэ, чингэхэд болох-хуйц.

755. НЕ ЛЫКОМ ШИТЫ мануухай биш, дээлийн гол биш, нүхтэй мах биш, чивтэй чуганц биш.

Мы тоже не лыком шиты. Бид нар ч малгай өмссөн мануухай биш шүү.

756. НЕ МЕСТО (здесь, там) 1. *кому* (энд) тэгдэг газар биш, ингэдэг газар биш, тэгэж болохгүй, ингэж болохгүй, хол очиж тэг, дуртай бол тэр хамар дээр гараад тэг, ... юмны орон юм уу? ... байдаг үүр юм уу?

Здесь не место разговорам (говорить) о делах. Энд алба ярьдаг газар биш.

757. НЕ МЕСТО КРАСИТ ЧЕЛОВЕКА, А ЧЕЛОВЕК МЕСТО хүн ширээний хүчинд биш, ширээ нь хүний хүчинд; ширээ нь хүний чимэг бус хүн нь ширээний чимэг. Хүн сайн бол ши-рээ шүтээн болохгүй, суудал тань таны нүүр тахлах юм биш, та суудал да нүүрийн буянтай болгох учиртай.

758. НЕ МЕШАЙ (-те) бүү саад хий, битгий үймүүл, яавал яаг, тэгвэл тэгэг, өөрөө мэдэг, зүгээр харж бай! зөнд нь орхи! гай болохоор зай бол!

759. НЕ МЕШАЕТ (НЕ МЕШАЛО БЫ) *кому.* [*разг.*] (тэгэхэд) зүгээр, (тэгэхэд) яах вэ (тэгвэл) дээр, (ингэвэл) дээр дээ, (ингэнэ чинээ) байгаа, тэгүүштэй юм шиг байна, (тэгэхэд, ингэхэд гэмгүй,

Сюда не мешает прибавить перцу. Жаахан халуун юм (ногоо) нэмчихэд зүгээр.

С дороги не мешает отдохнуть. Аянаас буцаж ирээд амрахад гэмгүй шүү.

Вам не мешало бы обратиться к врачу. Та эмчид үзүүлэхэд ер нь зүгээр юм даа.

Не мешает быть осторожным. Болгоомжтойхон явбал дээр байхаа.

760. НЕ МОГУ ЗНАТЬ (НЕ МОЖЕМ ЗНАТЬ) айлтгаж мэдэхгүй байна даа, сонордуулж чадахгүй нь ээ, дуулгаж амжихгүй байна.

761. НЕ МОГУ (не можешь и. т. д.) ПОХВАСТАТЬСЯ *кем-чем* [*разг.*] гавих юмгүй, гойд биш, онцгүй, сүрхий ч үгүй, гийгсэн юмгүй, сайн гэх юмгүй, юугий нь ч магтах вэ дээ, яах вэ дээ л нэг, нэг л ... гүй, нэг л тиймхэн, базаахгүй, сулбуухан, сулхан, сул, үлбэгэр, сулбагар.

Не могу похвастаться здоровьем (Миний бие ч ба-ртай л нэг байна даа). Бие минь нэг л жалхгүй

762. НЕ МОДЕЛЬ [*прост.*] ингэдэггүй, ийм биш, энэ таарахгүй.

Это не модель так поступать! Ингэж хийдэг юм биш шүү (Барил нь нэг л биш дээ)

763. НЕ МОЕ (твое, его, ее, наше, ваше, их) ДЕЛО Над ха-маагүй (падгүй, холбогдолгүй).

764. НЕ МОЕГО (твоего, его, нашего и. т. д.) УМА ДЕЛО [*разг.*] Би (чи, та, тэр хүн... г. м.) бардгүй (давахгүй) ажил, миний ухаан хүрэхгүй хэрэг, би нохой хорихгүй, над шиг нь шоу хүрэхгүй, над мэт нь таваглахгүй, би зэрэг нь холтлохгүй ааруул байна. Над ахдаа, би хэнздэнэ, над шиг нь дэмий, над шиг нь саналтгүй, над ахлуу юм.

765. НЕ МОЖЕТ ИДТИ НИ В КАКОЕ СРАВНЕНИЕ (в сравне-ние) *с кем чем* Н-733

766. НЕ МОЖЕТ СВЯЗАТЬ И ДВУХ СЛОВ [*разг.*] (хэн нэгэн хүн сэтгэд хөдөлсөн зэргээс болж) үгээ хойно урд нь оруулж яри-, пүл пал гэж, хэл нь ороолдо-, ээрч ээдрэ-, үгээ ч хэлж чадахгүй, (хэлэх) үгээ олохгүй.

767. НЕ МОРГНУТЬ (не моргнув) ГЛАЗОМ [*разг.*]Яах ийхийн хооронд, тэрүүхэн хооронд, тэр чигээрээ, ум хумгүй, ганц үсрээд,

768. НЕ МОЧЬ (не силах, нельзя) ОТОРВАТЬ ГЛАЗ ... ээс нүд салгахгүй нь, харж ханашгүй, харж хана-,

769. НЕ МУДРЕНО, *что* .. мэдээжийн хэрэг, бодолтгүй, бодоо-жийн байна шүү дээ, хэний ч бодоожийн, бодвоос ил, (тэгэх нь) аргагүй, ухаан оролтгүй, бодоод цөхөөд байх юмгүй,

Не мудрено, что он обиделся. Тэр амьтан хилс болов, гэдэг нь хэний ч бодоожийн байна шүү дээ.

770. НЕ МУДРСТВУЯ ЛУКАВО [*книжн.*] цэцэрхдэггүй, цэцэр-хээгүй, гайхуулаагүй, мэдэмгийрхээгүй.

771. НЕ МЫТЬЁМ, ТАК КАТАНЬЕМ арьс махы нь зулгаах, үйлий нь үзэж үсий нь тоолох, зовоож гүйцдэггүй, дээлтэй нь хатаах.

772. НЕ НА ДУРАКА (простака) НАПАЛ [*прост.*] эрийг бүү бас далайг бүү янд гэгчээр, голсон юм голд орох, сохорсон биш завшив.

773. НЕ НА ЖИЗНЬ, (живот), А НА СМЕРТЬ (бороться) үхэн тулалда-, амь тэмцэ-, үхэх сэхэхээ үзэ-, амь наана там цаана гэгчээр, үхэн хатан (тулалда-), цус асаруулан (тул-), ул асган байлдмуй.

774. **НЕ НА ПОЖАР.** [*разг.*] түймэрт хөөгдсөн биш, юундаа яарах юм бэ, тэвдэх юу байх вэ, юманд хөөгдсөн биш, хүн бушуул гээд байгаа биш.

Не на пожар, поспеешь на поезд. Түймэрт хөөгдсөн биш яараад яах вэ, галт тэрэг хөдлөхөөс өмнө амжиж хүрнэ.

775. **НЕ НА ТАКОВСКОГО напал** [*разг.*] Тийм (ийм) амаргүй, тэгдэг юм биш, санааны зоргоор болдог хэрэг биш, хялбаргүй, арай ч ... гүй, холоо хэвтэнэ, гонжийн жоо голионы сүүл.

Ты хотел меня обмануть, но не на таковского напал. Та намайг араар нь тавих санаатай юу, арай ч тэгж амархан дөнгөх хэрэг биш шүү.

776. **НЕ НА ТАКОВСКОГО (такого) НАПАЛ** [*прост.*] Голсон юм голд оров гэгч болжээ, эрийг бүү бас, далайг бүү янд гэгч болов ,сохорсон биш завшив.

777. **НЕ НА ТОГО НАПАЛ** Н-776.

778. **НЕ НА ТУ НОГУ** арай дор (тэрэнд) хүрэхгүй, баахан дутуу, хаа байсан юм, тэр ч гайгүй хэвтэнэ ээ.

779. **НЕ НА ЧТО** зоосгүй, мөнгөгүй, бэл дутаад, өвөр хоосон, юу ч алга.

Выпить не на что, а выпить-то хочется (А. Островский **бедность не порок**).

Архи уучихвал ч уучихмаар л байна л даа, даанч мөнгө алга.

780. **НЕ НА ШУТКУ** тоглоом биш, тоглоом ч үгүй, инээх юм биш, ... тэгэхийн (ингэхийн) дүрстэй тэгсэн шиг тэгэж, наадаамгүй, үнэнээсээ, тэгж алдах,

Работать не на шутку. Ажиллахын дүрстэй ажилла-, **Солнце не на шутку начало уже припекать.** Нар ч шарсан шиг шарж гарах нь дээ.

781. **НЕ НАДЫШАТЬСЯ** *на кого-что* халуун элэгтэй, элэг зөвтэй сайхан сэтгэл өвөрлө-, өр зүрхнээсээ сайн, голын хайртай, голоо тавьдаг, элгэмсүү, өөриймсүү, цөстэй,

782. **НЕ НАХОДИТЬ (найти) СЕБЕ МЕСТА** Байх суух газраа олохгүй сандчи-, тэвдэ-, босож суу-, өндөлзө-.

783. **НЕ НАХОДИТЬ СЛОВ** *для чего* гоодсон амтай, үгээр тэжээ-, үгээр хөхүүлэ-, хэлэх (сайн) үгээ олохгүй, яаж (юу гэж) (магтвал) хэлвэл таарах юм бэ, магтах үгээ олохгүй, амаа олохгүй хөхүүлэн магта-.

Не нахожу слов, чтобы выразить вам свою благодарность. Та яасан буянаа дэлгэрсэн хүн бэ, юү гэж хэлье дээ би.

784. **НЕ НУЖНО БЫТЬ ПРОРОКОМ ЧТОБЫ...** мэдэж цөхөх юу байх вэ, тэгнэ л биз, тэгэж л таарна даа тэх байх, ингэх байх гээд байх юмгүй мэдээжийн хэрэг.

785. **НЕ НЫНЧЕ—ЗАВТРА** өнөө маргаашгүй, өнөө биш бол маргааш, удаандаа л маргааш, өнөө маргаашаас хэтрэхгүй, (давахгүй), мөдхөн, хаяанд, айл буулаа, айсуй, яалтай бол доо. Н-883

786. **НЕ НЮХАЛ** *что* [*разг.*] огт тэгэж (тийм юмыг) үзээгүй, ер тэгэж яваагүй, тэр талаар ч үзэг ч үгүй шүү дээ, умаа хум шүү дээ, огт мэдэхгүй, А ч үгүй, зүг ч байхгүй, тесөө ч байхгүй, ээ маагүй.

787. **НЕ ОБЕССУДЬ (НЕ ОБЕССУДЬТЕ)** битгий муу юм бодоорой (санаарай), гомдохгүй биз дээ, юм бодуузай.

788. **НЕ ОБИНУЯСЬ** түс тас, эрс шууд, иймээ тиймээгүй, олон таван үггүй, булзааруулахгүй, гүдэс нь дээр, бүү цааргал, бүү зайц.

Не обинуясь подтвердить сказанное. Иймээ тиймээ юмгүй хэлснээ хүлээ.

789. **НЕ ОБСЕВОК В ПОЛЕ** [*прост.*] Хүн л бол хүн, хүн ялгадаггүй, байгаа нь тэр.

790. **НЕ ОГЛЯНЕШЬСЯ** *КАК* ... Н-932.

791. **НЕ ОГРЕБЁШЬСЯ** *чего* [*прост.*] өдүй, төдүй, бишгүй, олон, тоо томшгүй.

792. **НЕ ОСОБЕННО** [*разг.*] онц ... үгүй, төдийлөн (тийм) гүй, гойд тиймгүй, гавнатай биш, барагтайхан, хэтрүү биш.

Не особенно жарко. Онц халуун биш.

793. **НЕ ОСТАТЬСЯ В ДОЛГУ** өр зээлгүй, өгөө аваагүй, наймаа таарсан, санах юмгүй, өглөг авлагагүй, эх нь эцээгүй, тугал нь тураагүй, өр ширгүй.

794. **НЕ ОСУДИТЕ!** [*разг.*] өршөөгөөрэй! өршөөж хайрла! тоогүй юм боллоо, муухай юм боллоо.

795. **НЕ ОСУШАТЬ ГЛАЗ** усан нүдлэ-, тэсгэлгүй урсга-, уйлахгүй цаггүй мэлмэрүүлж-

796. **НЕ ОТ МИРА СЕГО** хүн хүнөэс этгээд зантай (хүн), мужийн ааштай хүн, хүнтэй таардаггүй амьтан, буруу ишилсэн сүх шиг, буханд ачсан ачаа шиг амьтан, тэр чигээрээ зантай, ад мөрийн ааштай.

797. **НЕ ОТВАЛИТСЯ ГОЛОВА, ВЫРАСТЕТ И БОРОДА** хүзүү толгой үргэлж байвал хүссэн хэрэг бүтэж болдог. Гол тасартал горь тасрахгүй, амьд явбал алтан аяганаас ус ууна, санаж явбал бүтнэ, сажилж явбал хүрнэ.

798. **НЕ ОТВЕДАВ, ВКУСУ НЕ УЗНАЕШЬ** үзэм бурам амттай боловч идээгүй бол мэдэхгүй, ухаан санаа сайн боловч үзэхгүй бол мэдэхгүй, үзэхгүй бол танихгүй, сонсохгүй бол мэдэхгүй, хүний сайныг ханилан байж, морины сайныг унан байж,

799. **НЕ ОТВЕДАВ ГОРЯ, НЕ ПОЗНАЕШЬ И СЧАСТЬЯ** зовлон үзээгүй хүн жаргал мэдэхгүй, зэжтэй хүний жаргалыг зэжгүй болоод л мэддэг.

800. **НЕ ПАРА** эвэр туурай шиг, зохихгүй, гологдох, дүйцэхгүй, тэмээ ямаа хоёр шиг, ижилдээ нийлэхгүй, тампуунд хийсэн эвэр шиг

801. **НЕ ПАХНЕТ** 1. тэмдэг ч алга, шинж алга, ...ийн царайгүй янзгүй, 2. доён, гон бие гозон толгой, эр ганц, хүний ганц хүүхэн,

802. **НЕ ПЕРВОЙ МОЛОДОСТИ** [*разг., фам., ирон.*] одоо хэн залуу гэх вэ, ямар арван наймт гэх биш, цэл залуу биш дээ, орь залуугийн цаг өнгөрчээ, залуу халуун нас биш, залуурхадаг хөг өнгөрчээ.

803. **НЕ ПЕРВОЙ СВЕЖЕСТИ** [*разг.*] Шинэ биш, хуучивтар, 2. [*перен. шутл., ирон.*] Нас залуу биш, нас ахилаа, цэл залуу биш, нялхамсахын хариу алга, залуугнйнх шиг юм алга, хүн зуйрдаг залуу нас өнгөрчээ,

804. **НЕ ПЕРЕВОДЯ ДЫХАНИЯ** Амьсгаа авах чөлөөгүй, нэг амиар.

805. **НЕ ПИТО НЕ ЕДЕНО** (мөнгө) аманд ч үгүй, хамарт ч үгүй үрэн таран болов, мөнгөнийхээ эдийг хийсэнгүй, альчгүй болов.

806. **НЕ ПЛЮЙ В КОЛОДЕЦ ПРИГОДИТСЯ ВОДЫ НАПИТЬСЯ** голсон юм голд орж шилсэн юм шил дардаг, давахгүй гэсэн даваагаараа гурав давж, уулзахгүй гэсэн хүнтэйгээ гурав уулзана. Тэгэхгүй гэж хэлдэггүй, урьдахаа бүү элэглэ, усанд унасныа бүү шоол.

807. **НЕ ПО АДРЕСУ** эзнээ олоогүй, хүнээ олоогүй, газраа олоогүй буруу нөхөр олсон.

808. **НЕ ПО ВКУСУ** санаанд таарахгүй, санаанд нийлэхгүй,

809. **НЕ ПО ГОДАМ** 1. хирнээсээ давуу (ухаантай), үе тэнгийнхнээсээ онц цоорхой ..., 2. хэвлүүхэн, ахиадхан, биенээсээ илүү ухаантай, хаанаасаа гарч байгаа юм гэмээр, харах царайнаасаа,

Он не по годам умён. Үе тэнгийнхээсээ цоорхой ухаантай (Биендээ байхгүй сэргэлэн).

810. **НЕ ПО ДНЯМ, А ПО ЧАСАМ** [*разг.*] жилийн газрыг сараар, сарын газрыг өдрөөр, өдрийн газрыг цагаар товчилж,

811. **НЕ ПО ЗУБАМ** *кому* нохой хорихгүй, шон хүрэхгүй, холтлохгүй, даахгүй, хүч хүрэхгүй, барахгүй, дөнгөхгүй, барж идэхгүй,

Этот философ не всякому по зубам. Энэ гүн ухаантныг хэн хүн судлаж хүч хүрэхгүй.

812. **НЕ ПО КАРМАНУ** *кому* [*разг.*] бэл хүрэхгүй, бэнчин хүрэхгүй, үний нь давахгүй.

813. **НЕ ПО МНЕ** нём, **тебе** и т. д.) санаанд (минь) таарахгүй, сэтгэлд нийцэхгүй, таалалд нийцэхгүй, сэтгэлд зохисгүй

814. **НЕ ПО НОЗДРЕ** *кому, кто, что* [*груб. прост.*] ой гутам, олиггүй шал дэмий,

815. **НЕ ПО НОСУ** *кому* [*разг.*] санаанд нийцэхгүй, таалалд нийцэхгүй, аашинд нь таарахгүй

816. **НЕ ПО НУТРУ** *кому, кто, что* [*прост.*] таалалд үл нийцэх шал дэмий, дургүйд хүчгүй гэгч, давашгүй даваа, даадгүй булуу, таваглашгүй хэрэг.

817. **НЕ ПО ПЛЕЧУ** *кому* хүч хүрэхгүй, чадал хүрэхгүй, давж дийлэхгүй, цаана нь гарахгүй, хирнээс хэтэрсэн, арай ахдуу арай хэнздэхээр, дөнгөхгүй

Такой перевод ему не по плечу. Иймэрхүү орчуулгыг тэр бид хоёр яаж дөнгөх вэ?

818. **НЕ ПО ПРАВУ** *(кому, кто, что)* таалалд нийцэхгүй

819. **НЕ ПО РЫЛУ** *кому* [*груб. прост.*] нийцэшгүй, нийцэмгүй, эгнэшгүй, хүрэлцэшгүй, хүрэлцэмгүй, хошуу хүрэхгүй

820. **НЕ ПО СЕБЕ** *кому* [*разг.*] дотор жигтэйхэн болоод, хачин юм санагдаад, бүлх залгисан юм шиг байх, гол горойлгоод, гол гонсойгоод

От его слов мне стало не по себе. Хэлсэн үгий нь бодохоос дотор аягүй санагдана.

821. 2. **НЕ ПОД ЛЕТА** [*устар.*] насанд хүрээгүй, бнед хүрээгүй, амны нь салиа арилаагүй, ээжийнхээ хөхнөөс гараагүй, аавынхаа өврөөс гараагүй, юу ч мэдэхгүй хүүхэд

822. **НЕ ПОБРЕЗГАЙТЕ нашим угощением** [*прост.*] гололгүй зооглоорой, цээрлэлгүй зооглогту! эрээлэлгүй зоогло! идэж болмоор бол ид! тоовол зоогло! гоочил! сормуучлаад гоочил!

823. **НЕ ПОГЛАДИТЬ ПО ГОЛОВКЕ** *кого* (за что) [*разг.*] таашаахгүй, сайн гэхгүй, таалахгүй, ивээхгүй, ойшоохгүй, үтээрэхгүй, хэрэгсэхгүй, ...-ын цандаагүй, ...-ын янзгүй

За это начальство не погладит тебя по головке. Дарга нар энэний тэнь таалахгүй дээ (Дарга нар үүнийг чинь ивээхгүй дээ).

824. **НЕ ПОДДАВАТЬСЯ ОПИСАНИЮ** бийр бэхээр бичиж барашгүй, үгүүлж баршгүй, туйлаас, машид, үнэхээр

Её радость не поддаётся описанию. Бийр бэхээр бичээд баршгүй их баярлав. Баярласан гэдэг учиргүй.

825. **НЕ ПОДДАВАТЬСЯ УЧЁТУ** тоолж баршгүй, тоо томшгүй.

826. **НЕ ПОДИВИ НА МЕНЯ** на нас өршөөж хайрла! уучилж хайрла! хэлтрүүлж хайрла! үзэж хайрла! аварч өршөө! энэрч үз! ивээж хайрла!

827. **НЕ ПОДЛЕЖИТ СОМНЕНИЮ** гайхалзах юмгүй, дамжиггүй, эргэлзээгүй.

Не подлежит сомнению, что он прав. Зөв гэдэг нь дамжигтүй.

828. **НЕ ПОДНИМАЕТСЯ РУКА** у *кого на что* [*разг.*] зүрх хүрэхгүй, зориг дутаад, сэтгэл төвдөхгүй, баахан шантраад, нэг л хулчийгаад, айхгүй ч болсон зэвүүн

829. **НЕ ПОДПУСКАТЬ НА ВЕРСТУ** *кого* [*разг.*] ойртуулахгүй, хавьтуулахгүй, халгаахгүй, газрын бараанаар, хаа газраас (холоос)

Гости отдали честь всем блюдам Гийчид хоолны нь сайныг шагшин магтав.

292. **ОТДАТЬСЯ С ГОЛОВОЙ** У-70

293. **ОТДЕЛИТЬ ПЛЕВЕЛЫ ОТ ПШЕНИЦЫ** Муугаа ялгаж муруйгаа заа-, учры нь олж хужры нь тунгаалга-, олон дунд үгээ шинжи, ор ганцаараа сэтгэлээ шинжи-.

294. **ОТДОХНУТЬ (отдыхать) ДУШОЙ** сэтгэлээ сэргээ-, сэтгэлээ билчээ-, санаагаа амраа-, сэтгэлээ тайтгаруул-

295. **ОТДУВАТЬСЯ СВОИМИ (собственными) БОКАМИ** [*прост.*] үйл хураа-, лай хураа-,

296. **ОТДЫХАТЬ ДУШОЙ (сердцем)** О-294

297. **ОТЕЦ СЕМЕЙСТВА** [*разг.*] Отгийн тэргүүн, өрхийн тэргүүлэгч

298. **ОТЗВОНИЛ И С КОЛОКОЛЬНИ ДОЛОЙ** [*разг, неодобр.*] нүглийн нүдийг гурилаар хуурав, ор нэр болсон, нүд хаав,

нүүр тахлав, оронцоглов, нүд хуурав, хуламдав, хам хум юм хийв, хайш яйш (юм хийх) хандав, гарын тоймоор, тэгж нигэв.

299. ОТКАЗАТЬ (отказывать) ОТ ДОМА [*кому*] оруулахгүй, ирүүлэхгүй, шагайлгахгүй.

300. ОТКАЗАТЬ СЕБЕ *в чём* ганд нь хая-; орхи-, гарзанд нь гарга-, зөнд нь орхи-,

301. ОТКАЗАТЬСЯ СЛУЖИТЬ [*разг.*] эвдрэ-, хэрэглэж болохоосоо өнгөрө-, хэргээс гара- хөг нь өнгөрө-, хэрэг нь өнгөрө-,

302. ОТКАЗЫВАТЬ (отказать) В РУКЕ О-303

303. ОТКАЗЫВАТЬ (отказать) ОТ РУКИ хянилахгүй гэ-, ураг болохгүй гэ-, ураг барилдахаас татгалза-

304. ОТКАЛЫВАТЬ (отколоть, отмачивать) ШТУКУ У-51

305. ОТКЛАДЫВАТЬ (положить) В ДОЛГИЙ (в дальний ЯЩИК [*разг.*] сүүлд бол гэ-. хойш тави-, далдын далд дайлангийн мухарт хий-, аяар бол-, хожим бол-. дара-, дарагдуул- П-684

306. ОТКОЛОТЬ (откалывать) КОЛЕНЦЕ У-51

307. ОТКРОВЕННО ГОВОРЯ үнэнийг хэлэхэд, ний нуугүй хэлэхэд, түс тас хэлэхэд

Откровенно говоря, он мне не нравится Ний нуугүй хэлэхэд, цаатах чинь нэг их аятайхан хүн биш шиг санагддаг юм (үнэнийг хэлэхэд түүнд би сайнгүй).

308. ОТКРЫВАТЬ АМЕРИКУ О-318

309. ОТКРЫВАТЬ НОВУЮ СТРАНИЦУ үгчилбээс: шинэ хуудас нээ-, утга нь: шинэ үйл үүсгэ-, шинэ гайхамшигт явдал гарга-, шинэ юм сэдэ-

310. ОТКРЫВАТЬ (открыть) СЕРДЦЕ *кому* сэтгэл уудлан өгүүл-, санаснаа ярьж ав-, бодсоноо дэлгэ-, санаж боддогоо гарга-

311. ОТКРЫТАЯ КНИГА [*перен.*] мэдээжийн юм, илхэн юм, хэний ч мэдээжийн, үзээжийн, хараажийн,

312. ОТКРЫТАЯ РАНА анаагүй шарх, эдгээгүй шарх, битүүрээгүй шарх, түрж гүйцээгүй шарх, илааржаагүй шарх, улаан шарх, шинэ шарх,

313. ОТКРЫТОЕ ЛИЦО үнэн царай, үнэн санаа, цагаан санаа, үнэн нүүр, байгаа нь,

314 ОТКРЫТОЕ МОРЕ 1. энгүй далай, их далай, оломгүй (хөлгүй) далай, сүн далай.

315. ОТКРЫТОЕ ПИСЬМО дуртуйгүй захиа, ил захидал

316. ОТКРЫТЫЙ ВОПРОС шийдээгүй хэрэг (асуудал), хэлтгийрээгүй явдал

317. ОТКРЫТЫЙ ЛОБ өргөн магнай, уужим магнай, толиотой магнай.

318. ОТКРЫТЬ АМЕРИКУ [*разг., ирон.*] үгчилбээс: америкийг нээ-, утгачилбаас: мэдээжийн юмыг улигла-. О-308

319. ОТКРЫТЬ (открывать, раскрыть, раскрывать) ГЛАЗА *кому на что* болгоомжтой бай-, мэдээтэй бай-; хараатай бай-, анаатай бай-, сэрэмжтэй бай-, Р-101

320. ОТКРЫТЬ (открывать) ДВЕРИ (дверь) *кому куда* замы нь тавьж өг-, үүдий нь нээж өг-, морий нь унуул-,

321. ОТКРЫТЬ (открывать) ДУШУ дунд санаагаа илгэ-, бодсоноо хэлэ-, сэтгэлээ илчлэ-.

322. ОТКРЫТЬ КАРТЫ Р-103

323. ОТКРЫТЬ КЛАПАН [*перен.*] сэтгэлээ дэлгэ-, санасан бүгдээ хэлэ-, бодсоноо ил гарга-, сэтгэлээ уудла-, доторхно уудла-.

324. ОТКРЫТЬ ОБЪЯТИЯ *кому* хоёр гараараа тэврэ-,

325. ОТКРЫТЬ (открывать) РОТ [*перен*] ам нээ-, үг хэлэ-, амаа ангай-,

326. ОТКРЫТЬ СЧЁТ даанс нээ-, даанстай бол-.

327. ОТКУДА БОГ ПРИНЁС [*разг. шутл.*] (чи чинь) газрын хаанаас гараад ирэв, газраас гарав уу, тэнгэрээс буув уу.

328. ОТКУДА (куда) ВЕТЕР ДУЕТ (идти, знать, наблюдать и. т. д) салхины аяар, хаашаа л бол хаашаа, эрэг хаашаа бол ус тийшээ, зүү хаашаа бол утас тийшээ, салхи хаашаа бол үүл (гал) тийшээ.

329. ОТКУДА НИ ВОЗЬМИСЬ [*разг.*] 1. хаанаас гараад ирэв, газрын хаанаас гараад ирэв?

330. ОТКУДА (из за что) СЫР-БОР ЗАГОРЕЛСЯ? (горит) [*разг.*] яагаад ийм болов, яагаад ийм хэрэг гарав, юу болох нь энэ вэ! хаанаас хэрэг дэгдэв? юунаас юу өгдөв.

331. ОТЛЕГЛО (отошло) ОТ СЕРДЦА [*разг.*] сэтгэл онгойв, дотор уужрав, мөрөн дээрээс нэг их юм авчихсан юм шиг болов, сэтгэл тэнийв. дотор тавирав, сэтгэл тайтгарав, дотор сэнгойв (сэнгосхийв)

332. ОТЛИТЬ ПУЛИ Л--86

333. ОТЛИЧАТЬСЯ КАК НЕБО ОТ ЗЕМЛИ газар тэнгэр хоёр шиг ялгаатай. Тэмээ ямаа хоёр шиг өдөр шөнө хоёр шиг

334. ОТЛОЖИТЬ ДО ГРЕЧЕСКИХ КАЛЕНД хойш тави-, хойшлуул-, орхизно-.

335. ОТЛОЖИТЬ НА ВСЯКИЙ СЛУЧАЙ юмыг яаж мэдэх вэ гэж, болгоон, азна-, байзна-, хүлгэлзэ-, хүлээзнэ-.

336. ОТЛОЖИТЬ НА СЧЁТАХ бодох мохлогт тоо хий-,

337. ОТЛОЖИТЬ НА ЧЕРНЫЙ ДЕНЬ гачигдах цагт хэрэглэхээр цааш хий-, хэрэг болно гэж хадгал-, хоол нэхэх юм биш байж байг

338. ОТЛОЖИТЬ ПОПЕЧЕНИЕ *о чём* бодохоо бай-, дурсан санахгүй бол-, ор тас марта-.

339. ОТМЕЧЕН ПЕРЕТОМ (божьим) [*разг.*] олноос цоорхой, сэнгой авьяастай; тасархай ухаантай, гарамгай, эгнэшгүй ухаантай, хосгүй ухаантай, ухаалаг.

340. **ОТНЕСТИ (относить) ЗА СЧЁТ** *кого чего*, . . . тэгж бодо-нигэж сана-,

341. **ОТНЕСТИ НА СЧЁТ** *кого чего* даансалж ав-, зэсэнд оруул-,

342. **ОТНИМАЮТСЯ РУКИ** О-135

343. **ОТНЫНЕ И ДО ВЕКА** [*разг. шутл.*] үүрд байх, мөнх орших,

344. **ОТНЯТЬ ОТ ГРУДИ (ребёнка)** (хүүхдийг) хөхнөөс нь гарга-, мээмнээс нь гарга-,

345. **ОТОЙТИ В ВЕЧНОСТЬ** [*книжн.*] үхэж үгүй бол-, өнгөрсөн хорвоо, эргэшгүй,

346. **ОТОЙТИ В ПРОШЛОЕ** тэгдэг цаг өнгөр-, өнгөрсөн хорвоо.

347. **ОТОЙТИ К ВЕЧНОМУ БЛАЖЕНСТВУ** диваажинд очи-, бурхны оронд очи-, бурхан бол-, өөд бол-.

348. **ОТОЙТИ КО СНУ** Унтаад ав-, туугтал унта-, нойроо ав-, томбойтол унта-, дугжира-,

349. **ОТОЙТИ ОТ МИРА (сего)** (энэ) ертөнцөөс хали-, мөнх бусыг үзүүл-, орчлонгийн мөнх бусыг үзүүл-

350. **ОТОЛЬЮТСЯ ВОЛКУ ОВЕЧЬИ СЛЁЗЫ** хорыг хороор; муу санааны үзүүрт цус, муу санааны үзүүрт ташуур, мууг хийвэл өөрт, өөрийн хийсэн өөрт, өөд нь хаясан чулуу өөрийн толгойд, муу санаа эзнээ отно, санаа муут яван хатна.

351. **ОТОЛЬЮТСЯ КОШКЕ МЫШИНЫЕ СЛЁЗЫ** өөрийн хийсэн өөрт, өөд нь хаясан чулуу өөрийн толгой дээр идсэн эрүү хувхайрдаг, нүгэл нүдээ олдог.

352. **ОТОПТАТЬ ПОРОГИ** үүдий нь ура-, босгы нь элээ-, босоо хоноц бол-, үнэ хүндгүй бол-, ам бүл нь болохдоо шаха-, өдрийн арван гурав дахи-,

От свах и сватов отбою нет, пороги отоптали зууч нь олдоод босгы нь элээж гүйцэв.

353. **ОТОСЛАТЬ (отправить) К ПРАОТЦАМ** [*разг., шутл.*] муу хий-, цааш нь харуул-, бодий нь хөтөл-, хөлий нь амраа-, нас баруул-.

354. **ОТОШЛО ОТ СЕРДЦЕ** О-331

355. **ОТПЕРЕТЬ ЗОЛОТЫМ КЛЮЧОМ** *что.* [*разг.*] хээл хахуул цутга-, арын хаалгада-, хахуульда-.

356. **ОТПЛАТИТЬ ТОЙ ЖЕ МОНЕТОЙ** *кому* өөрий нь мэхий өөрт нь хэрэглэ-, сурсан мэхээ сургасан багшид нь гарга-, өөр тэй нь барилдуул-, хорыг хороор

357. **ОТПРАВИТЬ В РАЙ** *кого* цааш нь харуул-, төрөл арилжуулмуу хий-, тамын түлш болго-, үгүй хий-,

358. **ОТПРАВИТЬ (отправлять) К ПРАОТЦАМ** *кого* хороо-, цааш нь харуул-, нас баруул-, жанч халуул-

359. **ОТПРАВИТЬ НА ТОТ СВЕТ** төрөл арилжуул-, бодий нь хөтөл-, тонилго-, маани уиши-, хороочи-,

360. **ОТПРАВИТЬСЯ (отправляться) К ПРАОТЦАМ** [*разг.*] өнгэр түши-, өөд бол-, онгодындоо бараалха-.

361. **ОТПРАВИТЬСЯ НА БОКОВУЮ** [*разг.*] хажуул-, сүүж амраа-

362. **ОТПРАВИТЬСЯ НА ПОКОЙ** явж нойрсо- (унта-) орондоо ор-

363. **ОТПРАВИТЬСЯ (отправляться) НА ТОТ СВЕТ** [*разг.*] төрөл арилжи-, өөд бол-, энэ орчлонгоос тонил-,

364. **ОТПРАВНАЯ ТОЧКА** үүсгэл, эх, эхлэбэр, эхлэх юм, эх авах юм нь, . . . аас бол-, . . аас үдэ-

365. **ОТПУСТИТЬ ГРЕХИ** *кому* нүглээ наманчила-

366. **ОТПУСТИТЬ (опусти, пусти) ДУШУ НА ПОКАЯНИЕ** [*шутл. разг.*] яс амраа-, амар саяа үзүүл-.

Отпустите мою душу на покаяние амар заяагий минь нэг жаахан үзүүлээд аль, жаахан амар заяа үзүүлээч!

367. **ОТРЕЗАННЫЙ ЛОМОТЬ** [*перен.*] харж хандуулалтгүй, толгойгоо даа-, амиа тээхтээ бол-.

368. **ОТРЫВАЕТСЯ ОТ СЕРДЦА** *у кого* [*устар.*] сэтгэл дэнслэсэтгэл зовни-, дотор хүйт орги-, зүрх шимширэ-

369. **ОТРЫВАТЬ (оторвать) ОТ СЕБЯ** [*прост.*] гол амь зуулгаа алда-, амь голоосоо хагаца-, наашаа харж инээгээд цаашаа харж уйлаад өг-, санадаг сарвайдаг юмнаасаа хагаца-

370. **ОТРЯСТИ (отряхнуть?) ПРАХ ОТ СВОИХ НОГ** [*перен.*] эргэлтгүй бол-, нааш харахаа бай-, нэгмөсөн шилээн харуул-.

371. **ОТСЕВ ШЕЛУХИ И ОТБОР ЗЁРЕН** шимий нь авч шимэлдгий нь хаях, шары нь авч шаары нь хаях

372. **ОТСОХНИ РУКА** [*прост.*] (худлаа байвал) гар минь хугараг гараа алддаг бий.

373. **ОТСОХНИ (у меня) РУКИ И НОГИ** [*прост.*] дээр нар байна (би тэгнэ . . . тэхгүй тэгсэн), (би гэх, тэхгүй, тэгсэн бол) нар баруун талаас навтас чирээд гараг.

374. **ОТСОХНИ ЯЗЫК, ЕСЛИ Я ВРУ** буюу **(отсохни у меня язык)** [*прост.*] худлаа байвал энэ толгойгоо аваад тавьчихъя, худал байвал хуйхтай толгойг минь ав!

375. **ОТСТАВНОЙ КОЗЫ БАРАБАНЩИК** [*разг. шутл. ирон.*] буурь суурьгүй болсон хүн, үеэ өнгөрөөсөн хүн, хэнд ч хэрэггүй болсон хүн, морь нь явахаа больсон хүн, мал юм бол таргалуулж алж идэх болсон, хөг нь өнгөрсөн хүн.

376. **ОТСТУПИТЬСЯ ОТ СВОИХ СЛОВ** хэлсэн үгэндээ хүрэхгүй, хэлснээ хийхгүй, хэрчсэнээ идэхгүй; амандаа хүрэхгүй, амаа буца-, үгээ буца-, хэлснээсээ няца-, эргэж хурга-, буцан туса-, няцаж буца-, бөөлжсөө эргүүлж идэ-, бөөлжсөө иддэг нохой аятай.

377. **ОТСУТСТВИЕ ВСЯКОГО ПРИСУТСТВИЯ** *у кого* [*шутл.*] толгой муутай, ухаан мөхөс, ой муутай, ухаан муутай, ой тойгүй, ой ухаангүй, сийрэгхэн биш, чээж муутай, юм тогтоохдоо муу.

378. ОТСЫПАТЬ ГОРЯЧИХ *кому* ташуурда-, торлогдо-, гуяда-, шавхра-.

379. ОТСЮДА ВЫТЕКАЕТ, *что* ... энэ чинь ... -ийг хаяалж байна, тэр чинь ... гэсэн үг, чингэхлээр .... (тэгэж) таарах нь байна, үүнээс авч үзвэл, тунгааж үзвээс, ингээд бодоход, ийм болохоор, нэгэнт ийм хойно.

380. ОТХОЖЕЕ МЕСТО [*прост.*] жорлон, морь харах газар, өтгөн шингэн мөр үзэх газар,

381. ОТХОЖИЙ ПРОМЫСЕЛ тэр ажил, хөлсний ажил, ацаг хийх.

382. ОТЧАЛИВАЙ [*прост.*] тонил, зайл, далд ор!, газрын мухарт хүр (оч,) яв! зай бол!

383. ОТЧЕКАНИТЬ ШАГИ шир шир хийтэл алха-, гулалзтал алха-; сэмбэлзтэл алха-

384. ОТЪЕЗЖЕЕ ПОЛЕ авын тов,

385. ОХ МНЕ! би явдаг билээ, би яанаа, би баларлаа.

386. ОХАНЬЕМ ПОЛЯ НЕ ПЕРЕЕДЕШЬ гаслаад гайнаас мултардаггүй, нулимс унагахаар нудрага зангид, гашуудсанаас ғараа зангидсан дээр, уйлаад уйлаад улсын шившиг, орилоод орилоод олны шившиг.

387. ОХИ ДА ВЗДОХИ [*прост, ирон*] гасалж гансрах, үглэж дуулах элээ халаг болох, түмэн зовлонгоон тоочих, уйлан донгодох,

388. ОХОТА ПОХВАЛЬБУ ЛЮБИТ үгчилбээс: гөрөөчин хүний ярна хөөргөн.

389. ОХОТА ПУШЕ НЕВОЛИ юу сайхан дур сайхан, дургүй ламыг дарж байж сахил хүртээж болдоггүй, дургүйд хүчгүй,

390. ОХОТА СМЕРТНАЯ, ДА УЧАСТЬ ГОРЬКАЯ шунал ихэдвэл шулам болдог, таван хүсэл, тамын зууч, хүсэл, зовлонгийн үүсгэл, хүсэл ихтийн хувин бага, хүсэл ихтийн заяа нь бага, шунал ихэдвэл (шулам болно) унал ихэднэ, хүсэл ихтийн хясал их.

391. ОХОТА ТЕБЕ (вам, мне, ему и. т. д) [*разг.*] яах гэсэн юм бэ, юунд нь дурласан юм бэ 2. Бас дуртай юу

Охота тебе спорить с ним! тэрүүнтэй маргахад юунд нь дуралсан юм бэ чи (тэрүүнтэй маргахад сайхан байна уу)

392. ОХУЛКИ НА РУКУ НЕ КЛАСТЬ (не положить) [*прост.*] бэлэн хоолноос хэн буцах вэ, аманд орсон шар тосыг хэлээрээ юунд түлхэх вэ, болж л байвал уухайн тос.

393. ОЦЕЖИВАТЬ КОМАРА хуурсанд жад, хулгананд хутга, бөөсөнд жад .... ямаа муудаа гэгчээр,

394. ОЦЕНИТЬ ПО ДОСТОИНСТВУ *кого что* меноор нь үнэлэүнэнээр нь цэгнэ-, голы нь ол-, ноён нуруу алдахгүй, дүн багцаа алдахгүй.

395. ОЧЕНЬ И ОЧЕНЬ тун их, асар их хичээнгүйлэн, заавал, тун ч, болбол л, болж л өгвөл, онцлон үзэж, онц(оос) онцолж, хичээж, базааж, хэрэг болгож, онцгойлж,

Очень и очень прошу вас прийти. Та хичээж морилж ирж үзээрэй (та заавал ч үгүй ирж үзээрэй).

396. ОЧЕНЬ (куда как) НУЖНО (тэхийш) хэрэг юу байх вэ? албатай биш. онц хэрэггүй.

397. ОЧЕРТЯ ГОЛОВУ [*разг.*] хөнгөн хуудам, саналга бодлогогүй, наана цааныг бодохгүй, юмыг яах бол гэхгүй, хийсгэлэн, хий сүрсэгнэх.

Он бросился в драку очертя голову юмны наана цааныг бодохгүй л нударгалдаж гарав (үг сүггүй говшилдов).

398. ОЧИСТИТЬ СОВЕСТЬ РАСКАЯНИЕМ гэмшин наманчил-, нүглээ наманчил, хилэндээ нимгэлэ-, омтгойлсноо гэмши-,

399. ОЧНАЯ СТАВКА нүүрэлдүүлэх, нүүрэлдүүлж байцаах.

400. ОШИБАТЬСЯ СВОЙСТВЕННО ЧЕЛОВЕКУ гэм хийхгүй хэн байх вэ, гэмээ барсан хэн байх вэ, алдаж онодог нь амьд хүний ёсоо, алдаж онох нь хорвоогийн жам, эр эндэг эрэг нурдаг, хүн эндэг хүлэг бүдэрдэг.

401. ОШИБКА В ФАЛЬШЬ НЕ СТАВИТСЯ гэмийг гэмэд үзэхгүй, байж болохгүй; алдааг аяар нь дасгаж болдоггүй, бурууг буруутаггүй тавьж болддоггүй.

П

1. ПАВОЙ ПРОЙТИСЬ (выступать [*разг.*] **и. т. п)** Их давилуун (эмэгтэй), данагар алхаатай (эмэгтэй), сунхалзан суялзан алха-, дөмсөн алхаатай.

2. ПАДАЕТ (Пала падет) ТЕНЬ *на кого.* Хардагдах, сэжигт орох, сэрдэгдэх, (хар) гүжирт унах, гөр үгэнд унах, хүний аманд багтах, гөр үгэнд сөөм харигүй гэгч болох

3. ПАДАТЬ В НОГИ У-107 - П-30,

4. ПАДАТЬ (упасть) В ОБМОРОК Муужра-, муужирч ойчи-, ухаан алдаж уна-, уна-, муура-,

5. ПАДАТЬ (Упасть, пасть) ДУХОМ сэтгэлээр уна-, урам хугара- сэтгэл гонсой- дур гута- санаагаар уна-. гол гонсой-.

6. ПАДАТЬ (пасть) К НОГАМ (к стопам) П-1062.

7. ПАДАТЬ (пасть, упасть) НА КОЛЕНИ *перед кем* П-34

8. ПАДАТЬ ОТ УСТАЛОСТИ ядраад унах шаха-, сульдаж гүйцэ-, мах бол-, салдирхила-, тамир тасра-, сүгтээ уна-, тамирда-, бие сулдай-.

9. ПАДАТЬ С НЕБА НА ЗЕМЛЮ У-111.

10. ПАЛЕЦ О ПАЛЕЦ НЕ УДАРИТЬ (пальцем не шевельнуть) 1. Хүч гаргахгүй; хүч орохгүй; хурууны үзүүрээр; хуруу нэмэхгүй; гар хөдлөхгүй; 2. гар хумхиж суу-, гарын гангаа хөлийн хөнгөн

11. **ПАЛКА О ДВУХ КОНЦАХ** Жаргал зовлон алин ч магадгүй, алаглаж ч магадгүй, сайн муу алин ч магадгүй, шаазгайлж ч магадгүй, аврах таврахын аль нь ч мэдэнгүй.

12. **ПАЛКА ПЛАЧЕТ** (*по ком*) Гар загатнаад, алга хорсоод

13. **ПАЛОЧНАЯ ДИСЦИПЛИНА** Ташуурын сахиля өх; бороохой сахиляга, хүчээр барих; шийдмээр далайлган барих

14. **ПАЛЬМА ПЕРВЕНСТВО** Түрүүлсэн байр; тэргүүн байр, эхний байр.
В шахматах пальма первенства за ним. Шатарт тэр хүн тэргүүн байр авав.

15. **ПАЛЬЦА В РОТ НЕ КЛАДИ** *кому* [*разг.*] Хартайхан ханилмаар хүн; улгайхан үзүүштэй (хүн), мэдээтэй үзүүштэй (хүн); давхар бодолтой дан биетэй бай; бөгс өндийхийг анддаггүй, галзуугийн аманд гараа битгий хий, хөлчүүгийн аманд хөлөө битгий хий, өрөвч сэтгэл хэрэгтэй ч өштөнд гараа бүү барнуул! (Д. Равжаа) Эр хүнийг ит тэхээр эрхий хуруугаа итгэ!

16. **ПАЛЬЦЕМ НЕ (Двинет шевельнет ПОШЕВЕЛЬНУТЬ** [*разг.*] Юу ч хийхгүй; гар хумхиад; жишим хийхгүй бай-

17. **ПАЛЬЦЕМ ПОКАЗЫВАТЬ** (*на кого что*, [*разг.*] хуруугаараа заа-, нүдэлж ав-, сайн хяшуур бай-

18. **ПАЛЬЦЕМ ТРОНУТЬ** *кого* [*разг.*] саад хий-; төвөг уда-,

19. **ПАЛЬЦЫ ЛОМАТЬ** [*перен.*] Санаа зово- магнайгаа үрчийлгэ-, яахаа мэдэхгүй бай-,

20. **ПАЛЬЧИКИ ОБЛИЖЕШЬ** [*разг.*] амт сайтай; арааны шүлс астаран хорхой хүрэм; шүлс гоожмоор; дээд уруулд хүргэмгүй, дэргэдэх хүндээн өгөмгүй; [*перен.*] сонин сайхан; дур татам; хүн шохоорхом; хараа булаам; нүд булаам, нүд хужирлам.

21. **ПАНУРГОВО СТАДО** сохроор дагасад, дүйвээнээр дагаачингууд; өвсний толгой шиг уяс; сохор нохой чимээнээр, соотон гөлөг дүйвээнээр; даган баясагсад

22. **ПАНЫ ДЕРУТСЯ А У ХЛОПЦЕВ ЧУБЫ ЛЕТЯТ а**) арслань аан хаванд таарахгүй, гарьдын шүүрлэг шаазгайд таарахгүй, **тэрмийн** хөлд бүүдай **б**) тэнгэрийн дүүнд аалз, тэмээний хөлд мөлхий; **в**) Ўулан дээр бар тоглоход уяан дээр няжиг баас аядана

23. **ПАРА НА ОТЛЁТЕ (отлёт)** Хос морин хөллөгөө, давхар дөр (давхар хөллөгөө) билчир хөллөгөө, билчирлэсэн хөллөгөө

24. **ПАРА ПУСТЯКОВ** [*прост. фам. разг.*] зовлон орохгүй; хөнж цохохгүй; гарын үзүүрийн, юухан байх вэ; хүйтэн цай зайдан морь, юмгүйхэн байна; ядаж нохөмгүй; ядах юмгүй; түүртэх юмгүй; төвөггүй; нохойн наадам; хүүхдийн тоглоом.
Сделать этот перевод для него пара пустяков. Энэ орчуулгыг мань хүн гарын үзүүрээр хийчхэнэ. (үүнийг мань хүн төвөггүй орчуулна).

25. **ПАРА С ОТЛЁТОМ** Давхар дөр, давхар хөллөгөө, хос морин хөллөгөө, билчир хөллөгөө, билчирлэсэн хөллөгөө

26. **ПАРА СЛОВ (пару слов)** [*прост.*] (ганц) хоёр үг; хэдэн үг; тав гурван үг Н-201

27. **ПАРИТЬ В ОБЛАКАХ В-659**

28. **ПАРФЯНСКАЯ СТРЕЛА** [*перен.*] 1. Онилы нь олж цохих Оний нь тааруулж цохих, 2. Гөлы нь оляж хэлэх, орой руу нь ортол нь хэлэх, таг мухардуулах, үгээр суулгах, үгээр таглах 3. Сумаа харваад нумаа нуух,

29. **ПАРШИВАЯ ОВЦА ВСЁ СТАДО ПОРТИТ** Муугийн гай олонд могойн цус тэнгэрт; муугаас муу модноос хөө; нэг ухрийн эвэр доргиход мянган ухрийн эвэр доргино, гөр үг гэвч гал шиг түлэхгүй ч нүүрс шиг хөдөө гэгчээр

30. **ПАСТЬ В НОГИ** У-107 П-3

31. **ПАСТЬ (упасть, падать) ДУХОМ (поникнуть упасть)** зориг шантра-, урам хугара-, зориг мохо-, зүрх үхэ-, сэтгэлээр уна-, П-733, У-109

32. **ПАСТЬ ЖЕРТВОЙ** [*книжн.*] . . . (биеэн) өргө- . . . тулд амиа өг-, . . . (тийм ийм юманд) хорлогдо-, 2. . . . нь золиос бол- Замд нь үрэгдэ-, хөлд нь үрэгдэ-, аль ч үгүй үрэгдэ-,

33. **ПАСТЬ НА ГОЛОВУ** С-216.

34. **ПАСТЬ (Падать) НА КОЛЕНИ** гуйж гувши; мөргөж сөхрө- У-110, П-7

35. **ПАСТЬ НА СЕРДЦЕ** [*устар.*] 1. Санаа төрө-, Ухаан сийя-, сэдэ-, үүсгэ-, 2. Тайл-, таашаг-).

36. **ПАТРИАРХАЛЬНАЯ СЕМЬЯ** [*истор.*] 1. Эцгийн эрхт гэр бүл 2. Хуучны айл; хуучин бууны хугархай.

37. **ПАХНЕТ (Запахло) ПОРОХОМ** дайн дэгдмээр болов; дарь утааны үнэр ханхалав; цэрэг, агт дайнд зэхээстай. цаг төр үймэв; төрийн нуруу төвшингүй болоз; цаг биш болов.

38. **ПАЧЕ ПЕСКА МОРСКОГО** Шороон түмэн; Ганга мөрний хумхийн тооноос олон, тоо томшгүй.

39. **ПАЧЕ ЧАЯНИЯ** Хэрэв заяа (хияа) юмыг яаж мэдэх вэ юм гэнэтэй; хэрэв бээр; . . . х болхул . . . х аваас. С-234
(если) паче чаяния я опоздаю, поезжайте сами без меня, Хэрэв заяа намайг хожимдвол та өөрөө явж байгаарай.

40 **ПАЧКАТЬ РЕПУТАЦИЮ** *чью* **(доброе имя)** *чьё* Нэрий нь гутаа-(бузарла-) (бааста;-) муу нэртэй болго-, нэрий нь хөндө, нэрий нь хугал-, нэргүй болго-, нэр нүүргүй болго-, нэг нэрий нь хоёр хий-. З-230

41. **ПЕЙ ДА ДЕЛО РАЗУМЕЙ** Уухыг уу, ухаан алдатлаа бүү уу, тааруулж уувая бал, гаарууллж уувал мал.

42. **ПЕЙ, ДА УМА НЕ ПРОПИВАЙ** П-41

43. **ПЕНЬ БЕРЁЗОВЫЙ** [*груб., прост.*] Мануухай, махан овоо

44. **ПЕРВАЯ ЛАСТОЧКА** Магнай; түрүү; хөлүү; тэрүүн; толгой; эхэн; анхных; үзүүр.

45. **ПЕРВАЯ ПОМОЩЬ** Дав дээр тус болох; урдаар туслах; нэн даруйд туслах; даруйхан туслах,

46. **ПЕРВАЯ СКРИПКА** [*перен, разг.*] Удирдах хүн; хөтлөгч хүн; голлох хүн; даамал; толгойлогч; зааж зурагч; юмны эзэн сумны занги; тэргүүлэгч; эзэн хүн.

47. **ПЕРВОЕ ВРЕМЯ** [*разг.*] эхэндээ; анхандаа; түрүүндээ; шинэхэн дээрээ.

48. **ПЕРВОЕ ДЕЛО** [*прост.*] 1. П-61 2. Сайхан хэрэг (явдал); баяртай явдал; чухал хэрэг.

49. **ПЕРВОЕ СЛОВО** 1. Эх, үүсгэвэр, үүд, магнай, түрүү түрүүч ууган нь үүтгэл, өдөөлөг. 2. Гол нь, үндэс нь чухаг нь, уул суурь нь, үнэн мөн нь, уг зүй нь, ном нь

50. **ПЕРВОЙ РУКИ** [*разг.*] Тэргүүн зэргийн; дээд зэргийн; хамгийн нэгдүгээр.

51. **ПЕРВО-НАПЕРВО** [*прост.*] Хамгийн эхэнд; эн тэргүүн; дав дээр

52. **ПЕРВЫЕ ШАГИ (шаг)** [*перен.*] Эхэндээ эхлэхдээ; эхлэж сурч байхдаа, анхандаа, анхан түрүүн.
Первые шаги ребёнка. (хүүхэд) хөлд орж байхдаа
Первые шаги молодого поэта. Залуу яруу найрагчийн эхний зохиол

53. **ПЕРВЫЙ БЛИН КОМОМ** Мордохын хазгай; холион бантан болгох; бурууг хэлж зөвийг дуулдаг; 2. Сураагүй ажил болгон хэцүү; хавханд ороогүй чоныг хашир чоно гэдэггүй; 3. Уйлсаар уйлсаар хүн, майлсаар майлсаар мал; дэгдэж суралгүй нисч болохгүй; анхандаа алдаж болно эхэндээ эндэж болно.

54. **ПЕРВЫЙ ВСТРЕЧНЫЙ (и поперечный)** дайралдсан хүн (ээс); эхлээд л дайралдсан хэн хамаагүй, тааралдсан болгон, учирсан болгон.

55. **ПЕРВЫЙ ГОЛОС** гол хүн; голлох эзэн; юмны эзэн, сумны занги.

56. **ПЕРВЫЙ ПОПАВШИЙСЯ** Дайралдсан эхний хүн; эхлээд дайралдсан хүн, эхэлж уулзсан хүн.

57. **ПЕРВЫЙ СЛУЧАЙ** Анхны явдал; анх удаагаа; эхэлж аваад л

58. **ПЕРВЫЙ СОРТ** [*перен.*] Хамгийн сайн; дээд зэргийн; хамгийн дөмөг; хамгийн бузгай; хамгийн шилдэг; хамгийн хамгийн сонгодог; хамгийн зүгээр, сайнаас сайн
Комната у неё-первый сорт Тэр хүүхний өрөө нь дээд зэргийн сайн өрөө (Мань хүүхэн сууц шиг сууцтай).

59. **ПЕРВЫЙ СРЕДИ РАВНЫХ** Тэргүүн, магнайд яваа ижлээсээ илүү, олноосоо онцгой, толгой цохьсон; тасархай; эгнэшгүй; жишишгүй; суга түрүүлсэн; цойлон тасарсан.

60. **ПЕРВЫЙ ШАГ** *сделать* [*перен.*] үүсгэх. түрүүнд нь эхлэх, магнайд нь; [эхлэл; зам нээв анхан; анхны (тавьсан) шав.

61. **ПЕРВЫМ ДЕЛОМ** [*прост.*] Эн тэргүүн, гол ажил; гол гоцоо; өгээгтэй зангилаа.

62. **ПЕРВЫМ ДОЛГОМ** [*прост.*] Эн тэргүүн, давын дээр; ав авсаар эхлээд л

63. **ПЕРЕБИВАТЬ ДОРОГУ** П-67

64. **ПЕРЕБИВАТЬ ЛАВОЧКУ** *кому* [*прост, шутл.*] Хоолы нь булаа-, амь зуулгы нь авч орхи-, голы нь гонсойлго-

65. **ПЕРЕБИВАТЬСЯ ИЗ КУЛЬКА В РОГОЖУ** [*прост.*] Ядуугийн зовлон эдлэ-, мацаг барьж аж төрө-, гуйлга гуйж, түүлэг түүж амьдра-

66. **ПЕРЕБИВАТЬСЯ С ХЛЕБА НА КВАС** [*разг.*] Ядуу гуцуу өлөн живэр аж төрө-, шар наран бор хоног өнгөрөө-, хоног өнгөрөө-, хоног төөрүүл-, хурхагла-, ахар дээс уяа хүрэхгүй гэгч бол-

67. **ПЕРЕБИТЬ (Перебежать) ДОРОГУ** *кому.* [*разг.*] Өрсөж хий-, өрсө-, түрүүлж үйлд-, урд нь оро-, урдуур өрсө-. П-63

68. **ПЕРЕБРАТЬ В УМЕ (В голове в памяти)** *чего что* [*разг.*] Нэг бүрчилэн сана-, нэхэн бодо-, ширхэг дараалан бодоширхэгчлэн бодс-, нарийвчлан бодо-, чандлаж сана-.

69. **ПЕРЕВЕРНЁТСЯ В ГРОБУ** [*шутл.*] санаа саванд багтмаргүй шившгийн явдал, хирээс хэтэрсэн шившиг.

70. **ПЕРЕВЕРНУТЬ (перевертывать) ВВЕРХ ДНОМ** Хөлөөрөө толгой хий-, ёроолы нь тэнгэр өөд харуул-, толгой түрүүгий нь алдуул-, бөгсөө тэнгэр өөд харуул-. П-78

71. **ПЕРЕВЕРНУТЬ ВЕСЬ МИР** Сүйдийн манан хадуул-, газар тэнгэр нийлүүл-

72. **ПЕРЕВЕРНУТЬСЯ В ГРОБУ** [*шутл, ирон.*] Үхсэн ч яс нь амрахгүй; үхсэн ч сүнс нь амраахгүй, ясы нь өндөлзүүлэ-.

73. **ПЕРЕВЕРТЫВАТЬ (переворачивать ставить, перевернуть) ВВЕРХ НОГАМИ** Үндсээр нь өөрчлө-; огт ондоо болго-; шинэчлэх

74. **ПЕРЕВЕРТЫВАТЬ (перевернуть переворачивать) ВВЕРХ ТОРМАШКАМИ** П-73

77. **ПЕРЕВЕРТЫВАТЬ (перевернуть, переворачивать) ВСЮ ДУШУ** *кого, чью, кому.* Хилэнг бадруул-; сэтгэл донсолго-, өррүү өшигле-.

78. **ПЕРЕВЕРТЫВАТЬСЯ ВВЕРХ ДНОМ** П-70

79. **ПЕРЕВЕСТИ ДУХ (Дыхание)** аниc хийх, амьсгаа авах зав гарах; амух зав гарах, сэгхийх.

80. **ПЕРЕВОЗНОСИТЬ ДО НЕБЕС** В-781, Д-321

81. **ПЕРЕВОДИТЬ (перевести) ДУХ** Санаа алда-, гүн амьсгала-.

82. **ПЕРЕВОДИТЬ (Перевести, ставить) НА РЕЛЬСЫ** *чего какие* Чиглүүл-,.. ын нөхцөлд зохицуул-, тааруул-, тийм нийм болго-.

83. **ПЕРЕГНУТЬ ПАЛКУ** [*перен разг. неодобр*] хэтрүүл-, дэндүүл-, давс хужры нь ихдүүл-, гааруул-, давуул-, дэндүүл-,

84. **ПЕРЕД ГЛАЗАМИ** дэргэд нь; нүдэн дээр, хөл дор чинь, өмнө нь, нүүр дээр
85. **ПЕРЕД ИСТИННЫМ БОГОМ** [*прост.*] хараадаг тэнгэр байвал харааж байг үнэн л юмдаг, үйлийн үргүй үнэн, хаа ч хүрсэн үнэн, ёстой үнэн, үнэндээ үнэн.
86. **ПЕРЕД ЛИЦОМ** П-925
87. **ПЕРЕД НОСОМ** П-441
88. **ПЕРЕД СМЕРТЬЮ НЕ НАДЫШИШЬСЯ** үхэл ирэхэд мянган бурхан хүрээлсэн ч нэмэргүй, амьсгааны тоо гүйцсэн бол аргалах арга гэж байхгүй, Эрлэгийн өөдөөс эгц хардаггүй, юу үнэн бэ үхэл үнэн, амраг садны зэргээр аварч үл болно, үхлийг ацаглаж болдоггүй, эрлэгийн элч хоосон буцдаггүй, үхлээс нуугдаж болдоггүй.
89. **ПЕРЕД ТЕМ, КАК...**-ын урьд,... -аас өмнө... гийн (нь) түрүүнд

Перед тем, как он пришёл. Ирэхээс нь өмнө

90. **ПЕРЕДНИЙ УГОЛ** Хоймор, дээд суудал, хүндтэй суудал
91. **ПЕРЕДОВАЯ СТАТЬЯ** тэргүүн, тэргүүн өгүүлэл.
92. **ПЕРЕЕЗЖАЯ СВАХА** [*прост.*] Нэг газар тогтдоггүй хүн, хаа байгаа нь мэдэгддэггүй хүн, хааяагүй суудаг хүн, хаа л бол хаа байдаг хүн.
93. **ПЕРЕЖИВАТЬ (пережать) (самого) СЕБЯ** 1. Үүрд дурсагда-, мөнх; 2. Үхсэн буурын толгойноос амьд ат айх гэгч.
94. **ПЕРЕЙТИ РУБИКОН (ПЕРЕШАГНУТЬ РУБИКОН)** шийдэмгий, ор-, халгалгүй оро-, халдацтай оро-, эр хүн шиг зүрхлэ-, зоримогхон хөдөлө-,
95. **ПЕРЕЙТИ (Пройти) ЧЕРЕЗ РУКИ** *чей кого.* олон юмыг өнгөрөөлөө бишгүй нэгийг үзлээ, үзэхээрээ л нэг боллоо, П-1130
96. **ПЕРЕКЛАДЫВАТЬ (Переложить) НА ПЛЕЧИ** *кого чьи кому* Зовлонгоо хүнд тохо-, (өөрөө сулраад өрөөл бусдад тай бол-,)
97. **ПЕРЕКОВАТЬ МЕЧИ НА ОРАЛА** Илдийг давтаж анжис болгоно.
98. **ПЕРЕЛАМЫВАТЬ (переломить) СЕБЯ** Хамраа мэдэ-, амаа мэдэ-, засал ав-, огт ондоо бол-, дөл нь эргэ-,
99. **ПЕРЕЛИВАТЬ ИЗ ПУСТОГО В ПОРОЖНЕЕ** Дэмий юмаар оролдо-, хэрэггүй юм хий-, дэмий ярнагаар цаг нөгцөө-
100. **ПЕРЕЛИВАТЬСЯ ЧЕРЕЗ КРАЙ...** бялхаж бай-, бадарч бай-, оргилж бай-.
101. **ПЕРЕЛОЖИТЬ ГНЕВ НА МИЛОСТЬ** уураа тэвчи-, хилэнгээ боомтло-, уурлахаар инээ-, уураа бари-, уураа тата-, шараа дара-, омгоо дара-.
102. **ПЕРЕМЕЛЕТСЯ-МУКА БУДЕТ** зовсон хүн жаргаж золбин нохой зоолох цаг бий, зовлон бүхнийг туулна, зовиур нь өмнө, жаргал нь хойноо, хүссэн юм хүзүүгээр татах цаг бий, хясад арилж, хүсэл биелнэ, юу санасан есөн хүсэл биелнэ, бэрхийг давж бэлэнд хүрдэг

103. **ПЕРЕМЕНИТЬ ДЕКОРАЦИИ** дүрээ хувилга-, торхөө өөрчил-, янз нь өөрсө-, М-77
104. **ПЕРЕМЕНИТЬСЯ В ЛИЦЕ** И-205, М-79
105. **ПЕРЕМИНАТЬСЯ С НОГИ НА НОГУ** [*разг.*] Яах учраа мэдэхгүй, сэтгэл хоёрдмол, хий дэвсэгнэ-, агада-, мэгдэ-.
106. **ПЕРЕМОЛВИТЬ СЛОВО** *с кем.* хэдэн үг соли-, ганц хоёр үг зөрүүл-. тав гурван үг соли-, мэнд мэдэлцэ-, хоёр үг
107. **ПЕРЕМЫВАТЬ (перемыть) КОСТОЧКИ** *кому* [*разг.*] Хов ярн-, хов хөө-, хошуугаа билүүдэ-, хошуу нь суна-,
108. **ПЕРЕОЦЕНКА ВСЕХ ЦЕННОСТЕЙ** Болж байгаа эсэхээ эрэгцүүлэн бодо-, сайн муу алин болохыг дахин цэгнэ-,
109. **ПЕРЕПОЛНИЛАСЬ ЧАША (Мера) (терпения)** *чья у кого* Тэсч чадалгүй, тэснэ тэснэ гэх янзгүй, тэсвэр алдан, хүлцэхийн аргагүй, тэсэж хүлцэлгүй, байж сууж чадалгүй, шээс алдан, хусран боос нь хавраа гэгчээр.
110. **ПЕРЕПОЛНЯТЬ (переполнить) ЧАШУ ТЕРПЕНИЯ** Хэтрэх хэтрэх гэхэд даанч хэтрүү; тэснэ тэснэ гэхэд даанч дэндүү; тэсэхээ бай-
111. **ПЕРЕСТАТЬ КЛАНЯТЬСЯ (раскланиваться)** *с кем* Нөхөрлөхөө бай-, Үерхэхээ боли-, ханилахаа зогсо-, зам замаа хөө-, мөр мөрөөрөө ява-, хувь хувиа хичээ-, нөхрийг тэвчи-, зэнзийцгээ-,
112. **ПЕРЕСТУПАТЬ С НОГИ НА ЛОГУ (Ногами)** (хөлөө) сольж гишгээд, (хөлөө) дэвслэн зогсном, дороо дэвсгэнэ, дороо хавчигна-, дороо холхи-, дэвхцэ-, тогтож яда-, хаягла-, ялаархсан адуу аятай, хөл даарсан хүн аятай, шээс нь хүрсэн хүүхэд аятай, өдтэй ямаа шиг, сая адуунаас барьж авсан (юүлсэн) морь шиг, тонгочоо хонь шиг, годгоно-, шаравгана-, цавчилахийлэ-, хөлөө сэлж солби-.

Лошади переступали ногами. Морьд хөлөө дэвслэн зогсном (Морьд хөлөө солбин соймуй, морьд тогтож ядан холхино, морьд цавчилхийлэн хавчина).

113. **ПЕРЕСТУПАТЬ (переступить, перешагивать, переходить) ЧЕРЕЗ ПОРОГ.** *кого, чего, чей,* Нэвтрэн ор-, дотор ор-, босгы нь алха-,
114. **ПЕРЕСТУПИТЬ (перешагнуть) ЧЕРЕЗ** *чей,* **ТРУП** хүний амиар арилжи-, толгойгий нь л авахаас нааш бүтээгүй; цааш харуулчихаад бол-, нүд анисны сүүлд бол-.

Можешь (можете) это сделать, лишь переступив через мой труп Намайг цааш нь харуулчихаж байгаад тэгвэл тэгдээ (энэ толгойг мөрөн дээр байлад санадаггүй санаа).

115. **ПЕРЕСЧИТАТЬ КОСТИ (Рёбра)** *кому* [*перен. прост.*] нэвсэртэл жанчи-, үхтэл зодо-, чөмгий нь таших шаха-, мөчий нь санжуул-, ясы нь яйл-, хэмх цохи-,
116. **ПЕРЕТЬ В ГОРУ** И-112.
117. **ПЕРЕТЬ ПРОТИВ РОЖНА** [*прост.*]

118. ПЕРЕШАГНУТЬ ЧЕРЕЗ ТРУП П-114

119. ПЕРЛ СОЗДАНИЯ шилдэг бүтээл, зохиолын сор, бүтээлийн дээж.

120. ПЕРСОНА ГРАТА [*ирон*] 1. эрх хүн, шадар хүн, ивээлд багтсан хүн. 2. ор залгах хүн, орондсуух хүн

121. ПЁС ВОЗЬМИ *кого* **чёрт возьми)** [*прост. вульг.*] Чөтгөр авмар; чөтгөр алгадмар, нохойн хоол болмор, нохой долоо, хэрээний идэш, нүдээ ухуулмар, хоёр нүдээ хон хэрээд ухуулмар.

122. ПЁС (его её) ЗНАЕТ (пёс его знает) чёрт знает 1. Хэн мэдэх вэ!, хэн мэддэг юм? бүү мэд! 2. Юуны чинь, элэнцгийн чинь

123. ПЕСЕНКА СПЕТА *чья*. дураараа дургидаг хөг өнгөрөв, сайн сайхан явах цаг өнгөрлөө, буянаа эдэлж дуусав аа, цагтаа цалгиж явсан шиг юм хаа байх вэ.

124. ПЕСОК СЫПЕТСЯ [*разг. шутл.*] Танаг нь тасчив аа, хүнд дараа болохоор боллоо, насанд дарагдаж гүйцжээ, нүдний булай болов, нэмэр болохоосоо нэмнээ болов, хөг нь өнгөрөв, най нь тасрав, найдаагаа алдав.

125. ПЕСТ, ЗНАЙ СВОЮ СТУПУ хирээ мэдэж бяраан тань! хир хирдээ, хэм хэмдээ; хирээ мэдэж барь! бяраа мэдэж өргө, адуу-рээр жий!

126. ПЕТЫЙ ДУРАК Тэнэг толгой, мааниг гайхал, усан тэнэг.

127. ПЕТЛЯ ПЛАЧЕТ (о ком) Далд ороосой, үхэл авмар, хижиг алгадаасай

128. ПЕТЬ В УШИ [*разг.*] Хоёр хүнийг хооронд нь уралцуул-, хов жив залгуул-, яс зөө-, яс хая-, хоёрын хооронд хоргол цана-, гурвын дунд гурил цана-, хонь чоно болго-, хагаралдуул-, тулталдуул-, эв тэнжингий нь хагал-, яйралдуул-, хутга-, будлиан тарн-, хэмхэлдүүл-, хоёр үзүүртэй зүү бол-, олон нохойн дунд яс хая-. Н-513

129. ПЕТЬ ГИМНЫ *кому* магта-, магтаж шагшин-, хэлэх сайн үгээ олж яда-, алтан чээжтэй мөнгөн бишгэй гэхээ шаха-.

130. ПЕТЬ (пропеть) ДИФИРАМБЫ *кому, чему*. хэт магта-, тэнгэрт тулга-, магтаад сайн үгээ бара-, цагаан малгай өмсгө-

131. ПЕТЬ ЛАЗАРЯ [*разг. пренебр.*] Заяаныхаа муудгомдо-, заяандаа гомдо-, гайгишан, гиншин заяагүйдээ гутра-, заяагаа хараа-, муу заяанд төрсөн гэх нь халаг.

132. ПЕТЬ ОДНУ И ТУ ЖЕ ПЕСНЮ [*разг.*] улиг болсон юмаа үглэ-, нургиж барагдахгүй, домогтоо улигла-, хэлснээ арван гурав дахи-, бавтна-, чихэнд чийр бол-, дуулахаас дур гутам-,

133. ПЕТЬ ОСАННУ *кому*. Магтахдаа үгээ олж яда-.

134. ПЕТЬ (пропеть) С ЧУЖОГО ГОЛОСА Хүний амаар будаа идэ-, бусдын аманаас будаа идэ-, хүний ам дагууламтгай

135. ПЕТЬ СЛАВУ *кому чему*. Магтан шагшин-, магтан дуулөрнүүлэн магта-, шагшин шааги-.

136. ПЕЧАЛЬНАЯ ИЗВЕСТНОСТЬ муу нэр, муухай нэр.

137. ПЕЧАЛЬНОЙ (не доброй) ПАМЯТИ Үхэл нь дуудсан юм, ёроо ёрлосон хохь нь, үхэх нь болсон амьтан, тэгэж л байвал таарна. Н-973

138. ПЕЧАТАТЬ ШАГ супатал алха-, гулалзтал алха-, лавилзтал алха-, данилзан алха-, гуналзтал алха-, сунхалзан алха-, сунилзан алха-, гуухалзан алха-, тавиг алха-.

139. ПЕЧАТЬ МОЛЧАНИЯ (безмолвия) *буюу* **ПЕЧАТЬ НА УСТАХ** 1. Үг хэлүүлэхгүй, ам ангайлгахгүй 2. Үг ч үгүй дуу ч гүй, дув дуугүй, ам нь үдээстэй шиг, 3. Нам жим

140. ПЕЧКИ-ЛАВОЧКИ *у кого, с кем* Ам амандаа орчих шахах, унаган холбоо бол-, өвөр түрийдээ оролцох шаха-.

141. ПЕЧЬ КАК БЛИНЫ [*прост.*] Хурдан хурдан хий-, шавраар хийж байгаа юм шиг, бариад тавил-, сурамгайлж

142. ПИВА НЕ СВАРИШЬ *с кем* [*прост*] ярна таарахгүй, ам нэгдэхгүй, үг нийлэхгүй, ганзага нийлэхгүй

> **Видно с вами пива не сваришь, поеду один.** За даа ер нь та нартай ярна таарахгүй шиг байна, ганцаараа сажлая даа

143. ПИКНУТЬ НЕ СМЕТЬ [*разг.*] огт зүрхгүй, зүрхээ зүсүүлчихсэн зүрх нь үхсэн, өөрийн толгойгүй, аймхай, тархнараа татуулдаг морь шиг

144. ПИКОВОЕ ПОЛОЖЕНИЕ [*разг.*] Бэрх байдалтай, хэцүүдчихсэн, яалт ч үгүй болсон, нүд хальтрам, өрөвдмөөр, сэтгэл зовмоор, ягтсан.

145. ПИР ВО ВРЕМЯ ЧУМЫ [*перен.*] бэлэвсэн эмийн сэтгэлийг найр хуримаар тамгалах, уйлж байхад нь учры нь асуухын аюул гэгч; ядрахад яр

146. ПИР ГОРОЙ Хаягаараа гарсан найр, нижгэр найр, бялхсан их той, зартай найр, гэр хагарам хуримтай.

147. ПИР НА ВЕСЬ МИР (пир горой) (*шутл.*) Нармай их найр наадам, аймаг хошуугаар дүүрсэн найр, дэлхий бүрхсэн найр, жаран жилийн жаргал хийж, наян жилийн найр хийх, хутга тавилгүй мах идэж, хундага тавилгүй архи ууж, улс хотлоороо найр наадам хийх, хотол даянаараа найрлах, гүрнээрээ цэнгэлдэх,

148. ПИРОГ С КАЗЁННОЙ НАЧИНКОЙ К-36

149. ПИРРОВА ПОБЕДА Дийлсэн эссэн болох, ялснаас ялаагүй нь дээр шахуу юм болох, цэнгээр олж ялангаар гэх

150. ПИСАНЫЙ КРАСАВЕЦ (писаная красавица) төрсөн байтлаа зурсан юм шиг, зургийн юм шиг цэвэрхэн сайхан, зургийн хуар шиг, зүйтэй төрсөн, нүд булааж төрсөн, морьтой хүн бууж харам, явган хүн сууж харам,

151. ПИСАТЬ БИСЕРОМ бичнэ гэж сийлдэг, зурсан юм шиг бичи-, дурайтал нь бичи-, шугамдсан юм шиг бичи-, хорхой хүрэм сайхан бичи-, бичнэ ч гэж бичсэн, сурцтай бичсэн, өдтэй бичиг гэгчээр янзтай сайхан бичсэн, ацаг өргөснь тодорхой, гэ-

дэс тэнцүү, сүүн цацлага жигд, шугамарсан гөлтөй угалзруудаг

152. ПИСАТЬ ВАВИЛОНЫ В-1110

153. ПИСАТЬ КАК КУРИЦА ЛАПОЙ шувууны мөр шиг, хорхойн мөр шиг

154. ПИСАТЬ КРОВЬЮ СЕРДЦА Чин зүрхнийхээ угаас бичи-, сэтгэлийн угаас бичи-, үнэн сэтгэлээ гарга-, цолбон бичи-, нойр хоолоо мартан туурви-, уух идэхээ мартан; унтах нойроо алдан бичи-, алжаалыг умартан бичи-,

155. ПИСАТЬ МЫСЛЕТЕ В-515.

156. ПИСАТЬ ПРОПИСИ *с кого* Үлгэр болмоор (хүн), тэр хүн шиг болсон гэмээр, атаархмаар, хүн шиг хүн, хүний сайн нь, олны хайр хүлээсэн хүн, хүний дур булаасан хүн, өөгүй хүн

157. ПИТАТЕЛЬНАЯ СРЕДА [*геран.*] Өрөхийн өр, дэлгэрэхийн дэвсгэр, сайн ёр, зөв совин.

158. ПИТАТЬ СЛАБОСТЬ *к кому чему* Голын хайртай, зүрхнээсээ амрагла-, сэтгэлээ өг-, үнэнээсээ хайртай, ёстой хайртай, бие сэтгэлээ өгсөн.

159. ПИТАТЬСЯ АКРИДАМИ (и диким мёдом) Өлөн зэлмүүр, мөчиг тачиг хооло- хүрч ядсан, өл залгах төдий, хоног төөрүүлэ-, төдий, өлөн элэг тайлах төдий, өтгөн шүлсээрээ хоол шингэн шүлсээрээ унд хий-.

160. ПИТАТЬСЯ МАННОЙ НЕБЕСНОЙ [*шутл, ирон.*] Хөөлтөй хоолгүй бай-, өлөн живэр ява-, диваны хоолоор хоолло-, өтгөн шүлсээрээ хоол хийж шингэн шүлсээрээ унд хийж бүсээ чанга бүсэл-, гэдэс нь нуруундаа наалдаж ява-

161. ПИТЬ БЕСПРОСЫПУ (без просину) [*разг.*] Мах болмоо согто-, мал болтлоо согто-, ногоортлоо согто-,

162. ПИТЬ (занить) ГОРЬКУЮ [*разг.*] 1. Үхэр шиг уу-, ханахаа мэдэхгүй уу-, мангас шиг уу-, 2. Мах болтлоо уу-, мал болтлоо согто-, ногоортлоо согт-, унатлаа согто-,

163. ПИТЬ (вынить) ГОРЬКУЮ ЧАШУ гашуун зовлон амса-, аль муугаа үзэ-,

164. ПИТЬ КАК БОЧКА Ангасан монголын үнээ шиг, лүү шиг К-53

165. ПИТЬ (выпить) КРОВЬ *чью* Шүүсний нь соро-, муугий нь үзэ-, нухлахын муухайгаар нухла-, зовоолын дээдээр зовоо- С-714

166. ПИТЬ МЁРТВУЮ Үхтлээ уу (архида-), хэмжээ хирээгүй уу-, үхэр шиг уу-

167. ПИТЬ (запить) МЁРТВУЮ ЧАШУ (мертвой чашей) ухаангүй согт-, мал болтлоо согт-, үхтлээ согто-

168. ПИШИ ПРОПАЛО [*разг.*] арга барагдав, гоочий нь барав, цөхрөнгөө барав.

169. ПИШУЩАЯ БРАТИЯ [*шутл.*] Зохиолчид, үзэг нэгтэй ахан дүүс.

170. ПИШУЩИЙ ЭТИ СТРОКИ Зохиогч би вээр, зохиогч миний бие

ПЛАВАТЬ В КРОВИ Цусандаа хутгалда-, цусандаа холиндо-

ПЛАКАЛИ ДЕНЕЖКИ *чьи* [*прост.*] Мөлгө дэмий үрэгдлээ, мөнгө идгүй өнгөрөв, өвөр хоосров.

Он долг не вернёт, плакали наши денежки. (Тэр хүн) өр өхгүй нь ээ, миний мөнгө нохойны хүзүүнд уясан мах шиг болж таарлаа шүү.

ПЛАКАТЬ В ГОЛОС (ёнгинотол хэнгэнэтэл,) уйл-, орь дуу тавьн уйла-, ийн ийн гэж уйла-, цурхиран уйла-, гиншин уйл-, хөгшин чоно ульж байгаа юм шиг, эхэр татан уйла-.

ПЛАКАТЬ (Плакаться) В ЖИЛЕТКУ *кому* [*разг. шутл. пренебр.*] Зовлонгоо тоочи-, долоон булчирхайгаа тоочин үглэ-үглэж дууд-; уйлан донгодо-.

ПЛАКАТЬ НА ГРУДИ *у кого* Цээжинд нь наалдан уйл-, энгэрий нь түшиж уйла-, нулимсаараа элгий (энгэрий) нь дэвтээ-

ПЛАТИТЬ ТОЙ ЖЕ МОНЕТОЙ Ачийг ачаар, бачийг бачаар, хүн ямар бол тийм

ПЛАТИТЬ (заплатить) ДАНЬ *кого чему* Бичин хүртээ-

ПЛЕВАТЬ В ГЛАЗА (В лицо в душу) *кому.* Хүний өөдөөс нулим-, хүний нүүр нулимж доромжило-.

ПЛЕВАТЬ (плюнуть) ДУШУ *кому.* Цусгүй ала-, хүний ёсноос гадуур доромжило-,

ПЛЕВАТЬ В ПОТОЛОК [*разг., шутл.*] Ажлаа алдан суу-, суйлбал маажиж суншаад унтаж дэмий бай-, гиюүрэн суу-, алсын уулын тотгой ширтэ-, гар газар хөл хөсөр, хийх ажлаа алдан хий дэмий суу-, тооноо ширтэн цаг нөгцөө-, тэнгэр ширтэн тэсгий-

ПЛЕВАТЬ ХОТЕЛ *кто на кого что* [*вульг.*] ер тоохгүй, нохой хүнсан чинээ болохгүй.

Плевать, я хотел на его угрозы! Тэрний далайлгах ядаг юм бэ, би ер тоохгүй!

ПЛЕВКА НЕ СТОИТ [*разг. пренебр.*] хүн гэж тоохгүй, ер тоохгүй

ПЛЁВОЕ ДЕЛО [*прост, раш.*] хийж цөхөх юмгүй, чигчий хурууны үзүүрээр хийх ажил, ганц барнад л хийх ажил, аяга цай уухын хооронд хийх ажил

ПЛЕВОК ПО АДРЕСУ *кого* Эс тоомсорло-, доорд үзэ-, хүн шаахгүй, үтээрсэн янзгүй, хэрэгсэх царайгүй, нохойн гөлөг орж ирсэн цандаагүй гэгчээр

ПЛЕСТИ БАСНИ Зохиож яри-, санаанаасаа гаргаж яри-, санаанаасаа бууда-, оргүй бууда-, зала-

ПЛЕСТИ (плесть) ЛАПТИ [*прост.*] мунгинаж гүйцэ-, чулуу хөө-

ПЛЕСТИСЬ В ОБОЗЕ Б-492

ПЛЕСТИСЬ В ХВОСТЕ Сүүл барн-, олноосоо хоцро-, туувар гүйцэхгүй, баас хама-, хөмөөл түү-, хойноос нь чангаа-, төлээнээс нь дүүжлэ-, хормойноос нь угзра-, тоосонд нь ч үгүй, ба-

рааид нь ч үгүй, барза туруугүй хоцро-, хааны морьд хаагуур (хэдийд) өнгөрөв гэгчээр, ижлээ гүйцэхгүй, хавханд орсон зээр шиг.

189. ПЛЕТЕНИЕ СЛОВЕС [*ирон.*] Үгийн хороо, үгэн овоо, үгэн далай

190. ПЛЕТЬЮ ОБУХА НЕ ПЕРЕШИБЁШЬ өндгөөр хад цохихөвөнгөөр хад цохи-, хад мөргөсөн нишигний толгой хагарав гэгч.

191. ПЛЕЧАМИ ПОЖИМАТЬ (пожать) Дал мөрөө хавчи-, (европын хүн юмыг мэдэхгүй гэх буюу ялангуяа эс мэдэн гайхахдаа дал мөрөө хавчигас хийлгэдэг зангилтай. Энэ саная байдлыг монгол хүн их төлөв нүдний харц, царайн байдал дууны өнгөөр илтгэхээс биш тэргэл их хавчиганах зангилтай байдаггүй) *хай бүү мэд тархи* гэсэн шиг санаа юм, толгой сэгсрэ-

192. ПЛЕЧО О (в) ПЛЕЧО үгчилбээс: Мөр (мөртэйгээ) зэрэгцэн уттга нь: 1. Зуузай холбон, эн зэрэгцэн, бөөр нийлэн, суудал зэрэгцэн. 2. Нэг тогоноос хоол идэх, тоонотой гэрт толгой холбож тостой цөлөнд хушуу холбох

193. ПЛЕЧОМ К ПЛЕЧУ П-192.

194. ПЛОТЬ И КРОВЬ *чья.* Яс махны тасархай, хавтгай ясны хэлтэрхий, өөрөөс төрсөн үр, дооросс ойчсон юм, үсэрсэн цус, тасарсан мах, элэг цэгтэй, ах дүүгийн барилдлагатай.

195. ПЛОТЬ ОТ ПЛОТИ, КОСТЬ ОТ КОСТИ *чьей* Яс махны холбоотой, яс махны тасархай. К-466, К-535, 466

196. ПЛОХО, КОГДА СИЛА ЖИВЁТ БЕЗ УМА, ДА НЕ ХОРОШО КОГДА И УМ БЕЗ СИЛЫ хүчтэн боловч ухаангүй бол нэг тусгүй, ухаантан боловч хүчин мөхөсдвөөс бас нэг гачаалтай.

197. ПЛОХО (близко) ЛЕЖИТ *что.* [*разг.*] Хамаг юмаа задгай хая,- (юмаа) дэл сул байлга-, ил сул орхи-, хулгай авчихмаар Б-230

Что плохо лежит, то водит бора в искушение. Юм хумаа дэл сул байлгаж хулгай оруулчихав.

198. ПЛОХО НЕ КЛАДИ [*разг.*] Битгий ундуй сундуй орхи, бүү дэл сул тавь! задгай бүү орхи!

199. ПЛОХО ПЛОХО [*прост*]. Ядахдаа, дор хаяхад, үгүй хаяхад, адаглаад, наандаж, наад зах нь, оргүйдээ л, юу ч үгүй дээ л.

Он плохо-плохо тысячу рублей в месяц за работывает. Дор хаяхад сард мянган рубли олдог.

Плохо-плохо денег хватит ешё месяц. Үгүй хаяхад, мөнгө маань нэг сар хүрэхээр байна.

200. ПЛЫТЬ В РУКИ *разг.* [*неодобр.*] Гарын үзүүрээр ол-, зовлонгүй ол-, төвөггүй хий-, тэгэс тэгэс хийгээд л, олж цөхөхгүй (юм), дор нь олдог, гараад л олдог, зовлонгүй олдог.

Всё ему плывёт в руки. Ямарч юмыг төвөггүй олдог хүндээ.

201. ПЛЫТЬ В ФАРВАТЕРЕ *кого чего. чьей* **ПОЛИТИКИ** Дүйвээнээр дага-, өвсний толгой шиг хаашаал бол хаашаа, чиг байхгүй, дагаж баяса-, сохор нохой дүйвээнээр гэгч, дуурамтгайн долоон ходоод. Б-498, Н-558

202. ПЛЫТЬ (уплыть, уплывать, уходить) СКВОЗЬ ПАЛЬЦЫ (мөнгө) үрэн таран хий-, гарын салаагаар гоожуул-, аль ч үгүй цаца-, даший нь өргө-,

203. ПЛЫТЬ ПО ТЕЧЕНИЮ [*перен.*] эрэг хаашаа бол ус тийшээ, салхины аяар, дүйвээнээр дага-, цагийн аяыг дага-, улирлын эрхэнд баригда-, өвсний толгой шиг хаашаа л бол хаашаа, чиг байхгүй.

204. ПЛЮНУТЬ ДА РАСТЕРЕТЬ [*прост.*] Огт тоохгүй, юманд бодмооргүй, нохойн баас гэж, хяламхийх ч үгүй, харах ч үгүй, тоосон цандаагүй, үтээрсэн янзгүй, хэрэгссэн царайгүй, царай өхгүй, нүүр өгөхгүй, мэнд ус ч үгүй, хар цагаан дуу ч үгүй.

205. ПЛЮНУТЬ (негде) НЕКУДА [*прост. шутл.*] Хөл гишгэх зайгүй, пиг, шиг дүүрэн, хөл орох зайгүй, бөгс эргэх зайгүй, Д-413

Сегодня в театре плюнуть было некуда. Өнөөдөр жүжгийн хүрээлэнд хүн гэж пиг дүүрэн.

206. ПЛЯСАТЬ НА КАНАТЕ 1. Олсны тэнцүүр, дээсэн дээрх тэнцүүр, 2. [*перен.*] Дэн дун, дээсэн дөрөөтэй, дүүжигнэсэн

207. ПЛЯСАТЬ ПОД *чью* **ДУДКУ** [*перен.*] Хүний ая дага-, хүний аяар самбагана-, хүний нохойны мод бол-, хоолойгоо засахад нь ч давхий-, аяын нь аяла- (дага), аяд нь нийцүүл-, царайчла-, харцаар нь бай-

208. ПО АДРЕСУ (сказать, заметить, обратиться и. т. п) *кого* [*перен.*]. . . (хүн) руу (рүү) (үг хэлэ-) (хүн) өөд (яри-)

209. ПО БЛАТУ [*вульг, прост, неодобр.*] Тал тохой татаж, танил талаар, арын хаалгаар, зүй бусаар, нэг л жогорхойтой, нүүр тал хара-, нүүрчлэ-, нэр нүүрээр, өнгөөр,

210. ПО БОКУ [*прост. разг.*] Хойш тавих, орхизна-, азна-, байзна-,

Сегодня все дело по боку. Өнөөдөр хамаг ажлаа орхизнав.

211. ПО БОЛЬШЕЙ ЧАСТИ Б-304

212. ПО БОЛЬШОЙ Ихээхэн томоохон, аривхан, ахиухан, нэмүүхэн

213. ПО ВАШЕМУ Таны тааллаар, таны таалснаар

214. ПО ВЕРЕ И ПРАВДЕ (жить, служить) В-525

215. ПО ВИДИМОСТИ [*прост.*] Харваас, үзтэл . . . бололтой, андашгүй, заяандгүй, хараажийн, үзээжийн, мэдээжийн, нв илхэн, байгаа биздээ.

216. ПО ВИНЕ *кого* . . . ны буруугаар, . . . аас болж, . . . ны харгайгаар , . . ны уршгаар, -гэж нэг юмнаас, . . . ны балгаар, . . . -аас болоод, . . , -аас хөдөгдөөд

Не по его вине. Тэр хүний буруу биш

217. **ПО ВКУСУ** (быть, прийтись и. т. п) Санаанд нийцэ-, сэтгэлд таара-,

218. **ПО ВОЗМОЖНОСТИ (МЕРЕ ВОЗМОЖНОСТИ)** аль болохоор, болох бүтэхээр

219. **ПО ВРЕМЕНАМ** Хааяа, үе үе, байн байн, заримдаа,

220. **ПО ВСЕЙ ВЕРОЯТНОСТИ** Төлөв, голцуу, ер нь л, ээ дээ, бодохоос, . . . нь дийлэнх, зонхи, П-227

221. **ПО ВСЕЙ ФОРМЕ** ёстой юмыг ёсоор нь, ёс ёсондоо, ёл уулындаа, ёстой л нэг, . . . гэж энүүн шиг юмыг л хэлдэг байх цогц, бүрэн, төгс

222. **ПО ВСЕМ ПО ТРЁМ** (ударить) [*разг. перен.*] хайр найргүй, эрээ цээргүй.

223. **ПО ВСЕМ ПРАВИЛАМ ИСКУССТВА** [*разг.*] Номын ёсоор, номын дагуу, гараа гаргаж, үйлийн үргүй зөв,

224. **ПО ВСЕМ СТАТЬЯМ** [*разг.*] Аливгаараа (алиугаараа) ч, ямраараа ч

225. **ПО ВСЕМ ШВАМ ТРЕЩАТЬ** [*разг.*] Үгчилбэл: заадал бүхнээрээ ганхах, утга нь: сүйрч гүйцэ-, зад үсрэ-, нурж-, уна-, сал унаад байгаа

226. **ПО ВСЕМУ** [*разг.*] Аль ч талаараа, ямар ч болсон, яалаа ч, алигуураа ч, цугаарааа, тэр аяараа, тэр чигээрээ, хуугаараа.

По всему видно что он прав. Юугаараа ч гэсэн тэр хүний зөв байна (Аль аль нь түүний зөв).

227. **ПО ВСЕМУ ВЕРОЯТИЮ (ПО ВСЕМ ВЕРОЯТИЯМ)** П-220

228. **ПО ВСЯКИЙ ДЕНЬ** [*прост.*] Өдөр болгон, өдөр тутам, өдөр алгасахгүй, үргэлжид, өдөр бүр, өдөрт л, өдөр өнжилгүй,

229. **ПО ГЛАЗАМ ВИЖУ** Нүдний нь харц бол, нүдий нь харвал, нүдний нь байрыг харваас, харсаар байтал тэр нүд нь.

230. **ПО ГОРЛО** 1. Хүзүүгээр, хоолойгоор, 2. [*перен. разг.*] . . . тэгтэл, ингэтэл, туйлын их, тун их

По горло в воде. ус хүзүүгээр татаж байна.

Сыт по горло Амаараа гартал идлээ, битүүртлээ цадлаа, гэдсээ цүдийтэл, гэзгээ, модойтол мадайтал цадлаа, гэдэс гэрэлтлээ, гэдэс гарлаа.

Дела по горло. Хийх юм үстэй толгойноос их.

Занят по горло. Борив бохисхийх завгүй (ажилдаа дарагдсан, гарч ирэхийн завгүй).

231. **ПО ГОРЯЧИМ СЛЕДАМ** [*перен.*] Шинэ сэрэг дээр нь, халуун дээр нь, цаг мөч алдалгүй завдан, ямагны мах халуун дээрээ гэгчээр, газар авахуулалгүй, хойш тавилгүй, мөн одоохон

232. **ПО ГРОБ** (дней жизни) [*прост. разг.*] Үхэхдээ, амьсгаа хураатлаа, нүд анитлаа.

233. **ПО ГУБАМ МАЗАТЬ** [*перен. разг.*] Амаараа гийгүүл-, гоо ам, сайхан ам, хоосон буян амла-, амаарза хуура- М-8, Н-716

234. **ПО ГУБЕ** (Губом) *кому* [*прост.*] яг таара-, санаанд нийлэ-, эдгээрээ нийлэ-, ганзага нийлэ-, нохой амаараа бий хан гээд.

235. **ПО ДЕЛОВОМУ** Ажлаар нь, үнэн мөнөөр нь, байгаагаар нь, ачир дээр нь, хэрэг дээр нь

236. **ПО ДОБРОЙ ВОЛЕ** сайн дураараа, сайхан сэтгэлээс, урилга, зэллагагүй, уриалгахан, униж туниглүй, уйлъя гэвэл сохроосоо, өгье гэвэл ганцаасаа гэгчээр, сайн хүн санаагаараа гэгчээр, зөв санасандаа гэмгүй санаад, ... гэсэндээ

237. **ПО ДОБРУ ПО ЗДОРОВУ** [*разг.*] Шалавхан, цаг өрөөж, бушуу завдаж, эр биеийнхээ эрүүл дээр, эмээл хазаарынхаа бүтэн дээр, мэнд дээрээ, өдий дайтай байгаа дээрээ

Уходи по добру по здорову. Бушуухан явж үз.

238. **ПО ДОМУ** *чего.* Номын ёсоор, жам ёсоор, жам нь тэр.

239. **ПО ДОРОЖКЕ ПРОТЯГИВАЙ НОЖКИ** Хүчнэж хийх

240. **ПО ДУШАМ** *с кем* **(Гозорить, беседовать и. т. д.)** [*разг.*] Сэтгэлээ сэргэтэл ярилца-, дотроо онгойтол ярилца-, сэтгэлийнхээ үгээ ярилца-, сэтгэлээ тэнийтэл ярилца-, шавиагаа ханатал

Поговорить по душам было не с кем. Сэтгэлээ тэнийтэл ярилцах хүнгүй (шавиагаа ханатал ярих юмсан).

241. **ПО ДУШЕ** 1. (хүний) санаад таарах, сэтгэлд нийлэх, замд таарах, 2. Чин үнэнээсээ, нууж хаах юмгүй,

Ваше предложение мне по душе. Таны санал миний санаанд (бодолд) яв цав нийлж байна.

242. **ПО ЖИВОМУ РЕЗАТЬ** Хүчээр салга-, улаан цайм салга-, албын хүчээр тасал-,

243. **ПО ЖИЗНЬ** Нэг насаар, насан турш (турхаруу, нэг сүүдэртээ)

244. **ПО ЖРЕБИЮ** Шодоод л, шавга татахад, шавганд

245. **ПО ЗАКАЗУ** [*разг.*] Хүний аяар, хүний эрхээр, хүний тэг гэснээр, хэлснээр, зөнгөөр амаар.

Я не могу писать по заказу. Би хүний эрхээр юм (зохиол) бичдэг хүн бишээ.

246. **ПО ЗАСЛУГАМ** Гавъяагаар нь, хийсэн гавъяаны нь их багаар, 2. [*перен, ирон.*] Хирд нь таарсан жавтий хүртээх, хир хирээр нь залхаах, . . . аар нь шан хүртээх, хөхүүлэх г. м.

Наградить по заслугам. Гавъяаны нь их багаар шан хүртээ- (Гавъяаны нь хиреэр хөхүүлэ-).

Наказать по заслугам. Хийсэн ялаар нь цээрлүүлэ- (Гэм зэмний нь дүйцүүл -).

По учить по заслугам. Амсах учиртай ялаа амса-, (Эдлэх учиртай лайгаа эдэл-, (оногдсон үйлээ эдэл)

247. **ПО ЗАСЛУГЕ И ПОЧЁТ** Гавъяа хичнээн бол хүнд төчнөөн, хүртэй бол бариутай, агны хариу жилдээ, аяганы хариу өдөртөө, хүнд тус хийвэл өөрт тус, нөхрийн тус бүтвэл өөрийн тус бүтнэ, цусыг цусаар, усыг усаар, ачийг ачаар, сайн санааны үзүүрт сүү (тос), өглөггүй авлага гэж байдаггүй.

248. ПО ИНЕРЦИИ Сурснаараа, сурсан зангаараа, сурсан юмыг сураар боож болдоггүй гэгчээр, өөрийн эрхгүй, яахын ч аргагүй, өөрөө мэдэлгүй

Делать что по инерции Сурснаар тэгчихэж орхи-,

249. ПО КАКОМУ ПОВОДУ Яалаа гэж? юу боллоо гэж, юу гэж, ямар хэргээр юуны учир

250. ПО КОЖЕ ДЕРЁТ [*прост.*] 1. Чичирмээр хүйтэн, дагжим жихүүн, 2. [*перен.*] Айж чичрэм, зүрх алдам, зүрх хүрмээргүй, нэг л зэвүүн, үстэй толгой арзайм.

251. ПО КОЛЕНО (ПО КОЛЕНИ) [*разг.*] Өвдөгцөө, өвдгөөр татам, борвиор татам, тахилзуураар, тахимаар, шилбээр

Вода по колени Өвдөгцөө ус

252. ПО КОНЯМ! Мориндоо! Мориндоо морд! Дөрөөгөө дөрөөлөөрэй! хөл дөрөөнд!

253. а. ПО КОСТОЧКАМ Р-29

253. ПО КРАЙНЕЙ МЕРЕ (ПО КРАЙНОСТИ) [*прост.*] 1. Ядахдаа, дор хаяад, цөөндөө, багадаа, бага л гэхэд. 2. Цаанадаж, болдоггүй юмаа гэхэд,

254. ПО КРАЙНОСТИ [*прост.*] Адгийн наад зах нь, адаглаад л, наанадаж, дор хаяад

255. ПО ЛИНИИ НАИМЕНЬШЕГО СОПРОТИВЛЕНИЯ [*перен.*] Биеэ зовоолгүй, биеийн амрыг харан, төвөг багатайг бодон, өргөнийг нарийсгаж, өргөстийг зөөллөж, амар хялбары нь бодосгээд, оргүйд орвол ор гээд, нэр болгоод, нэр хаасан болоод ор зүгээр байхаар, төвөг үргуулахгүйг хичээгээд, яршиг тарихгүйг бодоод, дөхмий нь бодоод

256. ПО МАЛОСТИ [*прост.*] 1. Бага багаар, аажуухан, зугуухан, яван яван байн суун, 2. Сайнгүй, муу ч үгүй, зүгээр нэг,

257. ПО МАТУШКЕ (ругать, обложить и. т. д) [*прост, вульг.*] Аль муугаар нь хараа-, муухай муухай хараа-, мэддэг хараалаа уншиж дууса-, улааныг урсга-, хараал нүүлгэ- (тави-)

258. ПО МЕЛОЧИ (мелочам) өчүүхэн ялимгүй, ялигүй, шалихгүй өдүйхөн, итгэхгүй, өчүүхэн төдүй

259. ПО МЕНЬШЕЙ МЕРЕ Цөөндөө, ядахдаа, дор хаяад, бүр үгүй дээ, оргүй дээ, наана хэлж, хоосондоо, зүгээрдээ, сулдаа.

260. ПО МЕРЕ *чего*. . .-ны хирээр, чинээгээрээ, . . . харгалзан, байдгаараа, чадлаараа.

По мере своих сил. Чадлынхаа хирээр (хир чадлаараа хирэндээ), байдаг чадлаараа

По мере возможности. Болохоороо л, болжмоороо л, аль болохоор л, хирээрээ л, болохын хирээр.

261. ПО МЕРЕ ТОГО КАК , . . ынд тэгэхэд ингэхэд

262. ПО МИЛОСТИ *кого* [*разг, ирон.*]-аас болж, . . .-ын хар гайгаар, . . . (хүний) -ач-аар . . .-ын (уршгаар, хөөгөөр балгаар-аас болоод

Много я претерпел по милости этого господина. Энэ ноёнтноос болж би дээ мөн ихээхэн шүү зүдэрлээ дээ.

263. ПО МИНОВАНИИ . . . өнгөрсөн хойно, (хэрэг нь) барагдсаны сүүлээр, . . . магц, . . . нгүүт, . . . хтай зэрэг

По миновании срока. Хугацаа өнгөрсний сүүлээр (хугацаа өнгөрмөгц),

По миновании надобности. Хэрэг нь барагдсан хойно

264. ПО МНЕ [*разг.*] Миний бодоход, миний санахад намайг бодоход, миний хээр (бол), би бол, над бол, бодсоноо хэлчихэд

По мне пускай, что хочешь говори. (Крылов) Намайг бодоход та ярья гэснээ л ярь л даа.

265. ПО МНЕ ПОЖАЛУЙ [*разг.*] Намайг бодоход яах вэ л санзгдаж байна, үгүй зүгээр зүгээр яая гэх вэ, давгүй над бол болох л байна, бололгүй яах вэ, хамаатай юү, болж л орхиж, мөн хөө.

266. ПО МОЕМУ КРАЙНЕМУ РАЗУМЕНИЮ Миний мөхөс ухааны хирээр бол-, би л бол ингэж бодох нь байна, адгийн би бодоход л

267. ПО МОДЕ (одет, сделано и. т. д) цагийн маягаар, маягийг бодон

268. ПО МОЛОДОСТИ ЛЕТ [*разг.*] Залуудаад, балчирдаад, томоогүйдээд

Совершил ошибку по молодости лет Арай л балчирдаад иймэ гэм хийж дээ (томоогүйдээ л алдаж дээ).

269. ПО НАЗНАЧЕНИЮ дурдсанаар, зааснаар, тогтсончилон, хаяг ёсоор нүүрээр нь, нүүрлэснээр нь, хэлснээр нь, хэлсэнчилэн

Вручено по назначению. Хаяг ёсоор нь гардуулав.

270. ПО НАИТИЮ (свыше) [*разг. шутл.*] зөн бэлгээр, амин гүйдлээр, хар аяндаа (мэдэв) санаадгүй мэдэж орхив.

271. ПО НАКЛОННОЙ ПЛОСКОСТИ КАТИТЬСЯ [*перен.*] уруудахад буруудах гэгч бол-, нэг дордоход долоо дордо-, заяаны нь үүд уруугаа хара-, үйлс нь нэгмөсөн барааната-, гарлагы нь үүд онгой-, заяа нь загла-, нэг бүдрэхэд долоо бүдрэ-, мууд муу нэмэр, муухайд улцан нэмэр.

272. ПО НАСЛЫШКЕ Хүний амаар, дам, амьтны амнаас, дам дамаас, давгайдаж, сургаар, чих дэлсэж.

Знать что только по наслышке. Амнаас дам мэдэ-

273. ПО НАСТОЯЩЕМУ Зэгсэн, бузгай, чамгүй, ёсоор нь, номын дагуу, олигтойхон, уухайсдаа гэмээр, овоолдоо гэмээр, хүн шиг, . . . тэгсэн шиг, ажил хийвэл дуустал давс хийвэл уустал, нэр хочгүй, нэр баастахааргүй, өөлөхөөргүй, голохоргүй, чамлахааргүй, болж гэтэл нь

Взяться за работу по настоящему. Ажлаа олигтойхон шиг хий-,

274. ПО НАЧАЛУ [*разг.*] Эхэндээ, бүр анхнаасаа, эхнээсээ.

275. ПО НАЧАЛЬСТВУ (устар). Эрхэм дээдэст, дээдүүлд, эрхтэн дархтан, эвэртэй, сүүлтэйд, 2. Хуулийн газарт, төрийн хүнд, засагт

276. ПО НЕЧАЯНОСТИ Санаандгүй (ийм юм, тоогүй юм) болов, тэгнэ гэж, ингэнэ гэж хэн мэдэх вэ? Санамсаргүй байтал, зүү-

дэндгүй байтал, . . . гэж бодоогүй байтал, тохиолдлоор, гэнэ сэнэгүй, гэнэтхэн

277. **ПО НИТКЕ** [*разг.*] Энэ (тэр) шижмээр, энэ (тэр) чигээр, нэг бүрчлэн,

278. **ПО НИТОЧКЕ РАЗОБРАТЬ** [*разг.*] Нэгэд нэгэнгүй нягтла-, бүр сайн үзэ-, ширхэг ширхгээр, толгой дараалан шүүж үзэ-

279. **ПО НУТРУ** *кому* [*разг.*] Санаанд нийцэх, сэтгэлд таарах, (голцуухан тэгэхгүй шигэхгүй гэж үгүйсгэх үес хэрэг болдог үг).

Это мне не по нутру. Энэ миний санаанд таарахгүй байгаа юм (Энэ ч нэг л биш дээ, энэ ч юу л бол доо).

280. **ПО ОБРАЗУ И ПОДОБИЮ** *кого чего чьему.* Ав адилхан, эгээ нэг, ихэр юм шиг, нэг хэвийн, нэг боовны хэвээр дарсан юм шиг, нэг хэвээр цутгасан мэт.

281. **ПО ОБРАЗУ ПЕШЕГО ХОЖДЕНИЯ** [*шутл.*[Явгаар явсан (явах), хоёр зээрдээрээ, хоёр шаргаараа.

282. **ПО ОБЫКНОВЕНИЮ** Сурсиараа л, бахь байдгаараа л, өнөөх л,

717. **ПОМЕРЕТЬ СО СМЕХУ** [*разг.*] Үхтлээ инээ-, элгээ маарштал инээ-, инээд нь хагачи-, элгээ хөшөө-, (ахар, богино сүүл нь) сүүж нь хугарсан юм шиг инээ-

718. **ПОМЕШАТЬСЯ В УМЕ (в рассудке) М-121.**

719. **ПОМЫЛИТЬ ГОЛОВУ Н-505.**

720. **ПОМИЛУЙ (-ТЕ)** 1. Өршөөж хайрла! 2. [*разг.*] Тэр дэмий, тийм ч биш шүү, тэгж ярихгүй

Помилуйте, мы с вами не ребята! Тэгж ярьдаггүй юм, бид нар хүүхэд биш шүү дээ!

721. **ПОМИЛУЙ БОГ** Тэгэхээ больё доо, байя чи минь, үүнээс хойш түүнээс цааш, больж үхье, чадашгүй ээ.

722. **ПОМИНАЙ КАК ЗВАЛИ** Сураг таг-, сураг чимээгүй, аг чи бол-, таг чиг бол-, хурга авсан чоно шиг бол-, хэл улгүй бол-

723. **ПОМИНАТЬ ДОБРОМ** [*разг.*] Сайны нь сана-, ачий нь сана, тусы нь бодо-.

724. **ПОМИНАТЬ ЛИХОМ** *кого что.* Өс сана-, муу юм сана-, дотроо муу сана-, муугий нь бодо-, муу санаа өвөрлө-,

725. **ПОМИРАТЬ СО СМЕХУ П -717.**

726. **ПОМНИТЬ СЕБЯ** 1. Санаж (дурса-), 2. Юм цээжил-, юм тогтоо-,

Я помню себя ребёнком. Би бага байснаа санаж байна.

Он помнит себя с четырёх лет. Дөрөвтэйгээсээ юм тогтоодог болов. (тэр чинь дөрөвтэй байсныхаа юмыг мэддэг юм)

727. **ПОМОГАЙ БОГ** Бүтэх болтугай! тэнгэр авраг!

728. **ПО МОЕМУ** Намайг санахад; миний бодоход; намайг бодоход; надаас асуувал: намайг хэл гэвэл; би л юм бол, би бол

729. **ПОМОЩЬ НА ДОМУ** Гэрээр нь эмчилэ-, гадуур эмнэ-.

730. **ПОМЯНИ -(те) МОЁ СЛОВО** [*разг.*] Миний хэлснийг сайн санаж аваарай; за миний хэлснийг марталгүй санаж аваад харж л байгаарай. Чи миний худалчийг хараарай, гайгүй; миний хэлдэг орой руу чинь орох цаг бий, худлаа хэлж хургатай, шар халзан хонь чирч яваагүй юм шүү! **П-771**

Помяните моё слово, он плохо кончит. Цаадах чинь сайнаа үзэхгүй дээ (миний хэлснийг сайн санаж аваад) харж л байгаарай. (Тэр тэгнээ гэж би ёр шиг эс хэллүү).

731. **ПОМЯТЬ БОКА (кому)** [*прост.*] Сүгт нь тултал зодо-, босолтгүй болтол нь зодо-, арьсы нь хуул-, турсгы нь хуул- (өвчи-) цусы нь холи-, мөчий нь тас цохи- мөчий нь санжуул-, нойтон голтой үлдээ-, **Н-430, 506**

732. **ПО- НАШЕМУ** Маны бодож байгаагаар; маныхаар бол;

733. **ПОНИКНУТЬ ДУХОМ П-31**

734. **ПОНИМАТЬ НАСКВОЗЬ В-631, З-337**

735. **ПОНИМАТЬ ТОЛК З-344 В-663**

736. **ПОНУРИТЬ ГОЛОВУ**-Уруу царайл-, толгойгоо ганзгал-, урвайж орхисон; хийморь нь үхсэн, царайгаа хормойл-, нусаа чирэ-; унжийчихээд аз нь хари-, хормойгоо чирэ-,

737. **ПОНЯТИЯ НЕ ИМЕЮ** [*разг.*] Би мэдэхгүй шүү, би үзэг ч гаргахгүй, мэдсэн юм алга, а ч үгүй буу мэд.

Когда уходит поезд? — Понятия не имею. Галт тэрэг хэдийд хөдлөх вэ? Би мэдэхгүй шүү.

738. **ПОНЯТНОЕ ДЕЛО (ПОНЯТНАЯ ВЕЩЬ)** [*разг.*] Мэдээжийн хэрэг; мэдээжийн юм; хэний ч мэдээжийн юм; хүүхэд ч андахгүй юм, тэгж их сүйд болох юм биш, нэг их сүр бадруулах эд биш.

739. **ПОПАДАТЬ (попасть) В ПЕРЕПЛЁТ (в переделку)** Урьханд оро- хайш ч үгүй бол-, хавчигдалд оро-.

740. **ПОПАДАТЬ КАК КУР ВО ЩИ К-116.**

741. **ПОПАДАТЬ МИМО** Онохгүй, чиглэ-, банзанд нь туса-; мэндгүй зөрө-, хасаанд нь биш хананд нь.

742. **ПОПАЛСЯ, ДА ОТОЛГАЛСЯ** Залдаг, даадаг, далан худалч, сүнсгүй худлаа хэлдэг; тэмээг ямаа болгож ярьдаг; хэтрэх ч хүзүүнийхээ тэнд хэтэрсэн далан банага (далан) тасгадах, буудах, гөрөх, галлах, авч алдах, худлаа бурах.

743. **ПОПАСТЬ (попадать) В ИСТОРИЮ В-793**

744. **ПОПАСТЬ В КОЛЕЮ В-794**

745. **ПОПАСТЬ В ЛАПЫ (к кому)** [*разг.*] . . . ны гарт (атганд) ор-, . . . ны саварт атгуул-, . . . ны эрхэнд оро-,

746. **ПОПАСТЬ В ЛОВУШКУ** Урхинд оро-, торонд оро-, саалинд уна-, уургалуул-, урхидуул- мэхэнд авта-, молиго үмхэ-, араараа тавиул-,

747. **ПОПАСТЬ В ЛУЖУ С-382**

748. **ПОПАСТЬ В ПЕРЕДЕЛКУ** [*разг*]. Зовлонд оро-, зовлон болажил гар-, хэрэг манд-, бөөн зовлон, явдал бол-,

749. **ПОПАСТЬ В ПРОСАК** (впросак) Өөрийнхөө муугаас юманд оро-, гэм нь урдаа гэгч бол-, зовлонд оро-, газрын гавт оро-, толгойгоороо ус уу-,

750. **ПОПАСТЬ В РУКИ** П-745, П-764

751. **ПОПАСТЬ** (попадать) **В САМУЮ ЖИЛКУ.** Гавы нь тааруул-, оноож буудаг; онилы нь тааруул-,

752. **ПОПАСТЬ** (попадать) **В САМУЮ ТОЧКУ** Яг оно-, мэнгий нь голло-, нүдий нь ол-: голд нь оно-, мэргэн тааруул-, хар хулхинар нь хий-. У-34

753. **ПОПАСТЬ** (попадать) **В ТОН** *кому* [*перен.*] Аяд нь нийлүүлж яри-, таалалд нь таарсан үг хэлэ-, санаанд нь ганц болсон юм дуулга-, загатнасан газар нь маажсан шиг үг хэлэ-, чихэнд нь чимэг болсон юм өгүүл-.

754. **ПОПАСТЬ** (попадать) **В ЧЕСТЬ** *к кому* иттгэл хүлээ-; итгэмжлэгдэ;

755. **ПОПАСТЬ** (попадать) **НА ЗУБОК (ЗУБ)** *кому* Амьтны элэг доог бол-, хүний шившиг бол-: хэл аманд идэгдэ-, хов живэн ороогдо-;

756. **ПОПАСТЬ** (попадать) **НА СЕДЬМОЕ НЕБО** Магнай хагартал баярла-, сүүрс алдаг баяс-,

757. **ПОПАСТЬ НА СКАМЬЮ ПОДСУДИМЫХ** Заалдагда-, шүүхэд байцаагда-, Гэмт хэрэгт баригда-, ялтны ширээнд суу-, С-388

758. **ПОПАСТЬ** (попадать) **НА ЯЗЫК** *кому, к кому* П-763

759. **ПОПАСТЬ** (попадать) **ПАЛЬЦЕМ В НЕБО** [*разг., ирон.*] Оноогүй тараагүй, хавьтаагүй; хавирагүй; мэндгүй зөрө-, шагайлгүй бууда-, байнд байтугай банзанд нь үгүй, давуул- гудруул-,

760. **ПОПАСТЬ** (попадать) **ПОД БАШМАК** Эхнэрийнхээ эрхэнд атганд оро-, эхнэртээ толгойгоо мэдүүл-, эмдээ азрагалуул-

761. **ПОПАСТЬСЯ** (попадаться) **НА ГЛАЗА** (в глаза) *кому* Харж орхи- нүдэнд туса-, нүдэнд өртө-, нүдэнд харагда-, нүдэнд үзэгдэ-, дайралда-, байж бай-.

762. **ПОПАСТЬСЯ** (попадаться) **НА УДОЧКУ** Урхинд оро-, урхинд авта- саалинд уна-, гал дээр гишгэ-, нүхэнд ойчи-, арганд авта- уруу татагда-.

763. **ПОПАСТЬСЯ НА ЯЗЫЧОК** *кому* Ярна бол-, хүний хэлэл нохойн хуцал бол-, дэвэн дэлхийгээр нэг ярна бол-, хот хүрээ- (айл саахалтаар) нэг ярна бол-, амтай бүхэн ярь-, амьтан л ярнад байна, амьтны хэл ам угаа-.

764. **ПОПАСТЬСЯ** (попадать, попасть) **ПОД РУКУ** *кому* [*разг.*] гарт орж (ороод) ирэ-, гарт (нь) оро-. П-498

765. **ПОПЕРЁК ГОРЛА СТАТЬ** *кому* [*разг.*] Хоолой дээр юм тээглэсэн юм шиг; бүлхи залгисан юм шиг бай-, сэтгэлийн зангилаа бол-, атгын чинээ бол-, яая даа байз гэмээр бол-.

766. **ПОПЕРЁК ПУТИ** *кому* С-881.

767. **ПОПЕРЁК СЕБЯ ТОЛЩЕ** (шире) [*разг.*] Бөөрөнхий болтол таргалсан, голийтол таргалсан, харвин нь унжсан; нүдээ чийхийтэл таргалсан, боодог шиг, хамраа шигдтэл таргалсан, (нохой дээр бол) зоолсон, (морин дээр бол) оноо суусан, (тэмээн дээр бол) туг ширээ; хом суусан, (хүүхэд дээр бол) мяраалсан, мал дээр бол хүчилсэн тэвээрсэн, өөхөлсөн, сэмжилсэн.

768. **ПОПЕРЁЧНАЯ МУКА** Будүүн гурил

769. **ПОПЛАТИТЬСЯ БОКАМИ** [*прост.*] Үхтэлээ зодуул-, жавтий хүртэ-, гувшүүл-, өвчүүл-, хуулуул-.

770. **ПОПОВСКИЕ КАРМАНЫ** [*разг. шутл.*] Шулхаганасан халаас (уут), гонжирсон (гоширсон) халаас, тулман халаас.

771. **ПОПОМНИ МОЁ СЛОВО** [*разг.*] П-730.

772. **ПОПРАВИТЬ СЧАСТЬЕ** [*разг.*] Хазайсны нь түшилж, хагарсны нь битүүл-, дундыг дүүргэн, дутууг нь гүйцээ-.

773. **ПОПРАВЛЯТЬСЯ ИЗ КУЛЬКА В РОГОЖКУ** [*прост.*] (Өвчтөн) засал авдаггүй ээ; гордлого тасарч байна.

774. **ПОПРОСТУ БЕЗ ЗАТЕЙ** Жир нэг; ер нэг; илүү дутуу юмгүй, дэл сүүл нэмэлгүй, давс хужир хийлгүй, нэмэр хачиргүй, алтдаж будалгүй, алт өргөлгүй.

775. **ПОПЫТКА-НЕ ПЫТКА, СПРОС-НЕ БЕДА** Үгчилбээс асуусны аюул гэж үгүй; лавласны лай гэж үгүй, бурууг хэлж зөвийг дуулах.

776. **ПОРА (надо) И СОВЕСТЬ ЗНАТЬ** Одоо болино байхаа, дэндэж байгаа юм биш үү? Тэгмээр дээ, дааич.

777. **ПОРА И ЧЕСТЬ ЗНАТЬ** [*разг.*] 1. Ирсэн гийчин буцдаг, орсон бороо арилдаг, долоо хоног болж үнэ хүндээ бара-, 2. Цаг нь болжээ. Тэгэх ийм нь болжээ, ёстой юм ёсоороо Н-440

Уже поздно (нам) пора и честь знать. Орой боллоо ирсэн гийчин буцдаг, орсон бороо арилдаг гэж үг бий харья аа.

Что же? Пожила старушка. Пора и честь знать. (Чехов) Одоо яах вэ дээ? Эмгэн өтөлж гүйцжээ, одоо ч сажилсан нь дээр шахам болж дээ. Эмгэн ч дор оржээ, одоо сажилваа барж.

778. **ПОРА НА БОКОВУЮ** Хажуулах (унтахаар хэвтэ-); ташаалда-, хавиргалда-, ойчоод өг-,

779. **ПОРА НА СМЕНУ** *кого-что* Солигдвол таарах болж; халаатай байвал дээр, эзний алба ээлжтэй хаяны алба халаатай, ирсэн гийчид буцаж, орсон бороо арилдаг. Шинэ юм зул болж хуучин юм ул болдог, түрүүч нь сүүлдээ зай тавьдаг.

780. **ПОРАЖЕНИЕ ТОКОМ** (человека) Цахилгаанд цохиулаж, зайд дайрагдах, гүйцэнд дайрагдах.

781. **ПОРВАТЬ ДОГОВОР** Үгчилбээс: гэрээсээ урж хая-, утганы гэрээнд авсан амлагаа (үүргээ) хөсөрдүүлэ-(зөрчи-), итгэлийг эвдэ-, алгаа буца-, үгээ буца-, амалснаа няца-,-андгайлснаа няца-,

782. ПОРОДА ЛЮДЕЙ Хэсэг амьтад; тиймэрхүү (иймэрхүү) улс; . . . ший л шиг, . . . ний хамаганыхан

783. ПОРОЗНУ ДУМАТЬ-ВМЕСТЕ НЕ ЖИТЬ Ёс ёсоороо ёсоо дүйзээрээ; ёс ёсондоо ёл ууландаа, ёс ёсоо дагадаг. ёр муугаа дагадаг, ёсыг бурхан дагадаг, ёрыг чөтгөр дагадаг; санаа зөрвөл салахын тэмдэг, жанжин ч жамыг дагана, мөрөн ч эргээ дагана

784. ПОРОТЬ (нести) АХИНЕЮ [*разг.*] Хамар дор хагархай зураас гэж чалчи-, ам мэдэн донгосо-, хагархай хэнгэрэг шиг, бн л амтай нь гэсэн шиг; амаа олохгүй бура-. Н-1010

785. ПОРОТЬ ГОРЯЧКУ [*прост.*] Сандан мэндэн; нурман дээр гишгэсэн юм шиг, түймэрт хөөгдсөн юм шиг; сүрэн паран.

786. ПОРОТЬ ЕРУНДУ (вздор, дичь, чушь и. т. п.) -Н—784

787. ПОРОХ ДАРОМ ТРАТИТЬ [*разг.*] Д-59

788. ПОРОХА НЕ ВЫДУМАЕТ Ухаанд гойд юм орохгүй. ухаан сайн гүйхгүй; ухаанд юм нь ив гэтэл орохгүй.

789. ПОРОХОВОЙ ПОГРЕБ Дарины хөмрөг; [*перен.*] юу ч болж магадгүй газар; есолтой орон нутаг, аймаар газар,

790. ПОРОХОМ ПАХНЕТ Үгчилбээс: дарь үнэртэв, утга нь дайн болохын шинж оров, байдаан гармаар болж ирэв, цаг цэвүүрэв, дайн дажин дэгдэхнйг ёрлов.

791. ПОРОХУ НЕ НЮХАЛ Буун дуу дуулаагүй; дайны хал үзээгүй; байлдааны зовлонг амсаагүй; зуутад багтаж дай дарах нь биттий хэл зурамны хамраас цус гаргаж үзээгүй, дайн самуунгүй, дайн дажингүй.

792. ПОРОХУ НЕ ХВАТАЕТ *буюу* **ПОРОХУ НЕ ХВАТИЛО** *у кого* шон хүрэхгүй, сачий хүрэхгүй, барж идэхгүй, чөмөг нь гүйцэхгүй

793. ПОРОЧНЫЙ КРУГ 1. Давтан эргэх ёс. 2. Нэг газраа эргээд бай-, гарах замгүй, нэг л байрандаа орчиж байх,

794. ПОРТИТЬ (испортить) ВСЮ ОБЕДНЮ кому [*прост.*] Гүйх нохойд гүйхгүй нохой саад бол-, нэгмесөн баллаж хая-, (бүр) будлиан хутгаад хаячи-.

795. ПОРТИТЬ КРОВЬ *кому* [*разг.*] Зүрхий нь хөдөлгө-(хөөрүүл) шары нь хөдөлгө-, дайран дээр нь давс хий-, ууры нь хүргэ-, гижгий нь хүргэ-, хөндүүрий нь хөндө-, эвэршээлий нь самарда-, хамры нь сөргө-, хаданд нь гарга-, галзуу нохойд салхи гэгчээр,

796. ПОРЫТЬСЯ В ПАМЯТИ [*разг.*] Санаж яда-; санахыг хичээ-, бодъё бодъё гэ-; байз уу юу билээ гэж духаа үрчийлгэ-,

797. ПОРЯДОК ВЕЩЕЙ *буюу* **СУЩЕСТВУЮЩИЙ (ОБЫЧНЫЙ) ПОРЯДОК ВЕЩЕЙ** Нэгэн хэвийн; ерийн байдал; байдгаараа, янзандаа хэвээрээ, хэв хэмэндээ, хуучнаараа,

798. ПОРЯДОК ДНЯ Хуралд хэлэлцэх зүйлс

799. ПОРЯДОК ДУША ВСЯКОГО ДЕЛА Үгчилбээс: эмх журам гэдэг бол ямарваа ажлын амин сүнс мөн. Юун түрүүн дэс дараалдаа чухаг.

800. ПОСАДИ СВИНЬЮ ЗА СТОЛ, ОНА И НОГИ НА СТОЛ [*шутл.*] Даварсаар даварсаар Дагийн сууринд, гар бариад бугуй барьдаг. ид ид гэдэг хүний ёс, ид гэсэн бүгдийг идэг гахайн ёс; ат авдаг; дэнэмгий; хойноос ирээд хот минийх, хотонд ирээд хуц минийх, хойморт гараад гэр минийх, шунал ихдэж шулам болох

801. ПОСАДИТЬ НА МЕЛЬ 1. Хайрда- 2. [*перен.*] Элс үмхүүлж эрэг мэрүүл-; үнсэнд хаягдсан шалз шиг болго-, улаан хады нь мөргүүл-.

802. ПОСАДИТЬ В ГАЛОШУ [*прост.*] Хаашаа үгүй бол-, гацаж орхи-, дээшээ тэнгэр хол, доошоо газар хатуу; ихээ алдсан огтоно шиг бол-,

803. ПОСАДИТЬ НА КОЛ *кого* [*истор.*] Европ газар эрт дээр цагт хэрэглэж ирсэн нэгэн зүйл залхаан шийтгэл, монголд хувьсгалын өмнө хэрэглэж байсан мөглөн, хумсны завсар хүлс шаах зэрэг эрүүдлэгтэй төстэй зүйл.

804. ПОСАЖЁНАЯ МАТЬ Хуримын ёслол үйлдэж байх үед эхнйг төлөөлж хуриманд оролцож буй хүнийг орос хэлэнд ийн өгүүлнэ. Эхийн оронд эх болсон, хуурай худгуй, хуурай хадам, хуурай эх гэх шиг.

805. ПОСАЖЁНЫЙ ОТЕЦ Мөн ёслол хийж байх үед эрэгтэй буюу эмэгтэйн аль нэгний эцгийг төлөөлөн оролцож буй эцгээд, эцгийн оронд эцэг болсон, хуурай эцэг, хуурай худ, хуурай хадам.

806. ПО-СВОЕМУ Дураараа, өөрийнхөөрөө, санасаараа, хирдээ, зоргоороо, бас ч гэж,

Поступить по-своему. Дураараа аашила-
Эта картина по-своему хороша. Энэ зураг хирхэндээ бузгай юмаа (Энэ зураг аминдаа аятай байна шүү.)

807. ПОСКОЛЬКУ . . . постольку . . . Тэгсэн л бол тэгэх, нигэсэн л бол нигэх; тэгсцээс болж тэгэх, нигэснээс болж нигэх, хичнээн л . . ., тэчнээн л; . . . тэх тусам . . . тийм;

Поскольку он хорошо занимается, постольку и результаты хорошие. Хичнээн л хичээж тэчнээн л үр гарнав.

808. ПОСЛЕ ДОЖДИКА (дождичка) В ЧЕТВЕРГ [*разг. шутл.*] Хожим хэзээг хэн ч мэдэхгүй; тодүйд тэгнэ гэх хугацаагүй; цагийн баримжаагүй тэгнэ- гэхийн тэмдэггүй, тэгнэ гэхийн онолгүй ор тас үгүй.

809. ПОСЛЕ УЖИНА ГОРЧИЦА [*разг.*] Мордсон хойно нь таваг тавих, өнгөрсөн бороony хойноос эсгий (хэвнэг) нөмрөх, нпргэсэн хойно нь хашгирах, өглөө болсон хойно өвсөн мануухай босгох, нидэрсэн хойно шудрах, үүр цайсан хойно мануухай босгох, [*неодоб р.*] ушгасан хойно нь хавчих,

810. ПОСЛЕДНЕЕ ПРОСТИ (сказать) Өнид сал-, талийгаач бол-, толгойгоо түшүүл-, ясаа бариул-,

811. ПОСЛЕДНЕЕ СЛОВО *чего* шинэ нээлт; шинэ нээмт,
Последнее слово техники. Техникийн шинэ нээлт. (ур зүйн шинэ нээлт)

812. ПОСЛЕДНИЕ ВРЕМЕНА (настали, наступили) [*разг.*] Өнгөрдгийнхөө дааванд хүрэв; хэцүү цаг болов.

813. ПОСЛЕДНИЙ ИЗ МОГИКАН Унтарсан галд уриагүй, гал нь буурсан эр; больж гүйцсэн амьтан, өөдөө барсан амьтан, шувтрага нь

814. ПОСЛЕДНЯЯ СПИЦА В КОЛЕСНИЦЕ 1. Холбоо (холбогдол) багатай; будааны хүн; ар жабдангийн хүн, лам олдохгүй бол буцахдаа залах гэгч; 2. олдохгүйд мундахгүй,

815. ПОСЛЕДНЯЯ СТАВКА Эцсийн ганц арга; сүүлчийн арга; гомдлын мөр; дэмийгээс дээр, үхэхдээ үхэр буу гэгч, дуугүй сууxаар дуглаж суу-, ноёнд шалаа айлтгаад уна-.

816. ПОСЛЕДНЯЯ ЧЕРТА [*перен.*] Цаад зах, эцсийнх, адаг нь

817. ПОСЛУЖИТЬ ПОВОДОМ *к чему* Шалтаг; шалтаг бол-, аян шалтаг, сайхан шалтаг; далим сэжүүр гар-, дургүйд хүчгүй, айхын чихэнд ууль, айхад аргал хөдлө-,

818. ПОСЛУШАТЬ ЧЕСТЬЮ Дуулгавартай; дуртайдаа, зөөлөн чихтэй, уриалгахан, С-669

819. ПОСМЕИВАТЬСЯ В БОРОДУ С-567.

820. ПОСМЕИВАТЬСЯ В КУЛАК Битүүхэн инээ-, жуумалза-, түг түг инээ-, мушилзан инээ-,

821. ПОСОЛОМ ЩИ СЛАДКИ Давс шорвог боловч идээний амтанд тустай.

822. ПОСПЕШИШЬ ЛЮДЕЙ НАСМЕШИШЬ [*шутл.*] Санд мэнд; бушуу туулай боривондоо баастай; яарахад даарах.

823. ПОСТАВИТЬ БАНОЧКУ [*перен. прост.*] юм (архи сархад) жаахан уу-, балга-, оочи-.

824. ПОСТАВИТЬ В ИЗВЕСТНОСТЬ *кого* мэдэгдэ-, мэдээлэ-,

825. ПОСТАВИТЬ В ПОЛОЖЕНИЕ Тийм ийм болго-, тэгж ингэтийм ийм байдалд оруул-, тийм, ийм байдалд хүргэ-.

826. ПОСТАВИТЬ В РАМКИ Өсөж өрнөхгүй, боовны хэв шиг (байлга)-, бууринаасаа ховхрохгүй.

827. ПОСТАВИТЬ В ТУПИК (втупик) Тэвдүүл-, аргы нь баруул, цөхрөнгий нь бара-, хөхөлзүүл-, мухардуулах-, С-774

828. ПОСТАВИТЬ В УГОЛ (хүүхдийг залхааж) буланд суулга-.

829. ПОСТАВИТЬ (перевернуть н. т. д.) ВВЕРХ ДНОМ [*разг.*] Эмх замбараагий нь алдуул,- ундуй сундуй болго-, эх толгойгүй болго-, тэмээ туйлсан юм шиг болго-, бөгс толгойгүй, толгой түрүйгүй, эх адаггүй.

831. ПОСТАВИТЬ К ПОЗОРНОМУ СТОЛБУ П-982

832. ПОСТАВИТЬ К СТЕНКЕ *кого* [*разг.*] Буудан ала-, цаазаар аваачи-, хороо-, подхийлгэ-, аяын нь ол-, цааш нь харуул-, нас баруул-, бодий нь хөтөл-, мааны нь уншн-, зүйл дууса-,

833. ПОСТАВИТЬ КРЕСТ на ком-чем Зүйл дуус-, нэг тийшээ бол-, хэлтгийрэ-, горьдлогогүй бол-, цэглэ-.

834. ПОСТАВИТЬ НА ВИД что кому Сануулж хэлэ-, санамж өг-, ягуулан сэнхрүүл-.

835. ПОСТАВИТЬ НА КАРТУ С-785

836. ПОСТАВИТЬ НА КАРТУ ВСЁ Үзээд алда-, тэнсээд үзэ-, зориглоод алда-, яадаг бол яадгаа үзэ-, үзэж алдаж үсэрч наалда-, зүгээр хаяхаар зүлгэж хая-,

837. ПОСТАВИТЬ НА (свое) **МЕСТО** *кого* Хирээ мэдэсхий-, хирэйхэн байгаарай-, тааруухан байгаарай.

838. ПОСТАВИТЬ НА КОЛЕНИ *кого* Буулгаж ав-; сөгдүүл- атгандаа оруул-, -уул-, -үүл-, гарын дор болго-.

839. ПОСТАВИТЬ НА НОГИ [*разг*] 1. Эдгээ-, (эмчлэн) босго-, (анагааж) хүн хий-, 2. хүн болго-, хүн хий-, хөмүүжүүл-, гары нь ганзаганд хөлий нь дөрөөнд хүргэ- С-788

840. ПОСТАВИТЬ НА ПУТЬ Замы нь зааж өг-, (зөв) замд нь оруулж чигий нь зааж өг-, дөрий нь олгож өг-, зааж зурж өг-, мэргэн багш нь бол-.

841. ПОСТАВИТЬ НА СВОЁ МЕСТО *кого* [*перен.*] Хирий нь мэдүүл-, бяры нь танпуул-. У-72

842. ПОСТАВИТЬ ПО (под) РУЖЬЁ Өвч (бүрэн) зэмсэгтэй нь зогсоож (шийтгэ-)

843. ПОСТАВИТЬ РЕБРОМ (вопрос и. т. п.) Түс тас хэлэ-, шулуухан яри-, палхийтэл хэлэ-, улаан цайм хэлэ-.

844. ПОСТАВИТЬ РЕБРОМ ПОСЛЕДНЮЮ КОПЕЙКУ [*разг.*] Түрийвчээ хоосло-, өөрөө гүвэ-, уутаа гүвэ-, байдаг мөнгөө нэгмөсөн хуйхла-, аль байдгаа бара-, . . .-д хамаг байдаг бэлээрээ нүүчи-; тоолдгоо тоолоод бара-, гар дээр тавьдгаа арилгачи-, байдгаараа гараа угаа-,

845. ПОСТАВИТЬ РУЖЬЕ В КОЗЛЫ Буу шөрөглө-, буу шөргөлөн босго-

846. ПОСТАВИТЬ СВЕЧУ (богу, святому и. т. п.) . . .дуул өргө-, . . . д зул бари (мандаа)-, лаа бари-,

847. ПОСТАВИТЬ СЕБЯ *как* (Өөрөө буюу өөрийгөө тийм ийм бай-) байлга-, ява),

848. ПО-СТАРОМУ Янзараа; хуучнаараа; байдгаараа; хэвээрээ, (хэв) янз ндаа, нөгөө-, хөрөө-

849. ПОСТНОЕ МАСЛО Ургамлын тос

850. ПОСТНЫЙ САХАР Жимсний чихэр

851. ПОСТОЛЬКУ ПОСКОЛЬКУ [*перен.*] Албагүй; лавтай биш; яаж ч магадгүй; итгэлгүй; хаанаа ч болох болзогүй; болзошгүй; хорнулгүй, мэдэшгүй; оншлгүй; онолгүй; яахаа ч ядахгүй.

Он с нами постольку поскольку. Бидэнтэй явж ч магадгүй үгүй ч байж магадгүй.

852. **ПОСТОЛЬКУ, ПОСКОЛЬКУ** . . . . . тийм ийм хэмжээгээр; тэхүйц, ингэхүйцээр ч.

Он помогает людям лишь постольку, поскольку это представляет выгоду для него самого. Өөртөө л ашиг болохуйцаар л хүнд тус болдог хүн шүү.

Постольку, поскольку это необходимо. Тэгэхгүй л бол болохгүйгээр л; байваас зохихоор нь л

853. **ПОСТОЯТЬ ГОЛОВОЮ** (Хар) толгойгоороо (биеэрээ) даа- (харнуца-), амиараа сахин хамгаал-

854. **ПОСТОЯТЬ ЗА СЕБЯ** Амиа хамгаал- (хайрла-), өөрөө өөрийгөө бодо-, Биеэ хаацайл-, аминдаа арчтай, амиа хоохойл-

855. **ПОСТОЯЛЫЙ ДВОР** Тэрэгний нүүз.

856. **ПОСУДИ (сам)** *буюу* **ПОСУДИТЕ** (*сами*) Өөрөө л (сайн) бод л доо; өөрсдөө л бод л доо, өөрснөө л сайн тунгаа даа

Посуди сам, можно ли так поступать. Ингэж (чингэж) болох юм уу үгүй юм уу сайн бод л доо.

857. **ПОСЫПАТЬ ПЕПЛОМ ГЛАВУ** Гансарч гашууда-, үсээ ура-, гунгин гутра-, дотор гонсой-, гүн энэлэлд учра-, унжийж урвай-, уруу царайлж усан нүдлэ-

858. **ПОТ ЛЬЁТСЯ (катится) ГРАДОМ** (хар) усан хулгана бол-, хар хөлс цутганам-.

859. **ПО-ТВОЕМУ** Чинийхээр; чиний бодлоор; чиний барилаар

860. **ПОТЁМКИНСКАЯ ДЕРЕВНЯ** [*ирон.*] Гаднаа гяланцаг, дотроо паланцаг; өнгий нь алтадсан; гадаад байдал нь толт тогос, дотоод байдал нь шалбааг намаг, нүд хуурах юм, үзлийн юм

861. **ПОТЕРЯ СОЗНАНИЯ** Ухаан алдах, муужрах, агуурах,

862. **ПОТЕРЯТЬ АППЕТИТ (к чему)** (Ямар нэгэн юманд) дургүй бол-, сонирхохоо бай-, сонь нь буура-, сонин дээрээ соохолзоод сониноо буурахаар гөөхөлзөх гэгчээр, дур гута-, тээр шаа-

863. **ПОТЕРЯТЬ ВЛАСТЬ НАД СОБОЙ** Биеэ барихгүй бол-, эс тэвчи-, тэсэж чадалгүй хөл алда-.

864. **ПОТЕРЯТЬ ГОЛОВУ** Ухаан алда-, өөрийн (ухаангүй) мэдэлгүй бол-.

864. а **ПОТЕРЯТЬ ГОЛОС** Хоолойгүй бол-. хоолой мууда-, хоолой өнгөрө-, хоолой сөө- Т-86

865. **ПОТЕРЯТЬ ИЗ ВИДУ** Т-87

866. **ПОТЕРЯТЬ ЛИЦО** Нүүрээ бара-, хөөдө-, нэр нүүрээ бара- (ширлэ-), ичгүүрээ дэлгэ-, амьтны шившиг бол-, нүдний булай бол-, ичмээр юм бол-, ичих нүүрэндээ илгэ наа-, айх нүүрэндээ адсага наа-, хүний нүүр (царай) харалтгүй бол-, нүүрээ түлэ-

867. **ПОТЕРЯТЬ НИТЬ (мыслей, рассуждений и. т. п.)** *чего* Үг хэл ороолдо-, дэс даралдаагүй ухаан; ороолдож хоцорсон утас

шиг, нүл налхий-, эг (ийг) маг (мааг) хий-, хойно урд нь оруулж яри-, уймарч гүйцэ-.

868. **ПОТЕРЯТЬ СЕБЯ** Аль ч учраа олохгүй хий уймра-, тэвдэж сандчзад хөл алда-, агада-, бажигада-, барьц алда-, мэгдэ-.

869. **ПОТЕРЯТЬ СЧЁТ кому чему** Тоогүй олон тоолошгүй тоолж барамгүй; түг түмэн; тоо алдам.

870. **ПОТРЯСАТЬ ОРУЖИЕМ** Б-438

871. **ПОТЕРЯТЬСЯ КАК ИГОЛКА В СЕНЕ (в стоге сена)** Ор сураггүй бол-, алга бол-, олдохоо бай-, газрын гаваар оро-.

872. **ПОТОМ ВИДНО БУДЕТ** Т-43

873. **ПОТОМ И КРОВЬЮ** [*перен*] (Өөрийн) хөлс хүчээр; хар хүчээр. биенйн чадлаар; үйлээ үзэж үсээ тоолж явж; хөлс хүчээ барж явж.

874. **ПОТУПИТЬ ВЗОР** Доошоо гөлий-, сүү долоосон гөлөг шиг; чонын бэлтрэг шиг; доошоо гөлөлзө-, хулгайч нохой шиг; гэмт хүн гэрийн цаанаас дайрт морь даваан цаанаас.

875. **ПОХВАЛЬБОЙ НЕ ГОРОДА БРАТЬ** Магтсан хүний малгай нь хазгай, маттуулаад өөдөлдөггүй, муушаалгаад урууддаггүй маттахыг маргааш, малтыг өнөөдөр-, магтсан хүүхэн хуриман дээрээ . . . цуутай хүүхний хурим дуутай тэнгэрийн бороо.

876. **ПОХОЖЕ НА ТО ЧТО . . .** [*разг.*] . . . (тийм ийм) бололтой; . . . тийм ийм шиг; тиймэрхүү иймэрхүү

877. **ПОХОРОНИТЬ ЗАЖИВО 1.** Амьдаар нь ала-, (сүнсгүй) цусгүй ала-, **2.** Амьды нь идийг хийлгэхгүй; хааш нь ч хөдөлгөхгүй; зад бари-; тушаатай юм шиг.

878. **ПОЦЕЛОВАТЬ ЗАМОК** (пробой) [*шутл. прост.*] Цоожтой хаалга мөргө-, цоож мөргө-, дух хавда-, үүд мөргө-, эзгүйд нь таара-, хоосон буца-, ирснээрээ сурснаа дуула-,

879. **ПОЦЕЛУЙ НУДЫ** Өнгөөрөө хуур-, хөөрхий нь ихдэ-, сайн хүн бол-, [*перен.*] Хойгуур нь тави, араар нь тави-,

880. **ПОЧВА КОЛЕБЛЕТСЯ ПОД НОГАМИ** *чьими, у кого* дэн дун, дээсэн дөрөөн дээр.

881. **ПОЧВА УХОДИТ (ускользает) ИЗ-ПОД НОГ.** Ул муутай бож-, суургүй бож-, доогуураа хөндийлүүж-.

882. **ПОЧВЫ ПОД НОГАМИ (под собой) НЕТ,** Суурьгүй, улгүй дэвсгэргүй, түшиг тулгуургүй.

883. **ПОЧЁМ ЗНАТЬ** Яаж мэдэх вэ яаж ч магад, хэн мэдэх вэ.

884. **ПОЧЁМ ЗРЯ (врать, ругать и. т. п.)** (*прост. вульг.*) Хамаа намаагүй; учир начиргүй, эв хавгүй; бодлогогүй, ойворгон

885. **ПОЧЁМ ФУНТ ЛИХА** Үйлийн үр гэдэг хэцүү юм даа; үйлийг биеэрээ амсана гэдэг (хэцүү). хал үзэж дол цохих

886. **ПО ХОРОШЕМУ** Эвтэй, эвлэг, эвээ нэг хийж, нийцвэртэй, эвтэй, найртай!

887. **ПО-ЧЁРНОМУ** Ч-64

888. ПОЧЕСАТЬ ЯЗЫКОМ [*прост.*] Дэмий яри-, хэл амаа урчих гэж; далан үг дэлгэ-, долоон (есөн) жорын юм яри-, зуун долоон үг дэлгэ-, үг нь олдож үхэр нь холдо-. Я-29

889. ПОЧЁТ И УВАЖЕНИЕ [*прост.*] (Золгох. уулзахдаа хэлдэг мэндийн ёсорхуу үг) амар айлдаж байна уу? Тавтай морилж байна уу?

890. ПОЧИН ДОРОЖЕ ДЕНЕГ Үгчилбэл: Албан тушаал алтнаас үнэтэй, эрх тушаал эд агуурсаас чухаг; Утга нь: ажил хийвэл амжирлага дээшлэнэ. Алба хаавал ажил сурна гэдэгтэй ойролцоо үг. Өнгөөр олохгүй (мөнгөөр олно).

891. ПОЧИТЬ В ПОЗЕ Үхэ-; нэгмөсөн нойрсо-, таалал бол-.

892. ПОЧИТЬ ВЕЧНЫМ СНОМ (*книжн.*) Талийгаач бол-, уртын аянд ява-, мөнх нойрсо-.

893. ПОЧИТЬ МЕЧ Илдээ ирэлж сэлмээ сэлбэ-, хурц сэлэм хурдан морио зэхэ-, зэр зэмсгээ агса-, өр биеэ зэхэж ирт зэмсгээ агса-

894. ПОЧИТЬ НА ЛАВРАХ Сэтгэл цада-, сэтгэл хана-, сэтгэл нь овой-.

895. ПОШЁЛ ВОН [*разг.*] Зайл! тонил! далд ор! Гай болохоор зай бол! Яв! Арил, Хол оч!

896. ПОШЛА ПИСАТЬ ГУБЕРНИЯ [*разг. шутл.*] Сандарч бужигна-, үймэн хөл бол-, хөл малгайгүй, дээр дороо ор-,

897. ПОШЛА ПОТЕХА, ПОЙДЁТ ПОТЕХА [*разг.*] Сүйд болцгоов, учраа алдав; жигтэйхэн болов; хэнээ алдав; хөөрч хөгжив, хөл хөөр болов, дуу нь өндөрсөв, дуу шуу болов, бужигнаж орхив.

Все напились и пошла потеха. Архиндаа халцгаачихаад хэнээгээ алдцагаав.

898. ПОЯВИТЬСЯ НА СВЕТ Я-10

899. ПОЯВЛЯТЬСЯ (возникать, выступать) НА ГОРИЗОНТЕ. Таньдаг нөхдийн дунд; хань хамсаатантайгаа, гал багаараа; гал дотроо, нутаг усныхантайгаа.

900. ПОЯВЛЯТЬСЯ (появыться) НА СЦЕНУ Илрэн гарч ирэ-, цоорон гарч ирэ-.

901. ПРАВАЯ РУКА *чья* [*перен.*] (хүний) баруун гар шахам шадрын хүн, өрөөсөн гар, дотнын нөхөр, (их) гарын найз.

902. ПРАВДА ГЛАЗА КОЛЕТ Үнэн үгэнд хүн өшөөтэй үхэр унасан хүнд нохой өшөөтэй; үнэн үгийн үзүүр ширүүн; үнэн үг явцгүй; үнэн үг чихэнд харш; үнэн үг хатуу.

903. ПРАВДА-МАТКА [*прост.*] Үнэн үг; үнэн явдал; үнэн сэтгэл, сүүн сэтгэл.

904. ПРАВДАМИ И НЕПРАВДАМИ Сайн муу алин боловч; арга бүхнийг сүвэгчлэн; үхэхээс бусдаар л; арай л үхэж үзээгүй

905. ПРАВДУ ГОВОРЯ (сказать) Үнэний нь хэлэхэд; үнэндээ нуулгүй хэлэхэд, чин үнэнээр ярихад

906. ПРАВО ЖИЗНИ И СМЕРТИ Цаазаар авахуулах; өршөөл үзүүлэх эрх.

907. ПРАВЫЙ СЛОВО [*прост.*] Нээрэн, үнэхээр лав хөдөлбөргүй, үнэнээрээ, яасан ч, яав ч, ерөөсөө, ёстой.

Правое слово, не опоздаю, Би нээрээ хожимдохгүй шүү.

908. ПРАВО ПОРОСЛО Б-482

909. ПРАЖСКАЯ ВЕСНА Прагийн хавар (нэртэй жил бүрийн хавар цаг Прагт болдог олон улсын хөгжмийн баяр)

910. ПРАЗДНОЕ ЛЮБОПЫТСТВО Илүү дутуу, олон үг; налиг үг, шалиг үг; чалчаа яриа; далан хэл, хэл ам сугалчих гэсэн

911. ПРАЗДНОСТЬ-НАЧАЛО ВСЕХ БЕД Баярын эцэст гуниг буй; жаргалын эцэст зовлон бий.

912. ПРАХ ЕГО ВОЗЬМИ С [*бран.*] Үхэж байх нь таарсан! үхээр чамайг! чөтгөр алгадмар вэ!

913. ПРАХОМ ПОЙТИ (рассыпаться) [*разг.*] Балран уна-, үнсэн товрог бол-, голомт нь хийсэ-.

914. ПРЕБЫВАТЬ В БЛАЖЕННОМ НЕВЕДЕНИИ [*ирон.*] Аль ч учры нь мэдэхгүй; тэнэг хүн тэг дундуур; мөртөө л нэг,

915. ПРЕВЗОЙТИ (самого) СЕБЯ *кд* хаваа үзүүл-, онцын өөр чадалтайгаа гарга-, олны дотроос цооро-, цойлон гара-, ид шидээ үзүүлэ-.

916. ПРЕВОЗМОГАТЬ (превозмочь) СЕБЯ Зүрхээ чангал-, зоригоо хөвчил-, биеэ бари-,

917. ПРЕВОЗНЕСТИ ДО НЕБЕС Тэнгэрт тултал (гаргал) магта-, өндерт мандуул-.

918. ПРЕВОСХОДИТЬ (превзойти) САМОГО СЕБЯ Санаснаас дээр; хаа очиж; харин ч овоо; тэгнэ гэж санасангүй.

919. ПРЕВРАТИТЬСЯ В ЗРЕНИЕ (в слух) Ширтэн хара-, шимтэн үзэ-, шохоорхон хара-, иэгэн үзүүрт сэтгэлээр сонос-, чих тавиан сонос-, хадангатан дуула-.

920. ПРЕВРАТНОСТИ СУДЬБЫ Заяа нь мэдэх, заяаны нь жолоо мэдэх, хувь зохиол нь хувирах, заяаны нь салхи эргэх.

921. ПРЕВРАЩАТЬ (превратить обращать, обратить) В ПРАХ *кого, что* Үнсэн товрог болго-, хүйс тэмтрэ-, үнсэн нурам болго;, ёроолоор нь балла-.

А ведь предстоящая война грозит обратить в прах очаги европейской культуры. Одоогийн гарах дайн бол-бол европын соёлыг үндсээр нь баллах аюултай юмаа.

922. ПРЕВРАЩАТЬСЯ (превратиться) В ПРАХ П-921

923. ПРЕВРАЩАТЬСЯ (превратиться обращаться, обратиться) ВСЛУХ Чих тавин чагна-.

924. ПРЕВЫШЕ ВСЕГО Эрхмийн эрхэм, дээдийн дээд, охь манлай, эрхмээс эрхэм, нэн эрхэм, оройн дээд

Любовь к отечеству превыше всего. Эх орноо хайрлах гэдэг эрхмийн эрхэм.

925. **ПРЕД ЛИЦОМ** *кого чего* . . . ийн өмнө, яг тулгарсан, нүүр тулсан; халз тулгарсан, өөд өөдөөсөө, эсрэгцэн. П-86

926. **ПРЕДАВАТЬ (предать) ОГНЮ И МЕЧУ** Хүйс тэмтрэгүйсий нь хийсгэ-, гал мэсийн аюулд эрсдэ-.

927. **ПРЕДАТЬ ДУХ** Амьсгааны тоо гүйцэ-, амьсгаа хураа-, насны тоо гүйцэ-.

928. **ПРЕДАТЬ ЗА ТРИДЦАТЬ СЕРЕБРЕНИКОВ** П-1111

929. **ПРЕДАТЬ ЗЕМЛЕ** Орнуул-, хөдөөлүүл-, булш бунханд оро-, хүн тави (хая-)

930. **ПРЕДАТЬ НА ВОЛЮ БОЖЬЮ (божию)** Тэнгэрийн зориг мэдэг. тэнгэрийн таалал болгоог

931. **ПРЕДЛОЖИТЬ РУКУ (и сердце)** *кому* Бэр гуй-, эхнэрээ болгохыг эрэлхийлэ-.

932. **ПРЕДОСТАВИТЬ (предоставлять) САМОМУ СЕБЕ** *кого* Дуранд нь тави-, зоргонд нь орхи-, жолоогий нь эвхэж тави-, хөндлөнгөөс хөлөө оруулахгүй; яавал яаг гэж;эс хайхра-, өөрөө мэдэг, дүүрсэн хэрэг, дураараа болог гэж,

933. **ПРЕДОСТАВИТЬ ВСЁ В РОЗОВОМ СВЕТЕ** Юм болгоныг сайхнаар боддог, дэндүү сайхан дотортой, баясангуйн үзэл нь дэндсэн, арилсан дотортой.

934. **ПРЕДСТАВИТЬ СЕБЕ** *что* Ургуулан бодо-, бясалга-.

935. **ПРЕДОСТАВЛЯТЬ (предоставить) СЛОВО** *кого* Үг хэлэх эрх сяго-, үг хэлүүл-.

936. **ПРЕДСТАВЛЯТЬ ИЗ СЕБЯ** *кого что* [*прост.*] . . . мөн; . . . мөн л; ямар нэг . . .

937. **ПРЕДСТАВЬ (-те)** *буюу* **ПРЕДСТАВЬ (-те) СЕБЕ** [*разг.*] За тэр; харахгүй юу, ёстой тийм. М-163

Представь себе, он не пришёл. За тэр, цаатах чинь ирэхгүй боллоо, ирэгүйнээ.

938. **ПРЕДСТАТЬ В КАКОМ СВЕТЕ** Өөр (хөгшин, тарган, сонин) бол-, нэг янз бол-, хувира-, төлжи-,

939. **ПРЕЖДЕ ВРЕМЕНИ** [*разг.*] Эртдүүл, дэндүү эрт, түргэдэ-, ам мөлтөс, бөгс хөнгөдө-,

Рассказал всё прежде времени. Хэлэх юмаа дэндүү эртдүүлэв (Ам арай түргэдэв.)

940. **ПРЕЖДЕ ВСЕГО** Эн тэргүүн; дав дээр; эхлээд урьдаар; түрүүнд нь; давын өмнө, эхэлж аваад л,

941. **ПРЕЖДЕ НЕЖЕЛИ** ... ийн урьд (өмнө түрүүн)

942. **ПРЕЖДЕ ЧЕМ** ... -аас[4] урьд (түрүүн урьдаар,) ... ынхаа өмнө

943. **ПРЕЗРЕННЫЙ МЕТАЛЛ** Алтыг эдлэвч ашид амьд явдаггүй, мөнгөтийг хэрэглэвч мөнх эсэн суудаггүй

944. **ПРЕКЛОНЯТЬ (преклонить колена перед кем перед чем).** Дуулгавартай зарц бол-, бууж өг-, өвдөг сөгдө-, сунаж мөргө-.

945. **ПРЕКРАСНЫЙ ПОЛ** Эр хүний эрвээхэйн бал эм хүйс, эм сүвгэй, эм хүн

946. **ПРЕКРАТИЛАСЬ ЛАВОЧКА** К-437

947. **ПРЕЛЕСТЬ НОВИЗНЫ** *для кого* Сонирхол буураагүй, сонин нь буураагүй, сонин дээрээ, шинэ сэрэг дээрээ, уйдаагүй дээрээ, залхаагүй дээрээ, шинэ тутам дээрээ, онон зуур, анхандаа,

Театр не потерял ещё для него прелести новизны. Жүжгийн хүрээлэнд сонин нь буураагүй л байгаа.

948. **ПРЕЛЮБОДЕИ МЫСЛИ** Биеэ худалдсан тоймч бэртэгчин шүүмжлэгч, өнөөг үзэвч маргааныг боддоггүй амьтан.

949. **ПРЕПОДАТЬ УРОК** *чего* Сургамж бол (өг-), юм бодуулж өг-сургамжла-, ялгуулан сэнхрүүл-

950. **ПРЕПОДНЕСТИ (дать и. т. п.) НА БЛЮДЕ** [*шутл. ирон*] Бэлэн (зөөлөн) юм; бэлэн хоол, хүний хийчихсэн юм; гараас гарчихсан юм өг-, төөг (бооли хой) нь арилсан юм, Д-83

951. **ПРЕТВОРЯТЬ В ЖИЗНЬ** В-850

952. **ПРИ ВИДЕ** Үзээд, үзээд л; үзэхдээ

953. **ПРИ ВСЁМ ТОМ** Хэдийвээр ... боловч; ... ч гэсэн; ... чин гэвч.

954. **ПРИ ВСЕХ СЛУЧАЯХ** Болдог л юм бол хэзээ л бол; хэзээд ч гэсэн. ямагт арга нь олдвол, хий (сийм хий) эрэлтгүй,

955. **ПРИ ДЕНЬГАХ** Бэл, бэнчин,

956. **ПРИ ДОРОГЕ** Замд; замын хажууд (дэргэд), зам зуур, зам дагуу, замаас үргэлж, зам дээр,

957. **ПРИ ЗАКРЫТЫХ ДВЕРЯХ** [*офиц.*] Битүү, далд; эчнээ нууцгай; терүүхэндээ, аминчхэн, хэдүүлхнээ хаалгаа түгжиж байгаад, мануул цагдуул гаргаж байгаад, сэм нам нийлж-, нууж хаагаад,

958. **ПРИ ОТКРЫТЫХ ДВЕРЯХ** Олны өмнө; Ил, задгай; нуужхаасан юмгүй, нүдэн дээр,

959. **ПРИ ПЕРВОМ ВЗГЛЯДЕ** Анх харагдсанаараа, анх санагдсанаараа

960. **ПРИ ПОМОЩИ** *кого чего* ... аар; ачаар; ач үрээр. (Энэ өвөрмөц хэллэгийг«гусламжаар буюу тусламжтайгаар»гэж хэт муу хай үгчилж орчуулсан байх нь хааяа үзэгдэг, монгол хэлнээ, шилбүүрийн тусламжтайгаар хонь хөө-, гэх мэт хэллэг байхгүй нь ушиггч авгай та бүхэн бэлхнээ мэднэ.)

При помощи друзей-Нөхдийн ачаар (дэмээр)

Отвечал при помощи учителя. Багшийн дэмжлэгээр харицулав (хэлэв).

Погняли при помощи трактора. Трактораар өргөв. **Понимал при помощи упорного внимания.** Хадангатан (чих тавиш) соноссоны хүчинд л ухаарав.

961. **ПРИ ПОСЛЕДНЕМ ИЗДЫХАНИИ** Амьсгаа хураадгийн даваан дээр; гол нь тасчих гэж байхад-, сажлах шахаад, гол та-

сэрдгийн даваан дээр, амь нь тээрч байх үе, амьсгаа авч байх үе.

962. **ПРИ ПОСРЕДСТВЕ** ... аар, ачаар

Переводить при посредстве словаря. Толь бичгээр орчуул-

963. **ПРИ СЛУЧАЕ** [*разг.*] Цагий нь болоход; цагт нь, чухам цагт нь; тохиолд нь ... хаа хүрвэл, ... хдаа тулбал, тэр цаг дээрээ.

При случае скажу. Цагт нь би хэлээд өгнө өө (Хэлэхээ болбол хэлнэ, хэлэхдээ хүрвэл хэлнэ).

964. **ПРИ СМЕРТИ** Үхдэгийн даваан дээр; үхэлтэйгээ айл буугаад (сэтгээд) мажийх шахаад, үхэхдээ, амьсгаа хураахдаа, үхлий нь шороо пур хийх үед

965. **ПРИ ЦАРЕ ГОРОХЕ** [*шутл.*] Эрт дээр, элэр балар цагт,эртээ урьд цагт; эрт урьд элий галбын үес, дивангарын үед, диван галбын үед, үе гүйцэхийн эцэсгүй, нас гүйцэхгүй.

966. **ПРИ ЧЁМ** 1. Бас тэгээд; чингээд; мөн бас (заримдаа орчуулалтгүй,) 2. Дашрамд, ялдамд.

967. **ПРИ ШАПОЧНОМ РАЗБОРЕ** [*устар.*] П-482

968. **ПРИ ЭТОМ** Түүнчлэн; тэгэсхийн хам; чингэхийн цацуу; тэр үес мөн, үүнчлэн, энэчлэн, басхүү, үүн зэрэгцээ,

969. **ПРИБАВЛЕНИЕ СЕМЕЙСТВА** [*шутл.*] (Айлд хүүхэд гарсныг) ам нэмэх, хүн нэмэгдэх, ам халиам өсөх, бүл нэмэгдэх, шинэ хүнтэй болох.

970. **ПРИБИРАТЬ К РУКАМ** *кого что* [*разг.*] (Хэн нэг хүн, юмыг) гартаа атга-, зад атга-; эрхэндээ бари-, мэдэлдээ байлга-,

971. **ПРИБЫТКИ С УБЫТКАМИ РЯДОМ ЖИВУТ** Олзын сүүдэр гарз, идсэн эрүү хувхайрч идүүлсэн бут ургадаг

972. **ПРИВЁЛ БОГ** Юун сайн юм, ингэнэ чинээ горьдоогүй; зол зэхий, уухайн тас.

973. **ПРИВЕСТИ В ДВИЖЕНИЕ** Хөдөлгө-, асаа-.

974. **ПРИВЕСТИ В ИЗВЕСТНОСТЬ** Нягтлан гарга-, тод томруун болго-,

975. **ПРИВЕСТИ В ИСПОЛНЕНИЕ** Гүйцээ-, гүйцэтгэ-, биелүүл-, бүрэлдүүл-, хий-.

976. **ПРИВЕСТИ В СЕБЯ** Сэргэж ирэ-, урам оро-, сэрвийж ирэ-, хий морь орох.

977. **ПРИВЕСТИ (приводить) К ОДНОМУ ЗНАМЕНАТЕЛЮ** Хумиж цомтго-, хураан цогцоло-, база-, шаха-, товчило-, агшаа-, бөөгнүүл-, эмх цэгцтэй болго-, эмхлэ-, эмхэнд нь оруул-,

978. **ПРИВЕСТИ (приводить) НА ПАМЯТЬ** *кому что* Сануул-, санаанд нь оруул-, хэлж өг-, санаа авахуул-; санагдуул-, сэрээ-, сэрүүл-, сэрхийлгэ-,

979. **ПРИВЛЕЧЬ** *кого* **К ОТВЕТСТВЕННОСТИ** Харнуцлагад тата-, баривчла-

Привлечь (кого) к судебной ответственности. Эрүүгийн хариуцлаганд тата- (шүүхэд дууда-, хэрэгт оро-, эрүүгийн хэрэгт тата-).

980. **ПРИВЫЧКА-ВТОРАЯ НАТУРА** Сурсан занг сураар боож болдоггүй, гэм биш зандаа, гэнэт биш хууч, завсрын юм биш заяаны юм гэгчээр.

981. **ПРИВЫЧКА НЕ ОТОПОК: С НОГИ НЕ СКИНЕШЬ** Сурсан юмыг сураар татаж болдоггүй, дадсан юмыг татаасаар боодоггүй,

982. **ПРИГВОЗДИТЬ** (пригвождать) **К ПОЗОРНОМУ СТОЛБУ** *кого* В-1234, П-831, П-1017

983. **ПРИГОВОРИТЬ К СМЕРТИ** *кого* [*перен.*] (Өвчтэй хүнийг) эмнэлгүй гэ-; авралгүй гэж хэлэ-, горьдлогогүй гэ-, наашаа х.-рахгүй гэж хэлэ- нөгцөлгүй гэ-, тангад таних гүй монгол мэдэхгүй гэ-,нэмэргүй гэ-, эдгэрэхгүй гэ-, мянган бурхан хүрээлээд ч дэмий гэ-,

Врачи уже приговорили его к смерти, но он всё-таки выздоровел. Эмч нар түүнийг эмчилгээгүй гэцгээж байсан хэдий боловч илаарь болов.

984. **ПРИДАТЬ ВИД** *кому чему* Үзэмжтэй бол-, сүр оруул-,

985. **ПРИДАТЬ (приписать) ЗНАЧЕНИЕ** (цену) *чему* Эрхэм лэ-, чухагт бодо-, П-1065

986. **ПРИДАВАТЬ** (придать) **КРЫЛЬЯ** *кому, чему* Жигүүр ургуула-, зориг оруул-, урамс сэргээ-.

Критика придаёт мне крылья. Өөлүүлэх тусам өө арилдаг. (хэлүүлэх тусам хий арилдаг, хатуу үг аминд тустай, муу үг дуулах тусам муу нь арилдаг).

987. **ПРИДЕРЖАТЬ НА ВОЖЖАХ** Д-220

988. **ПРИДЕРЖАТЬ** (придерживать) **ЯЗЫК** (язычок) [*разг.*] Амаа бари-, амаа жимий-, эрүү хамхи-, ам ангайж болохгүй, амаа үдэ-, амаа бөглө-

989. **ПРИЁМНЫЙ ПОКОЙ** (Эмнэлгийн хүлээлгийн өрөө, хүлээх өрөө, (түр) саатах өрөө

990. **ПРИЖАТЬ К НОГТЮ** *кого* [*прост., вульг.*] Зад шийтгэ-, чанга залхаа-, хүндээр цээрлүүл-, сайн хашраа-, байя гэтэл нь ав-, зүрхэнд нь шар ус хураа-.

991. **ПРИЖАТЬ К СЕРДЦУ** Агдлан тэврэ-, чанга тэврэ-, наалдуулан тэврэ-, элгэндээ наа-,цээжиндээ наа-,

992. **ПРИЖАТЬ К СТЕНЕ (к углу)** *кого* [*перен.*] Шахаж тулга-, тулгаж асуу-, бүлтэлзтэл нь, бөндөгнүүлэ-; хааш нь ч гарга хгүй, алхуулахгүй, үг хэлүүлэхгүй, улаан тулга-, үг дуугаргахгүй. З-111

993. **ПРИЖИМАТЬ** (прижать) **ХВОСТ** *кому* [*прост.*] Сүүл хавчизүрхий нь атга-, хулхы нь буулга-, даруулгатай болго-.

994. **ПРИЗВАТЬ В СВИДЕТЕЛИ** *кого* гэрч хий-, гэрч тата-,эш тата-, баримт ав-, гэрч болго-,

995. **ПРИЗВАТЬ К ОРУЖИЮ** *кого* 1. Зэвсэглэхийг уриала-, 2. Дайчилгаа зарла-

996. **ПРИЗВАТЬ К ПОРЯДКУ** Журам сахи хэж хэлэ-, дэглэм сахи хэмээ-, дүрэм гурим сахи гэ-, дүрэмдэ-.

997. **ПРИЗВАТЬ** *кого что* **НА ПОМОЩЬ** 1. Тусламж гуй-, гар сунгаач гэ-, дэм эрэ-, нэмэр хандив (чимэр) юу байна гэ-, нааш харсан ах дүү минь гэ-, тус эрэ-, туслаач хэмээ-, 2. Хүчээ гарга-, нэгэл үзүүрт сэтгэлээр хичээ-, чадах бүхнээ шавха-

Призвать на помощь союзные войска. Холбооны цэргээс тусламж гуй-.

Я призвал на помощь все свои знания в немецком языке Герман хэлээр юу л мэддэгээ шавхав (Миний герман хэл дууслаа гэгч болов)

998. **ПРИЗВАТЬ ПОД РУЖЬЁ** Цэрэгт тата-, цэрэгт ав-, цэрэгт оруул-, цэрэгт дайчила-, цэрэг цуухад тата-, эр цэргийн албанаа зарлан дууда-,

999. **ПРИЗНАТЬСЯ СКАЗАТЬ** [*разг.*] Үнэнийг хэлэхэд үнэнээрээ голоор нь хэлбээс, нуух хаахгүй хэлбэл, ний нуугүй хэлбэл, үнэндээ л гэхэд,

1000. **ПРИЙТИ (приходить) В ГОЛОВУ (на ум)** *кому что* ... санаанд оро-, санаанд орж ирэ-, тэгж ингэж бодогдо-, тэгмээр ингэмээр бол-, дотор сэрхий-, ухаанд (толгойд) орж ирэ-,

1001. **ПРИЙТИ В РАЖ** В-804

1002. **ПРИЙТИ (приходить) В СЕБЯ** Сэтгэлээн тогтоон бодо-, наадах цаатахыг бодо-, ухаалан бодо-, ухаара-, ултай тунгаа-, тогтоож бодо-, ухааная төвлөрүүл-,

1003. **ПРИЙТИ В СОЗНАНИЕ (в чувство)** Ухаалан бодо-, ухаан сийлэ-, учир начрыг шүү-, зүй зүйгээр бодо-, ухааная гарга- ухаан оро-

1004. **ПРИЙТИ В ТУПИК** Мухарда-, хаашаа ч үгүй бол-, таг бол-, арга барагда-, горь тасра-, ягтаж хоцро-, яг мухардаж, таг суу-,

1005. **ПРИЙТИ К ВЛАСТИ** (Төрийн) эрх ав-, ширээнд гар-, ширээнд суу-, (залра-), ширээ эзлэ-,

1006. **ПРИЙТИ К ВЫВОДУ** ... дүгнэлт хий-, тэгж ингэж тогто-, тэгж ингэж мэдэ-,

1007. **ПРИЙТИ НА ПАМЯТЬ** Сана-, бодо-, санаанд оро- санагда- бодогдо-, бодолд оро-, дурсагда-

1008. **ПРИЙТИ (приходить) НА УМ (в ум)** В-564

1009. **ПРИЙТИ С ПОВИННОЙ (головой)** Я-11

1010. **ПРИЙТИСЬ КО ДВОРУ** Хүн нааш гэ-, амьтан сайн бай-, зан сайтад хүн цугладаг, амьтан ах дүү нааш хара-, хүн амьтан нааштай бай-, нүүр өг-, тал өг-, хүндэлж мэндлэ-, өргөмжилө-, дээдлэ-,

Я в этом учреждении не пришёлся ко двору. Энэ байгууллагынхан намайг ч нааш гэхгүй л байгаа юм.

1011. **ПРИЙТИСЬ ПО СЕРДЦУ (по душе)** Санаанд нийцэ-, сэтгэлд таара-, таалалд нь нийцэ-.

1012. **ПРИКАЗАЛ (приказать) ДОЛГО ЖИТЬ** [*разг.*] Талийгаач болсон, өнгөрсөн.

1013. **ПРИКАЗНАЯ СТРОКА (пренебр.)** Асман түшмэл, будааны түшмэл, багахан түшмэл, шүдлэн дарга,

1014. **ПРИКИНУТЬ В УМЕ** Дотроо ухаантай дороо суурьтай, дотор хүнтэйгээ хэлэлцэ-, тунгаан бодо-, шүүн тунгаа-, хар ашгий нь нягтла-, гэм алдлы нь тунгаа-

1015 **ПРИКЛОНИТЬ ГОЛОВУ.** Толгой хоргодо-,

1016 **ПРИЛОЖИТЬ (приклонять) СЛУХ (ухо)** Чих тавин сонос-, чих тавин-, хадангатан сонос-,

1017. **ПРИКОВАТЬ К ПОЗОРНОМУ СТОЛБУ** П-982.

1018. **ПРИКОВАТЬ К СЕБЕ ВНИМАНИЕ** *чьё кого* **(книжн.)** Амьтныг өөр рүүгээ хандуул-, амьтны анхаарлыг тата-, олныг өөрлүүгээ тата-, бие хүрээлүүл-, биедээ тата-,

1019. **ПРИКУСИТЬ ЯЗЫК (язычок)** [*разг.*] Ярьж байснаа (хэл нь татсан юм шиг дуугүй бол-, амаа жимий-, хар цагаан дуугүй бол-, бүлхи залгисан юм шиг, хулгана залгисан могой аятай, хахсан хүн шиг,

1020. **ПРИЛИП ЯЗЫК К ГОРТАНИ** *у кого* Хэл нь татсан юм шиг, үг ч үгүй дуу ч үгүй, хэл амгүй мэт.

1021. **ПРИЛОЖИТЬ ПЕЧАТЬ** Тамга дара-, тамгала-,

1022. **ПРИЛОЖИТЬ РУКУ (руки)** *к чему* [*перен.*] 1. Гарын үсэг зура-, мутрын тэмдэг тави-, 2. (Ямар нэг юманд) хуруу дүрэгар хүрэ-.

1023. **ПРИНЕСЛА НЕЛЁГКАЯ** [*разг. неодобр.*] Дэмий прэв-, юугаа хийж яваа юм, үлийгээ хийж прэв ээ,

1024. **ПРИНЕСТИ В ЖЕРТВУ** *кого-что* [*перен.*] Зориул-, ... өргө ... тахилд тави-, тайж тавигла-, өглөг өг-

1025. **ПРИНЕСТИ** *кому- чему* **ДАНЬ УВАЖЕНИЯ** Хүндэтгэ-, дээдлэ-, хүндтэй бай- найр тави-, хүндлэх мэндлэ-, дотно бай-,

1026. **ПРИНЕСТИ (приносить) ЖЕРТВУ** *чему* [*перен*] Зориул-, тахилд тави-, ...-ийг өргө-.

1027. **ПРИНЕСТИ** *что* **НА АЛТАРЬ** *чего* Өргө-, зориул-, тай-, тавигла-, өглөг өг-, золи-.

Принести свою жизнь на алтарь отечества. Амь насаа эх орондоо өргө-, (Амь биеэ эх орондоо зориул-, алтан амна эх орныхоо тахилын ширээнд өргө-).

1028. **ПРИНЕСТИ ПЛОДЫ** үр нь гар-, идий нь үзэ-, хэрэг нь гар-, явсан похой яс зуу-,

1029. ПРИНЕСТИ (приносить) ПОВИННУЮ (голову) Нүглээ наманчила-, гэмээ гэмд хүлээ-, гэмээ өөрөө гэмши-, өөрийгөө зэмлэ-, өөрөөсөө ичи- Я-11

1030. ПРИНИМАТЬ ЗА ЧИСТУЮ МОНЕТУ П-1050

1031. ПРИНИМАТЬ ЗВАНЫХ И НЕЗВАНЫХ Ундтай устай, гар султай, хойгуур урдууруа гарсан бүгдийг хооллуулж ундлуулж байд-, өглөгөмч, гар татдаггүй, орсон гарсан амьтныг хооллож байд-, лусын сан шиг;

1032. ПРИНОСИТЬ СВОЮ ЛЕПТУ В-700

1033. ПРИНИМАТЬ (принять) НА СВОЙ СЧЕТ. Бие рүүгээ тата-өөртөө хамаатуул-

1034. ПРИНУДИТЕЛЬНЫЕ РАБОТЫ Албан ажил, албадан хөдөлмөр; шааж хийлгэх юм; дур асуухгүй ажил; Албадан хийлгэ-албын шаалтын юм, хар баагаар хийлгэх ажил.

1035. ПРИНЯТЬ (принимать) БЛИЗКО К СЕРДЦУ *что* Дотно шадар бай-, шахам шадар бай-, дотноло-,

1036. ПРИНЯТЬ БОЙ. [*воен*]. Дайн хий-, дайнд оро-, дайн тулаанд мордо-

1037. ПРИНЯТЬ В ДОМ *кого* Тэжээж өсгө-, сууж төрөөгүй болович сугавчилж өсгө-, өөрийн хүн мэт өсгөж өндийлгө-,

1038. ПРИНЯТЬ (принимать) В КУЛАКИ *кого* [*прост.*] Нударгажанчуул-, булдруу болго-, хярамцагла-

1039. ПРИНЯТЬ В ПАЙ (Нэг) галдаа элсүүл-, намдаа нийлүүл-, бүлдээ оруул-, хүй дундаа нийгэтгэж, хүнс олзоо хуваалца-,

1040. ПРИНЯТЬ В РАСЧЁТ Анхааран ав-, тоож үзэ-, хичээн болгоо-, В-582

1041. ПРИНЯТЬ В СООБРАЖЕНИЕ П—1040

1042. ПРИНЯТЬ В УВАЖЕНИЕ П—1040

1043. ПРИНЯТЬ (встретить) В ШТЫКИ Ташуур барьж уулза-, хартай хортой учира- В-1015

1044. ПРИНЯТЬ ВЗДОХ *чей* (Үхэхэд нь) толгойгий нь түшиж бай-, өргөж үхүүл-, ясы нь бари-

1045. ПРИНЯТЬ ВИД (какой) Арай өөр бол- баахан өөрөвдсөн янзтай; тийм ийм байдал (байртай), хувира-; хувьса-;

1046. ПРИНЯТЬ ВО ВНИМАНИЕ П—1040

1047. ПРИНЯТЬ ВСЕ ЗАВИСЯЩИЕ МЕРЫ Арга бүхнээ хэрэглэ-, байдаг арга ширгээ (чаргаа) бара-, чадах болгоноо хий-, хазаажаасаа бусдыг хий- зүсэн зүйлээр үзэ-.

1048. ПРИНЯТЬ ГРЕХ НА СЕБЯ Нүглий нь буулгыг хүзүүндээ угла-; нүглий нь өөртөө хүлээ-, гэмий нь даасугай гэ-.

1049. ПРИНЯТЬ ЗА ПРАВИЛО журам болго-, ёс болго-, журамла-

1050. ПРИНЯТЬ *что* **ЗА ЧИСТУЮ МОНЕТУ** Үнэнд бодо-, үнэнд ав-, ... -ийг үнэмшц-, эргэлтгүй (буцалтгүй) итгэ-, үнэнээсээ үнэмши-,

1051. ПРИНЯТЬ К ИСПОЛНЕНИЮ Гүйцэтгэ-; гүйцээ-, биетэй болго-

1052. ПРИНЯТЬ К НЕУКЛОННОМУ ИСПОЛНЕНИЮ Тууштай баримтла-, ягштал (чанд) баримтла-,

1053. ПРИНЯТЬ К СВЕДЕНИЮ Анхааран ав-; нягтлан мэдэ-, сайтар шүү-,

1054. ПРИНЯТЬ НА ВЕРУ *что* Үнэмши-; үнэнд бодо-, эргэлтгүй итгэ-,

1055. ПРИНЯТЬ НА СЕБЯ (труд) Өөрөө хүлээ-, өөртөө хүлээ-, хүлцэ-, хүлээн бари-,

Я принял на себя вину. Би буруугаа хүлээв.

1056. ПРИНЯТЬ ПОЗУ (какую кого) ... (тийм ийм) дүр үзүүл- (гарга-); байдал гарга, ... маяг үзүүл-, намжирда-.

1057. ПРИНЯТЬ (принимать) ПРЕДЛОЖЕНИЕ *кого чье* Зөвшөөрө-, ам өг-, за хүлээ-,

1058. ПРИНЯТЬ С РАСПРОС ТЁРТЫМИ ОБЪЯТИЯМИ Зочилсон шиг зочил-, хүндтэй, ёстой ямбатай хүлэээн хүндлэ-, их эрхэмлэн хүндлэ-, хүндэд үзэ-, хүндэлж сүйд майд бол-,

1059. ПРИНЯТЬ СМЕРТЬ үхэ-, талий-

1060 ПРИНЯТЬ (принимать) УЧАСТИЕ *в ком* (хэн) хүнийг өрөвдө-, төлөөнөө яс хавтай-, орноос нь зово-, яс хавталза-

1061- ПРИНЯТЬ (принимать) ЭСТАФЕТУ *от кого, у кого* Үе залгамжла- халаагий нь ав-

1062. ПРИПАДАТЬ К НОГАМ (к столам) *чьим* Мөргөж мөлхөгуйж гувши-, сөхөрч сөгдө-; хошуу цорвой- духаа цоортол мөргө-, өвдгөө цоортол сөгдө-, П-5

1063. ПРИПЕРЕТЬ (припирать,) К СТЕНЕ (к стенке) *кого* [*разг.*] Мухарлаж хэлэ-, (асуу-) ;үгий нь тагла-; амы нь тагла-; үггүй болго-; мохоож асуу-

1064. ПРИПИРАТЬ (припереть, прижимать, прижать) В УГОЛ *кого* [*прост.*] Зазагадуул-, мухардуул-, харцганд баригдсан болжмор шиг болго-,

1065. ПРИПИСАТЬ ЗНАЧЕНИЕ (цену) П-985

1066. ПРИПОДНЯТЬ ЗАВЕСУ *над чем* Үнэний нь хэлэ-, зэсий нь цухуйлга-,

1067. ПРИРАСТИ КОРНЯМИ В-935

1068. ПРИСТАЛ, КАК БАННЫЙ ЛИСТ [*разг. вульг.*] Нойтон хамуу шиг салж өгдөггүй, зангуу шиг; хачиг шиг, Хужир үзсэн тэмээ шиг, яргуй хөөсөн ямаа шиг, сүүдэр шиг, сүүл шиг, хөл хэрээтэй, хүзүү холбоотой юм шиг.

1069. ПРИСТАТЬ С НОЖОМ К ГОРЛУ [*разг.*] Хоолой дээр хутга, амь наана там цаана, хоолой дээр хутга тави-, хутганы ир- дээр, амиа амандаа зуу-,

1070. ПРИСТУПУ НЕТ [*разг.*] 1. Хүн хавьтахын аргагүй, хүн халгахын аргагүй, хүн ойртолтгүй, зан гэж зараа, хүнтэй өврөөрөө Н-850

нийлдэгүй 2. Үнэ гэдэг нь хавьтах аргагүй, үнэ нь аманд багтамгүй, үнэ барьчихсан.

Такой важный что и присутну нет (Гоголь) Ийм их язгаар ёмбогор хүнтэй чинь хүн яаж халж хандлах вэ?

1071. ПРИСУТСТВИЕ ДУХА Биеэ барьдаг, тэнчээргүй, амар тайван, хүлцэмтгий, дороо суурьтай, авсаар хөлөлдөггүй, хүнд бөгстэй хүний сүүлд дуугардаг.

1072. ПРИТЧА ВО ЯЗЫКАХ [*шутл.*] зүүн хүний хэлэн дээр, зуудаг нохойн шүдэн дээр, хүний хэлэл, нохойн хүнал, амтай болгоны амны бах болох, хүний ам угаа-, хүний аяны зугаа-бол-, хэлтэй болгоны хэлэнд оро-,

1073. ПРИТЯНУТЬ (притягивать) ЗА ВОЛОСЫ *что* албаар тааруул-, нийцвэргүй (тайлбар, шалтгаан) муйхраар болгосон бол-, харын албаар, хар хүчээр, албын хүчээр, дүргүй ламыг дарж байж сахиж хүртээх гэдэг шиг, мундагда-,

1074. ПРИТЯНУТЬ К ИИСУСУ [*шутл.*] хэрэг төвөг хий-, зарга зааяхайд оруул-, юманд тулга-,

1075. ПРИХОДИТЬ В ДВИЖЕНИЕ 1. Хөдөлж эхлэ-, хөдөлгө-, 2. Амь оро-, сэргэ-, амьдар-, амьл-,

1076. ПРИХОДИТ НА ПАМЯТЬ санаанд орө-, санагда-, бодогдо-, санаанд буу-

1077. ПРИХОДИТ НА ЯЗЫК *кому* мэдэлгүй дуугарчихдаг, гаднаараа хөөрөх.

1078. ПРИХОДИТЬ (прийти) В РАССУДОК мэдээ ороx-, томоожихэрсүүжи-, ханиp суу-, сэхээ оро-,

1079. ПРИЧИСЛИТЬ (причислять) К СОНМУ [*прон*]... ын тоонд оро-, тоонд багта-, шажинд оро-, элсэн оро-,

1080. ПРИШЕЙ КОБЫЛЕ ХВОСТ Н-851

1081. ПРИШЛА ОХОТА дур хүрэв-, дур оров-, тэгмээр, ингэмээр санагдав-, хорхой хүрэв-, тэгэх гэж бүр загатнав-, урам оров-, хорхой нөгцөв-, дон шүглэв-, дон нь хөдлөв-, донтов-, гуяа алгадав -,

Пришла охота поиграть в карты Хөзөр тоглохсон гээд л загатнаад байгаа юм,

1082. ПРИШИТЬ (пришивать ДЕЛО *кому* [*прост. неодобр.*] хэргээ хүн рүү чихэ-, булайгаа бусдад нялзаа-, сугарч гараxудрагада-, араар суу-,

1083. ПРИЯТНОГО АППЕТИТА! (хүн хоол идэж байхад ерөөж өгүүлэх үг) зоог амттай бол! Манж шимтэй байг! Идсэн үүсан шингүүртэй болог,

1084. ПРО ЗАПАС [*разг.*] нөөж хадгалах-, хэрэг болох айх гэж, бүмыг яаж мэдэх вэ гэж, сүүлд хэрэг болох байх гэж, цэнэ-, хямгада-, хойш нь хий-, үүцлэ-, хурлуулж унах морь, хуршаж идэх өөх гэгчээр,

1085. ПРО И КОНТРА болох болохгүй, зохих зохихгүй, таарах таарахгүй

1086. ПРО СЕБЯ 1. **(читать, говорить и. т. п.)** өөм үзэх, дуу тарахгүй, өөрөө өөртөө, амандаа хэлэх, 2. дотроо бодох, цээжиндээ санах, дотор хүнтэйгээ зөвших.

1087. ПРО ТО ЗНАЕТ ВСЯ УЛИЦА хүн толгойтой болгон мэддэг (юм) айл саахалтгүй, аймаг хушуугаараа алдарисан, мэдэхгүй хүнгүй, нутаг халъж хушуу дамжин дуурссан.

1088. ПРОБА ПЕРА 1. Бийрийнхээ гарцыг үзэх, үзэгнийхээ үзүүрийг сорих, 2. Зохиол зохиож үзэх.

Юношеская проба пера Залуу хүний (оролдож) бичиж үзэж байгаа зохиол (юм).

1089. ПРОБЕЖАТЬ ГЛАЗАМИ *что* гүйлгэж хара-, гүймэгхэн үзэ-, хараад өнгөрө-, харсан бол-, нүд гүйлгээд өнгөрө-, тоосло-, дайруут шүүрүүт өнгөрө-, хяламхийгээд өнгөрө-,

1090. ПРОБИТЬ БРЕШЬ в *чем* [*перен.*] саадыг дава-, бэрхийг дава-, тэглээг мултал-, айдаггүйгээ авдрандаа хий-, нөөц нуруу нугал-хоёр яс сал-,

1091. ПРОБИТЬ ЛБОМ (дорогу путь) явсан нохой яс зуу-, зовсон хүн жарга-, зовсон нохой зоогло-, сунан зүтгэсний хэрэг бүтэ-, зорьсныхоо хэргийг хий-,

1092. ПРОБИТЬ (пробивать) СЕБЕ ДОРОГУ [*перен.*] өөрийнхөө зямыг өөрөө заса-, замынхаа чулууг арилга-, зүтгэсэндээ хүрч зүтгэснээ өнгөлө-, явсан хүн яс зуу-.

1093. ПРОБИТЬ СТЕНУ саадыг дава-, өндөр босгыг дава-, учраагаа аразда хий-, бөөн ажил дара-,

1094. ПРОБКОЙ ВЫДЕТЕТЬ (выскочить и. т. п.) год үсрэ- год гээд алга боя-,

1095. ПРОБНАЯ МОНЕТА загвар зоос, зардаггүй зоос, зоосны хэв, мөнгөний маягт.

1096. ПРОБНЫЙ КАМЕНЬ [*перен.*] шалгармал, шилмэл, шалгуур, шигшмэл, сонгомол арав тунгаасан алт, шүүсэн, сонгодог сор, оюу нь, толгой нь.

1097. ПРОБНЫЙ ШАР [*перен*] тэнсүүр, тэнсэх, сорилго, турших, цохиж үзэх,

Пустить пробный шар. Тэнсэж үзэ-,

1098. ПРОВАЛИСЬ Я НА МЕСТЕ (если вру) [*прост.*] миний худалчийг үзээрэй, миний худлаа бол юу болдог бол доо. Худлаа хэлж хургатай шар халзан хонь чирч яваагүй юмсан, би хэзээндээ ээзэн, амандаа хүрдэг, үгэндээ хүрдэг, худал хэлиэ гэж зангүй (ёсгүй)

1099. ПРОВАЛИТЬСЯ В ТАРТАРАРЫ (готов, хотел-бы и. т. п.) [*разг.*] газар доогуур орчихмоор, зайлаад өгмөөр, чихээ бөглөмөөр.

1100. ПРОВАЛИТЬСЯ МНЕ НА ЭТОМ МЕСТЕ Л-120

1101. ПРОВЕРИТЬ ЧАСЫ цаг тааруул-, (тохируул-), цаг нийлүүл, (дүйлгэ-)

1102. ПРОВОДИТЬ ГЛАЗАМИ (взглядом, взором) *кого что* хойноос нь ширтэ-, (харуулда-), хойноос нь харан харан бай-, үдэж хоцро-, нэхэн хара-, (ширтэ-), гаргаж өг-,

1103. ПРОВОДИТЬ (провести) ГРАНЬ *между кем между чем.* ялга-, заагла-, зааг тогтоо-, дэслэ-,

1104. ПРОВОЖАТЬ *кого* **В ПОСЛЕДНИЙ ПУТЬ** (талийгаачийг) гарга-, нутаглуул-, хөдөөлүүл-, оршуул-, өндөр сайхан уулы нь дэрлүүлэн, өргөн сайхан голы нь сүндлүүл-, (сундлуул-,) хоёр хааны бол-

1105. ПРОГЛОТИТЬ ПИЛЮЛЮ [*перен. разг.*] цээжиндээ түймэр гарсан ч хамраараа утаа гаргахгүй бай-, тэсэ-, тэвчэ-, амаа жимий-, тэвчихийн сайнаар тэвчи-, дуугүй бай-, бүтэж үхэхгүй, урьдаар дуугарсан хөхөөний ам гэгч болуузай

1106. ПРОГЛОТИТЬ ЯЗЫК Хэл нь татсан юм шиг, дуу ч үгүй шүү ч үгүй, амаа үдүүлчихсэн юм, ам нь зуурчихсан юм шиг, хэл нь зуурчихсан юм шиг,

1107. ПРОГЛЯДЕТЬ ВСЕ ГЛАЗА В-960

1108. ПРОГЛЯДЕТЬ (все) ГЛАЗА [*разг.*] Нүдээ чилтэл ширтэ-, нүдээ хөхөртөл хара-,

1109. ПРОГНАТЬ СКВОЗЬ СТРОЙ (оросын цэрэг залхаах нэгэн ёс) шургуулан торлогдо-, хавсайдан жанчи-,

1110. ПРОГОЛОДАЕШЬСЯ-ХЛЕБ ДОСТАТЬ ДОГАДАЕШЬСЯ у г ч и л б э э с: өлсвөл талх олохын тэмдэг, у т г а н ь: өлсвөл идэхийн тэмдэг, идвэл уухын тэмдэг.

1111. ПРОДАТЬ (предать) ЗА ТРИДЦАТЬ СРЕБРЕНИКОВ [*высок.*] айхдаа аавыгаа барьж өх-, айсан хүн адуу хөө-, ичсэн хүн хүн ал-.

1112. ПРОДАТЬ ШПАГУ *кому чему* дайсанд урва-, дайсанд орж өг-, дайсны талд оро-, орж өг-, хөрөм эргэ-, өөрийн яс байж хүний цусанд уус-, элэг бууруул-, санаа бууруул-, өшөөтийн бахыг ханга-, янагийн сэтгэлийг зовоо-,

1113. ПРОДАЮ ЗА ЧТО КУПИЛ [*разг.*] (худалдан) авснаараа өгнө, дуулснаа хэлнэ,

1114. ПРОДИРАТЬ (продрать) ЗЕНКИ *кого* [*груб. прост.*] нүд нуух аниадан нүд акилчан

1115. ПРОДИРАТЬ (продрать) С ПЕСКОМ [*прост.*] тархий нь эргэтэл загнах-.

1116. ПРОДРАТЬ (продирать) ГЛАЗА [*прост. шутл.*] (сэрээд нүдээ онийлгон хара-, нүдээ сүүмийлгэ-, жийтайн хара-, шийнийн хара-, жониин хара-

1117. ПРОДУВНАЯ БЕСТИЯ бөөн заль, залины хүүдий, залины эзэн (хөрөнгө), үнэг шиг, бөөн бааш, бачтан

1118. ПРОЕХАТЬСЯ НА *чей* **СЧЁТ (ПРОЕХАТЬСЯ ПО** *чьему* **АДРЕСУ)** [*шутл.*] шоолo-, тоглоом хий-, тоглоом тохуу болго-, элэг бари-, элэг доог хий-, доог хий-, явуул-, цаашлуул-, (үмхий) үгээр ута-.

Я понял, это он проехался на мой счёт Намайг л шоолж байж гэдгийг нь би мэдэв.

1119. ПРОЖИГАТЕЛЬ ЖИЗНИ [*разг.*] тарган цатгалан нь дэндсэн хүн, хэт бүрэлгэгч сагасан амьтан, (мөнгөөр буянаар) туйлсан хүн, буйлсан бүргэд шиг, сан идсэн хүн гээч.

1120. ПРОЖИГАТЬ ЖИЗНЬ хэт бүрэлгүү аж төрдөг, тос ууж өөх идэ-, түйлж амьдардаг, идэх тусмаа араа нь халсан.

1121. ПРОЖУЖЖАТЬ (все) УШИ *кому* [*разг*] Улигла-, бавтана-, чихэнд чийр бол-, үглэ-, яншин-.

1122. ПРОИГРЫВАТЬ (спускать проигрываться) ДО (последней) РУБАШКИ хушуу хуурайл-, хувхай модо бари-.

1123. ПРОИЗВЕСТИ (производить) НА СВЕТ орчлонд төрө-, мэндэлэ- хүн болон төрө-,

1124. ПРОИЗНОСИТЬ В НОС Г-104

1125. ПРОЙТИ В ЖИЗНЬ биелэ-, хэрэгжи-, бүтэ-, бүрэлдэ-, юм бол-

1126. ПРОЙТИ МИМО *чего* [*перен.*] тоохгүй хайхрахгүй, мэндгүй зөрө-, юманд бодохгүй, гөлийгөөд өнгөрө-, хяламхийхгүй зөрө-, гишгэн алдаад өнгөрө-, харах ч үгүй, хэрэгсэхгүй, салхи татуулаад зөрө-, дайрч унагах нь халаг.

186. **РУКА РУКУ МОЕТ (и обе чисты)** нэг нэгэнтэйгээ хуувилдаж, нохойн баас нэгэндээ тустай; ороо нь ороогоо жороо нь жороогоо; таарсан таар (шуудай) гар гараа дагадаг, ганзага уяагаа дагадаг

187. **РУКА С РУКОЙ** Р—178

188. **РУКА СУДЬБЫ (провидения)** хувь зохиол; хувь тавилан

189. **РУКИ В БРЮКИ (ручки в брючки), (ходить и. т. п.)** [*разг. ирон*] дэмий сэлгүүцэ-; ажлаа алда-

190. **РУКИ ГОРЯТ** [*разг.*] гар загатнах (ямар нэг юм хиймээр)-хорхой хүрэх; санаа байвч сачий (чадал) хүрэхгүй.

191. **РУКИ КОРОТКИ** *у кого* [*разг.*] чадал хүрэхгүй; гар богино ганзага татуу, ахар дээс уяа хүрэхгүй гэгч

192. **РУКИ НЕ ДОШЛИ (доходят)** [*разг.*] гар хүрч амжаагүй; барнагүй л; гар хүрэх зав олдохгүй

193. **РУКИ НЕ ОТВАЛЯТСЯ** *у кого* [*прост*] нэг их юм болохгүй, базаах юу байх вэ, юу гийгэх вэ, нохой долоо, буруу хойшоо, юу гавнаж,

194. **РУКИ ОПУСТИЛИСЬ** арга барагдав; гар мухардав; урам хугарав, горь тасрав

195. **РУКИ ОТВАЛИВАЮТСЯ** *у кого* шөрмөсөө сунатал, ядрангаа цайтал, булчингаа сугартал, гараа сарвайтал, сарвайж хоцорлоо.

196. **РУКИ ПАЧКАТЬ (марать)** [*прост.*] 1. (у т г а н ь) гараа бузарда-; (бохир болго-) 2. Муу юманд хуруу дүрэ-; нэр бузарлах юм хийлцэ-; муу юманд гар бие оролцо-; хилэнцний нэмэр; мэрийн хор нүүрийн хир, дээгүүр баривал гар цустах; доогуур баривал гар баастах.

197. РУКИ ПО ШВАМ (держать, делать) гараа унжуулан цэх зогсох; гадас шиг зогсох: хөшөө шиг зогсох; шавар баримал шиг; модон өмдтэй мэт, хөшсөн мэт.

198. РУКИ ПРИЛОЖИТЬ хуруу нэмэ-, гар бие оролцо-; элбэлцэ-

199. РУКИ ПРОЧЬ *от кого-чего* савраа тат!

200. РУКИ СВОБОДНЫ өөрийн эрхээр; яая л гэвэл яахаар; гар баригдахгүй

201. РУКИ ЧЕШУТСЯ *у кого* (хүнд гар хүрэх, зодох юм хийх оролдох мэтэд) гар загатна-, гар нь өтсөн юм шиг, гар нь халуу орж

202. РУКОЙ НЕ ДОСТАНЕШЬ дээгүүр албаны; дээгүүр суудалтай; мань мэтэд хавьтахааргүй; дуу хүрэхгүй.

203. РУКОЙ ПОДАТЬ [*разг.*] ойрхон, дэргэд,хаяанд, гадаа хаяанд, айл гэсэн үг; гараад л орохоор; хараадаа; урдаас чинь би энэ байна гээд л байж байгаа, төө тэр, барааны газар, нүдэнд нл, заагаад өгөхөөр газар, энүүхэнд,

От нас до станции рукой подать Өртөө манай гадаа хаяанд байгаа

204. РУКУ ДАТЬ НА ОТСЕЧЕНИЕ 1. толгойгоороо даая; толгойгоо мөрийд тави-2. үхсэн ч яадаг юм; айсан ч ойчно алцайсан ч ойчно; нэг үхэхээс хоёр үхэхгүй.

205. РУКУ НА СЕРДЦЕ П—681

206. РУССКИМ ЯЗЫКОМ (сказать,говорить) [*разг.*] Орос хүн орос хэлээрээ хэлж байна шүү дээ! Хүний хэл мэддэг юм уу үгүй юм уу (Мо гол хүн монгол хүнд монгол хэлээрээ хэлж байна гэдгэрхүү хэллэг).

Ведь сказано тебе русским языком Чамд орос хүн орос хэлээрээ хэлээд байна шүү дээ!

Я сказал вам русским языком денег у меня свободных теперь нет (Чехов) надад дэл сул мөнгө зоос байхгүй ээ гэж байхад та тань хүний хэл мэддэг хүн үү үгүй хүн үү!

207. РУЧНАЯ КУКЛА хуруувчин хүүхэлдэй (бээлийн чинээ, хумсын чинээ, хуруун чинээ)

08. РУЧНАЯ ПРОДАЖА ганзгын худалдаа; шуугуур наймаа, үүргийн худалдаа, доншуур наймаа

209. РЫБА ЗАГНИВАЕТ С ГОЛОВЫ эх нь булингартай бол адаг нь булингартай; эх нь хээр алаг бол хүү нь шийр алаг; дээд хүн суудлаа олохгүй бол доод хүн гүйдлээ олохгүй.

210. РЫБА ИЩЕТ ГДЕ ГЛУБЖЕ, А ЧЕЛОВЕК ГДЕ ЛУЧШЕ хүний санаа хөрст газраас зузаан; аавын хүү олзонд, алтан эрвээхэй зулзанд, эр хүний дотор эмээлтэй хазаартай морь, хээрийн галуу нисэн үл хүрэх газар, хүний хүү нэр ашгийн төлөө чирэгдэнэ (нэрт сайчуудын хураасан бичиг)-ээс,

211. РЫЛО ВОРОТИТЬ *от кого-чего* [*вульг.,бран.*] тоохгүй; нэг нүдээр үзэхгүй; нүдний цагаанаар үзэ-; нүд үзүүрлэ-; хял **(в)** алза-;

212. РЫЛОМ НЕ ВЫШЕЛ [*вульг.*] муухай төрсөн; өөдгүй царайтай; царай муутай; аятайхан ч үгүй царайтай [*перен.*] зохихгүй гэж, таарахгүй хэмээн; орой гарсан дорой төрсөн; уранхай дээлтэй туранхай царайтай; муу нэртэй, муухай зүстэй; үзэхэд үрчгэр; харахад харчгар

213. РЫЛЬЦЕ В ПУХУ (пушку) [*разг.фам*] муу хэрэгт хуруу дүрэх; (алж идсэн хонины) дэлүү нь үнсэндээ; хөгнөнд хөлөө, хөндлөнд хүзүүгээ; нэрээ баастах (хөөдөх, хугалах, бузарлах) нэг нэрээ хоёр хийх

214. РЫТЬ (копать) МОГИЛУ *кому, чему* Р—215

215. РЫТЬ (копать) ЯМУ *кому* [*перен.*] 1. нүх малта-; 2. Ул шагай-; бөгс малта-. бөгсий нь хөндийл- К-443

Не рой другому ямы, сам в неё попадёшь үгчилбээс: хүнийг унагах алам бүү малта! Өөрөө дотор нь ойчдог (утга нь мэхт мэхэндээ; өөд нь хаясан чулуу өөрийн толгой дээр шүү. Муу санаа өөрийгөө отно; сана муут яван хатна, сарьсан багваахай наранд хатна)

216. РЫТЬСЯ В ГРЯЗНОМ БЕЛЬЕ *чьем* [*разг*] муугий нь дуудаж малгайгий нь сөхө-, сорхойгий нь уудла-; өргөсий нь маажи-; булайгий нь гаргаж, бузры нь уудла-; мөөрий нь дэлгэ-; паянгий нь дэлгэ-; мундры нь дэлгэ-; долоон булчирхайг нь тоочи-; боолыхойгий нь илчлэ-. К-444

217 РЫЦАРИ БОЛЬШОЙ ДОРОГИ [*ирон.*] зам хайчлаачин; зам огтлуур; зам тосоочин

218. РЫЦАРЬ БЕЗ СТРАХА И УПРЁКА [*перен.*] 1. журамт баатар; чигч баатар эр. 2. Ноён нуруутай хүн; гүндүүгүй хүн бүдүүн томоотой хүн.

219. РЫЦАРЬ НА ЧАС санаа нь зөв ч сачий нь дутмаг (хүн), аян даахгүй, туувар гүйцэхгүй, ачаа дагахаа байсан, сэтгэл нь л хэвээрээ, хий л санаа

220. РЫЦАРЬ ПЕЧАЛЬНОГО ОБРАЗА санаанаас цаашгүй хүн, хий, бодолтон, бодлого бишдүүрлиг болсон хүн

221. РЯДИТЬСЯ В ТОГУ *кого-чего* [*ирон.*] хуурамчила-.

Рядиться в тогу героя баатархархаж; баатар хүн болох гэж.

С

1. С АДАМА О—209

2. С АЗОВ эхнээс нь багаас нь эхлэн; дороос нь, наад захын юмнаас нь аваад

3. С **БЕЗУМНЫХ ГЛАЗ** [*прост.*] өөрийн эрхгүй болсон (янзтай), ухаан нь ууланд гарсан, учраа олохгүй, ухаангүй

4. С **БЛАГОСЛОВЛЕНИЯ** ... ны таалсанчилан, ... ны болгоос ноор, ... ны нөхөлөөр.

5. С **БОГОМ?** Тэнгэр өршөө! тэнгэр нөхөө.

6. С **БОЖЬЕЙ (божией) ПОМОЩЬЮ** тэнгэр нөхөөтүгэй, тэнгэ р чамайг өршөө! үйлс чинь бүтэх болтугай!

7. С **БОКУ ПРИПЁКА** [*прост.*] илүүдэх гарсан, хэнд ч хэрэггүй, (хүн) юм байхгүй гээд дутахгүй, 2. Холбогдолгүй, падгүй, хамаагүй, хүртээлгүй. С-210

Я в этом деле с боку припёка энэ явдалд би огтхон ч холбогдолгүй

8. С **БОЛЬНОЙ ГОЛОВЫ НА ЗДОРОВУЮ (валить, переклабывать)** [*разг.*] буруугаа (боолихойгоо), бусад руу чихдэг (бухдаг, тохдог нялзаадаг, сруулдаг). гэм **зэмээ бусдад нялзаа-,буруугаа бусдад халдааж, бузраа олонд нялзаах, тархин дахь хог новшсо бусдын савруу албан хүчээр чихдэг.**

9. С **БОЛЬШОЙ БУКВЫ** чухам тэр, мөн өнөөх, яг тэр хүн, нөгөөдэх чинь, яагаа вэ нөгөөдөх, андашгүй л дээ,

10. С **БОРОДОЙ** [*разг.*] хуучны, уяирсан, өвгөрсөн, хөзөө язааны элэгдсэн, гууль нь цухуйсан, аль диван арын

11. С **БОРУ ДА С СОСЕНКИ** [*разг.*] **есөн шидийн (дээдийн,жорын** өнгийн, хэлийн, омгийн) амьтан хөлхдөг (**хөлхидог, бужигнадаг,** байдаг, оршдог, цугладаг, сронодог, явдаг, зорчдог) газар (орсн) элдэв дээдийн (янзын, бусын, өнгийн, омгийн, шаддвын, газрын) газар орны уяс байдаг газар, долоон жорын амьтан бөөгнөдөг, зүсэн зүйлийн юмс байдаг, сайн муу, сархинагтай баастайгаа байдаг И—45

12. С **БУХТЫ-БАРАХТЫ** [*разг.*] түс тас, эрс (шулуун) шууд, бодол оролгүй, хий хүй шиг хөнгөн хуудам. балиу тавин,

13. С **ВАШЕГО ПОЗВОЛЕНИЯ (разрешения)** [*разг.*] та таалбал, таны таалалд нийцвэл (зохирвол), ... бая болохсон болов уу, ... -бал[4] яана, ... баас[4] ямар вэ, таныг ... үгүй бол нигэе (чингэе).

С вашего позволения я воспользуюсь вашим телефоном. Та таалбал утсаар тань нэг яриад орхие.

С вашего разрешения я возьму это Таны таалалд нийцвэл би энүүнийг авъя даа.

14. С **ВЕДОМА** *чьего кого* ... мэдээд, ... за хүлээсэн ... тэр гэсэн

Это сделано с его ведома тэр хүн инге гэсэн юм шүү

15. С **ВИДУ** харваас, харах өнцөнөөсөө (царайнаасаа), гаднаас нь харахад л, андашгүй, үзтэл, байр байц нь, **байдал төрх нь, янз байдал нь, хэлбэр галбир нь, хийц маяг нь,хэмжээ дамжаа нь.**

16. С **ВИЗИТОМ** гийчнээр, зочилж, айлчлан **уригдан, залагдаж,** хүндтэй мэндтэй.

17. С **ВЫСОТЫ СВОЕГО ВЕЛИЧИЯ** хүлцэнгүй, тэр гуай, энэ гуай гэж зөөлхөн, өргөн хүндэлж, аяар дуугаар, чих зөөлөн, зөвшингүй, халирхай, нийцэнгүй.

18. С **ГАКОМ** [*прост.*] илүү, гаруй, давуу, цаана, хол, агтлуу.
Десять километров с гаком арван километр илүү
Часа три с гаком гурван цаг гаруйтай

19. С **ГЛАЗ ДОЛОЙ** [*разг.*] нүдэнд бүү үзэгд (**хол яв! нүдэнд үзэгдэхгүй чихэнд дуулдахгүй газар арил! Далд ор! Долоон** уулын цаагуур, дов шороон доогуур **ор! Тонил цаашаа яв жав,** гай болохоор зай болох.

20. С **ГЛАЗ ДОЛОЙ ИЗ СЕРДЦА ВОН** уулзахгүй болохоороо л мартчих нь тэр дээ! үзэхээ байхаараа л мартчихна, хоёр анд удаан эс уулзвал хогийн өвс дунд нь **ургадаг гэгчээр,** нүднээс далд орохоороо л зүүдэнд ч гүй болчихно,хамар даваад л мартчихна даа.

21. С **ГЛАЗУ НА ГЛАЗ** [*разг.*] хоёр хар толгойгоороо, амихандаа энүүхэндээ, нүүр нүүрээрээ.

22. С **ГНИЛЬЦОЙ** [*разг.*] үнэр орсон, жаахан бээмэл, хөндлөн амттай болсон, баахан хахарсан, эвгүй амт орсон, хуршсан, хухирсан, боршсон.

23. С **ГОДАМИ** яваандаа, яваа яваандаа, **байн байсаар,** жил жилээр, он улирахад, нас ахихад.

24. С **ГОЛОВОЙ** [*разг.*] 1. ус зэргийн (босоо хүний дайтай) гүн; хүн далд орчмоор гүн, 2. ухаан сайтай, сүрхий толгой, амаргүй толгой.

Здесь мелко, а там с головой энд гүйхэн, тэнд тэнь л босоо хүний дайтай гүн (хүн далдарна)

25. С **ГОЛОВОЙ УЙТИ (во что)** нэгэн үзүүрт сэтгэлээр хичээнгүйлэ-, зорьж оролдо-, амиа тави-, толгой дээш (өөд) татахгүйоролдо-, үхэн (үхэн хатан) зүтгэ-.

26. С **ГОЛОВЫ** хүн бүр ... хүн, толгойтой болгон ..., хохимой толгойтой хонгооroo суудаг болгон, бөгсөөрөө суудаг бөндгөр толгойтой болгон.

27. С (от) **ГОЛОВЫ ДО НОГ (до пят) (пят)** *буюу* С НОГ ДО ГОЛОВЫ зулайнаасаа аваад (ул) тавхайгаа хүртэл, эхнээсээ аваад дуустал, уртаашаа, бүхэлдээ. С-87

28. С **ГОЛОВЫ ДО ПЯТ** О—219

29. С **ГОЛОСА (петь)** 1. Дагаж дуул-; (ая дуу) хоолой нийлүүлэн (хоршин) дуул-, 2. аядан дагалда-, юу л бол юу, үг дагуул-, юу л бол жа, яа л бол зэ, дуугарвал дуу нэг, дугтарвал хүч нэг, ам нэгтэй, нэгэн дуугаар.

30. С **ГОЛЫМИ РУКАМИ** С—131

31. С **ГРЕХОМ ПОПОЛАМ** [*разг.*] нүглийн нүдний (цаасаар) гурилаар хаа (бөглө)-, хам хум, (ам хаах) албын хүчээр, дургүйд хүчгүй гэгчээр, (хуламдаж) оромдож орхих, болсон болгох, гэгсэт нигэсэт болох, тэгмэр нигэмэр болох, өвстэй шороотой нь хутгаж

32. С ГУЛЬКИН (с воробьиный) НОС [*прост.*] 1. өчүүхэн,алгын чинээн, багашаар 2. маш өчүүхэн, бичил, жаахан, жижигхэн.

33. С ДАВНЫХ ПОР хэдийнээс, хэзээнээс, аль эртнээс, дээр үеэс, хэзээ язааны.

34. С ДОРОГИ 1. замдаа, зам зуур, замын гудас, аяны замд 2. Аянаас, аянаас ирээд (ирмэгц л) ирэнгүүтээ, ирэв үү, үгүй юү л

35. С ДРЕБЕЗГОМ [*разг*] жонгиносон дуутай, янгинасан дуутай, янгинуур, цуурай дуутай, хүүхэн хоолойтой, жингэнэсэн дуутай, нарийн дуутай, цангинасан дуутай, дуу нь тунна муутай.

36. С ДУШИ ТЯНЕТ. (рвет воротит) *от чего* [*разг, фам.*] [*прост.*] их дургүй яснаасаа зэвүүцдэг, үзэж чаддаггүй, нэг нүдээр үзэхгүй, (хүнд) их муу, чоно шиг боддог, нүд үзүүрлэдэг.

37. С ДУШОЙ үнэн санаанаасаа, хийе гэж хийх, чин сэтгэлээрээ, өөриймсгөөр, эзний ёсоор, миний юм манай юм гэж.

38. С ЖИВОСТЬЮ сэргэлэн, өөдрөг, хийморилог, цогтой, галтай, сүмбэтэй, цовоо ирмүүн, золбоотой, авхаалжтай.

39. С ЖИВОТОМ [*прост.*] (жирмэсэн) гэдэстэй, их гэдэстэй, (бие давхар, бие шалтгаантай, хөл хүнд, бие муутай, юмтай, давхар биетэй, хүүхэдтэй) олз олсон.

40. С ЖИРУ БЕСИТЬСЯ [*прост.*] эрхээрээ хатсан, эрх жаргалдаа гортсон, баян хүн бачтан нь болсон, торгонд умбаж, хурганд хөлбөрө-,

41. С ЗАКРЫТЫМИ ГЛАЗАМИ замаараа залбирч, мөрөөрөө мөргөсөн, гүдэс чигээрээ, энээ тэрээ байхгүй, гудиггүй, хүслээ тэвчсэн, харсан ч хараагүй юм шиг, үзсэн ч үзээгүй юм шиг, атаа мөчөөрхлөөсөө хагацсан, мэдсэн ч мэдээгүй юм шиг, нүдэн балай, чихэн дүлий, түс тас.

42. С ЗАМИРАНИЕМ СЕРДЦА амьсгаа даран, сэтгэл түгшин (байж) зүрх догдлон.

43. С ЗАТАЁННЫМ ДЫХАНИЕМ [*разг.*] амьсгаа даран, (хичээ-, анхаара-, хий-), чих тавин, хатангатан чагна-, толгой гилжийн.

44. С ИГОЛОЧКИ (одет) цоо шинэ хувцастай, (ява-), сая хийсэн хувцас, сая зүүнээс гарсан, нарийн хир ч асаагүй, (суугаагүй, болоогүй).

45. С ИЗЛИШКОМ илүүтэй, дэндүү, ихэдсэн, бялхаад, жаахан дэндээд, хэтрээд, үлдээд даваад, гаруйтай.

46. С КАКОЙ СТАТИ! [*разг.*] хэрхэн яах гэж? ямар учраас? яагаад? яахлаараа? юу боллоо гэж? яаж байгаа чинь энэ вэ? яахаараа ингэдэг байна? юун тухай, юуны учир (тул), учир начир нь юу юм? яасан дээрээс?

С какой стати платить такие большие деньги? яах гэж ийм их мөнгө зарах юм? (юу боллоо гэж ийм их мөнгө зарах билээ?

47. С КЕМ ПОВЕДЁШЬСЯ ОТ ТОГО И НАБЕРЁШЬСЯ шунханд ойр бол улаан, хөөнд ойр бол хар, алтны дэргэд байсан гууль шарладаг, алтны уул шар, сайныг дагавал сарны гэрэл, мууг дагавал могойн хорлол, хүрээнд суусан чавганцын чих цайдаг, модонд ойр нь бохь зажилдаг. бал барьсан хүн гараа долоодог, баас харсан хүн хамраа бөглөдөг.

48. С КОЛОМЕНСКУЮ ВЕРСТУ К-410.

49. С (от) КОЛЫБЕЛИ [*перен, книжн.*] хар багаасаа, хар нялхаасаа, балчир багаасаа, өлгийтэй байхаасаа, манцуйтай байхаасаа, хөлд орохоосоо, хэлд орохоосоо, нэг настай нялх үстэй байхаасаа, бүр жаахнаасаа, мэдээ орохоосоо, хүн болохоосоо, эхээс гарахын, заяаны

50. С КОЛЫБЕЛИ ДО МОГИЛЫ өсөхөөсөө аваад өвгөртлөө, ханан гэрт ирснээс аваад хадан гэрт очитлоо, нэг насаар, насаар, насан турхруу, насан турш, шүдлэн наснаасаа аваад шүдээ унатлаа, өсөх наснаасаа аваад өтлөх насаа хүртэл, эсгий гэрт мэндлээд энгэр газар түштэлээ, хүний мэдрэл орноосоо аваад, нэг сүүдрээр, энэ яваадаа

51. С КОНДАЧКА хөнгөн хуудам, эр шууд, түс, тас, нэгмөсөн, барнут л

52. С КОРТОЧЕК (подняться, встать) [*разг.*] өлмий дээрээ (бос-, өндий-)

53. С КОСТЕЙ ДОЛОЙ бие хөнгөрөөд яьчих шиг, залуу болчихсон шиг, сэв хийгээд явчи-

54. С ЛЁГКИМ ПАРОМ [*прост.*] (рашаан ус, угаалганд ороод гарч ирж байгаа хүнд хэлдэг үг, монгол хэлнээ мөн үүнтэй утга дүйх, хүндэтгэлийн үг байдаг) сайхан булхав уу? (рашаан усанд орохыг рашаанд бүлхах; голын усанд орохыг мөн хүндэтгэж голд булхах гэхчлэн өгүүлнэ) рашаан сайхан зохиж байна уу? гэж бас хэлдэг. Рашаан ууснаг бол: рашаан сайхан зооглов уу? гэж асууна, хариуд нь сайхан хүртлээ гэдэг.

55. С ЛЁГКИМ СЕРДЦЕМ [*разг.*] санаа амар, хөнгөн шингэн, хөнгөн шуурхай, шав шув хийгээд, дэгдэгнүүлээд, дэдэгнэн дадаганан цочис татас, шилтэгнэж, тавьтаргүй, догдолзуулаад, хөнгөн сэтгэлтэй.

56. С ЛЁГКОЙ РУКИ *чьей* [*разг.*] явдал урагштай эхлэх, гараа нь зөв, эхлэхээсээ л овоо, зөв дөртэй эхлэв.

57. С ЛИСТА (играть петь) нот харж дуул- (хөгжимдө-)

58. С ЛИХВОЙ [*разг.*] хүү ихтэй, хожоотой, элбэг дэлбэг нулга хожиж, илүүдэлтэй үлдэгдэлтэй

Затраты вернутся с лихвой зарсан мөнгөөрөө их хүү олдог.

59. С ЛИХОЙ СОБАКИ ХОТЬ ШЕРСТИ КЛОК авахдаа аралба, өгөхдөө өрөлбө (харамч хатуу хүний) гараас нь юм салгахад хэцүү, хялгас шиг нарийн (харамч) хүн, лонхонд унгаад нохойд зайлж өгөхөөр, гар татуутай, харамчийн хар тулам, авахдаа бөхийдөг, нарийн л хатсан, өгөхдөө гэдийдэг, эвэр гартай, хорголоо тоолсон амьтан

60. С ЛИЦА ЗЕМЛИ СТЕРЕТЬ сөнөөж дуус-, үгүй хий- үсгүй арчи-, хүйс тэмтрэ-.

61. С ЛИЦА НЕ ВОДУ ПИТЬ (шинэ бэр зэрэг) царайны сайхан муухай хамаагүй, сайхан муухай нь царайдаа биш, царайны сайхнаас чанарын сайхныг хар, хүзүүнээсээ доош хүүхэн бүхэн адил, царайгаар нь цэй сүлдэггүй, зүсний сайхнаас цөсний сайхан,

62. С ЛИШКОМ (С ЛИШНИМ [*разг.*] илүү (тэй), гаруй, давуу.

Два часа с лишком хоёр цаг гаруй

Два рубля с лишним хоёр рубляэс илүү

63. С ЛИШНИМ С-62.

64. С ЛУКАВИНКОЙ [*разг.*] (цаанаа л) нэг жоготой, тархигүй шинжтэй, дүрсгүй янзын хүйтэн харцтай, нүдэнд хүйтэн.

С лукавинкой во взгляде цаанаа л нэг жоготой харцаар (царайнаасаа л нэг жоготой).

65. С МАЛЫХ ЛЕТ [*разг.*] хар багаасаа, бага наснаасаа, бага балчир сайхаасаа.

66. С МАХУ [*разг.*] байдаг чадлаараа, (тэнхээгээрээ) хар бяраараа, хар хүчээрээ, барин тавин, бүсэн суун, хар тэнхээгээрээ.

Ударить с маху хар бяраараа цохи-, (**далайж далайж** бууля-).

67. С МЕСТА (берёт, развивает ход и. т. п.) тэр дороо, зогсоогоор нь, тэр даруйд, гарангуут л, цойлоод, сугараад л,

68. С МЕСТА В КАРЬЕР [*перен.*] тэр дор нь, **даруйд** нь, хойш тавилгүй шуудхан, нэн даруй одоо даруй

69. С МЕСТА НА МЕСТО [разг.] наана нь цаана нь болго-, нүш нь тийш нь аваачи-, холхинул-, шувуу шиг, хөөр тийш нь (зөөх), өвд нь уруу нь болго-.

70. С (на) МИЗИНЕЦ-ялимгүй, өчүүхэн, шалихгүй **четверийн** бага нь адтай.

71. С МИЛЫМ РАЙ И В ШАЛАШЕ сэтгэл **уужим** бол өвсөн урц ч уйтан биш

72. С МИНУТЫ НА МИНУТУ мөдхөн, удахгүй, даруйхан, одоохон, нигэсгээд, тэгсгээд, даан удахгүй, мөн одоо, **жаахан** азнаад, юу удах вэ, яах нийхийн зуур (хооронд).

Он придёт с минуты на минуту (тэр хүн) одоохон ирнэ

73. С МИРОМ 1. эрх дураараа, зэрлэг тэнүүн, эрх **таваараа**, энх амар, эетэй, зохиотой, 2. сайн **яваарай**, дараа **баяраар** учиръя, сайн сууж байгаарай.

74. С МОЕ над шиг, миний дайнд, миний насанд, **миний** хирийн,

75. С (от) МОЛОДЫХ НОГТЕЙ хар багаасаа, **нд залуугаасаа**, идэр залуугаасаа, бүр өдийхнөөсөө, хүүхэд **ахуйгаасаа**, нялхынхаа

76. С МОЛОТКА (устар) үнэ **хаяацуулан**, дуудан (**худалда-**)

77. С МОЛОТОЧКА (устар)цоо шинэ, шив шинэхэн, дөнгөж хийсэн эдлээгүй, гар хүрээгүй. П-431, П-484

78. С МУХОЙ [*прост.*] халамцуу, нийшингээ хаяасан, балгасан, юм оочсон, П-431, П-484

79. С МЯСОМ ВЫРВАТЬ [*разг.*] (товч) ханзачиж (өмчиж), ойчи-

80. С НАЛЁТА *буюу* **С НАЛЁТУ** хар хурдаараа, нисэх мэт, гүйдэл дундаа, сандан, мэндэн, бажга харайн, бажга алдан, агадам тэвдэн, хөл нь газар хүрэхгүй, нисэн алдан.

Ответить с налёта сандан мэндэн харилца-.

81. С НАМИ КРЕСТНАЯ СИЛА [*прост.*] тэнгэр өршөө! тэнгэр таалж соёрхо! маны бишрийн хүчээр тэнгэр биднийг **таалан** соёрхо!

82. С НАСКОКА [*разг.*] сандан мэндэн, ухаан жолоогүй, ум хумгүй, нисэн алдан, харайн дүүлэн, хөл газар хүрэхтэй хүрэхгүйтэй, газраас хийрэн хийрэн.

83. С НАЧАЛА ДО КОНЦА эхнээсээ аваад эцсээ хүртэл, дээрээсээ аваад дороо хүртэл.

84. С НЕБА СВАЛИТСЯ (упасть) [*разг.*] тэнгэрээс буусан юм шиг, гэнэт гарч ирэ-,

85. С НЕБОЛЬШИМ жаахан **гаруй**, жаахан өнгөрсөн гаруйхан, илүүхэн, ихээхэн, давуухан, ойрхон гараа-,

Сто с небольшим Зуу жаахан **гаруй**

86. С НЕЗАПАМЯТНИХ ВРЕМЁН тэргүүлэшгүй цагаас наана, аль дивангарын.

87. С НОГ ДО ГОЛОВЫ С-27.

88. С НОГОТОК хумсын толион чинээ, хумсын чинээ, хуруун чинээхэн, чиг чийн чинээн, чихэн чинээн (хүү-үлгэр)

89. С НОСА [*прост.*] ам бүрээс, толгой тоотоос, хүн болгоноос, хүн хүнээс, хүн нэг бүрээс, хүн тооноос.

90. С НОСОМ ОСТАВИТЬ *кого* [*разг.*) малла-, хуура-, толгойгий нь эргүүл-, үхэр шиг дөрлө-, хамраараа газар хатгатаа маллагда-, үнэгэнд хууртсан нохой шиг.

91. С НОСОМ ОСТАТЬСЯ (быть) [*разг.*] маллуул-, хууртагда-, толгойгоо эргүүлүүл-, араараа тавиул-, үнсэнд хутгуул-, үнэг барьж сурч буй нохой шиг.

92. С НОСУ (брать, получать) [*прост.*] хүн бүрээс, толгойтой болгоноос, үүнд нэг сонирхолтой зүйл бол монгол хэлнээ *амтай болгон*, *толгойтой бүр* гэх мэтээр хэлдэг бол орос хэлнээ *хамар бүрээс*, *хамартай бүрээс* гэсэн шиг хэллэг байна. Үгчилж орчуулбал монгол хэлэнд ямарч утга гарахгүйд хүрнэ.

93. С ОГЛЯДКОЙ хаширлаж, хаягаа манаж,

94. С ОГОНЬКОМ уухайн тос гэж, сүржигнэн, омог бардам (хийх)

95. С ОДНОГО ДЕРЕВА нэг эхээс гарсан юм шиг, нэг хэвээр цутгасан юм шиг, нэг дошны мөндөл.

96. С ОДНОГО (единого) МАХУ [*разг.*] нэг бариагаар, нэг амиар, нэг дор, нэгмөсөн, ганц ухасхийгээд л, гар хүрэв үү үгүй юү л, шүүрэнгүүт, нэг амьсгаагаар.

97. С ОДНОЙ СТОРОНЫ . . ., С ДРУГОЙ СТОРОНЫ . . . 1. Нэгэнтэйгүүр, нөгөөтэйгүүр, нэгдэж ирэхэд . . . хоёрдож ирэхэд, 2. хэдийвээр, . . . боловч, . . .

98. С ОТКРЫТОЙ ДУШОЙ (сердцем) ариун цагаан сэтгэлээр; сайн санааны угаас; итгэсэндээ; нл хэлэхэд. Ч-117

99. С ОТКРЫТЫМ чин үнэнээсээ (үнэнээрээ), үнэн голоосоо, хуурмаггүй, нууж хаах юмгүй, байгаа нь л тэр

100. С ОТКРЫТЫМ (поднятым) ЗАБРАЛОМ цагаандаа гарч, илэн далангүй, нууж хаалгүй. Б-57

101. С ОТКРЫТЫМИ ГЛАЗАМИ [*перен.*] хараажаар ил, хартал нь ил, мэдээжийн, хэн ч харсан мэдмээр, хэний ч нүдэн дээр,

102. С (от) ПЕЛЁНОК *буюу* **С ПЕЛЕН** багаасаа, хар багаасаа, нялхаасаа, нялх балчираасаа, жаахнаасаа, булбарай цагаасаа.

103. С ПЕНОЙ У РТА (С ПЕНОЙ НА УСТАХ) [*перен. разг.*] уур нь хүрч уушиг нь сагсайх, дээлэндээ багтахгүй уурлах, уур нь хагачих, уур нь шатах, шар нь гозойх, шар нь хөөрөх, шар нь буцлах, шар нь хөдлөх, Б-57

104. С ПЕРВОГО АБЦУГА анхнаасаа; бүр эхнээсээ, эхлэхээсээ.

105. С ПЕРВОГО ВЗГЛЯДА харад л; анх харад л, ганц харад л, эхлээд л харахад, хармагц л, харангуутаа л, үзэнгүүтээ л, харуут л. П-289

106. С ПЕРВОГО ЗНАКОМСТВА нүүр үзмэгцээ, мэндийн солио хийв үү, үгүй юү, уулзсан өдрөөсөө л, анх танилцсан цагаасаа л.

107. С ПЕРВОГО СЛОВА (слов) ам нээмэгц л, төдөлгүй, ганцхан үгэн дээрээс л,

108. С ПЕРЕВАЛЬЦЕМ (ходить) [*разг.*] найган ганхан (ява-), гуйван дайван (ява-) гулжиганан,салжиганан, салдиргалан, туйван.

109. С ПЕРЕПОЯ (С ПЕРЕПОЮ) [*прост.*] (сархадаа ихэдхэж) шартаад, мангартаад,

Болит голова с перепою шартаад толгой өвдөж байна.

110. С ПЕРЕПУГУ [*разг.*] цочоод, айсандаа, самгардсандаа, агадсандаа, мэгдсэндээ, давхийгээд, бусгаад, ухасхийгээд.

111. С ПЕСКОМ (пробрать, прочистить и. т. п.) хатуу хэлэх гашуун үг хэлэх, сайн хараагаад тавих.

112. С ПЕТУХАМИ (встать, подняться) тахиа дуугарахаас өмнө (бос-, өндлө-), өглөөний шувуунаас өмнө, үүрийн таван жингээр.

113. С ПИВНОЙ КОТЁЛ [*прост*] данхар толгойтой, зантгар толгой, зантайсан (зэнхайсан) толгой, махан толгой, дэгхэр толгой, агаруу толгой, чингэлэг толгой, авдар толгой, галзуу нохойн толгой шиг.

114. С ПИСАНОЙ ТОРБОЙ НОСИТСЯ *с кем чем* [*разг.*] **улиг,** болсон юмаа улиглах, бахи байдгаа л ярих, домогтоо улигалах амныхаа уншлагыг уншиж гарах.

115. С ПЛЕЧ (с рук) ДОЛОЙ (что) [*разг.*] за нэг санаа амрав, дотор онгойв, сэтгэлийн зангилаа тайлагдав, сэвхийв, сэтгэлийн бөөдий арилав, дотор далай болов.

116. С ПЛЕЧА (рубить) 1. тас цавчи-, 2. түс тас шийдэ-, нэг бариад л нэг тийш нь болго-, хамаа намаагүй, мэндэн сандан, 3. (хувцас) өгөр ч хуучирсан, өнгө доторгүй буучихсан, лавдар савдар хийсэн, онхор цонхор болсон, унжин санжин, элэнхий түлэнхий, эрийн нэг унжсан санжсан, навсай, дамбай.

Этот вопрос нельзя решать с плеча энэ асуудлыг тэгж хамаа намаагүй шийдчихэж болохгүй.

117. С ПОВИННОЙ (прийти, явиться и. т. п.) гэмээ хүлээ-, буруугаа мэдэ-, нүглээ наманчила-,

118. С ПОВИННОЙ ГОЛОВОЙ (головушкой) гэмээ мэдэ-, тоогүй юм болсноо ухаара-, амаа бари-,

119. С ПОДХОДЦЕМ [*разг. неодобр.*] тойруулсхийгээд, дөхүүлээд, битүү хатуу (хэлэ-), зайцуулаад.

Всегда говорить с подходцем үргэлж тойруулж яри-

120. С ПОЗВОЛЕНИЯ СКАЗАТЬ [*ирон*] 1. . . . нэртэйгээс цаашгүй нэр хэмээсэн, хэмээгч, шүү юм нь, 2. эрээ цээргүй хэлэ-, па, лайтал хэлэ-, санаснаа хэлээд тавьчи-, тэгэж нигэж хэлэх үндэстэй.

Этот, с позволения сказать, отец продал свою дочь эцэг нэриээс цаашгүй амьтан нь охиноо худалджээ, (эцэг шүү юм нь охиныхоо толгойгоор ус уужээ).

121. С ПОЛИЧНЫМ ПОЙМАТЬ (захватить и. т. п.) (хулгайч зэргийг) тэр дор нь бари-, болсон газар дээр нь бари-, халуун мөрөн дээр нь (ганц алхуулалгүй бари-, ганц гишгүүлэлгүй, төө гишгүүлэлгүй, сөөм ч газар явуулалгүй) бари-.

122. С ПОЛСЛОВА (с полуслова) ПОНИМАТЬ [*разг.*] хэлэнгүүт л мэдэ-, үг цухуйлгамагц л ухааны нь ол-, хэлэхтэй зэрэг л андахгүй, (ам) ангаймагц нь сэрхий-.

123. С ПОЛУЧЕНИЕМ СЕГО . . . . . энэхүү бичгийг авмагц . . . үүнийг хүлээн авмагц.

124. С ПОМОШЬЮ *кого- чего* . . . аар[4] . . . нд л.

Я окончил вуз лишь с вашей помошью би таны дэмжлэгээр л дээд сургууль төгслөө.

125. С ПОСКОННЫМ РЫЛОМ ДА В СУКОННЫЙ РЯД С—146

126. С ПОТОЛКА ВЗЯТЬ *что* [*разг, шутл.*] санаанаасаа гарга-, өөрөө зохио-, хамаагүй хэлсэн-, цээжээрээ шаа-.

127. С ПРИДУРЬЮ [*разг.*] мангар зантай, этгээд ааштай, (адуу мал бол) аатай, омголон, давдачисан зантай, давилуун ааштай, адаар зантай,

128. С ПРИРОДЫ О-240

129. С ПРОТЯНУТОЙ РУКОЙ (ходить, стоять и. т. п.) [*разг.*] өршөөл эрэ-, өршөөл гуй-, гуйж гувши-, хошуу норвой-,

130. С (высоты) ПТИЧЬЕГО ПОЛЁТА 1. явуут (дундаа) гүйлгэн хара-, их дээрээс хара-, сүмир уулын оройгоос харах мэт, харан өнгөрө-, тоймы нь үзэ- 2. [*разг. ирон*] гүймэгхэн хара-, өнгөцхөн, там тум, хам хум, хөнгөн хуумгай, хайни яаш, тоймло-, дайруут, шүүрүүт,

Вид города с птичьего полёта хотын байдлыг (тоймы нь) харан өнгөрөх (хотыг дээрээс нь харахад)

131. С ПУСТЫМИ РУКАМИ [*разг.*] гар хоосон, гартаа юу ч үгүй, **ганзага** хоосон, (гуяа) ганзагалж, ганзагаа мялаалгүй, С-30

Пришёл с пустыми руками гуяа ганзагалж ирэв.

132. С ПЬЯНЫХ ГЛАЗ [*прост.*] согтуу хөлчүү, согтуугаар, согтож мэлийцрээд, архины андуу, сархдын сандуугаар, П-304,305

Заблюдиться с пьяних глаз согтуу яваад төөрцөрө-,

133. С РАЗВАЛЬЦЕМ *буюу* **(С РАЗВАЛЬЦОЙ)** [*разг.*] 1. гуйваганан, 2. сал сул, салан, цалгар наазгай, наазгар, салан задгай, **задгай** зайдан, назгай, назгар.

Работать с развальцем салан цалгар **ажилла-** (цалгар назгай ажилда-).

134. С РАСПРОСТЕРТЫМИ ОБЪЯТИЯМИ найр тавин хүлээж авах, хөл хөөрцөг болон угтах, **хөл алдан (ширээ** тавин ширдэг дэвсэж угтах).

135. С РУКАМИ ОТОРВАТЬ булаах шахам (ав-) **уухайн** тос гээд ав-), уухайн хужир боя-.

136. С РУК ДОЛОЙ за нэг хөр яс **саялаа,** дуусаж **саялаа!** яс амарлаа! ингэж салдаг юмаа бас! **арайхийж цааш нь харуулласүүл** мунгимар боллоо.

137. С РУК НА РУКИ ПЕРЕДАТЬ И-176

138. С РУК СБЫТЬ (спустить) *кого что* [*разг.*] . . . **аас** ангиж ра-, . . . аас саяж амра-, . . . ийн гараас мултра-, . . . тай ороодолдохөө бай-.

139. С РУК СОЙТИ [*разг.*] яланд орсонгүй, хэрэгт **орсонгүй,** юм үзсэнгүй, хал бал болсонгүй

140. С РУК ТОРГОВАТЬ дуудаж зара-, ганзагалж худалда-, явж худалда-, доншуучлан наймаала-, хэсүүчлэн наймаала-, явуут худалда-, явуул худалдаа

141. С РУКАМИ ОТОРВАТЬ *что* [*разг.*] өрсөн (хуцалдаж) ав-, авахаас нь урьд ав-, үнэ хайргүй өрсөж ав-, булаах шаха-, **удаа дараа** гэлгүй урт гартайгаар ав-, үнэ зодо-, үнэ цохи-

142. С РУКИ [*разг.*] 1. амар, хялбар төвөггүй, авсаархан. 2. *чьей с чьей* **лёгкой руки** ядах юмгүй, цохолтгүй, **гарын** үзүүрээр, гар **хуруугны** үзүүрээр, гар хүрээд л.

Ехать в месте с вами мне не с руки. тантай цуг явах, **надад** төвөгтэй байна шүү (тантай **явахад** ч **горьгүй** дээ)

143. С СЕРДЦЕМ (сказать, сделать) [*прост.*] уурлан, хилэгнэн, ундуучаж, ундуурхан, уур нь хүрч уушги нь сагсайж уцаарлан, зүрхний өвчин нь хөдөлж,

144. С СЕРДЦОВ С-143

145. С СОБАКАМИ НЕ СЫЩЕШЬ *кого что* [*разг. шутл.*] хайх мөргүй харах бараагүй, ул мөргүй алга бол-, хэл ул тасра-, эрээд эрээд олдохоосоо өнгөрсөн нохойн замаар орсон, эрээд сураад олдохгүй, сураг тасарсан, сураг тавиад ч дэмий.

146. С СУКОННЫМ РЫЛОМ ДА В КАЛАШНЫЙ РЯД (не суйся) хирээ мэдэхгүй хэрээ луугны маханд дурлав, мэдэхгүй байж цацэрхэх, чадахгүй байж бардамнах, тэмээнд хүрэхгүй гараа тэнгэр өөд сарвалзах, оготнын дуу тэнгэрт хүрэхгүй г. м. эсгий хийсэн газар хүүхэд нохойны хэрэггүй гэгчээр, илүү **хуруутай,** илүүр хошуутай, өөртөө хүртээлгүй юманд хошуу дүрэмтгий, үсэггүй бэйж үзэг бари-,

147. С ТЕМ ЖЕ УСПЕХОМ мөн өдүй (төдүй) чинээ үртэй, бүтэлтэй адилхан дүнтэй.

148. С ТЕХ ПОР (С ТОЙ ПОРЫ) тэр цагаас хойш, тэр үеэс хойш тэрнээс хойш.

149. С ТЕЧЕНИЕМ ВРЕМЕНИ яаандаан, **аяандаан, нэг л мэдэхэд**

С течением времени это пройдёт аяндаа өнгөрнө биздээ (нэг л мэдэхэд өнгөрсөн байна даа),

150. С ТОЛКОМ учиртай, ёсоор нь, ёсын дагуу

Говорить с толком учиртай (юм) яри-,

151. С ТОЧКИ ЗРЕНИЯ . . . ийн үүднээс, . . . ийн үзлийн **үүднээс**

152. С ТРЕСКОМ ПРОВАЛИТЬСЯ [*разг.*] балран уна-, шившгэ дэлгэ-, нэрийн хор бол-.

153. С ТРИ КОРОБА (наговорить, насказать обещать) [*разг.*] (баахан) дэмий чалчи-, бурж алда-, далан хэл дэлгэ-, амаа урчих шаха-, далан долоон үг дэлгэ-, зуун долоон үг дэлгэ-, есөн дээдийн (жорын, өнгийн) юм яри-, долоон жорын юм яри-, **элдэв** шалдав, (дээдийн, өнгийн) юм яри-,

154. С ТРУДОМ хад[4] хэцүү (бэрх) тийм л болтугай, эргэлзмээр, хардмаар, үнэншимгүй, сэжиглэлтэй, юу л болдоо гэмээр.

Верится с трудом итгэхэд хэцүү, итгэхүеэ бэрх

155. С ТЯЖЕЛЫМ СЕРДЦЕМ гунигтай, гомдолтой, сэтгэл гонсгор, бодолт автагдан, сэтгэл зовиуун, сэтгэл зовлонтой.

156. С УЛИЦЫ [*разг.*] үл таних хүн, танихгүй хүн, **зангий нь мэдэхгүй** хүн, зүс үзээгүй, зүс танихгүй, таньж мэдэхгүй,

157. С УМА НЕЙДЕТ Н-726

158. С УМОМ (делать что) бодлого сайтай, ухаалаг, суурьтай **хашир,** хэрсүү, хөнгөн хөдлөхгүй, дороо суурьтай дотроо ухаантай.

159. С ХВОСТИКОМ [*разг.*] гаруйхантай, (жаахан дөнгөж) өнгийсөн (гарсан) хэвийсэн, өнгөрч л яваа.

Он чет тридцати с хвостиком (тэр хүн) гуч л өнгийж яваа (байх) (тэр чинь гуч гарч яваа юм) (тэр чинь гуч хэвийсэн хүн)

160. С ХОДУ [*разг.*] зогсоо зайгүй, хурдаараа, гүйхээрээ, барим, тавим, босон суун, явуут дундаа.

161. С ЦАРЕМ (со своим царем) В ГОЛОВЕ өөрийн толгойтой, өөрийн бодолтой, өөрөө өөртөө эзэн, биеэ мэдэх, хувиа борлуулахтайгаа, хүний царай харахгүй, хүн царайчлахгүй, өөртөө зөв.

162. С ЧАСУ НА ЧАС мөдхөн, төдөлгүй, удахгүй, ингэс хийгээд, удаж төдөлгүй, одоохон.

163. С ЧЕГО [*разг.*] 1. яагаад, ямар учраас, 2. алинаас, хаанаас, юунаас,

С чего он взял яагаад авчихав?
С чего начать? алинаас нь эхлэх вэ? чухам хаанаас нь эхлэе дээ?)

164. С ЧЕСТЬЮ хүндтэй мэндтэй, ёстой төртэй (хий-), хүн хэрэглэмээр, хүнд тоогдохоор, нэртэй, төртэй, хийсэн шиг хий.

165. С ЧУЖИХ СЛОВ хүний үгээр үг хийдэг, үхрийн баасаар балин хийхэг, хүн л юу бол юу гэж ярьж явдаг, хадны цуурай шиг, тоть шиг, тотьчилж явдаг, хүний амнаас будаа иддэг, нохойн сахлаар гийдаа хутгадаг.

166. С ЧУЖОГО ГОЛОСА (говорить, петь) С-165

167. С ЧУЖОГО КОНЯ ПОСЕРЕДЬ ГРЯЗИ ДОЛОЙ хүний юм хүчтэй, хүний юм хүнд наалддаггүй, хүний юм хүссэний цаашаа, хүүтэй цай хөөтэй.

168. С ЧУЖОГО ПЛЕЧА элбэгдсэн, дах шиг (хувцас), гомдож орхисон, далхайсан, дэлхийсэн.

169. САВРАС БЕЗ УЗДЫ [*разг.*] дөргүй бух дөрөөгүй янхирцаг, бурантаггүй тэмээ, цадигаа алдсан амьтан, амгай жолоогүй эр.

170. САДИТЬСЯ (сесть) ЗА ОДИН СТОЛ эвлэрэ-, хэлэлцэ-,

171. САДИТЬСЯ (сесть) НА ХЛЕБ И (на) ВОДУ мацаг (мацаг, бацаг) бари-,

172. САДИТЬСЯ (сесть) НА ШЕЮ *чью кому* өргүүлэ-, хүний асрамжинд орс-.

173. САДИТЬСЯ (сесть) НЕ В СВОИ САНИ тэмээнд хүрэхгүй гараа тэнгэрт сунга-.

174. САЖАТЬ (посадить) В ЛУЖУ (в галошу) доромжло-, мууг үзэ-.

175. САЖАТЬ (посадить) НА ЗЕМЛЮ *кого* хөөж явуул-, хүчээр суулга-, нүүлгэ-, шилжүүл-.

176. САЖАТЬ (посадить) НА МЕЛЬ *кого что* үйл тамы нь үзэ-, амьдын нажидлан болго-, ясы нь цайлга-.

177. САЖАТЬ (посадить) НА ХЛЕБ И ВОДУ *кого* өлбөрөө-, өлсгө-, хоолы нь хаса-

178. САЖАТЬ (посадить) НА ШЕЮ *чью, кого кому* асрамжинд өг- тэжээвэр,

179. САМ БОГ ВЕЛЕЛ тэнгэрээс заяасан, (тийм ийм) тавилантай, заяамал, учир нь тийм, үйл тавилан нь, төрсөн өдрийн төөрөг, гарсан өдрийн гараг*.

180. САМ БОЛЬШОЙ (сам маленький) [*прост.*] алд биендээ эзэн болсон хүн, өөрийн толгойтой хүн, их гарын эр, их эд, их хүн,

181. САМ НЕ РАД [*разг.*] И-35

182. САМ НЕ СВОЙ биеэ барьж чадахгүй, өөрийн эрхгүй, эрхбиш, яадгаа алдаад,

183. САМ ПО СЕБЕ 1. хүний үнэр, хүн нь, хүнээр, хүний мөсөөр (ясаар) 2. өөрийгөө л борлуулдаг, амиа даачихтай, хүний царай харахгүй, хүний гар харахгүй, хүнээс гуйхгүй, хувиа тавихгүй, мөчөөгөө алдахгүй.

Сам по себе он человек не плохой тэр хүн уг нь муу ч хүн биш шүү (энэ ч уг нь хүний хувьд зүгээр шүү)

184. САМ СЕБЕ (хозяин) ГОСПОДИН өөрөө өөртөө эзэн, эзэн хичээвэл заяа хичээнэ гэдгийг, ном болгосон хүн, өөрийн толгойтой хүн, хувьдаа л эр бар, хирхэндээ шаг хийсэх хүн, хүний дор орохгүй хүн.

185. САМ СОБОЙ өөрөө болчихдог, амиа даачихтай, хүнээс гуйхгүй, хүний царай харахгүй, хувиа борлуулахтайгаа, өөртөө зөв, хүнд хувиа өгдөггүй,

186. САМ (сама, само) СОБОЮ өөрөө, аяндаа, зөнгөөрөө, тэгнэ дээ, тэгэлгүй яахав.

187. САМ ЧЕРТ НЕ РАЗБЕРЕТ (не поймет) *кому* [*прост.*] хал балгүй, элдэв тотгоргүй, айх аюулгүй, айлгах дайсангүй

188. САМ ЧЕРТ НЕ БРАТ *кому* [*разг.*] юунаас ч айдаггүй, номгүй хар гөрөөчин, хараад бариад (хүн) гудиггүй эр.

189. САМ ЧЕРТ НОГУ СЛОМИТ зуун задгай жаран хагархай, ундуй сундуй, эмх цэгцгүй, тэмээ туйлчихсан юм шиг, тайны орон шиг, хөлнөөр хөглөрсөн, чимбэргээний орон шиг, ачаалж амжаагүй айл шиг.

190. САМА СЕБЯ РАБА БЬЁТ КОЛИ НЕЧИСТО ЖНЁТ өөрийн хийсэн өөрт, өөрөө ойчсон хүүхэд уйлдаггүй, өөрийн хийсэн лай одоо яана гэх вэ, шаварт унасан шарын эзэн хүчтэй.

191. САМИ С УСАМИ [*прост.*] биднэр . . . аас, дутах нь юу байх вэ талтай бол бүлтэй, таахайтай бол шилбэтэй, хэний ч дор орохгүй, амьд хүн аргаа олдог, араатан гөрөөтөн нүхээ олдог, нохой хамартаа хүрэхээр усч.

192. САМО СОБОЮ РАЗУМЕЕТСЯ (САМО СОБОЮ) [*разг.*] тэгэлгүй яахав, мэдээжийн хэрэг, тэр ч тэгнэ дээ, асуултаангүй тэгдэг нь ёс (хууль)

---

* гараг гэж бичих ёстой учир нь энэтхэг, самгарди бичгийн хэлэнд граха хэмээн байдаг нь монгол хэлнээ орж гараг болон сунжирсныг мэдэхгүй гариг хэмээн нэрлэдэг *нохойн баас, бузар муухай* юмны нэр болгожээ.

193. **САМОЕ БОЛЬШЕЕ** олондоо л, ихдэхдээ л, цаадзах нь, дээ гайгүй л ихэдвэл, цаана хэлж.

194. **САМОЕ МАЛОЕ** [*разг.*] багадаа л, доор хаяхад (очиход), наад зах нь, үгүй хаяхад, үгүйдээ л, ядлаа гэхэд, адаглаад л, оргүйдээ л, юу ч гүйдээ л, хоосондоо л, сааж бодоход л.

Самое малое, двое суток пробуду в дороге дор хаяхад хоёр хоног явна (адаглаад л хоёр хоногийн газар бий).

195. **САМОЕ МЕНЬШЕЕ** С-194.

196. **САМОМУ ПОДРУБАТЬ СУК НА КОТОРОМ СИДИШЬ** өөрийн толгой руу өөрөө ус хий-, өөрөө өөртөө төвөг уда-, хар толгойдоо булуу хураа-, угруугаа ус хий-, амар байна уу гэсэн бини гай болох гэгчээр, шуухы нь авах гээд нүдий нь сохло-, зүгээр байсан бнеэ зүүгээр хатга-, өөртөө лай тари-, өөртөө гай тари-, түүгээр явсан гайг үүгээр чирч ирэ-, өөрийн муудаа өөдөө бара-,

197. **САМОМУ СЕБЕ МОГИЛУ РЫТЬ** үгчилбээс- өөрийнхөө буянныг өөрөө уха-. утга нь: унаж ойчих нүхээ өөрөө уха-.

198. **САМЫЙ ЧТО НАЗЫВАЕТСЯ** [*прост.*] ёстой . . . гэдэг чинь дээ . . . гэж хэлэлцдэг чинь л жинхэнэ

Самай, что называется красавица Гоо сайхан хүн гэдэг чинь энэ хүүхэн дээ.

Он был самый, что называется, добряк ёстой сайхан сэтгэлтэй хүн гэдэг чинь тэр хүн дээ.

199. **САПОГИ ВСМЯТКУ** [*шутл.*] чадчаа яриа, дэмий донгосол, галзуу хүний амнаас гарсан юм шиг, шал худлаа.

200. **САПОГИ-СКОРОХОДЫ** (хүүхдийн үлгэрт гардаг) нисдэг гутал, газар товчилдог гутал, хурдан гутал. С-345

201. **САРАЦИНСКОЕ ЗЕРНО** (пшено) тутраган будаа, тутрага, цагаан будаа.

202. **САХАР МЕДОВИЧ** [*разг.*] ам гэж алт, уран үгтэй амьтан, аман бал (алс цагнаа жад), гоо амтан, гооддог, хэлж чаддаг, хэлэхдээ сайн, амаараа гийгүүлдэг.

203. **СБИТЬ** (сбивать) *кого* **С ПАНТАЛЫКУ** [*разг.*] алий нь алдуул-, яахы нь алдуул-, аль ч учраа олохгүй болго-, аяцагчин балцагчин болго-. аяцан тээрэн бол-

Кто говорит, что надо ехать, кто говорит, что не надо, совсем меня с панталыку сбили яв ч гэх хүн байх л юм, байг ч гэх хүн байх л юм, алий минь алдуулчихаад байна.

204. **СБИТЬ** (сбивать) **С ТОЛКУ (С БИТЬ С ПАХВЕЙ)** *кого* будлианы нь хутга-, учры нь алдуул-, холнож гүйцэ-, замы нь алдуул-, үймэн айман болго-, мундар хутга-, холион баитай хий-.

205. **СБИТЬСЯ С НОГ** 1. сөгдүүл-, буулгаж ав-, 2. (ядраад) сөхөрч ойчи-, ядарч туйлда-, сульда-, тэнхэл тасра-, хөл туйвацэ-.

206. **СБИТЬСЯ С НОГИ** [*воен.*] хөлөө олохгүй, хөл нийлэхгүй

207. **СБИТЬСЯ** (сбиваться) **С ПАНТАЛЫКУ** [*разг.*] учраа олохгүй яахаа мэдэхгүй, хий уймра-, бажига харай-.

208. **СБИТЬСЯ** (сбиваться) **С ПУТИ** төөрө-, буруу замаар ороо-

209. **СБИТЬСЯ** (сбиваться) **ТОЛКУ (СБИТЬСЯ С ПАХВЕЙ)** уйман айман, будлианаа хутга-, учраа алда-, замаа алда-, яадгаа алда-.

210. **СБОКУ ПРИПЁКА** С-7

211. **СБРОСИТЬ** (сбрасывать) **МАСКУ** багаа хая-, хуурамч зангаа орхи-, засдаг зангаа тата-, багаа хуу тата-, гууляа цухуйлга-, зэс нь цухуй-, улаан цагаандаа гара-, эрээ цээрээ алда-, үнэн царай нь илрэ-.

212. **СБРОСИТЬ С ПЬЕДЕСТАЛА** С-224

213. **СБЫТОЧНОЕ ЛИ ЭТО ДЕЛО?** Энэ болно гэж үү? Тийм байбайна гэж үү? Тийм ёс хаана байх вэ?

214. **СВАЛИТЬ С БОЛЬНОЙ ГОЛОВЫ НА ЗДОРОВУЮ** В-460

215. **СВАЛИТЬ С НОГ** *кого* (ядраад эцээд) сөхөрч ойчи-, сөхчимах бол-, сульда-, туйва-. В-461

216. **СВАЛИТЬСЯ НА ГОЛОВУ (свалиться на плечи)** толгой дээр буу-, хар толгой дээр, лан (тан) буу-.

217. **СВАЛИТЬСЯ С ОБЛАКОВ** [*разг.*] гэнэт гарч ирэ-, тэнгэрээс ойчсон юм шиг. У-112

218. **СВАЛИТЬСЯ С ПЛЕЧ** 1. (нөмөрсөн хувцас) мөрнөөс мултра-2. Элэнхий халанхай бол-, урагдаад буучих, мөр улайхаар бол-, онхор цонхор болсон

219. **СВАЛЯТЬ ВАНЬКУ** Л-112

220. **СВАЛЯТЬ ДУРАКА** [*прост.*] 1. тэнэгийн дүр бари-, тэнэг бол-; 2. Тэнэглэ-, тэнэг юм хий-, мангарла-, муихаг мулгуу юм хий-, бодох санахаа алда-, сэрэх сэтгэхээ алда-,

221. **СВАТУШКИ (мэй)** [*разг.*] (айж цочиход дуу алдах үг) ижий минь! Ээж-ээ, элээ халаг? Халаг хоохой! Ээ надаг билээ. Хүй таминь ээ!

222. **СВЕДЕНИЕ СЧЕТОВ** 1. Данс дугуйл-; 2. Харнугаа (өшөөгөө) ав-. С-242

223. **СВЕЛА СУДЬБА** (свел случай) санаандгүй тааран, заяагаар учран, заяа нь хөтөлж уулзуулав-, ерөөлөөр.

224. **СВЕРГНУТЬ** (сбросить, свести) **С ПЬЕДЕСТАЛА** *кого* [*книжн.*] буура-, доройто-, нэр сүрээ алда-, мөрь нь явахаа байж байгаа. С-212

225. **СВЕРКАТЬ** (сверкнуть) **ГЛАЗАМИ** *на кого* хялай-, ширэ-, муухай хара-,

226. **СВЕРНУТЬ В БАРАНИЙ РОГ** С-672

227. **СВЕРНУТЬ ГОЛОВУ** (шею башку) *кому* [*разг.*] 1. хүзүүгий нь хуга (тас) мушги-, аман хүзүүгий нь ар дээр нь гарга-, 2. [*перен.*] амы нь бари-, нядла-, цаан харуул-, нугасла-.

228. СВЕРНУТЬСЯ КЛУБКОМ (в клубок) (үнэг, нохой, мий зэрэг амьтан) цавиндаа хошуугаа хийгээд хэвтэ-, цагриглан хэвтэ-, атиран хэвтэ-,

229. СВЕРНУТЬСЯ КРЕНДЕЛЕМ [*разг.*] бохирч хэвтэ-, сөхөрч хэвтэ-, (мал) хэвтэ-, эвхэрч хэвтэ-,

230. СВЕРХ АБОНЕМЕНТА 1. санасныг бодвол илүүтэй. 2. [*разг.*] [*шутл*] ир гээгүй байхад ирэ-, урилгагүй ирэ-, заллагагүй ирэ-,

231. СВЕРХ ВСЯКОГО ВЕРОЯТИЯ огт санаандгүй, зүүдлээ ч үгүй, зүүд зөнд ороогүй, тэгэх юм чинээ бодсонгүй, шигэнэ гэж хэн мэдээв дээ, дааны санаагүй байтал

232. СВЕРХ МЕРЫ давуу, хэтэрхий, дэндүү, илүү, чинээнээсээ давсан, хирнээс давуу.

233. СВЕРХ ОЖИДАНИЯ санаснаас, санаснаас, өөр, санаандгүй, гэнэ сэнэгүй санамсаргүй

234. СВЕРХ ЧАЯНИЯ П-39

235. СВЕРХУ ДОНИЗУ дээрээсээ доош (оо); шувт, хуу булт, орой-гоосоо авааd охор сүүлээ хүртэл, нэвт шувт, цоо, шалба, дуустал, шувтартал.

Провести линию сверху донизу дээрээс доош нь шугам тата- (доош нь шугамда-)

Дождь промочил его сверху дони зу Бороонд шалба цохиулав.

236. СВЕСТИ (сводить) В МОГИЛУ *кого* булшила-, эрлэгийнд авааchи-, мажийлга-, муу хий-, амий нь ав-, толгойгий нь залги-, голы нь гогодо-, бодий нь хөтөл-.

Воспаление лёгких свело его в могилу Уушигны өвчин толгойгий нь залгив.

237. СВЕСТИ (сводить) КОНЦЫ С КОНЦАМИ шар наран бор хоног өнгөрөө-, хоёр идэхгүй хоосон хонохгүй, мөчиг тачиг бай-, чуу чаа бол-,

238. СВЕСТИ (сводить) НА НЕТ үгүй хий-, байхгүй болго-, хуурайл-, хувхайл-, хоосро-, арилга, гөвө-,

239. СВЕСТИ НА СМАРКУ юм болохгүй, талаар бол-, дэмий өнгөрө-, үргүй өнгөрө-, хоосон ашиггүй бол-, олзгүй, бүтэлгүй болж өгөхгүй.

Все усилия была сведены на смарку зүтгээд зүтгээд юм болсонгүй.

240. СВЕСТИ (сводить) С УМА *кого* галзуурахаа шаха-, галзуурахад ганц хуруу дутуу, галзуу нохойн шүлс долоосон юм шиг, ухаан алда-, ухаан нь гарах шаха-, сүнс нь халц-.

241. СВЕСТИ СО ДВОРА хазаар гүйлгэ-, учир мэдэ-,

242. СВЕСТИ (сводить) СЧЕТЫ *с кем чем* С-222

243. СВЕСТИСЬ (сводиться) НА НЕТ С-680

244. СВЕТ ЖИЗНИ *чьей* хүний ганц хайртай юм нь буюу хүний зүрх минь (нь, чинь, тэнь, тань), хонгор минь (нь, чинь

тань, тэнь), голт зүрх (нь), ганц зүрх, амин сүнс нандин юм, аминаасаа хайртай юм, мэлмийн шүтээн минь, мэлмийн мялаагч минь, сэтгэлийн зул минь, лагшны тань нарнаас зүрхний минь цэцэг холдвол гандана гэдэг шиг, эхийн оронд эх, эцгийн минь оронд эцэг, элэг зүрх минь, амин гол минь, зүрхний шүтээн С-248

245. СВЕТ НЕ БЕЗ ДОБРЫХ ЛЮДЕЙ ертөнцөд сайхан сэтгэлтэй хүн байлгүй яахав, түмэнд нүүрээ барж түймэрт хормойгоо барсан биш, наашаа харах сайн сэтгэлт ахан дүү хаа мундах вэ,

246. СВЕТ НЕ КЛИНОМ СОШЁЛСЯ [*разг.*] 1. газар дэлхийд мундсан биш, бөгс хоргодох зай олдохгүй яахав, алтан дэлхийд газар дутах биш, 2. гарах зам (аврал) байлгүй яахав, юм нэгээр дуусахгүй лай ч байна зай ч байна, алтан дэлхий алгын чинээ биш, амьтан хүн арав тавхан биш.

Что ты горюешь ведь свет не клином сошёлся Чи юундаа гунигдаг юм бэ, лай ч байна зай ч байна.

247. СВЕТ ЬЕ ПРОИЗВОДИЛ *кого чего* [*разг.*] газар дээр ганцхан, ертөнцөд ижилгүй, хорвоод хосгүй, хорвоод ховорхон, урьд хожид үзэгдээгүй, дуулдаагүй, эрээд олдохгүй эрдэнэ сураад олдохгүй сувд

Это такие мошенники, каких свет не производил! Хорвоод (хос) гүй холионы өзөн гэдэг эднүүс дээ,

248. СВЕТ ОЧЕЙ *чьих.* С-244

249. СВЕТ ПОМЕРК В ГЛАЗАХ *чьих* тэнгэр нь хаях, хиймор нь үхэх, юм бүхнээс уйдах, үйлс нь цайх, заяа нь орхих,

250. СВЕТА НЕ ВЗВИДЕТЬ [*разг.*] Өвдөөд (хорсоод) гол тасрам, толгой эргэм, маварmаар, дотор харанхуйлмаар, дотор балартмаар

251. СВЕТЛАЯ ГОЛОВА саруулхан ухаантай, цөлх ухаантай, ухаан нь хурдан гүйдэг сэлүүхэн ухаантай, ухаан гэж яана даа

252. СВЕТЛАЯ ЛИЧНОСТЬ Нэр хүндтэй хүн, нэр сүртэй хүн, нэрд гарсан хүн, нэртэй цуутай хүн.

253. СВЕТСКАЯ ЛЬВИЦА (СВЕТСКИЙ ЛЕВ) [*ирон.*] дээгүүр их тал олсон хүн, танил ихтэй хүн, тал сувээ ихтэй, найман талтай хүн, танихгүй хүнгүй эр

254. СВИДЕТЕЛЬСТВОВАТЬ ПОЧТЕНИЕ *кому* тал өг-, хүндэлдээдлэ-, найр тавь. С-524

255. СВИНЦОВАЯ АРМИЯ Хэвлэлийн ажилчид

256. СВИНЬЯ-СВИНЬЕЙ [*прост. неодобр.*] гахай шиг, заваан.

257. СВИСТЕТЬ (свистать) В КУЛАК [*прост. фам. шутл.*] гар хоосон, гар хоосон ганзага татуу, ядуу зүдүү (гуцуу) хувхай хоосон, арга нь барагдсан, хоосон хүний зовлон хорь гуч, ахар дээс уяа хүрэхгүй.

258. СВИСТИТ В КАРМАНЕ [*прост. шутл.*] өвөр хоосон, гар хоосон, уутаа гүвэ-, хувхайра-. В-547, В-86

259. СВИТЬ СЕБЕ ГНЕЗДО [*перен.*] 1. их дэлгэр-, үүрлэ-, 2. оршин суу-, орон оргино-, нутагла-, идээшин суу-,

260. **СВИХНУТЬ СЕБЕ ШЕЮ** [*прост.*] С-254

261. **СВОБОДА РУК** гар хөдлөх эрх, босож тэмцэх эрх, нудрага харнулах эрх

262. **СВОБОДА СОВЕСТИ** шүтэн бишрэх эрх, шашин шүтэх эрх.

263. **СВОДИТЬСЯ (свести) (свестись) К НУЛЮ** хэрэггүй бол-, яг тэг бол-, гаргуундаа бол-, талаар бол-,

264. **СВОДИТЬСЯ НА НЕТ** С-966

265. **СВОЕГО ПОЛЯ ЯГОДА** О-105

266. **СВОЕГО РОДА** [*разг.*] нэгэн зүйлийн, нэгэн янзын, нэг янзны, янзын

Своего рода оригинал бас нэгэн янзын этгээд хүн шүү **Лёгкие в речевом аппарате служат своего рода мехами подающими воздух** өгүүлэх эрхтний дотор уушги гэдэг нэгэн янзын хяс (тулман хөөрөг) л юм даа

367. 1. **СВОЕЙ СМЕРТЬЮ УМЕРЕТЬ** мөрөөрөө өнгөрө-, нас болоод үхэ-, насны хэмжил болоод өнгөрө-, амьсгааны тоо гүйцээд ява-, наслах насаа насалж гүйцээд ява-.

268. **СВОЙ БРАТ** [*разг.*] нэгэн санааны нөхөр, ахан дүү, өөрийн хүн, дотнын хүн

269. **СВОИ СОБАКИ ГРЫЗУТСЯ ЧУЖАЯ НЕ ПРИСТАВАЙ** хүний юм хүнд хамаагүй, айл буух хүн хүүхэд нохойгоо л хичээ! нохойн хэрүүл хүнд хамаагүй.

270. **СВОЙ ЧАС** ёсоороо өөд болсон эрэмбээрээ талийгч болсон.

271. **СВОИМ ГОРБОМ ЖИТЬ (добывать)** [*разг*] өөрийн биеийн чадлаар амь зуу-, (тэжээ-) хар толгойгоороо амь зуу-, хар хөлсөө урсгаж, хатан ясаа уясгаж амь зуу-, арван хурууныхаа арыг барж таван хурууныхаа тарыг барж амь тэжээ-, хар биеийхээ хөлсөөр амь зогоо.

272. **СВОИМ ПОРЯДКОМ** [*разг*] байдгаараа. хэвээрээ, нэгэн хэвээр ёсоороо хуучнаараа

273. **СВОИМИ СЛОВАМИ** чээжээр, утгаар нь, өөрийн ойлгосноор, чөлөөтэй.

274. **СВОИМИ (собственными) ГЛАЗАМИ** нүдээрээ, алгаараа үйлийн үргүй (үзсэн)

275. **СВОИХ НЕ УЗНАЕШЬ (узнать, узнаете узнают)** [*прост.*] (айлгах үг) ухааны чинь ууланд гартал авъя чамайг, чамайг байя гэтэл чинь авъя даа гайгүй,

276. **СВОЙ БРАТ** [*перен*] нэгэн санаат нөхөр, ахан дүү, өөрийн хүн, дотнын хүн

277. **СВОЙ В ДОСКУ** чин үнэнч нөхөр, хагацангүй хань, салшгүй нөхөр, дотно нөхөр, насны хань

278. **СВОЙ СВОЕГО ИЩЕТ (СВОЙ СВОЕМУ ПОНЕВОЛЕ БРАТ)** үе үеэрээ, тэн тэнгээрээ, нохойн баас нэгэндээ тустай, ороо нь ороогоо жороо нь жороогоо, ёоз дүйзээрээ болох

279. **СВОЙ УГОЛ** [*разг.*] оромж, толгой хорогдож байгаа газар бөгс хавчуулах зай, өөрийн муу овоохой, байдгийн баруун хаяа

280. **СВОРОТИТЬ ГОРЫ (гору)** В-861

281. **СВОРОТИТЬ (сбрости) С УМА** [*прост*] ухаан солиотой болөөрийн ухаангүй бол-, ухааны гажигтай бол-.

282. **СВОЯ ГОЛОВА НА ПЛЕЧАХ** өөрийн бодолтой, өөрийн толгойтой, аминдаа аргатай

283. **СВОЯ НОША НЕ ТЯНЕТ** дур байвал юу ч амархан, дуртайд хүчтэй, юу сайхан дур сайхан, дур дураа голддоггүй, дуртайдаа туулай дургүйдээ мэлхий, дур эзнээ голдоггүй.

284. **СВОЯ РУБАШКА БЛИЖЕ К ТЕЛУ** хүн аминдаа тулахад хар амна л боддог, амь үнэнч авгай худалч,өөрийн санаа өөртөө зөв

285. **СВОЯ РУКА ВЛАДЫКА** [*прост.*] дураараа, дураараа дургиж дунд чөмгөөрөө жиргэх, яан гэснээрээ яадаг, намайг хэн хэлхэв нохойг хэн саах вэ гэгчээр,

286. **СВЫЧАИ И ОБЫЧАЙ** [*разг*] зан заншил, зан дадгаал, ёс зуршил

287. **СВЯЗАЛСЯ ЧЕРТ С МЛАДЕНЦЕМ** давахгүй гэсэн даваагаар гурав давдаг, голсон юм голд орж шилсэн юм шилд хоцро-, аргы нь олвол юм бүхэн аргатай,

288. **СВЯЗАТЬ (связывать) ПО РУКАМ И НОГАМ** *кого буюу* **СВЯЗАТЬ РУКИ** хааш нь ч хөдөлгөхгүй, хүлэгтэй юм шиг өөрийн мэдэлгүй, хориотой, дөрвөн мөчөө хүлүүлсэн (эвхүүлсэн) гартаа гавтай, хөлдөө дөнгөтэй, ард нь араг гарт нь савар, хүний эрхэнд, бусдын хараанд, хүний гарт,

289. **СВЯЗЫВАТЬ (связать) РУКИ** *кому* гар хөл нь хүлээстэй, хэл ам нь үдээстэй, яахын ч аргагүй, мухардчихаад, халж ядсан байдалтай. П-309

290. **СВЯЗЫВАТЬ (связать) ЯЗЫК** *кому* хэл амаа үдүүлчихсэн, өөрийн эрхгүй, хүний ам хара-,

291. **СВЯТАЯ (неделя)** [*разг.*] дахин хувилсны баяр, (дахин ертөнцөд) төрөл авсны баяр.

292. **СВЯТАЯ ПРОСТОТА** [*разг.*] гэнэн хүн, дан бодолтой хүн, цагаан сэтгэлтэй хүн, богино жолоотой хүн, гэнэн хонгор хүн, арилсан дотортой.

293. **СВЯТАЯ СВЯТЫХ** [*книжн*] онгон, дархалсан, сэтэртэй

294. а. **СВЯТЫМ ДУХОМ (узнать)** [*разг шутл*] эглийн ухаан нохой хоришгүй, хутагтын ухаан зарахаар, бурхны хутагаар ухаар-, билгүүн оюунаар.

295. **СГИБАТЬ КОЛЕСОМ** *что* [*разг.*] дугуй болтол мата-, буулга болтол (нумартал, хавирга болтол, дохнур болтол) мата-.

296. **СГИБАТЬСЯ В ПЕРЕГИБ** [*разг.*] бөхөлзөж мэхэлээ-, (нахилза)-, нуруунд нь нугас ургасан юм шиг.

297. **СГИБАТЬСЯ КОЛЬЦОМ** С-675

298. **СГЛАЖИВАТЬ (сгладить) ОСТРЫЕ УГЛЫ** эв нөмөө ололцох-

299. СГОРАТЬ (сг реть) ОТ (со) СТЫДА нүүрнээс гал гарамичиж үхэ-, шарагда-, нүүр хийх газаргүй бол-, хуйхлуул-, нүүрээ түлэ-, нүүрээ хала-,

300. СГУШАТЬ (сгустить) КРАСКИ дэвэргэ-, давсла-, хэтрүүл-, давруул-.

301. СДАВАТЬ(сдать) В АРХИВ *кого* хуучраа-, халж соли-,

302. СДАЛСЯ МНЕ . . .! шал яршигтай! яаж ч болохгүй! яах ч арга олдохгүй.

303. СДАТЬ В АРХИВ [*перен.*] хэрэггүй бол-, хүн хэрэглэхгүй бол-, хэн ч хэрэглэхгүй, замгүй газар хаяхаар, хүн явдаггүй газар хаяхаар.

304. СДАТЬСЯ НА МИЛОСТЬ бүрмөсөн бууж өг-, авралд нь багтатолгойгоо тушаа-.

305. СДВИНУТЬ С МЁРТВОЙ ТОЧКИ *что* хавхнаасаа сала-, зовлонгоосоо ангижра-, шавраасаа сугара-, лайнаасаа хагаца-, хоёр яс сала-.

306. СДВИНУТЬ С МЕСТА *что* [*перен разг*] урагшаа алха-, урагшаа гишгэ-, дөхө-, ахи-, давши, хөдлө-, ява

Он так обленился что его с места не сдвинешь Залхуураад бүр урагшаа гишгэхгүй болжээ.

307. СДЕЛАЙ (-те) МИЛОСТЬ [*разг.*] тэгэхтү ,тэгэхтүгэй! болгоо! (тэгэж, ингэж) хайрла-,

Можно взять этот словарь? сделайте милость! Энэ толь бичгийг авч болох уу? та тэгэгтү

308. СДЕЛАЙ (сделайте) ОДОЛЖЕНИЕ [*разг.*] тэгэж ингэж хайрла (мөнгө) зээлүүлээч.

Сделай одолжение поедем в месте Танд бараа болж явъя.

Сделайте одолжение помогите. Та тус хүргэж хайрла!

309. СДЕЛАТЬ АКЦЕНТ *на чем* [*перен.*] онцло-, онцгойл-, чухаг хэмээ-

310. СДЕЛАТЬ БОЛЬНО *кому* сэтгэлий (санаагий) нь зовоо-, дотры нь гонсойлго-, өрийн өвтгө-, цээжний нь махыг идэ-

311. СДЕЛАТЬ ВЗБУЧКУ З-127, Д-86

312. СДЕЛАТЬ ВИД (тийм ийм) дүр гарга . . . байдал гарга-, . . тийм ийм болж үзгдэ-, . . . баг өмсө-, . . . царай гарга-,

313. СДЕЛАТЬ ВЫЗОВ Б-417

314. СДЕЛАТЬ ГЛАЗКИ С-919

315. СДЕЛАТЬ КАРЬЕРУ [*разг.*] 1. тушаал дэвши-, 2. Эрх зэрэг хөөцөлдө-, нэр тушаал хөөцөлдө-.

316. СДЕЛАТЬ КРЮК [*разг.*] тойро-, дайралгүй тойро-, чулуу хөөлгө- Д-80

317. СДЕЛАТЬ ЛЕВОЙ НОГОЙ [*разг, неодобр.*] будилж гүйцэ-, хийморьгүй юм бол-, долдой юм бол-, тоогүй юм боло-,

318. СДЕЛАТЬ МИНУ , . . (тийм ийм байдал гарга-, дүр үзүүл-,

319. СДЕЛАТЬ (составить) ПАРТИЮ сайн айлын хүргэн бол-, хаяа сайт айлд (олигтойхон айлд) хүргэн оро-, (хаяа сайтай айлын бэр бол-,) сайн айлын үүдэнд очи-, хадам сайтын хүргэн бардам гэгч бол-,

320. СДЕЛАТЬ ПЕРВЫЙ ШАГ эхлэж гар хүрэ-, хийж гар-, эхлэн бари-, шав тави-, тэрлэ-, хөндө-, үүдэ-,

321. СДЕЛАТЬ ПОД КОЗЫРЁК (цэрэг) ёсло-.

322. СДЕЛАТЬ ПОЧИН эхий нь гарга-, эхлээд өг-, хошуу тата-, үүсгэ-,

323. СДЕЛАТЬ ПРЕДЛОЖЕНИЕ *кому* бэр гуй-, толгой холбоё гэ-, эхнэрээ болохыг гуй-, хүн гуй-, Д-159

324. СДЕЛАТЬ РОЖУ [*разг.*] нүүр амаа жигтэйхэн болго-, ярвалда-, дарвалда-, арзаганан-, марзаганан,

325. СДЕЛАТЬ СВОЁ ДЕЛО санасандаа хүрэ-, явсан нохой яс зуу-, үрий нь үзэ-, хэргий нь хий-, зорьсон хэрэг бүтжээ, ганзагаа мялаа-.

326. СДЕЛАТЬ СЦЕНУ *кому* үг хаялца-, хамар муруй-, үг сөргөлцө-, тар (тур) түр хий-, толхилцо-,

327. СДЕЛАТЬ УПОР *на что на чём* Д-161

328. СДЕЛАТЬ УСИЛИЕ НАД СОБОЙ биеэ бари:, тэвчи-, сэтгэлээ бари-, амаа хамхи-,

329. СДЕЛАТЬ (делать) ЧЕСТЬ 1. нэрэнд нь нэмэр бол-, нэрий нь өргө-, алдаршуул-, цуу гарга-, 2. тал өг-, хүндэтгэ ямба ёсоор нь тойл-, Д-162, 146

330. СДЕЛАТЬ ШУМ [*разг.*] шуугилда-, улилда-, жор жор хийхуцацгаа-, гийналда-

331. СДЕЛКА С САМИМ СОБОЙ итгэлийг хөсөрдүүлсэн, өөх өгсөн хүнтэй өглөө нь заргалда-, ёс алдсан явдал, сүү шиг сэтгэл үрүү хар ус хийсэн явдал, сүү шиг сэтгэлийг ээдүүлж, тос шиг санааг царцаа-, өрөвдөхөд өр өшиглө-, нүүр өгөхөд бөгө өг-, баасы нь идээд эзний нь зуу-,

332. СДЕЛКА С СОВЕСТЬЮ [*перен.*] С-331.

333. СДЕРЖАТЬ СЛОВО үгэндээ хүр-, хэлсэндээ (амандаа) хүрэза гэвэл ёогүй

334. СДЕРЖАТЬ (сдержать) СЕБЯ тэсвэрлэ-, тэвчи- зоригоо хөвчилө-, шүдээ зуу-,

335. СДОБРИТЬ БЫЛЬ НЕБЫЛИЦЕЙ (чудесной) [*разг.*] нэмэхий нь нэмж чимэхий нь чимэ-,

336. СЕБЕ ДОРОЖЕ (станет, будет) [*разг.*] улам төвөгтэй, улам зовлонтой, бүр явдалтай

337. СЕБЕ НА УМЕ [*разг.*] дотроо бодолтой, дотуур тамиртай

338. СЕГОДНЯ ГУСТО А ЗАВТРА ПУСТО үгчилбээс өнөө өөр маргааш өлөн утгань: барж идэхээс мэрж иддэггүй, олдсон

цагт нь олиг олтол идээд, олдохгүй цагт нь өлөв дөлөв, байхад нь балгалзаад байхгүйд нь өлвөлзө-

339. **СЕДЛАТЬ (оседлать) ПЕГАСА** [*книжн.*] шуугиулж өг-, бичиж гара-, бичиж алда-,

340. **СЕДОЙ КАК ЛУНЬ** азай буурал, мөнгөн буурал, був буурал, цав цагаан толгойтой, цал буурал, өвгөн буурал,

341. **СЕДЬМАЯ ВОДА НА КИСЕЛЕ** Д-253

342. **СЕКРЕТ ПОЛИШИНЕЛЯ** нууц гэтлээ нууц бин, эчнээ гэтэл ил юм, далд атал плэд

343. **СЕКУНДА В СЕКУНДУ** яг цагтаа, бороотой ч болзоондоо, хуртай ч хугацаандаа гэгчээр.

344. **СЕМЕРО ОДНОГО НЕ ЖДУТ** цөөний зөвөөс олны буруу дээр.

345. **СЕМИВЁРСТНЫЕ САПОГИ** С-200

346. **СЕМИМИЛЬНЫМИ (гигантскими) ШАГАМИ (идти двигаться, развигаться)** газар товчлон алхдаг, жилийн газрыг сараар, сарын газрыг өдрөөр товчилдог.

347. **СЕМИ ПЯДЕЙ ВО ЛБУ** [*разг.*] анги ухаантай, гаргуу мэргэн цоорхой мэргэн, суу билэгт, холч ухаантай, хурцалсан тонгорог шиг ухаантай, хурц ухаантай

348. **СЕМО И ОВАМО** энд энд, үүгээр түүгээр.

349. **СЕМЬ БЕД ОДИН ОТВЕТ** их барьсан ч өмхий бага барьсан ч өмхий, нүгэл хийвэл зовол үздэг, хулгай хийвэл ташуур үздэг.

350. **СЕМЬ ВЕРСТ ДО НЕБЕС (и все лесом)** далан хэл дэлгэх, далан долоон юм яри-, түм буман юм яри-, зуун долоон үг дэлгэ-, элдэв шалдав үгтэй, элдэв дээдийн юм яри-, сархинагныхаа баасыг гөвө-,

351. **СЕМЬ ПОТОВ СОШЛО** *с кого* [*перен., разг*] (ядарч), тамир тасра-, чадал барагда-, сульдаж гүйцэ-, тэнхээ барагда-, хар хөлс чийхрэ-, хүйтэн хөлс нь асга-, тунхида-, туйлда-, сульда-, най нь тасра-,

352. **СЕМЬ ПЯТНИЦ НА (одной) НЕДЕЛЕ** олон санаат оргож босож чаддаггүй, товлосон (шөвөлсөн) бодолгүй, чиг баггүй (хүн) туйлбаргүй, чиг баримжаагүй, зээр хөөсөн нохой,

353. **СЕМЬ РАЗ ПРИМЕРЬ А ОДИН РАЗ ОТРЕЖЬ** үгчилбээс долоо хэмжиж нэг огтол! утгачилбаас: хэлэхийн урьд болгоомж, хийхийн урьд хичээмж.

354. **СЕНУ С ОГНЁМ НЕ УЛЕЖАТСЯ** чоно хонь хоёр шиг, гал ус хоёр шиг.

355. **СЕРАЯ СКОТИНКА** [*разг.*] (урьд цагт цэргийг дооглон, доор шааж хэлдэг байсан үг) саарал адгуус.

356. **СЕРДЦЕ БОЛИТ** элэг эмтрэх, зүрх шимшрэх, өр өмрөх, зүрх өвдөх, өр зүрх зүсэх шиг, сэтгэл өвдөх.

357. **СЕРДЦЕ ЕКАЕТ** (цочоод), дотор арзгас хийв, зүрх шир хийв, дотор пал хийв, оройн үс өрвөсхийх, (ар) нуруу хүйт оргих, бие

арзайх, хеолой гарахгүй, дуу гарахгүй, дуугарч чадахгүйе сүнс нь халих, сүнс зайлах, үнхэлцэг нь хагарах.

358. **СЕРДЦЕ ЖМЁТ** [*разг.*] зүрх шимшрэх, сэтгэл түвшингүй, энэлэн шаналан, сэтгэл доноголзон, сэтгэл хямран, санаа зовон

359. **СЕРДЦЕ ЗАМЕРЛО, (замирает)** дотор пал хийв, дотор харанхуйлах шиг болов, дотор бөглөрөв, дотор хүйт оргив, бие арзайв.

360. **СЕРДЦЕ ЗАНЫЛО (ноет)** *у кого* дотор аягүй, сэтгэлд эвгүй, гол харлав, сэтгэл сэвтэв.

361. **СЕРДЦЕ ЗАНЯТО** *кем* (хэн нэг хүнд) сэтгэлтэй болсон, сэтгэлээ өгсөн, хайртай болсон.

362. **СЕРДЦЕ К СЕРДЦУ** сэтгэл ойр, хоёр сэтгэл нийлэх, нжил дасал болох, элгээрээ нийлж, ойр дотно болох,

363. **СЕРДЦЕ КРОВЬЮ ОБЛИВАЕТСЯ (облилось)** *чье у кого* энэлж шаналах, дотор хачин болох, санаанд зовлонтой, сэтгэлд шаналгаатай, сэтгэл бухимдаж.

364. **СЕРДЦЕ МОЁ** толт зүрх минь! элэг зүрх минь! голт зүрх минь! амин хайрт минь! сэтгэлтэй ганц минь, хайрт минь, хонгор минь, ахаа, оохоо, хань минь.

365. **СЕРДЦЕ НЕ НА МЕСТЕ** Д-473

366. **СЕРДЦЕ ОБРОСЛО МОХОМ** *у кого* дотор нь хөрчихсөн, хал зовлон үзсэн, гашуун зам туулсан, зовлон амсаж явсан,

367. **СЕРДЦЕ ОКАМЕНЕЛО** *у кого* сэтгэл хатуутай болох, дотор нь хөрөх, сэтгэл хөндийрөх, сэтгэл холдох.

368. **СЕРДЦЕ ОСТЫЛО** Дотор нь уужрах, сэтгэл тэнийх, уур нь гарах, дотор нь онгойх, бие нь тавирах.

369. **СЕРДЦЕ ОТХОДИТ** *у кого* омог нь багасах, шар нь дарагдах, уур нь намжих.

370. **СЕРДЦЕ ПАДАЕТ** *у кого* шалдаа буух, урам нь хугарах, бүр гонсойх, зориг мохох, мятрах, шантрах.

371. **СЕРДЦЕ ПОХОЛОДЕЛО** *у кого* [*разг.*] сэтгэл түгшив, дотор харлав, сэтгэл гонсгор байв, сэтгэл зовиуртай, дотор цухалдав.

372. **СЕРДЦЕ РАЗРЫВАЕТСЯ** Д-475

373. **СЕРДЦЕ РВЁТСЯ НА ЧАСТИ** зүрх шимшрэх, сэтгэл зүдгүүртэй, зүрхий минь зүүгээр шивэх мэт, зүрх зүсэх мэт, элэг эмтрэх, өр өмрөх (өвдөх),

374. **СЕРДЦЕ СЕРДЦУ ВЕСТЬ ПОДАЁМ 1.** сэтгэлийн үгээ ярилцах, сэтгэл нийлэх, бие биеийн сэтгэлийг мэдэх, 2. Бие биеэ мөрөөдөх.

375. **СЕРДЦЕ УПАЛО** *у кого в ком* урамгүй болов, зориг шантрав, сэтгэлгүй болов, сэтгэлээр унав, ганихарч гансрав, гундаж гунив, туниж гутав, гиюүрч гэгэлзэв.

376. **СЕРЕБРЯНАЯ СВАДЬБА** (ураг барилдсаны хорин тавин жилийн ой, хийхийн) мөнгөн хурим.

377. СЕРЕДИНА НА ПОЛОВИНУ (серединка на половинку середка на половинку, середка на половинку, середка на половине) дунд зэрэг, саармаг, сайн ч биш саар ч биш, муу ч биш, тааруу нэг, хоёрын хоорэнд, гурвын дунд.

378. СЕРЁДКА, (середине) НА ПОЛОВИНКУ (на половинке на половине) [*прост.*] сайн ч биш муу ч биш, сайн ч гэхэд хэцүү, муу ч гэхэд хэцүү, хоёрын хооронд гурвын дунд, дунд баазын.

379. СЕСТЬ В БЕСТ З-250

380. СЕСТЬ (в лужу) В ГАЛОШУ [*прост.*] сүйд бол-, хөгөө чирэ-, баларч гүйцэ-, болохоо бай-.

381. СЕСТЬ В КРУЖОК Тойрч суу-, дугуйрч суу-, хүрээлэн суу-.

382. СЕСТЬ (садиться) В ЛУЖУ [*прост., разг., фам.*] Яадгаа алда-, болохоо бай-, хөг нь өнгөрө-. П-747

383. СЕСТЬ (садиться) ВЕРХОМ *на кого* [*разг.*] Дээр нь мордо-, толгой дээр нь гар-, хүзүүн дээр нь зайдал-(сандайл-).

384. СЕСТЬ (садиться) НА ГОЛОВУ *кому* [*разг.*] Толгой дээр нь гар-, хүзүүн дээр нь зайдал (мордо-)-, даварч гүйцэ-, даврa-, дэндэ-, хэтрэ-.

Молодая жена села ему на голову. Залуу эхнэр нь толгой дээр нь гарчихсан юм.

385. СЕСТЬ (садитьсь) НА ЗЕМЛЮ Газар тариаиы ажил хий-(эрхлэ-, оролдо-).

386. СЕСТЬ (садиться) НА МЕЛЬ [*разг.*] Хаашаа ч үгүй бол-, болохоо бай-, үнсэнд хаясан шалз шиг; гацаж орхи-, паг суу-, ягта-.

387. СЕСТЬ (садиться) НА СВОЕГО (любимого) КОНЬКА О-146

388. СЕСТЬ НА СКАМЬЮ ПОДСУДИМЫХ П-757

389. СЕЮ МИНУТОЙ (СИЮ МИНУТУ) [*разг.*] Одоохон, мөн одоо:, мөн шигээд; зогсоогоороо

390. СЖЕЧЬ (сжигать свои) МОСТЫ [*книжн.*] Буцах мөргүй, буух замгүй бол-,

391. СЖЕЧЬ СВОИ КОРАБЛИ [*книжн.*] Буцах мөргүй, буух замгүй бол-, уулын буга харж унасан бухаа гээ-, Сэхэшгүй, эргэлтгүй болго, нэгмөсөн нам цохи.

392. СЖИТЬ СО СВЕТА (со свету) С-671

393. СИАМСКИЕ БЛИЗНЕЦЫ 1. Ав адил; ив ижил; **2.** [*перен. шутл.*] Гарсан ч хамт орсон ч хамт явдаг; нэг морьтой нэг дээлтэй, буцалбал тогоо нэг булгивал даага нэгтэй; үүд хойморгүй найз; ижий ахай

394. СИГНАЛ БЕДСТВИЯ Аврал эрэх; уруудсаны тэмдэг; муудахын дохио, балрахын цондон.

395. СИДЕТЬ БАРИНОМ [*прост. разг.*] Дэмий суу-, юу ч хийхгүй; гэдсээ маажихаас өөр ажилгүй; .... маажиж суниаж унта-

396. СИДЕТЬ БОГОРОДИЦЕЙ [*прост., ирон.*] Юу ч хийхгүй; дэмий суу-, ажлаа алдсан амьтан

397. СИДЕТЬ В ГОЛОВЕ [*разг.*] Санаанаас гарахгүй; ямагт бодогдо-, сэтгэлд уяатай

398. СИДЕТЬ В ПЕЧЁНКАХ *у кого* [*разг.*] Түүшин түрүү бол-, гай уда-, гай чирэ-,

399. СИДЕТЬ ГВОЗДЕМ (как гвоздь) В ГОЛОВЕ (в мозгу п.т.п.) [*разг.*] Сэтгэлд шаналгаатай; сэтгэлийн зангилаа бол-, сэтгэл тувшингүй.

400. СИДЕТЬ ИДОЛОМ [*разг.*] Хөшөө шиг (үг ч үгүй дуу ч үгүй) суу-, ургаа хад шиг суу-; гөлийчхөөд л суу-,

401. СИДЕТЬ КАК НА ИГОЛКАХ Өндөлзөөд л өтцөрсөн юм шиг, тогтворгүй; өттэй ямаа шиг, салхин дэвүүр шиг; дороо суурьгүй.

402. СИДЕТЬ (стоять) КАК ПЕНЬ Модон өмдтэй юм шиг; мэл гайхаж зогсо-.

403. СИДЕТЬ МЕЖДУ ДВУХ СТУЛЬЕВ (двумя стульями) Бөөрөнхийлө-, Хоёрын хооронд гурвын дунд савда-.

404. СИДЕТЬ НА БОБАХ О-195.

405. СИДЕТЬ (как рак) НА МЕЛИ [*разг.*] Үнсэнд хаясан шалз шиг; элс үмхэж эрэг мэрэ-.

406. СИДЕТЬ НА ПИЩЕ СВЯТОГО АНТОНИЯ Өлөн живэр аж төрө-; өлөн бирдийн зовлон эдлэ-, мацаг барин суу-.

407. СИДЕТЬ НА ПЛЕЧАХ *кого у кого* Мөрдөн дага-, сүүл даран хөө-, хаяа хатган ажигла-.

408. СИДЕТЬ НА ХЛЕБЕ И (на) ВОДЕ С-406.

409. СИДЕТЬ НА ЧЕМОДАНАХ (на узлах) Явахад бүх юм жин тан болоод бай-, мориндоо дөрөөлөхөөс бусад нь бэлэн

410. СИДЕТЬ НА ШЕЕ (пагорбу) *чьей, у кого* Хүний юмаар хүүдэгнэ-, Бусдын гар харж суу-, бусдыг мөлжиж аж төрө-,

411. СИДЕТЬ НА ЯЙЦАХ (Шувуу өндгөө дара-, шувуу)

412. СИДЕТЬ СЛОЖА РУКИ [*разг.*] Хийх юмгүй суу-, дэмий алмайран суу-, гараа унжуулан суу-, гар хумхи-, элгээ тэвэр ч суу-, толгойгоо салаавчлан суу-.

413. СИДЕТЬ У МОРЯ И ЖДАТЬ ПОГОДЫ [*ирон.*] Бухын доотохыг харж үнэг турж үхэв гэгч, бүтэхгүй юмыг бүтэн жил хүлээ-.

414. СИДЕТЬ (оказаться) У РАЗБИТОГО КОРЫТА Газар алгадан хоцро-, модоо бари-, юмаа бара-, хувхайра-, аль ч үгүй хоосон үлдэ-, хотоо харлуул-.

415. СИДНЕМ (сидмя) СИДЕТЬ [*разг.*] 1. Хөдөлж чадахгүй; тушаатай юм шиг. 2. Гэрийн мухар сахи-.

Целыми днями сиднем сидит за книгой. Өдөржин гэрийн мухарт цоохор цаасаа шагайн суунэ

416. СИДЯЧАЯ ЗАБАСТОВКА Суумлаар ажил хаях, ажил хийсэн царай гаргаад зүгээр суух, элгээ эвхэн суух, гар хумхийн суух,

417. СИЗИФОВ ТРУД (СИЗИФОРА РАБОТА) Эх адаггүй ажил; дуусгаваргүй ажил, хоёр яс салдаг юм биш, салж үхдэггүй ажил, дуусахын заяагүй ажил.

448. СИЛ НЕТ [*разг.*] Болохгүй, чадахгүй; хүчгүй; аргагүй; яалт ч үгүй.

От напора ветра нет сил дышать. Салхинд амьсгаа (давхцана) ч авч болохгүй (байна)

419. СИЛ НЕТ КАК (дочего) Саная нь их ч сачий нь хүрдэггүй; таваглашгүй; даадгүй булуу юм шив дээ.

420. СИЛА СОЛОМУ ЛОМИТ Хүчтний дэргэд хүчгүй нь буруу; ямаа муудаа, чоно өтлөвч хургандаа зөв, цорж өтлөвч шавьдаа зөв, дийлсэн нь дэлбийсээ

421. СИЛОЮ В (от, до)... тоотой;... тооны

422. СИЛОЮ ВЕЩЕЙ Үнэнхүү байдал нйм; явдал нймээс өдгөөгийн нөхцөл нйм В-323

423. СИЛЫ НЕБЕСНЫЕ Тэнгэр минь тэнгэрийн хүчин мэд! Тэнгэрийн зориг.

424. СИЛЬНЕЕ ОБЫКНОВЕННОГО Эгэл биш; ер бишийн, мань мэтээс өөр эгэлгүй, зүгээргүй;

425. СИЛЬНЫЕ МИРА СЕГО [*ирон.*] Баян тарган улс; эрх дархтай улс; их мэдлийн улс, эвэртэй туруутан, эрхтэн, дархтан, ихэс дээдэс.

426. СИЛЬНЫЙ ПОЛ Эр, эр бие, эрчүүд, эр хүн, эрхтэйчүүд.

427. СИМВОЛ ВЕРЫ 1. (шажины) итгэл; сүсэг, сүжиг, бишрэл; 2. [*перен.*] гол үзэл.

428. СИМПАТИЧЕСКИЕ ЧЕРНИЛА Нууцын бэх; нууц бичгийн бэх.

429. СИНИЙ МУНДИР [*перен., разг.*] Цэргийн цагдаа (хаант оросын үед цагдааг цэнхэр өнгийн өмсгөл хувцаар нь тийнхүү нэрлэж байсан). цэнхэр мундар тэнэгүүд; дашрамд өгүүлбээс, «Өмсгөл» гэдэг үг манай одоо хэрэглэж буй формын хувцас гэдгийн оронд хэрэглэхэд аятайхан үг. Сургуулийн өмсгөл цэргийн өмсгөл г м.

430. СИНИЙ ЧУЛОК (*пренебр. презр.*) Хөх оймстон буюу эмсийн сургууль (үг нь англий‌н blue stocking гэдгээс дам орчуулж авсан үг.

431. СИРОТСКАЯ ЗИМА [*разг.*] Өнтэй өвөл

В этом году стояла сиротская зима. Энэ өвөл өнтэй өвөл байлаа.

432. СИЮ СЕКУНДУ *буюу* **СИЮ МИНУТУ (минутку)** [*разг.*] Одоохон, энэ хоромд; түн удахгүй, юу удах вэ, нигэсгээд, тэгсгээд, жоохон байзнаад.

433. СИЯ ЮДОЛЬ З-304

434. СКАЖИ (-те) НА МИЛОСТЬ [*разг.*], [*ирон.*] Ямар хачин юм бэ ямар жигтэй юм бэ Огт саная савand багтаагүй.

435. СКАЖИ (-те) ПОЖАЛУЙСТА [*разг., ирон., перен.*] (Харахгүй юү за тэр! Ямар жигтэй юм бэ бод л доо

Скажи пожалуйста неужели правда. Ямар жигтэй юм бэ Үнэн гэж үү

Скажи пожалуйста неужели тебе не стыдно. Үгүй чи бод л доо ичихгүй байна уу

436. СКАЗАНО СДЕЛАНО За гэвэл ёогүй; ам алдвал барьж болдоггүй, хэлсэн ам байна газар!

437. СКАЗАТЬ В ГЛАЗА (в лицо) Шулуухан хэлэ-, нүүрэн дээр нь хэлэ-, ил хэлэ-, улаан цайм хэлэ-.

438. СКАЗАТЬ ДУРАКА *кому* [*разг.*] Яаж мангартаж байна вэ, тэнэг юм хийв ээ; тэнэг мунхагаар нь дууда-, эргүү тэнэгт нь хүрэ-, мунхаг мулгууд нь хүрэ-.

439. СКАЗАТЬ (заметить) К ЧЕСТИ *кого чьей* Бахдан өгүүл-, талархал илэрхийл-, баяр талархал илэрхийл-, баяр талархлаа дэвшүүл-, тал өг.

440. СКАЗАТЬ ПО СОВЕСТИ Г-115

441. СКАЗАТЬ ПОДЛЕЦА *кому* [*разг.*] Муу муухайгаар нь дууда-, хэлэхгүй муугаар хэлэ-, хамаг муугаар хараа-, аль муугаар зүхэ-, П-1252

442. СКАЗАТЬ РУССКИМ ЯЗЫКОМ (Чамд) хэлж байна шүү; нохойн хэлээр хэлээгүй, хүний хэлээр хэлж байна шүү (чи чинь) хэл мэддэг юм уу, үгүй юү. Айн гэж байгаач! (Наана чинь) монгол хүн хэлж байна. Г-113

443. СКАЗАТЬ СВОЕ СЛОВО Газар ав-, гарч ирэ-, үр нь илрэ-.

444. СКАЗАТЬ СЛОВЕЧКО [*разг.*] Сэтгэлийнхээ үгийг хэлэ-, санаснаа хэлэ-, аятай үг хэлэ-.

445. СКАЗКА ПРО БЕЛОГО БЫЧКА (о белом бычке) [*разг. шутл.*] Улиг болсон юм улигла-, хэв болсноо нуршн-, нэг үгээ далан долоо дахи-, зангууны үлгэр, амныхаа уншлагыг уншиx.

446. СКАЛИТЬ ЗУБЫ ([*прост*]) Элэг доог бол-, тавваа хана-, бах бол-, тавла-, найр хийх.

447. СКАНДАЛ В БЛАГОРОДНОМ СЕМЕЙСТВЕ [*ирон.*] Балгаа тариx, хөгөө (чирэх) тариx, шившгээ дэлгэх (тариx), паянгаа хутгах, мундраа хутгах, хөөрхөө харуулах, сайхнаа үзүүлэх, муугаа мэдэгдэх, хөгөө хөглүүлэх, балгаа тариx,

448. СКАТЕРЬЮ ДОРОГА *кому* [*разг. ирон.*] 1. Хаа хамаагүй ява-, дэмий сэлгүүцэ-, 2. Тонил-, зайл-, далд op-. 3. Аян замдаа сайн морилоорой.

449. СКАЧКИ С ПРЕПЯТСТВИЯМИ [*перен.*] Саадыг даваж санаснаа хий-,

450. СКВЕРНЫЙ АНЕКДОТ Баларсан явдал; тоогүй юм болсон; муугаа хаяалсан ажил, элэг доог бол-,

451. СКВОЗЬ ЗУБЫ Дугарч (яда-) цөхө-, хямсалзаж яри-, дургай дүргүй ам нээ-, мэндийн хариугүй шахам, амнаас нь алт унах гээд байгаа мэт; уньтай туньтай үг дуугара-.

452. СКВОЗЬ ОГОНЬ И ВОДУ ПРОШЁЛ Хал их үзсэн хүн; юм их үзсэн; үзээгүй юмгүй; сайн муу юм их үзсэн; гашуун зов-

лон туулсан; хал үзэж хашир суусан, олон оймс элээсэн, доль цохьсон, юм үзэж нүд тайлсан, олон таргалж олон турсан, долоо дордож найм сэхсэн.

453. СКВОЗЬ ПАЛЬЦЫ СМОТРЕТЬ (**глядеть**) *на что* [*разг.*] Ухлмэдээчин бол-, харсан мөртөө хараагүй юм шиг; мэдсэн ч мэдээгүй юм шиг; чихгүй толгой орги-, үзсэн ч үзээгүй мэт, нүдэн балай чихэн дүлий,- эс мэдээчин бол-. С-601

454. СКВОЗЬ ПРИЗМУ *чего* (**смотреть, вспомнить и. т. п.**) [*перен.*] дам дамаа үзэ-, давхар давхар бодо-, харваж бодо-, хальтируулж бодо-.

455. СКВОЗЬ РОЗОВЫЕ ОЧКИ СМОТРЕТЬ *на что* хамгийг сайнаар бодо- (үзэ-), гол сайтай.

456. СКВОЗЬ СЛЁЗЫ Нүд (ээрээ) дүүрэн нулимстай; нулимсаа мэлтэлзүүлэн; нулимс нь цийлэгнэн, нулимс гүйлэгнэн, нулимс унаган алдаж,

457. СКВОЗЬ СОН (**слышать и. т. п**) Нойрондоо; зүүдэндээ; нойрмогт зүүрмэгээр, нойрон дундаа, шүлэг нойрын дунд.

458. СК ИЗУТЬ СО СЧЁТОВ Данснаас хаса-, тоохоо бай-, хэрэгсэхгүй бол-, гарзанд нь гарга-.

459. СКЛОНЕН ДУМАТЬ ЧТО ... ... гэж боддог-; ... (тийм) байх хэмээдэг ... тэгж бодож явдаг

Я склонен думать, что это было не так. Би ийм биш байх гэж бодож явдаг.

460. СКЛОНИТЬ ГОЛОВУ *перед кем-чем* Доогуур толгойтой, дуулгавартай, зөөлөн чихтэй.

461. СКЛОНИТЬ СЛУХ (**ухо**) Чих тавин сонс-, хичээн сонс-, хатангатан сонс-.

462. СКЛОНЯТЬ (**просклонять**) **ВО ВСЕХ ПАДЕЖАХ** (*кого, что*) Хүн муулахаа аяны уншлага болго-, ёроолы нь үудлан муула-, хамаг муугаар нь дууда-, бусдын мууг үзэх дуртай.

463. СКЛОНЯТЬ НА РАЗНЫЕ (**на все**) **ПАДЫ** [*разг.*] Нэрд гарголноороо шагшин хэлэлцэ-.

464. СКОК-ПОСКОК Дэгдэн дүүлэн; огло огло харайн; дэвхрэн цовхрон; ойлон цойлон.

465. СКОЛЬЗИТЬ ПО ВЕРХАМ Н-554, Х-1

466. СКОЛЬЗИТЬ ПО ПОВЕРХНОСТИ *чего* [*неодобр.*] Өнгөцхөн-, хөнгөн хуудам; хумс шигтгэхгүй; гүймэгхэн; тэгс ингэс хийгээд, хайш яйш, хам хум.

467. СКОЛЬКО ВЛЕЗЕТ Дураараа, зоргоороо, дураараа дургиж дунд чөмгөөрөө жиргэж. У-159

468. СКОЛЬКО ДУШЕ УГОДНО [*разг.*] Хэд л бол хэд; хичнээн л бол хичнээн; ямар л бол ямар; дур сонгох хэрэг, тааллаараа болгоох.

469. СКОЛЬКО ЛЕТ, СКОЛЬКО ЗИМ! (**не видались**) [*разг.*] Уулзалгүй удлаа; уулзалгүй олон жил боллоо. Ойрдоо уулзангүй их удлаа шүү, уулзалгүй мөн ч уджээ, хэдэн ч жил

болов доо? Нүүр учралгүй он удсан; бараагаа харалцахын мөрөөсгөл болсон

470. СКОЛЬКО МОЖНО СУДИТЬ ... ... бодвоос ...; нягталбаас..

471. СКОР НА РУКУ 1. Юман түрүүнд нударгалдаг: **муу хүн мод** чулуу гэгч; 2. Гарын уртай, гартаа дүйтэй, **мод ороллдог.**

472. СКОРЕЕ ВСЕГО [*разг.*] Ээдээ ... **байх; ...ны дийлэх бий;** ... тэгж таарах нь.

Скорее всего он сегодня не придёт Мань эр өнөөдөр ирэхгүй болж таарлаа шүү.

473. СКОРО, ДА НЕСПОРО Түргэн түүхий; **хий яараад;** бушуу туулай боривондоо баастай; яараад ямраа алдаж; хурдан хуумгай, яарвал даарах гэгч болох, хөнгөн хөөмөй (хуумгай)

474. СКОРО СКАЗКА СКАЗЫВАЕТСЯ, ДА НЕ СКОРО ДЕЛО ДЕЛАЕТСЯ. Хэлэхэд амар хийхэд хэцүү, ам бардан, гуя шалдан.

475. СКОРОТАТЬ ВРЕМЯ [*разг.*] Цаг нөхцөө-, цаг өнгөрөө-, хоног цаг түлхэ-, алгуурла-, хойш тави-, хоног төөрүүл-.

476. СКРЕБЕТ НА ДУШЕ (**на сердце**) *у кого* Гол гонсойж, сэтгэл санааны өвчин; гунихра-,

477. СКРЕЖЕТ ЗУБОВНЫЙ Шүд зуу- (зана-); шазуур зуу-, хөмгий зуу-, чулуу өвөртөл-, өшөө өвөрлө-, хорон сана-, муу сана-, хор санаж хонзон өвөрлө-,

478. СКРЕПЯ СЕРДЦЕ [*разг.*] Дургүйд хүчгүй гэгчээр; дуртай дургүй, аргагүйн эрхэнд; тэгсэн бол-, сэтгэлээ барихын сайнаар барьж, яахав дээ л гэж,

479. СКРЕСТИТЬ МЕЧИ (**шпаги**) [*книжн., перен.*] Цаана наанаа гар-, маргаж мэтгэлцэ-, өөр өөрийнхөөрөө зүтгэ-.

480. СКРУТИТЬ В БАРАНИЙ РОГ С-672.

481. СКУП НА СЛОВА (**разговоры**) [*разг.*] Үг ч үгүй дуу ч үгүй.

482. СКУПОЙ РЫЦАРЬ Хар гартахаа алдахгүй (тавихгүй) хүн хорголоо тоолсон хүн; нарийндаа хатсан хүн

483. СКУЧЕН ДЕНЬ ДО ВЕЧЕРА, КОЛИ ДЕЛАТЬ НЕЧЕГО. Хүлээсэн юм удаан хөөсөн юм хол,

484. СЛАБА ГАЙКА [*прост, пренебр.*] Өөдгүй; урагш муухантай, морь муутай; хийморгүй, золбоогүй, морь нь мод болсон, морь нь эцсэн, аминдаа арчгүй, Г-4

485. СЛАБАЯ СТОРОНА (СЛАБОЕ МЕСТО) *буюу* **СЛАБАЯ СТРУНА** *кого-чего буюу чьё* [*разг.*] Сүүдэртэй тал; доголтой нь, өрөөсгөл, муу.

Надо знать сильные и слабые стороны противника. Атаатныхаа аль сайн муу бүгдий нь арван хуруу шигээ мэдэж бай

486. СЛАБАЯ СТРУНКА *кого чья* (**Сэтгэлийн**) **уян тал, (зан авирын) зөөлөн зан, хийтэй газар**

487. СЛАБОЕ МЕСТО У-159.

488. **СЛАБЫЙ ЖЕЛУДОК** Дотор муутай; дотроо авсан, шингэвэр (шингэц) муутай, шингэдэггүй, зохидоггүй, нарийнтсан юм шиг.

489. **СЛАБЫЙ (нежный, прекрасный) ПОЛ** Бүсгүй хүн, богино жолоотой; эм хүн; охин хүн; хүний гарын дор амьтан, сайхан амьтан, хүний хүн.

490. **СЛАВА БОГУ** [*разг.*] 1. Тэнгэрийн ач! Тэнгэрийн ивээл

491. **СЛАВА ГЕРОСТРАТА** Муу хүн түймэр тавьж нэр авдаг, Муйхар хүн юм эвдэж нэр гардаг, Хүний муу арилдаггүй, тэнгэрийн муу арилдаг.

492. **СЛАВА ТЕ (тебе) ГОСПОДИ** Сайн хүн санаагаараа гэж ямар сайн хэрэг вэ? Буян чинь дэлгэр!

493. **СЛЕД ПРОСТЫЛ** *кого, чей* [*разг.*] Ор сураггүй; ор мөргүй. бараа туруугүй, хэл улгүй, сураг тасарсан, хайх мөргүй харах бараагүй, И-40

494. **СЛЕДИТЬ ЗА СВОЕЙ ВНЕШНОСТЬЮ** Биеэ заса-, биеэ цэнэ-.

495. **СЛЕДОВАТЬ ПРИМЕРУ** Үлгэр болго-, дуурна-, жишээ ав-.

496. **СЛЁЗЫ КИПЯТ** Тэссэнгүй уйла-; нулимсаа барьж чадалгүй; өөрийн эрхгүй уйла-; нүдний нь нулимс хар аяндаа мэлмэрэн асгара-, эхэр тата-, тогоо нэрэ-, архи нэрэ-, охило-, ухила-.

497. **СЛЁЗЫ ПОДСТУПАЮТ К ГОРЛУ** С-496.

498. **СЛЕПАЯ КУРИЦА** [*прост.*] Учир мэдэхгүй хүн; балай юм шиг амьтан.

499. **СЛЕПАЯ ФЕМИДА** Хууль зүйч; хууль сахигч-.

500. **СЛЕЧЬ В ПОСТЕЛЬ** [*разг.*] Хэвтэрт оро-, өвчиндөө угнуул-, хэвтээ бол-, хүний гарт оро-, хавтгайгаараа бол-.

501. **СЛИВКИ ОБЩЕСТВА** Дээгүүр толгойлсон; том толгойлсон, ихэс дээдэс, эрхтэн дархтан, нэр мяндагтан, эвэртэн туруутан, мяндагтан, тушаалтан,

502. **СЛИШКОМ СИЛЬНО НАЖАТЬ ПЕДАЛЬ** Дэндүүлж дэгэстүүл-, давс хужры нь шорвогдуул-, дэвэргэ-, дэгэсдүүл-, дэндүү дэвэргэ-, сүр бадруул-, сүржигнүүл-, цуугиул-.

503. **СЛОВ НЕТ** Хэдэх юм алга; ярангүй. Н-1034

Слов нет, пишет он хорошо. Ярангүй сайн бичдэг.

504. **СЛОВ НЕТ, КАК...** Хэлж барашгүй; өгүүлэвч барашгүй.

505. **СЛОВА БАРХАТНЫЕ, ДЕЛА ЕЖОВЫЕ** Аман дээрээ бал, алс цаанаа жад; ам бардан гуя шалдан; гоо ам гурил хошуу; ам нь дүүрэн ажил дулихан, ам нь цагаан ажил нь бараан, ам нь чадалтай ажил нь багтай, бардан ам бараан дээр, шалдан гуя шороон дээр, ам нь юм болгоныг чадна, ачир нь хавырын өдрийн уртыг ч гүйцэхгүй, эмаараа гийгүүлэн үгээрээ жийгүүлдэг.

506. **СЛОВА ЗАСТРЯЛИ В ГОРЛЕ** (Уг нь) арааид нь юм хоцров.

507. **СЛОВА НЕ ИДУТ С ЯЗЫКА** Хэл ам эвлэж өгөхгүй, хэлэх үг олдохгүй, үгээ олж ядан.

508. **СЛОВНО АРШИН ПРОГЛОТИЛ** К-40.

509. **СЛОВНО ВЫТОЧЕННЫЙ** Гоолиг, цэвэр төрсөн; зураг шиг; дуртмал, төрсөн байтлаа зурсан юм шиг, нүдний шүтээн гэгч, мэлмий мялаам, хараа булаам, нүд булаам, морьтой нь бууж хармаар, явган нь сууж хармаар; сайхан төрсөн, нүд хужирлам.

510. **СЛОВНО ГОРА СВАЛИЛАСЬ С ПЛЕЧ** Мөрөн дээрээс юм аваад хаячих шиг болов; дотор уужрав, бөөн зангилаа алдрав, сэвэсхийгээд явчихлаа, нэг толгой ажил дарагдав, бие тавирав.

511. **СЛОВНО ПЕЛЕНА (с глаз) УПАЛА (спала)** Цэлэс хийх мэт, ухаанд (юм) нь хийтэл буув, санаанд зураг шиг ургав. дотор сэрхийв.

512. **СЛОВО В СЛОВО** Нэг ч үг орхилгүй, үгчлэн, махчлан, нэгэд нэггүй, үг үсэг орхилгүй, таиц үг газар гээлгүй.

513. **СЛОВО-ДЕЛО** За гэвэл ёогүй.

514. **СЛОВО ЗА СЛОВО, СЛОВО ЗА СЛОВОМ** [*разг.*] Ууж хоосон бүцаахгүй, мөчөөгөө өгөхгүй; үг хоосон орхихгүй; үг газар орхихгүй, хувца тавихгүй, ахнадхан үгтэй, уралцаад байхтай, үзэж алддаг.

515. **СЛОВО И ДЕЛО (государевы)** Урвалга гаргаж байна! гэж гүтгэх улс төрийн хэрэгт гүтгэх үг зүггүй гүтгэж барнулах

516. **СЛОВО КРЕПКО** Унэндээ хүрдэг; үнэнч үгтэй; хэлснээ хийдэг, хэрчсэнээ иддэг, амандаа хүрдэг, за бол ёогүй.

517. **СЛОВО НЕ ВОРОБЕЙ ВЫЛЕТИТ, НЕ ПОЙМАЕШЬ** Ам алдвал барьж болдоггүй, аг алдвал барьж болдог; үг алдвал барьж болдоггүй, үхэр алдвал барьж болдог; үгийг буцааж болдоггүй үхрийг буцааж болдог; хэлснээ буцаж болдоггүй хэрчсэнээ идэж болдог.

518. **СЛОВОМ СКАЗАТЬ** [*разг.*] Товчилж өгүүлбээс; товчилбоос, товчоор; хурангуйлбаас, ухаандаа, байзаж хэлбэл.

519. **СЛОЖА РУКИ (сидеть)** [*разг.*] Гар газар хөл хөсөр дэмий суу-; ажлаа алдаж бай-, хийсэн юмгүй хий дэмий суу-, гар хумхиад, өлгөө эвхээд.

520. **СЛОЖИТЬ (свою) ГОЛОВУ** Амь үрэгдэ-, амиа золи-, дайнд амь үрэгдэ-, гэрт төрөөд хээр үхдэг гээч бол-. П-685

521. **СЛОЖИТЬ (складывать) ОРУЖИЕ** Зэвсгээ хураалга-, зэвсгээ хая-, бууж өг-.

522. **СЛОЖИТЬ (складывать) РУКИ** Гар хуруугаа тата-, тэгэх ингэ-; бай-.

523. **СЛОМАТЬ ЗУБЫ** 1. Элс үмхэж эрэг мэрэ-, газар үмхэ-, үйлс барааита-, газар алгада-, 2. Хүчин зүтгэ-, чармай-, сувигда-, хазъя шүдгүй, харайя хөлгүй, харъя нүдгүй, харья гэргүй гэгч бол-.

524. **СЛОМАТЬ (сломить) СЕБЕ ШЕЮ** *на чем* Санадаггүйг санаж соёогоо булгал-, хүсдэггүйг хүсэж хүзүүгээ булгал-, толгойгсороо ус уу-, биеэ (хирээ) мэдэхгүй аашилж муугаа үзэ-, саваагүй нохой саранд хуца-. С-254

525. **СЛОМАТЬ РОГА** О-31

526. **СЛОМИТЬ ГОЛОВУ** Өнгөрө-, сөнө-, хорвоо нь нөгчи-.

527. **СЛОМИТЬ ДУХ** Урмы нь хугал-, зоригий нь (шантал-) мохос-, зүрхий нь шантал-, сэтгэлээр унага-, зүрхэнд нь шар ус хуруул-.

528. **СЛОМИТЬ РОГА** *кому* Эврий нь хуга цохи-, цорвонд оруулхазаарлаж ав, номхотгож ав-, омгий нь шантал-, бэлд нь буулга-, чөдөрлөж ав-, шары нь дара-, дөрөлж ав-, шөргөлж ав-, гартаа оруул-, аагий нь дара-, омгий нь дара-.

529. **СЛОМЯ ГОЛОВУ (бежать и. т. п)** Сандан мэндэн, яаран сандран ухаан жолоогүй (хурдал-), хар хурдаараа, байдаг тэнхээгээрээ

530. **СЛОН В ПОСУДНОЙ ЛАВКЕ** Хотонд чоно оруулчихсан юм шиг;

531. **СЛОНА НЕ ПРИМЕТИТЬ** [*разг., ирон.*] Үгээ олж хэлээрэй, эзнээ олж байж хэл!

532. **СЛОНОВАЯ БУМАГА** Зааны арьсан (цаас)

533. **СЛОНОВАЯ КОСТЬ** Зааны соёо

534. **СЛОНЫ (слонов) СЛОНЯТЬ** [*прост.*] (Хийх юмгүй, дэмий тэнэ-, хоосон сэлгүүцэ-, хий хэсүүчлэ-.

535. **СЛУГА ПОКОРНЫЙ!** [*разг., ирон.*] Тун арга алга; за гэх аргагүй, тэгмээр л байна л даа даанч, хэрхэвч чадахгүй, чадашгүй ээ! яавч чадашгүй,

536. **СЛУЖИТЕЛЬ КУЛЬТА** Шажин талынхан; сахил санваартан; лам хувраг

537. **СЛУХОВОЕ ОКНО** Дээврийн өрх, төхөөний өрх, дээврийн тооно

538. **СЛУХОМ ЗЕМЛЯ ПОЛНИТСЯ** [*разг.*] Гадуур ярьж байна; амьтан (тэгж) ...байна; Жиг жуг хийх, шивэр авир хийх, ам ам дамжих, дам дамаа ярих, цуудамнах, муу үг модон улаатай гэгчээр.

Он сам не говорит, что собирается жениться, но слухом земля полнится. Эхнэр авна гэж өөрөө ч юм хэлэхгүй л байна. Гадуур л амьтан болгон яриад байна шүү дээ.

539. **СЛУЧАЕТСЯ ОРЛАМ И НИЖЕ КУР СПУСКАТЬСЯ** Хонь гаталсан успаас чоно долоо, баян гэгч мөнх биш, зарц гэгч заяа биш; баян нэг шуурганд, баатар нэг суманд; хүний баян нохойн тарган хоёр адил.

540. **СЛУЧАЙ НЕ ЗАМЕДЛИЛ ПРЕДСТАВИТЬСЯ** Нэг мэдэхэд л болчихоно, удахгүй цаг нь болж цай нь буцлана.

541. **СЛЫХОМ (слухом) НЕ СЛЫХАТЬ** *о ком, о чем про что* [*прост.*] үзээ ч үгүй, дуулаа ч үгүй; нүдэндээ ч үзээгүй, чи хэндээ ч сонсоогүй.

542. **СЛЫХАННОЕ (слыхано) ЛИ ДЕЛО** (Өдий наслахдаа) дуулаагүй л юм байна, хэзээ л билээ дээ, урьд хожид байгаагүй,

543. **СЛЫШАЛ ЗВОН, ДА НЕ ЗНАЕТ ОТКУДА ОН** Дам л дуулсан, үнэн худлыг мэдэхгүй, дамын үг дамжигтай, дамжсан нь сэжигтэй, далд газар дамтай, дамын үг гоомой; дамын үг далан худалтай, зуурын үг зуун худалтай.

544. **СЛЫШАЛ ОДНИМ УХОМ** [*прост.*] Хагас дутуу дуулсан; там гум дуулсан, тойм дуулсан, гоомой юм л сонссон, (тэгэж, ингэж) хэлэв үү дээ. чих дэлссэн.

545. **СЛЫШАТЬ КРАЕМ УХА** *что* [*разг.*] К-471

546. **СЛЫШНО КАК МУХА ПРОЛЕТИТ** ялаа ч ниссэн дуулдмаарчив чимээгүй; нам жим анир чимээгүй, чих дүнгэнэн.

547. **СЛЮНКИ ТЕКУТ** Шүлс гоожим; арааны шүлс асгарам; хорхой хүрмээр, шүлс хазан, Г-73

В витрине выставлены такие вкусные вещи, что прямо слюнки текут. Дэлгүүрийн цонхонд арааны шүлс асгармаар амттайхан юм тавилжээ.

548. **СМАЗЫВАТЬ (смазать, намазывать, подмазывать) ПЯТКИ САЛОМ** [*прост.*] Ум хумгүй зугада-, ухаан жолоогүй зугада-,

549. **СМАТЫВАТЬ (смотать) УДОЧКИ** [*прост.*] Бушуухан зайла-; эртхэн холдо-.

550. **СМЕЖИТЬ ОЧИ (глаза) 1.** Нойрсо-, дугжира-, **2.** Таалал төгсө-, нас эцэслэ-, нүд ани-.

551. **СМЕЛОСТЬ ГОРОДА БЕРЁТ** Зоригоор дийлдэг сургаар олдог; зориг байвал хэрэг бүтнэ; зоригтой хүн чадалтай, зорилготой хүн замтай, юу сайхан зориг сайхан; эр хүн зоригтой бол чоно цацга алдана, эр хүн пар гэхээс айдаггүй, биеийн бөхөөр нэгийг давна, сэтгэлийн бөхөөр мянгыг давна.

552. **СМЕНА ВЕХ** Үзлээ өвөрчлөх; чигээ солих төрөл арилжсан мэт болох.

553. **СМЕНИТЬ ВЕХИ** Үзлээ өвөрчлө-, чигээ соли-.

554. **СМЕНИТЬ (перетенить, преложить, положить) ГНЕВ НА, МИЛОСТЬ** [*разг.*] Өршөө-, хэлтрүүл, өшихөөр өршөө- уурлахаар уучил-. М-76, П-103, П-104

555. **СМЕРИТЬ (мерить, мерять, смерять) ВЗГЛЯДОМ (глазами)** *кого* Ажиглан хара-, шинжин үзэ-, ажиж сэжи-, шинжиж сонжи-,

556. **СМЕРТНЫЙ ГРЕХ** Амьдын хар нүгэл, их гэм; завсар хар нүгэл.

557. **СМЕРТНЫЙ СЛУЧАЙ** Үхэх нь; үхдэг нь, нүд аньдаг нь, хордог нь, мажийдаг нь, хүн болдоггүй нь.

Число смертных случаев от этой болезни достигало 15%. Энэ өвчнөөр үхдэг нь зууд арван тав л байгаа юм.

558. **СМЕРТНЫЙ ЧАС (ПОСЛЕДНИЙ ЧАС)** Үхэхийн даваан дээр, үхдэг дээрээ, Амьсгаа хураахын үед, амь гарах үе, амь нь тийрэх үес, царайн цэлдийх үе.

559. **СМЕРТЬ ВСЕХ РАВНЯЕТ** Үхэхгүй хэн байх вэ айсан ч ойчно алцайсан ч ойчно, төрсөн амьтан үхдэг нь ёс, хэн ч үхнэ, төрлөгтөн бүхэн үхэлтэй, юу үнэн бэ үхэл үнэн, мөнхөрдөг жам биш, өнхөрдөг нь жам; үхэл алагладаггүй; эрлэгийн өөдөөс эгц хардаггүй, эрлэгийн элч хоосон буцдаггүй.

560. **СМЕРТЬ МОЯ** [*разг.*] Дүүрсэн! Үхсэн! Ээ дээ бас! Үхтэл...! Би дүүрчээ үхлээ! Би яаж үхдэг билээ. Хаашаа харж үхдэг билээ, ингэж үхдэг (дүүрдэг) юмаа бас.

561. **СМЕТЫ НЕТ** *кого чего* [*прост.*] Тоогүй (олон); тоо алдсан, тоо томшгүй.

562. **СМЕХ И ГРЕХ** [*разг.*] Инээд ч биш ханиад ч биш; уйлах инээх зэрэгцэх; инээх нэг хэцүү уйлах нэг хэцүү; инээх ч зовлонтой, байх ч зовлонтой.

563. **СМЕХА РАДИ** [*разг.*] Наргиа болгож, тоглоом тохуу хийж.

564. **СМЕХУ ПОДОБНО** [*прост.*] Инээдтэй, хөх инээд хүрмээр.

565. **СМЕШАТЬ С ГРЯЗЬЮ** З-89

566. **СМЕШИНКА В РОТ ПОПАЛА** *кому* Хөх инээд нь хүрэв, тогтож чадахгүй инээв; элгээ хөштөл инээв.

567. **СМЕЯТЬСЯ В БОРОДУ** Тэрүүхэндээ инээ-, жуумалза-, жуумгана-, инээмсэглэ-, бүг бүг инээ-. В-11, П-819

568. **СМЕЯТЬСЯ В КУЛАК** Бүгшин инээ-, жуумгана-, нууцгай инээ-

569. **СМЕЯТЬСЯ ПОСЛЕДНИМ** Сүүлд нь инээ-.
Хорошо будет смеяться тот, кто будет смеяться последним. Эхэнд нь инээхээр сүүлд нь инээ.

570. **СМИРЕНИЕ ПАЧЕ ГОРДОСТИ.** Оволзуур зант ёроолд нь хоцорч, ихээр хүн есөн мөнгө хүрэхгүй, эр үхэр есөн мөнгө хүрнэ. Дээгүүр санаат дээл ч үгүй, сүүл ч үгүй, их санаа биелдэггүй, бага санаа балардаггүй, биеэ өргөхөөр бишнийг өргө-, өөрийгөө өргөхөөр өрөөлийг өргө-.

571. **СМИРИТЕЛЬНАЯ РУБАШКА (рубаха)** (Галзуу хүнд өмсгөдөг) номхотгох цам.

572. **СМОРЧКОМ ГЛЯДИТ, А БОГАТЫРЁМ КАШУ УПЛЕТАЕТ** Урагшаа гишгэхдээ ургаа хад ууж идэхдээ уургын морь; идэх нь идэр, явах нь ядар; идэх нь эр ботго шиг, явах нь охин ботго шиг; идэхдээ эр бар шиг хийхдээ хашин бух шиг; идэхдээ ялдам хийхдээ ядам, (хуудам) идэхдээ идэрхэн, хийхдээ хэдэргэн; идэхдээ хадарган; хийхдээ хэдэргэн мах гэвэл ухасхийдэг мал гэвэл ухарс-хийдэг; мал гэхээр хөмсөг нь мах гэхээр магнай нь; хоол гэхээр сэртэс, хонь гэхээр урвас.

573. **СМОТАТЬ (свой) УДОЧКИ** [*перен. фам. прост.*] Далд орж өг-, арилаад өг-, зулбан арил-, тонил-.

574. **СМОТРЕТЬ БИРЮКОМ** Уйдан зовни-, уйдхарлан зово-, уруу царайл-, хөмсөг нь буу-, руу царайла-, угнай-,

575. **СМОТРЕТЬ (глядеть) БОЛЬШИМИ ГЛАЗАМИ** хүний хараанд, хүний эрхэнд бай-, хүний гарт; хүний мэдэлд. Б-305

576. **СМОТРЕТЬ В ГЛАЗА** *буюу* **В ЛИЦО** *чему* 1. Өөдөөс нь хара-, эгц хара-, нүүр тула-, 2. Хүний царай хара-, царайчил-.
Смотреть в глаза смерти Үхэлтэй нүүр тула-.

577. **СМОТРЕТЬ В ДУШУ** Г-81

578. **СМОТРЕТЬ (глядеть) В ЗУБЫ** *кому* Ширээ тавьж, ширдэг дэвсэ-, их л ёсорхох.

579. **СМОТРЕТЬ В КНИГУ И ВИДЕТЬ ФИГУ** Г-82

580. **СМОТРЕТЬ В КОРЕНЬ** [*разг. фам.*] Ёзоороор нь аьч үзэ-, оор хойгоор нь оро-, угт нь тултал уг мухры нь ол-, улла-, нэр хочоо бара- угт тулж ягт нь зогсо-.

581. **СМОТРЕТЬ В КУСТЫ** 1. Оргохоор завда-, босохоор сэтгэл төвдө-, 2. Зайлсхийхийг оролдо, булзаарахыг хичээ-.

582. **СМОТРЕТЬ (глядеть) В ЛЕС** Санаа буца-, урам хугара-, санаа эргэ-.

583. **СМОТРЕТЬ В МОГИЛУ (в гроб)** Хоног тоолж байгаа; хоног нь бол-, нүднээс гарсан, хоногоо хүлээж буй,

584. **СМОТРЕТЬ В ОБА** Г-85

585. **СМОТРЕТЬ В РОТ** *кому* 1. Хүний ам хара-, хүнээс идэх юм горьдо-, хүний идэж байгаа юманд хорхойгоо оруул (нүдээ унага-), шүлс хаза-, амруу орчих гээд; 2. (Өөрийн зориггүй) хүний ам хара-, хүний ая хара-.

586. **СМОТРЕТЬ В РЮМКУ** [*разг. шутл. ирон.*] Сархад зоогло-, согтоох ундаан уу-, аяга ёроолдо-.

587. **СМОТРЕТЬ ВО ВСЕ ГЛАЗА** Г-86

588. **СМОТРЕТЬ (глядеть) ВОН** Зайлахын түүс бол-, далд орохын түүс бол-, санаа бурууда-.

589. **СМОТРЕТЬ** *чьими* **ГЛАЗАМИ** *на что* (Миний, чиний, тийм ийм хүний) нүдээр хара-.

590. **СМОТРЕТЬ ЖЕНИХОМ** [*разг.*] Баяртайгаар (хара-); баяр хөөртэй; хөхүүн; цовоо цоргиун, хөл хөөртэй, хөөр баяртай.

591. **СМОТРЕТЬ ЗВЕРЕМ** Ширүүн хара-, ширүүн харцаар хара-, муухай хара-, аймаар хара-, муухай хара-, зэвүүн хара-, хүйтэн харцаар хара-, догшин харц.

592. **СМОТРЕТЬ (глядеть) ИЗ РУК** *кого чьих* Хүний гар хара-

593. **СМОТРЕТЬ ИНЫМИ (другими) ГЛАЗАМИ** Г-87

594. **СМОТРЕТЬ (глядеть) НА ВЕЩИ** *как*, тары нь тани- судсы нь атга-, хирий нь тани-

595. **СМОТРЕТЬ (глядеть) НЕ НА ЧТО** Шал дэмий.

596. **СМОТРЕТЬ, КАК НА КЛОЧОК БУМАГИ** (Бичиг мөтсийг Хоосон цаас гэж үзэ-, цоохор цаас гэж үзэ-, эрээн цаас гэ-, навс гэ-.

597. **СМОТРЕТЬ** *кому* **ПРЯМО В ГЛАЗА** Өдөөс нь хара-, эгцлэн хара-, би ч би, чи ч чи гэсэн шиг хара-, дальтралгүй ширтэ-, аймсаргагүй хара-, хашрахгүй хара-, нүүр бардам.

598. **СМОТРЕТЬ СВЕРХУ ВНИЗ** *на кого* [*перен.*] Доорд үзэ-, дээрлэхүү харцтай; тоох янзгүй, энэ муу гэсэн янзтай. Г-88

599. **СМОТРЕТЬ СВЫСОКА** *на него* [*неодобр*] С-598

600. **СМОТРЕТЬ СЕНТЯБРЁМ** [*разг.*] Уйтхарлан суу-, уруу царайл-, царай дара-, бүтэнги царайтай, духаа үрчийлгэ-, гансран гиюүрхэн, бодолд дарагда-, толгойгоо маажи-.

601. **СМОТРЕТЬ СКВОЗЬ ПАЛЬЦЫ** С-453.

602. **СМОТРЕТЬ (глядеть) СО СВОЕЙ КОЛОКОЛЬНИ** *на кого на что*

603. **СМОТРЕТЬ ЯГНЁНКОМ** Г-90

604. **СМОТРИ (гляди) В ОБА** Тун болгоомжтой; дороо суурьтай, дотроо ухаантай шүү!

605. **СМОТРИ (смотрите) У МЕНЯ** [*разг.*] Чи хирээ мэдээрэй хөө! Чи татаарай хөө! Чи хирд! Сайхан мэдээрэй! Аригаа даана биз!

606. **СМУТИТЬ СЕРДЦЕ (душу, ум)** *чью, чем* Сэтгэл (санаа) зово-, шанал-, энэлэн шанал-, зүрх шимшрэ-, гол харла-, сэтгэл тав алда-, зовлонд хата-.

607. **СМЫВАТЬ (смыть) КРОВЬЮ** Амираа ч төлж чадахгүй, хүний цусаар гараа угаа-.

608. **СНА НИ В ОДНОМ (едином) ГЛАЗУ НЕТ** [*разг.*] Огт нойр хүрэхгүй; нойр хулжиж орхиод дэрэн дээр сэрүүн холхи-, үнэгний нүд залгичихсан юм шиг, огт унтахын цандаагүй.

609. **СНАЧАЛА ПОДУМАЙ, ПОТОМ СДЕЛАЙ** Олон удаа бодож ганц удаа хэл. Дороо суурьтай дотроо ухаантай бай.

610. **СНЕЖНАЯ (снеговая) БАБА** Цасан хүн, хунгар хүн

611. **СНЕСТИ ГОЛОВУ С ПЛЕЧ** Хүзүүгий нь хуга мушги-, догий нь тас цохи-, бөндгөрий нь өнхрүүл-.

612. **СНИМАТЬ ПЕНКИ** [*перен.*] Алтгыг эдэлж амттыг идэж эрх таваар бай-, уутач болж суу-, бэлэн зэлэн хоол хувцсан дээр жарга-,

613. **СНИМАТЬ (срывать, сдирать, снять) ПОКРОВ** *с кого с чего* багий нь хуу тата-, улаан нүүрий нь гарга-, үнэн нүүрий нь гарга-

614. **СНИМАТЬ (снять последнюю) РУБАШКУ** *с кого* Улаан нүцгэн болго-, гахай явган, нохой нүцгэн болго-.

615. **СНИМАТЬ СЛИВКИ** Охий нь ав-, шимий нь хүртэ-, дээжий нь хүртэ-.

616. **СНИМАТЬ (снять) СТРУЖКУ** *с кого* [*прост.*] Хосы нь урт ав-.

617. **СНИМАТЬ (снять) ШЛЯПУ** *перед кем.* Хөл малгайгүй, хүндэл-, мэхийн ёсло-, амар амгаланг нь айлтга-.

618. **СНОСУ НЕТ** *чему* [*разг.*] Ястай, эдэлгээтэй бөх (хувцас); авсаар элэгддэггүй, элдэггүй, цоордоггүй, элж үлтэрдэггүй (сэмэрдэггүй) эдмэртдэггүй, амь бөхтэй, эдэлгээ даадаг (сайтай), [хорж холтордоггүй, үжирдэггүй, гарын ая даадаг. Н-719

Шубе моей сносу нет. Миний зувцаа их бөх шүү.

619. **СНЯВШИ ГОЛОВУ, ПО ВОЛОСАМ НЕ ПЛАЧУТ** Гэм нь урдаа, гэмшил нь хойноо.

620. **СНЯЛО ЖИВОЙ РУКОЙ** (Өвчин зовлон мэтэс) зүгээр боллоо; гайгүй, илааршив, өргөсий нь авчихсан юм шиг болчлоо, өндийв, сэхэж сэрвийв, сайжирч дээрдэв, эдгэрэв, өвчнөөс салав.

621. **СНЯТЬ ГОЛОВУ** Толгойгий чинь авч орхино шүү! Хар толгойноос (чинь) хагацуулчихна гэж мэдээрэй, толгойдоо хайртай бол! толгойгоо өгнө гэж мэдээрэй. Бөндгөрийг (чинь) авна шүү.

622. **СО ВКУСОМ** Аятайхан; сайхан; гоолиг; гоозүйтэй, амтайхан,

623. **СО ВРЕМЕНЕМ** Хожим, нэг цагт, ирээгүйд, яваа яваа сүүлд, дараа нэг, алс нь хэт нь, тэгсхийж байгаад, яваандаа.

624. **СО ВСЕГО ПЛЕЧА** Гар мэдэн буулга-, бяр мэдэн буулга-, гарын хамаг хүчээр, хар хүчээрээ, хар тэнхээгээрээ

625. **СО ВСЕМ ТЕМ** Хэдийвээр . . . боловч; . . . боловч; . . . ч атугай, . . . ч гэсэн, . . . гэсэн ч, . . . юм гэхэд, . . . лаа гэхэд.

626. **СО ВСЕМИ ОНЁРАМИ** [*разг. шутл.*] Буйгаар нь; бууряар нь хөрөнгөөрөө; тэр чигээрээ; хөхүүртэй бүлүүртэй нь; юутай хээтэй (хүүтэй) нь.

627. **СО ВСЕМИ ПОТРОХАМИ** [*разг. шутл.*] С-626.

Продал дом со всеми потрохами. Байшингаа тавилгатай юутай (хүүтэй) хээтэй нь зарав.

628. **СО ВСЕМИ ЧАДАМИ И ДОМОЧАДЦАМИ** [*шутл.*] Гэр хотлоороо; хүүхэд шуухадтайгаа; элэг бөлгөөрөө, халуун амираа, байх бийхээрээ.

629. **СО ВСЕХ КОНЦОВ** Дөрвөн зүг найман зовхисоос, газар газраас; энд тэндээс; нутаг нуг болгоноос; гол бүрээс; хоолой жалга бүрээс; тал талаас; аймаг хошуу бүрээс; зүг зүгээс,

630. **СО ВСЕХ НОГ (бежать, броситься и. т. п.)** [*разг.*] Хөл мэдэн; хар хурдаараа; шандас сорин; дөрвөн (хоёр) тавхайгаа эргэтэл; нисэх шахан; далавчилсан мэт; шурд шурд хийж-, хурд саалгүй, хөлийнхөө хурдаар, жирэлзүүлэн, жирийлгэн, тавларган, харайлган, бөмбөлзүүлэн, гишгүүлэн, тэлмүүлэн, тэшүүлэн.

631. **СО ВСЯЧИНКОЙ** [*разг. шутл.*] Аливаа; хамаг; сайн муу бүгд; элдэв дээдийн; эсэн бусангийн; янз янзын элдвийн, элдэв янзын, элдэв өнгийн, есөн дээдийн (өнгийн, жорын, өнгийн шидийн) долоон жорын, өнгийн хангайн

632. **СО ДВОРА УХОДИТЬ** [*прост.*] Гэрээс (цухуй-, холдо-,) гар-, гадагшаа гар-, юманд ява, эзгүй ява, бөгс өндий-.

633. **СО ДНЯ НА ДЕНЬ** 1. Мөдхөн; ойрын хэд хоногт, өнөө маргаашгүй, удахгүй 2. Өдөр өдрөөр шөнө хоногоор, өдөр ирэх тутам, өдөр (хоног) ойртох тусам, нохойн дуу ойртох тусам, сүүл мушгих дөхөх тусам, айлын утаа үнэртэх тутам

Ждём его со дня на день. Хэдхэн хоног хүлээе дээ (Хоног тоолж суухаас даа).

Они откладывают это со дня на день. Тэд нэр өдөр өдрөөр л хойшлуулж сааруулаад байгаа юм.

634. СО СВОЕЙ КОЛОКОЛЬНИ СМОТРЕТЬ *на что* [*разг.*] Худ-тийн мэлхий шиг, гахай тэнгэр хардаггүй гэгчээр, юм бүхнийг мухар сөөмөрөө хэмжи-, хүн гэмээ мэддэггүй, гэмээ гэдгэрээ мэддэггүй, аяга усанд алд загас багтахгүй гэдгийг мэдэхгүй

635. СО СКРЕЖЕТОМ ЗУБОВНЫМ [*ирон.*] Дургүйд хүчгүй гэгчээр; хорын (харын) албаар, (хар) муйхраар, албын хүчээр-, шүд зууж байж; араасаа түлхүүлж, өврөөсөө дугтруулж байж.

636. СО СКРИПОМ Чадан ядан, бэрхшиг туулан, бэрх зам туулж, дов сондгуултай замаар, хатуу хүтүү замаар.

637. СО СЛОВ *чьих* (Хэн нэг хүн) үгээр; амаар дуулж; амаар, ярианаар, хэлснээр, хөөрснөөр, дам дуулснаар, чих дэлсэнээр.

638. СО СНА Хар нүд хуу татаад, дөнгөж сэрээд, нойрмог, сэрсэн сэрээгүй хоёрын хооронд, унтаж босоод, нойрсож сэрээд, нойр-ноос сэрээд, давс тээж ирээд, үртын аянд явж ирээд, ээзгүй бүцалгаж байснаа, сэрмэгцээ, шүлэг нойроос сэрээд, зүүд нойроос сэрээд, дүгхийж босоод, хажуулдаж босоод, өглөө босоод, орноосоо өндийгөөд.

639. СО СПОКОЙНОЙ СОВЕСТЬЮ Амарлангүй; хэв нэг; жолоомжтой; оршилтой; дөлгөөн; зөөлөн номгохон (номхон), төлөвхөн, төвшиндүү.

640. СО СТОРОНЫ Хөндлөнгийн; хажуугийн; дэргэдээс, гаднаас, хань хамаагүй

641. СО СТОРОНЫ *кого, чего чьей* . . . талаасаа; . . . (тэр энэ) зүгээсээ.

С их стороны нет возражений. Тэдний талаас дургүйцсэн юмгүй (гэдэр дургүйцээгүй)

642. СО СТОРОНЫ ВИДНЕЕ Хөндлөнгийн хүний нүд өлөн; айлын хүн ажигч (хошины хүн ховч), өрөөлийн нүд өөнтөгч, хөндлөнгөөс ажвал.

643. СО СЧЁТОВ СБРОСИТЬ (скинуть) [*перен.*] Данснаас хаса-, авч хэлэлцэхгүй.

644. СО ШКОЛЬНОЙ СКАМЬИ Сургуулийн ширээнээс (салж); сургуулийн шор мулталж, (хичээл) сургуулна дүүргээд, номын ширээнээс.

645. СО ЩИТОМ (вернуться) Дайснаан дарж, дархан цолоо мандуулаад (ирэ-); дийлээд (буцаж ирэ-)

646. СОБАК ВЕШАТЬ (Хүнийг) харааж зүхэ-, аль муугаар нь дуу-да-,

647. СОБАК ГОНЯТЬ [*разг. фам.*] Дэмий (тэнэ-), дэмий суу-, ажлаа алдаж бай-, дэл суд суу-.

648. СОБАКА ЗАРЫТА В-881

649. СОБАКА ЛАЕТ ВЕТЕР НОСИТ Нохойн хуцал хүнд хамаагүй, хэлдэг нь хэлж л байг! ам гэдэг салхи; хүний хэлэх хүнд хамаагүй, хэлээд хэлэн чинээ мах олж идэг, оготныг дуу тэнгэрт

хүрэхгүй биз дээ амандаа орсныг ярьж л байг, хүний хэлснээр болох юм биш

650. СОБАКА НА СЕНЕ Даахгүй нохой булуу хураана гэдэг шиг, хэнд ч хэрэггүй, хар дараа.

651. СОБАКА СОБАКОЙ *с кем чем* [*перен.*] Нохой хуцсан шинжгүй, нохойноос дор үзэ-, аль муугаар нь дууда-; элдэв муугаар дарла-,

652. СОБАКЕ СОБАЧЬЯ СМЕРТЬ Саная муут яван хатдаг; муу санаяны үзүүрт хөө; муу хүний үхэх нь хар өдөр, муу санаа биеэ отно.

653. СОБАКУ СЪЕСТЬ *на чем* [*разг. шутл.*] (юманд) нэвтэрхий мэргэн; сүрхий чадамгай; тоглоом шиг амархан хий-, (тэрэндээ) эр бар.

654. СОБАЧИЙ СЫН (собачья дочь, собачье дети) [*прост., бран.*] нохойн хүү; нохойн гөлөг; нохой эр; нохой (той) хүн, чонын бэлтрэг, ёстой гайхал.

655. СОБАЧИЙ ХОЛОД [*разг.*] Муухай хүйтэн, чөмөг царцам, хүйтэн, үхрийн эвэр хугарам хүйтэн, дээлтэйгээ дэрийм, гуталтайгаа гуруйм, үсдмээр, хөлдмөөр, голд хүйт ором хүйтэн,

656. СОБАЧЬЯ РАДОСТЬ [*разг., шутл.*] Огидас хүрэм, нохой ч шунимгүй;

657. СОБАЧЬЯ СТАРОСТЬ [*разг., шутл.*] Ид насан дээрээ, нохойтой нас (буюу гучин хэд дундаа яваа нас), хэрсүүждэг нас; ухаан сууж эхэлдэг нас, эрийн цээлд хүрсэн.

658. СОБИРАТЬ КУСКИ [*прост.*] Гуйранчла-, гуйлгачин, гуйранч; хамж шимэ-, гуйж түү-, бадар бари-,

659. СОБОЛИНЫЕ БРОВИ [*перен.*] Өтгөн хар хөмсөг, өтгөн хөмсөг, өтгөн сайхан хөмсөг, жигүүр хөмсөг, нумарсан хөмсөг, саран хөмсөг, дурайсан хөмсөг.

660. СОБРАТЬСЯ (собираться) С ДУХОМ [*разг.*] 1. Амьсгаа авамсхий-, 2. Сэтгэл төвдө-, зоригоо хөвчилө-.

661. СОБРАТЬСЯ (собираться) С МЫСЛЯМИ Ухаан сийлэ-, дотроо тунгаа-, оюундаа шүүн үзэ-.

662. СОБРАТЬСЯ (собираться) С СИЛАМИ Хийморь сэргэ-, сэтгэл сэргэ-, бие сэвхий-, сэгхий-; бие тавира-.

663. СОБСТВЕННОЙ ПЕРСОНОЙ Өөрөө, биеэрээ; бодьгал өөрөө.

664. СОВАТЬ (сунуть) ГОЛОВУ В ПЕТЛЮ 1. Боож үхэ-, 2. Өртөгдө-, биедээ балаг тари-,орой руугаа ус хий-,өөртөө лай чирэ-.

665. СОВАТЬ (сунуть) НОС (СОВАТЬСЯ) [*разг.*] Хөндлөнгөөс хөлөө; хошуу дүрэ-, хүний хэрэгт орооцо хуруу дүрэ-, илүү хуруулж илүүр хошуула-. С-950, Т-216

666. СОВЕСТЬ ЗАЗРИТ (зазрила) [*разг.*] Тийм ёсгүй юм яаж байх вэ? Ийм муухай юм яаж байх вэ? Дааны муухай! Ичмээр; **хүний** үнэргүй юм, хүнээ алдсан, хүний мөсгүй.

667. **СОВЕТ ДА (и) ЛЮБОВЬ** Эвтэй найртай; эв сайтай; эвийн цавуу шиг, үхрийн бөөр шиг эвтэй эетэй, найртай сайхан, найрсаг.

668. **СОВСЕМ ДРУГОЙ КОЛЕНКОР** [*прост.*] Шал өөр юм; жич хэрэг; хахи хамаагүй юм; тэс ондоо юм; хавьцах юм биш, тэнгэр газар хоёр шиг, гал ус хоёр шиг; тэмээ ямаа хоёр шиг; ижилсэх юм биш, адилтгах юм биш, өдөр шөнө шиг;

669. **СОГЛАСИТЬСЯ ЧЕСТЬЮ** П-818

670. **СОГНАТЬ СЕМЬПОТОВ** *с кого* [*перен, разг.*] Хөлс баасы нь гоожуул-, тамир тэнхээгий нь бара-, хар хөлсий нь цувуул-, хөлсий нь чив чив дуслуул-.

671. **СОГНАТЬ СО СВЕТА** (со свету) [*разг.*] Алтан дэлхийн хөрснөөс арилга-. С-392

672. **СОГНУТЬ В БАРАНИЙ РОГ** *кого* Чанд засагла; хатуу захирацорвонд нөмхрөө-, хульхы нь буулга-. С-226, С-480, Г-94

673. **СОГНУТЬ В ДУГУ** (в три дуги) *кого* Хатуу атга-, нухчин дара-, зэд бари-, багалзуурдан дара-, тамтгий нь үзэ-. Г-59

674. **СОГНУТЬ В ТРИ ПОГИБЕЛИ** Г-96

675. **СОГНУТЬСЯ КОЛЬЦОМ** [*перен, разг.*] Бөхөлзөж нахилза-, бөгтрөн мөргө-. С-297

676. **СОДОМ И ГОМОРРА** Самуунтай, эмх замбараагүй, хярамцаг шиг болсон, тэмээ туйлж тэнгэрт ширгүүлсэн юм шиг

677. **СОДОМСКИЙ ГРЕХ** Самуун, садар, завхай зайдан, гүймхий

678. **СОЖЖЕНИЕ НА КОСТРЕ** Шатааж алах (христусын шашинтан оронд хүнийг шатааж алж байсан нэгэн зүйл цааз) галд өргөх, амьдаар нь шатаах, амьдаар нь хайлгах.

679. **СОЙТИ В МОГИЛУ** Булш бунхны оронд очи- булшинд оро-, энгэр түши.

680. **СОЙТИ НА НЕТ** [*разг.*] Байхгүй бол-, алга бол-, умаахан суухай болох. С-243

681. **СОЙТИ С АРЕНЫ** Ширээнээсээ бууж ширдэгнээсээ гулса-. С-686

682. **СОЙТИ С ПУТИ** 1. Замаа соли-, чих багаа өөрчлө-, бодлоо өөрчлөх 2. Замаа алда-, завхра-, гудманд гара-

683. **СОЙТИ С РЕЛЬСОВ** Замаа алда-, завхарч гүйцэ-, лойж орхи-, архиар толгойгоо мэдүүлэх.

684. **СОЙТИ С РУК** [*кому. разг.*] Хүний гараас мултра-, занганаас гарлаа, заяатай л гарав, арайхийж мултарлаа.

685. **СОЙТИ С УМА** Ухаан солиоро-, хийтэй бол-. С-761

686. **СОЙТИ СО СЦЕНЫ** С-681

687. **СОКОМ ВЫИТИ** [*разг.*] Элдэвлэж (явж) олж авах, арайхийж дөнгөх, чуу чамай болгох.

688. **СОЛДАТСКИЙ ОТВЕТ сейчас, ПОДБЯЧЕСКИЙ-ЗАВТРА** цэрэг хүн „одоохон" гэж өчдөг, бичгийн түшмэл „маргааш" гэж өчдөг.

689. **СОЛНЦЕ ВОЗДУХ И ВОДА НАШИ ЛУЧШИЕ ДРУЗЬЯ** Үг-чилбэл нар агаар, ус гурав бол бидний сайн нөхөр

690. **СОЛОВЬЯ БАСНЯМИ НЕ КОРМЯТ** Олон үгэнд олзгүй, үгний олноос үхрийн олон (идээ зоог барь гэж урихын өмнө, мөн хааяа ханатал өглөг өгөхийн өмнө хэлдэг үг гэнэ).

691. **СОЛОМЕННАЯ ВДОВА** [*разг., шутл.*] Холхи эм, бэлбэсэн эм, эрээ үхүүлсэн 2. Эрээсээ эзгүй эм, эр нь эзгүй (эм), дэл сул эм, эзнээ алдсан эм,

692. **СОЛОМЕННЫЕ НОГИ (Ножки)** [*разг., шутл.*] дэрсэн шилбэтэй, зээрийн шилбэн хөлтэй зэнзгэр гэдгий явдалтай, нялх унага шиг цүүцэгнэсэн, алагдаахай хөлтэй, тэнцэрч буй ботго шиг. 2. Тамир муутай, хөлд орж байгаа хүүхэд шиг, чигчий хурууны чилээ гаргахгүй, өвс идэж ус уусан юм шиг, туйвсан дайвсан, туялзсан.

693. **СОЛОМЕННЫЙ ВДОВЕЦ** [*шутл.*] 2. Холхи эр, эмээсээ эзгүй эр, эм нь эзгүй (эр) бэлбэсэн эр.

694. **СОЛОМОНОВО РЕШЕНИЕ** [*разг., ирон.*] мэргэн шийдвэр

695. **СОЛОНО ПРИЙТИСЬ** *кому, чему* [*разг.*] 1. Гай нь ирсэн, уруудсан, зовлон үзсэн, муугаа үзсэн, баларч дууссан, 2. Өстөч болов, дайсан нь болчих, 3. Сэтгэлд зовиуртай, шаналгаатай, яршигтай.

Мне пришлось солоно. Би баларч дууслаа.
Говорят что я им солоно пришёлся. Би өстөн нь болчихсон гэнэ ээ!

696. **СОЛЬ ЗЕМЛИ** (аль нэг үндэстний охи болсон юм) хүчин сор нь, чарам хийх юм, хамгийн дөмөг нь

697. **СОМКНУТЬ ГЛАЗА (очи)** (Ихэвчлэн тэгсэнгүй ингэсэнгүй гэсэн утгаар буюу нүд анисангүй, нүд хамхисангүй, огт унтсангүй гэсэн утгаар хэрэглэдэг) нүд хамхи-, нүд ани-.

698. **СОМКНУТЬ ПЛЕЧО** *С чьим.* **ПЛЕЧОМ** Зах нийлэ-, хаяа дэрлэ-,

699. **СОН В РУКУ** [*разг.*] Мэргэн зүүд, зүүдээрээ мэдэх, зүүдээ манах-.

700. **СОННОЕ ЦАРСТВО** Шөнө дүл, хамаг амьтан нойрсохуйд, шүлэг нойрын үе, шүлэг нойрсн дунд (шүлэг нойрноор), дуг нойрноор 2. Зүүдний жаргал, хоосон хүчний жаргал.

701. **СОПЛЕЙ ПЕРЕШИБЁШЪ.** *кого.* Тамиргүй эр, ишигний тэнхээгүй, салхинд хийсмээр хүн, махан балин, дээлийн гол, голтой мах, өвс идэж ус уусан юм шиг, найрын гурван дугараагүй, наадмын хоёр даваагүй, аманд унахаар, шороон мөрийнд хүрэхгүй эр, эм шинжийн эр, өөдөө барсан амьтан.

702. **СОРВАЛОСЬ С ЯЗЫКА** Үг алдав, ам алдав, ам гарав.

703. **СОРВАТЬ БАНК** Мөрий (-д) (хөрөнгөө) алда-, (хамаг байдгаа) мөрийд алда-.

704. **СОРВАТЬ ГОЛОВУ** *с кого, кому* [*прост.*] Цаазаар ав-, цааз-ла-, толгойгий нь ав-, 2. Сайхан мэдээрэй, за чамайг дээ, гайгүй ээ, чи тэгж л бай, арьсы чинь өвчөөд өгье гайгүй.

705. **СОРВАТЬ (срывать) МАСКУ** *кого.* Багий нь хуучин хая-, гуулий нь цухуйлга-, тары нь таннул- үнэн нүүрий нь илчлэ-, багий нь хуулж балгий нь илчлэ-.

706. **СОРВАТЬ С МЕСТА (с работы)** *кого* [*разг.*] (Ажил алба зэргээс) зайлуул-, хала-.

707. **СОРВАТЬ (срывать) СЕРДЦЕ** *на ком.* [*разг.*] (Тийм нйм хүнд) уураа гарга-, зүрх нь хөөрө-, агсарч алда-, омогдо-, ямаан омог гарга-, шаралха-.

708. **СОРВАТЬСЯ С МЕСТА** [*разг.*] Босон харай-, (тосож) ухасхий-, үсрэ-, цовхро-, дүүл-, харва-.

709. **СОРИТЬ ДЕНЬГАМИ (средствами и. т. п)** мөнгө бүрэлгэ-, мөнгийг ус цас шиг зара-.

710. **СОРОК ОДНО (два) С КИСТОЧКОЙ** Тавтай юу амгалан морилж байх шив дээ!

711. **СОРОК СОРОКОВ (Москвагийн)** зөчин дөчин сүм, тоо томшгүй, зах хязгааргүй, үй олон.

712. **СОРОКА НА ХВОСТЕ ПРИНЕСЛА (Принесёт)** [*перен, ирон.*] Дам үг, дамын ярна, хов үг, сураг.

713. **СОРОКА ВОРОВКА** (хүүхдийн үлгэрт гардаг) хулгамхай шаазгай.

714. **СОСАТЬ КРОВЬ** *чью* П-165.

715. **СОСЕТ ПОД ЛОЖЕЧКОЙ** Б-291

716. **СОСЛУЖИТЬ СЛУЖБУ** *кому* Тус хүргэ-, нэмэр хандив бололцо-, тус бол-, элбэлцэ-, элбэж дэмнэ-, хамжиж дэмжи-, барал бол-, сүүдэр бол-, түшилцэ-.

717. **СОСУД СКУДЕЛЬНЫЙ** [*перен.*] Амь нас богинотой, заяа муухантай, заяа нь загласан, богино заяатай, насгүй.

718. **СОХРАНИ БОГ (господь)** Тэнгэр өршөө! Бүү үзэгд! битгий амлах юм биш!

719. **СОХРАНИТЬ СВОЁ ЛИЦО** Нүүрээ бодо-, нэр нүүрөө, бүтэн нэртэй бүлээн цустай бай-, нэр төрөө авч гар-, нэрээ хугалал-, гүй ява-, нэр хугарахаар яс хугар гэ-, нэг нэрээ хоёр хийлгүй, нэг нэр хоёр хоч авалгүй.

720. **СОЦИАЛЬНЫЙ ЗАКАЗ** Олны хүсэл эрцэл, (эрэмцэл) олны хэрэгцээ, нийгэмлэгийн хэрэг, олны шахалт, олны санаа, олны олон таван цэн.

721. **СОЧИНИТЬ СЕБЕ** [*разг.*] Дотроо итгэ-, өөрөө итгэ-, болно гэж бодо-, үнэнээсээ итгэ-, итгэж найда-.

722. **СПАЛ И БЕДУ НАСПАЛ** Үгчилбээс: Унтаж байгаад ослоос мултрав гэгч, сохорсон биш завшив.

723. **СПАЛА ЗАВЕСА С ГЛАЗ** У-105.

724. **СПАСАТЬ СВОЮ ШКУРУ** [*разг. неодобр.*] Хар амиа авч гар-, амь үнэнч авгай худалч гэгч бол-, өөрийгөө бодож өрөөлийг тэвчи-, эр бие эмээл хаззар бүтэн гара-, толгой мэнд гара-, амь мэнд гара-, аминдаа арчтай.

725. **СПАСТИ ПОЛОЖЕНИЕ** Зовлонгоос мултрах, гачаалаас гарах, хоёр яс салах, хугацах, уяанаасаа алдуурах, үүргээ тайлах, чөдрөөсөө салах, дөнгөнөөсөө мултрах, ял салах, ам хаах.

726. **СПАСТИ СВОЁ ЛИЦО** С-719.

727. **СПАТЬ И ВИДЕТЬ** [*разг.*] Зүүдлэхээ шаха-, гэгээн өдөр цээжиндээ, харанхуй шөнө зүүдэндээ, өдрийн бодол шөнийн зүүд, (бодоод) өвчтэй болохоо шаха-.

728. **СПАСТЬ (спадать) С ГОЛОСА** [*разг.*] Хоолой сөө-, хоолой таг бол-, хоолой боочих шаха-.

729. **СПАСТЬ ЛИЦА** Царай алда-, урвайж оцро-, царай нь барай-, үнсэн царайла-.

730. **СПАСТЬ (спадать) С ТЕЛА (С ЛИЦА)** [*прост.*] Арьс яс бол-, гувчийж гуриат-, мяраа шуур-, шумайж орхи-, дэрс шиг бол-, турж эцэ-, тураалдаа хүрэ-, эцэж ядра-, эцэнхий туранхай бол-,

731. **СПАСУ НЕТ** [*прост.*] авралгүй

732. **СПАТЬ БЕЗ ЗАДНИХ НОГ** [*прост.*] Үхсэн юм шиг унта-, таг унта-, сур шиг сунаж сухай шиг улайж хэвтэ-, харин ч нэг давсанд явж байна даа.

733. **СПАТЬ ВЕЧНЫМ СНОМ** Үүрд нойрсо-, нэг мөсөн унта-.

734. **СПАТЬ КАК УБИТЫЙ** Үхсэн юм шиг унта-, давс тээ-, холын аянд ява-, сур шиг сунаж, сухай шиг улай-, унтах үхэхийн хагас гэгч бол-, үлгэрийн баатар шиг унта-. З-254

735. **СПАТЬ (заснуть) МЁРТВЫМ СНОМ** Үхсэн юм шиг унта (нойрсо-), дуг унта-, таг унта-, нам унта-. З-255

736. **СПИЛИТЬ НА НЕТ** Хурц болго-, хурцла-, ирлэ-, үзүүрлэ-, хялгас тавиад үлээхэд даахаар болго-.

737. **СПИСАТЬ В РАСХОД** В-1102.

738. **СПИСЫВАТЬ (списать) В ТИРАЖ** *кого* Мулт авахуул-, ховх халагда-, үл тэнцэх, тэнцэхгүй.

739. **СПИТ ВЕЧНЫМ (могильным, непробудным) СНОМ** [*устар.*] Мөнх нойрсжээ, өөд болов, таалал төгсөв.

740. **СПИТ И ВИДИТ** Нойр хоолгүй бодох, өдрийн бодол, шөнийн зүүд болох.

741. **СПИТЬСЯ В КРУГУ (круга)** [*разг.*] Архичин бол-, архинд жолоогоо мэдүүл-, усанд уургалуул-, архинд толгойгоо мэдүүл-, архины дон шүглэ- (туса-), архинд амна тави-.

742. **СПЛОШНАЯ ГРУСТЬ** [*разг.*] Бөөн зовлон, хар яршиг, сэтгэлийн зовлон, хар төвөг, шал дэмий.

С ним работать-сплошная грусть. Тэргүүнтэй юм хийх гэж бөөн зовлон.

743. СПЛОШЬ и (да) РЯДОМ [*разг.*] Дандаа, үргэлж байнга, уяаны болсон, салахгүй, хэзээ ямагт, олонтой төлөв, хэзээ цагт хэзээд.

744. СПОКОЙНАЯ СОВЕСТЬ Нүүр баатар, тэх нь аргагүй, тэхэд гэмгүй, гудиггүй, санаа амар.
Я со спокойной совестью отказал ему в просьбе. Юм гуйсны нь нүүр баатар үгүй гэж хэллээ би

745. СПОКОЙНОЙ НОЧИ [*разг.*] Тавтай нойрсоорой! сайхан унтаарай.

746. СПОКОН ВЕКУ (СПОКОН ВЕКОВ) [*разг.*] Эрт урьд цагаас, эрт дээр, элэр балар цагаас, эртээ урьд цагаас, хэзээнээсээ, тэргүүлэшгүй цагаас наань, аль хэдийнээс, аль хэдүйний
Спокон веку известно. Аль хэдийн мэдэцгээсэн

747. СПОРУ НЕТ [*разг.*] Хэлцээнгүй, маргаангүй, тийм ийм гэх юм байхгүй, жа л гэхээс өөр юмгүй, зөрөх юм алга, яриангүй, яриад яахав, ярилтгүй.

748. СПРАВИТЬСЯ В ПАМЯТИ Санаанд оро-, мартсанаа сана-, сэрхий-, нэхэн сана-, дурса-, бодогдо-.

749. СПРАВАДИТЬ НА ТОТ СВЕТ Төрөл арилжуул-, сүнсий нь тонилго-, диваажинд хүргэ-, шамбалын хаалга тайлуул-, бодий нь хөтөл-, маанй нь унши-, амы нь бари-, нүд аниул-

750. СПРЫГНУТЬ С УМА Ухаан самуура-, төөрөлдө-, сэтгэл ороотой гараатай бол-, хийтэй бол-.

751. СПРЯГЛИСЬ СЛОВНО БЫК С КЛЯЧЕЙ Хотон дотор үхэр оруулчихсан юм шиг, ижил буруу юм, холбочихсон юм шиг, дүйцгүй, тэмээ ямаа хоёр шиг.

752. СПРЯТАТЬСЯ В КУСТЫ [*разг., ирон.*] Оргон зайла-, босож ява-, зулбан зайла-, дүрвэ-, оргож бос-, бууруул-.

753. СПУСТИТЬ В ТРУБУ *что.* [*разг.*] Мөрийд байдгаа алда-, мулз хожигдо-, мөлжүүл-, шулагда-, хонгоо шулуул-, өврөө хоосло-, хэдээсээ сал-, байдгаа тавьж туу-.

754. СПУСТИТЬ (дело) НА ТОРМОЗАХ (муу юмыг) барьж бай-, жаахан тогтоо (саатуул-), хазаарлаж бай-, хэсэг торгоо-.

755. СПУСТИТЬ С ЛЕСТНИЦЫ *кого* [*прост.*] Хөөж гарга-, гадагш нь хөө-, үлдэн зайлуул-, хөөж туу-.

756. СПУСТИТЬ ШКУРУ *с кого.* [*прост.*] арьсы нь хуул-, турсгы нь хуул-, зулга жанчл-, арьс махы нь ура-, хярамцаг болго-, нөжгүй бөөн мах, цусгүй цул мах болго-.

757. СПУСТИТЬСЯ С ОБЛАКОВ (на землю) Ухаан нь уулнаас бууж ирэ-, наашгай юм бодо-, дэмийгээсээ дэмтэй юм сана (бодо-)

758. СПУСТЯ ЛЕТО ПО МАЛИНУ В ЛЕС НЕ ХОДЯТ Өнгөрсөн борооны хойноос хэвнэг бүү нөмөр, өдөр алдаад нөнө, наранд олоогүй ч саранд эрээд яахав, унтасан хойноо хавчих.

759. СПУСТЯ РУКАВА [*разг.*] Хам хум, сал сул, салан, хамаа намаагүй, хайш хэрэг, хайш яйш, пүл пал, цалгай, хуумгай, онтгой, салан задгай, гарын тоймоор, дээгүүр харж байгаад, оромдох, хуламдах, ор нэр болгох.
Работать спустя рукава. Хайш яйш хий-.

760. СПУТАТЬ ВСЕ КАРТЫ [*перен., разг.*] Өрөнй нь үймүүлж, зэргэлсний нь хутга- (бодож санаж байсны нь үймүүл-), хутгууш хий-, холион бантан болго-, учир замбараагий нь алдуул-, намбаа нацаггүй болго-, эрэмбий нь алдуул-.

761. СПЯТИТЬ С УМА С-685.

762. СРАВНЯТЬ С ЗЕМЛЕЙ (хот балгад, орон сав зэргийг) тал болго-, газартай нь хавтгайла-, үсгүй арчи-, ээзгий болго-, будаа болго-, үнсий нь хийсгэ-, голомты нь самра-. С-770

763. СРАМНАЯ ЧАСТЬ (эр эм хүний) нууц, нуудаг юм, бөхөс хахас, бэлэг эрхтэн (бөгс хагс), салтаа саам, бүсэлдэхийнээс доошхи.

764. СРЕДНЕЙ РУКИ Дунд гарын, дунд баазын, дунд зэргийн, дунд хирийн, дутуу дулим, хир баргийн

765. СРЕДНИМ ЧИСЛОМ В-342

766. СРЕДСТВА ПЕРЕДВИЖЕНИЯ унаа хөсөг, уналга хөсөг, тэрэг чарга, үхэр тэмээ, хөл дүүжлэх юм, хөсөг хөтөл, ачлага, уналга, унаа унаш, морь мал, эмээл тохох юм, зам хороох юм, зайдлах юм, дээр нь сандайлах юм, дээр нь гарах юм, өвс идэж ус уудаг юм.

767. СРЕДЬ БЕЛА ДНЯ [*разг.*] Гэгээн цагаан өдөр гэрэлт шар нарнаар, дээр нартай дэргэд айлтайд, (хүнтэйд) улаан цайм, олны нүдний өмнө арваараа барьж алгааараа харж байгаад, нүдэн дээр (ав) түм түжигнэж бум бужигнаж байхад, хөл татраагүй байхад, өдрөөр.

768. СРЕЗАТЬ НОС *кому чему.* дайрчих шахаад өнгөрө-, шурд гээд гар-, гишигчихэн алдаад ява-, салхи татуулаад гар-.

768. СРЕЗАТЬ УГОЛ Ойрыг тата-, зам дөтлө-, ойрыг бодо-. дөтийг хара (бодо-).

770. СРОВНЯТЬ С ЗЕМЛЕЙ С-762.

771. СРЫВАТЬ ЦВЕТЫ УДОВОЛЬСТВИЯ [*ирон.*] Бодох санах юмгүй, жаргалдаа согто-, ташуура-, ничигнэж аж төрө-, хүнгэнэж чингэнэн аж төрө-.

772. СРЫВАТЬСЯ (сорваться) С ЯЗЫКА Өөрийн эрхгүй ам ангайж орхив, яагаад ч юм хэлж л орхиж.

773. СТАВИТЬ В ПРИМЕР үлгэр ав-, үлгэр хий-, үлгэр болго-, дууриал болго-, сургамж ав-, санаа ав-, баримжаа ав-.

774. СТАВИТЬ В ТУПИК (втупик) П-827.

775. СТАВИТЬ В УГОЛ (хүүхдийн) буланд зогсоож (шийтгэ-,)

776. СТАВИТЬ (поставить, положить) ВО ГЛАВУ УГЛА гол болго-, голд бари-, нуруу хий-, яс хий-,

777. **СТАВИТЬ ВО ГРЕХ** *что кому*. муушаа-, зэмлэ-, буруушаа-, жигшн-, тэвчи-.

778. **СТАВИТЬ (поставить) ВОПРОС РЕБРОМ** түстас хэлэ-, шулуухан хэлэ-, шийдмэг асуу-.

779. **СТАВИТЬ (поставить) В ПЕНЬ** *кого*. Мухардуул-, ягдуул-, цусгүй ал-.

780. **СТАВИТЬ (поставить) ВСЕ НА СВОЁ МЕСТО** зүй ёсоороо бол-, хуучнаараа бол-.

781. **СТАВИТЬ (поставить) В СТРОКУ** *кому, что* (хэрэг зэргийг) чихэ-, тохоо-, тулга-.

СТАВИТЬ (поставить) всякое лыко в строку Лай бүхнийг мөрөндөө үүрэ-, хэрэг бүхнийг хар толгойдоо хүлээ-.

782. **СТАВИТЬ ЗНАК РАВЕНСТВА** *между кем чем* 1 тэнцэх тэмдэг тави-, 2. [*перен.*] адилтга-, ижил хэмээ-, адилдаа адил годилдоо годил, эгээ нэг, огсод адил.

783. **СТАВИТЬ (поставить) К СТЕНКЕ** цаазаар аваачи-, буудан ал-

784. **СТАВИТЬ (поставить) НА ВИД** *кому*. хувь хүртээ-.

785. **СТАВИТЬ НА КАРТУ** *что*. үзээд алда-, ядгаа үзэ-, нэгийгээ үзэ-, эр охиноо үз-, П-835

786. **СТАВИТЬ (поставить) НА КОН** Амь үл хайрла-, амь насаа зориул-.

787. **СТАВИТЬ (поставить) НА КОЛЕНИ** өвдөг сөхрүүл-, сөгтгө-, мөргүүл-, дагуул-, номотго-, шары нь дара-, мөхгөө-, бэлд нь буулга-, хулхий нь буулга-, шалд нь буулга-, чихий нь дор болго-

788. **СТАВИТЬ НА НОГИ** *кого* П-839.

789. **СТАВИТЬ (поставить) НА ОДНУ ДОСКУ** *кого, с кем* Адилдаа, чацуул-, эн зэрэгцүүл-, жиши-, дүйцүүл-, харьцуул- С-884

790. **СТАВИТЬ НА СВОЁМ** Өөрийнхөө саваар хэмжи-, өөрийнхөөрөө бодо-.

790 б **СТАВИТЬ (поставить) НА СЛУЖБУ** *чему*. тохсон томил-, дайчла-.

790. в **СТАВИТЬ НА ТЁМНУЮ ЛОШАДКУ** [*перен*] ёс мэдэхгүй хүнд ёр халдахгүй гэгчээр дөнгө-, мэдээгүй бол мэнд сайхан болго-

791. **СТАВИТЬ ПАЛКИ В КОЛЁСА** В-1008.

792. **СТАВИТЬ ПОД ВОПРОС** *что*. Найдлагагүй ... гэж. юу л болдоо гэ-, эргэлзэ-, дамжиггүй, сэжиглэ-, харда-, хардаж сэрдэ-.

793. **СТАВИТЬ (поставить) РЕБРОМ ПОСЛЕДНЮЮ КОПЕЙКУ** [*гром.*] Нэг мөсөн, даший нь өргө-, мөнгөө үрэ-, уутаа эргүүл-, ёроолы нь гарга-, мөнгөө шавха-.

794. **СТАВИТЬ САМОВАР** Цай чана-, цай гал дээр тави-.

795. **СТАВИТЬ (поставить) ТОЧКИ НА (над) и** 1. Одоо цэглэе болье 2. Илүү үг.

796. **СТАВИТЬ (поставить) ТОЧКУ** [*разг.*] цэглэе өндөрлөе, дуусгавар болго-, гүйцээ-.

797. **СТАВИТЬ ФОНАРИ** [*разг. шутл.*] Хүрэн нүц болтол зодохөх нүц, эрээн болго-, хөх (алаг) тарлан болтол жанчи-, хярамцаг болго-, гуврүү гүйтэл, төвдрүүдтэл зодо-, салам зодо-.

798. **СТАВИТЬ ЧАСЫ** Цаг тааруул-.

799. **СТАДО БАРАНОВ** [*разг. неодобр.*] Хонь шиг номхон, дуулгавартай амьтад, далайхаар нь далд орж даллахаар нь ил гарагсад, зөөлөн хамартай.

800. **СТАЛКИВАТЬСЯ НА УЗКОЙ ДОРОЖКЕ** В-1019, С-862

801. **СТАЛО БЫТЬ** [*разг.*] Учир нимд, чингэхэд, иймээс, тэгэхлээр, нигэхлээр, нимнийн тулд, нимээс, нимд, нийм дээрээс, нигэхлээр.

802. **СТАНЕТСЯ С** *кого буюу* **СТАНЕТ** *с кого*. [*разг.*] Денгечнхөөр хийхээсээ бүцэхгүй, хийхээ сийхгүй, зөв, өлхөн, эр бар, хүн царайчлахгүй, баавгай, бардам, бардан, уужуухан.

С тебя этого станет. Чи ч энүүндээ эр бардаа.

803. **СТАНОВАЯ ЖИЛА (хребет)** Гол нуруу, нөён нуруу, гол судал, яс мод, араг яс.

804. **СТАНОВИТЬСЯ (стать) НА ЗАДНИЕ ЛАПКИ** долигоно-, зусарда-, пялгана-, урд нь бөндөгнө-.

805. **СТАНОВИТЬСЯ (Стать) НА КОЛЕНИ** *перед кем* өвдөг сөгдө-, гарт нь оро-, хүлцэн дага-, долдойдо-.

806. **СТАНОВИТЬСЯ (стать) НА ОДНУ ДОСКУ** *кем*. Эн зэрэгцэ-, эн чацуу бол-, зэндаа зэрэгцэ-, дээгүүр жаал-.

807. **СТАНОВИТЬСЯ (стать) НА ПУТЬ** *чего*. Зам нээгдэ-, шулуундаа оро-, зам нь шулууд-.

808. **СТАНОВИТЬСЯ НА СВОЁ МЕСТО** Ёсоороо, зүй ёсоороо (бол-) номын ёсоор бол-, (бай-), хуучин янзаараа, байсан хэвээрээ, байсан байсан газраа.

После произведенных изменений все становится на своё место Өөрчлөлт хийсний дараа яг хуучнаараа болно.

809. **СТАНОВИТЬСЯ (стать) НА СТОРОНУ** *кого чью*. Талд нь оро-, өмгөөл-, тал тохой тата-, талца-.

810. **СТАР И МАЛ (СТАРЫЙ И МАЛЫЙ)** [*разг.*] Хөгшин хөвөөгүй, хүүхдүүд цөм, найман настай балчраас наян настай хөгшид хүртэл, их багагүй, том жижиггүй, залуу хөгшингүй

811. **СТАРА ПЕСНЯ (СТАРАЯ ПЕСНЯ)** [*разг.*] [*неодобр.*] улигтбахь байдаг, улиг болсон, домогт яриа, амны умшлага, маань мэгзэм шиг болсон.

812. **СТАРАЯ ГВАРДИЯ** Тогтсон бөх, хуучия хашрууд, хий нь арилсан хуучны хулуу, өө нь гарсан, хашир хандгай, хуучны хуучин, хожуулын цог.

813. **СТАРАЯ ДЕВА** Хөгшин хүүхэн, хижээл авгай.

814. **СТАРАЯ ЗАКВАСКА** Хуучны хулуу, хуучин барилтан, хуучнаа тавьдаггүй, тогтсон бөх гэгчээр, тогтсон барилтай, авсаар юманд хөдлөхгүй.

815. СТАРАЯ КОЧЕРГА [*бран.*] -зөнөг, хөгшин зөнөг, зөнөг толгой.

816. СТАРАЯ ЛЮБОВЬ НЕ РЖАВЕЕТ Янаг удах тусам ээнэгшидэг. залуудаа эр эм, хөгширөхдөө аав ээж.

817. СТАРАЯ ПОГУДКА НА НОВЫЙ ЛАД Савы нь соливч сааль нь хэвээрээ. хөхүүрт нь соливч хөрөнгө нь хэвээрээ, хөгшин. азрага жороо сурдаггүй, тавь хүрснийг сургадаггүй, таван нохойг хорьдоггүй.

818. СТАРИННОГО ПОКРОЯ Хуучин барилтай (хүн юм), хуучны

819. СТАРО КАК МИР [*разг.*] Хув хуучин, ул болсон, улиг болсон (яриа), улиг домог болсон, хэн бүхний мэддэг, нуруугаа авчихсан.

820. СТАРОГО ВОРОБЬЯ НА МЯКИНЕ НЕ ПРОВЕДЕШЬ Хөгшин чоно мэхэнд орохгүй, хөгшин нохой чононд хууртахгүй, хашир хүн манаанд осолдохгүй.

821. СТАРОСТЬ НЕ (в) РАДОСТЬ Эрийг нас дарж уулыг цас дара-, энэ болж эцсэн хонины дэлэн болж, цаасаар хийсэн заяа бол-, өрхтөн бүгд мохож, эцэс хойтоо бодо-, цагаа болоход цастын арслан шоргоолжинд,

822. СТАРЫЙ ВОЛК (зверь) Т-169.

823. СТАРЫЙ ВОРОБЕЙ [*разг.*] Хашир хандгай, хуучин бууны хугархай, хуучны хуучин, хожуулын цог, хий нь гарч өө нь арилсан, оймс элээсэн, олон юм үзсэн, дол цохьсон, тогтсон бөх, хий нь гарсан бөх, алзахаааас өнгөрсөн, авсаар юманд гэнэдэхгүй. С-907

824. СТАРЫЙ ДРУГ ЛУЧШЕ НОВЫХ ДВУХ Хүний хуучин (дээлийн) хувцасны шинэ,хуучин хүн хуудуугүй хуучин нөхөр хоёр шинээс дээр, уулын буганаас унасан бух үнэнч, муу шинийг тоохгүй хуучин, бүтэлгүй арваас, бүтэлтэй нэг.

825. СТАРЫЙ КОНЬ БОРОЗДЫ НЕ ИСПОРТИТ Хүний хуучин нь дээлийн шинэ нь, хуучин хүн хуудуугүй, хуурай будаа чулуугүй, хуучин бууны хугархай гэсэндээ, хуучин үгэнд худалгүй, хурын усанд хужиргүй.

826. СТАРЫЙ ХРЕН [*разг.*] Өвгөрсөн хүн, өтөлж ядарсан хүн, эрүүл өвдөг нь нийлсэн хөгшин хөнхөрцөг, зөнөг толгой, хөгшин төгцөг, улаан бууль.

827. СТАТОЧНОЕ ЛИ ДЕЛО [*разг.*] Ингэж болох уу

828. СТАТЬ В ПЕНЬ [*разг.*] Эргэлзэ-, дүйнгэртээ-, мод орги-, хөшөө царайла-, арга тасра-.

829. СТАТЬ В ПОЗУ *какую кого* (Тийм ийм) дүр гарга-, (тийм ийм юмны, хүний) дүр үзүүл-, . . .-ны маяг гарга-, дүрэмдэ-, намжир гарга-,

830. СТАТЬ В СТРУНКУ В- 1254.

831. СТАТЬ (становится) **В ТУПИК** мухарда-, арга барагда-, яалт ч үгүй бол-, яг мухардаж, таг суух

832. СТАТЬ В ТЯГОСТЬ *кому* (хэн хүнийг) зовоо-, чирэгдүүл-, лай бол-, төвөг уда-.

833. СТАТЬ ГРУДЬЮ С—871.

834. СТАТЬ (сделаться) **ДОСТОЯНИЕМ УЛИЦЫ** [*разг.*] Айл амьтангүй, мэддэг бол-, хэн хүнгүй андахгүй, хот хороогүй мэдэ-, тарваганы дош шиг бол-.

835. СТАТЬ НА ДОРОГЕ (пути) В-1010.

836. СТАТЬ НА ДЫБЫ В-1011.

837. СТАТЬ НА МЕСТО Хир тааруу ажил ол-, болмын газар бай-, суудлаа ол-, өөртөө таарсан юм ол-, хирдээ таарсан юм ол-, барж идэх хоолоо барьж ав-, суурь намайг голохгүй, сууриа би голохгүй гэгчээр, чадах юмаа оролдо-, хүч хүрэх юмаа барьж ав-.

838. СТАТЬ (становиться) **НА НОГИ** [*разг.*] 1. Өвдөөд бос-, бие илар бол-, 2. Өндийж өөдлө-, толгойгоо даа-, эдгэрэ-, өндийхтэй бол-, сэхээж сэрвий-, сайжирч дээрдэ-, орох гарахтай бол-, хэвтрээсээ гар-, гарч шээхтэй бол-, өтгөн шингэнээ зөөлгөхгүй бол-, хүн бол-, алзахгүй бол-.

839. СТАТЬ НА ПОПА Босоо бай-, ас бол-, гозой-.

840. СТАТЬ НА РЕЛЬСЫ Хөл дээрээ босо-, зогсо-, биеэ даа-, зам шулууда-.

841. СТАТЬ (становиться) **ПОПЕРЁК ГОРЛА (глотки)** [*разг.*] [*прост., фам.*] Бүлхи залгисан юм шиг, сэтгэлд сэвтэй оргидотор бөглөөтэй юм шиг, дотор хахиулда-, сэтгэлийн бөөдий бол-.

842. СТАТЬ (становиться) **ПОПЕРЁК ДОРОГИ (пути)** *кому.* [*разг.*] В-1010

843. СТЕНА В СТЕНУ [*разг.*] Хамар хашаанд, хаяа нийлж суух, хөрш зэргэлдээ аж төрөх.

844. СТЕНА НА СТЕНУ (СТЕНКА НА СТЕНКУ Хоёр талын цэрэг, зодоочин зэрэг талцан (ханан хад шиг харгалд, халз өөд өөдөөсөө, дошилсон бух шиг).

845. СТЕНА ОБ СТЕНУ (стенка об стенку) Хаяа нийлж, босго дэрлэн.

846. СТЕНКА НА СТЕНКУ (стена на стенку) Бүлэглэх, бүлэг бүлгээрээ, (боорлон явцгаах).

847. СТЕНЫ УШИ ИМЕЮТ Гэрийн гадаа гэтсэн хүн бий, хоймрын хөөрөө хотонд дуулддаг. У-17

848. СТЕРЕТЬ В ПОРОШОК И—270.

849. СТЕРЕТЬ В РОГ С-528.

850. СТЕРЕТЬ С ЛИЦА ЗЕМЛИ *кого, что.* Голомты нь самра-, голы нь самна-, үнсий нь хийсгэ-, үнсэн товрог болго-.

851. СТЕРПИТСЯ-СЛЮБИТСЯ Эрд гарна гэдэг чинь энэ насны жаргал шүү . . . Буруу харж уйлаарай, зөв харж инээгээрэй.

(Д. Нацагдорж

852. СТЕЧЕНИЕ ОБСТОЯТЕЛЬСТВ Тохиров, нөхцөл, бүрэлдэх гав сүв нь таарах, бүгд нийцэх.

853. СТИРАТЬ (стереть) ГРАНИ (грань) МЕЖДУ *кем, чем.* Эх захаа алда-, ах захаа алда-, дээр дорхүй бол-, тэгшитгэл хий-.

854. СТИСНУВ ЗУБЫ Шүд зуун, шүд зууж байгаад, тэсэж гэмээ тэсээд, тэсэхийн сайнаар тэсээд, тэсэхийн дээдээр тэсээд, хүний хүү шиг тэсээд, аавын хүү шиг тэсээд.

855. СТИХ НАШЁЛ (находит) [*разг.*] Хэрэгтэй хэрэггүй бодол төрө-, элдвийн санаа орж ирэ-,

856. СТОИЛО БЫ тэгэхэд яахав, тэгж болно, зүгээр.

857. СТОИТ ДЕНЕГ [*разг.*] Үнэ хүрэхээр, үнэ сайн барьдаг, үнэтэй цайтай, үнэ зодогтой, хэн ч авах, төвөггүй борло-, хүн дурлам, ухаас гээд ав-.

858. СТОЛ КРИВОЙ [*шутл.*] Давсаа (тавихаа) мартсан

859. СТОЛБОВАЯ ДОРОГА Гол зам, их зам, хүрээ зам, төв зам, луугар зам.

860. СТОЛБОВОЙ ДВОРЯНИН [*разг.*] Сурвалжит (гэр бүл) айл, уе уламжилсан (удам), уе залгамжилсан,

861. СТОЛКНУТЬ ЛБАМИ *кого, с кем.* Мөргөлдө-, гэдсэндээ хөлөө хийлцэ-, хамрынхаа хатуу зөөлийг үзэ-, памалдгаа пээлцэ-, хамраа чихэлцэ-, толгой түрүүгүй зодолдо--

862. СТОЛКНУТЬСЯ НА УЗКОЙ ДОРОЖКЕ В-1019.

863. СТОЛЬКО ЖЕ. . ., СКОЛЬКО И. . . . ч, . . . ч, . . тэгэх тэгэх зэрэгцэ-.

Он столько же скромен, сколько и талантлив. Даруухан ч авьяастай ч хүн дээ. **Он любит эту работу столько же, сколько и я.** Энэ ажилдаа чухам л надшиг дуртай.

864. СТОЛЬКО . . ., ЧТО . . . тэгэх(гүй) л, . . . тийм л) энэ хэллэгийг өгүүлбэр дунд нь найруулсхийн орчуулбаас зохилтой.

Столько дел, что времени не хватает Зав гарахгүйгээр л их ажил

865. СТОН СТОИТ Дуу тасрахгүй (ёолон), дуу шуу болон, үргэлжлэн дүнгэнээ, тасралтгүй хангинан, дуу алдан.

866. СТОРОНОЙ ДОЗНАТЬСЯ (узнать и .т. п) хөндлөнгөөс (дамаас) мэдээ (дуул-).

867. СТОЯТЬ В ГЛАЗАХ *у кого.* нүдний нь өмнө, улаан цайм.

868. СТОЯТЬ (стать) ВО ГЛАВЕ *кого, чего.* Манлайла-, магнай цохи-, түрүү бари-, ноён суу-, дээгүүр жаал-.

869. СТОЯТЬ (держаться) В СТОРОНЕ Хөндий зайдуу, биеэ зайлсхий-, тойро-,

870. СТОЯТЬ ГОРОЙ *за кого, что.* [*разг.*] Хан уул шиг халх бол-, уул шиг түшигтэй, хангай шиг түшигтэй.

871. СТОЯТЬ ГРУДЬЮ *за кого-что.* Цээж түрэ-, шагайсан буу далайсан сэлэмнээс халхрахгүй, эр биеэрээ (хамгаала-), эрэлхэгээр хамгаала-, С-833, В-1009

872. СТОЯТЬ ЗА СПИНОЙ *у кого.* Гул бари-, бамбай бари-, араар нь тави-, (тийм нөм юмаар) түрээ бари-,

873. СТОЯТЬ ИДОЛОМ [*разг.*] Авдар дээр тавьсан бурхан шиг, хөшөө шиг зогсо-, дуу ч үгүй шуу ч үгүй зогсо-, шон шиг зогсо-,

874. СТОЯТЬ ИСТУКАНОМ Хөлөө шиг зогсо-, шон шиг гозой-, манхуухай шиг, шаасан гадас шиг, модон өмдтэй юм шиг, хөшөө чулуу шиг, шавар баримал шиг, суумал бурхан шиг, яндан шиг, зайнд цохиулсан юм шиг, гүйцэнд дайрагдсан юм шиг, хөдөлгөөнгүй зогсо-, хөдлөхгүй юм шиг, газартай нь бариад хадгийсан юм шиг.

875. СТОЯТЬ, КАК ПЕНЬ (пнём,) [*разг.*] Хөлөө шиг зогсо-, модшиг модой-, шон шиг шовой-, ёроол (ёрвон) шиг ёртойж, хожуул шиг гозойж, овоо босгочихсон юм шиг, ургаа хад (мод) шиг, эцэн морь шиг, ярдаг даага шиг, өвгөн шувуу сууж байгаа юм шиг, үлий сахисан сар шиг, нүх сахисан анчин шиг, нуунанд суусан гөрөөч шиг, үхэр чулуу шиг.

876. СТОЯТЬ КОЛОМ [*разг.*] Модой-, хөвчилө-, матай-.

877. СТОЯТЬ КОЛОМ В ГОРЛЕ [*разг.*] Хоолойгоор орохгүй, хоёр чихнээс хэтрэхгүй, доошоо орохгүй, амнаас уначих гээд, өөдтэйхөн, айлын нохой тоож идэшгүй, амсахын аргагүй, үнэр тоож шиншмээргүй, үхэр тоож үнэртэхгүй, нохойн хоол-, (шөл цай бол) угаадас шиг

878. СТОЯТЬ НА (этом, своём и. т. п.) (бодол санал зориг) чанга баримтал-, өөрийнхөөрөө зүтгэ-, зүтгэсэндээ зүтгэ-, гэгээрээ зүтгэ-, бууж өгөхгүй.

879. СТОЯТЬ НА ВЫСОТЕ (положения задачи) Элбэг чада-, дийлэхтэй, баавгай, эр бар, өлхөн ханхалзана, өөртөө зөв, хувна борлуулна, хүнд хувна өгөхгүй, хүн царайчлахгүй, уужуухан, элбэгдэ-, цаана нь юу байна гэ-, нохойн наадам, хүүхдийн тоглоом, юухан байх вэ, үзээд өнгөрнө.

880. СТОЯТЬ НА ВЫТЯЖКУ Гозойтол зогсо-, шон шиг зогсо-, цэх зогсо-, шаасан гадас шиг, бай шиг, шав шиг, газарт хатгасан сүмбэ шиг, хөдөлж болохгүй гэсэн юм шиг, амьгүй юм шиг, хөл нь газартай наалдчихсан юм шиг, овоолгоотой аргал шиг.

881. СТОЯТЬ НА *чьей.* **ДОРОГЕ (пути)** [*разг.*] (Хүнд) саад хий-, чодор тави-, тушаа тави-.

882. СТОЯТЬ НА ЗАДНИХ ЛАПКАХ Х-42

883. СТОЯТЬ НА НОГАХ Толгойгоо даа-, амна даахтай бол-, амна арчилдаг бол-, биед хүрэ-, хар амна аргалахтай бол-.

884. СТОЯТЬ НА ОДНОЙ ДОСКЕ С-789.

885. СТОЯТЬ НА ПЛАТФОРМЕ *чего. . . .*-нийг өмгөөлө-, хамгаала-, хаацайл-, . . . нийн талд бай-, . . . г баримтла-

886. СТОЯТЬ НА СВОЁМ (на одном) Яг баримтал-, бат зогсо-,

887. СТОЯТЬ НА СВОЁМ ПОСТУ Эзний ёсоор, харуулдагатай бай-, эзэн хүн шиг

888. **СТОЯТЬ НА (собственных) НОГАХ** бие даа-, хар толгойдоо эзэн бол-, дагнан аж төрө-, хүний гараас гар-, бусдын царай харахаа боли-

889. **СТОЯТЬ НА СТОРОНЕ** *кого чьей* талца-, ... ын талд оро-, ... ийн талыг бари-.

890. **СТОЯТЬ НА СТРАЖЕ** *чего.* Өмөг түшиг, түшиг тулгуур, хайр ивээл дор

891. **СТОЯТЬ НА ЧАСАХ** зогсоо манаа, харуул манаа, манаанд гар-

892. **СТОЯТЬ НАД ДУШОЙ** *у кого, чей* [*разг*]. Хүн зовоо-, хүний сэтгэл зовоо-, нойтон хамуу шиг-, хагацаж өгөхгүй, чээжний махы нь идэ-,

893. **СТОЯТЬ НАСМЕРТЬ** үхэн сахин, (үхтлээ хамгаал-, амнараа сахин хамгаала-, амь үл хайрлан, амь биеэ зориулан, өмөөрөн өмөглө-, амь-,тавин өмгөөлө-, амиа золин хамгаала-, эрстэн зүтгэ-

894. **СТОЯТЬ ОДНОЙ НОГОЙ В ГРОБУ** [*разг.*] О-108.

895. **СТОЯТЬ ПЕРЕД ГЛАЗАМИ** нүдэнд үзэгдэх мэт, санаанд илхэн, дотор тог, толгойд яг

896. **СТОЯТЬ ПОПЕРЁК ГОРЛА** *у кого.* Багалзуурт хутга тави-, лай бол-, буг бол-, бөөн гай дарамт

897. **СТОЯТЬ ПОПЕРЕК ПУТИ (дороги)** *кому* гүйх нохойд гүйхгүй нохой саад хий-, хөшиг бол-, хар хөшиг бол-, зам тагла-, зам хөшилдө-, зам хөндөлдө-.

898. **СТОЯТЬ СТОЛБОМ** [*разг.*] Хөшөө шиг зогсо-, шонгийн мод шиг (зогсо-,) мод шиг гозой-, гүүрийн түмбэ шиг, манаач шиг зогсо-, хилийн овоо шиг.

899. **СТОЯЧЕЕ БОЛОТО** 1. Тогтмол ус 2. Урагш ахихаа байсан (хүн юм), харимал, мохоо болсон, (хүн) больсон аргисан, хөг нь өнгөрсөн

900. **СТРАНЫ СВЕТА** Дөрвөн зүг найман зовхис, зүг бүхнээс, зүг зүг

901. **СТРАСБУРГСКИЙ ПИРОГ** (хээрийн) шувууны хуушуур

902. **СТРАХ ОТШИБ ПАМЯТЬ** Ухаан гартлаа айв, бэгтрээд яг болов, дүйрч хоцров, айж балмагтав.

903. **СТРАХА РАДИ** Айгаад, цочоод, айснаасаа болсод, айн гэлмээд

904. **СТРАХА РАДИ ИУДЕЙСКА** сүрд дарагдсаны учир, хулчийгаад, нирвэгдэж, гэлмэн сүрдээд, сүрдэж балмагтаад, сүрдэж бэргээд, бараанаар нь баас алдаад

905. **СТРЕЛОЧНИК ВИНОВАТ** [*ирон.*] Хүчтэний дэргэд хүчгүй нь буруутан, дийлсэн нь дэлдийснээ, ямаа муудаа, нохой сүүлээ, сүүл хонгорцгоо.

906. СТРЕЛОЧНАЯ ПТИЦА О-45.

907. СТРЕЛЯНЫЙ (старый) ВОРОБЕЙ С-823.

908. **СТРЕЛЯТЬ ГЛАЗАМИ** [*разг.*] Тойруулан хара-, нэг бүрчлэн үзэ-, дээш доош нь, нийш тийш нь хара-, сайтар ажигла-, ширвэн хара-,

909. **СТРЕЛЯТЬ ИЗ ПУШЕК ПО ВОРОБЬЯМ** [*разг., ирон.*] Бөөсөнд хутга гарга-, хуурсанд хутга, хулганад жад, ямаа муудаа, муу эр эмдээ дээрлэхүү, хүч хүрэхгүй юманд эрэлхүү, дээгүүр баривал гар цустах, доогуур баривал гар баастах, юманд эр гарга-,

910. **СТРЕЛЯТЬ ПАЧКАМИ** (буудах, харвах, намнах тэргүүтэнд) саадаг юүлэн харва-, замаг юүлэн шүршин-, угсруулан шүршин-, мөндөр шиг шүршин-, ширүүн мөндөр буулга-,

911. **СТРЕЛЯТЬ ХОЛОСТЫМИ ЗАРЯДАМИ** [*герен., шутл.*] дэмий юм бол-, талаар бол-, хоосон хоцро-, арилсан хорвоо бол-, амаа бари-. хий буудаа-, цаасан цэнэгээр буудаа-

912. **СТРЕМЯ В СТРЕМЯ** Зуузай холбон, дөрөө нийлэн, амгай нийлүүлэн

913. **СТРИЧЬ ВСЕХ ПОД ОДНУ ГРЕБЁНКУ** Нэг саваар савла-(хэмжи-), нэгэн хэвээр үзэх-, мэддэг дангийн жаа шигээ бодо-, өөрийнхөө төөгөөр өргөн дэлхийг төөл-,

Нельзя же стричь всех под одну гребёнку (или же мерить всех на один аршин) Юм бүрийг нэг саваар боллоггүй (юмыг ганц барилаар бүү хэмжээл!)

914. **СТРИЧЬ КУПОНЫ** [*разг.*] Ацгаар амь тэжээ-, түрээсээр амь зуу-, хүүгээр аж төрө-,

915. **СТРИЧЬ ПОД ГРЕБЁНКУ** Богино үстэй, ахар үстэй, түжгэр үстэй, тайранхай үстэй.

916. **СТРОГО ГОВОРЯ** Нарийвчилбал, яг талбаас, нарийн дээрээ очвол

Строго говоря, план ещё не выполнен. Нарийн дээрээ хүрэхэд, хийх юмаа хийгээгүй байна (албаны хэлэнд бол төлөвлөгөөгөө биелүүлээгүй байна).

917. **СТРОГО НАСТРОГО** [*разг.*] Чанд чанга, нарийн чанд, хатуу чанга, хий зайгүй, нарийн нягт, хатуу бат, хатан бат, бат бэх

918. **СТРОИТЬ ВОЗДУШНЫЕ ЗАМКИ**-Хоосон санаа, хий мөрөөдөл, гандирсын балгас босго-,

919. **СТРОИТЬ ГЛАЗКИ** Нүд ирмэ-, сээтэн хая-, сэртэндээ-жоготой хара-, жийвгана-, жаатгана-, нүдээрээ аалигүйтэ-, эннийг харж мишээ-, тэрийг харж инээ-, нүд хая-, нүд орхи-, нүдээрээ дохи-,

920. **СТРОИТЬ ДУРАКА ИЗ** *кого.* (хүнийг) малла-, хуура-, аргачила-. хуурмагла-, талхида-, бачила-,

921. **СТРОИТЬ ИЗ СЕБЯ.** *кого.* Биеэ мэдэхгүй, хирээ мэдэж бяраа танихгүй, сайрха-,гайхуул-,

922. **СТРОИТЬ КОЗНИ** Залхайла- хуйгуур зуйгуур-, явдлыг самууруул-, үймүүлж бусниул-

923. СТРОИТЬ КУРЫ *кому* [*шутл.*] Сээтэн хая-, сэртэндэ-, жоотолзо-, хүүхэн эргүүл-, хүүхэн (авгай хөө-), энэ хэллэг уг нь франц хэлний faire]a cour гэсэн өвөрмөц хэллэгээс гаралтай).

924. СТРОИТЬ НА ПЕСКЕ [*неодобр., книжн.*] Гандирсын балгас цогцоло-, тулгаа үдээрээр жимбийн (ягшгалдайн) тав болов гэгч бол-, эргүүд тус хийх элсэн дээр тос асгах хоёр адил, харганы ноос.

925. СТРОИТЬ РАСЧЁТЫ *на кого-что* горьдон хүлээ-, байцы нь хара-, улы нь шагай-.

Нельзя строить расчёты на ошибку противника. Хүний ул шагайх хэрэггүй.

926. СТРОКА В СТРОКУ буюу СТРОЧКА В СТРОЧКУ (пересказать, списать) (өгүүлэх, бичих, орчуулах тэргүүтэнд) үгчлэн, үг үгээр нь, шат бүрчлэн, нэг ч үг орхилгүй, үг үсэгчлэн, үг дагуулан, үг хөөн

927. СТУДЁНОЕ МОРЕ үгчилбээс: Хөшин хөлдсөн далай утгачилбаас: Хойт мөсөн далай (-ийг хэлдэг үг) хүйтэн тэнгис

928. СТУДЕНЧЕСКАЯ СКАМЬЯ [*перен.*] Оюутан ахуй цаг, оюутан байсан үе, сюутан бүлгээ тэр үе, суралцаж байх үе. Ш-35

929. СТУКНУТЬ В ГОЛОВУ (в башку) В-564

930. СТУПИТЬ НЕ УМЕЕТ Шон хүрэхгүй, дааж холтлохгүй, хага хазахгүй, нохой хорихгүй

931. СТУЧАТЬСЯ В ДВЕРЬ гадаа ирэ-, хаяанд ирэ-, айл буу-, тулаад ирэ-, харигүй бол-.

Уже зима стучится в дверь Өвөл гэдэг айл буучихав аа хөө.

932. СТУЧАТЬСЯ В ОТКРЫТУЮ ДВЕРЬ Л-118

933. СТЫДЛИВЫЙ КУСОК (айлын аяга тавагны ёроолд үлдсэн үлдвэрийг нигэж хэлдэг) үгчилбээс: нүгүүртэй хэсэг (хэрчим, ширхэг, балга) монголсор утгань: айлын таваг (хуурайлдаггүй) хоосолдоггүй гэдэгтэй утга дүйнэ.

934. СУД (да) ДЕЛО [*разг.*] Хэрэг зарга, зарга заалихай бол-, хэрэг нийлэ-, гэдсэндээ хөлөө хийлцэ-, бөөн зарга бол-.

Пока у них суд да дело, пройдёт целый год. Хэрэг зарга бодолцсоор нэгэн жилийн нүүр үзэж байна.

935. СУД ЛИНЧА Зэрлэг цааз, зэрлэгээр яргалах (хэрэгтнийг байцаалгүй шууд алах явдлыг ийн өгүүлнэ).

936. СУДА НЕТ *на кого что* ... буруутгах явдалгүй, ... гэмтэн биш, гэм зэмгүй.

937. СУДА БЛИЗНЕЦЫ Хоршоо онгоц (бөөр нийлэн явж загасчилдаг усан онгоц завь зэргийг ийн нэрлэдэг), зөөг онгоц, хөтөлцөө онгоц, зуузай холбосон онгоц, онь холбосон онгоц, зэл онгоц, жагсаал онгоц, сам онгоц.

938. СУДИ (те) САМ (и) өөрөө сайн бод! бодож үз л дээ! та өөрөө бодож болгоо доо, (юу гэж) санана даа.

Судите сами, как я могу согласиться с этим. Би яагаад тэгье гэснийг та өөрөө бодож болгоо л доо.

939. СУДИТЬ ДА РЯДИТЬ Хэлэлцэ-, маргалда-, тэмцэлдэ-, цэц булаалда-.

940. СУДЫ НА ПЕРЕСУДЫ хов жив, худал цуурхал.

941. СУДЯТ НЕ ПО СЛОВАМ, А ПО ДЕЛАМ Ам хэлээр болох, ажил явдлаар болдог.

942. СУЕТА СУЕТ Барчийж түрчийсэн бүгт бараа төдүй, бүх юм зэрэглээ мэт.

943. СУКИН СЫН *буюу* **СУКИНА ДОЧЬ (СУКИНЫ ДЕТИ)** [*брань*] Нохой толгойлсон, үмхий зулбасга, муу бэлтрэг, муу хар гөлөгний.

944. СУКОННОЕ РЫЛО Наймаачин, худалдаачин, панзчин, их гарын чинзд, панз үсэргээчин, арилжаачин, солио холионы эзэн. сүйхээний эр

945. СУКОННЫЙ ЯЗЫК Модон хэл, түг таг гэсэн хэл, орчуулмал хэл, дультраа хэл.

Доклад написан суконным языком. Модон хэлээр бичсэн илтгэл.

946. СУЛЁНОГО ТРИ ГОДА ЖДУТ Амласан юм аманд ортол, аманд ортол арван даваатай, за за гэсэн хүн хийх нь хол, завар завар гэсэн морь хүрэх нь хол.

947. СУЛИТЬ ЗОЛОТЫЕ ГОРЫ Өгнөө, өгтлөө удна байхаа! тэгнэ, тэгтлээ удна байхаа, тэгдэг ч харин өдүй байхаа! тэгнэ тэгнэ гэсэн хүн үгэндээ хүрдэггүй, дэдэр дэдэр гэсэн морь газартаа хүрдэггүй, санах нь нэрнээр, явах нь сарнаар.

948. СУМА ПЕРЕМЁТНАЯ орж гарсан хүн, уймраа амьтан, дав дув хийсэн хүн, улбарамтгай, хувьсамтгай хүн.

949. СУМАСШЕДИЙ ДОМ [*прост.*] Ж-24.

950. СУНУТЬ НОС (СУНУТЬСЯ С НОСОМ) С-565

951. СУТОЧНАЯ ГОТОВНОСТЬ хоногийн дараа аянд мордох онгоц зэхэ-.

952. СУХОЙ ЗАКОН (Америкийн урьдын архи хорьсон хууль) архины хууль, монголын хууль гурав хоног гэдэг шиг.

953. СУХОЙ РЕМОНТ (усан онгоцны) дотуур засвар.

954. СУХОЙ ТУМАН Манан, будан хүдэл. хуурай будан.

955. СУХО--НАСУХО (вытереть) (Хув хуурай болтол арчи-), аргатал (арчи-), аргуу болго-, чийг болтол, амь чийггүй болтол.

956. СУЧОК В ЧУЖОМ ГЛАЗУ ВИДИТ А В СВОЁМ БРЕВНА НЕ ЗАМЕЧАЕТ. Хүний тотгой дээр байгаа өлөн өвс үзээд өөрийн толгой дээрх тэмээ (өл буга) мэдэхгүй, хүний хир хэмжээ, өөрийн хир түгшээ, хүн гэмээ мэддэггүй тэмээ гэдгээ мэддэггүй, өөрийн гэмийг өлөн тоосны төдийд ч шинжилдэггүй, бусдын гэмийг намар цагийн цогцолсон цагаан үүл мэт олж

хара-, өөрийгөө хэлэхдээ өндгөө дарсан шувуу, хүнийг хэлэхдээ хүрэн эрээн бүргэд.

957. СУШИТЬ ВЁСЛА у г ч и л б э э с: сэлүүрээ сэврээ- у т г а ч и л б а а с: Онгоц завь яваагүй байгаа, морио хэд хазуул, тохмоо сэврээ-.

958. СУШЕЕ НАКАЗАНИЕ [*разг.*] Бөөн ял болж дээ, ял янхнаас доргүй юм болох, хаширмаар юм болгоо.

959. СФЕРА ВЛИЯНИЯ Хараат (орон), эрхшээлийн газар.

960. СХВАТИТЬ БЫКА ЗА РОГА В-576

961. СХВАТИТЬСЯ ЗА БОКА (от смеха) [*прост.*] Инээдээ бара-, элгээ хөштөл инээ-, өнхрөн инээ-, тэчиядгал инээ-.

962. СХВАТИТЬСЯ ЗА УМ гэгээрэ-, соён гий-, ухаан суу-.

963. СХВАТЫВАТЬ (хватать) НА ЛЕТУ (с лёту) сод ухаантай, түргэн ойлгодог, ганц хэлүүлээд л гүйцэ-, барин тавин тусгаж ав-.

964. СХОДИТЬ (сойти) В МОГИЛУ -Талийгаач бол-, нас бара-.

965. СХОДИТЬ (сойти) ЗА ЧИСТУЮ МОНЕТУ үнэмши-.

966. СХОДИТЬ НА НЕТ [*разг.*] **1.** Байхгүй бол-, алга бол-, арила-, үгүй бол-, оргүй бол-, **2.** [*перен.*] Хүчингүй бол-, хэрэггүй бол-, хэнд ч хэрэггүй бол- С-264

967. СХОДИТЬ (сойти) СО СЦЕНЫ Хуучра-, хоцрогдо-, хөг нь өнгөрө-, жагсаалаас гар-.

968. СХОДИТЬ (сойти) С РУК 1. Амь мултра-, амь зулба-, золтой гар-, **2.** Нуруутай өнгөрө-, нэг удаа мэнд гар-, **3.** Худалдагда-, гүй-.

969. СХОДИТЬ С УМА (*по ком по кому -чему*). [*разг.*] Ухаангүй (шохсорхо-,) дурла-, хүсэ-, эрэмцэ-,) их хордо-, амна тавин (дурла-, шохоорхо-.) үхтлээ даса-, салж чадахгүй бол-, өдрийн бодол шөнийн зүүд бол-, тэр зүгийн тэнгэр нь хүртэл сайхан гэгч бол-, нойр хоолоо марта-, юугаа ч хайрлахгүй бол-.

970. СЦИЛЛА И ХАРИБДА (Эртний грек домгоос гаралтай зүйл) [*перен.*] хоёр аюулын дунд, хоёр нохойн хооронд, хасар басар хоёр нохойн дунд, бэрс арслан хоёрын хооронд, давч газар дайсантай уулза-, дээш харах тэнгэр хол, доош хэлэх газар хатуу, алх дөшний хоронд.

971. СЧАСТЛИВ ТВОЙ БОГ! [*разг.*] Чи их азтай байна, аз чинь гозойжээ, тэнгэртэй байна, одтой байнаа, морьтой байна, өнгөтэй байна.

972. СЧАСТЛИВО ОСТАВАТЬСЯ Сайн сууж (сууцгааж) байгаарай Сайн морилж (морилцгоож) байгаарай! Сайн сууж байгтун! Сайн морилогтун! Мэнд сайхан цайгаа чанаад тавьж байя!

973. СЧАСТЛИВО ОТДЕЛАТЬСЯ *от кого-чего.* золоор гар (мултра-), аз болж сала-, өлзий заяагаар. . . аас мултра-,

974. СЧАСТЛИВОГО ПУТИ Аян замдаа сайн яваарай. (хүндэтгэл нь) замдаа тавтай морилоорой (морилогтун!, сааталгүй сайн морилоорой, сүү өргөх, алган шар зам чинь өлзийтэй бол! саадгүй сайн яваарай!).

975. СЧАСТЛИВЫЕ ЧАСОВ НЕ НАБЛЮДАЮТ Жаргалын цаг өнгөрч цөхдөггүй, зовлонгийн гол тасарч өгдөггүй. Зовлон жаргал хоёр, хүсэл хясал хоёр.

976. СЧАСТЬЕ МОЁ (твоё, его и т п) Миний (чиний түүний гэх мэт) аз болж, заяагаар,

977. СЧЁТУ НЕТ *кому чему* . . . тоогүй, тоо алдсан . . . тийм ийм юмандаа дарагдсан

У него счёту нет книгам. Номондоо дарагдсан хүн

978. СЧИТАННЫЕ ДНИ Мөдхөн, хэдхэн хоноод, өнөө маргаашгүй

979. СЧИТАТЬ ВОРОН (галок) 1. Алмайран суу-, гүндүү толгойл, **2.** Зугаа цэнгэл хөөцөлдө-,

980. СЧИТАТЬ ЗВЁЗДЫ (мух) [*разг.*] Хийх юмаа олж яда-, үсээ тоол-, загатнаагүй газраа маажи-, цаг нөгцөө-, зүгээр суу-, элгээ эвхэн суу-, гар хумхиж суу-, тэмээ хариулах гэгч,

981. СЪЕЗДИТЬ В РИГУ [*вульг*] (архинд) шартаж бөөлжи-, уусан идсэнээ шингээхгүй пологто-, түргэн дууддагүй түмбэн дууддаг өвчин туса-

982. СЪЕСТЬ ГРИБ (шиш и. т. п) Гаца-, мухарда-, таг суу-, ягта-,

983. СЪЕСТЬ СОЛИ ПУД Хашир суу-, их ултай буурьтай бол-, хэрсүүжи-, суурь суу-,

984. СЫГРАТЬ В ДОСКУ [*вульг.*] Мажий-, авдарлуул-, авсандаа оро-,

985. СЫГРАТЬ В ЯШИК [*вульг.*] Үхэ-, авдарлуул-, хайрцагтаа оро-,

986. СЫГРАТЬ НА РУКУ И-101

987. СЫГРАТЬ ШУТКУ (штуку) *с кем-чем* Тоглоом хий-, тоглоом тохуу болго-, хошигно-, хошигнуул-,

988. СЫПАТЬ ДЕНЬГАМИ [*разг.*] Мөнгийг гамгүй (ус цас шиг, барин тавин) үрэ-, үрэн таран хий-, мөнгөөр гараа угаа-, мөнгөөр туйл

989. СЫР БОР ЗАГОРЕЛСЯ 1. Хэрэг манда-, хэрэг гарга-, **2.** Хөл хөөрцөг бол-

990. СЫРАЯ ЖЕНЩИНА Сул эхнэр, гоож эхнэр, ганц бие хүүхэн, дэл сул хүүхэн, сул бие сунхсан, ганц бие ганхсан, нөхөрт (эрд, хүнд) гараагүй, очоогүй, (богтлуулаагүй) хүүхэн

991. СЫРАЯ ЗЕМЛЯ Газар шороо, газар, алаг дэлхий,

992. СЫРНАЯ НЕДЕЛЯ Эртний слав нар өвлийг үдэж хийдэг баяр Манай цагаан сарархуу аж

993. СЫТ ТО ПО ГОРЛО-Сэтгэл хангалуун, тав нь ханасан

994. СЫТОЕ БРЮХО К УЧЕНИЮ ГЛУХО Эрх жаргалын үрэнд эрдэм тогтдоггүй, эгц уулын оройд ус тогтдоггүй.

995. СЫТЫЙ ГОЛОДНОГО НЕ ПОНИМАЕТ (не разумеет) үгчилбээс: Цатгалан нь өлсгөлөнгийнхөө зовлонг мэддэггүй. утгачилбаас: Баян нь хоосныхсо зовлонг мэддэггүй, могой нь явганыхаа зовлонг мэддэггүй. Ухна ишигний зовлонг мэддэггүй, баян хүн бачтай, хоосон хүн хочтой, өвдөөгүй хүн ёолдоггүй, өлсөөгүй хүн уйлдаггүй, өлсөхийн эрхэнд хуялгайч, өсөхийн эрхэнд хэрүүлч.

996. СЯДЕМ РЯДКОМ ДА ПОГОВОРИЛИ ЛАДКОМ өвдөг зэрэгцэн сууж өр зүрхнийхээ үгийг ярилцъя. Нэгэн аяганаас ууж нэгэн бодлоо зөвшилцөе.

Т

1. **ТАИТЬ В ГРУДЫ** Цөөжиндээ хадгала-, дотроо бодо-, дотроо шингээ-, (гаҥц) өөртөө шингээ-, таг дара-, нууж хаа-, хав дара-, ганц (биеэрээ)-аараа дуус-, нуусандаа нуу-, ам ангайхгүй үг цухайлгахгүй, хар толгойгоорсо дуус-, хэнд ч шивхийхгүй-амаа хавчи-, амаа хамхи-, амаа үдэ-,
2. **ТАЙТЬ В СЕБЕ** *что* 1. Дотроо бодо-, 2. Авч бай-; дарж бай-
3. **ТАК БЫ** [*разг.*] (тэгчих) юмсан; тэгэх минь яваа (яалаа), (тэгдэг) л байж; тэгдэггүй яалаа,
   Так бы и уехал Яваад өгдөг л байж
4. **ТАК В ТАК** [*прост.*] Яг л тийм (ийм); эгээ адил; очоод нэг, аргагүй л тийм тийм нь ч тийм шүү.
5. **ТАК ВООБЩЕ** [*разг.*] Зүгээр, тийм ийм ч гэсэн юмгүй, санасан бодсон ч юмгүй; яалаа ч гэсэн юмгүй, ер нь л, ерөөсөө л, аяндаа л, харин л дээ, хай л даа, үгүй харин.
   Почему ты вдруг в спомнил об этом?-Так, Вообще Чиний сананд яагаад гэв гэнэтхэн ийм юм бодогдов?-Яалаа ч гэсэн юмгүй (Үүнийг чи яаж саначихав аа?-Тэглээ ч гэсэн юмгүй)
6. **ТАК ВОТ** За тэгээд; чингэснээ; ингээд
   Так вот, слушайте, что дальше произошло За тэгээд юу болов оо гэхээр, (чи) айн гээд уун гэж бай! (Тэгээд цаашдаа юу болсны нь чагна л даа)
7. **ТАК ЖЕ . . . КАК (и)** . . .-тай адил, . . , шиг, . . . мэт, лугаа адил, . . . л гэсэн үг,
8. **ТАК И** Тэгээд; чингээд; тэгэсхийснээ л; юу юугүй; тэр чингээрээ; харъяандаа; . . . нь тэр (үү); . . . шүү дээ; ердөө л
   Дождь так и льёт Тэгээд л бороо цутгав (Бороо асгасан хэвээрээ л).
   Глаза и так закрываются Нүд юу юугүй анилдав (нүд анилдсаар л).
   Я так и сделал Би ингэж л хийсэн (Би ч бас тэгж л хийсэн шүү дээ).

9. **ТАК И БЫТЬ** [*разг.*] Тэгвэл тэгье; за ингэж тогтъё! Таны тааллаар болъё. Ёсоор гүйцэтгэе.
10. **ТАК И ЕСТЬ** Үнэхээр (үнээр, нээрэн) тийм (ийм); яг л энэ; за тэр; яг, харин тийм; тэгээд яагаав; тийм л дээ.
11. **ТАК И ЗНАЙ (-те)** [*разг.*] За чи сайхан мэдээрэй! Чи мартав аа! (Чи үүнийг л) хичээнэ шүү; мэдэв үү.
12. **ТАК И НАДО** кому-чему [*разг.*] Хохь (чинь) болж! Хохь нь болоод нэрнэй! Болж хуна; жорлой.
    Так ему и надо-сам виноват Хохь нь, өөрийн нь буруу!
13. **(и) ТАК И СЯК** [*разг.*] 1. Элдвээр; элдэвчлэн; зүйл зүйлээ эр. 2. Хамаа намаагүй; хамаагүй; дайралдсанаар нь ингэс тэнгэс хийгээд; тэгсэн болоод; тэгсэн нэр хэмээгээд, домноод, оромдоод, додомдоод. И-53 Т-115
14. **(И) ТАК И ТАК** [*разг.*] Зүйл зүйлээр; ингэж ч бас ингэж, ингэж чингэж; ийш нь тийш нь.
15. **ТАК И ТАК (мол дескать)** [*разг.*] Тэгж байгаа бол; тийм бол, ингэж байхул.
16. **(и) ТАК И ЭТАК** элдвээр, элдэв зүйлээр, ингэж чингэж тэгж нэг, ингэж нэг, тэгж ч ингэж ч
17. **ТАК ИЛИ ИНАЧЕ** [*разг.*] Ямар ч байсан (гэсэн); юу ч атугай тэртэй тэргүй; алин ч болтугай
    Так или иначе я приду. Тэртэй тэргүй би мэдэх юм чинь!
18. **ТАК КАК** . . . учир; тул; . . . аваад[4] . . . аас[4], . . . ны улмаас . . . сан[4] дээрээс, . . . аар[4] нь.
    Не могу прийти, так как я занят. Би ажил ихтэй нрж чадахгүй
    Так как было уже поздно, я остался в городе ночевать. Орой болчихоод би хотдоо хоноҳоор хоцров.
19. **ТАК ЛИ?** ийм (тийм) гэж үү? Үнэн үү? Нээрэн үү? Юу гэнээ?
20. **ТАК ЛИ, СЯК ЛИ (так ли, этак ли)** тэгж ч ингэж ч, ингэж ч, чингэж ч, ингэн чингэн, (ийм) тиймээр
21. **ТАК НА ТАК (менять)** [*прост.*] нэг нэгээр нь солих, ингээд ингээд солих; хооронд нь солих
22. **ТАК НАЗЫВАЕМЫЙ** гэгч; хэмээгч; гэдэг; гэгддэг; гэсэн
23. **ТАК НЕТ** [*разг.*] харин . . . тэгэхгүй; . . . тэгэх байтал; . . . тал . . . харин . . . ын оронд харин, . . . маар байхад харин.
    Сидеть бы ему дома, так нет, пошёл гулять. Гэртээ байх учиртай байтал, зугаалаад явчихав (Гэртээ л суух байхгүй гараад арилдаг байна шүү).
24. **ТАК ОНО И ЕСТЬ** [*разг.*] үнэхээр (тийм) ийм; нээрэн тийм. ийм л байна; яг байна, мөн дөө, дүрээрээ дээ.
25. **ТАК ПОВЕЛОСЬ** ингээд (чингээд) сурчихжээ; бүр дасчихжээ занлчихсан байна.

26. ТАК СЕБЕ [*разг.*] 1. За яахав дээ; гайгүй дээ; мөртөө нэг хир тааруу; сайн ч үгүй, муу ч үгүй; тааруу нэг. 2. Зүгээр л; яалаа ч гэсэн юмгүй . . . хад яадаг юм.

Хороший фильм?- Так себеЗүгээр кино юм уу?- Тааруу нэг

Зачем ты это сделал?-Так себе Яах гэж ингэсэн юм бэ? яалаа ч гэсэн юмгүй,

27. ТАК СКАЗАТЬ . . . гэлтэй, . . . ж болох юм, үгүй ер нь, ер нь, . . . гэх юмуудаа, тэгээд

28. ТАК-ТО (оно) ТАК зөв нь зөв, үгүй тэгээд, тийм нь ч тийм, мөн нь ч яах аргагүй мөн . . . , тэгтлээ нэг . . . ,

29. ТАК ТОЛЬКО [*разг.*] Зүгээр л; . . . тэгэх гэж л.

Это он говорит только так для красного словца! Сүрхий үг хэлдэг хүн болох гэж л ингэж хэлсэн хэрэг (Цэцэн хүн болох гэж . . .)

30. ТАК ТОЧНО чухам чухам, яг, эй дээ, уухайс мөн хөө, дүрээрээ, болж байна да, ёсоороо

31. ТАК ЧТО Учир (нь); иймээс; юу гэвэл, иймийн тул л; ингэхлээр; ийм тул, иймийн учир, учир иймээс, ингээд л, ингэснээс, . . . сан дээрээс, . . . сан улмаас.

32. ТАК ЧТО НЕБУ ЖАРКО СТАНЕТ (будет) [*разг.*] Сайхан мэдээрэй! мартав аа! Хэцүү шүү! яггүй дээ!

33. ТАКИМ ОБРАЗОМ Ингэж; тэгж; ийн; тийн; ийнхүү; тийнхүү; энэ мэтээр; үүнчлэн; түүнчлэн; чингэж; үүн шиг; энүүн шиг иймэрхүү; тиймэрхүү; үүнэрхүү түүнлэхүү, энэрхүү ;

34. ТАКОВО ПОЛОЖЕНИЕ ВЕЩЕЙ байдал ийм (тийм), байр байц нь иймэрхүү, янз байдал нь ийм шиг, байдал төрх нь тиймцэр, иймэрхүү намжиртай.

35. ТАКОГО РОДА [*разг.*] ийм; тийм; иймэрхүү; тиймцэр энэрхүү, энүүн шиг, үүний адил, ингэсэн шиг.

36. ТАКОЕ ДЕЛО [*прост.*] иймэрхүү; иймэрхүү юм; ийм юм болсон юм (Орос хэлнээ энэ хэллэгийг ихэвчлэн хэлэх гол юмныхаа эхэнд хэрэглэдэг бол, монгол хэлэнд ийм санаагаа сүүлд нь хэлж төгсгөдөг өгүүлбэр зүйн жам байнам)

37. ТАКОЙ ЖЕ . . . КАК . . . шиг; . . .-тай адил; . . . рхүү (рхүү) . . . лугаа (лүгээ) ижил

38. ТАКОЙ, КАКОЙ ЕСТЬ Ингэе дээ; тэгэе дээ; за тэгэе

39. ТАКОЙ-СЯКОЙ (-ая, -ое) [*разг, фам.*] (тоглоомоор хараасан шиг хэлэхэд хэрэглэдэг үг) ийм дүүрсэн! нэвт оргисон! гайтай гайхал!

40. ТАКОЙ-СЯКОЙ НЕМАЗАНЫЙ [*разг, ирон, шутл.*] шал дэмий; өөдгүй; олигшийн

41. ТАК-ТО ТАК [*разг.*] Зүгээр нь зүгээр; яахав нь яахав . . . овоо нь овоо, гэхдээ . . . Тийм нь ч тийм л дээ, хэдүйгээр тийм ч,

Так-то так но, все-таки я не могу с вами согласиться Зүгээр нь зүгээр л юм, тэгэвч би нэг за хүлээж болохгүй л байна. Хэдүй тийм ч би л за гэшгүй.

42. ТАЛИЯ РЮМКОЙ (в рюмку) [*разг, шутл.*] шоргоолжин бэлхүүстэй; нарийхан бэлхүүстэй; бэлхүүс нарийн, бүсэлхий нарийн, тасам шиг.

43. ТАМ ВИДНО БУДЕТ Цаг нь болог дээ, харж л байя даа, аяндаа мэдэгдэнэ дээ гайгүй, харж л байя, азнасхийж бай, байж байтал. Т-120

44. ТАМ И СЯМ (тут) энд тэндгүй; газар сайгүй, газар болгонд; хаа хаагүй, хаяагүй

45. ТАМ И ТУТ энд тэндгүй, газар сайгүй, захаас авам замаар үргэлж, хаа хаагүй, хөлд ороолдохоор

46. ТАМ МУХИ ДОХНУТ [*разг.*] (тэнд) уйдаж үхмээр; амьд амьтан тогтмооргүй,

47. ТАНТАЛОВЫ МУКИ М-204.

48. ТАНЦЕВАТЬ ОТ ПЕЧКИ [*разг, ирон.*] эхнээс нь дахи-, бүр эхнээс нь дахин хий-

Говорите прямо о теперешнем положений дела. не надо танцевать от печки Одоогийн байдлыг л ярьдаа, эхнээс нь дахиад яах вэ! Дахилтгүй.

49. ТАРАБАРСКАЯ ГРАМОТА (перш, разг) Учир нь олдохгүй юм; тийм гэх тэмдэггүй юм; тэр гэхийн тэмдэггүй юм.

50. ТАРЫ-БАРЫ, КРАСНЫЕ ТОВАРЫ (шутл) Дэмий чалчаа; энэ тэр элдэв бусангийн юм бурах; амаа урах шахах, далан хэлээ дэлгэх

51. ТАСКАТЬ (доставать) КАШТАНЫ ИЗ ОГНЯ для кого хүний гараар могой бариул-

52. ТАШИТЬ (тянуть) ЗА УШИ 1. чихнээс нь чангааж байж (юм хийлгэ-), чихэнд нь хонх уя-, чихий нь мушгиж тэгүүл (ингүүл-), хойноос нь түлхэж урдаас нь чангааж 2. Сүүлий нь мушгиж, албан хар хүчээр, хар баагаар,

53. ТАЩИТЬ (тянуть) НА АРКАНЕ [*разг.*] татлаа түлхлээ бол-, салж (хаганаж) өгөхгүй; чирээд болж өгөхгүй.

54. ТАЩИТЬСЯ В ХВОСТЕ сүүл даран хөө- сүүдэр шиг дага-, 2. Баас түү-; хомоол хама-

55. ТАЯТЬ, КАК ВОСК Шөнө хоногоор доройто-, (тура-, мууда-), дордоод л бай-

56. ТВОРИТЬ СЕБЕ КУМИР (кумира) *из кого-чего* (Хүн бүю юмыг) онгон шүтээн шигээ тахи-; баастай бурхан болго-, оройн чимэгт ав-· шүтээнийхээ орон болго ганц хайртай юмаа болго-; онголо-, [*ирон.*] Бурхан дээрээ тавь-чих шаха-; сэтэрлэ-, амь шигээ үзэ-, амьтайгаа чацуула-, амин хайртай.

57. ТВОЯ (его и т. п) ДОБРАЯ ВОЛЯ таны тааллаар болъё. Таны таалал мэдэг, таны болгоосн оор

58. **ТЕБЯ ПРОСЯТ ЧЕСТЬЮ** В-476

59. **ТЕКУЩИЙ СЧЁТ** харилцах данс

60. **ТЕЛЕГРАММА-МОЛНИЯ** Яаралтай цахилгаан утас

61. **ТЕЛЯЧИЙ ВОСТОРГ** [*шутл.*] хүүхэд дэгэж дэрвэх; хүүхэд хөл хөөрцөг болох; дэвхцэж цовхчих, дэгдэн харайх

62. **ТЕЛЯЧЬИ НЕЖНОСТИ** [*ирон.*] нялуун найлангай; янаг ихдвэл тэнэг ихдэнэ гэгч; энхрий дэвээ хатсан.

63. **ТЕМ БОЛЕЕ** тэр дундаа даан ялангуяа; тэгэх **тусмаа тэгвэл** ч бүр, тэгвэл л ганц.

64. **ТЕМ ВРЕМЕНЕМ** Тэр цагт; тэр үес

65. **ТЕМ НЕ МЕНЕЕ** . . . аар үл барам, бас . . .; . . . **аар зогсохгүй** тэр байтугай; . . . (тэр) энүүхэнд . . . наад захын хэрэг, бас . . .
Он настойчиво возражал, но согласиться с ним я, тем не менее, не мог цаатахи чинь тас зөрөөд би яаж ч чадсангүй

66. **ТЕМ ПАЧЕ** тэгэх тусмаа; ялангуяа сиц, тун . . . аас цааш, . . . ны хэрэг юу билээ, . . . **нийх**, . . . сан **болохоор**, . . . аас хойш, . . . сан л (юм) бол.
Раз так, тем паче требуется осторожность Нэгэнт тийм бол, тун болгсомжтой баймаар юм байна даа.

67. **ТЕМА С ВАРИАЦИЯМИ** [*перен.*] Хувилбарт сэдэв.

68. **ТЕМНА ВОДА ВО ОБЛАЦЕХ** [*шутл.*] учир нь олдохгүй юм; хөндүүр нь гараагүй хэрэг; битүү хатуу юм; бүрэг бараг юм; жоготой юм; маапаантай хэрэг; будлиантай юм,

69. **ТЁМНАЯ ЛОШАДКА** С-790

70. **ТЁМНОЕ ПЯТНО** [*разг.*] 1. Хар толбо, бараан толбо, 2. Гэм муу явдал; алдаа согог; ео нь.
Это-тёмное пятно в его жизни Насандаа **хийсэн гэм** нь энэ дээ. Энэ насандаа нигэж нэг алдсан.

71. **ТЁМНЫЙ (дремучий) ЛЕС** *для кого* үзэггүй, А-ч үгүй, чихраа ч дуулаагүй, (. . . над, тэр хүнд) хөлдүү хонины толгой, холтлохгүй, дүн пад, нохой хорихгүй,

72. **ТЕМНЫМ-ТЕМНО** [*разг.*] Хэв харанхуй; дүн харанхуй; чив харанхуй; гүн харанхуй, хойшоо харсан нүх шиг, хоньгүй хот шиг, шөнийн айлын өтөг (бууц) шиг

73. **ТЁПЛАЯ КОМПАНИЯ** [*разг.*] 1. [*шутл.*] Халуун хань, шадар нөхөр, нөхөр сүүдэр, хань хамсаатан, дотуур нөхөд, нэг амьсгаатан; буцвал тогоо нэгтэн булгивал даага нэгтэн, халуун анд; нэг тэрэгний хоёр арал, дотны нөхөр, ходий, амь хүн, сайн нөхөр, баруун гар, сэтгэл (санаа) нийлсэн нөхөр, анд, ижий ахай, чиний минийгүй, үнэнч нөхөр, итгэлтэй хүн, бие битэр (мэтэр) хүн, ганзага нийлсэн, гар санаа нийлдэг хүн, дуугарвал дуу нэг, дугтарвал хүч нэг.

74. **ТЕПЛИЧНЫЙ ЦВЕТОК ТЕПЛИЧНОЕ РАСТЕНИЕ** [*перен.*] эрх танхи хүн; зовлон үзээгүй хүн; халуунд халж үзээгүй хүйтэнд хөрч үзээгүй хүн; өөхөнд хучсан бөөр шиг; эрх агь, ширүүхэн

үг ч дуулж үзээгүй, салхинар самнаж, бороогоор угаадаг, дархан тавьж догшин харавсан, сэтэртэй морь шиг, онгон шүтээн шиг, хүн харахад л хүн, ажлын зүг мэдэхгүй, ажлын дөр мэдэхгүй.

75. **ТЁПЛОЕ ГНЕЗДЫШКО** [*разг.*] 1. Халуун ам (бүл); элэг бө; лөг, халуун элгээрээ; 2. (суух нутаглахад) тавтай газар оронөлзийгөө өгсөн газар; идээшсэн нутаг; эх болсон нутаг.

76. **ТЁПЛОЕ (тёпленькое) МЕСТЕЧКО (место)** [*ирон.*] аятай газар; олзвортой тушаал (уг нь дээр цагт хээл хахууль авах боломжтой албан тушаал гэдгээс гарсан үг)

77. **ТЕРНИСТЫ ПУТИ СОВЕРШЕНСТВА** Сайн юманд саад их; зовж байж зорьсондоо хүрдэг, сайн юманд садаа мундахгүй, сайн юм бүтэхдээ ужиг, аманд ортол арван даваа гэгчээр.

78. **ТЕРНИСТЫЙ ПУТЬ** [*перен, книжн.*] бартаатай зам; муриг сориг ихтэй зам; адруу дудруутай; энхэл тонхол ихтэй, онхол цонхолтой зам.

79. **ТЕРНОВЫЙ ВЕНЕЦ** цаазын титэм; зовлонгийн (алх) тэмдэг.

80. **ТЕРПЕНИЕ И ТРУД ВСЁ ПЕРЕТРУТ** Хатуужил хичээнгүй хоёр хамгийг бүтээж өгдөг. Эр хүн зоригтой бол чоно чацга алдана, Хийвэл бүү ай! Явсан нохой яс зуудаг. Хичээл зүтгэл хоёр байвал юуг ч бүтээнэ. Уйгагүй хүн уул нүхлэнэ.

81. **ТЕРПЕНИЕ ЛОПНУЛО** [*разг.*] тэснэ, тэснэ гэхэд яаж нигэж тэсэх вэ, тэсээд тэсээд хир болсоо.

82. **ТЕРПЕТЬ НЕ МОЧЬ кого—чего** [*разг.*] тэснэ тэснэ гэхэд яаж тэсэх вэ, тэсэхийн аргагүй; тэсэж чадахгүй; хүлцэнгүй. дургүй; зэвүүрхдэг, зүгээр өнгөрөөхгүй, өнгөрөөхийн аргагүй;
Терпеть не могу, когда мешают работать. Хүн юм хийлгэхгүй байхад би яаж тэсэх вэ!
Она его совсем терпеть не могла. Хүлцэж огт чадахгүй болов (Эм нь эрийгээ зүгээр ер өнгөрөөдөггүй).

83. **ТЕРПИ, КАЗАК, АТАМАНОМ БУДЕШЬ** тэссэн хүн чаддаг, тэссэн хүн ялдаг; тэсвэр бий бол дуусвар бий; зориг байвал хэрэг бүтнэ, зүдэл байвал жаргал ирнэ, юу сайхан зориг сайхан; дэлдэхээр сүүлд, дуугүй байснаар бүтэж үхдэггүй, идсэн эрүү хувхайрдаг, идүүлсэн бут ногоордогийг бод.

84. **ТЁРТЫЙ КАЛАЧ** (*ирон*) 1. хал үзэж халуун чулуу долоосон хүн, үхэхээс бусдыг үзсэн хүн; олон юм үзээд оготныи нүхээр орох гарахтай болсон хүн. 2. (Нэгэн зүйл) цагаан талх, дол цохьсон хүн, оймс (олныг) элээсэн хүн, юм үзэж нүд тайлсан хүн,

85. **ТЕРЯТЬ (потерять) ГОЛОВУ** хий тэвдэ-; уйман айман; хармас чармас бол-; алдах, барьц алда-; хөл алда-; аага-; уймра-

86. **ТЕРЯТЬ ГОЛОС** П-864.

87. **ТЕРЯТЬ (ся) (потерять) ИЗ ВИДУ (вида) кого—что** 1. Уулзахаа бай-, дайралдахгүй бол-; хэл үггүй бол-. 2. Бодохгүй бол-; санаанд орохгүй бол-, сураг тасра-. П-865

Нам не надо терять друг друга из виду. Хэн хэндээ хэл үггүй болчихож болохгүй шүү.

89. **ТЕРЯТЬ (потерять) ПОЧВУ (землю) ИЗ—ПОД—НОГ** цохрөнгөө бара-, ул суурьгүй бол-, газраа хөндийлүүл-, явгара-, горидло тасра-

90. **ТЕРЯТЬ (потерять) РАССУДОК** ухааны эмгэгтэй бол-, орж гардаг бол-, голын хийтэй бол-, солиотой бол-, ухаан солироро-,

91. **ТЕРЯТЬ (потерять) (счет кому-чему)** Тоо томшгүй; тоолж барашгүй, цаглашгүй; яндашгүй, үлишгүй

92. **ТЕРЯТЬ УМ** [*разг.*] Т-85.

93. **ТЕРЯТЬСЯ В ДОГАДКАХ (в предположениях)** Тааж мэдэхгүй; тэр гэж хэлж чадахгүй; тийм гэх тэмдэггүй; тэр гэхийн найгүй

94. **ТЕРЯТЬСЯ В МЫСЛЯХ** ухаанаа олохгүй бай-, яахаа мэдэхгүй бай-.

95. **ТЕРЯТЬСЯ ИЗ ВИДА** алга бол-, үзэгдэхээ бай-, бараагүй бол; бараа тасар

96. **ТЕХ ЖЕ ЩЕЙ, ДА ПОЖИЖЕ ВЛЕЙ** Улигт л, улам ч дордсон юм уу, адилдаа адил, годилдоо годил.

97. **ТИПУН (тебе, ему, ей, вам, им) НА ЯЗЫК** *кому* [*разг.*] [*неодобр. шутл.*] аман дээр яр гармар; хар хэлтэй амьтан бэ муу амтай; амнаасаа болсон-.

98. **ТИХАЯ ПРИСТАНЬ** М-139.

99. **ТИХИЙ АНГЕЛ ПРОЛЕТЕЛ** Нам болов, чимээ намжив, амьсгаа дарцгаав, нам гүм болов; анир чимээгүй болов,

100. **ТИХОЙ САПОЙ** далдуур; сэм сэм, эчнээ; чимээ имээгүй, дуугүй байж байгаад,

Действовать тихой сапой Далдуур хорло-; дуугүй зуу-

101. **ТИШЕ ВОДЫ НИЖЕ ТРАВЫ** Хонь шиг хүн; нуур намаг шиг хүн; гэм халгүй амьтан, немхон тэмээг ноолоход сайхан гэгч хүн. Хал балгүй амьтан; төв даруу, мөрөөрөө амьтан, замаараа амьтан, хэвтээ хонь босгодоггүй хүн, бурхан шиг амьтан.

102. **ТИШКОМ ДА ЛАДКОМ** Намуухан аялаг ярна хөрөөтэй, түвшин төвхөн яриатай; дөлгөөн найрамдуу номгохон (номхон), нийцтэй; нуруутай хүн

103. **ТИШЬ ДА ГЛАДЬ (да божья благодать)** амар жимэр (аж төрө-); ам жим ажин түжин, амар сайхандаа жарга-, гар газар хөл хөсөр жарга-

104. **ТКНУТЬ НОСОМ кого-что** ео что (хүнд) зүг чиг заа-; хүнийг удирда (хөтлө-) зам заа-. Т-215

105. **ТО БИШЬ** Өө биш; үгүй бишээ.

Этот американец, то бишь, англичанин . . .
Энэ америк хүн, үгүй бишээ, англи хүн . . .

106. **ТО ГУСТО, ТО ПУСТО** Олондоо олон, неендөө неен, ихдээ их, багадаа бага, байхтай байхгүйтэй, байх нэг өдөр байхад байхгүй нэг өдөр байх жишээтэй. Р-80

107. **ТО ДА СЕ (и то и се, то и се, то-се)** юу хээ хамаагүй, элдэв дээдийн, есөн жорийн юм (ярих, хүүрнэх), хавь ойрын юм хамаж (ярих)

108. **ТО ЕСТЬ** өөрөөр хэлбэл; юу гэсэн үг вэ гэвэл, юу юм бэ гэвэл, юу гэх гээд байна вэ гэвэл, ухаандаа.

109. **ТО И ДЕЛО** цаг ямагт; үргэлжид; дандаа, хэзээд, хэзээ ямагт, үүрд, хэзээ цагт, цагийн цагт, дөрвөн цагийн эргэлтэнд, хэзээ ч, хэзээд, хэдүйд ч, хэзээ болович, хэзээд л, эгнэгт, тасалдахгүй, ашид, мөнхөд, үүрд, шувт (ан) . . ийн турш, (. . .) тойрон, . . . ийн туж, бүх л цагт, . . . аас аваад . . . . хүртэл (болтол) завсар сөгөөгүй, завсар сэггүй, завсар чөлөөгүй зай завсаргүй, завсар зайгүй, сэхээ сэтгээгүй.

110. **ТО И ЗНАЙ** [*разг.*] ямагт, дандаа хэзээ цагт, цаг үргэлж

111. **ТОГО И ЖДИ (гляди)** Харахгүй юү тэр, хэлээд байхад, одоо үзэх нь энэ дээ, тэгж л таарна.

112. **ТО ЛИ ДЕЛО** 1. Хамаагүй дээр; ганц болох нь (тэр); ?. шал өөр; гойд өөр; бүр анги, нэг л ондоо, болох нь яанаа . . . . болоосой, бол ч мөн . . . .

Как здесь жарко, то ли дело в лесу! Энд их халуун байна, модонд бол ганц сайхан даа (энд ямар халуун юм бэ, модон дунд болоосой, энд мөн халуун аа, ойд болхуна).

113. **ТО ЛИ . . . ТО ЛИ . . .** Н-916.

114. **ТО СЁ (того, сего и. т. п) ТО ДА СЁ (того да сего)** Энэ тэр, өнөөх, нөгөөх, яагаав нөгөөх, түрүү хэлдэг тэр

115. **ТО ТАК, ТО СЯК** Т-13.

116. **ТО ТАМ, ТО СЯМ** энд тэнд, энд тэндээс, газар газраас

117. **ТО ТАМ, ТО ТУТ** Т-116.

118. **ТОВАР ЛИЦОМ ПОКАЗАТЬ** П-634.

119. **ТОВАР ЧОХОМ, А ДЕНЕЖКИ СЧЁТОМ** эдийг сайн үзэж ав; мөнгийг сайн тоолж ав.

120. **ТОГДА БУДЕТ ВИДНО** Т-43.

121. **ТОГДА КАК** . . . болович; хэдийвэр; тэгэвч; . . . ч гэсэн . . . ч болович,

122. **ТОГО И ГЛЯДИ СМОТРИ** Сайн харж байгаарай . . . мэдээтэй байхгүй бол . . . тун хянуур байхгүй бол . . . ; бодолтой л байхгүй бол горьгүй шүү, яггүй шүү, амаргүй шүү,

123. **ТОГО И ЖДИ** [*разг.*] Т-122.

124. **ТОЛКАЧ ТОЛКАЧОМ** эргүү хүн, эргүү гэмээ эргүү, шал маанаг, зүүлэгэрсэн,

125. **ТОЛКУЧИЙ РЫНОК** хуучин (юмны) зах

126. **ТОЛОЧЬ ВОДУ В СТУПЕ** Ёроолгүй хувингаар ус бари-; цоорхой хөнөгөөр ус зөө-; хий цаг үрэх, хайран цагаа гарлагада-, тарвага түүсэн хүн хар гөрөөс гэгчээр,

127. **ТОЛСТАЯ (тугая) МОЩНА** *у кого.* бэлтэй (хүн), хур баян, нидрэгтэй баян, мөнгөөр баах нь шахсан, газар хагарам баян, дэлхий бүрхсэн баян, Т-437

128. **ТОЛСТЫЙ (тугой) КАРМАН** [*разг.*] 1. мөнгө ихтэй; хур бэл сайтай; багташгүй баян: хуртай баян; хотойхгүй баян, сан нь багтаж ядсан, буянаараа булгай, юм нь амаараа гаран, дундрашгүй баян, замгүй баян, зартай баян, нэртэй баян, цуутай баян,

129. **ТОЛЬКО В ОДНОМ ОТНОШЕНИИ** нэгэн талаар; нэг зүйлээр дангаар; нэг л юмаар

130. **ТОЛЬКО ВСЕГО** байгаа нь, буй нь хуугаараа

131. **ТОЛЬКО ДЕРЖИСЬ** [*разг.*] 1. Тэснэ шүү; тэснэ дээ хөө; тэсээд байгаарай. 2. Пянгий нь даавал; (тэгэх, ингэх) нь л халаг.

132. **ТОЛЬКО И ВИДЕЛИ** үзэгдээд л алга болсон, бараа нь харагдаад л байдаггүй

133. **ТОЛЬКО И ВСЕГО** ингээд л энэ; тэгээд л болох нь тэр; уртаашаа л ...; ердөө л; яг л, илүү дутуугүй, цаанадаж, цаана хэлж, ихдээ л.

Я задержу вас на пять минут, только и всего. Би таныг тавхан минут л саатуулах байх тэгээд л болох нь тэр.

134. **ТОЛЬКО И СВЕТУ что ОКОШКЕ (ОКНЕ)1.** Ганц энхрий (юм) нь; ганц эрдэнэ (болсон юм) нь 2. Мэддэг хийдэг нь л ганц тэр (Монгол хэлний эмээлээсэ өндөр даваа даваагүй эхнэрээсээ өөр хүн танихгүй гэдэг шиг хэллэг юм) О-75

135. **ТОЛЬКО (одна) СЛАВА** дутуу дуулаад гүйцээгээд ярьж орхидог, чихлүүлж буудаг. ярих ч гэж авч хаядаг, баримтгүй амтай байнд ч үгүй, банзанд ч үгүй.

136. **ТОЛЬКО МОКРО ОСТАНЕТСЯ** [*прост.*] сүйд хийж дууса-; үсгүй арчи-; голы нь самнаж, голомты нь самра-; нойтон голтой нь үлдээ-.

137. **ТОЛЬКО ПО ИМЕНИ** өнгөндөө л; нэрнээс цаашгүй; хоосон нэр; хөндий нэр, бнегүй их нэр, туг ширээ чөмөггүй, бараанаас цаашгүй, үхсэн буурын толгой, хоосон буу, цуутай хүүхний хурим, нидэр дээрээ ч, очир дээрээ мод.

138. **ТОЛЬКО ПТИЧЬЕГО МОЛОКА НЕТ** (*разг., шутл*) байхгүй юмгүй; хүний хар нүднээс л бусад юм бий; нохойн битүү туурай, погоон хурганы арьс, туулайн эвэр, тугалын соёо л л байхгүй.

139. **ТОЛЬКО ПЯТКИ СВЕРКАЮТ** [*разг.*] П-1285

140. **ТОЛЬКО ЧТО** Сав сая; дөнгөж сая; мөн сая, яг сая, одоо л,

Он только что поднялся с постели. Дөнгөж сая л хэвтрээсээ өөдөлж байнам (сая л орноосоо өндийж (сугарч) байна. Сая л хар нүд хуулж байна)

131. ХРЕН РЕДЬКИ НЕ СЛАЩЕ Алд бараг; адилдаа адил годилдоо годил; дүндээ дүн бандаа бан, нэг үг.

132. ХРИСТА РАДИ (гуйлга гуйх үг) юм хайрла! Хишиг хайрла! Буян бол!

133. ХРИСТИАНСКИЙ ВИД ПРИДАТЬ В-420

134. ХРИСТОВ ДЕНЬ Христосын мэндэлсэн өдөр

135. ХРИСТОВА НЕВЕСТА 1. Гэлэнма 2. [*шутл. ирон.*] чавганцын охин

136. ХРИСТОВЫМ ИМЕНЕМ ЖИТЬ (перебиваться) Хоол гуйж идэ-, гуйлгаар амь зуу-.

137. ХРИСТОМ БОГОМ МОЛИТЬ (умолять, просить и. т. п.) гуйж гувши-, тэгэж ингэж хайрла! Тэгж ингэж соёрхо!

138. ХРИСТОС С ТОБОЙ (с вами) [*разг.*] Юу болж байгаа чинь энэ вэ! Яаж байгаа нь тэр вэ? Яаваа таминь!

139. ХРИСТОС С НИМ (с ней, с ними) [*разг.*] Яавал яаг! Ду раараа болтугай! Өөрсдөө мэдэг! Зөнд нь орхи!

140. ХРОМАТЬ НА ОБЕ НОГИ [*перен.*] Болсон юмгүй; Зуун задгай; жаран хагархай.

141. ХРОНОЛОГИЧЕСКАЯ КАНВА цаг дарааллын бичиг

142. ХУДА БЕДНО [*прост.*] ядахдаа; үгүй хаяхад; дор хаяхад; наана хэлж.

143. ХУЖЕ ГОРЬКОЙ РЕДЬКИ шал залхуутай (яршигтай), тэсэхийн аргагүй, ой гутам, байж ядам

Ц

1. ЦАРИЦА ПОЛЕЙ Явган цэрэг

2. ЦАРСТВИЕ НЕБЕСНОЕ *кому* Амгалан оронд очих (болтугай)

3. ЦАРСТВО НЕБЕСНОЕ Диваажин, амгалант орон, хурмаст тэнгэр, хан хурмаст, дээд тэнгэр, хан тэнгэр, дээд тив, хурмастын орон.

4. ЦАРЬ В ГОЛОВЕ *кого* [*разг.*] ухаантай, мэргэн, өөрийн толгойтой, саруул ухаантай, суу билэгт.

5. ЦАРЬ И БОГ Суут богд, эзэн хаан, эзэрхэг хаан, догшин сүрт хаан, богд эзэн, хаан эзэн, эзэн хаан.

6. ЦАРЬ НЕБЕСНЫЙ Хан хурмаст тэнгэр, хурмаст, хурмастын хаан, тэнгэрийн хаан,

7. (при) ЦАРЕ ГОРОХЕ эртээ урьд цагт, элэрбалар цагт; сүн далайг шалбааг байхад, сүмбэр уулыг гүвээ байхад;

8. ЦВЕТНАЯ НЕДЕЛЯ (Христосын мэндэлсэн өдрийн) түрүү долоо хоног, өлзийт сайн өдөр.

9. ЦЕЛИКОМ И ПОЛНОСТЬЮ Бүрэн, бүв бүрэн, бүрэн төгс, төгс төгөлдөр, бүрэн төгөлдөр, бүрэн бүтэн, дүв дүүрэн, тэр чигээрээ, цөмөөрөө, цугаараа, буйдаа, тэр аяараа

10. ЦЕЛИЛ В ВОРОНУ, А ПОПАЛ В КОРОВУ М-118

11. ЦЕЛОВАТЬ В УСТА НЕТ ПОСТА санваарт гаргаагүй юм сайн хүнд шалтаг (аниг)

12. ЦЕЛОВАТЬ КРЕСТ *кому на чём буюу в чём* тангарагла-, тангараг өргө-, андгайл-, андгай тангаргаа өргө-, ам алда-, ам-ла-, өчи-, сүлднээсээ адис хүртэ- (ав-).

13. ЦЕЛОВАТЬСЯ ВЗАСОС [*разг.*] озо-, озож үнсэ-

14. ЦЕЛЫЙ КОРОБ (ы) *чего* [*разг.*] Өдүй, төдүй, үй түмэн, тэрэг тэмээгээр, сав суулгаар, их олон, хөсөг хөтлөөр.

15. ЦЕНТР ТЯЖЕСТИ [*перен.*] гол юм, амин чухал юм, үндсэн юм, онис нь, эгэзгэй газар, жоготой газар, болдог газар, оноч, зангилаа газар, гол зангилаа.

16. ЦЕНЫ НЕТ *кому-чему* [*перен.*] үнэт, үнэт эрдэнэ, үнэ хөлцөнгүй, үнэтэй цэнэтэй, үнэтэй цайтай.

17. ЦЕПНОЙ КАНАТ зангууны гинж, зангууны аргамжаа

18. ЦЫГАНСКАЯ ЖИЗНЬ [*разг., перен.*] хэсүүлчин (хэрээчин) амжрал, аятай газар арав хонож, таатай газар тав хонож, тавгүй газар гурав хонож, бадарчилах.

19. ЦЫГАНСКИЙ ПОТ (пробирает) [*шутл.*] дагжин чичрэх даар, дагжих, дэвжигнэх, жийрэх, хавчиганах, хавтаганах, эрүү дагжих,

20. ЦЫПЛЯТ ПО ОСЕНИ СЧИТАЮТ өсөхийн жаргал жаргал бишь, оадарчин баярлах болоогүй. Уул үзээгүй хормой шууж ус үзээгүй гүгал тайлах, юуны ч туханд хүрээгүй хэвтэж, бүтээчүү үгүйчүү, цаг дээр нь л бол, тэгэх дээр нь л тэглээ л гэж мэд яагаа ч үгүй хэвтэж

Ч

1. ЧАЙ ДА САХАРЫ [*прост.*] цай уу, зоогло! цай барь! Манж зооглох 2. ууж байгаа унд тань рашаан бол! зоог зохимжтой бол!

2. ЧАЙ ДА КОФЕЙ [*прост.*] Идэж уухаас өөр ажилгүй, идэхээс өөр идгүй, ангайж идэж алцайж хэвтэх, тунхуу суллаад л цайны хөнөг, ангасан монголын үнээ шиг, тунхуун ёроол сахигч, сархинаг нь хатсан юм шиг, ханаж цаддаггүй.

3. ЧАС В ЧАС яг цагтаа, бороотой боловч болзоондоон хуртай боловч хугацаандаа,

4. ЧАС ДОБРЫЙ! Үйлс тэнь бүттүгэй! сэтгэлчлэн бүттүгэй! жаргатугай! амарлитугай! амар сайхан жаргатугай!

5. ЧАС ОТ ЧАСУ Улам улам, яваи яван, чингэ чингэсээр яван явсаар, байн байсаар,

6. ЧАС ОТ ЧАСУ НЕ ЛЕГЧЕ уруудахад буруудах, нэг дордвол долоо дордох гэгч, бүр будилав.

7. ЧАС (часы) ПИК Оргилдоо хүрсэн, туйлдаа хүрсэн, чинээндээ тулсан, энэнээс цаадгүй хөл ихтэй үе

8. ЧАС ПРОБИЛ (настал) Цаг нь болж цай нь буцлав, цагтаа буув.

9. ЧАСТНЫЙ ДОМ Цагдаагийн газар, тусгай газар (ордон), тусгай өргөө.

10. ЧАША ТЕРПЕНИЯ ПЕРЕПОЛНЕНА (переполнилась) [*книжн.*] тэснэ тэснэ гэхэд яаж (ингэж) тэсэх вэ! Одоо ч даашгүй

11. ЧАЮШИЕ ДВИЖЕНИЯ ВОДЫ [*ирон.*] баяжихаас өөр юм бодоггүй (улс), бэртэгчин бодолтон, шунал нь дэндсэн, эдэнд ховдогло-, эдийн хүдэг үзэ-,

12. ЧЕГО (нечего) (и) ГРЕХА ТАИТЬ Ч-129.

13. ЧЕГО ДОБРОГО [*разг.*] тэх байхаа (айснаасаа), тэх бий тэгвэл яаж үхнэ, гай болох бий, сүйд болох байх, 2. Сонин юу байна? сонин сайхан юу вэ дээ?

14. ЧЕГО ИЗВОЛИТЕ [*перен., ирон.*] Цагийн ая хардаг, салхи хаашаа бол тийшээ, аяд нийлүүлдэг, юу л бол юу.

15. ЧЕГО МОЯ НОГА ХОЧЕТ [*разг., ирон.*] Намайг хэн хэлэх вэ, нохойг хэн саах вэ! Хийе гэвэл миний дур, хийсгэе гэвэл тэнгэрийн дур! Дураараа дургиж дунд чөмгөөрөө жиргэсэн, хөлөө хүрэх газар явж сурна, хэлээ хүрэх газар норгож долооно гэх.

16. ЧЕГО РАДИ [*прост.*] Нэг л учиртай, юунаас болоо юм, (жиг) жого ургаж таарлаа,

17. ЧЕГО СТОИТ (стойло) Ч-170

18. ЧЕГО ТАМ! [*прост. разг., фам.*] Юун ч хүнийрхүү юм, нэрэлхэх юу байх вэ! ёсорхоод яах вэ! юун ёсорхуу юм! эрээлэлтгүй, эрээ цээргүй бай, битгий хүнийрэх, бүү бишүүрхэ!

Входи, чего там! Ор ор, юун ёсорхуу юм!
Бери, чего там! Ав ав юун ёсорхуу юм!

19. ЧЕГО ТОЛЬКО НЕТ байхгүй, юмгүй, юу л байна... (Тэр)... л байна, байна даа харин, байхаараа бол, юм болгон бий яаж гэх вэ, болж л байна, хүнтэй л адилхан, дутсан гуцсан юмгүй, гэдэс цатгалан мөр бүтэн, юу дутлаа гэх вэ, хүн шиг л явна.

20. ЧЕГО *чему* **и. т. п. ХОЧЕШЬ (хотите)** [*разг.*] Юу л бол юу, Юу л бол юу, дуртайгаа л, тааллаараа хэрэгтэйгээ л

Проси чего хочешь Хэрэгтэй юмаа хэл (аль дуртайгаа л асуу)

21. ЧЕГО-ЧЕГО НЕТ *у кого* [*прост.*] Ч-19

Живёт он хорошо, чего-чего только у него нет (Тэр хүн) сайн яваа, байхгүй юмгүй. Гачигдаж дутагдсан юмгүй.

22. ЧЕЛОВЕК БЕЗ ПРЕДРАССУДКОВ [*ирон*]. Юу ч хийхээсээ сэйхгүй (буцахгүй) хүн, цадиггүй хүн, захиргаагаа алдсан амьтан, зүрх гэж чулуу.

23. ЧЕЛОВЕК В ФУТЛЯРЕ [*перен.*] бэртэгчин түшмэл, өөдгүй бэртэгчин, аминчхаан, ашиг тэмцээчин, хар амиа хичээгч, өөр мөртөө өрөөсөн зацаалтай, би л болж байвал гэгч.

24. ЧЕЛОВЕК НЕРОБКОГО ДЕСЯТКА [*разг.*] сөс ихтэй хүн, зүрхтэй хүн, харилтгүй эр, сэйхгүй, гудиггүй, харьдаггүй, буцдаггүй, няцдаггүй.

25. ЧЕЛОВЕК С ИЗЮМИНКОЙ [*разг.*] Наргиан, хөхүүн, хургиа хүн

26. ЧЕЛОВЕК СТАРОГО ЗАКАЛА Хуучин зан (заншил)-аа тавидаггүй хүн, хуучин ёсоо баримтгай хүн, барилаа тавьдаггүй.

27. ЧЕЛОВЕКА УЗНАЕШЬ, КОГДА С НИМ ПУД СОЛИ СЪЕШЬ Хүнии сайныг ханилан байж таньдаг, хөлгийн сайныг унан байж мэддэг

28. ЧЕЛОВЕЧЕСКАЯ НОГА НЕ СТУПАЛА Н-1202

29. ЧЕЛОВЕЧЕСКИЙ РОД Р-162

30. ЧЕМ БОГ ПОСЛАЛ Дуртайгаа зоогло, тааллаараа зоогло.

31. ЧЕМ БОГАТЫ, ТЕМ И РАДЫ Байгаа нь энэ битгий голоорой голслгүй зогсогтун.

32. ЧЕМ ДАЛЬШЕ В ЛЕС, ТЕМ БОЛЬШЕ ДРОВ Газар авахуулчихбал удах тутам хэцүү, удах дутмаа уршиг нь их болно, ямааны мах халуун дээрээ гэгчээр.

33. ЧЕМ ДЫШИТ [*разг.*] юуг эрхэмлэдэг, юуг дээдэлдэг, гол санаа нь ямар? цаанаа ямар бодолтой.

34. ЧЕМ МОГУ СЛУЖИТЬ Та юу гэж айлдав? танд миний хэрэг байх болов уу. Та юу хийлгэмээр байна? Та юу гэхсэн бол, яахсан бол!

35. ЧЕМ (ни) ПОПАДЯ [*прост.*] гартаа дайралдсанаар, юу дайралдсанаараа, аль хүрснээрээ

Бить чем попадя Юу дайралдсанаараа цохи-.

36. ЧЕМ СВЕТ Гэгээ орохоос өмнө, үүр цүүрээр, үүр хаяарахаас өмнө, нар битүү, хар үүрээр, үүр шөнөөр, харанхуй шөнөөр, нар гарахаас өмнө, үүрийн харанхуйгаар, бүрэн баран холын бараа үзэгдэхтэй үгүйтэй.

37. ЧЕМ ЧЁРТ НЕ ШУТИТ [*разг. фам. шутл.*] Юу болохыг яаж яаж мэдэхвэ? юу болохыг хэн мэдэх вэ? юмыг яаж мэдэх вэ? Яах ч юм билээ.

38. ЧЕМ (это) НЕ (что) [*разг.*] яагаад... биш байх вэ! Юунд нь болохгүй байна,... нь юу байх вэ!

39. **ЧЕПУХА (ерунда) НА ПОСТНОМ МАСЛЕ** [*прост.*] Хүн хэрэхээргүй юм, юу ч биш, дэмий юм, аргийн цоорхойгоор хоцрох юм. Е-33

40. **ЧЕРВОНЕЫЙ ВАЛЕТ** [*перен., разг.*] Олны хишиг хатгасан сагацуул, гадаад үзэгдэл нь тоть төгөс шиг дотсод байдал нь шавар шалбааг шиг (улс), угаадсы нь өтгөлөөд уяаг нь уртасгавал их содрох амьтан.

41. **ЧЕРВЯКА ЗАМОРИТЬ** З-220

42. **ЧЕРЕЗ ГОЛОВУ** *кого, чью* дайрах юмаа тойрох, азаргаа унаад слуугаа эрэх, өмсөөд эрэх,

43. **ЧЕРЕЗ МЕРУ** [*прост.*] хэт хэтүйдсэн, хирээс давсан

44. **ЧЕРЕЗ ПЕНЬ КОЛОДУ (валить)** [*разг.*] боолихой бүдүүн бартагдуу хийх-, оромдох.

45. **ЧЕРЕЗ СЕБЯ НЕ ПРЫГНЕШЬ (не перескочишь и. т. п.),** [*разг.*] Хүн хирээрээ тэмээ тэнгээрээ, савныхаа хэмжээгээр л.

46. **ЧЕРЕЗ СИЛУ** Хирнээс хэтрүү, хүч хүрэхгүй, шон хүрэхгүй нохой хорихгүй, арай ахдуу (ахлуу)

47. **ЧЕРЕЗ ЧАС ПО (чайной) ЛОЖКЕ** бүтэж цөхсөн, хөдөлж ядсан, жил болж нэг, удаж удаж нэг, бээцэрсэн,

48. **ЧЕРЕПАШЬИМ ШАГОМ** хөдөлж ядсан, хорхойн мөрөөр хорь хоног аалзны мөрөөр арав хоног, би явж, байна Бээжин сууж байна; мэлхий харайвч мэн дороо, мөндөл харайвч мөн дороо.

49. **ЧЁРНАЯ БИРЖА** дамынхан, дамчин, мөнгө дамлах мөнгөний дам

50. **ЧЁРНАЯ КОСТЬ** [*устар.*] харц хүн, сурвалж муутай

51. **ЧЁРНАЯ КОШКА ПРОБЕЖАЛА (между кем)** [*разг.*] Түнжин хагарах, ангай гарах, халбага нь хагарах (бур) хамар муруйх

52. **ЧЁРНАЯ МАГИЯ** Хар дом

53. **ЧЁРНАЯ НЕБЛАГОДАРНОСТЬ** ачийг бачаар, журмыг тэсрүүлэх, нүүр өгөхөд бөгс өгөх-, өөх өгсөнтэй өглөө нь заргалдах, өрөвдөхөд өшлөх, амар байна уу гэсэн бишгай болов.

54. **ЧЕРНИЛЬНАЯ (бумажная) ДУША** *буюу* **ЧЕРНИЛЬНЫЙ ОРЕХ (орешек)** [*разг., шутл., ирон.*] Хүнд сурталтан, албархуу, хоосон бичиг цаасаар хөөцөлдөх, албаны хийтэй, хэнхэг,

55. **ЧЁРНОЕ ДУХОВЕНСТВО** гэрээс гарсан хүн, тойд

56. **ЧЁРНОЗЁМНАЯ СИЛА** [*перен.*] Олны саналыг олсоор боож боддоггүй, олон хүчтэй, үер сөрөөд үргүй,

57. **ЧЁРНОГО КОБЕЛЯ НЕ ОТМОЕШЬ ДОБЕЛА** Угаавч уг нь хар, их барьсан ч өмхий бага барьсан ч өмхий болох, эх нь булингартай бол адаг нь булингартай, нүүрийг зүлгэвч өнгө ордоггүй,

58. **ЧЁРНЫЕ СПИСКИ** Хар данс

59. **ЧЁРНЫЙ ГЛАЗ** Д-451

60. **ЧЁРНЫЙ ДЕНЬ** [*разг.*] Хэцүү цаг, улирал бусын цаг, муу улирал, зовох цаг, тэнгэр нь хаясан үе, цөвүүн цаг, муу цаг.

61. **ЧЁРНЫЙ КАК СМОЛЬ** Тас хар (үстэй), пад хар, хав хар, хөө хар, хилэн хар,

62. **ЧЁРНЫЙ ХОД** арын хаалга, ар худрага, нүүр тал, тал тохой, танилын нүүр,

63. **ЧЁРНЫМ ПО БЕЛОМУ** Хонь нь хар хот нь цагаан (дурайсан, тодорхой бичиг), тов тод, дурайтал, өрсөн шатар шиг, сохор хүн ч олохоор, хэний ч мэдээжийн (хараажийн) эл байгаа нар, цагаан цаасан дээр хар бэхээр бичсэн шиг, толинд харсан юм шиг, нүдэн дээр.

64. **ЧЁРНЫМ СЛОВОМ (ругать браниться)** бүдүүн хадуун үгээр (хараа-, зүхэ-), муу муухай үгээр (хараа, зүхэ-), хараалын үгээр, хараах, зүхэх, амныхаа зоргоор хэлэх. П-887

65. **ЧЁРНЫМ-ЧЕРНО** [*разг.*] 1. Хав харанхуй, чив харанхуй, дүн харанхуй, пад харанхуй, тас харанхуй, нүх шиг харанхуй, ёстой харанхуй, гүйдээ нэг харанхуй, мөн ч харанхуй, маш харанхуй, тун харанхуй, асар харанхуй, дэндүү харанхуй, учиргүй харанхуй 2. Их олон хар заарцаг, хар баарцаг харлагтаад, бараантаад,

66. **ЧЕРПАТЬ ВОДУ РЕШЕТОМ** Ёроолгүй хувингаар ус барицоорхой хөнөгөөр ус ав-

67. **ЧЕРТ ВОЗЬМИ** [*разг., фам.*] Чөтгөр алгадмар! Нохой долоо, луд чамайг, ээ үхээр, чоныг хоол, хэрээний идэш, хижиг алгадмар,

68. **ЧЕРТ ДЕРИ** Чөтгөр чамайг, чөтгөр алгад, нохой долоо, буруу хойшоо, золиогоор гармар.

69. **ЧЕРТ (бес, леший, нелечкая) ДЁРНУЛ ЗА ЯЗЫК** *кого* [*разг., фам., неодобр.*] Ам нь чилдэггүй юмаа, хагархай хэнгэрэг шиг, бурж алдаваа. Л-68

70. **ЧЁРТ ДЁРНУЛ МЕНЯ СДЕЛАТЬ ЭТО** [*прост.*] өөрийн эрхгүй я нигэчихлээ! санаатай тэгсэнгүй санаандгүй л ийм болчихлоо, үйл нь ирсэн хог байлгүй.

71. **ЧЁРТ ДОГАДАЛ** Ээ чаваас тийм байж, ээлээ яалаа тоогүй

72. **ЧЁРТ ЗНАЕТ (чёрт его знает)** [*разг., фам.*] Хэн мэдэх вэ, хай, бүү мэд!

Я сегодня выпил чёрт знает сколько Өнөөдөр би хичнээн архи уув даа бүү мэд.

73. **ЧЁРТ ЗНАЕТ ЧТО** Б-246

74. **ЧЁРТА ЛИ** буюу **НА КОЙ ЧЁРТ** [*разг., фам., вульг.*] Яах юм, ямар хэрэгтэй юм, элэнцэгээ хийх юм. Сүрхий нь юу байбайгаа юм, хар яршиг.

75. **ЧЁРТА ЛЫСОГО** [*разг., вульг.*] Чөтгөр алгадмар, нохой долоо, лүд оргимор! Б-161

76. **ЧЁРТ НЕ БРАТ** [*разг.*] Дээгүүр толгойтой, хүн тоохгүй, давилуун зантай, хамарт нь баас түрхчихсэн юм шиг, зэргэлээ харсан юм шиг

77. **ЧЁРТ (бес, леший, нелегкая НЕСЕТ** *кого* Ч-80, Б-250

78. **ЧЕРТ НОГУ СЛОМИТ** С-189

79. **ЧЁРТ (нечистый, нечистый дух, нелегкая, грех) ПОПУТАЛ** [*разг*] учраа алдав, будилж гүйцэв, самуурчихлаа. Б-159, В-933

80. **ЧЕРТ ПРИНЁС (занёс)** [*разг. фам.*] гай нь даллажээ, гай иржээ, муу юм нь даллажээ, совин нь оржээ.

81. **ЧЕРТ РАЗБЕРЁТ** [*разг. фам.*] бүү мэд, хэн мэдэх вэ цаашаа.

82. **ЧЁРТ (леший, шут, пес, хрен, прах) С НИМ (с тобой, с вами и. т. п)** [*разг., фам., вульг.*] өөрөө мэдэг, дураараа болж дунд чөмгөрөө жиргэ дээ! Өөрийн чинь дур мэджээ. Дураараа болог. Дүүрсэн хэрэг болжээ. Б-160

83. **ЧЁРТ УГОРАЗДИЛ** *кого* [*прост.*] Муу юм нь түлхжээ-, далдын эзэнтэй юм шиг, ад нь адалжээ, адаршжээ, юм шүглэжээ.

84. **ЧЁРТ УНЕС** *кого* далд орж өглөө, ашгүй явлаа, шилий нь харахаа үздэг байж

85. **ЧЁРТА (беса) ЛЫСОГО** юу **ч . . .** (мэдэх, авах, хийх, ухаа, рах (үгүй, юу ч олж долоохгүй, умаахан суухай, мад, таг, аль ч үгүй.

86. **ЧЕРТА ЛИ кому, в ком, в чем** [*прост.*] Н-131

87. **ЧЕРТА ОСЕДЛОСТИ** Хебрей нарын хороо

88. **ЧЁРТ С ДВА (ЧЕРТА В СТУЛЕ)** [*прост., вульг.*] тиймгүй, хаанаас даа, тэгж ярихгүй, үгүй чиш, ядсан ч үгүй.

Черта с два я соглашусь Би яасан ч зөвшөөрөхгүй,

89. **ЧЁРТИКИ В ГЛАЗАХ (бегают, забегали)** [*разг.*] Нүдээ гөлөлзүүлэн, нүд нь бүлтэлзэн.

90. **ЧЁРТОВА ДЮЖИНА!** Дордохын долоо, арван гурав (европт бэлэг муутай тоо нь энэ арван гурав юм. Монголд бол бэлэг муут тоо нь долоо юм)

91. **ЧЁРТОВА КУКЛА** [*прост, вульг, бран.*] золиг (чамайг), үхсэн золиг, зүлд!

92. **ЧЁРТОВА ПЕРЕЧНИЦА** [*груб. прост.*] эм шулам, алмас оргисон,

93. **ЧЁРТОВА ПРОПАСТЬ (гибель)** тоо томшгүй, үй түм, элдэв долоон, долоон жорын, далан долоон

94. **ЧЕРТ-ТЕ-ЧТО** хачин, гайхалтай, хүн итгэхийн аргагүй, үнэмшихэд хэцүү.

95. **ЧЕРТУ ТОШНО** [*прост.*] Ч-96

96. **ЧЕРТЯМ ТОШНО** [*разг.*] тэсэхийн аргагүй, бөөлжис цутгам байж суух аргагүй, дур гутам ой гутмаар, огиудас (огидас) хүрэм, санашгүй, санахын халцгай

Накурили так, что чертям тошно Амьд амьтан байж болмооргүй тамхины утаа болжээ.

97. **ЧЕСАТЬ (ПОЧЕСАТЬ) ЗУБЫ** [*прост.*] хэл амаа билүүдэ-, ам мэдэн донгосо-, чалчи-, хэл ам нь загатнасан юм шиг,

98. **ЧЕСАТЬ ЗАТЫЛОК (ЧЕСАТЬ В ЗАТОЛЫКЕ)** [*прост.*] шилээ маажи-, юу билээ гээд бай-, духаа үрчийлгэ-, бодлогош-, ро,, бодоод бодоод бодын шийр дөрөв.

99. **ЧЕСАТЬ ЯЗЫК** П-888

100. **ЧЕСТНОЕ СЛОВО** Нээрэн шүү, үнэнхээсээ, үйлийн үргүй үнэ-, үнэнээсээ, ёстой үнэн, үнэнээсээ үнэн,

101. **ЧЕСТНЫЙ МАКЛЕР** [*ирон.*] (олон улсын) хон завшигч, зууч, хомхой зууч

102. **ЧЕСТЬ И МЕСТО** [*разг.*] Сууж морило-, дээшээ (өөдөө) морило-, дээшээ залра-, хоймор залра-.

103. **ЧЕСТЬ ИМЕЮ КЛАНЯТЬСЯ** [*устар.*] мөргөн ёслоод явъя, мөргөчихөөд мордъё, ёслоод салан явъя.

104. **ЧЕСТЬ И ХВАЛА** *кому* (*высок*) магтууштай, шагширмаар,

105. **ЧЕСТЬ ИМЕЮ (кланяться)** Би явъя даа (салж явахдаа хэлэх үг) Салъя гэж салаагүй (салаа замын эрхээр саллаа).

106. ЧЕСТЬ ПО ЧЕСТИ Номын ёсоор, зүй зохисоор, номынхоо үнэн цагаанаар, үнэн мөнөөрөө, үнэн зөвөөрөө.

107. ЧЕСТЬ ЧЕСТЬЮ [*разг.*] ёсоороо, номынхоо ёсоор, сайхан таарсан, болсон шиг болсон

108. ЧЕТВЁРТОЕ ИЗМЕРЕНИЕ [*ирон.*] Аврага, аугаа их, цаглашгүй.

109. ЧЕШУТСЯ РУКИ *у кого* [*разг.*] Гар нь загатнасан, гар нь өт чихсөн юм шиг, юм хиймээр санагдав хийх юмаа олж ядав, зүгээр сууж чаддаггүй.

Эх! возьми меня в работники, поработать руки чешутся Намайг ажилтнаар аваач гар минь загатнаад байна.

110. ЧИН ПО ЧИНУ Ёс ёсоор нь, номын ёсоор, байх учраар нь, зүй ёсоор, зүй зохисоор

111. ЧИН ЧИНА ПОЧИТАЙ [*ирон., шутл.*] 1. Ёс ёмбогор, төр төмбөгөр, 2. Хулганы дуу тэнгэрт хүрэхгүй, төрийн төлөө оготоно, боож үхэх гэж явахын хэрэггүй, ноогдсоноо хийгээд л явж явсан дээр, илүү зүйрган баяжихад саад.

112. ЧИН-ЧИНОМ [*разг.*] Ч-107

113. ЧИСТАЯ ОТСТАВКА [*разг.*] чармах (насжаад ажлаа гүйцэхгүй болох), тушаал үглэх

114. ЧИСТОЕ ГОРЕ [*разг.*] Хар зовлон, бөөн зовлон, ёстой лай, харлай

Чистое горе с таким мужем Ийм эртэй байх гэж ёстой зовлон

115. ЧИСТОЙ ВОДЫ [*разг.*] жинхэнэ, цэвэр, ёстой цэв цэвэр, хольцоогүй, арчуухан,

Брильянт чистой воды Жинхэнэ алмаас

116. ЧИСТЫЕ ДЕНЬГИ [*разг.*] бэлэн мөнгө, бие мөнгө, барил мөнгө

117. ЧИСТЫМ СЕРДЦЕМ С-98

118. ЧИСТО-НАЧИСТО Цэв цэвэр, цэвцийсэн цэвэрхэн, арилгасан сонгино шиг, гял цал, хиргүй ариун

119. ЧИТАТЬ В СЕРДЦАХ (луше) [*ирон.*] дотуур санаагий нь мэдэ-, (тайда-, тамжа-, таж мэдэ-), дотор нь ороод гарсан юм шиг мэдэ-,

120. ЧИТАТЬ МЕЖДУ СТРОК М-67

121. ЧИТАТЬ МОРАЛЬ [*ирон.*] Ёс хэлж өг-, зааж зурж өг-, хэлж сурга-, сургамжила-, орой руу нь ортол хэлэ-.

122. ЧИХАТЬ ХОТЕЛ кто на кого-что [*вульг.*] Нэг нүдээр үзэхгүй, хүн гэж тоохгүй, нохойноос дор үзэ-, нүд үзүүрлэ-, шоовдорло-, адла-, ад үзэ-, алаг үзэ-.

123. ЧЛЕН-СОРЕВНОВАТЕЛЬ [*устар.*] Орлогч гишүүн

124. ЧТО БОГА ГНЕВИТЬ [*разг.*] тун муугүй, элий халаг болсон юм алга, гайгүй, барагтай нэг, тааруу нэг.

125. ЧТО БЫЛО, ТО ПРОШЛО И БЫЛЬЁМ ПОРОСЛО Өнгөрсөн юм, тэгээд л өнгөрсөн юм нэгэнтээ өнгөрчихсөн юм тэгээд л тэр биз, тэртэй тэргүй (хөг нь) өнгөрсөн, яасан ч дүүрсэн, өнгөрсөн бороо, өнгөрсөн хорвоо, тэглээ ч яалаа, байлаа ч яалаа.

126. ЧТО В ЛОБ, ЧТО ПО ЛБУ Тэртэй тэргүй адил, хаашдаа л нэг, адилдаа адил, годилдоо годил, годилдоо годил, тэглээ ч яалаа байлаа ч яалаа, дүндээ дүн бандаа бан, нэг үг, яалаа ч өөрцгүй.

127. ЧТО ВАМ *ему, ей и. т. п.* **СТОИТ** Танд юухан байх вэ, танд зовлонгүй, танд ч амархан даа, танд ч тоглоомоо тоглоом.

128. ЧТО ГОРОД, ТО НОРОВ, ЧТО ДЕРЕВНЯ, ТО ОБЫЧАИ Усы нь уувал ёсы нь дагадаг, ёстой юм ёсоороо болдог, сохрын газар сохроор, доголонгийн газар доголонгоор

129. ЧТО (и) ГРЕХА ТАИТЬ [*разг.*] Нуугаад юу хийх вэ, муу нуухаар сайн илчил, сэтгэлийн сэвтэй юм хэрэггүй, хүн мэдэхгүй юм шиг, эл байгаа нарыг алгаар хаадаггүй. Ч-12

130. ЧТО ДЕЛАТЬ [*перен.*] Яах вэ дээ (одоо) арга алга даа, одоо яана гэх вэ? Яая даа? За байз уу! (даа)

131. ЧТО ДО 1. *кого-чего.* . . . ийн хувьд, 2. *кого-чего кому.* Ямар хүртээлтэй юм? Юуны нь хүртээл байгаа юм, ямар хамаа байх вэ?

Что до меня, то я не могу согласиться Миний хувьд бол би л зөвшөөрөхгүй юм байна.

Что мне до ваших дрязг Та нарын хэрүүл (хэл ам) над ямар хүртээлтэй юм бэ? Та нарын шившигт би хамаагүй шүү.

132. **ЧТО ДУШЕ УГОДНО** дуртай болгон, таалсан бүгдээ, санаандаа таарсан бүр (нйг), тэгэе гэсэн бүгдийг

133. **ЧТО ЕСЛИ . . .? 1. . . .-бал⁴ . . .** яана вэ? Хэрэв заяа . . . яах вэ? . . . болж таарвал яана даа? 2. . . .-бал⁴ болох уу?

Что если я сам поеду? Би өөрөө явбал яана вэ? (яасан юм?)

Что если подымется буря? Хэрэв заяа шуурга тавивал яана вэ?

Что, если бы вы зашли к нам после кино? Та кино тараад манайд ирвэл болох уу?

134. **ЧТО ЕСТЬ В ПЕЧИ, ВСЕ НА СТОЛ МЕЧИ** (Зочид) аль байдгаа гарга! Авдарныхаа ёроолдохыг гарга! Гараа гарга! байдаг жаахнаа бари! Юу байдгаа, юутай хүүтэй нь гарга!

135. **ЧТО ЕСТЬ ДУХУ** хар хурдаараа, хар эрчээрээ (давхих, гүйх, харайх мэт), уухи аахи болон, уушги зүрх нь амаараа гарах шахан

136. **ЧТО ЕСТЬ МОЧИ (духу)** Хамаг (байдаг, бүх) хүчээрээ, буй чадлаараа, эрвийх дэрвийхээрээ.

137. **ЧТО ЕСТЬ СИЛЫ ЧТО БЫЛО СИЛЫ (сил)** [*разг.*] байдаг (байгаа хар) хүчээрээ, хамаг тэнхээгээрээ

Ударил что было силы байдаг (хар) хүчээрээ цохих.

138. **ЧТО ЖЕ (ж)** үгүй яах вэ дээ, зүгээр, яах вэ, яаж байгаа нь тэр вэ?

Сегодня нельзя? Что же, подождём Өнөөдөр дэмий юу? За яах вэ хүлээе дээ.

139. **ЧТО (ж буюу же) ТАКОГО** буюу **ЧТО (ж буюу же) ТУТ ТАКОГО?** [*разг.*] онц юм юу байгаа юм? гайхалтай юм юу байгаа юм? Байдаг л юм, хүнд үгүй юм биш.

Что тут такого? Я тоже могу так сделать. Энэнд гойдын юм юу байгаа юм би ч хийчихнэ.

140. **ЧТО (же это) ТАКОЕ!** Юу болж байгаа нь энэ вэ! Яаж байгаа нь энэ вэ! Юу болох нь энэ вэ! Юу вэ? Яав аа?

141. **ЧТО ЗА 1.** Юутай яасан, шал (дэмий) 2. Ямар жигтэй яацарсан, ашгүй, мөн ч бузгай, ёстой нэг, мөн л,

Что за прелесть! Юутай сайхан! яасан сайхан!
Что за безобразие Шал завхарсан
Что за ерунда Яасан дэмий юм ярина вэ? Шал дэмий юм.

Что за человек приехал? Юун хүн ирээ вэ? Хэн ирээ вэ?
Что за ученики, такие не послушные! Яахаараа ийм үг дуулдаггүй сурагчид байна вэ (яасан үг мэддэггүй хүүхдүүд вэ!)

142. **ЧТО ЗА БЕДА** Юундаа зовох вэ, зовох юу байх вэ.

143. **ЧТО ЗА ВОПРОС?** [*разг*] 1. Асуух юу байх вэ, асуултаангүй бололгүй яахав 2. Юу гэж асууж байгаа нь энэ вэ? Юу гэсэн үг вэ?

144. **ЧТО ЗА ДИВО** [*разг.*] 1. гайхалтай хачин юм, 2. Гайхах юу байх вэ.

Что за диво, поезд опаздывает Хачин юм даа галт тэрэг хожимдож ирж байна.
Ну это что за диво: Каждый это знает Гайхаад байх юм юу байх вэ энийг хэн ч мэднэ.

145. **ЧТО ЗА НЕВИДАЛЬ!** Э-4

146. **ЧТО ЗА ОХОТА** [*разг.*] юунд . . . буй . . . аан⁴ яах юм бэ?

147. **ЧТО ЗА ПРИТЧА** [*разг.*] Энэ яаж байгаа юм? юу болж байгаа нь энэ вэ?

148. **ЧТО ЗА СЛЕД** *кому* . . . албатай юм уу? . . . ёстой юм уу? К-276

Что за след тебе в эти дела мешаться Чи энүүнд хуруу хошуу дүрэх ямар албатай юм бэ?

149. **ЧТО ЗА СПРОС** *кто* Яагаад ингэж асууж байгаа юм? Чи яах нь вэ? Чи яах гээв Чамд ямар хамаатай юм.

150. **ЧТО ЗА СТРАННОСТЬ!** [*разг.*] Ямар жигтэй юм бэ? яасан хачин юм бэ? Гайхмаараа бас?

Что за странность! Была здесь книга и вдруг исчезла Ямар хачин юм бэ? Энд байсан **юм** гэнэтхэн алга болчихлоо.

151. ЧТО ЗА СЧЁТЫ! [*разг.*] Юугий нь голж **шилэх вэ!** Энэ нь тийм тэр нь тийм гэх юу байна.

152. ЧТО ЗА (какая там) ЧЕСТЬ, КОГДА НЕЧЕГО ЕСТЬ! Чөмөггүй байж туг ширээ гэгч.

153. ЧТО И ГОВОРИТЬ Н-1040

154. ЧТО И ТРЕБОВАЛОСЬ ДОКАЗАТЬ Гэрч нь энэ байна. Энэ бол гэрч нь.

155. ЧТО И К ЧЕМУ [*прост.*] учир холбогдол, ёс журам, нийм тийм гэдгийг

Толковый человек! Понимает что к чему. Ухаалаг хүн учир холбогдлыг андахгүй

156. ЧТО ЛИ 1. Юу вэ? Яагаа вэ? Яах вэ? **2.** . . . гэж үү? . . . юм уу? . . . юу?

Пойдем что ли? Явах уу яах вэ?

Что то случилось! Пожар, что ли? Нэг л юм болжээ. Түймэр үү юу вэ?

Заболел ты, что ли Чи өвдөө юу яагаа вэ?

Столько получаешь и не хватает тебе, что ли. Тийм их мөнгө авч байгаа байж хүрэхгүй байна гэж үү?

157. ЧТО МОЖНО ДЕЛАТЬ СЕГОДНЯ, НЕ ОТКЛАДЫВАЙ НА ЗАВТРА Өдрийн юмыг өдөрт нь цагийн юмыг цагт нь

158. ЧТО НАДО [*прост.*] бузгай, сүрхий дорнун сана- санчлан, овоо, зэгсэн, бас ч гэж.

159. ЧТО НАЗЫВАЕТСЯ [*разг*] гэгч, хэмээгч' юу гэвэл.

Он был, что называется, воин ёстой дайчин эр гэгч байсан бүлгээ.

160. ЧТО НАПИСАНО ПЕРОМ, ТОГО НЕ ВЫРУБИТЬ ТОПОРОМ үгчилбээс бийрээр бичсэнийг балтаар цавчиж хаяж болдоггүйн шарх эдгэрдэггүй, мэсийн шарх эдгэрдэг, ам алдвал барьж болдоггүй.

161. ЧТО НИ ГОВОРИТЕ (ни говори) *буюу* **КАК НИ ГОВОРИТЕ** Юу ч ярьсан, юу ч гэсэн. К-155

162. ЧТО НИ НА ЕСТЬ . . . [*прост.*] **нжилгүй, жишиггүй,** дээргүй, дээдийн дээд хэсгүй, гаргуу, тасархай, онцгой, гойд, гоц, онц, гүй. эгнэшгүй, зэрэгцэшгүй, энэнээс цаадгүй, шилдэг, тэргүүн, толгой,

Товар что ни на есть лучший Энээс сайн бараа гэж, үгүй (жишиггүй сайн, эдийн дээд)

Самый что ни на есть красивый Сайхны дээд болсон (сайхны сайхан, энэнээс цааш сайхангүй)

163. ЧТО (ни) ПОПАЛО (гартаа) дайралдсаныг л

Есть что попало (Гартаа аль) дайралдсаныг л идэ-

164. ЧТО НИ ШАГ газар бүр, хаа хаагүй, хаана, хаанагүй

165. ЧТО ПОСЕЕШЬ, ТО И ПОЖНЁШЬ 1. арвайнаас арвай л ургадаг, буудайнаас буудай л ургадаг. 2. Гэм нь урдаа гэмшил нь хойноо, өөрийн хийсэн өөрт

166. ЧТО ПРИКАЖЕШЬ буюу **КАК ПРИКАЖЕШЬ** [*разг.*] Таны зарлигийг сонсъё, алтан сургаалыг тань хүртэе.

167. ЧТО ПСУ (собаке) ПОД ХВОСТ [*вульг.*] Нохойн хүзүүнээс мах уясантай адил, нохойн аманд орсон яс бүтэн гардаггүй, чононд хонь хадгалуулахтай адил, уухайн тас, зол зэхий К-195

168. ЧТО СЕЙ СОН ЗНАЧИТ? [*разг. шутл.*] Энэ юу гэсэн үг вэ? Юу гэж ухаарвал болох байна? Үүнийг тайлж өгөөч.

Что сей сон значит, объясните пожалуйста. Энэ юу гэсэн ухааны юм бэ тайлж хэлж өгөөч

169. ЧТО СКОРО ТО И НЕСПОРО Түргэн түүхий, бушуу туулай борвиндоо баастай, яарвал даардаг

170. ЧТО СТОИТ (стоило) буюу **ЧЕГО СТОИТ** [*разг.*] хичнээн их үнэ (цаг, хүчин) суйтгэв дээ яасан гэж санана. Ч-17

171. ЧТО ТАКОЕ Юу вэ? Юу болж байна? Юу гээч вэ?

172. ЧТО ТВОЙ [*разг.*] . . . шиг, . . . тай адил Н-377

Этот силач-что твой Энэ бөх аврага гэмээ аврага юм.

173. ЧТО ТЫ (ЧТО ВЫ!) юу яасан, яасны чинь, за яав, яалаа гэж

Надо уже домой!- Что вы так рано? посидите ещё! Харих боллоо! -Юу яасан, нийм эрт жаахан саатаж морилоо!

Я думаю что он тебя обманывает- что ты! Не может этого быть! цаадах чинь чамайг хөөрхөн маллаад л байгаа юм шиг байна. Яалаа гэж тэр ч үгүй шүү.

174. **ЧТО ТЫ ГОВОРИШЬ (вы говорите)** Яана гэнэ ээ? Юу гэнэ ээ? Юу гэсэн үг вэ?

175. **ЧТО ТЫ ХОЧЕШЬ (хотите)** В-918

176. **ЧТО Я ТАМ ЗАБЫЛ?** [*разг.*] Би тэнд очоод юугаа хийх юм? Надаар яах гээв?

177. **ЧТО ЧЁРТ ПОШЛЁТ** [*разг. вульг.*] Юу болохыг бүү мэд, тэнгэрийн зориг мэджээ. Тэнгэр мэдэг

178. **ЧТОБ ПУСТО БЫЛО** ДааНч яав аа, ээ чаваас

179. **ЧТОБ ТЕБЕ** (*ему, ей, вам, им*) **ПОВЫЛАЗИЛО** [*груб. прост.*] харах нүд нь харалган болмор, нүд нь сохорсон, нүд нь циймэр

180. **ЧТОБ ТЕБЕ** (*ему, вам, им*) **ПУСТО БЫЛО** [*прост.*] Чи ёстой дүүрсэн амьтан, чи дээ бас үхэж далдармар

181. **ЧТОБЫ (и) ДУХОМ НЕ ПАХЛО** *чьим* [*прост.*] далд ормор, долоон уулын цаагуур дов дошин доогуур ормор, нүдэнд үзэгдэхгүй чихэнд дуулдахгүй газар тонил бүү үзэгд! Үсгүй далд ор!

182. **ЧТОБЫ (и) ДУХУ (праху) НЕ БЫЛО** [*прост.*] Сэг сэвсгүй болох, сэг сэвсгүй одох, сэг сэвсгүй очих, алга болоод өгөх,

183. **ЧТОБЫ НЕ БЫЛО ПОВАДНО** [*разг.*] Тэгүүлэх ингүүлэхгүйн тулд,

Я его проучил, что бы не было повадно воровать. Хулгай хийлгэхгүйн тулд би гайгүй сургамжлав.

184. **ЧТОБЫ НЕПОВАДНО БЫЛО** *кому* Хашраах, тэгүүлэхгүй болгох,

185. **ЧТОБЫ НЕ СКАЗАТЬ...** Худалч хүнд, тийм ийм шахуу, бараг тийм,

Это-акт не дружелюбный, что бы не сказать враждебный Энэ тун найрсаг биш явдал, худа лч хүнд дайсагнасан ажил даа.

186. **ЧТОБЫ НЕ СКАЗАТЬ БО ЛЬШЕ** Цаадахы нь байлаа гэхэд л бусды нь ярихаа байя гэхэд...

187. **ЧТОБЫ ТЕБЯ (его) РАЗОРВАЛО!** [*прост, бран.*] Чи яасан дүүрсэн амьтан бэ! Хачин амьтан бэ? Мөн хүн ээ чи! Дүүрсэн амьтан

188. **ЧУВСТВО ЛОКТЯ** [*перен.*] Бөөр нийлсэн (санаа нийлсэн) гар санаа нийлсэн, ганзага нийлсэн.

189. **ЧУВСТВОВАТЬ СЛАБОСТЬ** к *кому-чему* элэгтэй, талтай хайртай дотно, элгэмсүү, өөриймсүү, цөстэй,

Сам в университете не был, но к студентам всегда чувствую слабость (Лесков) Өөрөө их сургуульд байж байгаагүй ч гэсэн оюутан нарт их элэгтэй (талтай)

190. **ЧУДЕСА В РЕШЕТЕ** [*ирон.*] Жигтэй юм, хачин юм.

191. **ЧУДНОЕ ДЕЛО** Жигтэй хэрэг ээ! Хачин юм. Ээ мэдэхгүй,

192. **ЧУДО-ЮДА** Этгээд муухай, зүүдэнд ормоор, ёргүй, ёозгүй,

193. **ЧУЕТ КОШКА, ЧЬЁ МЯСО СЪЕЛА** З-317

194. **ЧУЖАЯ ДУША-ПОТЁМКИ** Хүний доторхийг яаж мэдэх вэ, хүний дотор орж үзсэн биш, хүний санаа хөрст газраас зузаан хүний эрээн дотроо могойн эрээн гадпаа

195. **ЧУЖИЕ КРАЯ** Хүний нутаг, харь газар, хүний газар, гүний нутаг.

196. **ЧУЖИМ ГОРБОМ ЖИТЬ (добывать)** [*разг.*] Хүний хүчинд амь зуу-, хүн бараадаж аж төрө-, хүний гараар могой бариулж амь тээ-, хүний царай харж аж төрө-, нохойн сахлаар гийдаа хутгах,

197. **ЧУЖИМ ДОБРОМ НЕ НАЖИВЁТСЯ** Хүний юм хүнд наалддаггүй,

198. **ЧУЖИМ УМОМ НЕ ПРОЖИВЁШЬ** Хүний ухаан хүнд улживаргүй, хүний эрхээр хүрд эргүүлэхээр өөрийн мэдлээр бул эргүүлэх минь, хүний мэдэлд явахаар өөрийнхөө толгойгоор өнхөрч яв, ухааныг худалдаж авдаггүй.

199. **ЧУЖИМИ РУКАМИ ЖАР ЗАГРЁБАТЬ** хүний гараар могой барнул-, уутач болж бай-,

200. **ЧУЖОЕ ГОРЕ НЕ БОЛИТ** Үхсний хойноос үхдэггүй, өвдсөний орноос өвддөггүй, хүний зовлонг хүн мэддэггүй, эрүүл хүн өвчтэй хүний зовлон мэддэггүй, хүний бүсэр хүн өвдөхгүй, үхлийг ацаглаж болдоггүй.

201. ЧУЖОЙ ВЕК ЗАЕДАТЬ Зовоо-, үйлий нь үзэ- тамла-, тамы нь цайлга, үйл тамы нь бара-тартгий нь цайлга-

202. ЧУТЬ (было) НЕ *буюу* [*разг.*] **ЧУТЬ-ЧУТЬ НЕ**...тэгэх ингэх шахав,...тэгэн ингэн алдав. арай л...(тэг) сэнгүй.

Она чуть не упала (Тэр эмэгтэй) унан алдав (унах шахав, арай л ойчсонгүй).

203. ЧУТЬ ЛИ НЕ [*разг.*] бараг,...тийм байхаа, тийм шахуу (шахам)

204. ЧУТЬ ОТ (с) ЗЕМЛИ ВИДАТЬ (видно) О-226

205. ЧУТЬ *чем* **СВЕТ** Үүр тэмдэг ороход, уул завсарлахад, үүр хаяарахад, цагаан гэгээ ороход, холын юм үзэгдэхтэй дайтай болоход.

206. ЧУТЬ ЧТО Юм (гай) л болбол, сав л хийвэл.

Чуть что, сразу выезжай Юм л болбол тэр даруйд нь мордоорой

Чуть что, она начинает плакать Сав л хийвэл уйлдаг

207. ЧУТЬ-ЧУТЬ [*разг.*] арай чамай, чуу чамай, дөнгөн данган чуу гэж, ялимгүй, жаалхан.

208. ЧУХОЙСКОЕ МАСЛО Шар тос.

Ш

1. ШАГ ЗА ШАГ хоёр нэг гэж алхах, хөлөө зөөж тавих, сажлах, ханчирах, нэг хоёрлон гэлдрэх.

2. ШАГ ЗА ШАГОМ Яван яван, алгуур аажмаар, ягуухан, дасга дасгасаар, ахь ахисаар, байн суун, тэг тэгсээр

3. ШАГНУТЬ НЕ ДАЮТ (нельзя) [*разг.*] Хааш нь ч хөдөлгөхгүй, яг бариатай, хааш нь ч алхуулахгүй, бөгс өндийлгөхгүй, чөдөртэй.

4. ШАГУ НЕГДЕ (некуда) СТУПИТЬ Хөл хийх зайгүй бай-, пиг шүрэн, (хөл) гишгэх зайгүй бай-,

5. ШАГУ НЕ СДЕЛАТЬ *для чего* Шаварт зоогдсон юм шиг, огт хөдлөхгүй, гар хумхиж суу-, шавар баримал шиг, хөшөө чулуу шиг, хормойг нь газартай хадчихсан юм шиг,

6. ШАГУ СТУПИТЬ НЕЛЬЗЯ не (может) *без кого-чего* [*разг.*] дэргэдээс нь салахгүй, огт хагацахгүй, гүзээнд наалдсан дөлүү шиг,...-гийг л байхгүй бол болохгүй, сүүдэр шиг, нойтон хамуу шиг.

7. ШАЛЬНАЯ ПУЛЯ Зэрлэг сум, тэнэсэн сум,

8. ШАЛЬНЫЕ ДЕНЬГИ Сул олсон мөнгө? зовлонгүй олсон зоос, зовлогоо зовоолгүй олсон мөнгө, бэлэн хоол, олзны юм.

9. ШАЛЯЙ-ВАЛЯЙ [*прост., недобр.*] Хайш яйш, хам хум, сал сулхан, тэгж нигэн,

10. ШАПКА ВОЛОС (кудрей) Ортууз малгайтай, шөвөг толгойтой, сэгсийсэн үс, араг толгой (гой), их үстэй, сангас толгойт, удган шиг, довдгон шиг, аврага шиг, мангас толгойтой.

11. ШАПКА-НЕВИДИМКА Далдын хар малгай

12. ШАПКАМИ ЗАКИДАЕМ [*разг.*] (хүн олонтой нь) махаараа дарчих (мар)

13. ШАПОЧНОЕ ЗНАКОМСТВО [*разг.*] Мэндээс цаашгүй (таних), зүс таньдаг, зүс танихаас цаашгүй нүүр үзсэн төдий.

14. ШАПОЧНЫЙ ЗНАКОМЫЙ Зүс таньдаг хүн, мэндтэй л явдаг, зүс танихаас цаашгүй танил

15. ШАРАШКИНА КОНТОРА [*разг., пренебр.*] Эх толгойгүй газар, ажлаа алдсан газар.

16. ШАРИКОВ НЕ ХВАТАЕТ [*прост., пренебр.*] Нанжин ухаангүй, гойд ухаантай биш, бүдүүн тойм хүн, үл мэдэг шүүдэнгэ-,

17. ШАХМАТНЫЙ ПОРЯДОК Эгнүүлэн, үелэн эгнэсэн, ерийтэл, ярайсан, өрсөн сур шиг, жингийн тэмээ шиг, цэргийн жагсаал шиг, нүүдлийн шувуу шиг, зэлний ногт шиг, өрсөн шагай шиг.

18. ШВЕДСКИЕ СПИЧКИ Банзан шүдэнз

19. ШВЫРЯТЬ ДЕНЬГИ НАПРАВО И НАЛЕВО Б-398

20. ШЕВЕЛИТЬ МОЗГАМИ [*разг., шутл.*] Ухаан сийл-, юм бодо-, бодлогошро-, бодолд дарагда-,

21. **ШЕВЕЛЯТСЯ ДЕНЬГИ** *у кого* [*разг.*] Бэлтэй, мөнгө сайтай, бэлтэй хөдлөх, бэлэрхүү, мөнгөөр зодох, бэл заах.

Шевелятся лишние деньги в кармане Өврийн цасаар сайн

22. **ШЕМЯКИН СУД** Хууль завхруулан шийтгэх, хилсээр аваачих, хууль бусаар яллах, ёс бус шийдэх, хэргийг хэлтгий шийдэх, нүдээ олохгүй нүгэл хийх.

23. **ШЕРОЧКА С МАШЕРОЧКОЙ** [*разг., шутл.*] (хоёр эмэгтэй (хам) нийтийн бүжиг бүжихэд шоодон хэлэх үг)

24. **ШЕСТАЯ ДЕРЖАВА** [*перен.*] 1. Сурвалжлагчид, сурвалжлаачид, мэдээ цуглаачин, 2. үзэхгүй харахгүй юмгүй, орохгүй гарахгүй юмгүй, шам гэхээс дутдаггүй шар гөлөг.

25. **ШИВОРОТ-НАВЫВОРОТ** [*разг.*] Чанх баруу, арааараа нийлсэн харь, этгээд, гаж буруу,

26. **ШИЛА В МЕШКЕ НЕ УТАИШЬ** Үгчилбээс: шуудайд (уутанд) шөвөг нууж болдоггүй утгачилбаас: булавч бултална, даравч дарайна, муу нуухаар сайн илчил!

27. **ШИЛЬЦЕ И МЫЛЬЦЕ** Юм бүхэн бүрдсэн, байхгүй юмгүй, зүү утас саван сойз хүртэл бий

28. **ШИРОКАЯ МАСЛЕНИЦА** Шинийн тавд

29. **ШИРОКАЯ НАТУРА** уужим дотортой, гудиггүй, хирийн юманд хөдлөхгүй, тохитой (хүн), элбэг цөлх хүн

30. **ШИРОКО РАСКРЫТЬ ГЛАЗА (рот)** [*перен.*] Нүд амаа орой дээрээ гарга-, нүдээ бүлтийлгэн алмайр-.

31. **ШИТО БЕЛЫМИ НИТКАМИ** [*разг*] нуухын аргагүй, даравч дарайж булавч бултална. Зэс нь заавал цухайна. Муу нуухаар сайн илчил.

32. **ШИТО-КРЫТО (шито и крыто, шито да крыто)** [*разг. неодобр.*] Бив битүү, бөглөөтэй таглаатай, оёотой шидээтэй, хав дараастай, далдын далд дайлангийн мухарт

33. **ШИШКА НА РОВНОМ МЕСТЕ** [*прост. пренебр.*] Биеэ ихэд бодсон хүн, тун дээгүүр зантай хүн, сээр нь овойсон хүн, уулын толгой харсан хүн

34. **ШКОДЛИВ КАК КОШКА, ТРУСЛИВ КАК ЗАЯЦ** зүггүй мөртөө зүрхгүй

35. **ШКОЛЬНАЯ СКАМЬЯ С—92.**

36. **ШКУРА БАРАБАННАЯ** [*перен, разг, брен*] арьс яс хоёр, ясан хэдрэг, тураалынхаа туйлд хүрсэн, найман чөмгөндөө хэлхээтэй зүүд зэрэглээ шиг, амь нь хаанаа байдаг юм бол гэмээр эцэнхий

37. **ШКУРА ОВЕЧЬЯ, ДА ДУША ЧЕЛОВЕЧЬЯ,** Зүс нь хар ч бол. сон зүрх нь цагаан, царай муутай ч чанар сайтай, зүс муутай ч цөс сайтай.

38. **ШКУРУ ДРАТЬ** *с кого* Тонон мөлжи-, мөлжин цөмө-, чөмгий нь соро-, хонгий нь шула-

По две шкуру с нас дерут (Рылеев) Манийг хувхайртал мөлжиж байна.

39. **ШМЫГАТЬ НОСОМ** [*разг.*] Хамраа шуухиртал тата-, нусаа тата-, бороонь хонь шиг, гудрагатсан нохой аятай, бурантгаа эвхэ-

40. **ШТАТСКИЙ ГЕНЕРАЛ** [*разг.*] Шадар түшмэл

41. **ШУБЫ НЕ СОШЬЁШЬ** *из кого* [*перен, разг, шутл.*] огт нэмэргүй, шал дэмий, үр ашиггүй.

42. **ШУМ В УШАХ (ШУМИТ В УШАХ)** Чих дүнгэнэ-, чих шууги-, чихэнд юм дуугарах,

У меня завсегда перед обедом в ушах шумит. Хоолноос өмнө (хоол олдвол) миний чих шуугиад л байдаг юм.

43. **ШУМИТ В ГОЛОВЕ** толгой дүйрэ-, мансуурах, мэнэрэх, дүнсийх, эргэх, ан хөвөл тогоо дүүрнэ архи уувал толгой дүйрнэ

После выпивки у него шумело в голове Архи уучихаад толгой нь манарч байв.

44. **ШУНДЕР-МУНДЕР** [*разг.*] элдэв долоон юм, эсэн бусангийн юм есөн шидийн юм.

45. **ШУТ ПОБЕРИ (ШУТ БЫ ПОДРАЛ)** *кого* Чөтгөр алгад!

46. **ШУТ ГОРОХОВЫЙ (чучело гороховое, пугало гороховое)** [*разг, бран.*] Марзан амьтан, алиа салбадай

47. **ШУТ ЕГО ЗНАЕТ** [*разг, фам*] Тэнгэр мэддэг хэрэг, тэнгэр болгоож дээ.

48. **ШУТ С ВАМИ** Хэ, эцгий чинь, буруу хойшоо, хай цэс, тоглохтой манатай.

49. ШУТИТЬ С ОГНЁМ [*перен.*] үгчилбээс: галаар тоглоутгана: (аминд) халтай тоглоом, тэгж наргиж болохгүй, . . . болох, болохгүй тоглоомоор бүү тогло, өөд нь хаясан чулуу өөрийн толгойд. И-106, 79

50. ШУТКИ ПРОЧЬ (ШУТКИ В СТОРОНУ) [*разг*] тоглоом шоглоомоо орхив (татъя), наргиа тата-, битгий тоглоом хийгээд бай,

Шутки в сторону, товарищи, этот вопрос требует немедленного разрешения. Тоглоом шоглоомоо татъя, нөхдөө, энэ асуудлаа одоохон дав даруй шийдэх хэрэгтэй.

51. ШУТКА ШУТКОЙ (ШУТКИ ШУТКАМИ) Тоглоом ч яахав тоглоом л байгаа биз, тоглоом даах,

Это он только пошутил!-Шутка шуткой и, но он действительно обижен Цаадах нь ердөө л тоглосон юмсан, наадах нь тоглоомоо даахгүй уурлаж дээ.

52. ШУТКИ ПЛОХИ Тоглоом тоотой нь дээр, илүү (наргиа) зангаар яах юм бэ?

Да с ним шутки плохи, нужно держать себя осторожно Тоглоом тоотой нь дээр, цаатахтайгаа хаширхан үзнэ шүү.

53. ШУТКИ (шутку) ШУТИТЬ 1. Тоглоом тохуу хий- 2. шоолж элэглэ-, наадам хий-, наада-, наргих,

54. ШУТОЧНОЕ ЛИ ДЕЛО? Тийм ч амаргүй, нохойн наадам бишээ

Щ

1. ЩЕДРОЙ РУКОЙ гар татдаггүй, гар султай (өглөгч), харам ба гатай, харуусдаггүй

2. ЩЕДРОЮ РУКОЮ 1. өглөгч, гар сул, өгөөмөр гартай, өгөөмөр харамгүй, 2. эр шуудамгай

3. ЩЕЛКАТЬ ЗУБАМИ [*прост.*] өлсөж үхэх шаха-, гол харда-өлөн гэдэс ороолдо-,

4. ЩЕМИТЬ ПОД ЛОЖЕЧКОЙ Б-291

5. ЩЕМИТ СЕРДЦЕ [*разг.*] зүрх шимшрэх, дотор гонсойх, зүрх өвдмөөр, гол харлах

Э

1. ЭЗОПОВСКИЙ (эзопов) ЯЗЫК Аесопын хэл

2. ЭК, КУДА МЕТНУЛ [*прост.*] Ээ, юугаа яриад байна даа! За ямар элэнцэгээ ярих чинь энэ вэ! Юу гээд байна аа!

3. ЭКА (что за) ВАЖНОСТЬ В—509

4. ЭКАЯ (эка) НЕ ВИДАЛЬ! В—889

5. ЭТО В ПОРЯДКЕ ВЕЩЕЙ Энэ ч аргагүй тэрч гарцаагүй; энэ ч зүйн хэрэг ээ, энэ ч долоон зев

6. ЭТО ГОВОРИТ САМО ЗА СЕБЯ хэлэлтээнгүй; яриангүй; хэлэх юу байхав ёстой доо,

7. ЭТО ДАРОМ НЕ ПРОЙДЁТ *кому* (энэ) зүгээр өнгөрөхгүй; тала ар болохгүй

8. ЭТО-ДЕЛО ДЕСЯТОЕ энэ огт хамаагүй; өчүүхэн ч холбогдогдогүй

9. ЭТО (дело) НЕТЕРПИТ ОТЛАГАТЕЛЬСТВА тэвчих юм биш! яаж тэсэх вэ?

10. ЭТО ДРУГОЙ КОЛЕНКОР [*разг.*] шал өөр юм; хохь хамаагүй юм; жигтэй юм

11. ЭТО ЕСТЬ энэ дээ; энэ шүү; за энэ; энэ бол

Это есть мой труд миний зохиол энэ дээ
Вот это есть наша школа-За манай сургууль энэ дээ

12. ЭТО ЕЩЁ ЧТО ЗА НОВОСТИ? Юу болж байгаа нь энэ вэ? Яаж байгаа нь энэ вэ? Энэ чинь одоо юу гэгч нь болоо вэ?

13. ЭТО НЕ ДЕЛАЕТ ПОГОДЫ [*разг.*]. Юм шуу юм болохгүй; огт нэмэргүй; шал дэмий инээж тараахгүй шүү,

14. ЭТО НЕ ДЕЛО Энэ биш ээ! болохгүй шүү! ийм гүй! биш байна даа!

15, ЭТО НЕ СУТЬ ВАЖНО [*разг.*] Энэ яахав дээ! онц юм биш! дэмий шахуу юм; энэ ч гайгүй хэрэг шүү,

16. ЭТО-НЕБО И ЗЕМЛЯ газар тэнгэр хоёр шиг юм; шал ондоо; энэ ч тэмээ ямаа хоёр шиг юм болж; огт зүйргүй юм; дүйцэхгүй юм,

17. **ЭТО НИ К ЧЕМУ НЕ ОБЯЗЫВАЕТ** гэмгүй дээ; гэм зэм болохгүй; гайгүй биз дээ.

18. **ЭТО ОДНО ВООБРАЖЕНИЕ** хий бодол; бодлоос цаашгүй; санаанаас цаашгүй; цээжний хонжоо; сэрэхгүй бол сайхан зүүд

19. **ЭТО ПРИСКАЗКА, А СКАЗКА ВПЕРЕДИ** энэ юу ч биш ээ, сүүлдээ яана гэж санана! Юм гэдэг өдүй байна шүү! Нар эрт байна аа! Гайгүй ээ; болоогүй!

20. **ЭТО ТЕБЕ ПРИСНИЛОСЬ** Чи зүүдлээ байлгүй! тийм юм яаж байх вэ!

21. **ЭТО ТОЛЬКО (ешё) ЦВЕТОЧКИ, А ЯГОДКИ (будут) ВПРЕДИ** Энэ юу ч биш юм өдий шүү; юм эрт байна; Нар эрт бай байна шүү; бадарчин баярлах болоогүй

22. **ЭТО УЖ ПОСЛЕДНЕЕ ДЕЛО** баларсан хэрэг! завхарсан ажил, ийм юм байх уу; ингэнэ гэж байх уу;ийм ч юм байгаасай! даанч яав аа!

23. **ЭТО Я ПОНИМАЮ!** В-920

24. **ЭТОГО (ещё) НЕДОСТАВАЛО (хватало)** [*разг. неодобр.*] Ийм баларсан юм байх уу даа! ийм юм гэж байх гэж! ингэж сүйд болдог оо бас! таарч дээ.

25. **ЭТОТ НОМЕР НЕ ПРОЙДЁТ** ингэж болдоггүй хэрэг ээ! тэр тэгдэггүй юм аа! тэр ярихгүй!

26. **ЭТОТ СВЕТ** энэ насанд; энэ яваад; энэ орчлонд; энэ сүүдэр тээ

27. **ЭФИРНЫЙ ОКЕАН** В-773

Ю

1. **ЮМОР ВИСЕЛЬНИКА** [*ирон.*] ядсан хүний зугаа; арга барагд саны илүү үг; ингэж ч суугаасай даа

Я

2. **Я ДУМАЮ!** тэгэлгүй яахав; тэр ч тэгнэ дээ, тэгж таарна, хэний яантгүй тэгж бодож байна.

3. **Я ТЕБЕ (те вам, им)** *буюу* **Я ТЕБЯ (его, вас, их)** [*разг.*] Чамайг дээ би дээ! за гайгүй чамайг!
Я тебе дам! чамайг дээ би дээ! нэг сайн!

4. **Я ТЕБЕ (вам) ДОЛОЖУ** [*разг.*] нохойтой шүү! . . . хэцүү шүү хэлчихэе; яггүй шүү; гэмтэй (осолтой) шүү

Ну и ветер, я вам доложу Ийм салхи тун нохойтой шүү.

5. **Я ТЕБЕ (вам, ему и. т. п.) ЗАДАМ! Я ТЕ ЗАДАМ** [*разг.*] Гайгүй чи тэгж л бай! Би чамайг дээ нэг! Хаана чинь загатнаад байна! Таван салаа боов иднэ бий, эз чинь татаад байна уу!

6. **Я ЧЕЛОВЕК, И НИЧТО ЧЕЛОВЕЧЕСКОЕ МНЕ НЕ ЧУЖДО** Би хүн юм чинь хүнээс юугаараа дутах вэ! хүн болоход хүнд л байдаг юм над байна! хүний хүү зорьсондоо, чонын хүү зуусандаа; эр хүн зорьсондоо, эр морь харайсандаа; би юугаараа дутаж үхэх юм.

7. **ЯБЛОКО, РАЗДОРА** (библээс гаралтай үг) үгчилбээс; хэрүүлийн алим; утга нь; хэрүүлийн шалтгаан: хэрүүлийн хөрөнгө; тэмцлийн уурхай.

8. **ЯБЛОКУ НЕГДЕ УПАСТЬ** [*перен. разг.*] хөл орох гишгэх зайгүй; пиг дүүрэн, бөгс эргэх зайгүй

9. **ЯВИТЕ (яви, сделай) БОЖЕСКУЮ МИЛОСТЬ** өршөөж хайрла-, таалалдаа багтааж соёрхо-!

10. **ЯВИТЬСЯ НА СВЕТ** 1. Гарч ирэ-; төрө-; мэндлэ-; буй бол- 2. шинээр гар-; анх хэвлэгдэ-. П-898, У-28

11. **ЯВИТЬСЯ С ПОВИННОЙ** П-1029

12. **ЯВОЧНЫМ ПОРЯДКОМ** (урьдаар) ам тохироогүй; хэлэлцээгүй; ингэнэ чингэнэ гэж тогтоогүй.

13. **ЯДРОВОЕ МЫЛО** дөмөг саван; сайн саван

14. **ЯЗВИ** (*чью*) **ДУШУ** [*прост, бран*]. үхэж байх нь таарсан! үхмэр чамайг! муугаа үзэж үхмэр!

15. **ЯЗЫК БЕЗ КОСТЕЙ** *у кого* [*перен, разг.*] хэл нь чилдэггүй хүн; ам нь хуурай байдаггүй (их юм чалчдаг) хүн; гавчуур хүн;

16. **ЯЗЫК ДО КИЕВА ДОВЕДЁТ** ямхын төдүй хэлээр ямрыг ч хийж болдог; хэлж чадах хүний хэл нойтон; хэлж чадахгүй хүний нүд нойтон; муу эрэхээр сайн сур!

17. **ЯЗЫК ЗАПЛЕТАЕТСЯ** *у кого* хэл (нь) ороолдо-; олигтой хэлж чадахгүй.

18. **ЯЗЫК МОЙ-ВРАГ МОЙ** үгчилбээс; миний ам миний дайсан утгачилбаас: даган дээрээс унаагүйгээ даравгар хар дээрээс унах; олон үг толгой ороодог; урт хошуу хоолой ороодог, урт хормой хөл ороодог.

19. **ЯЗЫК НА ПЛЕЧЕ (на плечо)** у *кого* үлбийтэл ядра-; мах болтлоо ядра-.

20. **ЯЗЫК НА СТОРОНУ** (үг нь нохой хэлээ унжуулах гэсэн үг нээс гаралтай) дэмий биеэ зовоосон; зовлогоо зовоосон; хий л махаа идсэн.

21 **ЯЗЫК НЕ ЛОПАТКА, ЗНАЕТ ЧТО СЛАДКО** үгчилбээс хүний хэл хүрэ биш. хүрснээ амтлана;

22. **ЯЗЫК НЕ ПОВЕРНЕТСЯ (поворачивается) (сказать рассказать и. т. п.)** хэлэхэд хэцүү; амнаас багтаж гарахгүй; яаж ч хэлэх вэ дээ; хэлэхэд зовлонтой.

23. **ЯЗЫК ОТНЯЛСЯ** у *кого* таг дугуй бол-; хэл нь татсан шиг бол-, ангайж хоцро-.

24. **ЯЗЫК ПЛОХО ПОДВЕШЕН (привешен)** амнаас үг гарахгүй үг нь түг таг гээд; хэл ам ээдрээд; хэл ам эвлэхгүй,

25. **ЯЗЫК (прилип) ПРИСОХ К ГОРТАНИ** у *кого* мэл гайхаж цэл хөхрөх; ангайж хоцрох,

26. **ЯЗЫК ПРОГЛОТИШЬ** [*прост.*] сайхан амттай; дээд уруулд хүргэмгүй дэрэгдэх хүнд өгөмгүй; шүлс гоожмоор; амт гэж яана даа.

> **В этом ресторане борщ-язык проглотишь** Энэ зоогийн газрын шөлний амт гэж яана даа

27. **ЯЗЫК РАЗВЯЗАЛСЯ (развязывается)** *у кого* [*разг.*] ам нээвэл уушги нээх гэгч болох; (ярианд) ам халах;

28. **ЯЗЫК (не плохо) ХОРОШО ПОДВЕШЕН (привешен)** *у кого* хэлэмгий шаламгай; үг хэл нь гүйцэгдэхгүй; хэл гэж ус цас; ам ч гэж ам; олон үгтэй; хөврүүлж алддаг.

29. **ЯЗЫК ЧЕСАТЬ** Т-176

30. **ЯЗЫК ЧЕШЕТСЯ** [*разг.*] (юм) хэлмээр санагдах; хэл ам загатнах.

31. **ЯЗЫКИ ПЛАМЕНИ** галын дөл; долоолсон дөл, дүрэлзсэн гал.

32. **ЯЗЫКОМ БОЛТАЙ А РУКАМИ ВОЛИ НЕ ДАВАЙ** амаар хэлэх яахав, гар бүү хүрэх; муу эр мод чулуу.

33. **ЯЗЫКОМ ТРЕПАТЬ** Т-176

34. **ЯЙЦА КУРИЦУ НЕ УЧАТ** аавдаа авгай авахыг заах хэрэггүй

35. **ЯКОРЬ СПАСЕНИЯ** ганц аврал; ганц горьдолго, үхэхдээ үхэр буугаа тавих; эцсийн ганц арга

36. **ЯСНЕЕ ЯСНОГО** тодын тод; тодоос тод; ив ил; харваас ил; тод гэмээн тод

37. **ЯСНО КАК (божий) ДЕНЬ** [*разг.*] тов тодорхой; ив ил; сав саруул; гэгээн тодорхой.

38. **ЯСНО С ПЕРВОГО ВЗГЛЯДА** харваас ил; харангуут ил; хэн ч харсан ил; үзүүт ил; андашгүй.

39. **ЯСНОЕ ДЕЛО** [*разг.*] тов тодорхой; тодорхой хэрэг; илэрхий явдал; мэдээжийн хэрэг.

40. **ЯСТРЕБИНЫЙ ВЗГЛЯД** ширүүн харц, хурц харц, аймаар харц

41. **ЯСТРЕБИНЫЙ НОС** шонхор хамар, бүргэд хамар, шонх хамар

42. **ЯЩИК ПАНДОРЫ** [*нижн.*] (зовлонгийн уурхай (үүд), зовлонгийн хөрөнгө. мундрагын ундрага

ТӨГСӨВ

ISTITUTO UNIV. ORIENTALE
N. Inv. 8754
SEMINARIO DI STUDI ASIATICI

Чой. Лувсанжав
ОРОС МОНГОЛ
ӨВӨРМӨЦ ХЭЛЛЭГИЙН ТОЛЬ

Техникийн редактор *Ц. Содов*
Хянагч *Б. Цэдэв*

Өрөлтөнд 1970 оны 1-р сарын 4-нд Хэвлэлтэнд 1970 оны 4-р сарын 25-нд А—39559. Хэвлэсэн тоо 20 000 Цаас 84×108/32 Х.Х. 20 Х.Н.Х 33,6 Т.Х 33,41 Х.г. № 19/69. За № 544

Улсын Хэвлэлийн газар, Улаанбаатар
Их сургуулийн гудамж, 1.

Сүхбаатарын нэрэмжит Хэвлэлийн Комбинат
Улаанбаатар Сүхбаатарын талбай, 2.

Чой. Лувсанжавын зохиосон ОРОС МОНГОЛ ӨВӨРМӨЦ ХЭЛЛЭГИЙН ТОЛЬ хэмээх номын залруулга

Хуудасны дугаар	Мөр буюу хэллэгийн дугаар	Ташаарсан нь	Залруулсан нь
7—	12-р мөр	номны	юмны
24	70-р хэллэг	[разг.]	[разг.] **З—201**
54	484-р	ума	ума **Б—102**
60	29-р	ногоо	ногоон
73	212-р	хөдөө	үйлдвэрт
90	419-р	на ходиться	находиться) болдог хүний гарт зөв хүний үүдэнд
95	486-р	ВЫ	БЫ
96	505-р	(Та бид нар мөнхийн усыг уусан биш	Үүнийг доорохи хоёр мөрий нь алгасуулан, . . . олсон биш) гэдгийн араас залгаж үзнэ үү
126	87-р	збезда	звезда
168	14-р	голувой	голубой
176	-р	фасон)	фасон **(Д—241**
191	27-р	ВЕРЕТ	ВЕРСТ
201	41 -р	ихэдэ-, (дагжи), сүнс нь зайлчих дөхө-, учиргүй чичирэ-	**К—103**
220	30-р	[прост]	[прост.] **З—29, К—264**
223	69-р	за чай сахар	За чай сахар-хишгий тэнь хүртлээ (цайлж дайлсанд хариу талархах үг)
245	41-р	*о чем*	*о чем* **Н—1020**
276	202-р	(упал)	(упал) **С—217** (хачирхах үг)
	203-р	(упал)	(упал) **С—217**
278	223-р	как собака	как собака прост, ядарч мах болох, сүг болох;)
			(өлсөн) бирдийн зовлон эдлэх; (даарч) чөмөг царцах
280	247-р	как штык [прост.]	бороотой ч болсон болзоондоо хүртай ч болсон хугацаандаа, цаг цагт нь, яг л
436	385-р	явдаг	яадаг
443	117-р	РОЖНА [прост]	РОЖНА [прост.] **Л—51**
455	298-р	ирьд урьд	урьд урьд
526	12-р	балин	барин
593	194-р	карманом) [прост.]	КАРМАНОМ прост. сул гартай, дэл сул зарамтгай
604	142-р	*с чем*	*с чем* гуяа ганзгалаж ирэ- (очи- ява), ганзага хоосон
609	54-р	хол унаа хөл	хөл унаа, хол
616	19-р	байхгүй, юмгүй	байхгүй юмгүй